



ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 3



АГШИН ЗУУР
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 3

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

**АГШИН ЗУУР
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР**

Гуравдугаар боть

АГУУЛГА

Намтрын өмнөх үг	3
Товч илгээлт	4
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар	5
Өмнөх үг	9
Арга, билиг тэнцвэржвэл Бурхан болно	10
Нас нөгчих үеийн нөхцөл байдал	46
Хар болон цагаан ид шид	76
Могойн хорхой	12
Ад чөтгөрийн ажлыг тодорхой танихуй	139
“Бодь мөр”-ийг олсон жинхэнэ их багшийн соронзон талбайн татах хүч хязгааргүй их	161
Үйл түйтгэр ба тогтсон үйлийн үрийн ялгаа	188
Үйл түйтгэр угаас хоосон	194
Хэлбэлзэлийн хүч үйл түйтгэрийг ариусгаж чаддаг	224
Авшиг хүртэхүй -Арьяабалын бясалгалын арга	250
Таван сахил	252
Веган хоолны ач тус	253
Эрүүл мэнд ба хоол хүнс	254
Экологи ба хүрээлэн буй орчин	258
Дэлхийн өлсгөлөн	260
Амьтны зовлон	260
Гэгээнтнүүд ба үйлс нэгтнүүд	261
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт	264
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ?	268

НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Машид гэгээрсэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар, энэ ертөнцийн үгээр илэрхийлэх боломжгүй. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичнээн тодорхой хичээнгүйлэн дүрсэлсэн ч бүрэн дүүрэн өгүүлж чадахгүй.

Эрт цагт Энэтхэгийн нэг бясалгагчид өөрийн Багшийн намтар түүхийг бичих үүрэг оногджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг асуухад дуусаагүй гэжээ. Дахиад хэсэг хугацааны дараа асуухад: “Их Багштай ижил дэсэд хүрч, түүний үзэгдэх, үзэгдэхгүй түвшний ажлыг жинхэнэ үнэн зөвөөр ойлгохоос нааш би энэ ажлыг хэзээ ч дуусгаж чадахгүй. Учир нь миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн билээ.” гэж хариулсан гэдэг.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн өмнөх амьдралын талаар дурдсан нь тун бага. Гэсэн ч Багшийн намтрыг ихэд сонирхсон газар газрын шавь нарынхаа тавьсан олон янзын асуултад хариулахаас өөр аргагүй болдог. Энэ товч намтарт Их Багшийн амьдралын замналыг эмхэтгэж, найруулан бичжээ. Иймээс бүрэн төгс болоогүй тал мэдээж бий.

ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай уран бүтээлч, оюун санааны агуу хөтчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх аливаа хэлбэрт дуртай. Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр, амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэ эрдэнийн арал, ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн улс орон, зон олонд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинд алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн билээ. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лак (Вьетнам)-ын төв нутагт мэндэлж, Европт суралцсан бөгөөд Улаан загалмайн нийгэмлэгт ажиллаж байжээ. Тэрбээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон шаналлаар дүүрэн байдгийг хараад үүнээс ангижрах арга замыг хайхаар даруй шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон юм.

Тэрбээр тухайн үед нэгэн герман эмчтэй гэр бүл болж, жаргалтай сайхан амьдарч байсан ч өөр өөрийн зам мөрөөр явах амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн зорилгоо биелүүлэх их аянд морджээ. Ингэж Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрж хайх сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнажээ. Эцэст нь Энэтхэгийн Хималайн уулнаа Төгс Гэгээрсэн нэгэн Их Багш түүнд дотоодын Гэрэл, Аялгууг ажиг “Арьяабалын бясалгалын арга”-ыг уламжилсан байна. Ингээд Тэр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрсэн ажээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагдсан. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, өөрийн дотоодын бурхан чанарыг нээн илрүүлэхэд тэднийг дэмжин зоригжуулж эхэлжээ. Удалгүй Америк, Европ,

Ази, Австрали, Африк таван тив, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд ном айлдахыг хүсэж, урин залах болсон байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай зовж зүдэрсэн олонд энэрэл нигүүлслэлийн сэтгэлээр бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуус, ядуу буурай амьдралтай өндөр настнууд, шоронд хоригдож буй хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй, оюуны чадамжгүй иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг маш олон хүнд хүрсэн юм.

Дулаарлаас үүдсэн олон хямрал дэлхий дахинд нүүрлэсэн өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг өгч буй бөгөөд байгалийн гамшигт нэрвэгдэгчдэд туслахаар нийгэмлэгийн гишүүдээ дэлхийн олон оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бидэнтэй зэрэгцэн орших эрхэм ариун амьтад, хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг юм.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлслэл олон сая хүний сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болдог билээ. Их Багш өөрийн уран зураг, дэнлүүний чимэглэл, хувцас загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлийн орлогоор тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэсээр байдаг.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Ноход миний амьдралд”, “Эрхэм ариун амьтад” гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдсан байна. Их Багш телепат холбоо, сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлдээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшаан 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт Манлайлал”-ын шагнал, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатар”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй Үйлстэн”, “Дэлхийн Гэрэлт Шударга Үйлстэн”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгч” зэрэг олон цол, шагналыг бий болгосон юм. Эдгээр нэр

төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс оронд олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлалтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Жанез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны тэргүүн, Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн (НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амь биеэ үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Оюун ухааны шагнал”-ыг олгож, үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон орны төр засгийн газар, хувийн байгууллага өндрөөр үнэлэн шагнаж, хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие, сэтгэлийн харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг.

Их Багш Чин Хай бол билиг ухаан, баатар зоригороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн

хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч мөн. Үнэндээ Тэрээр хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно.”, “SOS - дэлхийн дулаарлыг зогсоох нь.” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан, түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё.” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн юм. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторанууд Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл, тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гараг ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл, энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийд гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон эцэс цуцалтгүйгээр тусалсаар байна.

ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгатай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой ярианы хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус, уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог. Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж, шавь бид эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.



АРГА, БИЛИГ ТЭНЦВЭРЖВЭЛ БҮРХАН БОЛНО

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайбэй хот. Цаглашгүй гэрэлт
бясалгалын төв. 1987 оны 10 дугаар сарын 10.
(Эх нь хятад хэлээр)*

Би та бүхнийг Арьяабалын бясалгалын аргыг дадуулах хэрэггүй гэж ятгая. Учир нь бясалгах болсноос хойш хүн уурлавал бид хариу уурлахаа больдог. Ийм байх нь шударга бус биз дээ? (Бүгд инээлдэв.) Тэр ч байтугай мөнгийг маань авах гэсэн хүнд дуртайяа өгнө, учир нь мөнгөтэй байх нь мөнгөгүй байхтай адилхан. Та нар ойлгож байна уу? Сүнслэг бясалгал дадуулсны дараа эхнэр, нөхөр ч чухал биш болж мэднэ, найз нөхөд ч мөн адил. Тэр ч байтугай юм идсэн ч дуршилгүй байж, юу ч уусан амтгүй болно. Иймд сүнслэг бясалгал дадуулах хэрэг байна уу?

Тиймээс миний бодлоор Арьяабалын аргаар бясалгахгүй байх нь хамгийн сайн, учир нь бясалгасны дараа нэр алдар, эд хөрөнгө огт хамаагүй болж, зөвхөн хэрэгцээнийхээ л хэрээр мөнгө олно, илүү шунахгүй. Урд нь их мөнгө олох дуртай байсан бол одоо ер хайхрахгүй. Мөнгө байвал хэрэглэнэ, мөнгө байхгүй ч гэсэн сэтгэл зовохгүй. Бясалгал дадуулсны дараа бид ногоон хоол идэх болсон, харин бусад хүн мах иддэг тул биднийг хачин жигтэй гэж боддог. Хэрвээ хүмүүс бүгд ногоон хоолтон болчихвол махны худалдаачид ажилгүй болно, тийм биз? Ингэснээр бид “энэрэн нигүүлсэх сэтгэл”-гүй болчих биш үү? (Бүгд инээлдэв.)

Арьяабалын аргаар бясалгах нь тун сайн гэж та нар ярьдаг. Харин ч миний бодлоор сайн биш. Бясалгасны дараа Багш шигээ хүмүүсийн асуултанд хариулж чадахгүй болчихож ч магадгүй.

Саяхан нэг хүн Багшаас нь: “Бурханы шашин гэж юу вэ, та мэдэх үү?” гэж асуухад нь би: “Мэдэхгүй” гэсэн. Тэгэхэд тэр дахиад: “Арьяабалын бясалгалын арга гэж юу вэ?” гэж асуухад нь би бас л хариулж чадаагүй. Нэгэнтээ нэг хувраг намайг доогуур суудалд суухыг урихдаа: “Та хариулж чадахгүй байгаа нь даяанч биш гэдгийг илэрхийлж байна, тэгэхлээр та доогуур суудалд суу.” гэв. Түүний зөв байсан учраас би уг нь доор суухыг хүсэж байсан ч тун их ядарснаасаа болоод суудлаасаа босолгүй зүгээр л тэндээ хөдлөлгүй сууж байлаа.

Арьяабалын бясалгалын аргыг дадуулвал яг тэнэг хүн шиг болдог. Хүн юу ярьсан ч тоохгүй, маргаж чадахгүй, маргахыг ч хүсэхгүй болно. Ингэх нь юуных нь сайн хэрэг байх вэ? Арьяабалын аргаар бясалгахаас өмнө би бас ч гэж хүмүүстэй мэтгэлцэж: Юуг Даяан гэх вэ? Бодь мөрийг бүтээсний дараа ямар байдалтай байдаг вэ? Бурхан, бодьсадва болсны дараа ямар байдалтай байх бол гэх зэргээр маргадаг байжээ. Гэвч Арьяабалын бясалгалын аргыг дадуулснаас хойш би энэ тухай ярихаас улам залхуурч, бүр ярих ч дургүй болсон. Учир нь жинхэнэ байдлыг эгэл хүний үг хэлээр илэрхийлэх аргагүй тул ярих тусам Үнэн ёсноос улам холдоод байх шиг санагддаг. Энэ мэт шалтгааны улмаас Арьяабалын аргаар бясалгах нь тийм ч сайн биш гэж би бодож байна.

Урьд нь би их л хоолсог байсан, одоо идэх маань улам багасаж, юу ч идмээргүй санагдах болжээ. Ийм байдлаар Арьяабалын аргаар бясалгах нь ямар ашиг тустай байх вэ? Уг нь бид энэ тоост хорвоо дээр идэж ууж, жаргаж цэнгэж байдаг, тийм биш үү? Гэвч бясалгал дадуулсны дараа жаргал цэнгэлд ч дурлахаа болино. Жаргаж цэнгэх дургүй байгаа хэрэг биш, хүсвэл наадаж цэнгэсэн ч болно, гэхдээ урьдынх шигээ ихэд хүсэхээ больчихдог. Сайхан хоол идвэл амттай байна гэж хэлэх боловч урьдынх шигээ дурлаж ховдоглож идэхгүй.

Бясалгах тусмаа энгийн хүнээс өөр болно. Та нар Багшийгаа хар, ярихыг хүсэж байвч ихэнхдээ ярьж чаддаггүй, ярьсан ч үргэлж энгийн хүмүүсийн ярьдгаас эсрэг зүйл ярьдаг, энэ бүхэн Арьяабалын бясалгалын аргыг дадуулснаас болсон хэрэг. Тиймээс та нар: “Арьяабалын аргаар бясалгавал ямар вэ?” гэж бүү асуу. Би сайн юмгүй гэж л хэлнэ.

Уг нь бусад бясалгалын аргыг дадуулвал ид шидтэй болдог. Жишээлбэл, хэрвээ жаахан хүч чадалтай болбол бусдын өвчнийг эмчилж чадна, эсвэл бурханд мөргөх, уул овоо тахихаар явж болно,

саад бэрхшээл тохиолдвол бурхныг бодон өөрийгөө тайтгаруулж болно, таагүй явдал учрах, эсвэл өвчин зовлонд өртвөл Арьяабал бодьсадвад даатгаж болно. Гэвч Арьяабалын аргаар бясалгасны дараа хэнээс ч тусламж гуйх хүсэлгүй болж, гуйх бурхан ч байхгүй болдог, тэр үед бурхад бүгд зугтаачихдаг. Арьяабалын аргаар бясалгасны дараа алдар нэр, эд баялаг, хорвоо дэлхий, шунал хүсэл, уур хилэн, харанхуй мунхагаа бүгдийг алдчихна, тэр ч байтугай бурхныг ч бас алдчихна. Ингэж бясалгах нь ямар ашиг тустай байх вэ? Хожим маш ихээр өнчрөн ганцаардвал яах билээ? Арьяабал бодьсадва ч байхгүй, бурхан ч байхгүй, тэгэхээр бид яаж амьдрах вэ? Эр нөхөр, эхнэртээ хоргодохгүй, нэр алдар, эд баялагт ч сэтгэл татагдахгүй, хоол ундыг ч голж шилэхээ больдог. Өмнө нь энийг иднэ, тэрийг идэхгүй гэж голж шилдэг байсан бол одоо юу ч байсан хамаагүй болсон, юу байгааг нь иддэг болсон. Урьд нь хамгийн орчин үеийн машинд, эсвэл нэгдүгээр зэрэглэлийн онгоцонд л суух ёстой байсан бол одоо энэ бүхнийг тоохгүй болжээ.

Арьяабалын бясалгалын аргыг хэдий их дадуулвал урьдын дадал зуршлаа төдий их орхиж, бүр их бясалгавал бүх юм үгүй болж, тэр ч байтугай “хоосон” ч үгүй болно. Арьяабалын аргаар бясалгахаас өмнө бол хүмүүстэй “хов хоосон”-ны ёс учрыг ярилцаж, бас “Даяан”-ы тойрог зураад “би” үүнийг бясалгадаг гэдгээ илэрхийлдэг байв. Нөгөө Даяанчийн пүүс дэх “их бясалгалтан” шиг, би түүнээс: “Та юуг бясалган дадуулдаг вэ?” гэж асуухад тэр юу ч ярилгүй, зөвхөн тойрог зурж үзүүлсэн юм.

Арьяабалын бясалгалын аргыг дадуулсны дараа ингэж чадахгүй, энэхүү “хоосон” гэгчийг ч бас бясалгаж чадахгүй, тэр ч байтугай “Даяан”-ы хамгийн дээд төлвийг ч илэрхийлж чадахгүй, ингэж бясалгал дадуулах нь юуных нь сайн байх вэ дээ? Та (*нэг шавиа заав*) Даяаны бүлэгт буцаж очин бясалгах хэрэгтэй, тэгвэл сая энэ зурах “тойрог”-той болж чадна. Харин Багшийгаа дагавал юу ч байхгүй болно, бүгдийг усны сувагт хаяж орхих тул ашиглаж болохгүй, бас яаж ашиглахаа ч мэдэхгүй, ойлгож байна уу? Тиймээс бясалгах тусам улам бядуу тэнэг болж, Даяаны хамгийн дээд төлөөллийг ч яаж илэрхийлэхээ мэдэхгүй. Ойлгож байна уу? Жишээ нь, хүн надад: “Даяаныг бясалгавал даруй нэгэн Бурхан болно.” гэж хэлсэн ч би тоохгүй, учир нь надад одоо бурхан ч байхгүй болжээ, ойлгож байна уу?

Иймээс би та нарт хамгийн сайн нь Арьяабалын аргаар бясалгах хэрэггүй гэж анхааруулъя! Хариад бурханд мөргө, ингэвэл

зовлон тохиолдвол бурхантай ярилцаж, бурхнаас тусламж гуйж, олон хэрэг явдлыг даатгаж чадна, өвдвөл Арьяабал бодьсадвагаас Их нигүүлсэнгүйн рашаан хүртээхийг гуйж болно. Хэрэв өвчнөө түргэн эдгээхийг хүсвэл бас Арьяабал бодьсадвагийн өмнө: “Хэрвээ миний өвчин эдгэвэл би... -х болно.” гэж тангараг тавьж болно. Харин Арьяабалын аргаар бясалгавал энэ бүхэн цөм алга болдог. Арьяабал бодьсадва зугтаачихна. Эгэл ертөнцийн аливаа билиг ухаан бүхэн алга болно, тэгж яаж болох билээ?

Тиймээс дөнгөж сая та нар Багшаасаа: “Арьяабалын бясалгалын арга гэж юу вэ?” гэж асуухад би үнэндээ хариулж чадаагүй. Би худлаа хэлээгүй шүү, та нар үүнд итгэж байна уу? Заримдаа жаахан ухаалаг үедээ бас ярьчихна. Гэвч ихэнхдээ ярьж чадахгүй, юу ярих ёстойгоо мэддэггүй. Хүмүүс ном тайлуулахаар намайг урих болгонд би тэр өдөр юу ярихаа мэддэггүй. Харин бусад “билиг ухаан”-тай номын багш нар бол бүгд л ном тайлах тогтолцоог сайн мэддэг, эхлээд ингэж, дараа нь тэгж ярина гэх мэт. Нэгдүгээр зүйлийг ингэж хэлэх ёстой, хоёр дахь санаагаа тэгж хэлэх ёстой гэх мэтчилэн урьдчилан бэлдэж, тоймыг нь гаргачихсан, нэгдүгээр зүйлээ ярьж дуусгаад цааш нь хоёрдугаар, гуравдугаар, дөрөвдүгээр ... гэх зэргээр үргэлжлүүлэн ярьдаг.

Гэвч Багш нь тун бядуу, ийм ч юм хийж чадахгүй, хийе гэсэн ч яаж хийхээ мэдэхгүй. Жаахан билиг ухаантай номын багш бол нэг боть судрыг эхнээс нь дуустал тайлж чадна. Тэдэнд маш их лавлах материал байдаг. Гэтэл би ийм зүйлийг ч хийж чадахгүй. Хэрвээ надаар нэгэн боть судар тайлуулбал Багш нь ярьж байхдаа унтчихаж мэднэ. Тэр үед бурхан яваад зогсохгүй, Багш нь өөрөө ч бас явчихна.

Германд байхдаа би заримдаа бас судар уншдаг байсан, учир нь тэр сүм тусгайлан судар уншдаг байсан болохоор өдөр бүр хамтдаа судар аялгуулан уншина. Судар аялгуулан унших нь муу биш, сайхан сонсогддог. Гэвч жаахан сатаарвал сүнс дорхноо зугтаад явчихна. Тэр үед унших хүнгүй болдог, ойлгож байна уу?

Судар уншихад нилээд ядардаг, уншихаасаа өмнө анхаарлаа сайн төвлөрүүлэх ёстой. Хэрвээ эзэн нь байхгүй бол хэн унших вэ? Тиймээс би судар уншдаг хүмүүсийг их биширдэг, бясалгах тусмаа тэднийг улам их бишрэх болсон. Би ер нь судар цээжээр унших, аялгуулан уншихын аль нь ч сайн биш бөгөөд нэмэргүй, бурханд мөргөх ч бас хэрэггүй гэдэг. Харин өнөөдрийн ярих зүйл бол өөр, тиймээс та бүхэн тэмдэглэж аваад ном болгон хэвлээрэй. Энэ тун чухал.

Судар аялгуулан унших нь маш сайн, учир нь уншихын тулд заавал анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй бөгөөд маш дээгүүр “дэс”-тэй байх хэрэгтэй. Багш нь одоо “дэс”-гүй тул уншиж чадахгүй, бас тийм олон судар уншиж чадахгүй, учир нь судар уншвал бүгдийг нь аль хэдийн мэддэг юм шиг санагдаад уйтгартай байдаг. Ямар нэгэн зүйлд дургүй болох үед нойр хүрдэг биз дээ? Жишээлбэл, энд Багш нь ном тайлж байхад хэн нэг нь ойлгохгүй байвал уйдаад нойрмоглодог, ойлгож байна уу?

Шавь нарын зарим нь Багшийг нь ном тайлахыг сонсоод уйтгартай санагдвал, тэндээ бясалгаж, түр зуур ангижран Төгс баясгалант оронд очиж, Авид Бурхантай уулзаад удалгүй буцаж ирдэг. Хэрэв тэнд нь харах Авид Бурхан байгаа бол нилээд сайн бясалгадгаа харуулж байна гэсэн үг. Даанч бурхан бодьсадватай уулзсан бясалгагчдын ихэнх нь төд удалгүй ном уламжлаад эхэлдэг. Сэтгэл нь хангалттай даруу биш бол бурхан бодьсадваг харвал тэд өөрсдийгөө тун сүрхийд тооцох болно. Зарим хүн бодьсадваг зөвхөн ганцхан удаа л харсан, тухайлбал, Арьяабал бодьсадва түүнд ямар нэгэн зүйл, эсвэл номын хэрэгсэл өгөхийг хараад өөрийгөө их багш болчихлоо гэж боддог тухай сонсож байсан. Бурханыг ганц, хоёрхон удаа харах нь үнэндээ юу ч биш. Миний даруухан бодлоор үнэхээр сүртэй явдал биш. Бясалгал дадуулж байгаагүй хүн ч гэсэн Арьяабал бодьсадватай уулздаг. Хэзээ ч бясалгаж байгаагүй, ногоон хоол огт идэж байгаагүй, бурханд залбирч мөргөдөггүй, шашин номын талаар ойлголтгүй зарим хүн авшиг хүртэх үедээ бурхан бодьсадваг шууд хардаг.

Бурхан бодьсадваг харах нь ердөө л анхан шатны ахуй ойлголт, сүртэй явдал биш. Тэдний өгсөн зүйлийг авч огт болохгүй гэж Багш нь та нарт сануулдаг. Жишээлбэл, бурхан бодьсадва, эсвэл хэн нэг хүн илрэн гарч ирээд бидэнд ямар нэгэн зүйл өгвөл хэрхэвч авч болохгүй. Тэр биднийг ямар нэгэн хутагт хүрсэн гэж яривал хүлээн зөвшөөрч болохгүй. Арьяабал бодьсадва өгсөн ч авах хэрэггүй. Хэрвээ бид зөвшөөрөх юмуу, хүлээж авбал тухайн түвшиндээ гацна. Тэгээд түүний зарц болж, зөвхөн түүнд үйлчлэхээс биш, өөрөө Арьяабал бодьсадва болж чадахгүй.

Зарим хүн бясалгал дадуулаад дэс нь тодорхой нэг хэмжээнд хүрвэл ямар нэг түвшин, ертөнцөд очоод ирж чаддаг. Жишээлбэл, диваажинд очиж аршийн тоор иддэг бөгөөд түүнийгээ тун сүрхийд бодно. Үнэндээ орчлон ертөнцөд маш олон дэс түвшин байдаг, та хаана нь ч очиж болно, энэ нь тун энгийн хэрэг, гэхдээ танд очих түвшин бас байсаар л байдаг. Гэтэл зарим хүн бясалгаад очмоор

түвшин байхгүй болж, газар бүхэн түүнийх болдог тул хаана ч оршин байдаг. Зарим хүн өнөөдөр Баруун зүгийн Төгс баясгалант оронд очиж, Авид Бурхантай уулзаад маргааш нь Арьяабал бодьсаватай уулздаг бол түүний хувьд огт өөр. Жинхэнэ дээд бясалгалтай хүнд нэгэнт ялгаварлах түвшин байхгүй болчихдог. Тэрээр хаана ч оршино. Миний санааг ойлгов уу?

Тэр бол Арьяабал Бурхан ч, Авид Бурхан ч, Шагжамуни Бурхан ч, Оточ Манал Бурхан ч, Бяруузана Бурхан ч мөн. Харин Бяруузана Бурхан, эсвэл Авид Бурхан ирж, Түүнд авшиг хүртээх, эсвэл түүнийг ямар нэгэн хутагт хүрсэн гэж хэлдэг биш юм. Тэр өөрөө Бяруузана Бурхан, тэр өөрөө Авид Бурхан болчихсон хэрэг. Ойлгов уу?

Тэр хаа сайгүй оршин байдаг бөгөөд тэр үед Тэрээр их билгүүн хүн тэнэг мангар мэт харагдана гэдэг л болно, учир нь Түүнд яримаар үг, очмоор түвшин, мөргөмөөр бурхан аль хэдийн байхгүй болчихсон. Хэн ч Түүнийг аварч чадахгүй. Тэр өвчлөх үедээ өвдөнө, толгой нь өвдөх үедээ толгой нь өвдөнө, нас барах үедээ явж одно. Түүнийг аварч чадчихмаар хүн үгүй, өвчнийг нь эдгээж чадчихмаар эм үгүй, өвдсөн ч оношлож чадчихмаар эмч үгүй.

Бясалгал сайтай бусад хүн ч бүгд бурхан бодьсавга харж чадна, саяхан миний ярьсан тэр хүн шиг, хэсэг хугацаанд бясалгасны дараа ямар нэгэн түвшинд хүрч, тийм тийм бурхантай, эсвэл тийм тийм гэгээнтэнтэй уулзах ч байж мэднэ.

Орчлон ертөнцөд нэгэн газар байдаг, тэнд олон гэгээнтэн, эсвэл их бясалгагч цугларч, номын хурал хийдэг. Хэрвээ аль хэдийнээ хэдэн арван жил бясалгасан нэгэн их бясалгагч тэнд очвол түүнийг олон гэгээнтэн угтаж, “Тийм тийм их багш тавтай морилно уу.” гэж нэрийг нь бичсэн байхыг олж харна. Мөн түүнийг хоёр, гурван жилийн дараа ямар шашны сургаалын эзэн болно, эсвэл алдартай их багш болно хэмээн бошиглоно. Тэр үүнийг сонссоны дараа ихэд баярлаж, өөрийгөө нэн чухал үүрэг даалгавартай, буцаж очоод Дээдийн Ном дэлгэрүүлж, хамаг төрөлтнийг гэтэлгэх ёстой хэмээн боддог.

Тиймээс Багш нь авшгийн үеэр та нарт: “Тиймэрхүү ахуй ойлголт бол сүртэй юм биш. Энэ бол зүгээр л нэг зүйлийн дэс төдий бөгөөд түүнийг даван туулбал зохино, эс бөгөөс тэндээ гацчихна.” гэж маш тодорхой хэлсэн. Учир нь “би” хамаг төрөлтнийг гэтэлгэнэ гэсэн бодол байсаар байдаг. Бурхан,

харанхуй мунхаг хүмүүс гэх зүйл бас байсаар л байгаа бол хамгийн дээд дэс биш.

Хамгийн дээд дэсэд арга ч байхгүй, билиг ч байхгүй. Гэвч бид ихэвчлэн хэт аргын тал, эсвэл хэт билгийн тал руу хэлбийдэг. Бумбын шашны арга, билгийг дүрсэлсэн зургийн нэг тал нь хар, голдоо цагаан толботой, нөгөө тал нь цагаан, дундаа хар толботой байдаг нь арга, билгийн нөхцөл байдлыг харуулж байгаа хэрэг. Ихэнх хүнд билгийн тал нь давамгайлж, аргын тал нь бага байдаг, тэр ч байтугай зарим үед бүхлээрээ билиг байж, ямар ч арга байхгүй байдаг. Харин зарим хүний арга тал нь хэт их, билиг тал бараг байхгүй байдаг.

Арга гэж юу вэ? Билиг гэж юу вэ? Жишээлбэл, бид нэгэн их алдартай багшийг маш их хайрладаг нь түүнийг дэндүү их хүндэтгэн биширдгээс болов. Бүх зүйл түүний төлөө байж, багшдаа тун баяр жаргалтай, чин сэтгэлээр үйлчилнэ. Тэр үед бид аргын талд байдаг. Хэрвээ багш маргааш нь биднийг сүрхий зэмлэж, ямар ч шалтгаангүй загнавал, ямар ч буруу хэрэг хийгээгүй бид багш намайг хилсдүүлэв гэж боддог. Тэгээд ихэд бухимдан уурлаж, багшийгаа орхиж явахаар шийднэ. Энэ үед бид билгийн талд байдаг, ойлгов уу?

Арга ба Билиг, Билиг ба Арга ийнхүү ээлжилсээр биднийг солиоруулж мэднэ. Эгэл хүмүүс бид байнга арга, билгийн нөлөөнд өртдөг болохоор өөрийн биеэ хянаж чаддаггүй. Бид арга байхыг хүстэл билиг болчихоод билиг байх гэтэл арга болчихоод байдаг. Гэтэл бурхан болон бодьсатва харин арга, билиг тэнцүүхэн байдаг. Ойлгов уу?

Зарим Даяаны багш тойрог зурж, арга болон билиг үгүй гэдгээ илэрхийлэх дуртай. Гэтэл тэднээс илүүхэн хэдэн асуулт асуувал дорхноо уурлана. Саяхан Багшийнх нь ярьсан тэр нэгэн Даяанчийн пүүс дэх “их багш”-тай адилхан. Бид арга, билгээс хэтийдвэл сая бурхан бодьсатва болно. Миний санааг ойлгов уу? Даяанч хэмээгч хүмүүстэй уулзвал тэд тойрог зурж, өөрийн дэсээ бумбын шашинтныхаас илүү өндөр гэж ойлгуулах дуртай. Тэдний Арьяабал Бурханыг харах, маш олон сахиус, эсвэл өнгөрсөн цагийн их багш нарыг шүтэн тахих, ёс суртахуунтай үйл хэрэг үйлдэх, арга, билгийг эрхшээдэг болох зэрэг нь бүгд арга, билигт багтдаг. Гэтэл тэд: “Надад арга ч байхгүй, билиг ч байхгүй. Арга, билгийг би аль хэдийн даван туулсан.” гэж ярьдаг.

Ингэж ярих нь бас буруу биш. Гэхдээ би та нарт хэлэхэд, бурхан бодьсатвад арга ч бий, билиг ч бий, тэд түүнээс

хэтийдээгүй, хэдийгээр тэд арга, билгийн дотор байдаг ч тэдэнд арга ч, бас билиг ч үгүй, ойлгож байна уу? Тэд арга болон билгийг бүгдийг нь огоорон орхисон гэсэн үг биш. Хэрвээ бүгдийг нь хаячихвал юу болж хувирах вэ? Бүгдийг хаячихвал бид яаж энэ махан биетэйгээ байж чадах вэ? Яаж хамаг төрөлтнийг гэтэлгэх вэ? Учир нь зарим төрөлтөнд арга хэрэгтэй байдаг, зарим төрөлтөнд билиг хэрэгтэй байдаг. Тиймээс бүгдийг нь хаячихаж болохгүй, миний санааг ойлгов уу? Багшид нь арга, билиг аль аль нь бий. Хэрвээ өөр зүйл шаардлагатай бол би бас дахиад илүүг нэмнэ. Тиймээс Багшийгаа энд ирвэл дандаа бурам шиг сайхан үг хэлнэ гэж бүү бодоорой. Энэ бол та нарын гэнэн цайлган бодол. Тийм байвал хамаг төрөлтнийг гэтэлгэж чадахгүй. Арга ч, билиг ч байж байж л сая төгс төгөлдөр болж чадна, хамаг төрөлтнийг гэтэлгэж чадна.

Яагаад арга, билиг аль аль нь байх ёстой вэ? Учир нь зарим хүнийг загнах хэрэгтэй, жишээ нь, бид эелдэг зөөлнөөр хэлбэл хүүхэд дороо ойлгож, даруй хийдэг. Гэтэл зарим хүнийг аашилж загнавал л хийнэ. Ойлгож байна уу? Ийм болохоор л арга ч, билиг ч хэрэгтэй, тийм биз? Эгэл хүмүүс хүртэл үр хүүхдээ хүмүүжүүлэхдээ арга, билгийг хослуулдаг байтал хүмүүсийг Гурван ертөнцийг даван туулахад сургахад арга, билгийг ашиглахгүй байж яаж болох вэ?

Орчлонд арга, билиг байгаа нь бидэнд хэрэглүүлэхийн төлөө юм, тийм биш бол тэр нь оршихгүй байх байсан, ойлгож байна уу? Энэ дэлхийд нэг ч хэрэгцээгүй зүйл, нэг ч муу зүйл гэж байдаггүй ч бид яаж ашиглахыг мэддэггүйн улмаас ач тусгүй, муу зүйл болж хувирдаг. Жишээлбэл, зарим хорт өвсийг эмч хоруу чанартайг нь мэдэвч өөр зүйлтэй хольж, тамир тэтгэх эм болгон найруулж, өвчин эмнэдэг, тэр нь хэдийгээр маш сайн эмийн ургамал мөн боловч хэтрүүлэн хэрэглэвэл хор болно, тийм биз?

Тиймээс хэт их, эсвэл хэт бага билиг байх нь сайн биш. Бидэнд арга болон билиг аль алин нь байж, хэзээ ч гэсэн хэрэглэж болж байвал сайн. Тэрнээс арга, билгийг бүгдийг нь хаях ёстой биш юм. Бүгдийг огоорвол хөндий хоосон болж хувирна, ямар ч хайрлан энэрэх сэтгэлгүй болно. Хайрлах сэтгэлгүй хүн яаж хамаг төрөлтнийг энэрэн нигүүлсэх вэ? Хэрвээ бясалгаад бүх зүйл “хов хоосон” болсон бол хүн танд зовлонгоо яривал та юу ч мэдрэхгүй бөгөөд бясалгаад ийм хэмжээнд хүрвэл буруу болно, бясалгасны хэрэг гарахгүй. Хэдийгээр танд ямар ч асуудал тохиолдоогүй байсан ч бусад хүнд асуудал бэрхшээл байдаг болохоор та

тэднийг өрөвдөн хайрлах хэрэгтэй. Өрөвдөх сэтгэлгүй бол бурхан болохын ч хэрэггүй. Хамаг төрөлтнийг гэтэлгэх ч шаардлагагүй. Ном тайлах бүр ч хэрэггүй. Энэ дэлхий дээр ийм байдлаар амьдраад юу хийх вэ? Ойлгож байна уу?

Гэхдээ энэ ертөнц бас тийм ч муу биш. Аль ч ертөнцөд үлдэж болно. Тамд ч очиж болно. Тэгвэл энэ тоост хорвоод яагаад үлдэж болохгүй байх билээ? Энэ дэлхий тун үзэсгэлэнтэй. Олон янзын төрөлтөн нь өөр өөр төрхтэй. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь бүгд хоорондоо адилгүй. Тэр ч байтугай хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй байсан ч харахад өөр байдаг нь үнэхээр сонирхолтой. Өдөр бүр хүмүүстэй уулзаж ярилцан цаг нөгцөөж болно, уул ус харан баясаж болно, сонирхолтой зүйл их. Тиймээс энэ дэлхий хэрэгцээгүй биш, харин тун сайн газар.

Орчлон ертөнцөд гарцаагүй нэгэн бүтээгч байдаг, учир нь аливаа зүйлсийг үүдэн бүтээх нэгэн хүн байх ёстой, ингэж байж л сая оршин тогтнож чадна. Тиймээс аливаа юмыг зохион бүтээдэг тусгай үйлдвэр заавал байх ёстой. Бидэнд ийм сайн бие махбод, ийм сайхан гараг дэлхий байна. Энэ нь хэн нэгний гараар бүтсэн зүйлгүйгээр яаж байх билээ? Тэр хүн нь магадгүй нэгэн зүйлийн хүч, эсвэл бидний сэтгэл байж магадгүй. Хэдийгээр бид үүнийг хараахан мэдэхгүй ч бүхэл бүтэн орчлон ертөнцийг бүтээж чадах ямар нэг зүйл заавал байх ёстой. Энэ дэлхийг харахад үнэхээр үзэсгэлэнтэй, янз бүрийн төрөлтөнтэй, модтой, чулуутай, цэцэгтэй, ургамалтай. Энэ бүхнийг бүтээсэн бүтээгчийн хүч заавал байх бөгөөд өчнөөн түм буман сая жилийн хугацаанд бүтээсэн байх ёстой, ойлгож байна уу?

Тэр хүч, эсвэл тэр хүний ажил тун их, маш завгүй, үнэхээр хичээнгүй ажиллаж, онцгой их билиг ухаан, төсөөлөн бодох хүчийг дайчлан байж ийм нэг сайхан гараг дэлхийг бүтээн та бидэнд эдлүүлжээ. Бид юу ч хийхгүй ч гэсэн жарган цэнгэж болно. Жишээ нь, өдөр бүр хүмүүстэй уулзахын тулд мөнгө үрэх шаардлага гардаггүй, уул ус харан баясахад бас мөнгө төлөхгүй, тэгэхлээр энэ дэлхийд муу тал байна уу?

Хэрвээ муу гэвэл бидний сэтгэл муу, сайныг саар болгон харах болсноос бүх зүйл үүдсэн хэрэг. Тиймээс хэдийгээр энэ дэлхий хичнээн сайхан байсан ч бид түүнийг эвдэн сүйтгэж, ой модыг дур зоргоороо тайрч огтолдог. Эсвэл хөдөө явган аялал хийж, зугаалсны дараа энд тэндгүй гялгар уут, хоосон шил, лааз хаяснаас тэр газар аажимдаа хогийн цэг болдог. Энэ бүхэн бидний буруу болохоос дэлхий муу байгаагийнх биш.

Дэлхий муу байгаа нь бүгд хүнээс болсон, тийм үү, үгүй юу? Угаас ямар ч асуудалгүй байв. Гэтэл нэг хүн уурлаж, нөгөө хүнийг хөнөөснөөр үр дүн нь муу болж хувирсан байна. Уг нь саяхан тун сайхан царай зүстэй байсан тэр хүн одоо үхдэл болон хувирч, улам бүр харлаж зэвхийрээд цус нь урсаж, нүд нь дээш гөлийн хөдлөх ч үгүй хэвтэнэ. Уг нь тэр их сайхан нүдтэй, өчигдөрхөн л хүний сэтгэлийг хөдөлгөж, харсан хүний хайрыг татаж байсан, гэтэл өнөөдөр үхээд нүд нь галгүй болжээ. Тэрээр төмөр, мод, ус, гал, шороон таван махбодын бие цогцсоо эвдүүлж, үзэшгүй муухай болж эхэлжээ.

Хөгшин хүн ч байсан биеэ сайхан арчилж, үсэндээ хими хийлгэн буржийлгаж, нүүрээ будан өөрийн “бяцхан ертөнц”-ийг нүдэнд илүү таатай харагдахаар болгож чадна. Настай хүмүүсийн зарим нь бас гэрлэдэг, энэ нь тэр гоё сайхан хэвээрээ байна гэсэн үг. Тэрээр хувцас өмсөхдөө ч толины өмнө өөрийгөө удтал шинжин сэтгэл ханамжтай болсны дараа л гадагш гардаг. Иймээс энэ дэлхий тун зугаатай, муугүй. Хэрвээ сайн биш байвал тэр нь хүмүүсээс л болсон хэрэг. Хэн нэгэн хүн муу муухайг үйлдвэл бусад нь гомддог, тийм биз дээ?

Жишээлбэл, нэгэн хүн бусдын эхнэрийг хөнөөж, аймаар үхдэл болговол эр нөхөр нь мэдээж маш их хорсож: “Миний эхнэр өчигдөрхөн ямар сайхан гоо үзэсгэлэнтэй хүн байлаа, гэтэл өнөөдөр ийм болов.” гэж бодно. Тэгээд хорссон сэтгэлээр нөгөө этгээдийг хөнөөнө. Түүний ах дүү нь бас сэтгэл төвдөлгүй ирээд нөгөө хүнийг хөнөөнө. Дараа нь алагдсан этгээдийн ах дүү нь эсрэг этгээдээ хөнөөнө. Ингэж харилцан хөнөөлдөж, өшөө хорслын гал хэзээ ч унтрахгүй үргэлжилнэ.

Өшөө хорслын үндэс нь ердөө л ганц хоёр хүнээс болж эхэлдэг бөгөөд тэд дэлхийг бусниулснаас дэлхий ертөнц муу газар болдог. Жишээлбэл, нэг хүний билиг тал хэтэрхий их бол уурлах дуртай байдаг. Үүнд нь бид эгдүүцэн маш их үзэн яддаг тул түүнтэй дайтаж, улмаар хөнөөнө. Тэр үеэс дэлхий ертөнц эмх замбараагүй болж, самуурч эхэлнэ. Ойлгож байна уу?

Ихэнх хүн билиг талын шинж чанар давамгай байхад дургүй, бүгд арга талын чанарт дуртай, тиймээс бид хүмүүсийн инээмсэглэж байхыг харах дуртай байдаг. Сая Багшийнх нь харсан тэр хүн билиг тал руу хэт хэлбийсэн мэт санагдсан, тиймээс түүнд “арга” талаа илүү их нэмбэл сайнсан гэж хэлсэн. Багш нь түүнд дургүйдээ биш, дуртай учраас бага ч гэсэн туслахыг хүссэн. Харин эгэл хүмүүс дургүй нь хүрвэл даруй түүнийг хорлохыг, тэр

ч байтугай хөнөөхийг боддог. Ойлгов уу?

Ихэнх хүн нэг хүн дэндүү хар бараан санагдвал жаахан цайвар өнгө нэмж, тэнцвэртэй болгохыг хүсэхгүй, харин бүрмөсөн арчиж хаяхыг боддог, түүнд дотоод сэтгэлээ засахад нь туслахыг боддоггүй.

Жишээлбэл, хувцасны маань ихэнх хэсэг нь бохирдсон байлаа гэхэд бид дэндүү залхуу, эсвэл тэвчээргүй бол тэр хувцсаа шатаачихна. Уг нь угаагаад хожим өмсөж болох байв. Угаагаад арилахгүй бол будаад өөр гоёмсог хувцас болгох, эсвэл тэр хэсэгт нь хэдэн цэцэг хатгаж, согогтой хувцсыг бүтээлч, цэцгийн хээтэй хувцас болгоод өмсөж болно.

Гэвч бидний ихэнх маань бүтээлч чадвараа ашиглахгүй, харин эвдэн сүйтгэгч чадвараа дэндүү их ашигладаг. Хэн нэгэн хүнд дургүй бол шууд хөнөөмөөр санагдана. Бусад хүн бидний арга барилд дургүй бол төвөг саад учруулна. Энэ бүхэн бидний санаа бодол сайн биш байгаатай холбоотой.

Бид зарим хүнийг муу хүн гэж боддог, гэтэл зарим хүн түүнд их сайн байдаг. Жишээлбэл, зарим хүүхэн харахаас зэвүүцэм, түүнд дуртай хүн байхгүй, гэтэл нөхөр нь түүнийг хүндэлж, хайрладаг. Тиймээс дургүй гэх шалтгаанаар хэн нэгнийг алж хөнөөх эрх бидэнд байхгүй, “Чи яаж ийм эхнэрийг тэвчиж чадаж байна аа, би чамд туслаад хороож өгье.” гэж болохгүй. Түүнийг хөнөөвөл нөхөр нь мэдээж таныг маш их үзэн ядна, тэгээд танаас өшөөгөө авна. Тэр үеэс эхлэн энэ дэлхий аятай сайхан байхаа болино.

Хэрвээ бид үргэлж баяр хөөртэй байвал юм бүхнээс сайн сайхныг мэдэрнэ. Муу муухай зүйл байсан ч сайн сайхан болно, учир нь муу муухай байгаа нь бидэнтэй холбоогүй, ойлгож байна уу? Тэр цагт л энэ дэлхий эмх замбараагүй биш болно. Арьяабалын бясалгалын аргыг дадуулсны дараа бид ч мөн баяр хөөртэй, эрх чөлөөтэй болж, юм бүхнийг хүлээн зөвшөөрч, юунд ч үл автана.

Тэр үед яагаад бидэнд юм бүхэн сайн сайхан, төгс төгөлдөр харагддаг вэ? Учир нь орчлонг бүтээгч их хүч нь аргыг ч бүтээдэг, билигийг ч бүтээдэг. Энэ нь түүний эрх мэдэл, энэ нь түүний дур сонирхол юм. Тиймээс бид хэн нэгэнд хичнээн дургүй байсан ч түүнийг эрх чөлөөтэй байлгах учиртай. Учир нь арга ч бай, билиг ч бай бүгд л бүтээгчээс үүдэлтэй. Ойлгов уу? Жишээлбэл, хүүхэлдэйн жүжигт нэг хүн ард нь зогсоод хоёр, гурван

хүүхэлдэйг тоглуулдаг. Хүүхэлдэйнүүд нэг нь ийшээ, нөгөө нь тийшээ үсэрч бүжиглэж байдаг, энэ бүхнийг ард байгаа тэр хүн хийж байгаа, харин хүүхэлдэй нь өөрөө харгис, эсвэл сайхан сэтгэлтэй байгаадаа биш. Бүх зүйлийг ар талд байгаа найруулагч хянаж удирдаж байдаг.

Киноны хувьд ч адилхан, тэр алдартай одод, жүжигчид ч үнэндээ жирийн хүмүүс бидэнтэй адилхан, тийм биз? Би өмнө нь кинонд тоглож байсан тул өөрийгөө тийм ч сайхан харагдахгүй гэдгээ мэднэ, би намхан туранхай, жижигхэн биетэй. Гэтэл тэд нүүр царайг маань хувирган будсаны дараа намайг би өөрөө ч танихааргүй болгосон, яг л хатан хаан болсон мэт санагдаж байв. Надад өөр хувцас өмсүүлж, нүүр хувиргасанд жийнсэн өмдтэй явдаг шигээ чөлөөтэй байж зүрхлэхгүй болсон. Тэр үед би Арьяабалын аргаар бясалгадаггүй байсан юм.

Нүүр хувиргасны дараа огт өөр хүн болсон мэт санагдсан. Энэ бол найруулагч намайг ийм үзэсгэлэнтэй болгон өөрчилж, бас тийм үзэсгэлэнтэй хүмүүстэй хамт бүжиглүүлснээс болсон хэрэг. Тэр үед би үзэсгэлэнтэй, эрхэмсэг бяцхан гүнж, хатагтай болж хувираад ханхүү, их түшмэлтэй хамт ёслолын дайллага хийв. Найруулагч яаж жүжиглэхийг заагаагүй ч би тийм орчинд аяндаа жүжиглэж байв. Учир нь тухайн орчин их өөр байсан, ойлгов уу? Хүмүүс бүгдээрээ маш гоё хувцаслаж, тун дэгжин эрхэмсэг байсан тул би аяндаа л яг тэдэн шиг болж өөрчлөгдсөн.

Зарим хүн гэнэт маш догшин хэрцгий болж хувирсан нь хувцаслалт, нүүрний будалтаас болсон хэрэг. Учир нь түүний нүүрэнд хар баг зүүж, харгис догшин харагдахуйц хувцаслан маш хэрцгий болгон хувиргасан. Тиймээс тайзан дээр эгэл жирийн нэг хүн нүүр будалтын дараа тэс өөр болж хувирдаг. Жишээ нь, таны найз жүжигчин бол нэн эртний хувцас хунар өмсөж, урт сахал зүүгээд нүүрээ хар, цагаанаар будвал та түүнийг бараг танихгүй, тийм биз? Учир нь тэр үед тэр маш харгис дүрд тоглосноос болж байгаа юм.

Энэ дэлхий ч мөн адил, арга, билиг аль аль нь бүтээгчийн бүтээл. Сайн хүн байгаа нь бүтээгчийн хүсэл, муу хүнийг ч бас бүтээгч тийм байлгахыг хүссэн, ойлгов уу? Өөрийнхөө дүрд тоглож дуусаад хувцсаа тайлж, будгаа арилгаад жирийн хүн болж хувирна. Санааг нь ойлгов уу?

Тиймээс бид билгийн талд ч их дурлах хэрэггүй, бас аргын талд ч хэт дурлах хэрэггүй. Гэхдээ одоо бид ийм байж чадахгүй

байна. Арьяабалын бясалгалын аргыг дадуулсны дараа бид арга, билгийг эрхшээж чадна. Тэр цагт л харин арга, билгийг ашиглаж болох юм. Арга, билгийн аль алинд захирагдахгүй. Одоо бол бид арга, билгийн эрхээр л байна. “Билиг” тийш хэлбийвэл тун ширүүн, ууртай, хүлцэж чадахааргүй болдог. “Арга” тийш хэлбийвэл аз жаргалтай, баяр хөөртэй болно.

Тэр нь өөрөө л ирдэг, бид ирүүлье гэхээр ирдэг юм биш. Бид арга, билгийг цүнхэндээ хадгалаад аргыг ашиглая гэвэл аргыг гаргаж ирээд билгийг хэрэглэе гэвэл билгийг гаргаж ирээд яг л мөнгө шиг дуртай үедээ хүссэн хэмжээгээрээ хэрэглээд байж чадахгүй.

Зарим хүн их мөнгөтэй ч мөнгөнийхөө боол болж, ганц зоос ч хэрэглэж зүрхлэхгүй, бүгдийг нь банкинд хадгална, эсвэл газарт булж, газар, усны эздээр мануулаад өөрөө ч хэрэглэж төвдөхгүй, аав, ээждээ ч зориулж чадахгүй байдаг.

Бидний нөхцөл байдал ч адилхан, хэрвээ бид арга, билгээ ашиглахгүй бол арга, билиг биднийг ашиглана, ойлгож байна уу? Тийм учраас бид биеэ барьж дийлэхгүй, уурлавал галзуурах шахна, дурлавал мөн л солиорох дөхнө. Хэн нэгнийг хайрлавал галзуурах мэт болно. Нэгэн бүсгүйд дурлаад солиорох шахдаг нь бүсгүйн сэтгэл хөдлөлд эрхшээгдсэнээс болдог ажээ.

Арьяабалын бясалгалын аргыг дадуулсны дараа бидэнд хэдийгээр баяр хөөр, уур хилэн, гуниг зовлон хэвээр байдаг ч хянаж чаддаг болно. Бясалгах тусам хянаж эрхшээх чадал нэмэгдэж, хорь, гуч, тавь, жаран хувь болдог. Энэ нь бидний бясалгалын дэс түвшнээс хамаарна. Бясалгал сайжирч дэвшихийн хэрээр хянаж эрхшээх хувь өснө. Арга, билгийг хяналтандаа бүрэн оруулж чадвал бид Бурханы хутагт хүрнэ.

Бурханы хутагт хүрнэ гэдэг нь тун сүрхий явдал ч биш, бас ер бусын биелэгдэшгүй явдал ч биш. Учир нь арга, билиг бидэнд угаасаа заяагдсан байдаг, ойлгож байна уу? Гаднаас хайж олоод ашиглах хэрэг биш. Бидний дотоодод юм бүхэн байдаг. Арга ч бий, билиг ч бий. Гол нь ашиглаж чадах нь чухал.

Одоо би та бүхэнд энгийн нэг зүйрлэлээр тайлбарлая, жишээлбэл, заримдаа эцэг, эх хүүхдүүддээ жинхэнээсээ уурладаггүй, харин чихэр жимс дэндүү их идээд шүд нь өвдөх вий гэж эмээснээс болж загнадаг, эсвэл гадаа их тоглоод хичээл номоо хийж амжихгүй болох вий гээд уурласан дүр үзүүлж, хонгыг нь хорсгодог. Зузаан гуян дээр нь алгавал гэмтэхгүй, зодуур даана,

жаахан хорсохоос цаашгүй.

Энд ер хүүхдийг дураараа зодож занчиж, уурласан юмгүй. Хэрвээ уурлаад зодсон бол биеэ захирч дийлэхгүй, харангуутаа шууд алгадаад авах байсан. Харин жинхэнээсээ уурлаагүй учраас хаана алгавал өвдөхгүй, гэмтэхгүй байх тухай бодоод тийм газар хайжээ.

Хэрвээ хүүхдийг өдөр бүр аргадаж, эрхлүүлээд байвал таны үгийг огт сонсохгүй болно. Тиймээс хэзээ нэгэн цагт түүнд хатуухан бясалгалын аргаар хандах хэрэг гарна. Хатуухан гэдэг нь хатуу зөөлний “хатуу”, мөн арга, билгийн “билиг”-ийн тал ч гэж хэлж болно, ойлгов уу?

Бурхан бодьсадвагийн хувьд ч адилхан, арга, билгийг бүгдийг нь орхино огоорно гэж байхгүй, түүнд юм бүхэн бий, учир нь хамаг төрөлтөн үй олон, тэдэнд өөр өөр бэлэг шаардлагатай. Хэрвээ бурхан бодьсадва юу ч үгүй хоосон байвал юугаа зарах вэ? Тиймээс арга, билгийг бүгдийг огоорч орхиж болохгүй. Жишээлбэл, нэгэн баян хүний гэр орон нь дутах юмгүй элбэг дэлбэг, хүссэн бүхнээ худалдаад авчихна. Хэдий тийм ч тэр хүн нэг том худалдааны зах нээжээ. Тэнд нь зарахгүй юм гэж үгүй, бүгд байна. Энэ бүхнийг тэр өөрөө хэрэглэх гээгүй. Тэр аль хэдийнээ маш баян болсон тул юугаар ч дутахгүй. Хэрэг гарвал хүмүүс түүнд худалдаж аваад хүргээд ирнэ. Харин тэр бусдын төлөө л энэ худалдааны төвийг нээсэн аж.

Яг үүн шиг, бурхан бодьсадва хамаг төрөлтнөөс ангид байж болохгүй, бурхны сэтгэл бол хамаг төрөлтний сэтгэл. Бодь сэтгэл бол нисваанис, нисваанис бол бодь сэтгэл. Гэхдээ бурхан бодьсадва нисваанисыг бодь сэтгэл болгон хувиргадаг. Ойлгов уу? Хэрвээ та бүхэн тийм хүн больё гэвэл Арьяабалын аргаар бясалгаж болно.

Арьяабалын аргаар бясалгавал ямар муу тал байдгийг би та нарт бүгдийг ярилаа. Сонголтоо өөрсдөө хийнэ биз ээ. Учир нь Арьяабалын аргаар бясалгахад сайн тал байхгүй, буян хишиг ч байхгүй, ид шид ч байхгүй, байсан ч хэрэглэж болохгүй. Бясалгалдаа дэвшье гэвэл шид ашиглаж болохгүй, Арьяабалын аргаар бясалгаж байгаа хүн шидийн хүчээр бусдын өвчнийг эмнэж ч болохгүй, юу ч байхгүй.

Тэгэхээр та нар одоо ч бясалгамаар байна уу? Бясалгах хүн хэд байна? (*Харьж гэрийнхээ асуудлыг зохицуулчихаад ирж бясалгана аа гэж нэг хүн хариулав.*) Битаныг гэрбүл, үр хүүхдээсээ

хөндийр, тэднийг бүү асар, бүү халамжил гэж хэлээгүй. Дэндүү тэнэг байна. За яахав! Бүгдээрээ бясалгах шаардлагагүй, та нар хараахан гэгээрээгүй байсаар байна. Бурхан бодьсатва ч хүртэл хүмүүсийг өөрчилж чадахгүй, тэдэнд нөлөөлж чадахгүй, тэгэхээр та нар яаж нөлөөлөх вэ дээ? Хүн бүхэн өөр өөрийн үйлийн үртэй, өөр өөрийн зам мөрөөр явдаг, ойлгов уу?

Шагжамуни Будда хамгийн энэрэнгүй, хамгийн сайхан сэтгэлтэй, гэтэл үеэл ах Девадатта нь түүнийг хорлож хөнөөхийг боддог байсан. Тийм болохоор та нар ч хүүхдэдээ яаж нөлөөлж чадах вэ? Ийм их би гэх үзэлтэй хүн яаж Арьяабалын аргаар бясалгах вэ? Бодох зүйл ихтэй бол бясалгах хэрэггүй.

Та нарыу ч бодохгүй, Багшдаа бүрэн итгэсэн цагт Багшийнхаа заасан бүхнийг дагаж чадна, зөвхөн тэр үедээ ирээрэй, миний санааг ойлгов уу? Одоо бол таны уяа хүлээс дэндүү их, ийм их би гэх үзэлтэй, түүнийгээ арилгаж чадахгүй. Цаг үргэлж ертөнцийн хэрэг явдлыг бодож, энэ ертөнц Багшаас илүү хэрэгцээтэй, үр хүүхэд Багшаас илүү, туулан гэтлэхээс илүү чухал байна. Тэгэхээр бясалгаад хэрэггүй, одоо бясалгахаар шийдсэн ч би таныг хүлээж авахгүй, ийм хүнийг шавиа болговол Багшид нь төвөг л болно.

Тийм ч учраас өчигдөр би та нарыг өвс хадуулахаар явуулаагүй юм, тэнд хүн болгоныг очуулдаггүй. Зөвхөн авшиг хүртсэн, олон жил ногоон хоол идсэн, маш сайн бясалгадаг, бие, хэл, сэтгэл нь ариун хүмүүс л очиж болно. Авшигтай хүн ч Багштай нь дураараа уулзахгүй, Багшид нь дураараа өргөл барьц өргөхгүй. Хэрвээ өргөл барьц өргөө гэвэл эхлээд өдөр бүр хичнээн цаг Арьяабалын аргаар бясалгаж суудаг, бясалгал дэвшсэн эсэхээ тодорхой хэлэх ёстой.

Авшиг хүртээгүй хүмүүс Багштайгаа уулзах нь мөн л адилхан. Багш нь дэндүү өгөөмөр, тиймээс та бүхэн энд ирэх, Багштайгаа уулзах, Багшаасаа суралцах, суралцахгүй энэ бүгдийг өөрийн дураар шийддэг. Хараахан авшиг хүртээгүй учир та нар зөвхөн ном тайлах үеэр л ирдэг. Тэгэхээр энэ нь түр зуур шавилж байгаа хэрэг. Тиймээс би та нарт жаахан өгөөмөр ханддаг. Өөрийн шавь нарт бол харин нилээд хатуу чанга хандана. Одоо та хүүхдээ бодоод хожим ирж бясалгая гэж байна. Тэгвэл та бодох ч шаардлагагүй, бясалгах ч хэрэггүй, харьж үр хүүхдээ асарсан нь дээр гэж зөвлөө.

Бид төрөл төрөлдөө их олон хүүхэдтэй байсан, дараа төрөлдөө бас олон хүүхэд өсгөх байх, одоо байгаагаас ч илүү

олон байж магадгүй. Төрүүлж өсгөх хүүхэд олдохгүй гэж бүү зов, харин Их Багштай уулзаж чадахгүйд л зовбол зохино.

Төрөл төрөлд үр хүүхдээр дутахгүй, өөр олон олон авлагын эзэн бидний үр хүүхэд болж, бид тэдэнд цаг зав, хөрөнгө мөнгө, хүч чадлаа зориулан үйлийн үрийн өр төлөөсөө төлж дуустлаа халамжлан өсгөнө. Магадгүй тэдний зарим нь их эрт, дөрөв, зургаа, арван насандаа явчихдаг. Тэр үед бид хүү минь явчихлаа гэж ихэд шаналан уйлдаг. Уг нь бол “Миний авлагын эзэн явчихлаа. Одоо би эрх чөлөөтэй болов. Үйлийн үрээ ийм хурдан төлж дуусгах боломж олгосон бурхан бодьсадвад талархлаа.” гэж баярлавал зохилтой.

Гэвч манай энэ дэлхийд бүх зүйлийн хөл, толгой нь солигдож, хамгийн чухал явдал хэрэггүйд тооцогдож, хамгийн хэрэггүй зүйл нэн эрхэм чухал болжээ. Тиймээс бид эхнэр, нөхөр, үр хүүхдээ хамгийн чухалд үздэг. Энэ нь тэднийг үл тоомсорлоно гэсэн үг биш юм, бид тэднийг асарч халамжлах ёстой, учир нь тэдэнд төлөх урьдын өр төлөөс бидэнд байгаа, одоо бүгдийг төлж барагдуулах хэрэгтэй нь мэдээж. Үүнийг төлөхдөө уурлаж бухимдах хэрэггүй, ойлгов уу? Гэхдээ тэд бол бидний хамгийн гол, хамгийн чухал зорилго биш, хэрвээ энэ нь бидний хамгийн дээд зорилго болчих аваас хөл толгой нь солигдсон алдаа болно.

Бид яагаад төрөл төрөлдөө үхэж, төрөх сансрын хүрдэнд эргэлдэн тэдний дотуур хувцас, оймсыг угааж, мөнгө олж, тэднийг өнөөдрийг хүртэл тэжээж, бас ихэд хайрлаж, сэтгэл хоргодон байдгийн шалтгаан нь энэ үнэн ёс учрыг мэдэхгүйгээс болж байгаа юм. Ойлгож мэдээгүй нь “мунхагийн харанхуй”, ухаарч ойлгосон нь “бурхан”, ялгахад ядах юмгүй.

Бурхан хамаг төрөлтнөөс ялгаагүй, нэг талаар хамаг төрөлтөн, нөгөө талаар бурхан. Хамаг төрөлтөн угаасаа бурхан, бурхан гэдгээ л мэдээгүй яваа юм. Ханхүү багадаа хааны хүү гэдгээ мэдэхгүй байснаа том болоод ойлгодогтой адилхан, ойлгов уу?

Та нар яагаад ингэж их инээлдэв? Дараа энэ ертөнцөд дахин төрөл авч ирээд дотуур хувцас угаах дургүй байна уу? Нарийн ажвал хүний амьдрал яг л илжигнийх шиг болохыг ойлгоно доо. Өөрийгөө ч зовж зүдрэн тэжээж байгаа атлаа эхнэр, хүүхэд гэнэ, яг л илжиг шиг, өөрийн идэх өвсийг олно, бас бусдын өгсөн ачааг үүрэх тул ачаа дарамт их. Үхэр, адуу ч адилхан, тэд ийм том, хүнд тэрэг чирэх болдог, ойлгов уу?

Хэрвээ Багшийнхаа ярьж буй ёс учрыг сонсоод ойлгосон, сэтгэлд тань нийцсэн бол энд үлдэж болно. Өмнө нь Багш нь авшгийг нилээн чөлөөтэй хүртээж байсан. Харин одоо илүү хатуу чанга байх хэрэгтэй боллоо, учир нь цөөнгүй хүн эрхэм хүн байж чадалгүй, хэлсэн үгэндээ хүрээгүй. Тэд Дээдийн Ном сурахын төлөө бус, ном хулгайлахын төлөө ирсэн байжээ. Номын ёсонд суралцах үедээ Багшдаа насан турш ногоон хоолтон байж чадна гэж амласан ч гэртээ хариад мах идэх болжээ. Ингэж болохгүй, мах идвэл маш хүнд үйлийн үрийн өр төлөөсөнд унаж, туулан гэтэлж чадахгүй болно.

Багш нь дэндүү өгөөмөр байж болохгүй. Одоо заавал тэднээр андгай тангараг өргүүлдэг болсон. Урьд нь Газрын зүрхэн бодьсадва тангарагласан шиг. Ингэвээс тэд эрхэмлэн нандигнана. Зарим шашны бүлэг шавь нараа тангараглахыг шаарддаг тухай сонссон. Жишээ нь, төрөл төрөлдөө үргэлж хамт байна гэх зэргээр. Би тийм ч их зүйл шаардахгүй. Энэ нэг насаараа байхад л хангалттай. Яах гэж төрөл төрөлдөө салахгүй явах вэ? Энэ төрөлдөө л салахгүй явбал болно. Хожим дээд түвшинд очоод эргэж ирэхгүй болно. Багштайгаа үргэлж зууралдах шаардлагагүй. Тиймээс төрөл төрөлдөө хамт байна гэж болохгүй. Та нар эртхэн салах нь хамгийн сайн, хурдхан их багш болж, эрх чөлөөт хүн болно. Төрөл төрөлдөө Багштайгаа зууралдах хэрэггүй, та нар тэгэхийг хүссэн байлаа ч би дургүй.

Хүнтэй зууралдах нь их зовлонтой, шавь нар ирж зууралдвал бүр ядаргаатай. Учир нь тэдний үйл түйтгэр над руу шилждэг. Хааяа Багш нь зарим үйл түйтгэрийг хүлээж авахгүй байх сонголт хийдэг. Гэтэл тэдний тэгж их зовж зүдрэхийг хараад сэтгэл төвдөхгүй, өмнөөс нь авчихдаг. Ойлгов уу? Тиймээс шавь нартай зууралдах нь үнэхээр ядаргаатай.

Хүмүүсийн ихэнх нь их сул дорой, энийг ч, тэрийг ч сурахыг хүсдэг хэрнээ нэгийг нь ч үргэлжлүүлэн сурч, бүрэн эзэмшдэггүй. Жишээ нь, өмнө нь анагаахын шинжлэх ухаанд суралцан эмч болоод өвчтэй хүнийг зовлонгоос нь аврахыг хүссэн ч ганц хоёрхон жил суралцаад ихэд ядарсан шиг санагдахаараа, “Тэд өвдөх нь тэдний хэрэг, энд би ингэж зүдрэх хэрэг байна уу.” гэж бодно. Тэр үед түүний дэс нь яг тэндээ үүрд гацдаг.

Бясалгагч хүн ч адилхан, авшиг хүртэх амархан, багшийгаа олчихвол авшиг хүртэж чадна. Гэгээрэх ч бас хамгийн хялбар явдал, Төгс Гэгээрсэн Их Багшийг олж чадвал гэгээрч чадна. Гэхдээ бид гэгээрлээ үргэлжлүүлж чадахгүйгээсээ санаа зовдог,

“гэгээрэл”-ээ хөгцрүүлээд өдөр бүр тордохгүй байх нь хамгийн ноцтой асуудал.

Заавал сахих ёстой сахилуудаа үл тоомсорлож, өнөөдөр Багшаасаа авшиг хүртэхийг хүсвэл яаруу сандруу ирээд би гарцаагүй ногоон хоолтон байна, асуудалгүй хэмээн амална. Гэртээ харивал эхнэр нь ногоон хоол хийж өгөхгүй бол тэр даруй мах идэх шалтаг болгоно. Хэрвээ танд тууштай сэтгэл байвал эхнэр, аав, ээж аль аль нь ч хорьж дийлэхгүй. Хүмүүс бид хэл яриатай, хэдийгээр үг яриа хүч муутай ч ядаж ойлголцох хэрэгсэл болгон тэдэнтэй хүндэтгэлтэй, эелдэг боловч эрс шийдэмгий өнгө аясаар ярилцах хэрэгтэй. Өнөөдөр ярихад тэд хүлээж авахгүй бол маргааш дахиад ярилцах хэрэгтэй.

Аав, ээж тань хор өгвөл хор ууж, мах ид гэвэл Багшийнхаа зааврыг тэр дороо мартан мах идэх нь тэдэнд ачлалтай байгаа хэрэг огт биш. Үнэндээ бол та нарын мах идэх эсэх нь надад ямар ч хамаагүй. Гэвч хамаг төрөлтөн нэгэн бурхан болоод ирж аврахыг тань хүлээж байдаг юм. Тун олон гахай, тахиа, адуу, үхэр гэх зэргийн амьтан биднийг ногоон хоолтон болж, тэднийг олон жилээр амьдруулахыг хүсэн хүлээж байгаа. Хэрвээ хүн төрөлхтөн бүгд ногоон хоолтон болбол маш олон амьтан баярлана. Тэд баярлаад дуулан бүжиглэнэ. Биднийг хайрлана. Хаана ч очсон тэд бидэнд дуртайяа ойртон ирнэ. Бас бидэнд дасаж хоргодоно, ойлгов уу? Энэ бол Арьяабалын аргаар бясалгал дадуулдаг хүний “сэтгэлийн амар амгалангийн өглөг” юм. Хамаг төрөлтнийг айлгаж зовоохгүй.

“Сэтгэлийн амар амгалангийн өглөг” гэж юу вэ? Айдас хүйдэсгүй байлгах өглөгийг хэлнэ. Бид айдасгүй байлгах өглөгөөр хамаг төрөлтний сэтгэлийг тайтгаруулж, “Та нар зовох хэрэггүй ээ, өнөөдрөөс эхлэн би та нарыг идэхгүй тул та нар урт наслах болно.” гэж тайвшруулдаг. Хэрвээ бид өөрөө үхэлгүй мөнх наслах хүсэлтэй мөртлөө хамаг төрөлтнийг идэхийн тулд алах нь зөв гэж үздэг бол энэ нь үйл, үрийн хуулийг зөрчсөн явдал биш гэж үү? Ямар үйл байна, тийм үр байна, бид богино наслах үйл хийгээд хэрхэн урт наслах үрийг олж чадах вэ?

Хэрвээ үхэлгүй мөнхрөхийг хүсвэл Арьяабалын аргаар бясалгах хэрэгтэй. Мэдээж махан биеэр мөнх наслах биш, учир нь энэ махан бие чухал биш. Бидэнд маш үзэсгэлэнтэй, нэн таатай, өөрийн болгоход илүү тохиромжтой өөр биес байдаг. Тэр бие маань бидний өсөлт хөгжилт болон арчлахад зохистой. Гагцхүү түүнийгээ нандигнаж байж л үхэлгүй мөнх байж чадна.

Энэ махан бие бол зөвхөн нэг хувцас төдий, хэсэг хугацааны дараа тайлах хэрэгтэй болдог. Энэ хувцсаа тайлсны дараа л бид сая жинхэнээр эрх чөлөөг олно, тиймээс махан биед хоргодох хэрэггүй.

Жишээ нь, хоригдол хүн хэдэн арван жил гавтай, эсвэл хүзүүндээ дөнгөтэй яваад дасчихсан байдаг. Хэрвээ хэн нэгэн хүн түүнд “Та эрх чөлөөтэй боллоо. Харьж болно. Одоо энэ дөнгийг тайлж хая.” гэж хэлбэл тэр хоригдолд хачирхалтай санагдах нь мэдээж. Тэр үргэлж, “Олон арван жил болоод би дасчихжээ. Одоо гэнэт дөнгөгүй болчихоор би яах ёстой вэ?” гэж бодно.

Заримдаа ялтан хүн тас харанхуй өрөөнд удаан хугацаагаар хоригдоод гадаа гарангуут нарны гэрэлд нүд нь гялбаж, хараа нь нэг, хоёр хоног бүрэлзэнэ. Тиймээс хэрвээ ялтан хүн их удаан хоригдсон бол суллагахаас нь өмнө өөр газарт тодорхой хугацаанд байлгаж дасгаад дараа нь явуулах хэрэгтэй. Тийм биз? Тэрээр нэг жижигхэн өрөөнд амьдарч дассан тул гаднах ертөнцийн эрээнтэй бараантай их амьдрал дунд ороод айх болно. Багш нь тоглож байгаа юм биш, энэ бол сэтгэл зүйн асуудал учраас тийм ч амаргүй.

Үүн шиг, авшиг хүртэх нь бидэнд асуудалгүй, гэгээрэх ч бас асуудалгүй, Их Багштай л бол гэгээрч чадна. Асуудлын гол нь эрх чөлөөт нөхцөл байдалд та дасаж чадах эсэх нь юм. Зарим хүн өөрийгөө гэмтэн гэж бодсон хэвээр байдаг. Хэдийгээр эрх чөлөөтэй болоод удаж байгаа ч өөрийгөө эрх чөлөөтэй нэгэн болсон гэдэгт бас л итгэж чадахгүй, урьдын адил айдастай, өөрийгөө дорд үзэх мэдрэмж нь хэвээрээ, бусад хүн түүнд сайн хандвал муу хандаж байна, эсвэл дорд үзэж байна гэж бодно.

Өчигдөр Багш нь нэг хоригдол байсан хүнтэй таарсан. Тэр урьд нь их олон амьтны амь хөнөөсөн тул уг нь насаараа хоригдох ял авсан гэж ярьсан. Шоронд ороод хожим бясалгах болжээ. Одоо тэр хэдийгээр суллагаж, эрх чөлөөтэй хүн болсон ч хүмүүс түүнд муу ханддаг гэж бодсон хэвээр, мөн хүмүүс түүнтэй “хоригдол хүн шиг харилцдаг” гэж үргэлж боддог байна.

Үнэндээ бол энэ нь тэр хүн зүрх сэтгэлдээ аз жаргалгүй, айдастай, өөрийгөө доогуур үнэлдгээс болж байгаа юм. Нийгэм даяараа түүнийг гадуурхаж, таагүй хандаад байгаа юм биш. Тэр бас эхнэр, хүүхэдтэй. Эхнэр нь түүнд хайртай. Хэрвээ хайргүй байсан бол юу гэж түүнтэй гэрлэж, хүүхдийг нь төрүүлэх билээ? Тэр бас өөр олон найз нөхөдтэй. Тэд байнга түүнийг дагуулан

хоолонд ордог. Өвдвөл ирж, дэргэд нь байж тайтгаруулна. Түүнд хайргүй гэж яаж хэлж болох билээ? Гэвч түүний сэтгэл зүрх нь өөрийгөө уучилж чадахгүй байгаа ажээ.

Үүнтэй адилхан, гэгээрэхэд ямар ч асуудалгүй, та бүхэн Их Багшаас авшиг хүртмэгцээ өөрийн харанхуй мунхагийн ачааг тэр даруй буулгаж чадах эсэх нь л асуудал. Тэр ачааг өдөржин хүзүүндээ зүүгээд явах биш, ойлгов уу? Багш нь өнөөдөр та гэгээрсэн гэж хэлсэн. Үүнийг хэлэхэд заавал үг хэл хэрэггүй. Та нар өөрсдөө ч бас гэгээрлийн ахуй ойлголттой болоод тэр даруйдаа нотолгоотой болсон.

Гэвч та нар итгэхгүй байж магадгүй, тэгээд гэртээ хариад өдөр бүр мунхагийн ачаагаа тэвэрч, дэрлээд унтана. Авшиг хүртэх үеийн гэгээрлийн нөхцөл байдлаа мартаж, өөрийн Бурхан чанараа мартаж орхидог. Түүнийгээ арчиж зүлгээгүй төдийгүй, бүр хөгцрүүлж муудуулаад өдөр бүр мунхагийн харанхуйн ачаагаа л зүлгэж суудаг. Үргэлжлүүлэн бясалгахгүй, эрдэнийн сувдаа нандигнахгүй, түүнийг барьж үзэхгүй, түүнийгээ угааж цэвэрлэхгүй, нэг буланд шидэж орхиод харин өдөр бүр чулуугаар тоглож явна.

Хүүхдүүд ихэвчлэн шаврыг жигнэмэг, модны навчийг мөнгө болгон тоглодог гэдгийг та нар мэднэ биз дээ? Хэрвээ энэ бүхнийг өгөхгүй бол тэд баяр хөөргүй болно. “Энэ чинь жинхэнэ мөнгө биш ээ, хариад ээж нь чамд жинхэнэ мөнгө өгье.” гэж хэлсэн ч тэр үед хүүхэд тоглож наадаад тун их баяр хөөртэй байх тул жигнэмэг авч идээрэй гэж ээжийнхээ өгсөн жинхэнэ мөнгийг халаасандаа хийчихээд хуурамч жигнэмэгээр л тоглоод байдаг, ойлгов уу?

Мэдээж түүнд өгөх мөнгө аав, ээжид нь байгаа, бас жинхэнэ жигнэмэг авч өгч чадна. Харин хүүхэд нь тэрийг хэрэглэж чадах уу, эсвэл хэрэглэхийг хүсэж байна уу,гүй юу гэдэг нь асуудал. Зүгээр л халаасандаа хийгээд мартчихаж ч мэднэ, хоёр, гурав хонуулбал тэр нь муудна, ойлгов уу?

Үүнтэй адилаар, бид маш хурдан гэгээрдэг, энэ бол үнэн, гэгээрэх хамгийн амархан, миний харснаар энэ дэлхий дээр гэгээрэх шиг амархан зүйл байхгүй. Би дэлхийн олон газраар явсан, бараг гуч гаруй орноор аялжээ. Ер нь юм худалдаж авах хүртэл амаргүй шүү дээ. Зарим нэг авсан хүнс таалагдахгүй, идэж чадахгүй, өөрийг авъя гэвэл заавал хэд хоног хүлээнэ. Ихэнхдээ бид ямар нэг зүйл авахыг хүсвэл эхлээд мөнгө олохын тулд шаргуу ажиллах болдог. Мөнгөө жаахан хуримтлуулбал хэрэгцээтэй

зүйлээ авч чадна. Гэсэн ч авсан эд нь сэтгэлд хүрэхгүй ч байж болно. Учир нь юмс гаднаасаа сайхан харагдавч доторх нь хэрэгцээгүй байх нь бий.

Сэтгэлдээ нийцсэн нэг аятайхан хувцас өмсөе гэвэл эхлээд заавал мөнгөө цуглуулж байж, бөс даавуу худалдаж авна. Тэгээд бас нилээн удаан хүлээсний эцэст оёдолчинд зав гарвал оёж өгдөг. Тэрээр хоёр долоо хоногийн дотор амжуулна гэж амлах боловч гурван долоо хоногийн дараа утасдахад бас л оёж дуусаагүй байдаг.

Бид гаднаас юм худалдаж авахад амаргүй, мөнгө нь байсан ч адилхан, эсвэл тэр газар уг зүйл байхгүй байна. Бид нилээд хэдэн дэлгүүрээр явж байж сая нэг сэтгэлд нийцэх зүйлээ олж авна, тэгэхээр юм худалдаж авах ч гэгээрэх шиг тийм хурдан, тийм амархан биш байх нь. Гэгээрэх бол энэ дэлхий дээрх хамгийн хялбархан зүйл. Харин цааш нь үргэлжлүүлэн хөгжүүлж, улам гэгээрч, өөрийн Бурхан чанараа үргэлжлүүлэн ойлгох явдал л цорын ганц хэцүү зүйл нь юм. Хүмүүсийн ихэнх нь Бурхан чанараа дөнгөж жаахан танив уу, үгүй юу, хөгцрүүлэн муудуулдаг. Авшиг хүртчихвэл боллоо гэдэг бол буруу бодол. Та нар авшиг авахаасаа өмнө түүнийг хэрхэн ихэд нандигнах учиртайг мэдсэн байх ёстой.

Авшиг хүртэхээсээ өмнө эхлээд заавал: Би энд ямар зорилготой ирсэн билээ? Гэтлэгдэх гэж ирсэн үү, эсвэл зугаацах гэж ирсэн үү? Эсвэл сонирхож, Багш ямар бясалгалын арга заадгийг мэдэх гэж ирсэн үү? Багшийн сургадаг бясалгалын арга бусдынхаас өөр, дэс түвшин нь ч адилгүй гэж сонссон тул дэнсэлж үзье, Багшийн дэс ер нь хаана хүрсэн юм бол гэх мэтээр өөрөөсөө тодорхой сайн асуух хэрэгтэй.

Та нар дэнсэлж чадахгүй, та нарт дэнслэгдэх газар Багшид нь байхгүй, хэрвээ хүн юу ч үгүй бол та нар яаж дэнслэх вэ? Дэс түвшингүй бол юутай, хэрхэн харьцуулах вэ? Ойлгож байна уу? Багшид нь ямар ч дэс байхгүй, мөн ямар ч билиг ухаан байхгүй. Энэ тухай би сая тун тодорхой ярьсан, Багш нь маш их билиг ухаантай, эсвэл өөрийгөө их билгүүн ухаантан гэх мэтээр дөвийлгөн яриагүй. Зарим хүн өөрийгөө “их эрдэм мэдлэгтэй хүн” гэж нэрлэдэг. Гэвч Багш нь огтхон ч тийм их, тийм том биш, тиймээс та нар Багшийгаа нэрлэх үедээ “их биш Их Багш”, “билиг ухаангүй Их Багш”, эсвэл “нэр үгүй Их Багш” гэж нэрлэж болно.

Нэр үгүй гэдгийн “үгүй” гэдэг нь юу ч байхгүй, “нэр” гэдэг нь нэр алдар гэсэн үг. Нэр үгүй гэдэг нь нэр байхгүй гэсэн үг

биш, гэхдээ бас нэр үгүй гэж хэлж болно. Энэ тохиолдолд мэдээж дэнсэлж болохгүй. Учир нь дэс байвал л дэнсэлж болно, нэгэн газарт байж, тэр нь эргэн тойрон хил хязгаартай бол дэнсэлж болно. Өөртөө юу байгааг Багш нь мэдэхгүй, надад үнэхээр ямар ч билиг ухаан байхгүй.

Та нар Багштайгаа ирж уулзах бүртээ өөрсдийн “бэлэг”-ээ авч ирдэг. Зарим хүний бэлэг нилээн цайвар, заримынх нь хар бараан, зарим хүнийх овоо амттай, заримынх нь их гашуун, зарим хүнийх нилээн том, заримынх нь жижигхэн байдаг. Ямар байх нь хамаагүй, бүгд л Багшдаа өгсөн бэлэг. Багш нь та нарын өгсөн бэлгэнд үндэслэж, хувь барилдлагын дагуу тусгаж, та нарт харуулдаг. Тиймээс ном тайлахыг сонсохоор ирсэн зарим хүн зөвхөн энэ хэсгийг ойлгоно, зарим нь тэр хэсгийг нь ойлгоно, эсвэл зөвхөн нэг хэсгийг нь л сонсох төдий байдаг, буцаж харьсныхаа дараа зөвхөн тэр хэсгээ санаад бусад бүх зүйлийг мартдаг. Ойлгов уу?

Учир нь та нар тэр тийм бэлгийг авчирсан болохоор, дараа нь дахиад аваад явдаг. Багш нь зөвхөн та нарт нээж харуулсан төдий, Багшид нь юу ч байхгүй, яг л нэг толь шиг, хэрвээ толийг энд тавибал явж өнгөрсөн хүн бүхэн мөн чанараа харна, нүүр царайгаа ямар янзтайг харна, тэр толь үг ярьдаггүй бөгөөд хүн болгонд өөр өөрөөр харагдана, бид ямар байна, тэрийг л тусгаж харуулдаг.

Ном тайлахын өмнө би юу ярихаа мэддэггүй, тайлсныхаа дараа дөнгөж сая юу ярьснаа бас санахгүй байдаг. Та нар магад итгэхгүй байх. Гэвч бодит байдал ийм байдаг. Би хятад бичиг мэдэхгүй учраас шавь нар “Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр” ботийг ном болгон хэвлүүлэхэд дотор нь юу бичигдсэнийг ер мэдэхгүй байсан. Тэд хэдийгээр надад хэд хэдэн удаа уншиж өгсөн боловч унших бүрт надад цоо шинээр уншиж байх шиг санагдаж байв. Би бүр нэг хүнд: “Энэ тун дажгүй ярьсан байна шүү, Багш яаж ингэж ярьж чадаж байна вэ?” гэж хэлсэн удаатай. Учир нь Багшид нь “оршмоор орон байдаггүй”, тиймээс надад билиг ухаан байхгүй. Арьяабалын аргаар бясалгавал их билиг ухаантай болно гэж та нар бүү бод. Эхэн үедээ болж магадгүй ч хожим нь алга болж, билиг ухаан гээгдэнэ. Учир нь та Бурханы хутагт хүрсэн ч өөрийгөө бурхан гэдгээ мэдэхгүй, бас мэдэх арга ч байхгүй. Хэрвээ хэн нэгэн хүн танд “Та бол Будда” гэж хэлвэл та үүнийгээ бага зэрэг санаж, “Будда магадгүй ийм байдаг байх” гэж бодох байх.

Өчигдөр Багш нь Иланаас ирэхдээ их оройтсон, бараг шөнө дундаас хойно ирсэн байх. Тэр цаг уг нь өлөн чөтгөрүүд хооллодог цаг юм. Хэдий тийм ч уулын замаар явсан болохоор гэдэс маань жаахан эвгүйрхсэн, тэгээд буцаж ирэх үедээ өлссөн байв. Одоо яах вэ?

Би өлөн чөтгөрийн явдлыг тоосонгүй, өлссөн тул юм олж идэх хэрэгтэй байлаа. Багш өлсвөл их иддэг гэж та нар боддог байх, тийм үү? Үнэндээ би ганц хоёр үмхээд л дуршилгүй болж, дахиж идэх хүсэлгүй болчихдог.

Тэр үед өөртөө жаахан идэх дуршил төрүүлэх санаатай яншуй нэмсэн боловч багадаад дахин очиж авав. Би гал тогооноос яншуй авахаар явах үедээ гэнэт зог тусаж: Энэ нь бурхны амьдрал мөн үү гэж бодсон. Учир нь олон хүн Багшийг нь Будда гэдэг. Гэвч би ихэд гайхаж, Будда яаж ийм байхав дээ? Өглөө үүрээр нэг хоёр цагт ирээд өлсөж, идэх яншуй хайж байна. Энэ нь нилээд хачин жигтэй Будда шиг санагдав, хожим та нар: “Наму хачин жигтэй Будда” гэж уншиж тун магадгүй. (*Бүгд инээлдэв.*)

Тэгэхэд надад их л хачин санагдаж байсан, гэхдээ тийм хачин ч бас биш, гэхдээ тэр мэдрэмжийг үгээр илэрхийлэхийн аргагүй.

Би дэргэд байсан шавиасаа : “Буддагийн амьдрал нээрээ ийм байдаг юм болов уу” гэж асуухад тэр: “Тийм ээ! Энэ бол Буддагийн амьдрал.” гэсэн тэнэгдүүхэн хариу хэлж билээ.

Учир нь түүний хувьд Багш нь юу ч ярьсан бүгд зөв, Багш нь юу ч хийсэн бүгд сайн, тиймээс ийм байвал Будда мөн гэж тэр итгэдэг. Тэр намайг тайвшруулж: “Та бол жинхэнэ Будда мөн. Учир нь өнөөдөр тантай таарсан хүн хөнөөсөн гэмт хэрэгтэн таныг хараад л сэтгэл нь хөдөлж, бас гэгээрч чадсан.” гэв.

Гэвч би ямар ч “Будда”-гийн явдлыг мэдрэхгүй, ямар ч Будда байхгүй байв, ойлгов уу? Би бэлэн гоймон идмээр байхаар нь идээд орхитол ямар ч “Будда” идэж байгаа юм шиг санагдсангүй, зүгээр л идэж орхив.

Хэрвээ та нар иймэрхүү нөхцөл байдлаас эмээж байгаа бол Арьяабалын бясалгалын аргыг дадуулах хэрэггүй. Учир нь бясалгасны дараа өөрийгөө хэн болохоо мэдэхээ болино. Хүн танд, “Та бол Будда мөн.” гэж хэлсэн ч та мэдэхгүй, урьдынхтайгаа адилхан хэвээрээ байх шиг санагдана. Хэрвээ хэн нэгэн хүн танд одоо, “Та бол Будда мөн.” гэж хэлбэл та түүнд: “Та тоглоод байна уу?” гэж хэлэх нь гарцаагүй. Тэр ч байтугай Багш нь та нарт:

“Та нар бүгд Будда мөн.” гэж хэллээ гэж бодоход та нар бас л итгэхгүй, жаахан ойлгосон ч бүрэн дүүрэн итгэж чадахгүй. Ийм байдаг, тийм үү? Өөрийгөө Будда гэдэгт бүрэн дүүрэн итгэдэг хүн байна уу? Хэрвээ байвал та босоод зогсоно уу, би танд нэг ёслоё! (Бүгд инээлдэв.)

Та бүхэн Арьяабалын аргаар бясалгахад бас л адилхан. Хүмүүс таныг шүтэж, “амьд Будда” гэж дуудна, гэвч та юу ч мэдрэхгүй. Та итгэхгүй биш, бас итгэх биш, мэдэхгүй биш, бас мэдэх ч биш, тийм л болно.

Бодьдарма Лиан Үди хаантай очиж уулзахад Лиан Үди хаан Түүнийг өөрийг нь ийм ч сүрхий, тийм ч сайн, хязгааргүй их ач буянтай гэх мэтээр магтана гэж бодож байсныг та нар санаж байна уу? Эцэст нь Тэр юуг ч магтан сайшаасангүй, Лиан Үди хаанд: “Сүм хийд барих, хуврагийн чуулганд өргөл өргөхийн аль нь ч ач буянгүй.” гэдгийг л хэлсэн аж. Тэгэхэд Лиан Үди хаан ихэд уурлаж, Түүнээс: “Та хэн бэ?” гэж асуужээ. Лиан Үди хаан магадгүй “Би хэн бэ?” гэдэг коан-ном хаялцааныг дадуулдаг байсан байх. Тэгээд Бодьдармагаас: “Та хэн бэ?” гэж асуухад: “Би мэдэхгүй.” гэж хариулжээ. Тэр үед Тэрээр хэт их бясалгаад бүхнийг мартан тэнэг болж, өөрийгөө хэн болохыг ч мартсан байж магадгүй.

Бодьдарма түүнийг хуурч мэхлээгүй, түүнтэй тоглоом наадам хийгээгүй, хариулахаас залхуурсан ч биш юм, хувраг хүн худал ярьж болохгүй. Тэр үнэхээр мэдэхгүй байсан учраас л мэдэхгүй гэж хариулсан хэрэг. Тэр үед Лиан Үди хаан “мэдэхгүй”-н тэр дэсийг ойлгож чадаагүй тул Түүнийг эгэл хүн юм байна гэж бодоод үдэж явуулжээ. Бодьдармааг явсны дараа Лиан Үди хаан хүмүүсээс “мэдэхгүй” гэх энэ хүн үнэндээ хэн бэ гэдгийг асууж батлахыг хүсэхэд бусад хүн түүнд: Та мэдэхгүй гэж үү ? Тэр бол машид гэгээрсэн хүн байна гэж хэлэв.

Тэгэхэд л Лиан Үди хаан сая харамсаж, даруй Түүний араас нэхэж очих хүн томилжээ. Бусад хүн түүнд: “Одоо та түүний араас нэхээд нэмэргүй, Тэр эргэж ирэхгүй. Бүх дэлхий даяараа Түүнээс гуйсан ч Тэр эргэж ирэхгүй” гэжээ. Үнэхээр хачирхалтай шүү! Тэр өөрөө мэдэхгүй, гэтэл бусад хүн Түүний хэн болохыг мэдэж байдаг. Бодьдарма үнэхээр өхөөрдмөөр хөөрхөн.

Багш нь бас өөрийнхөө хэн болохыг мэдэхгүй, гэвч олон хүн ирж, Багшийг нь батлан та бол Очирваань Бурхан, зарим нь та бол эртний Будда гэв, гэвч дэндүү эртний Будда болохоор хэзээ

ч хараагүй, хэзээ ч сонсоогүй, тиймээс ямар нэртэйг нь мэдэхгүй байдаг. Зарим хүн Багш бол биндэрьяа болор бурхан мөн гэнэ, зарим хүн Багшийнх нь биеэс олон мутар гарахыг харжээ, Багш бол мянган мутар, мянган мэлмийт Арьяабал бодьсадва мөн гэнэ, зарим хүн Багш бол Газрын зүрхэн бодьсадва мөн гэнэ, бас нэг хүүхэд надаас: “Багш аа, та Очирваань Бурхан мөн үү? Надад тэгж харагдлаа.” гэж асуусан. Зарим хүн Багш бол Манзушри бодьсадва мөн, учир нь Багш билиг ухаантай гэнэ. Тэр тэгж бодож л дээ, би биш шүү. Зарим хүн Багшаас нь их гэрэлт цагариг цацрахыг харжээ. Тэд бүгд хардаг. Бүгдээрээ Багшийг нь хэн болохыг мэддэг. Гэвч би өөрөө мэдэхгүй.

Та нарт тун илэн далангүй хэлэхэд би тоглоом наадам хийгээгүй шүү, бас Бодьдарматай өөрийгөө харьцуулах гэж байгаа ч юм биш, миний хувьд тэр бас ялгаагүй. Би та нарт Бодьдарматай адилхан гэдгээ онцлох гээгүй, би ийм утгаар хэлэх гэсэн биш. Учир нь Тэр бол Тэр, би бол би. Түүнтэй дэсээ харьцуулах ямар ч шаардлага надад байхгүй. Түүний Бурханы хутагт хүрсэн нь ч надад бас хамаагүй. Тэрээр, орчлонгийн оройн дээд нь бөгөөд надтай ямар ч хамаагүй.

Гэхдээ та нарт шулуухан хэлэхэд, би Түүнийг сайн ойлгож байна. Учир нь би ч бас одоо өөрөө хэн болохоо мэдэхээ больсон. Харьцуулах гээгүй шүү, ойлгов уу? Олон хүн Багшийг нь хэн болохыг мэддэг. Зөвхөн би өөрөө л мэддэггүй. Энэ байдал нь бүгд энэ “залхмаар” Арьяабалын аргаар бясалгаснаас болсон юм. Хэрвээ та нар айж байвал бясалгах хэрэггүй.

Өмнө нь би өөрийгөө бодьсадвагийн хувилгаан гэж боддог байлаа. Учир нь би сайн хүн, өглөг өгдөг, хүлцэн тэвчдэг, номхон даруу байдаг, ногоон хоол иддэг хүн. Гэвч Арьяабалын аргаар бясалгаснаас хойш би: “адуу, үхэр ч бас өвс ногоо иддэг, тэгэхээр ногоон хоол идэх нь тийм сүрхий явдал биш юм байна.” гэж бодох болов. Өглөгийг их мөнгөтэй байж өгнө. Магадгүй, бидэнд өмнөх төрлийн өр төлөөс байгаа учраас одоо тэднийг хараад шууд буцааж төлмөөр санагдаж, ам нээж гуйхаас нь өмнө аль хэдийнээ түүнд буцааж өгсөн хэрэг. Энэ нь сая Багшийнх нь ярьсан авлагын эзэн хүүхэд тань болж ирдэг гэсэнтэй ижилхэн, ойлгов уу?

Та нар Багшийнхаа хэлсэн үгэнд итгэхгүй байж магадгүй. Энд ирж, Үнэн ёсыг сонсохыг хүсдэг, гэвч Үнэн ёс ихэнхдээ чигч үг чихэнд сөргүү гэдэг шиг байдаг. Хэрвээ та нарын чихэнд таагүй санагдвал энд чих бөглөх хөвөн бий шүү. (Бүгд инээлдэв.) Бөглөхөд одоо ч дэндүү оройтсон бололтой. Хожим

бид ном тайлахаас өмнө эхлээд хүмүүст хөвөн тараах хэрэгтэй. Сонсмооргүй санагдсан үедээ бушуухан чихээ бөглөж байг. Ингэвэл бидэнд яршиг төвөг бага болно. Та нар ч гомдох юмгүй байна, Багшдаа ч уурлахгүй. Сонсоход хувраг хүнийг уурлуулбал буян хишиг барагдана гэдэг, би ингэж сонссон болохоос надад тийм мэдрэмж төрдөггүй. За одоо асуулт байна уу? Та нар бас уурлаж, уур тань хүрч байгаа зүйлсийнхээ талаар яривал тэрийгээ бас Багшдаа өгсөн нэг зүйлийн бэлэг гэж үзэж болно.

Асуулт: Арьяабалын аргаар бясалгахад сэтгэлийн талаар ямар бэлтгэлтэй байвал сайн бясалгаж чадах вэ?

Их Багш: Та зөвхөн үхэж, төрөхийн сансрын хүрднээс туулан гэтлэхийг хүсэхэд л хангалттай. Энэ бол хамгийн их сэтгэлийн бэлтгэл. Туулан гэтлэхийг жинхэнээсээ хүсэж, Бурханы хутагт хүрэхийг хүсэж байвал Арьяабалын аргаар бясалгаж болно. Гэвч та бясалгал дадуулсныхаа дараа харин нэгэн бурхан болох хүсэлгүй болчихож магадгүй юм.

Асуулт: Их Багшийг анх хараад л зүрхний гүнээс бишрэх сэтгэл төрсөн. Бас Их Багшийн ном сургаалыг уншсан, гэсэн хэдий ч би гэгээрээгүй л байна. Энэ нь би ногоон хоол идэхгүй байгаа, их хүнд үйл түйтгэртэй байгаатай холбоотой юу?

Их Багш: Бидний бодол санаа маш их хүчтэй, юу бодно түүнийгээ олдог. Тиймээс “Бүх зүйл сэтгэлээр бүтээгдсэн.” гэж ярьдаг юм. Бясалгавал бидний бодол сэтгэл улам хүчирхэг болно. Учир нь бид одоо өөрийн хүчээ ашиглаж чаддаг болсон байна. Билиг нээгдэн гэгээрэх гэдэг нь энэ их хүчээ нээсэн гэсэн үг, тэгэхлээр одоо түүнийг өдөр бүр ашиглаж болох болжээ. Үүнийг ашиглаж байх үедээ бидний бие, хэл, сэтгэл цэвэр ариун байх ёстой. Эс бөгөөс бид тийм их хүч чадалтай мөртлөө муу бодол, муухай санаатай бол бүр илүү аймаар явдал болох биш үү? Миний санааг ойлгов уу?

Хэрвээ тэр үед бид хэн нэг хүнийг хөнөөмөөр санагдвал хутганы ч хэрэггүй, тэр хүн хөнөөгдөнө. Тиймээс бясалгагч хүний хувьд хамгийн чухал зүйл бол бие, хэл, сэтгэл цэвэр ариун байх явдал юм. Багш нь та нарыг ногоон хоол идэхийг уриалдаг нь энэрэн нигүүлсэх сэтгэлийг тань тэтгэн тэлэхийн төлөө юм, хүч чадал тань өссөний дараа л сая түүнийгээ та нар сайн зүйлд ашиглаж чадна. Жишээ нь, бид нэгэн барыг нялхаас нь тэжээж, өдөр бүр мах өгдөг байсан бол том болоод хэзээ нэг цагт идэх махгүй болсон үедээ хэнийг барьж идэх вэ? Тэр бар хүн барьж

идэх болно, учир нь тэр бар мах идэж дассан, бид түүний энэрэн нигүүлсэх сэтгэлийг тэтгэж хөгжүүлээгүй. Түүнд өдөр бүр дүүфүү, глютен өгч байгаагүй тул мэдээж мах идэж сурсан хэрэг.

Тиймээс Шагжамуни Будда айлдахдаа: “Бясалгал дадуулдаг хүн ногоон хоолтон биш бол нэгэн бурхан болж чадахгүй. Сайндаа л адын эзэн болно.” гэжээ. Адын эзэн болж чадвал бас тун давгүй хэрэг. Учир нь адын эзэн бол Гурван ертөнцийн дотор маш дээд байр суурь эзэлдэг бөгөөд Гурван ертөнцийг хянаж байдаг. Тэр бол Гурван ертөнцийн хаан юм.

Адын эзэн хамгийн сайндаа Эсэрваа тэнгэрийн сууринд хүрдэг. Маш их хүч чадалтай, сэтгэгдэшгүй их ид шидтэй, гэвч Гурван ертөнцийг давж чадахгүй. Учир нь энэрэн нигүүлсэх сэтгэл нь хүрдэггүй, мөн арга, билгийг төгс эзэмшиж чадаагүй тул билгийн тал нь хэт давамгай, аргын тал нь тун бага, ганц ялгаа нь энэ, ойлгов уу? Тиймээс яагаад заавал ногоон хоол идэх ёстой юм бэ гэж Багшаасаа бүү асуу. Хэрэв Гурван ертөнцийг даван туулахыг хүсэж байвал заавал ургамал хоол идэх хэрэгтэй. Энэрэн нигүүлсэх сэтгэл маш чухал. Бидэнд хүч чадал байсан ч энэрч нигүүлсэх сэтгэлгүй бол тэрхүү хүч чадлаа дураараа ашиглана. Багшийнхаа санааг ойлгов уу?

Яг л өндөр, том биетэй, хүч чадалтай хэрнээ хэрцгий догшин хүн шиг. Тийм хүн нийгэмд их аюултай. Эсрэгээрээ өндөр том биетэй, хүч чадалтай хүн энэрч хайрлах сэтгэлтэй бол олон хүнд тустай байх нь гарцаагүй. Тэрээр бие махбодын хүч чадлаараа бусдад эд зүйлээ өргөхөд нь тусална, зам засна, хүнд ачаа үүрч, олон хүнд тусалж чадна. Гэтэл энэрэн нигүүлсэх сэтгэлгүй, хамаг төрөлтнийг хайрлахгүй хүн бол хүч чадлаа бусдыг зодох, хүн хөнөөхөд ашиглана. Ингэвэл бүр аймшигтай, тийм биз?

Хэрэв хүн сул дорой бол хорон санаатай байсан ч аюул багатай, түүний хүн цохих нь загатнасан газар маажихтай л адил, тэгэхээр асуудал бага.

Асуулт: Авшиг хүртсэний дараа өдөр бүр хоёр цаг хагас бясалгаж сууж чадахгүй бол би яах ёстой вэ?

Их Багш: Тэгвэл бясалгаж хэрэггүй. Хэрэв жинхэнэ чин үнэн сэтгэлтэй хүн бол амжуулж хийж чадах нь гарцаагүй. Бага унтана, зурагт бага үзнэ, сонин бага уншина, утсаар ярихаа багасгаж, хүмүүстэй ярилцахаа цөөлж, найзуудтайгаа хааяа нэг уулзана. Ингэвэл өдөр бүр маш их цаг хэмнэнэ, ойлгов уу? Заавал нэг удаад хоёр цаг хагас суух шаардлагагүй. Өглөө эртхэн босоод

нөхөр, хүүхдүүдээ сэрээгүй байхад нэг цаг бясалгана, орой хожуухан унтаж бас нэг цаг бясалгаад үдийн амралтаараа дахиад хагас цаг бясалгачихад болно.

Та нар Багшаасаа юм асуухдаа дандаа эмэгтэй хүний сэтгэлээр ханддаг. Энд ирэхдээ нилээд төв чанга, няхуур хандах хэрэгтэй. Элдэв шалдар булдар зүйл асууж, Багшийнхаа эрч хүч, цаг завьг бүү гарзад. Би та нартай тоглоогүй. Та нар заримдаа тоглож наадаж бололгүй яахав. Гэхдээ сүнслэг бясалгалын талаарх асуудлыг ингэж асууж болохгүй.

Асуулт: Урьд нь би мах идэх их дуртай байсан, идэхгүй бол шанална. Харин Их Багшийн номыг уншсанаас хойш мах харвал огиудас хүрч, бөөлжмөөр болдог болов, яагаад энэ вэ?

Их Багш: Хачирхалтай хүн болсонд тань баяр хүргэе! Арьяабалын аргаар бясалгах нь их аюултай гэж би та нарт хэлсэн дээ, та бясалгаж эхлэхээсээ ч өмнө, зөвхөн Багшийнхаа номыг уншихын төдийд л хэдийн ийм аюултай болсон байна, бясалгал дадуулсны дараа хүнсний ногоог ч идэх хүсэлгүй болж магад, мах идэхийг бол бүр ярих ч хэрэггүй. Тэгэхлээр бясалгахгүй байх нь дээр.

“Баатараа явагч нэрт их хөлгөн судар”-т Шагжамуни Будда айлдахдаа: “Юу ч идсэн хүүгийнхээ махыг идэж буй мэт санавал зохино” (*Баатараа явагч нэрт их хөлгөн судрын 4-р хэсэг*) гэжээ. Түүний санаа нь бясаллагч хүн, эсвэл хувраг хүмүүс хүнсний ногоо идсэн ч хүүгийнхээ махыг идэж буй мэт бодох ёстой гэсэн үг, залгихад бэрх, хоолойгоор давахгүй, тэгэхлээр махыг бол бүр яриад ч яахав! Ойлгов уу?

Үнэхээр тийм, илүүхэн бясалгасны дараа хүнсний ногоо ч идэх хүсэлгүй болдог, учир нь тэд ч бас амьтай, гэхдээ үхлээс айх болон амьдрахыг хүсэх ухамсар харьцангуй багатай, тиймээс тэдгээрийг идвэл зовлон шаналал нь их биш. Аливаа бүхэн цөм бурхан мөн, тиймээс бид хүнсний ногоо идсэн ч бурхныг идэж байна гэсэн үг. Багш нь саяхан хүүхэлдэйн нөхцөл байдлын тухай ярьсан, хүнсний ногоо бол бас нэгэн хүүхэлдэй юм. Орчлон ертөнцөд нэгэн их хүч байдаг бөгөөд бүхий л төрөлтийг гийгүүлэн гэрэлтүүлж, тэжээн тэтгэж байдаг.

Хэрвээ энэ хүч байхгүй бол хамаг төрөлтөн байхгүй. Тиймээс бид үргэлж “Бурханы Гэрэл мөнхөд гийгүүлнэ.” гэж ярьдаг. Бурханы Гэрэл гэж энэ их хүчийг хэлж байгаа юм. Хэрвээ бид энэ их хүчийг харахыг хүсвэл Тэрээр Гэрэл болон хувирдаг, хэрвээ

бид энэхүү Бурханы Аялгууг сонсохыг хүсвэл Тэрээр чанагуух ертөнцийн Аялгуу болон хувирдаг. Тэр нь “Чанагуух ертөнцийн ялгуулсан дуун” хэмээгч мөн, миний санааг ойлгов уу?

Хэрвээ энэ их хүч ургамалд орвол ургамал болон хувирна, хүний биед орвол хүн болон хувирна, амьтны биед орвол гахай, тахиа, нугас зэрэг амьтан болж хувирна. Тэгэхлээр ургамал ч бас энэ их хүчээр бүтээгдсэн нь мэдээж, зөвхөн гаднах дүрс нь өөр. Тэд янз бүрийн ялгамжтай савлагаатай байдаг тул өөр өөр харагддаг ч үнэндээ доторх бэлэг нь яг ижил. Жишээ нь, Сарны баярын үеэр бид хүмүүст арвин их бэлэг сэлт илгээдэг. Хэдийгээр бид адилхан зүйлс худалдан авдаг боловч гаднах сав баглаа нь өөр тул адилгүй харагддаг, задалбал үнэндээ доторх нь бүгд ижил.

Тиймээс хүнсний ногоо ч Эзэн Бурхан, Бурхан, бүтээгчийн хүч мөн, тэдэнд онцгой юм байхгүй. Муу хүнийг ч гэсэн тэр хүч сэтгэлийг нь хөөргөснөөс муу болж хувирсан, өөрөөр хэлбэл муу хүн ч тэр хүчний бүтээл юм.

Жишээ нь, хоёр хүн байжээ, нэг нь тун сайн, нэг нь тун муу. Тэд адилхан цагт нас барах үеэр хэн нь үхлээс мултарч чадах вэ? Тэдний махан бие нь ялгаагүй болсон, хэн нь ч сууж чадахгүй, бүр өнөөх сайн хүн ч бас сууж чадахгүй. Тэр үед сайн болон муу нь хаашаа одсон бэ? Их хүчиндээ буцсан уу? Их хүчинд арга ч бий, билиг ч бий. Билгийн зүйлс нь билгийн талдаа, аргын зүйлс нь аргын талдаа буцжээ. Тэд хаашаа явсан нь хамаагүй, бүгд их хүчнийхээ дотор байсаар л байдаг, ойлгов уу?

Яг л Багш шиг нь, миний дээр толгой, доор хөл байна, хөл, толгой хоёулаа минийх. Та нар: “Бид зөвхөн Их Багшийн толгойг л хүндэлдэг, тэгэхээр хөлийг тань тайрчихъя, болох уу?” гэж болохгүй. Хэдийгээр хөлийг харахад сайхан харагддаггүй байлаа ч гэсэн миний л хөл, ойлгов уу? Миний хэвлий доторх мэдээж сайхан харагдахгүй, гэхдээ та нар: “Багш аа! Таны гэдэс дотор маш муухай бохир юм. Түүнийг тань аваад хаячихъя. Бид зөвхөн таны толгойг л хүндэлнэ.” гэж ярьж болохгүй.

Учир нь гэдэс ходоод минь хоол унд идэж, уухад хэрэгтэй, тэргүй бол би идсэн хоолоо хаана шингээх вэ? Жишээ нь, зуслангийн байшинг харахад гоёмсог ч дотор нь бие засах өрөө бас байдаг. Бие засах өрөөнд хүн унтаж амардаггүй ч энэ нь бидэнд хэрэгтэй.

Тиймээс арга, билиг бүгд сайн. Муу хүн, сайн хүн аль аль нь сайн. Ад ч сайн, чөтгөр ч сайн, бурхан ч бас их мундаг. Санааг

минь ойлгов уу? Та бүхэн Будда болохыг хүсэж байгаа учраас бясалгал дадуулах хэрэгтэй. Будда болохгүй бол буг болж болно, тэр ч бас хэрэгцээтэй. Учир нь тамд байгаа хүмүүст үйл түйтгэрээ хурдан цэвэрлэхэд нь туслах чөтгөрүүд хэрэгтэй. Жишээ нь, хувцас жаахан бохирдсон үед зүгээр л усаар угаагаад арилгаж болно. Харин дэндүү их бохирдсон бол угаалгын шингэнд хоёр, гурав хоног заавал дэвтээж байж угаадаг. Хэрэв хир нь сайн арилаагүй бол хамар цоргисон хурц үнэртэй, гарт хүрвэл арьс хуурмаар цайруулагчид булхаж, хамгийн хүчтэй, хамгийн хортой химийн бодистой цайруулагчаар угаавал харласан бохир хэсгийг арилгаж, хувцсаа цагаан болгож чадна. Тийм зүйлийг уувал хордоно. Уух дуртай хүн ч байхгүй. Бид хамгийн хортой зүйлийг өндөрт байрлуулж хүүхэд авахаас сэргийлдэг. Гэхдээ цайруулагч бол маш бохир хувцсыг маань цэвэрлэхэд тусалдаг болохоор хэрэгтэй зүйл.

Там ч бас бидний тусын тулд оршдог. Гэхдээ бид маш хянуур болгоомжтой байж, өөрсдийгөө цэвэрлэх гэж там руу явах хэрэггүй. Одоогоор нэгэн аядуу зөөлөн, амьд сэрүүн байгаа Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олоод алгуурхнаар цэвэрлүүлбэл арай аятайхан. Харин ад ирж цэвэрлэх болбол нилээн хэцүүхэн болж мэднэ, маш их өвдөж зовох байх.

Асуулт: Нэгэн их бясалгагч хүн яагаад догшин хэрцгий араатныг номхруулж чаддаг вэ?

Их Багш: Энэ их амархан. Ердөө л энергийн соронзон талбайн асуудал. Төрөлтөн бүхэн Бурхан чанартай, өөрийн Бурхан чанараа төгс хөгжүүлсэн хүн аливаа төрөлтний Бурхан чанарыг татан гаргадаг. Тэр үед Бурхан чанар нь татагдан гарснаас бар гэдгээ мартаж, зөвхөн Бурхан чанараа харуулна.

Амьд төрөлтөн бүхэн Бурхан чанартай. Хэрвээ Бурхан чанараар нохойг харвал нохой ч мөн бурхан. Дөнгөж сая Багшийнх нь ярьсантай ижил, их бясалгагч хүн ялгаварлах сэтгэлгүй байдаг.

Гуан Чин өвгөн хувраг бясалгалаа тун сайн хийдэг байжээ, хамгийн багадаа архадын хутагт хүрсэн тул зэрлэг араатныг номхруулна, бар, арсланг гөлөг, муур мэт дуулгавартай болгоно, тэр амьтад түүнийг маш их хүндэлдэг. Үхэр толгойт уулын Даяаны багш Фаруныг Үхэр толгойт ууланд бясалгаж байхад эргэн тойронд нь дүүрэн араатан байжээ. Тэд энд тэндгүй гүйлдэж, могой нааш цааш мурилзан мөлхдөг байсан ч түүнийг огт гэмтээж байгаагүй. Тэгэхээр тэр наад зах нь архадын хутагт

хүрч чадсан гэсэн үг.

Багш нь тэр дэсэд хүрээгүй байх. Учир нь намайг шумуул хаздаг, мэдээж суусан газар болгондоо хазаад байхгүй, хазмаар санагдсан газраа л хаздаг. Би ч бас тэднийг чөлөөтэй байлгадаг, ойлгов уу?

Та нар бясалгаад архадын хутагт хүрвэл амьтад таныг их биширдэг гэдгийг мэдэх болно. Шувуу, сармагчин ирээд цэцэг, жимс өргөл болгон өргөнө. Энэ нь архадын дэсийн хамгийн онцгой зүйл, архадын онцлог гэж болно.

Урьд нэг маш сайн бясалгалтай хүн ууланд амьдардаг байжээ. Шувууд түүнд цэцэг, жимсээр өргөл өргөнө, гэсэн хэдий ч хэсэг бясалгасных нь дараа тэд алга болов. Учир нь шувууд түүнийг хаана байгааг нь ойлгохгүй, “би” нь хаана буйг үнэрлэж чадахгүй болсон байжээ. Тиймээс тэрээр түүнийг дэмжих юу ч үгүй болсон байна. Энэ нь түүний дэс унаснаас болсон биш юм.

Асуулт: Багшийн сая айлдсан зүйлсийг сонсоод таныг даган суралцах ёстойг ойлголоо. Сая та ярихдаа таныг шумуул хаздаг гэв, гэвч эртээд “Цагаан ордон”-ны өрөөнд ном айлдаж байхад тань шумуул таныг биш, биднийг л хазаад байсан.

Их Багш: Та нар ийм олон бодьсадва очсон тул намайг аварч таарсан. Учир нь бодьсадваг хазвал илүү буян хишигтэй гэж тэд мэднэ, тиймээс эгэл намайг тоогоогүй хэрэг. Бодьсадвагийн цусыг сорох гэдэг тун амаргүй. Тиймээс Тансан лам баруун орноос ном залахаар явах үед тун олон ад чөтгөр түүнийг хөнөөж, махыг нь идэхийг санаархсан. Бодьсадвагийн махыг идвэл урт насалж, их ид шид, буян хишигтэй болдог гэж сонсжээ.

Тэр өдөр хүн олон байсан болохоор шумуулнууд завгүй байв. Хэзээ ч ийм олон бодьсадва хараагүй тул та нарыг хурдан хурдан хазаж байсан хэрэг. Багш нь өдөр бүр нэг л газар байдаг болохоор заримдаа хазуулна, заримдаа хазуулахгүй. Эгэл хүнийг хазах нь тэдэнд ашиггүй, уйтгартай, тиймээс та нарыг ирмэгц боломжийг ашиглажээ.

Та Багшийгаа даган суралцаж болно, гэхдээ Багш нь ч бас шумууланд хазуулбал заавал тос түрхэх хэрэгтэй болдгийг мэдвэл зохино. Өвчин тусвал өөрийгөө эмчилж чадахгүй, хятад эмнэлэгт очиж судсаа бариулж, эсвэл европ эмнэлэгт очиж цусны шинжилгээ өгвөл бие тань эрүүл байна гэсэн хариу хэлнэ. Гэвч Багш нь ихэд өвдөж зовуурилж байсан ч ойлгох хүн байдаггүй.

Тиймээс Багш нь: “Би өвдөв” гэж ер хэлдэггүй. Учир нь хэн ч итгэхгүй, эмч нар ч өвчингүй байна л гэнэ. Би өөрөө л мэдэхээс хүмүүс итгэдэггүй.

Бясалгавал шумуул хазахгүй, могой ч хатгахгүй, эсвэл бар ирээд танаас сахил хүртэж, өргөл өргөнө гэж бүү бодоорой. Багшийгаа даган бясалгавал ийм зүйлсэд шунах хэрэггүй, ийм үр дүн олж ч мэднэ, олохгүй ч байж мэднэ. Яг л шумуул шиг, тэр чимээгүй л хаздагтай адил.

Арьяабалын аргаар бясалгах нь ийм л сонин жигтэй. Өөрийн дэсээ архадын түвшинд хүрсэн үү, бодьсадвагийн хутагт хүрсэн үү гэдгээ мэдэхгүй. Ер нь ямар дэсэд хүрснээ ч мэдэхгүй, яг л Бодьдарма шиг тийм этгээд сонин төрөлтөн болон хувирч магадгүй. Хүн түүнээс: Та хэн бэ гэж асуувал, Тэр бас мэдэхгүй. Харин Түүний оронд олон жил “Даяан”-ыг бясалгасан хүн байсан бол ийм асуултанд заавал хариулна. Эсвэл ямар нэгэн зураг зурж, тэдэнд өөрийн дэсийг илэрхийлнэ, эсвэл Даяаны ер бусын нууцлаг хэллэг болох: “Үйл түйтгэр угаасаа хоосон, хамаг төрөлтөн угаас байсан, дүрс хоосноос ялгаагүй, хоосон нь дүрсээс өөрцгүй.” гэх мэтийг хэлнэ. Ингэж хэлбэл хүмүүс түүний ямар дэстэйг ойлгоно.

Арьяабалын аргаар бясалгадаг хүнд ийм нөхцөл байдал байхгүй, би ч та нарт ийм зүйл заахгүй. Тиймээс Арьяабалын аргаар бясалгавал урам чинь хугарч мэднэ, ойлгов уу? Мэдээж бясалгавал ололт байгаа, байхгүй биш. Ололтгүй бол бясалгаад яахав дээ, тийм ээ? Ололтгүй бол хохирсон хэрэг болно биз дээ? Орчлон хорвоогийн юмс ийм элбэг арвин байхад бясалгаад юу ч үгүй болбол хохиролтой бус уу?

Мэдээж бясалгах зүйл бий, түүнд түшиж бясалгана. Гэхдээ үгээр илэрхийлшгүй, үзүүлж болшгүй, бас дүрсэлж чадамгүй. Та нар Даяаны арван үхрийн зургийг мэдэх үү? Эхнийх нь үхэр эрж хайсан, удаах нь мөр олсон, гутгаар нь үхэр харсан гэх мэт зургууд. Харин бидэнд ийм зүйлсийн хэрэг байхгүй.

Тиймээс та бүхэнд тодорхой сайн хэлэх ёстой. Эхлээд та нар сайтар тунгаан бод. Багш биднийг мэхэлж байна гэж битгий ярь, бясалгавал бар ирвэл толгойг нь илнэ гэсэн юм байхгүй, бар харвал хурдан зугтаарай. (*Бүгд инээлдэв.*) Эсвэл хурдан сэтгэж хариу үйлдэл хий. Тэрнээс биш бар ирвэл толгойг нь илнэ дээ гэж бодох хэрэггүй. Энэ аюултай. Бясалгал дээшлэх тусам араатан амьтад илүү дотносно гэж бүү бод, тэд таны махны үнэрээр ирж мэднэ, (*Бүгд инээлдэв.*) заавал эрсдэлтэй зүйл хийж, шумуул

хамгийн их байдаг газарт аз туршин бясалгаж суух хэрэггүй, хоёр, гурав хоногийн дараа хувхай яс болж ч магадгүй.

Арьяабалын аргаар бясалгах тун энгийн, өөрөө өөрийгөө сайтар халамжилж, өдөр бүр шимтэй хоол идэж, өвөлдөө дулаан, зундаа нимгэн хувцаслана. Шим тэжээлтэй уураглаг хоол идэх хэрэгтэй. Харин Арьяабалын аргаар бясалгасны дараа энэхүү махан биеэ халамжилж анхаарахаа больчихно гэсэн хэрэг биш, ойлгов уу?

Зарим хүн сайн ойлгоогүйгээс барын толгой илэх дуртай. Багш нь бартай газар очиж зүрхлэхгүй (*Бүгд инээлдэв.*), багшийг нь тэнд нь сууж байхыг бар аль нэгэн өдөр Бурхан чанараараа биш ходоодоороо харчихвал ихээхэн аядуу хялбараар Багшийг нь ходоодондоо гэтэлгэчихвэл яана? (*Бүгд инээлдэв.*) Тиймээс би баранд бариулахаас айж, аглаг ууланд бясалгадаггүй. (*Бүгд инээлдэв.*)

Асуулт: Би Даяаны нэг ном уншсан юм. Зохиогч бичихдээ гэгээрэх тун хэцүү, олон их багш насаараа бясалгаад арай гэж гэгээрдэг гэжээ. Гэгээрсний дараа бүх зүйл хов хоосон болдог уу? Багштан та үүнийг тайлж соёрхоно уу?

Их Багш: Хэрвээ юу ч бодохгүй болдог бол чулуунаас өөрцгүй бус уу? Угаасаа арвин их зүйлтэй байсан атал бясалгаад юу ч үгүй хов хоосон болох нь хохиролтой биш үү? Номын багш нарын иймэрхүү яриаг сонсох хэрэггүй. Тэдний бодлоор бясалгаад хов хоосон болдог бол би л лав бясалгахгүй, хохирох юм байна. Бид угаасаа билиг ухаантай байтал яагаад хов хоосон болох вэ? Чулуу ч бас хов хоосон. Ингэвэл бид өөрийгөө гэсэн явдал болно.

(Даяаны багш нар бидэнд бодлоо тасал, элдэв зүйлийг замбараагүй бодох хэрэггүй, тархиа хоосол гэж сургадаг.) Хоосолж болохгүй. Хоослох гэдгийн утга нь тийм биш. Хоосон нь “Мөр ёс”-ыг илэрхийлдэг болохоос биш, хов хоосон, юу ч үгүй гэсэн санаа биш. Хоосон гэдэг нь төрөлх Мөн чанар, Эх сурвалж гэсэн санаа. Тэр эх сурвалжид хүрвэл бид алагчлахгүй, сайн, муугийн ялгаваргүй болдог. Элдэв бодолгүй болно гэдэг тийм ч амаргүй. Хоосол гэдэг нь Арьяабалын аргаар бясалга гэсэн санаа юм. Учир нь Арьяабалын аргаар бясалгавал Багш нь таныг эх сурвалждаа буцахад тань тусалдаг. Тэр үед жинхэнэ амар амгалантай болно. Энэ явдлыг үгээр илэрхийлж боломгүй, бас ярьж ч чадамгүй байдаг.

Асуулт: Би уг нь Багшийг дагахыг тун их хүсэж байна. Гэхдээ гэрийн явдлаа шийдээд дараа нь ирж, Багшаас суралцанаа, болохсон болов уу?

Их Багш: Хэрвээ чин сэтгэлтэй бол болно. Чин сэтгэлгүй бол ирээд хэрэггүй. Ирвэл Багш нь таныг хөөгөөд явуулах байх. Тэр үед та их уурлах байх аа. Тиймээс эхлээд чин сэтгэлтэй эсэхээ өөрөөсөө асуух хэрэгтэй. Багшид заавал шууд итгэх хэрэггүй. Гэхдээ чин сэтгэлээсээ гэгээрэх хүсэлтэй байх ёстой. Учир нь Багш нь саяхан, та яаж шууд Багшид итгэх вэ гэж ярьсан. Ахуй ойлголттой болж байж л итгэл төрнө. Ахуй ойлголтгүй бол итгэх хэрэггүй. Их сонсож, их үзвэл сая итгэнэ. Багшийнхаа сургаалыг илүү их уншиж судалж, зөвшөөрч байна уу, үгүй юу гэж өөрөөсөө сайтар асуух хэрэгтэй.

Бясалгасныхаа дараа ахуй ойлголттой болж, бас нилээд дэвшилттэй, баяр жаргалтай, ач тус хүртэж, билиг ухаан нээгдсэн бол тэр үед итгэж болно, гэхдээ чин сэтгэлтэй байх нь хамгийн чухал.

Чин сэтгэлтэй байх нь итгэхтэй адилгүй. Хэрвээ та чин сэтгэлээсээ гэгээрлийн төлөө, үхэж, төрөх сансрын хүрднээс ангижрахын төлөө бол Багш нь та бүхнийг заавал Багшдаа итгэ гэж албадахгүй. Чин сэтгэл гэдэг нь өөртөө чин сэтгэлтэй байна гэсэн үг. Итгэлийн тухайд бол бясалгасны дараа л сая төрдөг зүйл. Заавал шууд итгэх ёстой гэсэн үг биш, ойлгов уу?

Худалдаж аваагүй, эдэлж хэрэглээгүй бол яаж итгэх вэ? Худалдаж аваад үнэхээр сайн эдэлгээтэйг нь танивал сая итгэлтэй болдог. Ихэнх хүн бүгд таныг там, диваажин байдагт, Авид Бурхан байдагт, Арьяабал Бурхан байдагт хүчээр итгүүлдэг. Гэхдээ танд жаахан ч ахуй ойлголт үзүүлж чадахгүй. Арьяабал Бурхан гэж хэн болохыг ч та мэдэхгүй, жаахан ч Гэрэл олж хараагүй, Бурханы Аялгууг жаахан ч олж сонсоогүй, ийм байдалтай бол яаж итгэл төрөх вэ? Багш нь хэзээ ч хүнийг хүчилж итгүүлэхгүй. Харин та нар жинхэнэ чин сэтгэлээсээ гэгээрлийн төлөө зорьж ирэх ёстой.

Асуулт: Багш аа! Гэрээс гарагчдыг яаж авгайлах ёстой вэ?

Их Багш: Яаж ч дуудсан болно. Ёслол хүндлэл нэг их чухал биш. Учир нь таны сэтгэл жинхэнэ ёсоор ёслон хүндлээгүй байдаг. Ихэнх хүн гэрээс гарагчдыг номын багш хэмээн дууддаг. Гэвч та багш, эсвэл Чин Хай гэж дуудсан аль нь ч болно.

Нэршил тийм ч чухал биш, харин таны чин сэтгэл хамгийн чухал нь.

Асуулт: Би өмнө нь өөр нэгэн бясалгалын аргыг сурч байсан. Мөн л хүмүүст Гэрэл үзэж, Аялгуу сонсохыг заадаг. Их Багшийн зааж байгаатай түн төстэй байна.

Их Багш: Та авшиг хүртэхгүй байж болно. Үргэлжлүүлэн уг бясалгалын аргаараа бясалгаж болно. Би таныг хэрхэвч хүчлэхгүй. Танд зөвхөн дуулгах төдий. Зарим номын багш бас ийм бясалгалын аргыг сургадаг гэж ном бичигт тэмдэглэсэн байдаг. Үнэндээ харин адилгүй байдаг. Ау Лакт тийм номын багш нар олон бий. Америкт бас байдаг. Зөвхөн Энэтхэгт гэхэд л хоёр, гурван төрөл байдаг. Харахад “ижил төстэй” бясалгалын арга хэдий ч үнэндээ огт адилгүй. Багшийнх нь зааж буй энэ арга хамгийн ёс журамтай, хамгийн тодорхой, хамгийн дээд бясалгалын арга. Тэд өөр газраас ном хулгайлаад дураараа зааж байдаг. Заасан ч тов тодорхой биш, олигтой сайн ч заадаггүй, тал хагасыг нь л заах төдий. Түүний доторх нэгээхэн хэсгийг л заана. Зуун хувь бүрэн гүйцэд заадаггүй. Тиймээс шавь нар нь хойшид үргэлжлүүлэн бясалгаж чадахгүй. Жишээ нь, танд заасан тэр хүн нас нөгчвөл та үргэлжлүүлэн бясалгаж чадахгүй болно. Учир нь тэр зөвхөн яаж анхны алхмыг хийхийг зааснаас биш, хоёр дахь алхмыг яаж хийхийг заагаагүй байна, ойлгов уу?

Одоо ч Энэтхэгт тиймэрхүү төгс бус аргыг зааж л байна. Тэдний багш нарын зарим нь маш хатуу чанга, шавь нараа сорихын тулд бүрэн заадаггүй. Гэвч жинхэнэ агуу Их Багш бол энэ мэтийг тоохгүй, бас таны бясалгах эсэхийг ч тоохгүйгээр зуун хувь уламжилдаг. Хожим бясалгах, бясалгахгүй байсан ч таныг яах ч үгүй. Түүний доторх нэгээхэн хэсгийг заагаад байтал багш нь хорвоогоос ангижирвал та яаж үргэлжлүүлэхээ мэдэхгүй үлдэнэ.

Өмнө нь Энэтхэгт нэгэн номын багш байсан, тэр багш хүмүүст ганц өгүүлбэр заах төдий. Жишээ нь, тэр зөвхөн нэгдүгээр ертөнцийн нууц үгийг л заана, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа, долоо, наймдугаар ертөнцийн нууц үгийг заахгүй. Тэр хүн бясалгаад нэгдүгээр ертөнцөд хүрсний дараа багш дээрээ ирэхэд түүнд хоёрдугаар ертөнцийн нууц үгийг заана. Бас тэр багшийн тогтоосон дүрэм журам нь маш хатуу чанд.

Гэвч шавиа хоёрдугаар ертөнц хүрэхээс өмнө багш нь нас эцэслэвэл өнөөх шавь дахин нэг удаа төрөл авч, өөр нэгэн их

багшийг хайх хэрэгтэй болно. Энэхүү Төгс Гэгээрсэн Их Багш нь түүнд бүрэн агуулгыг хэлж өгөөгүй, зөвхөн хоёрдугаар ертөнцийнхийг хэлээд тэр хүн тийм ч сайн бясалгаж амжаагүй байтал нөгөө багш нь бас таалал төгсжээ. Тэр хүн дахин төрөл авч өөр нэгэн их багшийг хайх хэрэгтэй болжээ. Хамгийн сүүлд нь миний Өвөг Багштай уулзсан байна.

Энэ бол саяхан болсон явдал, дөнгөж арван хэдхэн жил болж байна. Тэр хүн миний Өвөг Багшид хандан: “Багш аа! Энэ удаа би бүрэн газрын зураг авмаар байна, тал хагас, эсвэл нэг хэсгийг нь авмааргүй байна. Учир нь би хоёр удаа төрөл авлаа, ирэх болгонд номын багш өчүүхэн бага хэсгийг зааснаас хараахан сурч дуусаагүй байтал багш яваад өгдөг. Одоо та надад бүрэн дүүрэн уламжилна гэдэгт найдаж байна. Тэгвэл хожим та явсан ч би үргэлжлүүлэн бясалгаж чадна.” гэжээ.

Заримдаа Багш нь ч бас их зөрчилддөг. Учир нь хүмүүс энэ гайхамшигтай бясалгалын аргад талархахгүй атлаа буруушаан гүтгэж, үйл түйтгэр хурааж байна. Гэсэн ч би мөн л үргэлжлүүлэн бясалгалын аргыг бүрнээр нь уламжилсаар байгаа. Учир нь зарим хүн бас чин сэтгэлтэй. Хэрвээ бясалгалын аргыг бүрнээр уламжилбал номын багш нь маргааш нь явсан ч та нар үргэлжлүүлэн бясалгаж чадна. Хэрвээ тал хагасыг уламжилбал Багш нь явчихвал та нар заавал дахин нэг төрөл авах хэрэгтэй болно. Учир нь бүрэн бүтэн бясалгалын арга байхгүй бол та нар Гурван ертөнцийг даван туулж чадахгүй.

Зарим номын багш адилхан зүйл ярьдаг боловч тэр зөвхөн сургаал айлдахаас биш, Дээдийн Ном уламжилдаггүй, сар бүр танд нэгэн сургаалын агуулга хүргүүлж, таныг ойлголттой болгоно. Тэгээд хоёр жилийн дараа ном уламжилна, ном уламжлахдаа зөвхөн ганц л өгүүлбэр заана. Багш шиг нь ийм нээлттэй биш, хамаг төрөлтнийг нэгэн төрөлдөө туулан гэтэлж, үүрд эргэж ирэхгүй болгохын тулд би бүгдийг нэг дор зааж өгдөг.



НАС НӨГЧИХ ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Лүөдүн. 1987 оны 9 дүгээр сарын 11
(Эх нь хятад хэлээр)*

Өнөөдөр би хүмүүсийн хамгийн их айдаг ч зугтаж үл болох зүйл болох “үхэл”-ийн талаар ярина. Төрөх, өтлөх, өвдөх, үхэхийн дундаас бидний хамгийн их айдаг нь хамгийн сүүлийнх нь, тийм биз? Айсан ч зайлахын аргагүй. Өнөөдөр Багш нь ихэнх хүн нас барах үедээ ямар байдаг талаар ярих болно.

Бид энэ бие махбод маань шороо, мод, төмөр, ус, гал болон сүнснээс бүрддэг гэж сонссон. Бурханы шашинтан бидний хувьд сүнс бол “Жинхэнэ бие”, “Уг дүр”, “Бурхан чанар” юм. Одоо эдгээр нэрийг хамааралгүй, “сүнс” гэж ярья, ингэж яривал хүмүүс арай амархан ойлгоно байх.

Нас барах үед шороо, мод, ус, гал, төмрөөс бүтсэн энэ махан биеэс сүнс нь гарч оддог бөгөөд төмөр, шороо, ус, гал, мод нь нэгдмэл байхаа больж, бие биенээсээ салдаг гэж сонссон. Учир нь сүнс биед байвал нэгэн зүйл тэднийг хооронд нь наасан мэт байдаг. Яг л энэ маанийн эрих шиг, дотор нь утас байгаа. Утас байвал эрихнүүд нь хэлхээндээ байна, хэрвээ Багш нь энэ утсыг авчигвал бүх эрих газарт унаж бутарна.

Бидний үхэх үеийн нөхцөл байдал яг үүн шиг. Гэхдээ бид маанийн эрих биш, бас бид сэрэл мэдрэмжтэй болохоор үхэх үедээ маш их зовж шаналдаг. Энэ нь: Нэгд, бид энэ дэлхийгээс явах дургүй, хамаатан садан, найз нөхөд, эхнэр нөхөр, үр хүүхэд, эцэг эхээсээ салахыг хүсдэггүй, Хоёрт, эндээс яваад хаана очихоо мэдэхгүй байгаа тул бид маш их айдаг. Бид зөвхөн энэ дэлхийг л мэддэг, өөр түвшнийг хэзээ ч мэдэж байгаагүй. Гуравт, бид

өөрсдийгөө сайн бэлтгэж дадуулаагүй тул нас нөгчих үедээ юу хийхээ мэддэггүй зэргээс болдог. Нас нөгчих үедээ бид маш их баярлах ёстой юм, айх зүйл ер байхгүй.

Үнэндээ үхэх нь хамгийн аз жаргалтай мөч. Хэрвээ Багш нь маргааш явж чадвал хамгийн их баяртай байхсан. Гэхдээ би одоогоор явж чадахгүй, та нарт татагдах тул явах арай болоогүй, дээр нь бас надад хийх ёстой үүрэг хариуцлага байдаг болохоор тэднийгээ хийж дуусгасны дараа л сая явж чадна. Тэр ч байтугай Багш нь өнөөдөр явахыг хүслээ ч бурхан бодьсатва түлхээд буулгачих болохоор явж чадахгүй.

Гуан Чин өвгөн хувраг самадид орж, өндөр дээд түвшинд хүрч, бурхан бодьсатвагаас суралцаж байхдаа эргэж ирэх хүсэлгүй байсан гэдгийг та нар сонссон байх. Учир нь тэр үнэхээр баяр жаргалтай байжээ, тэр түвшин нь тун гоёмсог сайхан, эрх чөлөөтэй, амар тайван тул хэн энэ жижигхэн, харанхуй шоронд буцаж ирэхийг хүсэх билээ дээ? Хэн ч хүсэхгүй. Хэрвээ бидний сүнс биеэсээ гарч, суралцахаар дээгүүр дэсийн түвшинд очиж чадвал, энэ жижигхэн, харанхуй шоронд буцаж ирэхдээ дургүй байх нь гарцаагүй.

Гуан Чин өвгөн хувраг ч мэдээж буцах хүсэлгүй байсан, гэвч бурхан бодьсатва нар түүнийг дахин нэг удаа доош бууж, хамаг төрөлтнийг гэтэлгэх хэрэгтэй, тэгсний дараа л дээшилж болно гэж хэлжээ.

Олон Төгс Гэгээрсэн Их Багш түүнтэй ижил ийм нөхцөл байдалд орж байсан. Нэг өдөр миний Өвөг Багш сандал дээр суугаад ихэд бухимдуу гунигтай байхыг харсан ахмад шавь нь: Багш аа! Таныг ийм гунигтай байхыг бид ер харж байгаагүй, яагаад өнөөдөр ингэж бухимдав гэж асуухад Тэр хариулсангүй, дахин асуухад ч хариулсангүй, гурав дахиа асуухад нь аргагүйн эрхэнд: “Тэгэлгүй яахав дээ! Хэн энд амьдрахаар буцаж ирэхийг хүсэх вэ? Энэ махан биед ирэхийг хүсэх хэн байх вэ? Буцан ирж, энэ махан биеийн шоронд хүчээр сууна гэдэг үнэхээр аз жаргалгүй явдал.” гэж хариулжээ.

Яг үүнтэй адил, хэрвээ бид өөрийгөө сайтар дадуулж чадвал дэлхийг орхих мөчөө хүлээх тэр үедээ бид дэлгүүрээс чихэр, жигнэмэг авчрах эхийгээ гэртээ ирэхийг хүлээх хүүхэд шиг л байна. Сүнслэг бясалгал сайтай хүн үхэх мөчөө хүлээх нь яг л ногооны захаас юм аваад ирэх эхийгээ хүлээх хүүхэд мэт айх юмгүй байдаг. Гэвч ихэнх хүн амьд байхдаа дадуулаагүй байдаг тул үүнийг хэрхэн хийхээ мэддэггүй, яах ёстойг нь хэн ч зааж

өгөөгүй тул нас нөгчих үедээ маш их зовдог.

Энэ дэлхийд бидэнд янз бүрийн зүйлийг зааж сургадаг олон хүн байдаг, эцэг, эх маань хэрхэн идэх, хэрхэн алхахыг заасан, багш нар англи хэл, хятад хэлээр хэрхэн бичихийг зааж, бас өөр олон зүйлийг сургадаг, эмч, сувилагч, эх баригч нар ирээдүйн эхчүүдэд жирэмсэн байх үедээ биеэ хэрхэн арчлах болон хүүхдээ хэрхэн асрах гэх зэргийг зааснаар хүүхдээ хэрхэн өвдөлт багатай, хялбархан төрүүлэх аргад сургадаг.

Гэтэл нас нөгчих үедээ юу хийхийг хэн ч бидэнд заадаггүй. Энэ асуудлыг орхигдуулсан байна. Төрөх, өтлөх, өвдөх, үхэхийн дотроос төрөхийг бидэнд зааж өгдөг хүмүүс байдаг, өтлөх үед асрах хүнтэй, өндөр насны тэтгэвэр, эсвэл халамжийн тэтгэмжийг урьдчилан бэлтгэнэ, өвдсөн үед эмчлэх эмч нар бий, эмнэлгийн ажилтнууд өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, эсвэл өвчин бага тусахын тулд юу хийх зэргийг зааж өгнө. Харин “үхэх”-ийг хэн ч заадаггүй. Ингэж болохгүй. Тиймээс маргааш Багш нь та нарт яаж “үхэх” (*авшиг хүртэхийг хэлж байна*)-ийг заах болно. Өнөөдөр эхлээд нас нөгчих үеийн нөхцөл байдлыг ярилцъя. Хүмүүсийн ихэнх нь нас нөгчих үедээ энэ дэлхийг орхих хүсэлгүй байж, ээж, аав, эхнэр, нөхөртөө хоргоддог. Яагаад вэ? Учир нь энэ амьдралынхаа туршид тэдэнтэй хамт амьдарсан, өдөр бүр тэдний тухай боддог тул салахын цагт уураг тархинд нь зөвхөн тэд л бодогддог. Хайрлаж дуусаагүй байгаа болохоор эхнэртээ хоргодоод: Тэр минь одоо ч ийм залуугаараа байна, хэн түүнийг минь халамжлах вэ? Хүүхдүүд балчир байна, би одоо ингээд явчихаж яаж болох вэ гэж дотроо бодон ихэд санаа зовно. Ингэж санаа зовсон үедээ бид хамгийн их, хамгийн чухал хүсэл найдвараа хүүдээ, эхнэртээ, эсвэл нөхөртөө тавьдаг. Тэгээд энэ дуусаагүй оюун санааны хүчээр дахин төрөл авна.

Дахин төрөл авахдаа түүнийхээ эхнэр, нөхөр, аав нь болохгүй, нохой болж ч магад, ингэвэл байдал нилээд төвөгтэй болно. Нохой болсон ч түүнийхээ ойр байж болох юм, тиймээс энд л зовлонтой тал нь байдаг. Хэрвээ бид дахин төрөхдөө урьдын адил аав нь, эсвэл эхнэр, нөхөр нь болж чаддаг бол тийм ч муугүйсэн. Тийм байдаг бол мэдээж бүгдийг буцаж ирэхийг урина.

Гэвч тухай бүр хүсэн хүлээсэн болгондоо хүрэх боломжгүй, яагаад вэ? Учир нь үйл байвал үр байна. Жишээлбэл: Хэрвээ бид жүрж таривал жүрж хураана, алим таривал алим хураана. Хэрэв амьд ахуйдаа ямар ч сайн үйл хийгээгүй, зөвхөн муу үйл л хийж явсан бол нас барсныхаа дараа эргэж ирвэл мэдээж муу

үйлийн үрийг амсах нь тодорхой. Хэрвээ бидний шинж чанар, зан ааш, амьдралын хэв маяг нохойнхтой төстэй байсан бол дахин хүн болох эрхгүй байж, эргэж төрөхдөө нохой болох ёстой. Энэ нь Эзэн Бурхан биднийг шийтгэхийг хүссэн хэрэг биш, харин бид өөрсдөө ийм зам тавьж, ийм нөхцөл байдлыг бий болгосон байна. Бид алим таривал алим хураах нь мэдээж. Нохой болох үйл тарьсан бол нохой болох үрийг л олж авна. Хүн болох үйл хийсэн бол үр нь хүний төрөл байна.

Хүн гэж юу вэ? Хүн өглөг өгөх, сахил сахих, хүлцэл тэвчээрийг дадуулах, хичээнгүйлэн дэвших, даяанд агуулах гэх мэтийн чанаруудтай. Аливаа хүн таван сахилыг сахих ёстой. Үүнд: амь хөнөөхгүй, хулгай хийхгүй, согтууруулах ундаа уухгүй, садар самуун явахгүй, худал ярихгүй зэрэг орно. Амь хөнөөхгүй гэдэг амьтны мах идэхгүйг багтаадаг. Учир нь бид хэдийгээр өөрсдөө алж хөнөөдөггүй ч бидэнд идүүлэхийн тулд бусад хүн амьтныг алдаг. Тэд бидэнд зориулан алдаг тул энэ нь дам байдлаар амь хөнөөсөн хэрэг болдог, тиймээс бидэнд бас нөлөөлнө. Хэрвээ бид энэ таван сахилыг сахиж чадахгүй бол дахин хүн болж чадахгүй.

Тиймээс аль ч шашны судар номд энэ дэлхийг тэгтлээ их бодох ёсгүйг, мөн үгүйлэн санаж зууралдахгүй байхыг онцолсон байдаг. Яагаад вэ? Учир нь хэрвээ бид энэ дэлхийн тухай бодох юм бол буцаж ирэх ёстой болно. Харин Эзэн Бурханыг бодвол дээшээ дэвшинэ, Бурханыг бодвол Бурханы оронд очно. Тиймээс шашнууд энэ бүхнийг бидэнд сургадаг юм. Гэхдээ Бурхан, Эзэн Бурханы тухай бодох амаргүй.

За, та нар даруйхан ангижирмаар байна уу? Авшиг хүртэх гэдэг нь ангижрахыг сурах явдал юм. Хэрэв айж байвал авшиг авахаар ирэх хэрэггүй. Авшиг хүртээх гэдэг нь Багш нь та нарт яаж “үхэх”-ийг зааж байгаа явдал юм. Би өөр зүйл заагаагүй, нас нөгчих үед ямар байдгийг л заадаг. Авшиг хүртэх үе нь үхэхтэй л адил, гэхдээ энэ нь зовлон шаналгаатай үхэл биш, харин хуурмаг үхэл, баяр жаргалтай үхэл. Хэрвээ үхэхээс айж байвал авшиг хүртэх хэрэггүй. Авшиг хүртэх нь яг Багшийнх нь одоо ярьж байгаа нас нөгчих үеийн нөхцөл байдалтай адилхан. Энэ нь аймаар биш төдийгүй, маш сонирхолтой байдаг.

Хангалттай буянгүй хүн нас барвал дахин төрөл авахдаа адгуус, эсвэл чөтгөр болдог, үүнд: бирд, хэрмэл сүнс болно. Долдугаар сард та нар салют буудуулан хөөр хөгжөөн болж, хоёр тахиа, нэг үхэр, нэг гахай, гурван алим, гурван багц хүжээр тахил өргөж, буг, өлөн чөтгөрийг тахидаг. Тахил өргөх хүнгүй бол тэд

өлсөж үхэх байх. Буянгүй хүн нас нөгчвөл тиймэрхүү чөтгөр, эсвэл бирд болно.

Хүнд үйл түйтгэртэй хүн нас нөгчвөл тамд унана. Үйл түйтгэр гэж юу вэ? Муу үйл, жишээ нь: амь хөнөөх, садар самуун явах, хууран мэхлэх зэрэг амьддаа хийсэн муу үйл юм. Багш нь та нарыг зориуд айлгаагүй шүү. Судар номд бичсэнийг л ярилаа. Там байхгүй биш, үнэхээр бий. Хамаг төрөлтний үйл, үрээр там бий болсон.

Багш нь сая жүрж таривал жүрж хураана гэв. Сайн үр таривал сайн үр дүн амсана. Муу үр таривал муу үрийг эдэлнэ. Там бол бидний хийсэн муу үйлийн үрээр бий болсон. Диваажин байвал там байна, там байдагт итгэвэл диваажин байдагт ч бас итгэх хэрэгтэй. Буг байдагт итгэвэл бурхан байдагт мөн итгэх хэрэгтэй. Буян муутай хүмүүсийг яриад яах вэ. Би та нарыг бүгд буянтай байгаасай гэж хүснэ. Формоса их буянтай газар бололтой. Чинээлэг хүн тун олон. Гэвч нас нөгчсөнийхөө дараа яахаа мэддэггүй, энэ талаар ярьдаг хүн байхгүй.

Хүний заяа төөргийг үздэг хүн тун олон. Тэд “Таны байдал тун давгүй шүү. Хоёр жилийн дараа их баяжих юм байна. Сургуулиа төгсөөд баян эзэн болно.” гэх зэргээр хэлнэ.

Гэвч нас нөгчсөний дараа хаана очихыг хэлж өгөх хүн байхгүй. Бидний хамгийн их сонсох дуртай зүйлийг хэлж өгөх хүн алга. Хамгийн их мэдэхийг хүсдэг зүйлийг заах хүн байхгүй, тийм биз? Элдэв хэрэгтэй, хэрэггүй зүйл л заадаг.

Жишээ нь, хүүхэд төрүүлэхийг заалгаагүй ч төрж болно. Амьтдад үр төлөө төрүүлэхийг хэн ч заагаагүй, гэсэн ч тэд өсөж үржиж, асар олон болдог. Гэхдээ хүн төрөлтнүүд дэндүү “нигүүлсэнгүй” болчихжээ, дэндүү ихээр өсөж үржихээс нь санаа зовоод тэднийг идэж дуусгах дөхсөн байна, тийм биш үү? Хэн ч тэдэнд заагаагүй, гэвч тэд маш олон үр төл төрүүлдэг. Тиймээс “төрөх”-ийг заах шаардлага байхгүй.

“Өтлөх”-ийн тухайд бол бид угаасаа л хөгширнө. Хэдэн арван жилийн дараа яалт ч үгүй аяндаа өтөлнө. Тэтгэврийн мөнгө, даатгалын мөнгө байсан ч баталгаагүй. Зарим хүн хэдийгээр тэтгэврийн мөнгөтэй ч тийм ч урт насалдаггүй, тийм биз дээ? Тэтгэврийн мөнгөө эдлэх хүртлээ урт насалж чаддаггүй.

“Өвдөх” үед эмч олон байлаа ч баталгаагүй, тийм биз? Одоо эмчлэгддэггүй өвчин их болжээ. Жишээ нь, одоо ч ДОХ-ыг эмчлэх

эм байхгүй. Хорт хавдрыг ч эмчилж чадахгүй байна, тийм биз?

Орчин үеийн хүмүүс их мөнгөтэй, эмнэлэг олонтой, эм элбэгтэй болсон. Гэхдээ өвчин бол өвчин. Өвчлөл урьдынхаас илүү төвөгтэй болсон. Сонсоогүй өвчин маш их гарч байна, яагаад вэ? Учир нь бидний үйл түйтгэр дэндүү их болсон байна.

Манай гарагийн хүмүүс улам сул дорой болж, ёс суртахуунаа гээж, Мөр ёсонд нийцэх өөр нэгэн амьдрал байдгийг мартжээ. Байгалийн хуульд зохицон амьдрах ёстойг ч бас мартсан. Байгалийн баялгийг дураараа ашиглаж, мод ургамлыг тасдаж, тайрч байна. Тухайн газрын байгалийн нөхцөлийг урьдчилан тооцолгүй мод ургамлыг тайрч, байгаль орчныг сүйтгэж, өнөөдөр биднийг ууланд аялан зугаалах боломжгүй болгожээ.

Олон газрын замын хажуугийн модыг огтолсноос хөрсөө тогтоон барих аргагүй болж, нөмөрлөх модгүйгээс хөрс хурдан элэгдэж байгаа нь эдгээрийн ганцхан жишээ. Мод огтлохоос гадна ан амьтдыг устгаж, хүмүүсийг хөнөөж, бүхэл бүтэн улс орныг сүйрүүлж, хот тосгодыг ч сүйтгэж байна. Дэлхийн хоёрдугаар дайны үед Японы Хирошима хотыг тэр аяар нь газартай тэгшилсэн.

Бид мод огтлоод зогсохгүй ан амьтан хөнөөнө, цаашлаад хүн алах болсон. Ингэж ёс суртахууны асар их доройтолд орж, уруудан доошлов. Иймэрхүү уур амьсгалыг бий болгож, тийм нэг үйлийн үрийг үүсгэсэн учраас бид дэлхий ертөнцийг маш аймшигтай газар болгон хувиргажээ. Уг нь дэлхий тун сайхан газар. Хүний бие үнэхээр хамгийн эрхэм дээд юм бол дэлхий ч хамгийн сайн сайхан газар байх учиртай, тийм биз дээ? Гэвч өөрсдийн байр сууриа мэдэхгүйн улмаас бид эрхэм дээд үнэ цэнээ унагаж байна. Үнэхээр харамсалтай.

Бид өөрсдөөсөө: “Бид төрсний эцэст үхнэ, тиймээс хэдэн амьтан хорооход ямар асуудал байна вэ? Та амьтан алаагүй ч тэд удалгүй үхнэ, гамшигт өртөж, эсвэл өвчин тусаад үхнэ. Хэрвээ бид тэр хүнийг алаагүй байлаа ч тэр өвчин тусаад эсвэл өтлөөд үхнэ. Тиймээс хэдэн хүн хөнөөхөд ер хамаагүй байх.” гэх мэтээр асууж магадгүй.

Мэдээж хамаатай зүйл олон, учир нь үйл, үр нь дуусаагүй байхад түүнийг хүчээр хөнөөжээ. Жишээ нь, жимсийг гүйцэд боловсорсны дараа иддэг. Боловсроогүй үед нь идвэл хордож, гэдэс өвдөнө, толгой өвдөнө, хүнсний ногооны хувьд ч адилхан. Тиймээс амь хөнөөх нь сүнсийг нь хүчээр гарган явуулж байгаа

хэрэг. Явах дургүй, бэлтгэж амжаагүй, цаг нь болоогүй байхад хүчээр гаргаж явуулбал үйл түйтгэр үүснэ.

Би нэг түүх ярья, Шагжамуни Буддаг заларч байхад нэгэн улсын хааныг хүү нь барьж хорьжээ. Эцэг, эхдээ ачлалтай байх нь үр хүүхдийн үүрэг. Гэтэл тэр ханхүү ачлалгүй төдийгүй, эцгээ шоронд хорьсон байна. Хатан эх нь нөхөртөө хоол унд хүргэж ирэх тэр үед ханхүү хэдийнээ эзэн хаан болсон байсан бөгөөд ээж нь хаан аавд нь хоол хүргэснийг сонсоод ихэд хилэгнэж, хатан ээжийгээ бас хорьжээ. Та бүхэн Бурханы шашны түүхийг уншвал үүнийг мэднэ. Тэр хоёр хоёулаа хоригдсон байна.

Багш нь өчигдөр “Цаглашгүй насан хутагийн судар”-ыг тайлсан. Тэр бол энэ хатан ээжид зориулж айлдсан судар. Хааны хатан шоронд хоригдоод ихэд шаналж, Бурхан Багшаас тусламж гуйн залбирчээ. Шагжамуни Бурхан түүний Багш нь байсан. Тэр аль хэдийнээс Бурхан Багшийг даган суралцаж байжээ. Тиймээс Бурхан Багшид хандан туслахыг гуйсан байна, Бурхан Багш ч ирж. Шагжамуни Буддагийн хувилгаан бие, Анандын хувилгаан бие, бас Молом тойны (Модгальяана) хувилгаан бие хамтдаа шоронд ирж, хатанд сургаал айлдаж, тайтгаруулсан байна. Тэр үед хатантан Бурхан Багшаас: Энэ дэлхийгээс илүү сайн, илүү амар тайван газар хаана байна вэ? Зовлон шаналал багатай гэж асуухад Бурхан Багш түүнд олон ертөнцийг харуулжээ. Хатанд Төгс баясгалант орон таалагдсан байна. Тэр үеэс хойш бид энэ Цаглашгүй насан хутагийн судартай болсон юм.

Тэр хатны үйл үр нь түүний өмнөх төрөлтэй холбоотой байв. Хатан ихэд шаналж, Шагжамуни Буддагаас: Бид ямар ч муу үйл хийгээгүй, гэтэл яагаад ийм үйлийн үртэй болов? Яагаад ханхүү бидэнд муугаар хандав? Та бидэнд учрыг тайлж өгнө үү хэмээн асуухад Шагжамуни Будда түүнд: Та санаж байх ёстой, олон арван жилийн өмнө үр хүүхэдгүй байхдаа та хоёр үрийн хутаг гуйж, чин сэтгэлээсээ даатгасан байна. Нэгэн өдөр зүүдэнд тань тэнгэрийн элч ирж танд: Хималайн ийм нэгэн их ууланд бясалгаж буй хүн таны хүү болон төрөөд танай ханхүү болно гэж хэлсэн байна. Дараа өдөр нь та хоёр сэрээд Хималайн ууланд бясалгаж буй хүнийг олж уулзан манай хүүхэд болох дуртай эсэхийг асуухаар очжээ.

Тэрээр самадид орж, үйлийн үрийн тэрхүү барилдлагыг хараад хэлсэн нь: Тийм байна, би дуртай. Гэвч миний энэ нас дуусахад гурван жил хэрэгтэй. Хаан, хатан хоёр түр хүлээнэ үү. Гурван жил бясалгал дадуулахаас нааш миний амьдрал

дуусахгүй, тэгээд би танай хүү болон төрнө гэв. Нөгөө хаан ихэд яарч, би одоо их хөгширсөн, дахиад гурван жил хүлээж чадалгүй үхэж мэднэ. Та одоо л манай хүүхэд болбол сайн байна гэхэд бясалгагч: Болохгүй, та намайг хүчилж болохгүй, миний нас хараахан дуусаагүй, үхэх цаг болоогүй байна гэв. Тэр хаан хүлээж төвдөлгүй, сэлэм далайн түүнийг сүрдүүлж, та одоо л миний хүү болох хэрэгтэй, би хүлээж чадахгүй гэв.

Хаан хараахан бясалгал хийдэггүй, тэвчээр муутай, өглөг өгдөггүй, сахил сахидаггүй, хүлцэл тэвчээрийг дадуулдаггүй, Бурханы шашныг ойлгодоггүй байсан учраас түүнийг хүчээр үхүүлэхийг санаархсан аж. Бясалгагч: Миний нас дуусах арай болоогүй, гэвч та эрх мэдлээрээ надад үхлийг тулгавал хожим таны хүү болон төрсөн ч ачлалгүй төдийгүй, таныг хөнөөж, хаан суудлыг булааж авах болно гэж хэлээд хор уун үхэв гэнэ.

Түүнийг нас нөгчсөний дараа удалгүй хатан бие давхар болж, ханхүү төрүүлэв. Мэргэн хүнээр хүүгийн заяа төөргийг шинжүүлэхэд: Ханхүү хожим хааны ордныг түйвээж, хааныг хөнөөнө. Хатан ээждээ ч бас сайнгүй байна гэж хэлжээ. Тэр хоёр сонсоод ихэд айж, муу ёрын явдал тохиолдохоос эмээн ханхүүг өсгөхөөс татгалзан ордны гурван давхраас шидэж алахыг оролдов. Гэвч ханхүү үхсэнгүй, ганц хуруу нь л хугарчээ. Өргөөд автал үхээгүй, харин часхийтэл уйлж гэнэ. Хожим хурдан өсөж, өсгөлүүн биетэй, ухаалаг, царайлаг сайхан хүү болсон тул хаан, хатан хоёр их хайртай болж, дахин хөнөөх санаа агуулсангүй гэнэ. За яахав! Зүгээр дээ, өсгөө, өсгөө гэж бодох болов. Түүнийг өсөж том болоод ёс суртахууныг сөрсөн, ачлалгүй хэрэг үйлдэнэ гэж үнэхээр санаагүй байжээ.

Шагжамуни Буддаг ярьж дууссаны дараа хатан санаж эхлэв, тэгээд ихэд харамсан гэмшиж, хүүгээ үзэн ядахаа больжээ. Хүү нь ч мөн хожим ихэд гэмшиж, Бурхан Багшийг шүтэн дагаад хичээнгүй сайн бясалгаж, сайн хүн болсон гэнэ.

Багш нь энэ түүхийг үйл, үрээс мултрахын аргагүй, ямар үр тарина, тийм үр дагаврыг хүртдэг гэдгийг та бүхэнд ойлгуулахын тулд ярилаа. Бид амь насыг, хүний амийг хөнөөвөл сүнсийг нь хүчээр гарган явуулсан хэрэг болохоор энэ үйл, үрээ заавал эдэлж, хожим тэд биднийг алж хөнөөнө, эсвэл биднийг хүчээр үхүүлэх болно. Бид тэдэнд яаж хандсантай яг ижил нөхцөл байдал үүсэх юм. Магадгүй бид амьтны төрөл авч ирээд алуулж ч мэднэ, заавал хүн болж төрөөд алуулахгүй байж магадгүй, эсвэл энэ төрөлдөө алуулахгүй, дараа дахин нэг төрөл авах үедээ энэ үйлийн үрээ

төлж барагдуулна.

Тиймээс шашны ямар ч урсгал амь хөнөөхийг хатуу цээрлэдэг. Амь хөнөөхгүй байх гэдэгт амьтны амийг хөнөөх ч бас багтана. Учир нь амьтад сүнстэй, тэд үхэхээс айдаг, амьдрах хүсэлтэй байдаг. Хэрвээ тэд амьдрах хүсэлгүй бол мэдээж асуудалгүй. Өвс ногоо, мод чулуу бол амьд явах хүсэл ухамсаргүй, үхэхээс айх айдасгүй учраас хүнсний ногоо, жимс идэхэд үйл түйтгэр тун бага. Хэрвээ бид өдөр бүр хоёр цаг хагас Арьябалын аргаар бясалгавал иймэрхүү үйл түйтгэрийг байхгүйтэй адил болгоно. Гэтэл амьтад хүнтэй адил амьдрах хүсэл тэмүүлэлтэй, тэр нь амьтдын далд ухамсарт хэдийнээ суучихсан байдаг учраас амийг нь хөнөөвөл асуудал үүсэх нь тодорхой.

Тэгвэл хүний нөхцөл байдал ямар бол? Хүмүүс бид хэн нэгэнд алагдаагүй, хэн ч бидэнд үхлийг тулгаагүй байхад яагаад тэгж их зовдог вэ? Учир нь бид үхэлд бэлдээгүй, үүд маань нээгдээгүй байдаг.

Жишээ нь, эндхийн хаалга бүгд хаалттай, удтал нээгээгүй бол мэдээж хаалга нээгдэхээ болино. Хүчлээд ч нээгдэхгүй, галын аюулын үед сандарч, нээхийг оролдсон ч нээгдэхгүй тул эвдэхээс өөр аргагүй. Гэвч ингэж нээвэл түлэгдэнэ, зовно, өвдөнө. Хэрвээ өдөр бүр нээдэг байсан бол дадал болчихоод түлхмэгц онгойно, ямар ч асуудалгүй шуудхан гараад явчихна.

Үүн шиг, бидний бие махбод бас олон үүд хаалгатай. Гэхдээ хаалга бүхэн сайн гэсэн үг биш. Жишээ нь, бид гуравдугаар давхарт амьдардаг бол мэдээж цонхоор үсэрч гарч болохгүй, тэгвэл бэртэж гэмтэнэ. Буух шаттай хэдий ч хаана байгааг нь мэдэхгүй, эсвэл сандарч тэвдээд шатаа олохгүй, гал дундуур гүйвэл түлэгдэнэ.

Тиймээс заавал дадуулах хэрэгтэй. Дайнгүй үед манай улсын засаг төр биднээр яг л дайны үеийнх шиг дасгал сургуулилт хийлгэдэг. Намайг Ау Лакт байхад манай улс мөн дохиоллын систем суурилуулсан байсан бөгөөд долоо хоногт, эсвэл сардаа нэг удаа сургуулилт хийдэг байв. “Үү... Үү...” гэх дуунаар бүгд аюулгүй газар нуугдаж, тав, арван минутын дараа дохио унтрахад тардаг байв. Мэдээж ямар ч аюул болоогүйг мэдэвч өдөр бүхэн ийм сургуулилт заавал хийх ёстой.

Гэтэл нас барсан хүн өмнө нь дадуулаагүй байдаг. Бид ч бас хэзээ нэгэн цагт нас нөгчинө, тиймээс заавал урьдчилан дадуулах хэрэгтэй гэдгийг хэн ч санадаггүй. Ихэнх хүн: Өглөө юу идэх вэ?

Өдөр, орой бас юу идэх вэ? Арван цагт гадуур гарч амттан идье гэх мэт зүйлийг л өдөр бүр бодож байдаг. Та нар гадуур явбал ойлгоно. Багш нь ном тайлах үед ашрамд ихдээ хэдэн зуун хүн цугладаг. Гадуур хүн их ч ном сонсох хүн тун цөөн. Хоол эргүүлэх хүн харин маш олон. Тэд үхэлд бэлдэх дургүй, мартчихсан байдаг. Хэзээ нэгэн цагт үхнэ гэдгээ тодорхой мэдэж байгаа ч дахин зуун жил амьдрах юм шиг л явж байдаг.

Үнэхээр зуун жилийн хугацаа бий юу? Хэлэхэд хэцүү, маргааш ч үхэж мэднэ. Олон хүн залуугаараа хорвоог орхидог. Тиймээс бид ухаалаг байж, амьддаа үхэлд бэлдэх хэрэгтэй.

Та нар хүүхдээ төрүүлэхээс өмнө бүгдийг бэлдчихдэг биз дээ? Урьдчилан оёж урлаж, хөөрхөн хувцас худалдан авч, хүүхдээ төрөхийг хүлээдэг. Хүйсийг нь хүртэл мэдчихсэн байдаг. Төрөөгүй байхад л хамаг юм нь бэлэн болчихно. Тэгвэл яагаад үхэхдээ бэлддэггүй вэ? Нас нөгчих мөч бол хамгийн чухал үе мөн. Төрөхөд олон хүн эргэж ирдэг. Олон хүн хань бараа болж, тайтгаруулна. Асарч халамжилна. Харин нас нөгчих үед хань болох хүнгүй. Тэр үед ихэд ганцаардаж, маш их зовно. Нас нөгчихөөсөө өмнө яагаад бэлддэггүй вэ? Энэ нь ухаалаг алхам мөн үү?

Бид урьдчилан бэлдээгүй учраас зовдог. Хэрэв бэлдэхийг хүсвэл эхлээд нээж чадах хүнээр хаалгаа нээлгэх хэрэгтэй. Тэгээд өдөр бүр нээж хааж, дахин дахин нээж хааж байвал гацахгүй чөлөөтэй болно, нээе гэхэд л хурдан нээгддэг болгох хэрэгтэй. Эс бөгөөс гарахад амаргүй. Учир нь бид олон хаалгатай ч тэр бүхэн гарах хаалга биш. Жишээ нь, энэ цонх харахад өргөн том, зай ихтэй ч цонхоор гарах гэвэл толгойгоо цохино. Гаръя гэвэл заавал хаалгаар гарах хэрэгтэй. Гэхдээ тэр хаалга нээгдээгүй бол гарч чадахгүй.

Бидний бие махбодын нүд, чих, хамар гэхчлэн бүгд л хаалга мөн, нийтесөн сүв байдаг бөгөөд тэдгээр нь бүгд хаалга мөн. Гэхдээ энэ бүх хаалгаар гарвал бид үхэж, төрөх сансрын хүрдэнд дахин эргэлдэж, доогуур түвшинд төрөл авна. Харин өөр нэгэн хаалга байдаг бөгөөд түүгээр гарвал бид тун дээгүүр түвшинд очно. Тэр хаалга нүдэнд үзэгдэхгүй, энгийн түлхүүрээр нээгдэхгүй, зөвхөн бясалгалтай хүн нээж чадна. Хэрвээ бид өөрсдөө нээж чадахгүй бол үүнийг хэдийнээ сайтар дадуулсан хүнээс асуух хэрэгтэй. Учир нь тэр хүн өөрийнхөө хаалгыг хэдийн нээсэн тул хэрхэн нээхийг мэднэ, бас бидэнд яаж хийхийг зааж чадна. Энэ хаалгыг нээх тун амархан.

Бид бүгд “төрөх”, “өтлөх”, “өвдөх”-өд бэлтгэлтэй байдаг. Ажиллаж байх үедээ мөнгөө хуримтлуулдаг. Хожим өвдөж, ажил хийх чадалгүй болохын цагт хэрэглэх мөнгөтэй байна. Хэдий тийм ч жаахан ч гэсэн ач буян хураавал нас нөгчихийн цагт хэрэг болно. Ач буяныг өглөг өгөөд хураахгүй. Гэхдээ өглөг өгөх нь мэдээж тустай. Бидний сэтгэл нилээд хоосрон тэлж, өдөржингөө өөрийн явдлыг л бодоод байлгүй, бусдыг жаахан ч гэсэн бодно. Хэрвээ бид бусдын талаар бодож байвал бидний бодол сэтгэлийн орон зай тэлж, уужим болдог. Тиймээс дайны үед хүмүүсийн сэтгэл нилээд уужим болж, зөвхөн улс эх орныхоо амар тайван, аюулгүй байдлыг бодож, өөрсдийн гэр бүлээ бодохгүй байдаг тул бодол сэтгэлийн орон зай нь тэлдэг. Жишээ нь, Бидний нүд зөвхөн хамраа л хардаг бол хамраа л мэдэхээс цаашгүй. Сайхан хүүхэнд сэтгэл татагдаад хамраа мартах үед бидний бодол сэтгэлийн орон зай тэр бүсгүйг хүртэл тэлнэ, тийм биз?

Үүнтэй ижил, өглөг өгвөл бидний сэтгэл нилээд уужирч, энэ “би”-гээ мартан бодол сэтгэлийн орон зай маань тэлнэ, хэдий чинээ тэлж өргөжинө, сэтгэл төдий чинээ хөнгөрөн тайвширч, бачуураад байсан мэдрэмж алга болно. Тиймээс өглөг өгөх нь хүнийг чөлөөтэй, тааваараа, аз жаргалтай болгодог. Учир нь зүрх сэтгэл нь уужран тэлжээ, яг л алсын бараа харах шиг. Хэрвээ олуулаа умгар өрөөнд амьдарвал сэтгэл давчиддаг, тийм биз? Яг л хоригдож хашигдсан мэт санагдана. Хэрэв нилээд уудам том өрөөнд байвал агаарын солилцоо сайтай байдаг, тийм биз? Зарим хүн хот газар дэндүү удаан амьдарвал давчдаад амралтаа авч, зугаацахаар хөдөөг зорих юм уу, эсвэл уул толгодоор гүйдэг нь орон зайн шаардлагаас болдог аж.

Өглөг өгөхөд ч мөн адил, өглөг өгснөөр нэгэн үл үзэгдэх орон зайг өөртөө бий болгож, амьсгалах сайн орчныг бүрдүүлдэг. Өглөг бидний сүнсэнд тустай. Тиймээс аливаа шашны урсгал бусдыг өөр шигээ хайрлахыг сургадаг. Өглөг өгөх нь бидэнд их тустай. Гэвч өглөг өгөх нь билиг ухааны үүд хаалгыг нээхтэй ямар ч холбоогүй. Өдөр бүр өглөг өгсөн ч сая жилийн дараа ч хаалга нь нээгдээгүй хэвээрээ л байна. Энэ хаалгыг тусгай мэргэшсэн хүн нээдэг. Яг л мэс заслыг мэс заслын эмч л хийж чадна, барилгыг барилгачин хүн л барьж чадна, англи хэлийг англи хэлээр мэргэшсэн багш л зааж чаддаг шиг. Билиг ухаан нь нээгдэж гэгээрсэн хүн бусдыг гэгээрүүлэх чиглэлээр мэргэшсэн байдаг. Өөрийн хаалгаа нээсэн л бол бусдын хаалгыг нээж тусалдаг.

Хэрвээ үл үзэгдэх энэ хаалгаа нээхгүй бол бид замбараагүй гүйлдэнэ. Жишээ нь, бид амьддаа “үхэх”-ийг дадуулаагүй бол нас

нөгчих үед гарах хаалга маань хаалттай байх бөгөөд сүнс гарч чадахгүй тул нааш цааш гүйхээс цаашгүй, тиймээс ихэд зовдог. Хэрвээ хаалга нь хэдийн нээгдсэн бол сүнс (эсвэл үзэл ухамсар, бидний эзэн) өөрөө аяндаа гарна.

Хэрвээ сайн хаалгыг нээсэн бол сүнс гарсныхаа дараа яриангүй их л баяр жаргалтай болдог. Харин нээгдсэн хаалга нь муу бол сүнс гармагцаа саад тотгортой учирна. Тэр ямар ч хамаагүй нэгэн хэвлий олж ороод төрөл авдаг. Хэрвээ хүний хэвлийд орж чадвал бас ч давгүй. Харин амьтны хэвлийд орчихвол төвөгтэй.

Энэ бол үнэн бодит зүйл. Бид сонин хэвлэл, зурагтаас ямар ямар амьтан уйлж байгаа нь яг хүн шиг, мөн ямар амьтан яг хүн шиг харагдав гэх зэрэг мэдээлэл сонсдог. Энэ бүхэн бол сүнс замаа мэдэхгүй замбараагүй тэнэж одсонтой холбоотой юм.

Багш нь авшиг хүртээхдээ та нарт ямар замаар явах ёстойг зааж өгдөг. Яг л агаарын довтолгооноос хамгаалах сургуулилт хийдэгтэй адилхан, хэдийгээр энэ нь жинхэнэ биш боловч бодит нөхцөлтэй тулгарахын цагт санаа амар байна. Цэрэг хүмүүс ч мөн адил, Формосад насанд хүрсэн эрчүүд бүгд цэргийн алба хаадаг, тийм үү? Цэргээс халагдсаныхаа дараа ч хааяа цэргийн үүрэг гүйцэтгэдэг нь дасгал сургуулилт хийх шаардлагатай байдаг учраас тэр.

Сүнслэг бясалгалын хувьд ч мөн адил, авшиг хүртэх үед Багш нь та нарт хэрхэн үхэхийг сургана. Өөр онцгой зүйл заахгүй, зөвхөн хэрхэн үхэхийг л заана. Гэхдээ та нар өдөр бүр дадуулах хэрэгтэй, тэгэхгүй бол мартаж орхино. Яагаад вэ? Учир нь өдөр бүр энэ дэлхийтэй хэт их найзалж, дэндүү ойр байдаг, эхнэр, нөхөр анхаарлыг тань татаж, ажил алба, ажлын газрын эзэн хамаг анхаарлыг тань татчихдаг. Жишээ нь, бид дөнгөж сайхан сэрүүн зүүд зүүдлэхийг завдтал эзэн, эсвэл эхнэр ирж үймүүлнэ, тийм биз? Тиймээс бид ядаж өдөр бүр хоёр цаг хагасын зав гаргаад үхэхийг дадуулах хэрэгтэй.

Энэ нь яг цэрэг шиг, цэргийн хүн болохын тулд урьдаар сайн дасгал сургуулилт хийх хэрэгтэйг хэн бүхэн мэднэ. Дайны үед хүн амархан алж чадна. Гэвч нас нөгчихдөө өөрийгөө урьдчилан дадуулах хэрэгтэйг хэн ч санадаггүй. Энэ нь тийм ч нууцлаг, зүй ёсонд нийцэхгүй хэрэг биш. Энэ бол яг л хоол идэх, унтахтай адил жам ёсны явдал. Гэвч ийм зүйлийг хэн ч бидэнд сануулаагүй, энгийн хялбараар тайлбарлаж өгөөгүй учраас бид үхэл бол тун ярвигтай, ер бусын нууцлаг зүйл хэмээн боддог, үүнийг зөвхөн

Шагжамуни Бурхан л хийж чадна, бид мэтийн “эгэл хүн” яаж чадах вэ гэж боддог.

Үнэндээ бид Түүнээс юугаараа ялгаатай вэ? Тэр амтай, хамартай, чихтэй бол бидэнд ч бас байна. Шагжамуни Бурханы үйл түйтгэр биднийхээс бүр ч илүү. Энэ тухай хэн ч бидэнд хэлж яриагүй, учир нь тэд ярьж зүрхлэхгүй. Өнөөдөр та нарт Шагжамуни Бурханы үйл түйтгэрийн талаар ярьж өгье.

Шагжамуни Бурхан нэгэн ханхүү болж мэндэлсэн. Хүн бүхэн Түүнийг тэврэх гэж булаацалдана, уйлбал арав, бүр зуун хүн очиж асарна, Түүнд бусдын ачийг хариулах төлөөс маш их байв. Гучин нас хүртлээ хийсэн сайн юмгүй, өдөр бүр идэж ууж, наргиж цэнгээд бас үе үе ан хийнэ, хүйтний улиралд суух өвлийн ордон, халууны улиралд залрах сэрүүн лаврин, хавар амьдрах хаврын харштай байв. Иймэрхүү амьдралаар амьдарч байсан Тэр бусдын ямар тусыг бүтээж байсан бэ?

Хүн бологсод өглөг өгч, сахил сахиж, хүлцэл тэвчээрийг дадуулж, хичээнгүйлэн дэвшиж, даяанд агуулж, билгүүн ухаантай болох ёстой гэдэг. Гэвч Тэр алийг нь ч хийгээгүй. Өглөг өгч байсангүй. Үргэлж улсын сангаас хүртэж өссөн. Хүмүүс өдөр бүр Түүнд үйлчилж, аав, ээж нь дагалдаж, хүссэн бүхнийг нь тэр даруй гүйцэлдүүлнэ. Бараа бологсод хажуугаас нь хэзээ ч салахгүй. Хүссэн бүхнийг нь биелүүлнэ. Хатад нь ч бас ингэж үйлчилнэ. Бүхэл улс даяараа ганцхан Түүнд үйлчилж байв. Тэгэхээр Шагжамуни Бурхан олон хүнд өртэй болсон, тийм биш үү?

Хэрвээ хэн нэгэн хүн өглөг өгөхгүй, ажил хийхгүй бол үйл түйтгэр нь маш хүнд байдаг гэж ярьдаг. Бид сайн хүн, сайн эхнэр, сайн нөхөр байж, нийгэмдээ тус нэмэртэй байх хэрэгтэй. Учир нь дөрвөн энэрлийг заавал хариулах ёстой юм. Гэвч Шагжамуни Бурхан үүнийг өчүүхэн ч хариулалгүй гучин нас хүрчээ. Идэж ууж, наргиж цэнгэж, ертөнцийн жаргалыг эдлэхээс өөрийг хийгээгүй. Тэгэхээр Түүний үйл түйтгэр маш хүнд байхаас яахав? Гэтэл тийм хүн бас гэгээрч, Бурханы хутагт хүрч чаджээ. Гэтэл балчир багаасаа аав, ээждээ ачлалтай, улс нийгэмдээ их тустай, хайрлаж энэрэх сэтгэлтэй, өглөг өгч, сахил сахьдаг, хүлцэл тэвчээрийг дадуулдаг та нар шиг ийм сайн хүмүүс Бурханы хутагт хүрч чадалгүй яах вэ?

Хэрэв ийм байж чадвал Бурхан болж чадах нь гарцаагүйг би батална. Өөрийгөө бүү дорд үз. Энэ бол бидний асуудал, учир

нь бид өөрийгөө хүндэлдэггүй. Өөрийгөө үл хүндэлсэн хүн бусадтай их бардам харилцдаг. Өөрийгөө хүндлэх, бардамнах хоёр их ялгаатай.

Бардамнах гэж юу вэ? Бусдыг дорд үзнэ, түүний нүдэнд эмэгтэй хүн муу, боловсролгүй хүн муу, доод албан тушаалтнууд муу, дарга нар муу. Учир нь “би” тэднээс илүү цэцэн ухаантай, мөнгөгүйн улмаас л дарга болж чадаагүй гэх мэтээр бодно. Энэ бол бардам сэтгэл, өөрийгөө ч, өрөөлийг ч үл хүндэлнэ. Өөрийгөө хүндэлдэггүй учраас бусдыг ч хүндэлдэггүй. Иймэрхүү бардам сэтгэл бол нэг төрлийн өвчин, өөрийгөө хүндэлж байгаа хэрэг биш.

Өөрийгөө чин сэтгэлээсээ хүндэлдэг хүн бусдыг ч ихэд хүндэлдэг. Өөрийн үнэ цэнийг, мөн бусдын үнэ цэнийг ч хаана байдгийг мэднэ. Ийм хүн тун сайн, өөртөө их итгэлтэй байдаг. Гэхдээ тэр бардам зантай биш. Бардам зантай хүн Будда болж чадахгүй, учир нь ийм хүн бусдыг хүндэлдэггүй. Өөртөө итгэлтэй хүн л сая Будда болж чадна. Эдгээр нь ялгаатай гэдгийг та нар ойлгох хэрэгтэй. Бид өөртөө итгэлтэй байж, Бурханы хутагт хүрч чадна гэдэгтээ итгэх ёстой. Будда болж чадахгүй хүн нэг ч байхгүй. Хэрвээ би худал ярьж байгаа бол тамд унана.

Будда болж чадахгүй хүн нэг ч байхгүй атал Будда болж чадаагүй хүн тун олон байдгийн учир юу вэ? Учир нь бид өөртөө итгэлгүй, Төгс Гэгээрсэн Их Багшийн удирдлага байхгүй, биднийг бясалгаж дадуулахад урамшуулж дэмжих хүнгүй байдаг. “Бид хэн бэ? Бидний үнэ цэнэ юу вэ? Бид хэн болон хувирч чадах вэ?” гэдгийг хэн ч бидэнд хэлж яриагүй.

Магадгүй энэ талаар тийм нэгэн хүн хэлэхэд нь бид ойлгоогүй, эсвэл итгээгүй байх, учир нь нийгмийн нөлөөнд хэт автдаг. Жишээ нь, аав, ээж маань биднийг бага байхад “Энэ янзаараа чи том болоод олигтой хүн болохгүй, гарцаагүй гуйлгачин л болно.” гэдэг байсан бол тэр үгэнд нь итгэж, өсөж том болохдоо өөртөө итгэлгүй нэгэн болдог. Дараа нь нийгэм нөлөөлнө, найз нөхөд, даргынхаа: “Чи ер нь олиггүй хүн байна. ... ийм ч муу, тийм ч муу.” гэж шүүмжлэхэд бас итгэж, би ер нь үнэхээр муу хүн юм байна гэж бодно. Багш нар бас: Та нар үнэхээр тэнэг байна. Хичнээн заасан ч юу ч ойлгохгүй хэвээрээ, англиар ярьж чадахгүй, шал тэнэг гэгцгээнэ. Үнэндээ бол ердөө ч тэнэг биш. Дэлхийн явдлыг сураагүй хүн тэнэг биш ээ.

Шулуухан хэлэхэд энэ дэлхийд суралцмаар юм байхгүй, бага,

дунд, дээд сургуульд өнөөдрийг хүртэл суралцаад юу сурч болох вэ? Арван есөн жил сурсан мэдлэгээс хэдий хэрийг нь ашиглаж байна вэ? Ихэнх нь мартагдсан. Олон жил англи хэл сурсан ч ярьж чадахгүй. Франц хэл сурсан ч багшдаа буцаагаад өгчихсөн. Тоо үзсэн ч яаж бодохоо мэдэхгүй хэвээр. Одоо компьютер ашиглан бодвол илүү хурдан болсон болохоор мэдээд ч ашиггүй. Маш их зүйл сурсан ч, аль нь ч ямар ч хэрэггүй. Англи хэл сурч байгаа ч хэрхэн орчуулахаа мэдэхгүй. Их сургууль төгссөн хүн энд олон байна. Тэднээс захын зүйл асуухад мэдэхгүй. Математик гэж юу вэ гэхэд мэдэх хүнгүй. *(Их Багш инээв.)* Яагаад вэ? Учир нь энэ дэлхийн юмс бидэнд тийм их хэрэгцээтэй биш.

Энэ дэлхий мөнх бус, бид хичнээн ихийг сурсан байлаа ч хамаагүй, агуу эрдэмтэн байсан ч эндээс явах ёстой, хамгийн алдартай сод авьяастан байсан ч заавал явах л болно. Эцэстээ юу ч үгүй хоосон буцацгаана.

Тиймээс энэ дэлхийн мэдлэгийг эзэмшээгүй хүн бол тэнэг хүн биш, сургуулиа төгсөж чадаагүй хүн ч бас тэнэг хүн биш. Харин “үхэх”-эд суралцаагүй хүн бол хамгийн тэнэг хүн. Энэ бол жинхэнэ тэнэг явдал. Яагаад төрөх, өтлөх, өвдөхөд суралцаад сайн сурсан мөртлөө ганцхан “үхэх” гэдэг хичээлд л суралцсангүйдээ гэж ер бодолхийлээгүй хүн бол жинхэнэ тэнэг хүн, ойлгов уу? Учир нь нас нөгчих үед маш их зовдог! Төмөр, мод, ус, гал, шороо задрахдаа үнэхээр их, бүр маш их зовоодог.

Тиймээс хүн нас барахдаа яаж зовдог билээ, та нар мэдэх байх, тийм үү? Тэр үед өөрийнх нь сахилын багш дэргэд нь суугаад бурхны алдрыг дуудсан ч нэмэргүй, аав, ээж нь хамжилцан уншаад ч бас тус болж чадахгүй. Багш нь англиар яриад ч тусгүй, их эмчийн дипломыг нь дэргэд нь харагдахаар тавьсан ч нэмэргүй. Эхнэр, нөхөр, үр хүүхэд нь ч тусалж чадахгүй. Тиймээс бид нас нөгчих үед тусалж чадах хүнийг заавал хайх хэрэгтэй.

Өнөөдөр нэг хүн надаас: “Ихэнх хүн нас барахдаа энэ дэлхийд татагдаж, эхнэр, нөхөртөө санаа зовж, энэ ертөнцийн төлөө шаналдаг. Тэд ийм байж яаж явах вэ?” гэж асуусан. Энэ бол үнэхээр том асуудал. Зовж буй нь, дэлхий ертөнцөд татагдсаных, нөгөө талаар бэлтгэж чадаагүйнх. Тиймээс одоо амьд сэрүүн залран буй жинхэнэ Их Багшийг олох нь маш чухал юм. “Будда” гэдэг нь нэгэн жинхэнэ Их Багшийг заадаг. Багш нь “Будда” гэж ярих дургүй. Учир нь би Будда гэж яривал та нар Бурханы шашны Шагжамуни Буддатай зууралддаг. Тиймээс би Төгс Гэгээрсэн Их Багш, эсвэл жинхэнэ Их Багш гэж ярьдаг.

Жинхэнэ Их Багш гэж нэгэн хүнийг зааж байна. Тэр хүн хэдийнээ бурхны дэсэд хүрч, үхэж, төрөхийн сансрын хүрднээс ангижирсан дэсийг олж, үхэж, төрөхийн хаалгаар орж, гарч чаддаг. Энэ нь яг бид гарах хаалгаар орж, гардагтай адил хялбархан байдаг. Тэрээр биднийг дагуулан явж чадна. Тэр яагаад биднийг дагуулж чадах вэ? Учир нь амьддаа бид Түүнд шавилж, авшиг хүртвэл нас барах үед Тэр биднийг дагуулан явж чадна.

Авшиг уламжлах гэж юу вэ? Энэ нь Тэр биднийг алган дээрээ тавьж, хамгаалалтын хүрээндээ багтаасан гэсэн үг. Тийм учраас Түүний хувилгаан бие ирж биднийг дагуулна. Тэр хувилгаан бие маш үзэсгэлэнтэй, гэрэл цацарсан, гучин хоёр лагшин найраг төгс байдаг. Үүнээс гадна маш олон бурхан бодьсадва хамт ирнэ. Бид Их Багшийг болон Баруун зүгийн Төгс баясгалант орныг хармагц эхнэр, нөхрөө мартдаг. Учир нь тэр үед харьцуулж үзээд эхнэр, нөхөр маань хичнээн царай муутайг олж мэднэ, тэгээд сэтгэлдээ шууд л: “Би одоо даруй бурхан бодьсадваг дагана, та нар надад төвөг болох хэрэггүй.” гэж бодно.

Үнэндээ бодохын ч завдалгүй Багш нь ирээд л шууд авч явна. Энэ дэлхий, эхнэр нөхөр, үр хүүхдийн талаар бодох цаг байхгүй, та тэдний уйлахыг сонсож ч амжихгүй. Та зөвхөн Багшийнхаа яриа, Багшийнхаа айлдах номын дуу, бурхан бодьсадвагийн гайхамшигтай яруу тунгалаг Аялгууг л сонсоно. Ах дүү, гэр бүлийн хүмүүсийн гашуудаж байгааг ч харахгүй, зөвхөн гайхамшигтай сүрлэг сайхан гэрэлтэн цацрах Багшийгаа харж, ямар их хүчтэйг нь ойлгоно. Баруун орны үзэсгэлэнт түвшин, өөр бусад сайн сайхан түвшнийг харна, энэ дэлхийд байхдаа ямар хэмжээнд хүртэл бясалгасан байна, нас барах үеэр тийм түвшин илрэн гарч ирдэг.

Жишээлбэл, Багшийнх нь шавь нарын бясалгалын дэс харилцан адилгүй байдаг. Хэрвээ нэгдүгээр ертөнцийн дэсэд хүрсэн хүн нас барвал нэгдүгээр ертөнц илрэн гарна. Нэгдүгээр ертөнц ч манай дэлхийгээс хавьгүй илүү үзэсгэлэнтэй, тэндхийн төрөлтнүүд манай дэлхийн төрөлтнүүдээс илүү гоё сайхан. Тэр үед эхнэрүүд маань бидэнд хэн ч биш шиг санагдана. Харьцуулж хараад дэндүү царай муутай болохыг нь мэдчих болохоор бид тэдэнд сэтгэл хоргодохоо болино. Эс бөгөөс энэ дэлхийгээс бид салж чадахгүй. Учир нь бид энд дэндүү их хүлэгдсэн байдаг, төрөл төрөлдөө хүлэгдэж уягдсан болохоор одоо татагдахгүй байна гэж байх уу? Мэдээж татагдана.

Бид энэ дэлхийд байгаа болохоор сайн мэднэ. Харин өөр

бусад ертөнцийг мэдэхгүй. Хэрэв бүр ч илүү сайн түвшин илрэн бидний сэтгэлийг татахгүй, эсвэл сүрлэг сайхан бурхан бодьсатва угтан авахгүй бол бид энэ дэлхийг орхих ямар ч боломжгүй. Тийм учраас л Төгс Гэгээрсэн Их Багш маш чухал. Хамгийн чухал цаг мөч бол Тэр биднийг нас нөгчих үед ирж угтан авах үе юм. Тэр бидний анхаарлыг өөртөө татан сүнсийг маань дагуулж, биднийг энэ дэлхийд хүлэгдэхгүй болгоно.

Авшиг хүртэх гэдэг нь нас нөгчих үеийн нөхцөл байдалд суралцана, харин өөр зүйлд суралцах биш. Гэхдээ хэдийгээр бид “үхэж” сурч байгаа ч нөхцөл байдлыг бас сайн сурах ёстой, нас нөгчих үедээ нас нөгчсөнийхөө дараа очих түвшнээ чөлөөтэй сонгоход суралцана. Тэрнээс ихэнх хүн шиг нас нөгчих үедээ ямар ч тусламжгүй, бусдын эрхээр болдог шиг биш.

Ихэнх хүн амьддаа жаахан буян хишигтэй байсан бол нас нөгчиж, энэ ертөнцөөс салах үедээ жаахан Гэрэл харна, жаахан Аялгуу сонсоно. Гэхдээ тэр нь тун доогуур дэсийнх байна. Жишээ нь, нэгдүгээр ертөнцийн дэсэд хүрвэл тэр нь асурын орон бөгөөд тэнд диваажин, там аль аль нь бий. Харин асурын орон бүхэлдээ муу байдаг биш, тэнд бид бас Гэрэл харж чадна. Америкт нэгэн мэргэжлийн бус зөнч хүн байдаг. Тэр бол эмч, эмнэлэгт ажиллаж байхдаа нас нөгчөөд дахин сэргэсэн хүмүүсийн яриаг тэмдэглэж авдаг байжээ. Тэдний ярьсан зүйлс бүгд ижил төстэй, тэд Гэрэл харсан, эсвэл Гэрэл цацруулсан нэгэн хүн ирж, авч явсан гэх зэрэг байдал тохиолдсоныг олж мэджээ.

Тэр хүмүүсийг бясалгагч байсан гэж үзэх боломжгүй, гэхдээ буянтай сайн хүн байсан учраас нас нөгчих үедээ диваажинд очжээ. Диваажинд очсон хүнийг бас Гэрэл цацруулсан төрөлтөн тосож авсан байна. Тэр нь тэнгэрийн элч юм. Тэнгэрийн элчис Гэрэлтэй байдаг, тиймээс тэд Гэрэл харсан гэж ярьжээ. Зарим нь маш гоё үзэсгэлэнтэй сайхан түвшинд очсон байна, эргэж ирснийхээ дараа олон хоног уйлсан гэнэ. Учир нь тэр газар үнэхээр үзэсгэлэнтэй сайхан байсан учир тэд энэ дэлхийд буцаж ирэх хүсэлгүй байж л дээ. Гэвч тэнд байсан хүмүүс түүнд: “Таны ажил хараахан дуусаагүй, үйл үр тань барагдаагүй байна.” гэсэн аж. Тэгээд буцаж ирээд олон хоног уйлжээ. Хүнд ч хэлэх аргагүй. Хожим нь хүмүүс асуусан учраас ярьсан байна.

Олон хүн клиник үхэлд орох үедээ дээд түвшинд очсон ч буцаж ирээд ярьж зүрхэлдэггүй, учир нь хүмүүс итгэхгүй. Ялангуяа Америк зэрэг Барууны улс оронд, тэд бүгд шинжлэх ухаанд л итгэдэг, харин үхлийн дараах зүйлст итгэдэггүй. Клиник

үхэлд ороод дахин сэргэсэн хүмүүсийн ихэнх нь эргэж ирснийхээ дараа ихэд ганцаардаж, харсан сайхан түвшиндээ амьдарч чадаагүйдээ харамсан хэдэн долоо хоног уйлдаг. Учир нь тийм түвшнийг харсныхаа дараа эргэн ирж, энд амьдрах нь мэдээж дэндүү гашуун зовлонтой.

Би ер нь хүмүүс баяр жаргалтай байхыг харах дуртай. Гэтэл шавь нарын маань зарим нь Багштайгаа уулзвал уйлдаг. Яагаад ингэж сэтгэл шаналан уйлсныг асуухад: “Багш аа, та намайг дээд түвшин рүү дагуулан аваачсан. Буцаж ирээд энэ дэлхийг харсан чинь үнэхээр дургүй хүрээд цаашид амьдарч чадахгүй нь ээ.” гэдэг.

Байдал хэдий тийм ч цаашид үргэлжлүүлэн амьдрах хэрэгтэй, зугтаж болохгүй. Сүнслэг бясалгал сайтай хүн ийм байдалд орохгүй. Дөнгөж бясалгаж эхэлж байгаа хүмүүс л хурдан ангижрахыг маш их хүсдэг. Багшийнхаа зааврыг даган бясалгаж буй хүн бүхэн хожим дээш дэвшиж чадна. Одоо яараад яах вэ? Уйлах ч хэрэггүй. Гэвч зарим хүн уйлсаар л байдаг, учир нь харсан түвшин нь гайхалтай сайхан байсан бөгөөд тэрээр маш их аз жаргалыг мэдэрчээ. Гэтэл тэр бясалгаж дуусаад нөхөр, хүүхэдтэйгээ уулзахаар буцаж ирэх ёстой, хүнсний ногоогоо цуглуулахаар бохир захаар явах ёстой болно. Нөхөр нь халамж муутай бол бүр ч дордож, илүү их зовно.

Ийм байдал нь дөнгөж сүнслэг бясалгал дадуулж эхэлж буй хүнд тохиолддог, энэ нь түүний бясалгалын хүч нь хангалтгүй байдаг учраас энэ дэлхийг дээд түвшинтэй харьцуулаад байдгаас болдог. Харин бясалгалаар нилээд сайн хүний хувьд жаргал нь зовлонтой адилхан байдаг тул ямар ч асуудалгүй байдаг. Тийм биш бол бид яаж амьдрах вэ? Миний Өвөг Багш ганцхан удаа л бухимдангүй байсан. Магадгүй тэр өдөр бие нь жаахан тавгүйрхсэн, эсвэл шавь нь үгэнд нь ороогүй байх, тэрнээс биш Тэр бухимддаггүй юм. Багш нь бас заримдаа бухимддаг ч хүмүүст мэдэгддэггүй. Учир нь Багш нь бухимдсанаасаа болж яваад өгвөл шавь нар мэдээж бясалгахаа бүр ч болино.

Шавь нарын зарим нь бясалгал дадуулсныхаа дараа: “Би одоо эхнэртэйгээ хамт байхыг, эсвэл нөхөртэйгээ хамт байхыг хүсэхгүй байна.” гэдэг. Гэвч ингэж болохгүй, бид энэ дэлхийн үүрэг хариуцлагаа биелүүлэх ёстой хэвээрээ байна. Үйл түйтгэрээ төлж дуусгах ёстой, зугтаж болохгүй. Бясалгагч хүн зоригтой байж, хичнээн хэцүү байсан ч зовлон бэрхшээлийг тэсэх хэрэгтэй, учир нь энэ бол бидний хамгийн сүүлчийн нэг төрөл. Бусад хүнтэй

харьцуулбал бид үнэхээр азтай. Тэд энэ дэлхийд дахин ирэх ёстой, гэхдээ хэзээ буцаж ирж чадахаа мэдэхгүй байдаг, буцаж ирэхдээ ч заавал хүн болох биш, харин чөтгөр, адгуус гэх мэт болж ч магадгүй.

Бид авшиг хүртэх үедээ энэ бол бидний хамгийн сүүлчийн төрөл гэдгийг мэдэх болно. Мэдээж хэрэв бид залхуу, бас яг Багшийнхаа заасны дагуу өдөр бүр бясалгадаггүй бол дахин ирэх ёстой, ганц удаа ч биш, гурав, эсвэл дөрвөн удаа төрөл авч магадгүй. Залхуу хүмүүст энэ нэг төрөлдөө туулан гэтлэж чадна гэсэн баталгааг Багш нь өгч чадахгүй, бүр Шагжамуни Бурхан байсан ч баталж чадахгүй. Шагжамуни Бурханы амьд сэрүүн байх үед сотапанна (Sotapanna or Srota-аранна) гэж байсан. Сотапаннагийн хутгийг ологсод ч дахин хоёр, эсвэл гурав, дөрвөн удаа төрөл авах хэрэгтэй. Харин архадын хутагт хүрвэл дахиж ирэхгүй. Архадын хутагт хүрэхийн тулд маш хичээнгүй бясалгах хэрэгтэй. Энэ бол маш өндөр дэс. Сотапанна бол нэг тийм залхуу хойрго, аажуу тааваараа бясалгадаг, нэг өдөр бясалгаад хоёр, гурван өдөр “амардаг” хүн. Мэдээж, тийм хүн дахин ирэх ёстой.

Гэхдээ энэ дэлхийд дахин ирнэ гэдэг үнэхээр зовлонтой, эхлээд хүүхэд байх ёстой, энэ үед гайхаж алмайрсан байдалтай байж, юугаа ч мэдэхгүй, өсөж том болсон ч Багшийгаа хайж олохгүй байж магад, нас ахисан хойноо Багшийгаа олдог. Олон хүн наяд гарсан хойноо Багшаасаа суралцдаг. Ийм хүмүүс дэндүү оройтсон байдаг болохоор би тэднийг гэртээ хариад Авид Бурханы тарнийг унш даа л гэдэг. Миний багш, Өвөг Багш нар бол бүр ч хатуу байсан, авшигтан шавь нарын эцэг, эх биш л бол жар гарсан хүнийг хэрхэвч хүлээн авахгүй.

Гэхдээ заримдаа онцгой нөхцөл байдалтай байвал би бас хүлээн авдаг юм. Миний шавь нарын зарим нь хэдийнээ наяд хүрсэн ч бясалгаж чаддаг хэвээрээ. Зургаан настай хүүхэд ч бас бясалгаж байдаг.

Зургаагаас наяд насны эрэгтэй эмэгтэй, хөгшин, залуу бүгд ялгаагүй бясалгаж болно, тэд бясалгаад яг л эртний архад, эсвэл бодьсадва нар шиг гайхалтай ахуй ойлголттой байдаг.

Бодьсадва, архадыг бид ер бусын хүчирхэг төрөлтөн гэж бодох хэрэггүй. Үнэндээ тэд бидэнтэй л адилхан, зөвхөн дотооддоо өөр байдаг, тэдний дэс нь өөр, далд ухамсар нь хэдийн хөгжиж, билиг ухаан нь тэлсэн байдаг. Багшаас нь авшиг хүртсэний дараа хүмүүсийн дэс ч бас өөрчлөгддөг.

Шагжамуни Бурханд ерөн есөн хүний амийг бүрэлгээд зуу болгохын тулд эцэст нь Шагжамуни Бурханыг хөнөөхийг завдсан нэгэн шавь байжээ. Мэдээж, түүний үйл түйтгэр маш хүнд тул ёроолгүй тамд унах ёстой, тийм үү? Учир нь тэрээр архад хүнийг хороосон, бас Буддаг хөнөөхийг завдсан, гэвч Шагжамуни Бурхан түүнийг гэтэлгэжээ. Тэр хүн Буддад итгэсэн болохоор зам мөрөө өөрчилсөн байна, үр дүнд нь бясалгал дадуулсныхаа дараа бас архадын хутагт хүрчээ.

Энэ ертөнцөд залран буй Төгс Гэгээрсэн Их Багш ийм үнэ цэнтэй. Тийм ч учраас судар номд Шагжамуни Бурхан: “Бурхныг хайж олоход бэрх, учрахуйяа ховор. Зөвхөн бурхныг шүтэн дагаснаар л сая гэтлэгдэх бөгөөд тамд үл унана, адгуусанд үл төрнө.” гэж магтан сайшаасан байдаг. Бурхан гэж энэ ертөнцөд залран буй Төгс Гэгээрсэн Их Багшийг хэлж буй. Шүтэн дагана гэж зөвхөн Шагжамуни Бурханыг шүтэн дагахыг хэлээгүй, Бурхан энэ дэлхийд амьд сэрүүн заларч байвал л сая бид шүтэн дагаж чадна, Түүнийг явсны дараа шавийг нь шүтэн дагана, шавь нар нь явсны дараа шавийнх нь шавийг шүтэн дагана... Ийм дарааллаар шүтэн дагадаг, Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Одоо бидний шүтэн дагаж буй энэ уламжлалыг эртнээс нааш тасралтгүй залгамжилсаар иржээ. Тийм учраас хэрэв бид эрх чөлөөг олъё гэвэл амьд сэрүүн залран байгаа жинхэнэ Их Багшийг хайж олох хэрэгтэй. Тэрнээс биш өнгөрсөн үеийн бурхдыг шүтээд нэмэргүй, энэ нь ямар ч тусгүй. Яг л Хуа Туо, Биан Чүе нарыг шүтээд бидний өвчин эдгэхгүйтэй адилхан шүү дээ. Учир нь тэд бол өнгөрсөн цагийн эмч нар. Одоо тусчихаад байгаа өвчнөө эмчлүүлье гэвэл одоо энд байгаа эмчид хандах ёстой. Магадгүй тэр нэр алдартай биш байж болно, гэсэн ч хамаагүй, өвчнийг маань эдгээж чадах л бол заавал Хуа Туо шиг алдартай байх шаардлагагүй биз дээ?

Хуа Туо, Биан Чүе нар бол хятадын хамгийн их алдар нэр нь түгсэн хоёр хувилгаан эмч. Даанч тэд одоо байхгүй, хичнээн гуйж мөргөөд ч нэмэргүй. Үүн шиг бид өнгөрсөн цагийн бурхдад мөргөөд хэрэг байх уу? Мөргөж болно, гэхдээ энэ нь бид Тэднийг хүндлэн биширснээс л болсон хэрэг. Өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн багш нараа хүндлэх нь зүй ёсны хэрэг. Гэвч туулан гэтлэе гэвэл заавал одоо байгаа жинхэнэ Их Багшийг хайж олох хэрэгтэй. Хаалгаа хэдийнээ нээсэн, туулан гэтэлчихсэн хүн түлхүүртэй байдаг учраас бидний тусын тулд хаалгыг маань нээж өгнө.

Энэ нь тун энгийн явдал, ямар ч нууцлаг гайхамшигтай зүйл

биш. Бид угаасаа л төрөх, үхэх, өвдөх, өтлөх дөрөвт бүгдэд нь суралцах ёстой. Нөгөө гурвыг нь сурсан, одоо дахиад нэгийг нь сурахад тийм ч том асуудал биш, ойлгоход ч хэцүү биш.

Бид төрөх, өвдөх, өтлөхөөс гадна бас “үхэх”-ийг сурах ёстой. Хэрэв “үхэх”-ийг сурахыг хүсвэл заавал өдөр бүр үхэж, төрж, өөрийн хүслээр болгож чадсан нэгнийг хайж олох хэрэгтэй. Тэр хүн үхье гэвэл үхэж, төрье гэвэл төрж чадна. Тийм л хүн бидэнд тусалж чадах юм. Учир нь тэр бол тусгай мэргэжлийн хүн. Яг л англи хэл заах чиглэлээр мэргэшсэн багш нар л гагцхүү англи хэлийг хэрхэн заахыг мэддэг шиг, үхэх талаар мэргэшсэн багш л бидэнд үхэхийг зааж чадна. Магадгүй та нар үхлээс айдаг байх, гэвч айлаа гээд зайлахын аргагүй. Зайлахын аргагүй юм чинь хурдхан сурах хэрэгтэй, тийм биз?

Та нар “үхэл”-ийн тухайд суралцах уу? Сурахгүй байж болохгүй, тэгэхгүй бол ангижрах мөчид эрлэгийн элчид хүчээр чирэгдээд явахын цагт бид үнэхээр зовно. Хэрэв амьд ахуйдаа өмнө нь энэ хаалгаа нээсэн бол нас нөгчих үед ямар ч асуудал гарахгүй. Бидний биед есөн сүв байдаг, гэхдээ үл үзэгдэх нэгэн үүд хаалга энд (*Билгийн мэлмийгээ заав.*) бас байдаг. Энэ бол арав дахь хаалга. Хэрэв та нар амьд ахуйдаа өдөр бүр Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байвал ангижрахын цагт тэр хаалга тань даруй нээгдэнэ, маш хурдан, ганцхан секундэд л нээгдчихнэ. Гэтэл та нар өдөр бүр хаалттай байлгадаг болохоор та нарт туслан нээж өгөхийн тулд Багшид нь нэг цаг зарцуулах шаардлага гардаг.

Өчигдөр та нар: “Багш аа! Та бидэнд түлхүүрээ өгөөгүй л байна уу” гэж асуусан. Түлхүүр өгч болно оо, асуудалгүй. Асуудал нь та нарын хаалгыг нээхэд хэцүү бөгөөд нэг цагийн хугацаа зарцуулдаг. Багшийнх нь хаалга дорхноо нээгддэг. Та нарын хаалга нээгдээгүй удаж байгаа болохоор заавал хүчтэй тогшиж, нүдэх хэрэгтэй, тиймээс илүү их цаг хугацаа шаардагдана. Тэрнээс Багш нь түлхүүрээ тэр даруй өгөхгүй байгаа юм биш, өгсөн ч гэсэн энэ нь нөхцөл болзолтой байх болно. Ер нь та нар хэн нэгнээр хаалгаа нээлгэх, хаалгах, түлхүүр хийлгэх, тааруулуулахдаа мөнгө төлдөг, эсвэл хоолоор дайлах хэрэгтэй байдаг. Багшаараа хаалгаа нээлгэхийг хүсвэл Багшийнхаа болзлыг хүлээн авч, заавал дагах хэрэгтэй. Ургамал хоол идэх ёстой, та нар өөрөө нээж үл чадах тэр нэгэн хаалгыг тань нээхийн тулд өдөр бүр Багшдаа тусалж, хоёр цаг гучин минутыг өгөх ёстой. Энэ хоёр цаг гучин минут бол Багшийнх нь цалин юм. Ердөө л энэ, өөр зүйл надад хэрэггүй.

Багшаараа хаалгаа нээлгүүлэхийг хүссэн хүн амь хөнөөж

хэрхэвч болохгүй, харин энэрэн нигүүлсэх сэтгэлтэй байх ёстой. Энэ бол Багшийнх нь тавих болзол. Бид өөрсдөө нэгэнт бусдад хүчээр тийм зовлонтойгоор алуулахыг хүсдэггүй л бол мэдээж, шууд болон шууд бус аль ч байдлаар бусад амьтныг хүчээр, ийм зовлонтойгоор амь насаа алдах байдалд хүргэж болохгүй. Сайн үйл хийвэл сайн үр дагавар хүртэнэ. Хэрэв бид амар амгалан байдлаар хорвоогоос ангижрахыг хүсэж байвал бүхий л төрөлтөнд амар тайван нас нөгчих нөхцлийг бүрдүүлэх ёстой. Хэрэв бид сайн үйл хийхгүй бол яаж сайн үр дүнд хүрэх вэ? Багш нь хэрвээ та нарыг ингэж сургахгүй бол худал хэлж, хууран мэхэлсэн хэрэг болно. Энэ нь бас үйл, үрийн хуульд нийцэхгүй. Жүрж тариад алим хураах уу? Ийм юм байхгүй, тиймээс би энэ нөхцөл болзлын талаар ярих ёстой.

Би та нарыг өдөр бүр хоёр цаг хагасыг Багшдаа өгөөрэй гэдэг. Үнэндээ энэ нь Багшдаа биш, өөртөө л зориулж байгаа хэрэг. Гэхдээ өөртөө зориулж байгаа нь бас Багшдаа зориулсантай адил юм. Та бүхэн баяр баясгалантай байвал Багш нь баяр баясгалантай байна. Тиймээс өөртөө сайн хандахыг хүсэхгүй байвал ядаж Багшдаа сайн байж, хоёр цаг гучин минутаа өргөл болгох хэрэгтэй. Надад өөр юу ч хэрэггүй, ердөө л та нараас өдөр бүр хоёр цаг гучин минутыг бадар болгон гуйна. Хэрвээ та бүхэн Багшдаа ийм өглөгийг өгч чадвал ангижрахын цагтаа баяр жаргалтай байх нь гарцаагүй. Тэр ч байтугай ангижрах хүртлээ аль хэдийн өдөр бүр баяр жаргалтай болчихдог, бясалгаж суугаа үедээ Баруун зүгийн Төгс баясгалант оронд очдог, буцаж ирснийхээ дараа даруй ажиллахаар явна. Яг л сурагч хүн өдөр бүр сургуульдаа явж, ямар нэг зүйл сурдаг, тэгээд буцаж ирэхдээ хоолоо идчихээд гэрийн даалгавраа хийдэг, маргааш нь дахиад л сургуульдаа явдагтай адилхан.

“Үргэлж Буддаг даган суралцана” гэдэг нь өдөр бүр бурхны оронд очиж суралцахыг хэлжээ, энэ дэлхийд суралцах биш. Энэ дэлхийд юу сурч чадах вэ? Энэхүү тоост хорвоод Багш нь та нарт юу ч зааж чадахгүй, зөвхөн зарим нэг энгийн ёс учрыг ярьж, одоогийнх шиг харилцан ярилцаж л чадна. Гэхдээ хэрвээ та бүхэн дээгүүр түвшинд очвол Багш нь дээд түвшний өөр бусад ёс учрыг заана, учир нь энэ дэлхийд болон дээд түвшинд өөр өөр багаж хэрэгсэл байдаг.

Өчигдөр Багш нь нэгдүгээр ертөнцийн тухай ярьсан. Тэндхийн төрөлтний зохион бүтээсэн тоног төхөөрөмж болон бусад зүйл нь биднийхээс илүү соёлжингүй байдаг. Бидний

төсөөлөх ямар ч боломжгүй, хэзээ ч хараагүй, сонсоогүй зүйлс байдаг. Одоо бидэнд байгаа компьютер, зурагт, утсыг бид их боловсронгуй зүйл гэж боддог. Үнэндээ энэ бүхэн юу ч биш. Энэ бүгд тэдний хог энд унаж ирсэн болохоор бид цуглуулж аваад ашигласан төдий. Манай эндхийн хамгийн сайн эрдэмтэд бол тэндхийн хамгийн муу сурлагатнууд, эсвэл сургуулиа төгсөж чадаагүй оюутнууд бөгөөд энд унаж ирснийхээ дараа хувирсан байна. Тэндээ төгсөж чадсан нь эрхэм ариун газар оронд өөр ажил хийж байдаг ажээ.

“Үргэлж Буддаг даган суралцана” гэдэг нь бурхны оронд очиж суралцахыг хэлнэ. Энэ дэлхийд ч гэсэн Багш нь та нарт заах гэж чадах чинээгээрээ хичээдэг. Харин та нарыг дээгүүр түвшинд очиход Багш нь өөр зүйл зааж сургана. Дэс дээшлэх тусам заах зүйлс нь өөр болдог. Ертөнц бүхэнд сургууль байдаг. Энэ дэлхийд байхдаа та нар, жишээлбэл, Цаглашгүй гэрэлт бясалгалын төвд байх үед тань Багш нь та нарт дотоодын нууцлаг зүйлсийн талаар жаахныг заадаг. Дээгүүр түвшинд хүрэх үед тэнд бас сургууль байх бөгөөд Багш нь тэнд мөн дээд дэсийн билиг ухаан зааж өгөх болно. Унтаж байхад тань Багш нь та нарыг өндөр дээд дэсийн сургуульд сургахаар дээш дагуулан авч явна. Учир нь та нар өдрийн цагаар дэндүү завгүй байдаг, зарим нь бүр бясалгалаа ч хийдэггүй тул Багшид нь дагуулж явах боломж гардаггүй, тиймээс шөнө унтаж байхад тань дээш татан гаргаж суралцуулдаг.

Унтаж байхдаа та нар тэмцэлдэхгүй, уураг тархи тань тийм ч зөрүүд биш байх тул авч явахад амар, өдөр бол амаргүй байдаг, бясалга гэвэл завгүй гэнэ. Завтай байсан ч бүжиглэж, хүмүүстэй ярилцахаар явдаг, элдэв хэрэгтэй, хэрэггүй зүйл хийнэ. Бүжиглэж, эсвэл кино үзэж болно оо, гэхдээ бясалгах жаахан цаг зав гаргах хэрэгтэй. Та кино үзэх завгүй байж болно, харин бясалгаж суухгүй байж болохгүй, өдөр бүр ангижралыг дадуулах хэрэгтэй. Хэрвээ танд өнөөдөр дөрвөн цаг байгаа бол нэг цаг хагас зурагт үзээд хоёр цаг хагаст нь бясалгах хэрэгтэй. Маргааш хэрэв зөвхөн хоёр цаг хагасын цаг гарвал бүгдийг нь бясалгахад зориулах ёстой. Гэвч жинхэнэ Их Багшийн удирдлагагүй бол “бясалгаж суух” биш, “буруу” бясалгал болно. “Буруу” гэдгийн учир нь бясалгалаа буруу хийж байна гэсэн үг, “буруу” бясалгавал адад баригдаж, толгой дүйрэх байдалтай болдог, очигдөр таны асуусан нөхцөл байдалтай ижил болно. Хэрвээ “зөв” бясалгавал тийм байдал үүсэхгүй. Ихэнх хүн буруу бясалгаж, яаж бясалгааа мэдэхгүй, замбараагүй бясалгадаг тул “буруу” гэж байгаа юм.

Жинхэнээр бясалгаж суудаг хүмүүс маш их баяр баясгалантай байдаг бөгөөд толгой дүйрэхгүй. Бясалгах тусам зөвдөж, суух тусам сайжирдаг. Ер буруудана гэж байхгүй. “Буруу”-гаар бясалгаж суух ба “бясалгаж суух” нь адилгүй, Багш нь хятад хэл ойлгохгүй байдаг юм биш, “буруу”-гаар бясалгаж суух гэдэг нь буруугаар, дур зоргоор бясалгаж суухыг хэлнэ. Бясалгаж суух гэж юуг хэлдэг вэ? Энэ бол даяанд агуулах (самади) юм. Гаднаа энэ дэлхийн хэлбэр дүрсээс салахыг “даяан” гэнэ, дотооддоо сэтгэл тогтуун байхыг “агуулах” (төвлөрөл) гэнэ.

(Энэ үед ном айлдаж буй танхимийн гадна нэг хүн дуу чимээ гаргаж үймүүлэв.) Хэрвээ та бүхэн өмнө нь ад чөтгөр ер хараагүй бол одоо хараад мэдэж болно. Ад гэж юу вэ? Багш нь ном тайлахаар явах үед машиныг нь асахгүй болгодог, эсвэл ном тайлж байх үеэр зориуд үймүүлж байгаа бол ад юм. Ад гэхээр л эвэртэй амьтан байдаг юм биш. Хүмүүсийг хааж, саад учруулдаг, эсвэл тэдний бясалгалд саад болдог, мөн Төгс Гэгээрсэн Их Багшийг саатуулж, хамаг төрөлтнийг гэтэлгүүлдэггүй бөгөөд хамаг төрөлтнийг ном сонсохоор ирүүлдэггүй, хүмүүс ном сонсож байх үеэр унтдаг, эсвэл юм ярьдаг, хүмүүсийг сайн сургаал ёсыг сонсуулдаггүй, өөрийн эмх замбараагүй санаа бодлоо л сонсож, өдөржингөө хэрэгцээгүй олон юм ярих нь адад уруу татагдсан гэсэн үг юм.

Энд ирж ном сонсож буй хоёрхон цагаа зөв ашиглахгүй, дэмий юм ярьсаар л байдаг. Өөрийгөө нэн чухалд бодон өдөржин ярина. Энд ирчихээд Багшид ном тайлах боломж өгөхгүй, өөрөө л ярьсаар байдаг нь адад ашиглагдаж байгаа явдал мөн. Тэр хүн өөрөө ад биш, ад гэдэг нь нэгэн зүйлийн хүч бөгөөд энэ хүч түүнд нөлөөлөн ийм болгодог.

Миний Багшийг Германд ном тайлж байхад гаднаас нэг хүн адууны хомоол барьж орж ирээд тайзан дээр гарч, Багш руу шидэх гэхэд нь Багш маань “За, надад өг дөө.” гэв. Гэвч юу ч болоогүй, өнөөх хүн тэндээ зогсоод хомоолоо шидэх ч үгүй, газарт тавих ч үгүй байв. Сонирхолтой нь тэр шидэхийг оролдох бүртээ цахилгаанд цохиулах шиг болоод шидэж чадахгүй байсан, бас газарт ч тавьж чадахгүй байв. Тэр үед Багш маань түүнд гарч явахыг гараараа дохив. Гарч явахад нь өнөөх юмс газарт уначихсан. Тэр үед би урд сууж байсан болохоор тэр нь уут дүүрэн хамаг төрөлтний үйлийн үр байсныг (Хүмүүс инээлдэв.) харсан юм. Их Багш байх амаргүй, ихэвчлэн тийм төрлийн ад чөтгөрийн саад тогтортой учирна. Ад чөтгөрийн саад яагаад

гардаг вэ? Энэ бол хамаг төрөлтний нийтийн үйлийн үр, ойлгов уу? Ном сонсохоор ирсэн зарим хүн үйл түйтгэр ихтэй, буян хишиг хангалтгүй, их бардам зантай байдаг. Ад чөтгөр тийм хүнийг ашиглаж, саад хийдэг. Хэрвээ хүн бүхэн ариун цагаан сэтгэлтэй, даруухан бол ад чөтгөр саад хийж чадахгүй. Даанч хамаг төрөлтний сэтгэл нь цэвэр ариун биш болохоор адын саад, тогтсон үйлийн үр, мөн нийтийн үйлийн үр гэж байдаг. Хүмүүсийн үйл түйтгэр бараг ижилхэн байдаг болохоороо нэг улсад, нэг гэр бүлд, нэг бүлэгт амьдардаг. Энэ нь нийтийн үйлийн үр гэгч юм. Нийтийн үйлийн үрээс гадна хувь хүний үйлийн үр бас бий, энэ бол хувь хүний өөрийнх нь үйл түйтгэр юм. Тэр нь нилээд онцгой, бусад хүнийхээс өөр байдаг, тиймээс “хувь хүний үйлийн үр” гэнэ. Хэрвээ бид нийтийн болон тогтсон үйлийн үрийг даван туулья гэвэл бясалгалд түших хэрэгтэй. Учир нь бидэнд нэг зүйлийн хамгийн их хүч байдаг. Тэр бол Уг дүр, эсвэл Бурхан чанар гэгч юм. Шагжамуни Бурхан “Эзэн Бурханд итгэх ёстой.” гэж сургаагүй, харин “Өөртөө найдаж, өөрийнхөө Гэрэл нь бай.” гэж сургажээ.

“Өөрөө” хэмээх нь чухам юу вэ? Уг дүр юм. Эгэл хүний оюун ухаан, уураг тархинд найдах ёстой гэж Шагжамуни Бурхан сургаагүй, Багшийнхаа санааг ойлгов уу? Төрөлтөн бүхэн Бурхан чанартай, төрөлтөн бүхэн бурхан мөн гэсэн санаа юм. Энэ зүйлийг таньж мэдэхээсээ өмнө бид эгэл хүн байдаг, таньж мэдсэнийхээ дараа Будда болдог. Бидний дотор бурхан ч бий, ад ч бий. Хэрвээ хүн адын чанараа хөгжүүлвэл адын орон луу унана, ойлгов уу?

Тиймээс Бурханы шашинд энэ хоёр хүчийг “бурхан ба ад (буг)” гэж хэлдэг. Бумбын шашинд бол “арга, билиг” гэдэг. Бид хэрвээ билиг талаа хөгжүүлбэл билиг болон хувирна, арга талаа хөгжүүлбэл арга болон хувирна, арга, билгээ тэнцүүхэн хөгжүүлбэл “Мөр ёс”-ыг бүтээнэ. Сэтгэл амирлангуй тогтуун байвал Мөр ёс болох бөгөөд Мөр ёсонд нийцсэн хүн бол арга, билиг нь тэнцсэн хүн юм. “Жинхэнэ эр” гэдэг нь арга, билиг нь тэнцсэн хүн, аргын тал руу ч хэлбийхгүй, билгийн тал руу ч хэлбийхгүй болсон хүн юм. Жинхэнэ эр гэж зөвхөн эрчүүд та нарыг хэлээгүй, эмэгтэй хүний Бурхан чанар эрэгтэй хүнийхтэй адилхан.

Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн Тавдугаар үеийн Өвөг Багштай уулзахаар очихдоо намхан туранхай, царай муутай ау лак хүн байжээ. Тиймээс Тавдугаар Өвөг Багш Түүнийг: “Өмнөдийн бүдүүлэг чи яаж Будда болж чадах вэ?” гэж загнажээ. Тэр үед

хятадууд ау лак хүнийг өмнөдийн бүдүүлгүүд гэдэг байсан. Тэд манай улсыг эзэлж, биднийг нүдний булангаар хардаг, ау лак хүнийг дорд үздэг байсан. Тиймээс ау лак хүнийг өмнөдийн бүдүүлэг гэж нэрлэжээ. Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн бол ау лак хүн байсан. Тэрээр Өмнөд тэнгисийн орноос ирсэн царай муутай, намхан, хав хар царайтай, туранхай эцэнхий хүн байжээ. Мод тайрч, түлээ бэлдэн амьдралаа залгуулдаг түлээчин байв. Тэр тун ядуу хүн байсан тул Түүнийг ирэхэд Тавдугаар Өвөг Багш загнаж: “Өмнөдийн бүдүүлэг чи яаж Будда болж чадах вэ?” гэхэд Зургадугаар Өвөг Багш: “Хүнд өмнөд, умардын ялгаа байвч Бурхан чанарт ийм ялгаа байхгүй.” гэж хариулжээ.

Багш нь ч бас адил зүйлийг хэлнэ. Хүнд эрэгтэй, эмэгтэйн ялгаа байвч Бурхан чанарт ийм ялгаа байхгүй. Хэрвээ хэн нэг нь зөвхөн эрэгтэйчүүд бурхан болж чадна гэж зүтгэсээр байгаа бол буруу. Жинхэнэ эрийн шинж байдал бол арга, билиг нь тэнцсэн хүн байдаг. Билиг хэт давамгай бол эмэгтэйлэг байх бөгөөд эмэгтэй хүний шинж чанартай байдаг, арга хэт давамгай бол тэр нь эрэгтэй хүн болдог. Жинхэнэ эр гэдэг нь арга, билиг нь тэнцүүхэн хүнийг хэлдэг.

Тэгэхээр Жинхэнэ эрийн дүр төрх гэж махан биеийн байдлыг хэлдэггүй ажээ. Мэдээж, заавал нэгэн махан биетэй байж л хамаг төрөлтнийг гэтэлгэж чадна. Гэвч тэрхүү Жинхэнэ эрийн дүр төрх бол энэ махан бие биш. Хэрвээ бид Жинхэнэ эрийн дүр төрхийг харъя гэвэл бурхны мэлмий, тэнгэрийн нүд, эсвэл билгийн мэлмийгээр л харж чадна. Эгэл хүний махан нүдээр харах аргагүй. Гэвч билгийн мэлмий нээгдсэний дараа нэг өдөр махан нүдээрээ ч харах боломж их бий. Заавал тэнгэрийн нүдээ хэрэглэнэ гэхгүй, учир нь тэр үед махан нүд нь тэнгэрийн нүд болон хувирсан байх болно. Нүдээ нээлттэй байхад ч бясалгаж чадах бөгөөд тэнгэрийн орон, диваажин, тамыг ч харж чадна. Махан бие нь энд ном айлдаж байхын зэрэгцээ хувилгаан биеэр Америкт очиж, тэндэх шавиа аварч, гэтэлгэдэг. Хаанаас ч ямар ч төрөлтөн даатган гуйсан биеэ хувилан очно, тиймээс “Үй түмэн хувилгаан бие” гэж нэрлэжээ.

Зөвхөн Шагжамуни Бурхан л үй түмэн хувилгаан биетэй байдаг биш, Мөр ёсыг бүтээж чадсан хэн ч үй түмээр хувилж чадна. Авшиг хүртсэн хүн бүрийг Багшийн нэг хувилгаан бие харж харгалзаж байдаг. Тийм биш бол энэ олон шавь нарыг яаж бүгдийг нь харж харгалзаж чадах билээ? Яаж тэднийг хамгаалах вэ? Багшийн махан бие ердөө ганц, яаж ийм олон хүнийг

халамжилж чадах вэ? Нас барах үед нь тэднийг дээш авч явахаа яаж баталгаажуулж чадах вэ?

Учир нь тийм хүн үй түмээр хувилж чаддаг, өөрөөр хэлбэл хэн ч Түүний хамгаалалтанд багтаж чадна гэсэн үг. Ингэснээр л сая Тэр Их Багш, багш, эсвэл эцэг хэмээн хүндлүүлэн дуудуулах эрхтэй болно. Учир нь Тэр хүн биднийг багш мэт сургаж, эцэг шиг хүүхдээ харж харгалзах төдийгүй бидний сүнсийг авардаг, тиймээс бид Түүнийг шы фу (эцэг-багш) гэж нэрлэдэг. Номын багш гэдэг нь хүмүүст бясалгалын арга заадаг учраас тэр юм.

Мөр ёсыг бүтээсэн нэгэн Их Багш бол яг англи хэлний багш шиг. Англи хэлний багш хэдийнээ англиар чөлөөтэй ярих болсон тул тэр бол Master of English (англи хэлний их багш) юм. Номын багш бол Master of Dharma (Дээдийн Номын Их Багш) бөгөөд ном гэдэг нь Dharma (Дээдийн Ном) юм. Зөвхөн Дээдийн Номыг олж авсан хүнийг л Дээдийн Номын Их Багш, эсвэл Их Багш гэнэ. Эс бөгөөс зөвхөн нэг төрлийн нэрийдэл, хоосон нэр төдий байж, харин жинхэнэ хүч байхгүй.

Асуулт: Багш та ярихдаа билиг ухааны хаалгыг нээж чаддаг түлхүүртэй гэсэн. Гэхдээ энэ хаалгыг нээсний дараа үхэл рүү явах уу, төрөлт рүү явах уу, эсвэл өөр нэг муу орон руу явах уу гэдгийг би сайн ойлгохгүй байна. Ямар нэг баталж гэрчлэх зүйл бий юу? Байгаа бол би энэ бол жинхэнэ бясалгалын арга гэдэгт итгэж чадна, амь амьдралаа Багшид сэтгэл амар даатгаж чадна.

Их Багш: Амь амьдралаа Багшид даатгах хэрэггүй, та өөрийнхөө амьдралд өөрөө санаа тавьж чадна. Надад тийм зав байхгүй, хариуцахыг ч бас хүсэхгүй байна. Та зөвхөн Багшийнхаа заасны дагуу хийх хэрэгтэй. Арьяабалын аргаар бясалгахад мэдээж баталгаа бий бөгөөд та билиг нээгдэх агшиндаа баталгаа нотолгоотой болно. Та өөрийнхөө үзсэн ахуй ойлголтыг судрын ахуй ойлголттой харьцуулаад ижил эсэхийг нь хар, тэгээд л ойлгоно. Ахуй ойлголтгүй бол харьцуулах арга байхгүй.

“Авшиг хүртэх” гэдэг нь тэр даруй судрын ахуй ойлголттой болох явдал юм, ингэвэл билиг нээгдсэн гэж хэлж болно. Ахуй ойлголтгүйгээр бид яаж гэгээрсэн байж чадах вэ? Яаж нотлох вэ? Юуных нь авшиг хүртээсэн байх вэ? Авшиг хүртээнэ гэдэг нь сэтгэлээс сэтгэлд уламжлахыг хэлнэ. Сэтгэлд уламжлах үед та мэдэх болно, та өөрийн ахуй ойлголтоо эртний бясалгагчдынхтай, сударт бичигдсэнтэй яг ижил болохыг мэдэх болно.

Жишээлбэл, “Хотол зохилдогч”-ид, Арьяабал бодьсадвагийн

хүчийг олбол Түүний гучин хоёр лагшин хувилгаан биеийг харж чадна, магадгүй Арьяабал бодьсадва ирж, таныг аврахыг харж чадна гэж тэмдэглэжээ.

Та нар авшиг хүртэх үедээ Багш нь ирж, ямар нэгэн зүйл сургахыг харна. Энэ бол анхны нотолгоо, энэ нь Багш бол бодьсадвагийн хувилгаан мөн гэдгийг илтгэж байгаа юм. Бодьсадвагийн хувилгаан гэдэг нь дотоодод тань юм зааж сургадаг, эсвэл дээгүүр түвшин рүү таныг дагуулан очиж чадах хүнийг хэлдэг. Эс бөгөөс та энэ хүн бусад номын багш нараас юугаараа ялгаатайг яаж мэдэх вэ?

Хоёрдох нотолгоо нь Арьяабал бодьсадвагийн ахуй ойлголтой болно. Арьяабалын аргаар бясалгаж буй хүн Арьяабал бодьсадва шиг далайн түрлэгийн чимээ, Эсэрваагийн эгшиг гэх мэтийг сонсож чаддаг. Та нар авшиг хүртэх үедээ ийм дэсийг олно, хэрвээ энэ дэсэд хүрээгүй бол ядаж л анхны дэсийг олох бөгөөд Гэрэл олж харах нь гарцаагүй. Та нар “Баатаргаа явагч нэрт их хөлгөн судар”-т тэмдэглэсэн хорин таван бодьсадвагийн ахуй ойлголтыг уншсан байх, тэд билиг нээгдэх үедээ юу харсан бэ? Бүгд Гэрэл харсан, тийм үү? Та нар авшиг хүртэх үедээ мөн тэр даруй Гэрэл харж чадна. Үүгээр та бас өөрийгөө харьцуулж болох юм. Багшийнхаа хариултанд сэтгэл хангалуун байна уу? (*Сэтгэл хангалуун байна гэж хариулав.*)

Асуулт: Гэрэлд сайн, муугийн ялгаа байдаг уу?

Их Багш: Сайн ч биш, муу ч биш, зөвхөн дээд дэс ба доод дэсээр л ялгагдана. Авшиг хүртэх үед Багш нь аль нь доод дэсийн Гэрэл, аль нь дээд дэсийн Гэрэл болохыг хэлж өгнө.

Асуулт: Аялгууны урсгал хэмээгч нь Бурхан чанар мөн үү?

Их Багш: Зөвхөн нэршил нь өөр, заримдаа өөр өөр нэр хэрэглэдэг, жишээ нь, Аялгууны урсгал, дуу Аялгуу, хэлбэлзэлийн хүч, Эсэрваагийн эгшиг, далайн түрлэгийн дуу, чанагуух ертөнцийн ялгуусан аялгуу гэх зэргээр нэрлэдэг хэдий ч үнэндээ бүгд нэг ижил зүйл. “Богдсын ном Цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-т “Аялгууны урсгал” гэж дурдсан байдаг, Багш нь зүгээр л энэ судраас эшилсэн юм. Шагжамуни Бурхан “Богдсын ном Цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-таа: “Бурхан энэ Аялгууны урсгалд түшиглэн хамаг төрөлтнийг гэтэлгэхээр бууж ирдэг. Бодьсадва болон хамаг төрөлтөн энэ Аялгууны урсгалаар дээш гарч, төгс төгөлдөр туулан гэтэлдэг” гэж айлдсан байдаг. Та бүхэн энэ хэсгийг уншсан уу? (*Нэг хүн уншсан гэж хариулав.*)

(Бурхан байтлаа бас энэ Аялгууны урсгалд түшиглэсэн гэхээр эрх тааваараа биш болчих биш үү?) Мэдээж, эрх тааваараа байдаг. Жишээлбэл, хэрэв танай байр шаттай бол та байрныхаа шатаар доошоо бууна. Мэдээж, та бас үсрээд бууж ч болно, гэхдээ гэмтэж бэртэнэ. Байрны шатаар бууж байгаа нь та хүч чадалгүйдээ биш бөгөөд шат нь сүрхий зүйл ч биш, зүгээр л нэг доош буух арга хэрэгсэл юм, ойлгов уу? Үнэндээ “түшиглэнэ” гэж ярихад бас нийцэхгүй, гэвч эгэл хүний хэлээр тайлбарлах ямар ч боломжгүй, ярих тусам яришиг төвөг ихсэнэ. Тиймээс Багш нь ном уламжлахдаа юу ч ярьдаггүй, гэхдээ та нар Номыг олж хүртдэг. Үүнийг “Сэтгэлээс сэтгэлд уламжлах” гэнэ.

Өнөөдрийг хүртэл Багш нь их зүйлийг ярилаа, аль хэдийнээ гурав, дөрвөн өдөр дараалан ярьсан ч Номыг хараахан уламжлаагүй байна. Ном уламжлах үед нэг ч үг ярихгүй, гэхдээ энэ бол хамгийн чухал үе. Хэдийгээр энэ гурав, дөрөв хоногт маш их зүйл ярьсан боловч та бүхэн номыг хүртэж чадаагүй байна. Багш нь юу ч яриагүй үедээ л сая авшиг уламжилна, сэтгэлээс сэтгэлд уламжилна. Дэлхийн үг хэл ашиглахгүй, ойлгов уу? Үг хэлийг ашиглах тусам үл ойлголцол ихсэж, ярих тусам яришиг төвөгтэй болно. Та нар хар л даа, ном судар сонсож, уншиж буй хүн хичнээн олон байна, гэтэл гэгээрсэн хүн алга. Учир нь үүнийг сургаал ёсноос гадуур тусад нь уламжилдаг, судар ном хэрэглэдэггүй.

Асуулт: Төгс Гэгээрсэн Их Багшийн номд үйл түйтгэр Аялгууны урсгалаас үүссэн гэж дурдсан байна. Энэ нь аливаа юмс бүгд Аялгууны урсгалаас үүсэлтэй гэсэн үг үү?

Их Багш: Тийм, хэрвээ Аялгууны урсгалаас үүсээгүй бол өөр хаанаас үүсдэг вэ? Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн. Ингэхлээр, мэдээж, бидний үйл түйтгэр ч энэ Бурхан чанар - Аялгууны урсгалаас үүссэн хэвээр байна. (Их Багшийн номд бүхий л юм Аялгууны урсгалаас үүссэн гэж дурдсан. Хэрвээ бид гэм хийсэн бол энэ нь бидний буруу юу?) Үгүй, гэвч та адын эзэнд ингэж хэлбэл тэр зөвшөөрөхгүй, тэр “Тэсэн ч та заавал тамд унах ёстой.” гэж хэлнэ. “Тийм биз дээ? Та Эрлэг номун хаанд: “Надад ямар ч гэм нүгэл байхгүй. Энэ бол Бурхан чанарын гэм нүгэл, энэ бол Аялгууны урсгалын гэм нүгэл.” гэж хэлж болохгүй. Учир нь “мэдэх” нь “туулан гэтлэх”-тэй адил биш.

(Үүнийг дуу нь алгасаж үсрээд байгаа пянзтай зүйрлэж болох уу? Дууны пянз үсрээд байгаа нь бичлэгийн явцад гарсан алдаа болохоос миний алдаа биш.) Тийм, гэвч танд ямар ч арга

байхгүй! Бичлэг нэгэнт хийгдчихсэн болохоор одоо цэв цэвэр, хов хоосон байхаа больчихжээ, ойлгож байна уу? Бичлэгийг та өөрөө хийсэн, гэвч та үүнийгээ мэдэхгүй, тиймээс таны буруу биш. Гэхдээ л энэ нь таны өөрийн буруу, бичлэгийг жинхэнэ эзэн хийчихсэн.

Бид ч үүнтэй ижил, бидний Уг чанар тун цэвэр ариун. Энэ дэлхий бол биднийг сургадаг сургууль. Гэвч бид суралцах явцдаа мэдэхгүйгээсээ болж олон зүйлийг буруу хийдэг, тэгчихээд бид өөрсдийгөө буруутгадаг. Бүр хэн нэгэн бидэнд: “Энэ таны буруу биш, та чинь суралцах шатандаа яваа хүн юм чинь мэдээж алдаа гаргана.” гэж хэлээд ч нэмэргүй. Бидний санаа сэтгэл тайвширч чадахгүй, маш ихэд бачимдан бухимддаг. Тэр ч байтугай зарим хүн сурч төгсөхөөсөө өмнө амиа хорлодог, учир нь ухаарч мэдээгүй байдаг тул биеэ барьж чаддаггүй. Ойлгов уу?

Гэгээрээгүй хүний гадна төрх нь гэгээрсэн хүнтэй адилхан харагддаг. Хүн гэгээрснийхээ дараа ч иднэ, унтана, гэхдээ маш тааваараа, ямар ч үйл түйтгэргүй байна. Тэр өмнөх шигээ л байдаг. Энэ нь гэгээрсний дараа улам үзэсгэлэнтэй болдоггүй гэсэн үг юм. Мэдээж сүнсэн бие нилээд үзэсгэлэнтэй байдаг, гэхдээ үүнийг эгэл махан нүдээр харах боломжгүй. Гэгээрсний дараа гаднах төрх нэг их өөрчлөгдөхгүй, зөвхөн дотоод нь өөрчлөгддөг, үүнийг тэр өөрөө мэдэж байдаг, одоо түүний үйл түйтгэр үгүй болсон гэдгийг ухаарч, өөрөө бурхан, бодьсатва, архад гэдгээ мэдэх болно.

Хэдийгээр тэр “мэднэ” гэж хэлсэн ч бас “мэдэхгүй”. Хэрвээ тэр өөрийгөө Будда болсныг мэдэж байвал Будда биш юм. Гэхдээ тэр мэдэхгүй гэж хэлж бас болохгүй. Үүнийг би тодорхой тайлбарлаж чадахгүй байна. (*Бүгд инээлдэв.*) Та нар Бурханы хутагт хүрэхээрээ үүнийг ойлгоно. Намайг ийм маягаар тайлбарлахад та нарын сэтгэл дундуур байгаа нь мэдээж. Би ч гэсэн өөрөө сэтгэл хангалуун бус байгаа ч өөр арга алга! Үүнийг эгэл хүний үг хэлээр тайлбарлах аргагүй.

Жишээ нь, та нар Багшаасаа: Та Будда мөн үү гэж асуувал би “мөн” гэж хэлж чадахгүй, “биш” гэж ч хэлж чадахгүй. “Мөн” гэх нь ч зөв, “биш” гэх нь ч бас зөв. Утгыг нь ойлгож байна уу?

Хэрвээ та нар намайг Будда биш гэвэл би ч бас тэгж бодохгүй. Хэрэв та нар намайг жинхэнэ Будда мөн гэсэн ч миний сэтгэл мөн л дундуур байна, ойлгов уу? Будда гэдэг ийм л байдаг, та нар юу ч гэж хэлсэн онож хэлэхгүй. Та бүхэн Багшийгаа Будда гэдэгт итгэх

шаардлагагүй. Багшийгаа та нарт тусалж, билиг ухааны тань хаалгыг нээж чадах чадвартай гэдэгт л итгэж байвал та нар тэр дороо гэгээрлийн ахуй ойлголттой болж чадах бөгөөд түүнийгээ судар номд тэмдэглэгдсэнтэй харьцуулж болно. Энэ хүн чухам хэн болохыг хамаараад хэрэггүй. Харин та өөрөө хэн бэ гэдгээ л хамаарах нь зөв.



ХАР БОЛОН ЦАГААН ИД ШИД

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайваний Цаглашгүй гэрэлт бясалгалын ашрам
1987 оны 9 дүгээр сарын 20. (Эх нь хятад хэлээр)*

Өнөөдөр би та бүхэнд хар болон цагаан шидийн талаар ярьж. Ид шидэнд дуртай хүн энд олон байгаа тул шид яаж ашиглахыг зааж өгье. Эс бөгөөс та нар Багшийгаа шидгүй гэж боддог. Багшид шид байхгүй гэж боддог хүн байна уу? Хар, цагаан шид бол хамгийн амархан зүйл, тэгэхлээр Багш нь яагаад шидгүй байх билээ? Багшид нь юм бүхэн бий, хар шид, цагаан шид бий, улаан, ногоон, шар, хөх, саарал, хүрэн гээд өнгө өнгийн шид бий. (Бүгд инээлдэв.) Та нар аль төрлийн шидийг сонирхож байна, эхлээд нэрийг нь бүртгүүл. Та нарын хүсэл сонирхолд нийцүүлэн заая. Өнөөдөр ирсэн хүмүүс шидийн талаар сонсмоор байна уу? (Сонсмоор байна гэж хариулцаав.) За тэгвэл Багш нь та нарт хар, цагаан шидийн талаар ярьж өгье.

Хар шид нь угаас цагаан шид юм, хар нь цагаан, цагаан нь хар. Энэ нь “Очир огтлогч судар”-т дурдсантай адил, тэрнээс Багш нь дур зоргоороо ярьж байгаа биш. Яагаад хар нь цагаан юм бэ? Яагаад гэвэл энэ нь мөн л Бүтээгчийн хүч, ойлгож байна уу? Арга нь билиг, билиг нь арга юм. Арга үгүй бол билиг үгүй, билиг үгүй бол арга үгүй. Арга, билгийн зохирол байхгүй бол дэлхий ертөнц оршин тогтохгүй байх байсан.

Хар шид гэж юу вэ? Бясалгалтай хүн энэ их хүчийг ашиглан муу үйл хийхийг хэлнэ. Яаж ингэж хийдэг вэ? Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн, Багшийнхаа санааг ойлгож байна уу? Жишээлбэл, тамир тэнхээ нөхөх эмийг хэтрүүлэн уувал өвчин болдог, тийм биз? Багш маань надад иллэгийн эм уулгасан удаатай.

Уугаад үхэх дөхсөн. Бөөлжөөд гаргачихмаар байсан ч Багш өгсөн тул уухгүй байж болохгүй, тэгээд хүчээр уусан. Уугаад огиулна, дахин залгина. Хэд хэдэн удаа ингээд эцэст нь хүчээр залгисан. Иллэгийн эмийг зөвхөн иллэгэнд хэрэглэхээс ууж болохгүй. Би золоор амьд үлдсэн, үхээгүй, хордоогүй, одоо ч амьд явж байна. Зарим эмийг гадуур хэрэглэвэл хоргүй ч уувал хордоно.

Ид шидийн хүч ч үүнтэй адил. Хэрвээ бид түүнийг сайн зүйлд ашиглавал цагаан шид болно, муу зүйлд ашиглавал хар шид болно. Ердөө л ийм, ялгаа байхгүй. (*Ном тайлахыг сонсохоор олон хүн ар араасаа орж ирэв.*) Гаднах ертөнц ийм их, гэтэл та нар наадаж зугаацахаар явалгүй энд ирж ном сонсох гэж чихэлдэн суугаа нь үнэхээр мэдрэл нь муудсан мэт. Багш нь та нарыг арай хар шидээр эрхшээсэн юм биш биз? (*Бүгд инээлдэв.*) Та нарыг шидээр эрхшээж яах ч юм билээ? Надад зөвхөн төвөг бэрхшээл л нэмнэ. Би шөнөжин бясалгаж суугаад өдөр жаахан унтъя гэсэн ч чадсангүй, туслах маань ирээд: “Олон хүн ном сонсохоор ирлээ” гэсэн. Мэдээж нэг хүнээс олон хүн илүү чухал, тиймээс би нойроо золиослох хэрэгтэй боллоо. Хүн хэдий олон байвал миний ажил төдий их болдог. Багш үүнд дуртай гэж бүү бодоорой. Багш нь хар шид ашигладаггүй.

Хар шид гэж юу вэ? Энэ нь яг хор шиг. Та нар хар шидийг байнга ашиглаж байдаг, гэхдээ өөрсдөө мэддэггүй. Та нар мэддэг үү? (*Үгүй гэж нэг хүн хариулав.*) За! Багш нь одоо та нарт хэлж өгье. Та нар өөрийгөө ч бай, бусдыг ч бай муугаар бодох бүртээ, хэрвээ бодол санаа тань асар их хүчтэй бол өөртөө ч, өрөөл бусдад ч нөлөөлдөг, ойлгов уу? Жишээлбэл, хэрэв та өдөр бүр “Тэр үнэхээр муу хүн, тэр өвдчихөөсэй, тэр тэгчихээсэй, ингэчихээсэй...” гэхчлэн бодвол тэр хүн лавтай тэгэх болно. Хэрэв та хэн нэгэн хүнийг та ингэж их занаж зүхвэл түүнд ямар нэг байдлаар нөлөөлөх нь гарцаагүй, ойлгож байна уу? Үүнээс бид үйл, үр байдгийг мэдэж болно. Жишээ нь, та хэн нэгнийг хөнөөвөл, эсвэл хорловол тэр хүн хожим төрөл авч ирээд таныг хорлох юм. Энэ бол хар шид. Хэрэв энэ нь хар шид биш юм бол өөр ямар шид байх вэ?

Бидний дотоодод асар их хүч бий, хязгааргүй, сэтгэгдэшгүй их хүч бий. Бид зөвхөн түүний өчүүхэн хэсгийг нь л ашигладаг байхад хэдийн маш айхтар болчихжээ. Бид үүнийг сайн зүйлд, эсвэл муу зүйлд ашиглалаа ч бүгд л тун айхтар байдаг. Хэрэв энэ хүчийг бид сайн зүйлд ашиглавал дэлхий маань илүү сайн сайхан газар болно, тийм биш гэж үү? Гэтэл бидний олонх нь сайн үйлд

ашигладаггүй. Та нарыг хэлээгүй шүү, та нар нөхрөө загнах, эхнэрээ зодох, Багштайгаа маргах гэх мэт сайн зүйл хийдэг байх бүрэн магадлалтай. *(Бүгд инээлдэв.)* Хэрэв бид энэ хүчийг асар их хүчтэй гэдгийг мэдэж байгаа бол тун болгоомжтой байх хэрэгтэй, хар шид бүү ашигла, зөвхөн цагаан шид л ашигла! Хар шид бидэнд ч бас нөлөөлнө. Тиймээс аливаа шашин, эсвэл шашны урсгалын сургаалын эзэд хөршөө өөр шигээ хайрла гэж сургадаг байна. Учир нь хөршөө занах нь өөрийгөө занахтай ижил. Энэ нь Багшийнх нь сая ярьсан “үйл, үрийн үр дагавар” юм, ойлгов уу? Хэрэв та хөршөө занаж, түүнд муу зүйл тохиолдоосой хэмээн харааж, өвдөж зовоосой, даруй түргэн үхээсэй гэхчлэн зүхвэл хожим тэр таныг ч бас ингэж харааж зүхнэ. Та зөвхөн энэ хар шидийн хүчээс болоод төрөх, өтлөх, өвдөх, үхэх зовлонгийн энэ тойрогт ахин дахин төрөл авч, үхэж төрөхийн хүрдэнд эргэлдэнэ. Хар шидийн хүчээр бусдыг хорлох төдийгүй өөрийгөө ч хорлох болно. Зарим хүн бусдыг ховсдох чадвартай байдаг, эхлээд тэр танаас нүдээ аньж байхыг хүснэ, дараа нь та түүний хэлсэн болгоныг нь хийх болно. Та өөрийгөө огт хянаж чадахгүй. Энэ бол бас хар шид, гэхдээ нэр нь өөр. Энгийн хүмүүс үүнийг “ховс” гэж нэрлэдэг. Харин би үүнийг “хар шид” гэнэ. Учир нь ховсдогч этгээд хар шидийн хүчийг ашигладаг. Гэхдээ энэ хар шид нь мөн цагаан шид болон хувирч болно. Учир нь тэрээр энэ хүчийг ашиглан бусдын өвчнийг эмчилж болно, миний санааг ойлгож байна уу? Ховсоор өвчин эмчилдэг тухай та нар мэдэх үү? *(Нэг хүн, Мэднэ гэж хариулав.)* Иймээс Багш нь сая хар, цагаан шидийн аль аль нь бидний өөрсдийн санаа бодлоос бий болсон гэж хэлсэн юм.

Зарим хүн өвчнөө эдгээхийн төлөө “ум мани бадми хум” тарнийг уншдаг, зарим хүн ад чөтгөр зайлуулахын төлөө “ум мани бадми хум” тарнийг уншдаг, эсвэл ямар нэгэн муу хүч, азгүйтлийг үлдэн хөөхийн төлөө уншдаг гэж сонссон байх. Ямартаа ч эдгээр нь багахан ид шид. Зарим хүн “ум мани бадми хум” гэж уншаад хүмүүсийн өвчнийг эдгээдэг. Та нарыг энэ тарнийг уншаарай гэж байгаа юм биш, харин тэр хүмүүс тарни уншаад их удаж байгаа учраас бодол санаагаа төвлөрүүлэх чадвартай болдог гэдгийг та нарт ойлгуулах гэсэн юм. Бодлоо төвлөрүүлж чадвал их, бага ямар ч байсан хүчтэй болдог.

“Ум мани бадми хум” тарнийг ач тустай гэсэн биш, харин лам нар энэ тарнийг удаан хугацааны туршид аялгуулан уншиж байсан учраас хүчтэй болсон байна. Энэ нь тэд өөрсдийгөө тогтмол дасгалжуулж байснаас болсон хэрэг, гэхдээ бас бага сага

тус нэмэртэй. Харин зөвхөн ганц өдөр уншсан бол нэг их хэрэг болохгүй нь ойлгомжтой. Жишээ нь, та англи хэл анх сурах үедээ мэдээж сайн ярьж чадахгүй. Хэрэв өдөр бүр бага багаар суралцаж, дахин давтан дасгал хийвэл чөлөөтэй ярьдаг болно. Багш нь анх Формосад ирэхдээ хятадаар ярьж чаддаггүй байсан. Одоо ярьж чаддаг болсон. Учир нь би өдөр бүр дасгал хийсэн хэрэг, ойлгов уу? Усанд сэлэх нь ч ялгаагүй. Би анх эхлээд сэлж чаддаггүй байсан ч өдөр бүр сэлж, дасгал хийж байтал зөнгөөрөө л сурсан.

Хар болон цагаан шидийн хүч нь бүхэлдээ бидний бодлоос хамаардаг. Хэрвээ бид хэн нэгнийг баяр жаргалтай, амар амгалан болоосой гэж үнэхээр чин сэтгэлээсээ ерөөвөл тэр баяр жаргалтай, амар амгалан байх болно. Мэдээж энэ нь бас түүний үйл, үрээс хамаарна. Гэхдээ л наад зах нь тэр хэсэгхэн хугацаанд тэрээр баяр жаргалтай, амар амгалан байна. Сударт тэмдэглэгдсэнээр, нэг хүн ерөн есөн хүнийг хөнөөжээ. Учир нь “Үдээс өмнө зуун хүн хөнөөвөл чи гарцаагүй бурхан болж чадна” хэмээн багш нь түүнийг мэхэлсэн байна. Тэрээр Багшийнхаа үгэнд итгэж, хэлснээр нь хийсэн аж. Ерөн есөн хүнийг хөнөөчихөөд зуу дахь хүнийг олсонгүй. Тэр үед эхийгээ ирж явахыг хараад хөнөөхийг завдав. Эх нь Бурхан Багшид итгэдэг, Түүнийг шүтэн дагасан хүн байсан тул Бурхан Багш түүнийг аврахаар илрэн гарч иржээ. Өнөөх хүн Бурхан Багшийг хармагц хөнөөхийг завдав, гэвч Шагжамуни Бурхан шидийн хүчээрээ түүнийг аварчээ.

Бурхан Багшийн шидийн хүч нь миний сая ярьсан хар, цагаан шидтэй адилгүй, та нар хэрхэвч хольж хутгаж болохгүй. Шидгүй байх нь Бурхан Багшийн шид юм. Бурхан Багш өөрөө ид шид юм. Энэ тухай өмнө нь Багш нь нилээд хэдэн удаа ярьсан.

Багштай уулзаад л миний өвчин даруй эдгэсэн, эсвэл саад бэрхшээл маш хурдан шийдэгдсэн гэж зарим хүн ярьдаг. Багшийгаа шид хэрэглэж байхыг та нар ер нь харсан уу? Эсвэл ямар нэгэн тарни уншиж байхыг сонссон уу? Эсвэл Их нигүүлслэлийн рашаан сүрчиж байхыг харсан уу? Эсвэл арц, хүж уугиулж, ямар нэгэн юм бичээд усанд хийж, хүнд уулгахыг харсан уу? (*Бүгд, Үгүй гэж хариулав.*) Эдгээр нь бүгд л хар, цагаан шид юм. Багшийнх нь бол жам ёсных байдаг, та нар ирвэл хүссэн зүйлээ авна. Та нар харин банкнаас хулгай хийж болохгүй шүү. (*Бүгд инээлдэв.*) Тийм зүйл хийхэд Багш нь туслахгүй.

Шагжамуни Бурхан өнөөх хүнийг аварсанд тэр ихэд талархаж, Бурхан Багшийг даган гэрээс гарч, Түүнтэй өдөр бүр хамт байж, номд суралцжээ. Нэг өдөр тэрээр бадар барихаар явж

байгаад замдаа нэгэн бие давхар бүсгүйтэй таарчээ. Тэр бүсгүй амаржих гэж байсан бөгөөд ихэд өвдөж байгаа харагдав. Тэрээр: “Багш аа! Би удахгүй амаржих нь байна. Эх, үр бид хоёр эсэн мэнд байхын ерөөл хайрлаж туслаач!” гэж их дуунаар гуйв гэнэ. Тэр хүн гэрээс гараад удаагүй тул яаж туслахаа мэдэхгүй, буцаж очоод Бурхан Багшаас асуужээ. Бурхан Багш түүнд түргэн буцаж очоод бүсгүйд “Та гарцаагүй хүүхдээ эсэн мэнд төрүүлнэ. Эх, үр хоёул баяр жаргалтай, энх тунх, эрүүл саруул байх болно. Би төрснөөсөө өдийг хүртэл хэзээ ч худлаа ярьж, муу зүйл хийж байгаагүй. Миний хэлсэн бүхэн гарцаагүй биелнэ” гэж хэлээрэй гэв. Нөгөө хүн Бурхан Багшид: Багш аа, ингэж болохгүй! Би төрсөн цагаасаа хойш муу хэрэг хийгээгүй хүн биш шүү дээ, би ерөн есөн хүний аминд хүрсэн гэдгийг та мэднэ. Би яаж хэзээ ч муу хэрэг үйлдээгүй, хэзээ ч худлаа яриагүй гэж хэлэх вэ?” гэхэд Бурхан Багш, “Энэ бол өнгөрсөн зүйл, та намайг дагаж гэрээс гарснаас хойш өнөөдрийг хүртэл хэзээ ч худлаа яриагүй, хэнийг ч хөнөөгөөгүй, ямар ч муу хэрэг үйлдээгүй, тэгэхлээр үүнийгээ л түүнд хэлээрэй” гэв. Ингээд өнөөх хүн даруй түргэн буцаж, Бурхан Багшийн хэлсэн ёсоор өнөөх бүсгүйг тайтгаруулжээ. Үнэхээр нялх хүүхэд тэр даруй эсэн мэнд төрж гэнэ. Харахад булцгар улаан, эв эрүүл чийрэг хүүхэд байлаа. Уг нь тэр бүсгүйн төрөлт нь хүндэрч, хэдэн өдөр өвдсөн боловч амаржиж чадахгүй байжээ. Гэтэл тэр хүнийг ерөөл хэлж дуусмагц хүүхэд тэр дорхноо төрж, эх, үр хоёр мэнд сайн, баяр жаргалтай, эрүүл саруул байсан төдийгүй тэр хувраг ч өөрөө маш их баярлав гэнэ.

Яагаад ийм зүйл болдог вэ гэвэл бурхны хүч өнгөрсөн цагийн үйл түйтгэрийг арилгаж чаддаг, ойлгож байна уу? Авшиг хүртсэний дараа таны урьдын бүх үйл түйтгэр алга болно, зөвхөн одоогийн үйл түйтгэр болон тогтсон үйлийн үр л үлдэнэ гэж Багш нь байнга хэлдэг. Хэрвээ Багш нь тогтсон үйлийн үрийг тань арилгачихвал та нар авшиг хүртэх тэр үедээ л дорхноо ангижирна, тиймээс арилгаж болохгүй. Бид одоо ч үйл үртэй, учир нь бидэнд энэ махан бие байгаа, бидэнд тогтсон үйлийн үр байна. Тогтсон үйлийн үр гэж юу вэ? Энэ бол тогтчихсон, биднийг төрөхөөс өмнө тогтоогдчихсон үйл түйтгэр юм. Үүний дээрээс бидний өдөр бүр үүсгэж буй шинэ үйл түйтгэрүүд нэмэгдсэнээр энэ төрлийн амьдралдаа бид маш их үйл түйтгэрийг бий болгодог. Жишээлбэл, биднийг амьсгалах үед нүдэнд үл үзэгдэх асар олон нян бактер, бичил биетэн үхдэг, алхаж явахдаа ч бичил биетнийг олноор нь хөнөөдөг, өвс хадах үед бас олон төрөлтнийг хөнөөдөг, ойлгож байна уу? Мөн цардмал замаар явах, эсвэл

машин жолоодох үедээ бид бас хамаг төрөлтөнд үйлийн үрийн маш их өр төлөөстэй болдог. Иймээс бид дөрвөн их энэрлийг хариулах ёстой юм. Энэ махан бие байгаа цагт бидэнд дөрвөн их энэрэл байна. Энэ бүгдийг бид хоромхон хугацаанд бүгдийг төлж барахгүй. Багшийнхаа санааг ойлгов уу? Тиймээс энд үлдээд төлөх хэрэгтэй. Яаж төлөх вэ? Бие, хэл, сэтгэлээрээ, өөрөөр хэлбэл бид ажил хийж, бясалгал дадуулж, бясалган сууж байж л төлж чадна. Гэрээс гараагүй хүн ажил хийж мөнгө олж, үйл түйтгэрээ төлнө. Гэрээс гарсан хүн бясалгал дадлынхаа хүчээр энэ дэлхийн хорт муу уур амьсгалыг саармагжуулж, нийгмийг илүү ёс суртахуунтай болгож, дэлхийг улам харанхуй, улам там шиг болголгүй, амьдрахад илүү тохиромжтой газар болгоно, ойлгов уу? Энэ бол “бие”-тэй хамаатай тал нь.

“Хэл”-ний тухайд бид бусдад ёс суртахуун, амар амгалан, эрхэм дээд үзэл бодлын тухай ярьж, тэднийг илүү баяр жаргалтай болгож, гэгээрэлд илүүхэн тэмүүлэх сэдлийг өгч, тэдэнд дотоодынх нь Бурхан чанар, хамгийн агуу дотоод хүчийг нь сануулахыг хэлнэ. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Энэ бол “хэл”-ний тал нь.

“Сэтгэл”-ээрээ гэдэг нь юу вэ? Бид цагаан шидийн хүчийг ашиглан бусдад баяр жаргал, улс орны амар амгалан, дэлхий дахины энх тайвныг хүсэн ерөөх явдал юм, ойлгож байна уу? Бид бие, хэл, сэтгэлээрээ хамаг төрөлтөнд үйлчилж, дөрвөн их энэрлийг хариулах ёстой, тэгсний дараа эндээс явж болно.

Хэрэв та нар тогтсон үйлийн үрээ арилгахад Багшаараа туслуулахыг хүсвэл бас болно, энэ нь боломжгүй зүйл биш. Даруй ангижрахыг хүсэж байгаа хүн байна уу? Гараа өргөөрэй. (*Нэг хүн гараа өргөв.*) Та бусдад өр төлөөс ихтэй тул хурдан зугтах санаатай байна, тийм үү? Тийм ээ, үүнд учир байгаа юм. Гэхдээ ингэвэл та баатар хүн биш. Төрөл төрөлдөө бид асар олон муу үйл үйлдсэн. Одоо хамаг төрөлтөн зовж шаналж байна, бид тэднийг тайтгаруулах хэрэгтэй. Тэд биднээс болоод зовж байна. Бид энэ дэлхийд амьдарч байгаа бөгөөд хамаг төрөлтний өмнө хариуцлага хүлээдэг. Ойлгож байна уу?

Дэлхий ямар ч болсон бай, энэ нь бид бүгдийн үүрэг хариуцлага. Муу байсных нь төлөө тэднийг бүх зүйлд буруутгаж болохгүй, бидэнд ч бас буруу бий. Бид өнгөрсөн төрлүүддээ, эсвэл өмнөх нэг төрөлдөө хэн нэгэнд муу хандсан байж мэднэ, тиймээс тэр энэ дэлхийд буцаж ирэхдээ бидэнд хорсох болно. Энэ нь бидний алдаа. Бид түүнийг ийм болгосон. Тиймээс бүх бурууг

бусдад хамаатуулж болохгүй. Бид сайтар бясалгаж, өөрийгөө ариусган энэ өшөө хорслын шижмийг таслах хэрэгтэй.

Бид “хорсож гомдоллох”-ын оронд “өшөө хорслыг ач буянаар хариулах” хэрэгтэй, тэгвэл тэр хорсол гомдол арилна. Хорсол гомдол аль хэдийнээс л байгаа, тиймээс амархан арилгах боломжгүй, арилгая гэвэл нөгөө этгээдээ хөнөөх хэрэгтэй болно. Гэвч түүнийг хөнөөгөөд ямар ч нэмэргүй, хорсол гомдлыг арилгахгүйгээр барахгүй хоёр дахин нэмж, улам төвөгтэй болгоно. Иймээс Шагжамуни Бурхан, эсвэл ямар ч Их Багш “Хорсол гомдлыг энэрэл хайраар хариулах хэрэгтэй.” гэж хүмүүст сануулжээ. Есүс Христ: “Дайснаа хайрла.” гэсэн байна. Учир нь дайснаа бас та өөрөө бий болгосон. Ойлгов уу? Бурханы шашны сургаалд: “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.” гэдэг. Лууз: “Гэрээсээ гаралгүй дэлхийн явдлыг мэдэж болно” “Мөр ёсны судар”-т: *(Гэрээсээ гаралгүйгээр дэлхий дахины байдлыг мэднэ.)* гэжээ. Үүний утга нь “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.” гэдэгтэй ижил. Бид сэтгэлээрээ дэлхийн явдлыг ажиглаж болно. Учир нь гадаад ертөнц, сэтгэлийн ертөнц хоёр ижилхэн. Тиймээс гэрээс гарахгүй ч дэлхийн байдлыг мэдэж болно. Энэ үгийн утга маш гүн, зөвхөн бидний сүнс гарвал л энэ дэлхийг харж чадна гэсэн үг биш. Мэдээж сүнс гарвал бас харж чадна, гэхдээ энэ нь тун доогуур дэс.

Зарим хүн сүнсээ гаргаж чаддаг, тэгээд тэр хүмүүс энд ном тайлахыг сонсох гэж ирдэггүй, харин сүнсээ явуулж, сэмхэн сонсож, сэмхэн хардаг гэж та нар сонссон байх. Заримдаа миний шавь нар ч сүнсээрээ энд ирэх нь бий. Тэд харж чаддаг хэдий ч сонсож чадахгүй. Тэр дэндүү залхуурчээ. Бусад нь ирээд ном тайлахыг сонсож байхад тэр өөрийгөө тун сүрхийд бодоод ирэхийг хүсдэггүй. Энд ирвэл хүмүүс Багшаас нь сурахаар ирснийг нь мэдчих тул нүүрээ барна гэж боджээ. Тэр өмнө нь Игуандао-гийн бясалгагч байсан бөгөөд бясалгалын талаар нэгэнт “ахмад үе” нь болсон хүн. Тэрээр Багшаас нь авшиг хүртсэнээс хойш хэзээ ч энд ирж байгаагүй, харин сүнс нь ирдэг. Би түүнд: “Жинхэнэ эр хүн юу хийсэн ч ил тодорхой байх ёстой. Шөнө бусдын хувийн орон гэр лүү гэтэх хэрэггүй. Яагаад ингэж байна вэ? Бидэнд бусдын өргөө гэрт сэм орох эрх байхгүй. Хэрэв суръя гэвэл төв чигчээр ном сонсоорой. Та өөрийн бие махбодоор ч бай, эсвэл асурын хэлбэр дүрсгүй биеэр ч бай, сэм ирэх нь бүгд хулгайн явдал мөн” гэж хэлсэн.

Лууз: *“Гэрээсээ гаралгүйгээр дэлхий дахины байдлыг мэднэ.”*

гэсэн нь энэ хүний нөхцөл байдалтай адилгүй. Сүнс гарах хийгээд туулан гэтлэх хоёр ондоо. Туулан гэтлэх гэдэг нь Гурван ертөнцийг туулан гарч, бидний хамгийн дотоодын, хамгийн нарийн бие маань гадуурх хэд хэдэн биеэсээ салан гарч одохыг хэлнэ, ойлгов уу? Хамгийн дотоодын тэр бие цогцос бол сүнс биш. Энгийн хүний ярьдаг сүнс бол мөн нэг зүйлийн бие бөгөөд бидний махан биеэс арай дээр, илүү нарийн байдаг. Түүнийг энгийн нүдээр харж чадахгүй, гэхдээ бясалгалтан харж чадна. Манай зарим авшигтан долоо хоногийн даяанд ч, гурав хоногийн даяанд ч оролцдоггүй, гэхдээ сүнсээ гаргаж Багшийгаа харахаар энд ирэх дуртай байдаг. Ингээд яах вэ дээ? Мэдээж, тэд сүнсээ гарган энд ирж болно, гэхдээ энэ нь дэндүү залхуурсан хэрэг. Тиймээс эндхийн ном хамгаалагч луугийн сахиус тэднийг зодож, зайл хэмээн хөөсөн байна. Тэрээр, “Би эндхийн Их Багш Чин Хайтай танил юм аа.” гэсэнд сая ном хамгаалагч луугийн сахиус орохыг нь зөвшөөрчээ. Гэвч тэр Багш нь ном тайлж байхад сонсож чадаагүй. Сонсож чаддаг болохын тулд бясалгаад нилээд дээгүүр дэсэд хүрэх хэрэгтэй, ойлгож байна уу? Тэр тийм дэсэд хараахан хүрээгүй, хэдийгээр тэр Багш болон авшигтнууд, мөн хэлбэр дүрсгүй төрөлтнүүдийг харж байсан боловч юу ч сонсож чадаагүй, зөвхөн Багшийнхаа ам хөдлөхийг л харжээ. Тиймээс тун урамгүй байсан гэж түүнийг хэлэхэд нь би, “Урамгүй болох хэрэг байна уу? Зүгээр л долоо хоногийн даяанд суухаар ирээрэй!” гэсэн. Багш нь хэзээ ч хүмүүсийг ийм зүйл хийхийг дэмжихгүй, учир нь тэр шавь урьд нь бөөгийн эрдмийг дадуулж байсан бөгөөд тэр дадлаасаа одоо ч бүрэн салж чадаагүй. Энэ тоост хорвоод сүнсээ ашиглан ийш тийш гүйх нь ямар ч хэрэгцээгүй зүйл бөгөөд хүч чадлаа дэмий үрж байгаа хэрэг. Сүнсээ гаргая гэвэл Гурван ертөнцийг даван туулж, дээш гарч, “Мөр ёс”-онд суралцах хэрэгтэй. Энэ нь л сая бурхнаас жинхэнэ ёсоор суралцсан хэрэг болно, учир нь Багш нь энэ дэлхий дээр бурхны судрыг тайлах аргагүй, зөвхөн энэ дэлхийн судрыг л тайлж, ямар ч сайн зүйл зааж чадахгүй. Хэрэв хамгийн сайн зүйлийг суръя гэвэл дээш гарч суралцах хэрэгтэй, ойлгов уу? Энэ дэлхийн юмсаас зөвхөн өршөөл энэрэл, зөв шударга байдал, ёслол хүндлэл, ёс журам, билиг ухаан болон итгэл үнэмшил, эелдэг зан, ёс суртахуун, бие биедээ сайнаар хандах гэх мэтийг л сургана. Мөн хулгай хийхгүй, худал хэлэхгүй, садар самуун явахгүй, согтууруулах ундаа уухгүй, тамхи татахгүй, амь хөнөөхгүй байх зэрэгт сургана. Энэ бүхэн цөм дэлхий ертөнцийн асуудал бөгөөд угаасаа бидний хийх ёсгүй зүйлс. Гэвч та бүхэн бүгдийг мартсан тул Багш нь дахин сануулах ёстой. Үнэндээ бол ийм зүйлсийн талаар ярих нь үнэхээр уйтгартай. Дээд дэсийн

түвшинд эрэгтэй, эмэгтэй гэж байдаггүй, ямар ч асуудал байхгүй тул эдгээр уйтгартай зүйлийн талаар ярих шаардлагагүй байдаг. Багшийнхаа санааг ойлгов уу? Зөвхөн дээд түвшинд л жинхэнэ Үнэн ёс, жинхэнэ Мөр ёсонд суралцана. Гэхдээ заавал Дээдийн Ном уламжлах хэрэгтэй, авшиг хүртсэний дараа Багшийн заавраар хичээнгүйлэн бясалгаж, бидний сүнсэн биеийн гадуурх хэд хэдэн давхар бие цогцосын хүлээснээс мултарч байж л сая дээш гарч чадна. Хэрэв бид зөвхөн хамгийн гадна талын нэг давхар биеэс салаад энэ тоост хорвоогоор ийш тийш явбал энэ нь зөвхөн сүнсээ гаргаж зугаацаж байгаа хэрэг болно.

Формосад нэгэн гэлэнмаа хэдэн долоо хоногоор самадид ороод хөдлөлгүй сууж гэнэ. Шавь нар нь түүнийг таалал болов гэж бодсон ч бие махбод нь зөөлөн, бүлээн хэвээр байсан тул оршуулж төвдсөнгүй. Хоёр долоо хоногийн дараа түүний сүнс буцаж ирээд: Би олон газраар явлаа, үзлээ. Дэлхий дахин тун ч ороо бусгаа байна даа!” гэж хэлжээ. Энэ бол мөн л сүнс гарсан хэрэг юм, учир нь тэр зөвхөн нэг л биеэсээ салсан байна, ойлгож байна уу? Энэ нь хараахан жинхэнээр туулан гэтэлсэн байдал биш. Жинхэнээр туулан гэтлэх гэдэг нь энэ тоост хорвоогоор ийш тийш явахыг бус, харин дээш гарч, бурхнаас суралцахыг хэлнэ, ойлгож байна уу? Би уг нь хар шидийн тухай ярьж байсансан, яагаад одоо ийм зүйл ярих болов? Хар шид хэрэглэх нь мэдээж сайн биш, хэзээ ч сайн байхгүй. Учир нь эрт орой хэзээ нэгэн цагт эргэж бидэнд нөлөөлнө. Үйл байвал үр заавал байна. Жүрж таривал жүрж хураана. Алим таривал алим хураана. Алим тариад жүрж хураахгүй, тийм биз?

Үүнтэй ижил зарчмаар, хэрэв бид хар шид хэрэглэвэл өөрийгөө л хорлоно. Үр дагавар нь одоо харагдахгүй байж магадгүй ч хожим лавтай ирнэ. Хэд хоног, хэдэн долоо хоног, хэдэн жил, тэр ч байтугай хэдэн төрлийн дараа ч харж мэднэ, бид хар шид ашигласныхаа үр дагаврыг эдлэх нь гарцаагүй. Зарим хүн ирээд Багшид нь: “Хэний садан төрлийн хүнд хэн гэдэг бөө хар шид, тарни хэрэглэснээс болж мэдрэл нь муудсан, эсвэл бүр бие нь өвдөв.” гэдэг. Ийм зүйлийн талаар би юу хэлэх вэ дээ, тиймээс би зөвхөн, “Түүнд маани тарни уншиж, бурханд даатга, ёс суртахуунтай зүйл хийгээрэй гэж хэлээрэй” гэж л хэлсэн. Тэр хүн яагаад ийм асуудалд орсон бэ? Учир нь тэрээр урьд төрөлдөө хар шидээ ашиглан бусдыг хорлосон бөгөөд одоо үйл, үр нь боловсрон ирсэн байна. Иймээс хэзээ ч бусдыг буруутгаж болохгүй, харин өөрийгөө л буруутгавал зохино. Бидэнд юу ч тохиолдсон бай бүгд бидний өөрсдийн үйлийн үрээс үүдэлтэй байдаг, ойлгов уу?

Хэрэв та нар гадны хүмүүст загнуулбал тэднийг зэмлэж буруутгах хэрэггүй, Багш нь жаахан загнахад л уурлаад явчих юм уу, эсвэл Багшийгаа гүтгэдэг гэх зэргээр байж болохгүйг бүр ч ярилтгүй. Багш нь загнах үед уурладаг хүн бол үнэхээр мунхаг юм. Багшдаа жаахан загнуулах нь та нарын асар их үйл түйтгэрийг угаахад тустай, ингэснээр та нар тамд унахгүй, эсвэл чөтгөрт баригдаж, махаа шаруулахгүй болно. Багш нь өнгөрсөн долоо хоногт, хэрэв та бүхэн тамд очиж, махаа шаруулахыг хүсэж байвал Багштайгаа дахин уулзах гэж бүү ирээрэй, хэрвээ диваажинд хүрч аршийн тоор шарахыг хүсвэл Багшийнхаа үгийг илүүхэн сонсох хэрэгтэй гэж долоо хоногийн даяаны үеэр хэлсэн. Гуан Чин өвгөн хувраг ч гэсэн: “Багш тань хичнээн ч их загнасан бай, та уурлаж бухимдаж болохгүй.” гэжээ. Энэ бол танай хятадын хувраг хүний хэлсэн үг шүү, Багш нь ганцаараа ингэж яриагүй. Хэрэв зөвхөн Багш нь ингэж хэлсэн бол ганцаар дарангуйлагч болно. Гэхдээ бүх их багш нар адилхан зүйл ярьдаг. Би ч бас Багшийнхаа ярьсныг л давтаж байгаа. Би Их Багш биш, зөвхөн Их Багш нараас суралцсан төдий, Тэд юу ярьсан байна, түүнийг л ярьдаг.

Бусдад сайн хандах нь өөртөө сайн хандсан гэсэн үг. Иймээс бид өглөг өгч, сахил сахиж, хүлцэл тэвчээрийг дадуулдаг. Хүлцэл тэвчээрийг дадуулна гэж юу вэ? Юу ч тохиолдсон бай, энэ бүхэн өөр хэн нэгний буруу биш, миний өөрийн л үйл, үр, үүнд өөр хэн ч буруугүй. Надад муу хандаж байгаа нь магадгүй би урд төрөлдөө тэдэнд муу хандаж байсан, тиймээс одоо түүнийгээ төлж байна гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үг юм. Та нар Багшийнхаа ярьсан Даяаны бүлгийн гучин гурван их багшийн түүхийг санаж байна уу? Даяаны бүлгийн их багш нар ч үйл, үрээс зугтаж чадаагүй, зарим нь толгойгоо цавчуулж, зарим нь гараа тайруулж, зарим нь алуулсан гэх зэрэг явдал тохиолдож байсан. Энэ бүхэн тэдний өөрсдийнх нь үйл, үр, тэд үүнийгээ заавал төлөх ёстой. Даяаны бүлгийн их багш нар ч ийм байхад эгэл хүмүүс биднийг хэлэх юун? Өчүүхэн саад бэрхшээл учирвал шантарч, Багшдаа загнуулбал гуниглаж, буцаж явахыг хүсдэг, цаашид Багшийгаа дагах хүсэлгүй болж, амныхаа зоргоор шүүмжилнэ. Хэрэв түүнээс “Яагаад Багшаасаа хөндийрсөн юм бэ?” гэж асуувал тоочих шалтгаангүй байдаг. Багшдаа загнуулаад л холдсон гэвэл үнэхээр мунхаг, мөн хангалттай баатарлаг биш байна. Хэрвээ одоо даруй ангижрахыг хүсэж байгаа хүн байвал адилхан бөгөөд эр зоригоор дутуу нэгэн юм. Тэр урьд төрөлдөө хүн зоддог байсан бөгөөд одоо бусдад жаахан зодуулаад л цаашид амьдрах хүсэлгүй болж, зугтах гэж байна. Ингэж болохгүй, тийм шалтгаан (үр)

тарьсан болохоор үр дагаврыг нь амсах ёстой. Эдэлж барсныхаа дараа л эндээс явах боломжтой. Та бүхэн даруй ангижирч болно, би зөвшөөрнө. Гэхдээ бүгд ангижирчихвал энэ дэлхийг хэн харж харгалзах вэ? Формосагийн ард түмнийг хэн харж хамгаалах вэ? Ерөнхийлөгч яах вэ? Хэрвээ Формосагийн хүмүүс авшиг хүртээд бүгдээрээ ангижирвал ерөнхийлөгч яах вэ? Сайдуд яах вэ? Тэд их ганцаардана, тийм үү? (Бүгд инээлдэв.)

Ерөнхийлөгч ганцаараа үлдэж, Формосагийн хүмүүс бүгд Багшийгаа дагаад Баруун зүгийн Төгс баясгалант орон руу одвол, бид ч бас тэнд тайван амьдарч төвдөх үү? Төгс баясгалант орноос харахад баяртай санагдах уу? Хэрэв та одоо эндээс явчихвал үр хүүхэд, ач зээ нар чинь үхэтлээ уйлна! Учир нь та үйл, үрээ төлж дуусаагүй. Тэд уйлан гашуудаж байгаа нь үйл, үрээс болдог. Хэрвээ үйл, үр бүрэн тасарсан бол тэд юу ч мэдрэхгүй байх болно, ойлгож байна уу? Тиймээс зарим хүн гэрээс гарсныхаа дараа нэг дор тасалж чаддаг. Уг нь тэд аав ээж, хань нөхөртэйгээ зууралддаг байсан. Харин Багшийгаа харсны дараа бүгдийг орхиж, зөвхөн Багшийгаа л дагадаг. Ингэснээр Багшдаа маш их бэрхшээл учруулдаг. Багш нь угаас түүнийг шавиа болгох дургүй байсан, би түүнийг авч яах юм бэ? Гэвч нөхөр нь, Багш нь түүнийг шавиа болгох дургүй гэдэгт итгэхгүй, гэргийдээ тун их хайртай болохоор Багшийг нь ч мөн эхнэрт нь их хайртай гэж бодно. Та нар ер нь нохойг хооллож байхад нь харж байсан уу? Ойртвол “хав хав” гэж хуцна. Үнэндээ хоолыг нь булаах гэсэн хүн байхгүй. Хэн нохойн хоол идэхийг хүсэх вэ дээ? Гэвч нохой ингэж бодохгүй, учир нь тэр хоолондоо маш их дуртай, таныг түүнд бүр хүрээ ч үгүй байхад тэр шүдээ ярзайлган хуцна. Энэ нь, “Бүү ойрт, энэ ясыг би мэрж байгаа, чи хүрч ирж, харах хэрэггүй.” гэсэн санаа юм. Түүний хоолыг хэн хүсэх вэ дээ. Тэр нь зүгээр л хог.

Үүнтэй адил, хэрвээ эхнэр, нөхөр чинь гэрээс гарвал Багшид тэр таалагддаг юм байна гэж бүү бодоорой. Би түүнд дуртай болоод яахав дээ? “Эрх дураараа” байхгүй бусдад хүлэгдээд юу хийх вэ? Гэхдээ та нар намайг хүлээсэлнэ гэвэл би бас зөвшөөрнө, та нартай тоглоё доо! Би та нарын эхнэр, нөхөрт сэтгэл татагдаад тэднийг заавал гэрээс гаргаж, түүнгүй бол үхчих гээд байгаа юм байхгүй, тийм биш шүү! Гэрээс гаръя гэвэл эхлээд эхнэртэйгээ, нөхөртэйгөө тодорхой ярилцах хэрэгтэй. Багш нь та нарын хог новшийг авахыг огт хүсэхгүй байна, ойлгов уу? Хэрэв тэр өөрөө дуртай байгаа бол энэ нь түүний л хэрэг, харин би дургүй. Бүхий л орчлон ертөнцийг огоорсон байтлаа таны эхнэр, нөхрийг хамаараад яахав дээ? Би үүнийг зөвхөн түүний бясалгалын төлөө

л хийсэн. Түүний үйлийн үрийг харахад яг л тасарчихсан шиг байсан, тиймээс эгэл ертөнцтэй зууралдахаа больж, салах гэсэн болохоор нь түүнийг гэрээс гарахыг нь зөвшөөрсөн юм. Угаасаа аав, ээж нь хүүдээ тун хайртай байдаг. Энэ дэлхий дээр бидний хувьд үр хүүхэд, хань ижил хамгийн чухал, тийм биз? Гэвч үйл, үр тасрах гэж байгаа үед тэд яг гадны хүн шиг санагддаг, эсвэл хамтран бясалгагч шиг, эсвэл бүр жирийн нэг найз шиг санагдаж, огт сэтгэл татагдахгүй, хоргодохгүй болсон байдаг. Ийм учир шалтгаанаас Багш нь гэрээс гарч чадсан юм. Эс бөгөөс нөхөр маань маш сайн хүн байсан тул түүнээс салж төвдөхгүй байсан нь лавтай. Энэ тухай та бүхэн номоос, Багшийнхаа намтар хэсгээс уншсан бол мэднэ. Би хятадаар уншиж чадахгүй. Тэр номыг шавь нар маань бичсэн юм. Заримдаа тэд нэг бүлгийг надад бүтнээр нь уншиж өгдөггүй, яагаад гэвэл сонсох дургүйг минь мэднэ. Тэгээд ном хэвлэгдсэний дараа надад ямар нэг зүйл буруу байгаа санагдсан тул тэднээс: “Номын гарчиг нь хаана байна?” гэж асуухад үүнийг уншиж өгсөн юм. Өмнө нь надад зориуд буруу уншиж өгсөн гэдгийг нь тэгэхэд л мэдсэн. Гэхдээ бас аргагүй, учир явдал угаасаа тийм байх ёстой. Багш нь хятад бичиг үсэг төсөөлдөггүй гэдгийг та нар мэднэ. Хэрвээ номд ямар нэгэн алдаа байвал энэ нь миний хамаарах асуудал биш. Би яагаад хятад хэлний тухай энэ түүхийг ярьчихав аа? *(Бүгд инээлдэв.)* Багш нь хөгширчээ. Зарим хүн Багш бол нэн эртний бурхан гэж хэлдэг. Дэндүү эртнийх тул заримдаа саяхан ярьсан зүйлээ ч мартчихдаг. *(Бусдыг гэрээс гарахад дургүй гэж Багш ярьсан гэж нэг хүн хариулав.)* Тийм! Мэдээж дургүй, зүгээр л хог шүү дээ! Яг л тэр нохойн түүхтэй адил, Багш нь бусдыг гэрээс гарахыг зөвшөөрдөг нь түүний өөрийнх нь хүсэл зоригийг хүндэлснээс болдог. Гэвч хэрэв би үүнийг хэлж ярихгүй бол та нар ойлгохгүй.

Багшийнх нь хувьд энэ дэлхий нохойн хоолтой ижил, тиймээс юунд нь хоргодох вэ? Бүх дэлхийд хоргодохгүй болсон атал таны эхнэр, эсвэл нөхөрт хоргодоод яах билээ? Гэвч та нар туулан гэтлэхийг болон бясалгал дадуулахыг хүссэн, бас Багшийнх нь энэ газар бясалгал хийдэг газар болохоор та нарын ирэхийг зөвшөөрсөн. Хэн юу бясалгахаа өөрөө мэдэг. Учир нь энэ дэлхий минийх биш, сургаал ёс нь ч минийх биш. Та бүгд энд ирж, бясалгах эрхтэй. Гэхдээ өөрийн хувийн зан араншин, алдаа дутагдлаасаа болж энд жинхэнээр бясалгах гэж ирсэн хүмүүст төвөг болохгүй байхыг Багш нь хүснэ. Ердөө л энэ.

Заримдаа Багш нь гэрээс гарагчдыг хатуу чанга дадуулан сургадаг. Бүлэг нийтээрээ амар тайван байж л сая хамтаар

бясалгаж чадна, ойлгож байна уу? Багш нь та нарыг ирүүлэх дургүйдээ, эсвэл та нарт сайн биш дээ ингэж байгаа юм биш, харин энэ нь бусад бясалгагчийг хамгаалахын төлөө юм. За, одоо гол яриандаа буцаж орёе.

Яаж хар шид ашигладгийг ойлгов уу? Гэртээ хариад хар шид ашиглаарай гэсэн санаагаар Багш нь яриагүй шүү. Зөвхөн цагаан шид л хэрэглэж болно. Бясалгах тусмаа илүү болгоомжтой байх хэрэгтэй. Учир нь илүү их бясалгах тусам таны хүч чадал нэмэгдэж, бодол тань илүү хүчтэй болно. Хар шид гэдэг нь маш хүчтэй бодлоор бусдыг харааж зүхэх, эсвэл өөрийгөө шийтгэхийг хэлдэг. Та өдөр бүр: “Би муу, би муу хүн. Би яагаад ийм болчихов оо?” гэх мэтээр боддог. Энэ нь “өөрийгөө ятган үнэмшүүлэх” явдал бөгөөд ийм төрлийн зүйл нь маш муухай хэрэг. Хар шидээр бусдыг хорлох нь угаасаа маш муу зүйл, гэтэл хар шидээр өөрийгөө хорлох нь бүр ч илүү, төсөөлөхийн аргагүй байдаг. Зарим хүн гэрээс гарахын тулд өдөр бүр цагаан шидээр: “Би төрөл төрөлдөө гэрээс гарах дуртай.” гэхчлэн өөрийн далд ухамсарт суулгадаг. Хэрвээ та бүхэн гэрээс гарья гэвэл одооноос эхлэн өдөр бүр: “Би гэрээс гарна, би гэрээс гарна, би лавтай гэрээс гарна, би гэрээс гарах болно, би гэрээс гарна.” гэж бодоорой. Та хэзээ нэг өдөр гэрээс гарах нь лавтай. Гэхдээ зөвхөн яриад л болох бус, чин сэтгэлээсээ итгэх хэрэгтэй. Иймээс ихэнх хүний маани унших нь ач тусгүй гэж Багшийнх нь хэлсэн ийм учиртай. Ойлгож байна уу? Учир нь тэд ямар ч хүчгүй байдаг, өдөржин маани унших нь яг л амьсгалахтай адилхан нэг төрлийн дадалтай болохоос цаашгүй, төвлөрч чаддаггүй бөгөөд ямар ч утгагүй байдаг. Тиймээс Төгс баясгалант оронд очиж чадахгүй. Багшид нь та нарыг анхаарлаа төвлөрүүлж “маани унших”, Төгс баясгалант оронд гарцаагүй очиж чадах арга бий. Энэ бол Арьяабалын бясалгалын арга. Багш нь төрсөн цагаасаа хойш хэзээ ч муу хэрэг хийгээгүй, хэзээ ч худал яриагүй. Иймээс миний хэлсэн бүхэн үнэн тул лавтай биелнэ. Яг өнөөх хүн алсан архад шиг, ойлгов уу? Бидний сургаалын эзэд бүгд худал ярьж, хулгай хийж, амь хөнөөж болохгүй гэх зэргээр сургадаг нь та бидний төгс төгөлдөр их хүчийг хамгаалахын төлөө юм. Хэрвээ амь хөнөөж, хулгай хийвэл бидний их хүчинд цоорхой бий болно, ойлгов уу? Хэрвээ цоорхой байвал бидний хүч алга болно, тиймээс бясалгагч хүн бясалгах тусмаа илүү маш хянамгай, илүү сэрэмжтэй байх ёстой.

Сахил сахих нь өөрийгөө хамгаалахын төлөө байдаг. Зарим хүн цэвэр ариун биш байсан ч бясалгал хийвэл мөн хүч чадалтай, шидийн хүчтэй болно. Гэхдээ ийм хүн хэдийн муу зүйл хийж

дадчихсан байдаг болохоор энэ их хүчээ ачтай тустай зүйлд ашигладаггүй. Хэдийгээр асар их хүчтэй ч ам нээмэгц худал ярьдаг болохоор тэрхүү хүч нь үнэн бодит бус, хий хуурмаг бодол болон хувирна. Эсвэл бодол үүсмэгц бусдыг хорлох, эсвэл хөнөөх мэтийн муу бодол төрнө, хорон муу бодлуудаа зогсоох аргагүй. Хэрвээ бясалгадаг бөгөөд хүчтэйч хорон муу санаа өвөрлөсөөр байвал үнэхээр хэцүү шүү. Багшийнхаа санааг ойлгов уу? Хар шид ингэж бий болсон, бидний ариун бус сэтгэл, муу санаа, муухай бодлоос үүссэн. Угаас хар, эсвэл цагаан гэж байгаагүй, бидний бодол санаа өөрчлөгдөөгүй учраас хар болсон хэрэг. Хэрвээ бодол санаа өөрчлөгдөн сайжирвал цагаан шид болон хувирна.

Жишээ нь, бид өөрсдийгөө дадуулж, бие, хэл, сэтгэлээ ариусган ёс суртахуунтай байж, бусдад үргэлж сайн сайхан, амар амгалан, баяр жаргалтай болохыг хүсэн ерөөж, хэзээ ч муу бодол өвөрлөхгүй байж чадвал мэдээж бидний хүч тэр дороо бусдад ач тустай болно. Бусдад хор хөнөөл учруулахгүй, зөвхөн туслах болно.

Тиймээс богд гэгээнтэн ба харын бөө, удганы зөрөө тийм их биш, зөвхөн бодол нь адилгүй. Муу бодолтой нь харын бөө, удган болж, сайн бодолтой нь бодьсатва, архад болно. Иймээс бид онцгой хичээж болгоомжлох хэрэгтэй. Бясалгагч хүн ямар арга, ямар бясалгалын арга, ямар урсгалыг дадуулсан ч бай ёс суртахуун бол хамгийн суурь үндсэн нөхцөл нь юм. Зөвхөн ёс суртахуунтай байх нь хангалтгүй. Ёс суртахуун нь хүмүүст тустай хэдий ч зөвхөн ганц төрөлд нь л тустай, дараа төрөлд нь ач тустай байж чадахгүй. Өөрийн дараагийн төрлийг ч харж харгалзаж чадахгүй юм чинь бусдынхыг яаж халамжилж чадах вэ? Яг л далайн дунд зүг чигээ алдан салхины аясаар хөвөх завь хаа хүрэхээ өөрөө шийдэж чадахгүйтэй адил, ойлгож байна уу?

Хэрэв Багшаасаа суралцвал ёс суртахуунтай хүн болох төдийгүй очих газар тань ч тодорхой байна. Тэгэхгүй бол зөвхөн ёс суртахуунтай байснаар туулан гэтэлж чадахгүй. Угаасаа ёс суртахуунтай үйлийг хийх ёстой болохоор хэрэв өглөг их өгсөн бол өөрийгөө сайн хүн гэж бүү бодоорой, тийм биш. Магадгүй та урд төрөлдөө бусдад маш их өртэй байгаад энэ төрөлдөө төлөхөөр буцаж ирсэн байж мэднэ. Иймээс орчлон ертөнцийн үйл, үрийн хуулийн эрхээр бидний санаа бодол, мөнгө хөрөнгө арван зүгт татагдаж байдаг нь үргэлж урьд төрлийн өр төлөөсөөс болдог ажээ, ойлгож байна уу? Одоо би нэг жижигхэн зүйрлэл хэлье. Өчигдөр би нэг өвчтэй хүнийг эргэж очив. Буцаж ирээд

усанд ч орж амжаагүй байтал нэг хүн уулзахаар зочлон ирлээ. Тэр хүн: “Би ау лак хүмүүст их хайртай. Коллежид сурч байхад минь хамт сурдаг байсан нэг ау лак оюутан надад маш их тусалсан. Мөнгөний хэрэг гарвал мөнгөөр тусална, хэрэгцээтэй юм бүхнээр тусалдаг байв. Тэр одоо Америкт амьдардаг.” гэв. Өчигдөр надтай уулзахаар ирсэн тэр зочин бол уран барилгачин мэргэжилтэй, формоса хүн. Тэр тун сайхан сэтгэлтэй, үргэлж бусдад тусалдаг. Яагаад вэ? Учир нь урьд нь олон хүн түүнд тусалж байсан. Түүний хамгийн ачтай хүн бол тэр ау лак оюутан байсан гэж ярьсан. Багшийг нь ау лак хүн болохыг мэдээд тун дотно санагдсан гэнэ. Та нар хар даа, Багш нь хүртэл тэр ау лак оюутны нөлөөг хүртэв. Тэгэхлээр нэг хүний хийсэн сайн үйл нийт улс оронд нөлөөлдөг, тийм биз? Нэг хүн муу хэрэг хийвэл улс орон бүхэлдээ муугаар нөлөөлөгдөнө. Тэрээр нэгэн цагт ау лак хүний тусыг авч байсан бол одоо хөрөнгө мөнгө, эрх дархтай, хүч чадалтай болсон байна. Түүнд тусалж байсан өнөөх ау лак хүний амьдрал одоо жаахан дорой байгаа тул тэр хүн даруй мөнгөөр тусалж, тэр ч байтугай түүнийг эргэхээр Америкт очсон байна. Өмнө нь тус дэмийг нь авч явсан болохоор одоо ачийг нь хариулахыг хүсжээ. Үүний нэгэн адил хэрэв бид урьд төрөлдөө бусдын ач тусыг маш их авч байсан бол хэдийгээр одоо энэ төрөлдөө мартсан байлаа ч үйл, үрийн хуулийн нөлөөгөөр мөнгөтэй болсон үедээ өглөг өгөх дуртай байна. Тэр хүн (урьд төрлийн ачтан)-ээ хармагц тун их хайрлаж, Яагаад ингэж зовно вэ? Яагаад мөнгөгүй байна вэ гэж бодон даруй түүнд мөнгөөр тусална. Яагаад өөр бусдын зовж зүдрэхийг харсан ч сэтгэл үл хөдлөх атлаа түүний зовлонг хараад тэгж их сэтгэл хөдөлнө вэ? Учир нь өмнө нь тэр хүн танд тусалж байжээ, ойлгож байна уу?

Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн, бүх зүйл үйл, үрээр шүтэн барилдсан тул сайн үйл хийх нь бардамнахаар явдал биш, өглөг өгөх нь ч тийм сүрхий хэрэг биш.

Есүс Христ: “Нэг гараараа өглөг өгвөл нөгөө гартаа бүү мэдэгд.” гэжээ. Энэ бол жинхэнэ өглөг юм. Бид төрөхдөө бие нүцгэн ирсэн, явахдаа гар хоосон буцна. Ийм байхад би өглөг үйлдэв гэж болох уу? Хэрэв хэн нэгэн өлсөж байвал бид идэх юм өгөх нь гарцаагүй. Үүнийг хүн гэлтгүй амьтад ч хийж чадна. Зарим их бясалгагч Хималайн ууланд, эсвэл маш өндөр ууланд нуугдан бясалгал дадуулж байхдаа хоолгүй болох үед нь сармагчин тахил болгон жимс хүргэж ирдэг, мөн шувууд тахил болгон самар, жимс хүргэдэг, заан чихрийн нишингээр тахил өргөдөг гэж сонсож байсан. Амьтад хүртэл тийм сайн байхад хүн төрөлтөн бид яаж

муу байж болох вэ? Багшийнхаа санааг ойлгов уу?

Өглөг өгөх нь ямар учиртай байдаг вэ? Энэ нь зүгээр л тун энгийн хэрэг. Наад захын ийм энгийн зүйлсийг Багш нь тун цөөхөн ярьдаг. Гэвч бас ярина. Авшгийн үеэр ярьсан, тийм үү? Та бүхэнд тараасан материалд өглөг өгөх ёстой, сахил сахих ёстой... тухай бичсэн байгаа. Энэ бүхэн бол хүмүүсийн хийх ёстой зүйлс. Учир нь бид хамаг төрөлтний дөрвөн их энэрлийг хариулах өртэй, үүнийг эргүүлэн төлөх ёстой. Иймээс энэ нь сүрхий явдал ерөөсөө биш, ойлгов уу?

Тийм учраас өглөг өгөхийг ямар урсгал, эсвэл шашин байхаас үл хамааран бүгд хөхиүлэн дэмждэг, гэхдээ Их Багш нар үүнийг дахин дахин онцлоод байдаггүй, дурдаад л өнгөрдөг, үлдсэнийг нь та өөрөө хийх ёстой. Тэд өглөг өгөхийг хамгийн чухал зүйл, эсвэл хамгийн гол зорилгоо болгодоггүй. Учир нь хэдийгээр бид өгөхийг хүслээ ч хангалттай өгч чадахгүй, тийм үү? Ертөнцийн зовлон ийм их, бид тэрбумтан байсан ч хүн бүхнийг харж хандаж чадахгүй. Бид боломжийнхоо хэрээр гэр бүл, эцэг эх, улс орондоо ач тустай байхад л хангалттай, учир нь бидэнд дэлхийг бүхэлд нь харж харгалзах боломж байхгүй.

Өглөг өгөх нь бас нэгэн төрлийн цагаан шид юм, учир нь өглөг өгвөл бусдыг баярлуулна, өөрийн хүчээр хүмүүст баяр жаргалыг ерөөнө, бусдад тусална, тэднийг ядуурлаас баян чинээлэг болгоно, өлсөж үхэх гэж буй хүмүүсийг хоол хүнс, хувцас хунараар хангана. Тэгэхээр өглөг бол нэг зүйлийн цагаан шид, ойлгов уу? Бид ийм шидийг өдөр бүр ашиглах ёстой. Хар, цагаан шид гэж юу байдгийг мэдэхгүй гэж бүү бодоорой. Мэдээж та нар мэднэ, гэхдээ хэрхэн ашиглахаа л мэддэггүй. Өнөөдөр Багш нь та нарт цагаан шидийг хэрхэн ашиглах талаар тодорхой тайлбарлана.

Хэрвээ цагаан шидийг бясалгая гэвэл “бодол”-оороо л бясалгана. “Бодол”-оороо бясалгана гэдэг нь юу вэ? Энэ нь зориуд ямар нэгэн шид бүтээх, зориуд бусдыг цагтах, зориуд бусдад мөнгөө өгөх, зориуд бусдыг өлбөрүүлэхгүй байх, зориуд тарни хэрэглэх зэрэг юм. Товчоор хэлбэл, цагаан шид гэдэг нь нэг төрлийн зориуд үйлдсэн шид.

Арьяабалын аргаар бясалгах нь нэг зүйлийн хамгийн дээд дэсийн үйлдэхгүйгээр болдог шид юм. Энэ нь жамаараа болдог бөгөөд ямар ч бие, хэл, сэтгэлийг шаарддаггүй, ойлгож байна уу? Жишээ нь, та нар энд ирэх үедээ маш их баяр жаргалыг мэдэрдэг,

эсвэл өвчин тань дорхноо эдгэж, гай зовлон даруй түргэн арилна, эсвэл Багш нь ирж аврахыг хардаг гэх мэтийн явдал болдог. Энэ бүхнийг Багш нь зориудаар хийгээгүй. Багшид нь ямар ч бие, хэл, сэтгэл огт хэрэггүй. Энд би урьдын адил ном тайлсан хэвээрээ байж, унтаж амарч, хооллож ундлан яг энгийн үеийнх шигээ л байдаг. Гэхдээ Багш нь юу ч хийсэн байлаа гэсэн та бүхэн ач тусыг нь хүртэх болно.

Багш нь бие, хэл, сэтгэлийн дотор оршдоггүй учраас тийм төрлийн “зориудын шид” ашигладаггүй, тодорхой нэг тарни бичиж юм уу, эсвэл “бодол”-оороо шид бүтээх хэрэг надад байхгүй. Бодлоор бүтээсэн бүхэн цагаан шидийн хүрээнд байдаг. Багш нь цагаан шид ашигладаггүй.

Багшийнхаа ид шидийг та нар харж чаддаггүй, бас мэдэрч чаддаггүй. Зарим хүн энд Багшийнхаа тарнидсан рашааныг ууна хэмээн хүсэж ирдэг ч би юу ч өгдөггүй. Хэрвээ ус авчраад Багшаараа адислуулах гэвэл надад бас адисламаар юм байхгүй, адислах гээч юу болохыг ч би мэдэхгүй. Гэвч та нарын өвчин жамаараа л эдгэрдэг. Энэ нь та нар өөрөө өөрийгөө аварсан явдал юм. Надад адислах юм байхгүй. Энд би оршихгүй, тэгэхээр хэн адислах вэ? Адислах хүн байхгүй, гэвч та нар адислуулах дуртай, тиймээс Багш нь та нарын хүслийн дагуу хийдэг. Адислах хүч мэдээж байгаа, байхгүй биш. Та бүхэн бүгд энэ адислах хүч ямар их тустайг, ямар их хүч чадалтай болохыг нь мэддэг. Гэвч Багш нь юу ч хийгээгүй. Энэ бол жинхэнэ “үйлдэнэ, гэхдээ үйлддэггүй”, “хийнэ, гэхдээ хийдэггүй” гэдэг нь юм, ойлгов уу?

Багш нь сая өглөг өгөх нь нэг зүйлийн цагаан шид бөгөөд өглөгөөр ядуу хүнийг баяжуулж, өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүсийг хоол, хувцас хунараар хангаж болно гэж хэлсэн. Бусдын өвчнийг эмнэх нь бас нэг төрлийн цагаан шид мөн. Тэр нь зориуд үйлдэгддэг. Учир нь бодлоо заавал төвлөрүүлэх хэрэгтэй. Эсвэл ямар нэгэн тарни бичиж, эсвэл ямар нэгэн бариа иллэгийн арга хэрэглэн өвчнийг нь эдгээдэг. Цагаан шид хэрэглэвэл мэдээж хүмүүст маш их ач тустай. Гэхдээ мөн л энэ үйл түйтгэрээ хожим төлж дуусгах ёстой. Үүнээс мултрахын аргагүй, ойлгож байна уу?

Яагаад үйл түйтгэртэй болсон бэ гэвэл өвчтэй хүний үйл түйтгэрт бид хөндлөнгөөс оролцсон байна. Тиймээс төлөх ёстой. Энэ үйл түйтгэрийг төлөхийн тулд бид хэсэг хугацаанд өвдөж магадгүй, тэр ч байтугай амь насаа ч алдаж мэднэ. Мэдээж бид сайхан сэтгэлээр тусалж, түүнийг өвчнөөс аварсан болохоос хорлоогүй. Гэвч өвчнөөс нь аваръя гэсэн энэ санаа нь “бодол”-ын

хүрээнд л байна. Энэ нь Гурван ертөнцийн чанадад гарсан хүч биш юм. Гурван ертөнцийн дотор байгаа л бол та юу ч ашигласан бай, сайн, эсвэл муу ч бай ялгаагүй заавал төлөх хэрэгтэй болдог. Тэр ч байтугай ширхэг зүүгээр хувцас оёсон ч төлнө, ганц зоос хэрэглэсэн ч төлнө.

Тиймээс хамгийн дээд дэсэд танд юу ч шаардлагагүй байдаг, тийм хэдий ч тэнд юм бүхэн бий, ойлгов уу? Олон жинхэнэ их бясалгагчийн аж амьдрал харахад тун хүнд хэцүү байсан. Жишээ нь, Мял богд. Тэрээр Төвөдийн өндөр ууланд бясалгаж байхдаа идэх хоол, өмсөх хувцасгүй болох үе байсан ч өөрөө бол тун их баяр жаргалтай байжээ. Энэ нь Тэр зориудаар өөрийгөө зовоож байсан явдал биш, харин бүхий л дэлхий ертөнц Түүнд шаардлагагүй тийм дэсэд хэдийнээ хүрчихсэн байжээ. Хэрвээ танд ямар нэгэн зүйл шаардлагатай хэвээр байвал энэ дэлхийн үйл, үрд нөлөөлөгдсөн хэвээр байна гэсэн үг. Юу ч шаардлагагүй болдог тийм дэсэд хүрвэл юуг ч хэрэглэсэн үйл, үргүй болно. Юуг ч хэрэглэсэн бай дотоодын Их Багш бидэнд өгсөн гэдгийг мэдэх ёстой. Аливаа зүйлийг дотоодоосоо хэрэглэж, дэлхий ертөнцийг гаднаас биш, дотоодоосоо харах ёстой. Ихэнх хүн үйл түйтгэрээсээ болж зовж шаналж байгаа нь бодлоо гадагш сарниаж, өөрийн эрхээр бус бусдын эрхээр байдгаас болдог юм, ойлгов уу? Хэрвээ жинхэнэ амар амгалан, баяр баясгаланг олъё гэвэл бусдын эрхээр бус өөрийн эрхээр байдаг тийм хүн болох хэрэгтэй. Өөрийн эрхээр байх гэдэг нь юуг хэлнэ вэ? Аливааг энэ дотоод хүчээр хийхийг, дотоод хүчиндээ түшиглэн дэлхий ертөнцийг харахыг хэлнэ. Энэ дотоод хүч бол бидний өөрийн хүч бөгөөд Багшийнх нь үргэлж хэлдэг “Их Багшийн хүч” юм, ойлгож байна уу? Өөрийн хүчээ хараахан бүрэн хөгжүүлээгүй учраас та бүхэн Багшийнхаа хүчээс зээлдэг. Хэрэв та нар мөнгө олж амжаагүй байгаа бол бага зэргийг Багшаасаа зээлж болно. Өөрийн дэлгүүрээ нээж ажиллуулаад их мөнгөтэй болбол Багшаасаа зээлэх шаардлагагүй болох юм. Одоо түр зуур хэрэглэж болно, асуудалгүй. Эхэндээ Багшийнхаа хүчийг түшнэ, хожим өөрийн хүчээ ашиглана. Үнэндээ Багшийн хүч ч гэсэн та нарын хүч. Гэвч та бүхэн хараахан мэдэхгүй байгаа тул Багшийнхаа хүчээс зээлдэг.

Хэрэв бид энэ хамгийн дээд дотоод хүчээ түшиж, дэлхий ертөнцтэй харилцвал дэлхийд нөлөөлөгдөхгүй. Харин дэлхий ертөнцөд найдан дэлхий ертөнцтэй харилцах, эсвэл өөртэйгөө харилцвал бидэнд асуудал үүсэж, саад бэрхшээл тулгарна, яришг төвөгт орооцолдох болно. Дэлхий ертөнц гэж юу вэ? Та нарын харж буй энэ дэлхий ертөнц тун эмх замбараагүй байна, тийм

биз? Юм бүхэн эмх цэгцгүй, энэ дэлхий төрөх, өтлөх, өвдөх, үхэхийн зовлонгоор дүүрэн. Ийм байдлыг өдөр бүр харвал бидэнд ч бас нөлөөлнө, ойлгов уу? Жишээлбэл, халдварт өвчтэй хүнийг асарч, дэндүү ойрхон байвал хэрэв анхаарал болгоомжтой байж, өөрийгөө хамгаалахгүй бол халдвар авч, өвчлөнө, тийм биз дээ?

Хэрвээ өөрийн дотоод их хүчээ түшиж амьдарвал өөрийн эрхэт хүн болно. Ийм хүнийг бид өөрийн Уг дүр, эсвэл өөрийн жинхэнэ эзнээ олсон хүн гэдэг. “Өөрийн жинхэнэ эзнээ олох” гэдэг нь өөрийн дотоод их хүчээ түших гэсэн санаа. Гэтэл хэрэв бид энэ хүчийг мэдэхгүй бол яаж түших вэ? Ойлгож байна уу? Ийм учраас “Авшиг хүртээх” гэдэг нь Багш нь та нарыг харж халамжилж, энэ хүч хаана байдгийг, түүнийг өдөр бүр хэрхэн ашиглахыг зааж өгөх явдал юм. Бид үүнийг хэдий их хэрэглэнэ, төдий чинээ баян болно. Жишээ нь, банкинд бид үлэмж хэмжээний мөнгө хадгалуулсан ч өдөр бүр авч хэрэглэхгүй байвал юугаа түшиж амьдрах вэ? Үүний адил бидний дотоодод хэдийгээр их хүч байдаг ч хаана байгааг нь мэдэхгүй, яаж өдөр бүр авч ашиглахаа мэдэхгүй бол ямар ч хэрэгцээгүй. “Авшиг хүртээх” гэдэг нь Багш нь та нарт мөнгөө хэрхэн ашиглахыг заана гэсэн үг. Мөнгө тань хангалттай их биш бол зээлдүүлнэ. Хэсэг зуур түүнийг хэрэглэж болно. Зээлдүүлсэн гэж байгаа ч буцааж авахгүй, та хүү ч төлөх шаардлагагүй. Учир нь Багш нь хэрэглээд барахгүй их мөнгөтэй. Тиймээс та нар хэрэгтэй бол Багшаасаа зээлж болно. Хичнээнийг ч зээлж болно, хамаагүй. Учир нь тэрбумтан хүн ядуурал, алдагдал, дампуурлаас айдаггүй. Арьяабалын аргаар бясалгах нь хар шид ч биш, цагаан шид ч биш гэж Багш нь сая хэлсэн. Гурван ертөнцийн доторх бясалгалын аргыг дадуулсан бол л хар, цагаан шидийн тухай ярина. Арьяабалын аргаар бясалгахад “бодол”-ыг ашиглахгүй. Гэхдээ бид энэ билиг ухаан буюу мэдлэгээ ашиглан өдөр бүр нийгэмтэй харилцвал өөртөө ч тустай, дэлхий ертөнцөд ч тустай. Хэрвээ өдөр бүр муу бодлоор бусдыг харааж, энэ үхээсэй, тэр дампуураасай гэж зүхвэл энэ дэлхий мэдээж өөдлөхгүй. Ингэвэл хар шид болж хувирна, ойлгов уу?

Иймээс бясалгах тусам улам болгоомжтой байх ёстой. Сайн сайхан зүйлсийг бодож, зөвт байдал, сайн төлөвлөгөөг бодож боловсруулан хүмүүст хэрэгтэй, ертөнцөд тустай, улс орондоо дэмтэй бол цагаан шид гэж болно.

Гэхдээ та нарт хэлэхэд, юу ч бодохгүй байх нь хамгийн сайн. Учир нь Арьяабалын аргаар бясалгахад жамаараа л хамаг төрөлтөнд ач тустай болдог, энэ нь гэр бүл, улс орон, цаашлаад

дэлхий дахинд ач тустай. Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүн авшиг хүртсэнийхээ дараа хичээнгүйлэн сайн бясалгаж, багшийнхаа зааврын дагуу өдөр бүр хоёр цаг хагас бясалгаж суувал таны очсон газар бүхэн тэр дороо өөрчлөгдөж, буян хишгээр бялхдаг. Учир нь Багшийнх нь хүч тантай хамт явж байдаг юм, ойлгож байна уу? Жишээлбэл, усны хоолойгоор урсах усны хэмжээ их байвал түүнд холбогддог л юм бол хаанаас нь ч холбосон устай болно. Элсэн цөлийг нэвт туулсан ч асуудал гарахгүй, ус бол ус. Элсэн цөлд ч усны хоолойд холбогдож чадвал устай болно.

Арьяабалын бясалгалын аргыг дадуулах нь энэ усны урсгал, усны хоолойтой ижилхэн. Хэрвээ Багшийгаа урсгал устай зүйрлэвэл та нар хараахан урсгал ус шиг болоогүй ч ядаж усны хоолой шиг байж чадна. Тантай хаанаас ч холбогдсон уух устай болно. Заавал урсгал устай газар очиж байж л сая уух устай болох шаардлагагүй. Усны хоолойд холбогдвол уух устай болно. Багшийнхаа хэлэх гэсэн санааг ойлгож байна уу? Тэр үед залбирах ч шаардлагагүй, аяндаа л устай болно. Эзэн Бурханаас тусламж гуйх шаардлагагүй, ус зөөх, эсвэл “хиймэл ус” гаргах ч хэрэггүй. Усны хоолойд залгагдмагц л устай болно. Тийм биз? Ус дамжуулах хоолой маш хямдхан. Усны хоолой бол хоёр цаг хагас бясалгаж суух явдал юм, үнэхээр хямдхан.

Хоногийн хорин дөрвөн цагийн хорин хоёрыг нь бид дэлхий ертөнцөд зориулчихаад ердөө аравхан хувийг нь өөртөө үлдээдэг ч бүрэн зориулж чаддаг уу? Тэнэг хүн л бие, хэл, сэтгэлээ бүгдийг нь энэ ертөнцөд зориулна. Өдөржин энэ ертөнцийг ажиглан хэн нь сайн, хэн нь муу, хэн нь зовж, хэн нь жаргаж, хэн нь ядуу, хэн нь өвдөж байгаад хамаг анхаарлаа хандуулж, харж хандаад завгүй. Гэртээ харих үедээ эхнэрт маань хувцас байна уу, үр хүүхдүүд минь өлсөж байна уу гэх мэтчилэн санаа тавина, хоногийн хорин дөрвөн цагаа тэдэнд зориулна. Хэрэв та нар бид өөрсдийгөө харж хандаж байдаг гэвэл буруу. Учир нь хооллож байхдаа ч яаран ажил төрлөө бодон санаа зовж, аажуу тайван идэж чаддаггүй. Орондоо орох үедээ унтаж чадахгүй, өнөөдөр даргын царай нэг л таагүй байсан, би ажлаа сайн хийж чадсангүй гэхчлэн бодсоор байдаг. Иймээс та нар өөрсдийгөө жинхэнэ ёсоор харж халамжилж чаддаггүй. Энэ ертөнцөд хорин дөрвөн цагаар эрхшээгдэж, хорин дөрвөн цагаар хүлэгдэж, хорин дөрвөн цагаар цоожлогддог. Өдөржин энд хоригддог, үүнийгээ өөрөө ч мэдэхгүй, ойлгож байна уу?

Багш нь та бүхэнд хоёр цаг хагас “битүүмжлэн суух”-ыг заахад та нар дэндүү урт байна гэнэ. Хоёр цаг хагас “битүүмжлэн суух” дургүй, харин дэлхий ертөнцөд хорин дөрвөн цаг “хоригдох” дуртай. Үнэхээр тэнэг байна даа, ойлгож байна уу? Яагаад бүгд дуугүй чимээгүй болчихов. Нээрээ хошин шогийн мэдрэмжгүй хүмүүс шүү. (*Бүгд инээлдэв.*) Одоо л жаахан инээх аядлаа. Багшийгаа баярлуулахын тулд л хүчээр инээмсэглэж байгаа дүр эсгэцгээж байна уу?

Энэ ертөнцөд өдөр бүр хорин дөрвөн цагаар “хоригдож цоожлогдож”, хөлс, цусаа дуслуулан эцэж ядарч, хүч тамираа бартал ажилласан ч та нарт зовлонтой санагддаггүй. Багш нь та нарт хоёр цаг хагасын цаг хугацаа гарган “битүүмжлэн сууж” өөрийгөө халамжилж, хүч чадлаа сэлбэж, өвчин эмгэгээ сувилж, бие, хэл, сэтгэлээ хөгжүүлэхийг сургадаг, тэгвэл та нар маргааш нь дахиад л ертөнц авхайтай нүүр тулж, дэлхийд үйлчилж чадна. Тун хэцүү байна, бясалган суух цаг зав алга гэж элдэв шалтаг тоочих хэрэггүй. Та нар дэндүү залхуу, хоногийн хорин дөрвөн цагийг дэлхийг харж хандахад үрээд дуусгаж байна.

Үнэндээ энэ дэлхий дээр харж харгалзмаар юмгүй, ихдээ л идэх хоолтой, өмсөх хувцастай байхад болно. Бусад нь ямар ч хэрэгцээгүй. Тийм биш үү? Нэг хүнийг насаараа харж халамжилж өдөр бүр хамгийн сайхан амттаныг идүүлж, сайхан хувцас өмсүүлсэн ч өөр илүү юу өгч чадах вэ, та? Зуун жилийн дараа тэр хүн бас өнөөх л мөнхийн зочид буудалд очиж, нойрсох л хэрэгтэй болно, тийм биз? Тэнд мөнх нойрсоод дахин хэзээ ч буцаж ирэхгүй тул Багш нь оршуулгын газрыг нь мөнхийн зочид буудал гэв.

Формосад тийм зочид буудал маш олон. Энд хүн их, газар нутаг нь бага, хаа ч очсон мөнхийн зочид буудал тааралдана. Тэд тун ч гоёмсог. Заримдаа Багш нь гэрээс гарагчдад хандан: “Хэрвээ бидэнд амьдрах газар олдохгүй бол Формосад зочид буудлууд байна, гоё гэр (булшны бунхан) ихтэй тул тэнд амьдарч болно, асуудалгүй, та нар санаа бүү зов.” гэж хэлдэг юм. Үнэхээр газаргүй болбол бид тэнд амьдарч болно. Тэдэнд өвсийг нь хадаж тусалвал эзэн нь баярлана. Тэнд нь гэрээс гарсан хүмүүс бясалгахаар ирвэл тэдний буян хишиг нь нэмэгдэх тул их талархана, ямар ч асуудалгүй. Хэрвээ толгой хоргодох газаргүй болбол бид булшны бунханд амьдар ч болно.

Амьдрах газаргүй болохоос Багшийнх нь санаа их зовдог гэж битгий бодоорой. Хүмүүс ирж ном сонсох ашрамгүй болно гэж

л Багшийнх нь санаа зовдог. Багш нь хувьдаа хаана амьдрах вэ гэдэгт огт санаа зовдоггүй. Гэхдээ та нар олуулаа болсон тул Багш нь амьдрах газар хайх хэрэгтэй болоод байна. Иймээс Багшийнх нь нэг ширхэг үс хэдийнээ цайжээ. (Бүгд инээлдэв.) Өмнө нь цагаан үсгүй байсан, харин одоо нэгийг олов. Нэг ширхэг хагас болсон шиг байна. (Бүгд үргэлжлэн инээлдэв.) Олны төлөө үс минь цайж эхэлжээ. Тэрнээс биш гэрээс гарагч бидний амьдрал хамгийн энгийн. Багш нь хаана байна, тэд тэнд байна. Юу ч шаардахгүй. Бидэнд “цахилгаан” ч, “чийдэн” ч хэрэггүй. Хаана “ус” байна, тэнд амьдарна. Формосад хаа сайгүй усны эх үүсвэр байдаг, бид зөвхөн усны хоолой холбосноор гэртээ хэрэглэх устай болно. “Амьдрах”-аар бол тиймэрхүү мөнхийн зочид буудал-булшны бунхан, нэгдүгээр зэрэглэлийн байшин олдоно. Зарим нь ердийн байшингаас ч илүү гоёмсог, та нар ер нь харж байсан уу? Зарим хүн саяыг зарцуулж бунхан бариулж байна. Гэтэл би газар авах арван мянган юань олж чадахгүй л байна. Гэрээс гарагчдын хувьд амьдрах орон байр нэг их асуудал биш. Тэд бүгд янз бүрийн нөхцөл байдалтай тулгарвал юу хийх ёстойд суралцсан, мөнгөгүй бол яаж амьдрах, хувцасгүй бол өөрөө яаж эсгэж, оёх, хоолгүй үед зэрлэг ногоо хайж олох, өргөл барьцгүй үед хэрхэн бие даан аж төрөх, орох оронгүй бол хэрхэн тухайн нөхцөл байдалд зохицох зэрэгт бид бүгд суралцсан, та бүхний дэмжлэггүй ч амьдарчихна. Өргөл өргөж байгаа тань өөртөө л тусалж буй хэрэг. Авшигтанд, Багшид тусалж байна гэж бүү бод. Тиймээс өргөл барьц өргөх үедээ тийм дуу ихтэй, бас тэгж их хэтрүүлэн ярих хэрэггүй. Өргөл өргөхөөс тань өмнө улс даяараа мэдчихсэн байх юм. “Би” нэг зуун мянган юань Багшид өргөхөөр авсан, “би” төдийд өдийд Багшид машинаараа үйлчилдэг гэж ярих хэрэггүй. Та бүхэн өөртөө л өргөл өргөж байдаг.

Багшид нь хэрэгтэй юу байх вэ, өдөрт нэг удаа хамгийн ихдээ хоёр, эсвэл гурван удаа хооллоно, муурын зулзагын иддэг хэмжээний хоолтой. Та бүхэн хэнд өргөл өргөх вэ? Надад та нарын өргөл барьц огт хэрэггүй. Өглөг ч өглөг гэмээргүй, өргөл ч өргөл гэмээргүй. Өөрийн биедээ л өргөж байгаа хэрэг. Ашрамгүй бол та нар ирж, Багштайгаа уулзаж чадахгүй, эсвэл ном сонсож чадахгүй. Багш нь булшны бунханд амьдарвал өнөөдөр шиг ийм сайхан өдөр таарвал хамаагүй, та нар ном сонсохоор ирж болно. Харин бороотой, хар салхитай өдөр тохиовол та нар ирж, Багшийнхаа ном тайлахыг сонсох боломжгүй. Тиймээс та бүхэн мөнгө хандивлаж, газар худалдаж аваад ашрам барих гэж байгаа нь бүгд өөрсдийнхөө төлөө шүү. Үүнийг бүгдээрээ сайн ойлгох хэрэгтэй.

Иймэрхүү зүйлсийг Багш нь огт ярьдаггүй. Намайг “Багш нь газар авах санаатай байна, та нар боломжоороо туслаарай.” гэж байхыг та нар ер сонсоогүй дээ. Багшийнхаа ингэж ярихыг сонссон уу? Мэдээж үгүй. Би их ичимхий. Ам нээнгүүтээ мөнгө гэж ярих дургүй. Иймэрхүү юм бодохгүй.

Зарим хүн Багшийн бясалгал нэн өндөр тул хүссэн бүхэн нь биелнэ гэж ярихыг сонсоод надаас “Багш аа, Та яагаад мөнгөтэй болох тухай боддоггүй юм бэ?” гэж асуусан. Үүнийг сонсоод хэдэн цагийн турш дотор муухайрч (*Бүгд инээлдэв.*), бөөлжих шахсан. Би та нарт үнэнийг хэлэхэд, хэн нэгэн хүн надад ийм зүйл хэлнэ гэж би итгэж чадахгүй, тэр нь бүр миний “шавь” шүү. Нээрээ “шавь” биш “шавар” (*Бүгд инээлдэв*) байна. Ямар ч билиг ухаан алга.

Багш нь юу гэж мөнгө бодох вэ? Надад мөнгө гэсэн ойлголт ер байхгүй. Багшийнхаа шуудангийн газарт очсон түүхийг та нар мэдэх үү? Багш нь мөнгөө тоолж чадахгүй байсан тул шууданд аваачиж, тэднээр тоолуулсан. Маш их мөнгө байсан болохоор тоолоход амаргүй байсан юм. Шуудангийн ажилтан: “Таны мөнгө хэд байсан вэ? Та яагаад эхлээд тоолсонгүй вэ?” гэхэд нь би: “Та надад машинаараа тоолоод өгвөл арай хурдан байх.” гэхэд тэр: “Ингэж болохгүй, хүн таныг мэхэлнэ шүү дээ!, яагаад гэвэл та бараг есөн зуун мянга байгаа гэсэн чинь тоолоход нэг сая гаран байна. Илүү мөнгийг тань буцааж өгөхгүй бол яана?” гэсэнд би: “Тэгэхгүй дээ, тэгээд ер авсан ч яахав. Угаасаа формосачуудын мөнгө, тэгэхээр Формосагийн хүн аваад хэрэглэхэд нь надад ямар хамаа байх вэ?” гэв. Та бүхэн ашрамгүй байгаа нь формоса хүмүүсийн нийтийн үйлийн үр юм. Энэ нь надтай ямар ч хамаагүй. Том газартай байх нь та нарын л буян. Ашрам байвал хүн бүхэн ирж, ном сонсож чадна. Энэ нь Багштай нь ямар ч хамаагүй. Энэ хамаатай юу? (*Хамаагүй гэж бүгд хариулав.*) Иймээс өргөл өргөх нь надтай ямар ч хамаагүй. Өгөхдөө “би” өгөв гэж бүү бод, өргөл өргөсөн ч өсгөж ярих хэрэггүй. Эдгээр нь үнэндээ юу ч биш, хэрвээ яривал миний дотор муухайрна, аягүй бол мөнгийг тань буцааж мэднэ. Өргөл өргөхдөө ямар ч санаагүй бол өргөж болно, ойлгов уу? Мөнгөндөө баригдвал өргөх шаардлагагүй, Багшид нь хэрэггүй. Одоо маш их мөнгө байгаа, бид бүгдийг нь хэрэглээд барахгүй. Дуусвал харин хэлэмз. (*Бүгд алга ташив.*) Үнэндээ Багш нь иймэрхүү зүйлсийг огт ярьдаггүй. Заримдаа Багш нь мөнгөгүй болдог, та нар үүнийг огт мэдэхгүй. Мөнгөтэй байхдаа энэ талаар хэлэхгүй л бол та нар бас мэдэхгүй байдаг, тийм биз? Багш нь ийм зүйлийн талаар ярьдаггүй, учир нь миний сэтгэл

үүнд хүлэгддэггүй.

Хамаг төрөлтөнд тустай байхыг хүсдэг тул ном тайлах үедээ би энэ талаар жаахан ярьдаг, тэрнээс би юу гэж мөнгөний тухай бодох вэ? Тэр шавь, Багшийн сүнслэг бясалгалын дэс тун өндөр, тиймээс бодсон бүхнээ авч чадна гэж бодож байсан тул Багшид нь мөнгөний талаар бодохыг санал болгожээ. Би бодож болно, бодсон даруйдаа мөнгөтэй болно, болохгүй биш. Гэхдээ би угаас бодож болохгүй.

Хүн өлсвөл хоол боддог, тийм биз? Өлсөж үхэх гэж байгаа хүнд юу бодогдох вэ? Мэдээж идэх зүйл, хүнсний ногоо, талх бодогдоно, тийм биз? Цатгалан хүнд хоол бодогдохгүй, хоол идсэний дараа бол амттан байсан ч тоохгүй. Цангах үед хамгийн түрүүнд юу бодогдох вэ? Уух юм олохыг л бодно. Гэтэл эндээ (*Их Багш хоолойн тус газраа заав.*) тултлаа уусан хүнд амттай сайхан үзмийн архи, дэлхийн хамгийн тансаг дарс өгсөн ч уумаар санагдахгүй, ойлгов уу? Тиймээс мөнгөнд дуртай хүн л мөнгө бодно. Үүнийг тэр шавь мартжээ. Мөнгөнд дургүй хүн юу гэж мөнгө бодох вэ? Цадсан хүнд хоол бодогдох уу? Багш нь мөнгөний тухай бодож яаж чадах вэ? Үүнийг сонсоод миний дотор муухайрсан нь нөхцөл байдлаас бус, миний шавь ингэж бодсоноос болсон хэрэг. Багшийгаа мөнгө бод гэж хэлж яаж болох вэ? Би энэ талаар бодож чадахгүй. Хэрэв хүчээр бодвол тун зовлонтой байна. Хүн цадсан үед чинь зодож байгаад хүчээр идүүлэх гэх, идэхгүй бол хөнөөнө гэхтэй адил танд тун зовлонтой байх болно.

Гол сэдвээсээ хазайгаад дэндүү их ярилаа. Одоо юу ярихаа мартчихлаа, дэндүү хөгширчихжээ. Зарим хүн Багшийг нь их эртний бурхан гэсэн. Нэн эртнийх, тиймээс ярих зүйлээ байнга мартана. (*Бүгд инээлдэв.*) Багш нь саяхан хар шид, цагаан шидийн тухай ярьсан. Харин Арьяабалын бясалгалын арга бол ид шидээс хэтийдсэн бясалгалын арга юм. Миний бодлоор хар шид, цагаан шидийг ерөнхийд нь ярьж дууслаа. Одоо би жаахан амсхийж болно гэж бодож байна. Та нарт асуулт байна уу? Багшдаа хар шидээ үзүүлэх хүн байна уу? Эсвэл цагаан шидийн хүчээ харуулмаар байгаа хүн байна уу? Та (*Жилунгийн нэгэн авшигтныг заав.*) шид дадуулахыг хүссэн хэвээрээ байна уу? Та өдөр бүр ямар шид дадуулж байна вэ? Хар уу, цагаан уу? (*Нэг авшигтан: Би мэдэхгүй гэж хариулав.*) Та нар өдөр бүр хар, цагаан шид үзүүлдэг, гэхдээ зөвхөн өөрсдөө мэддэггүй л болохоос.

Та нарт тарааж өгсөн бясалгалын өдрийн тэмдэглэлийг

хөтлөх нь хар шид, цагаан шидийг хэр их үзүүлсэн бэ гэдгээ шалгахад тань туслах зорилготой юм. Ойлгож байна уу? Өдөрт хэр их хар шид үзүүлж байна, хэр их цагаан шид үзүүлж байна гэдгээ хянана. Тэмдэглэлийг хөтлөхийн утга учир нь энэ. Эс бөгөөс та нар замбараагүй зүйл хийнэ, үүнийгээ өөрөө ч мэдэхгүй бөгөөд өөрийгөө хянаж чадахгүй. Муу хэрэг хийх нь хар шид, сайн зүйл хийх нь цагаан шид, ойлгов уу? Ид шидийн талаар мэдэхгүй хүнгүй, бүгд мэднэ. Гэхдээ өөрийгөө эрхшээж чаддаггүй, түүнийгээ сайн зүйлд ашигладаггүй. Цагаан шидээс илүү их хар шид хэрэглэдэг. Тиймээс тэр нь эргээд өөрсдөд нь хор хөнөөл учруулна.

Бусдыг хорлосны дараа үр дагавар нь өөрт эргэж ирдэг. Төрлөөс төрөлд төрөх, өтлөх, өвдөх, үхэхийн хүрдэнд эргэлдэж зовдог нь цагаан шид ашиглаж мэдэхгүй, хар шидийг хэт их ашигласнаас болдог юм. Хар шидийг хэдий чинээ их ашиглана, амьдрал төдий чинээ зовлонтой байна. Хэрвээ хэн нэгний аж амьдрал нь хүнд бэрх, асар их зовлонтой байвал бид тэр хүний үйл түйтгэр дэндүү хүнд гэж ярьдаг.

Үйл түйтгэр гэж юу вэ? Энэ нь муу үр дагавар юм, үүнийг тэр өөрөө зохиожээ, одоо тэр нь түүнтэй мэнд мэдэхээр ирсэн байна, ойлгов уу? Даанч тэр хүн санахгүй байгаа тул түүнд их л зовлонтой санагдаж, гомдоллоно. Хэрвээ энэ бүх нөхцөл байдлаа өмнө нь өөрөө л бий болгосон гэдгээ мэдвэл мэдээж гомдоллохгүй. Гэвч ихэнх хүн өнгөрсөн төрлөө мэдэх чадваргүй, мартсан байдаг.

Өнгөрсөн төрлөө мэдэх чадвар гэж юу вэ? Өнгөрсөн төрлийн амьдралаа харж чадна гэсэн үг. Хоёрдугаар түвшинд хүрвэл өнгөрсөн төрлийн амьдралаа харна, гэхдээ Тавдугаар ертөнцөд хүрсний дараа л сая ирээдүйн төрлийн амьдралаа харж чадна. Тиймээс мэргэ төлөгчдийн ихэнх нь таны хэзээ нас барах, хэзээ баяжих, хэзээ алдагдалд орох, хэзээ гэрлэхийг тань хэлдэг. Зөвхөн ийм л зүйлсийг хэлж чадна. Хамгийн сайндаа тэд зөвхөн энэ төрөлдөө хойшид яахыг тань, жишээ нь, ойрын хэдэн жилийн доторх, эсвэл энэ төрлийн туршид болох явдал учрыг хэлж чадах төдийхөн. Тэд өөр юу ч хэлж чадахгүй. Нас бараад хаана очихыг тань хэлж чадахгүй. Ойлгов уу?

Нас барсны дараах нөхцөл байдлыг хэлж чадах хүн тун цөөн, хэлсэн ч зөвхөн нас барах яг тэр үед юу болох талаар л хэлж чадна. Жишээ нь, тэр хүнийг үзээд: “Тэр одоо тамд унажээ, эсвэл Тэр диваажинд дэвшжээ.” гэхээс хэтрэхгүй. Хамгийн ихдээ ийм л зүйл хэлнэ. Ирээдүйд түүнд юу тохиолдохыг мэдэхгүй, диваажинд

очоод юу хийхийг, тамын оронд юу хийхийг нь мэдэхгүй, Хэзээ диваажингаас явах, эсвэл хэзээ тамаас гарахыг нь бүр ч мэдэхгүй. Ийм явдлыг мэдэх хүн тун цөөн. Зөвхөн Тавдугаар ертөнцөд хүрвэл сая бүхнийг мэднэ, түүний өнгөрсөн, одоо, ирээдүйг харах нь хуудас хуудсаар нь ном уншихтай л адил байна.

Тавдугаар ертөнцийн хүмүүс хэдийгээр бидний өнгөрсөн, одоо, ирээдүйн амьдралыг төрөл тутмаар нь харж чаддаг ч энэ тухай ярьдаггүй. Хэрвээ хэлбэл бидний бясалгалын явц, бясалгалын чадварт нөлөөлнө. Жишээлбэл, та өдөр бүр бясалган суудаг, бясалгал дадуулдаг байтал Багш нь: “Урьд төрөлдөө та ийм, ийм дарангуйлагч байжээ” гэвэл гарцаагүй таны сэтгэл шанална, тийм биз? Хэрэв “Та урьд төрөлдөө татвар эм Ян Гүй фэй, эсвэл Ши Шы... байсан.” гэвэл одоо та их царай муутай, яг Дүн Шы шиг харагдаж байдаг бол (*Бүгд инээлдэв.*) сэтгэлээр маш их унаж, мөс шиг царцан ихэд бухимдах нь гарцаагүй. Тийм биз дээ? Тэгээд урьдын Ши Шы байсан тэр цаг үедээ хүлэгдэж орхино.

Их Багш нар ийм зүйлсийг ярихгүй. Хэрвээ мэдэхийг хүсвэл Тавдугаар түвшинд хүртэл бясалгавал мэдэж чадна. Гурав, Дөрөвдүгээр ертөнцийг туулаад Тавдугаар ертөнцөд хүрвэл өнгөрсөн, одоо, ирээдүйнхээ амьдралыг мэдэж, өөрийн амьдралыг өөрөө шийдэх болно. Жишээлбэл, хэрвээ хүсвэл энэ тоост хорвоод бууж ирэн хамаг төрөлтнийг гэтэлгэж болно, эсвэл ахиад дээш гарч зургаа, долоо, найм, ес, арав, арван нэг, арван хоёр, арван гуравдугаар ертөнц... гэхчлэн тоолшгүй олон, хязгааргүй их ертөнцөөр зугаалж болно. Тэр үед бид өөрийн эрхэт хүн болох бөгөөд бусдын эрхээр байхаа болино, ойлгов уу?

Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаггүй, эсвэл ямар ч бясалгалгүй хүмүүсийн ихэнх нь энэ ертөнцийн “эрхээр” байдаг, иймээс “бусдын эрхээр” гэдэг юм. Ойлгож байна уу? Харын бөөгийн хар шидэнд хорлогдоно, дахиад өөр нэгэн харын бөөгөөр авруулна, эсвэл өөр хүний хар шидэнд хорлогдож өвдөнө, дараа нь цагаан бөө дээр очиж, шидийн хүчээр өвчнөөс аврагдана.

Сахил хүртэж, шүтэн дагасан ау лак багшийн маань охин дүү бусдын өвчнийг эмнэсэн түүхийг би та нарт ярьж байсан. Тэр бас гэрээс гарсан хүн байсан, өвчин засаж эмнэхдээ гаргууд. Их шидтэй, гэвч одоо шидээр өвчин эмнэхээ больсон. Учир нь энэ нь хэсэг хугацаанд, зөвхөн махан биеийг нь л аварна, сүнсийг нь үүрд мөнх аварч чадахгүй. Хэдийгээр тэр цагаан шидээр эмнэсэн ч төвөгтэй. Заавал бусдын үйлийн үрд хөндлөнгөөс оролцож, үйл

түйтгэрийг нь үүрэх болдог. Тиймээс хүмүүсийг эмчээр эмчлүүл гээд явуулдаг болсон.

Бусдын эрхээр байдаг төрөлтөн тун ч зовлонтой шүү! Заримдаа бид мөнгөгүй болбол их шаналдаг. Эсвэл сайн хоол ундгүй, эсвэл өмсөх хувцасгүй бол бас их шаналдаг, тийм биз? Гэтэл Гуан Чин хувраг ууланд амьдарч байхдаа хамгийн жаргалтай хүн байжээ. Хэдийгээр тэр мөнгөгүй, навсархай хувцастай, бас идэх хоолгүй байсан ч хэдэн долоо хоногоор, бүр хэдэн сараар хүнтэй уулзаагүй байна. Тэрээр зөвхөн сармагчин, бар, могой, шувуу болон бусад амьтнаас өөр ханьгүй байсан ч хамгаас илүү аз жаргалтай байжээ. Буцаж ирэн хамаг төрөлтийг гэтэлгэснээс хойш зовж шаналах болсон, ойлгов уу? Хоол идэх хүсэлгүй байхад нь шавь нар нь хүчээр идүүлэх гэж тасралтгүй ятгах нь үнэхээр шаналгаатай, тийм биш үү? Өөд болохынхоо өмнөхөн тэрээр: “Энэ хоолыг идвэл энд дахин долоо хонох хэрэгтэй болно, тиймээс идэхээ больё.” гэж байжээ. Та бүхэн хар даа! Энэ дэлхийд тэр маш их “хайртай” байсан ч дахин долоохон хоног саатахыг хүсээгүй байна. Тиймээс тэр хоолыг идээгүй. Гэтэл эгэл хүмүүс бид их багшийн махан биеийг үлдээхээр хүчилсэн нь шаардлагагүй зүйл байв. Түүнийг залгамжилж чадах гарамгай сайн шавь байвал тэр өөрөө хорвоод үлдсэнтэй ижил юм.

Одоо та бүхэн хар шид, цагаан шидийн алийг нь ч бясалгасан болно. Багш нь бүгдийг хэлж өгсөн болохоор өдөр бүр юу бясалгахаа өөрсдөө шийд. Гэхдээ Багш нь та нарт хар ч үгүй, цагаан ч үгүй байдаг Арьяабалын аргаар бясалгавал хамгийн сайн гэдгийг зөвлөө. Дотоодын Аялгууны урсгал жамаараа энэ дэлхий ертөнцийг болон Бидний үйл түйтгэрийг ч мөн угаан цэвэрлэнэ. Мөн Аялгууны урсгалын хүч жамаараа дэлхийг цэгцлэх болно.

Биднийг эмх цэгцтэй болгоно гэдэг бол дэлхийг цэгцэлж байгаа хэрэг. Учир нь “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.”, ойлгов уу? Лууз ч мөн ижил зүйлийг хэлсэн, Тэр: “Энэхүү “Нэг”-ийг олвоос аливаа бүхнийг олно. Дэлхий дахин өөрчлөгдөн сайжирна.” Ингэж хэлсэн, тийм биз? Миний орчуулга тийм ч сайн биш, гэхдээ та бүхэн “Мөр ёсны судар”-ыг уншвал ойлгоно. (Мөр ёсны судрын гучин есдүгээр бүлэг: “Энэхүү “Нэг”-ийг ологсод тэнгэртэй Нэг болбоос тунгалаг болмуй, газартай Нэг болбоос тайван болмуй, сахиусантай Нэг болбоос шидийг олмуй, гол горхитой Нэг болбоос бялхам болмуй, түмэн бодистой Нэг болбоос өсөж төлжмүй, хаад ноёдтой Нэг болбоос дэлхийг төвшитгөмүй.”

“Нэг”-ийг олох гэж юуг хэлнэ вэ? Бурхан чанараа олох, дотоод диваажингаа олох, өөрийн Уг дүрээ олох, өөрийн их хүчийг олохыг хэлж байна. Аялгууны урсгал бол бидний Уг дүр, бидний их хүч мөн. Одоо бид зөвхөн багаханыхыг нь л ажиж байгаа, харин хамгийн ихийг нь ажаагүй байна. Үүнээс ч илүү өндөр дэс бий. Бидний Уг дүр маш олон зүйл байдаг, ойлгож байна уу? Зарим хүн зөвхөн өчүүхэн бага хэсгийг сураад харын бөө болдог. Хэрэв сайн талаас нь суралцвал цагаан шидтэн болно. Бүгдийг сурвал Бурхан Багш болно, Есүс Христ болно, Мөр ёсыг бүтээсэн Лууз болно. Багшийнхаа ярьсан санааг ойлгов уу? Бид төгс төгөлдөр хүн болон хувирах ёстой.

Ямар хүнийг төгс төгөлдөр хүн гэх вэ? Гэрээс гараагүй хүн гэр бүлээ сайтар харж хандан улс орноо хайрлаж, өөрийн үүрэг хариуцлагаа сайн биелүүлэх ёстой. Гэхдээ бас цаг зав гаргаж, энэхүү их Мөр ёсыг танин мэдэх хэрэгтэй, тэгснээр л сая төгс төгөлдөр хүнд тооцогдоно. Төгс төгөлдөр хүн болоход тун амархан. Зөвхөн Шагжамуни Будда л төгс төгөлдөр хүн болж чадна гэсэн үг биш, бид ч бас болж чадна. Багшийгаа дагаж бясалгавал болж чадна. Бид энэ дэлхийг үл тоомсорлодог бус, гэр бүлээ харж хандана, бид эхнэр, нөхрөө харж харгалзах ёстой хэвээр бөгөөд ажлаа ч хийх ёстой. Зөвхөн бид арай илүү ухаалаг байж, өдөр бүр өөрийн цаг хугацааны арван хувийг хэмнээд бие, хэл, сэтгэл, өөрийн ертөнц, өөрийн сэтгэлийг сэлбэн засах ёстойг мэддэг байх хэрэгтэй. Тэгвэл хожим дэлхий ертөнц ч жамаараа сайжирна, учир нь “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.” байдаг. “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.” учраас хэрэв бид сэтгэлээ тэгшитгэн засахгүй бол өөр юугаа тэгшитгэн засах вэ?

Гэтэл ихэнх хүн гаднаас хайдаг, дайн байлдаан хийж, энэ нийгмийг өөрчилж байж л энх тайван тогтож, дэлхийгээ амар амгалан, баяр жаргалтай болгоно гэж боддог. Үнэн хэрэгтээ дайтах тусам муудаж, өөрчлөх тусам доройтдог, тийм биш гэж үү? Бидний энэ нийгмийг өөрчлөхийг хүсдэг хүн төрөл тутамд л байсан, гэсэн ч өөрчилж чадаагүй хэвээр л байна. Яагаад вэ? Учир нь тэр хүмүүс өөрийгөө өөрчилдөггүй юм. Күнзийн сургасан зарчмуудыг хятадууд бүгд мэддэг. Олон хүн “Шүүмжлэл өгүүлэл”, “Их суртахуй”, “Хэв дундын ёсон” гэсэн ном сургаалыг нь уншсан ч бодитой хэрэгжүүлдэггүй. Тиймээс дэлхий ертөнц одоо ч ороо бусгаа байдалтай хэвээрээ, Хятад улс ч энх амгалан биш байна.

Эхлээд биеэ зас, тэгвэл та гэр бүлээ удирдаж, төр улсаа

төвхнүүлж, дэлхий дахиныг төвшитгөж чадна. Хэрэв биеэ засаагүй бол гэр бүлээ эв зохиролтой байлгаж чадахгүй. Хэрэв нэг гэр бүл төвшин амгалангүй, хоёр гэр бүл төвшин амгалангүй, олон гэр бүл төвшин амгалангүй бол улс орон эмх замбараагүй болно. Улс орон самуун бол дэлхий дахин энх тайван байж чадахгүй нь гарцаагүй. Иймээс биеэ засах нь хамгийн чухал үндсэн суурь зүйл мөн. Биеэ засаагүй бол төр улсаа төвхнүүлэх, эсвэл дэлхий дахиныг төвшитгөх тухай ярих хэрэггүй. Ийм хүн удирдах тусмаа улам эмх замбараагүй болгоно. Күнз маш тодорхой хэлсэн боловч хэн ч хийж хэрэгжүүлээгүй.

Та бүхэн бүгд өөрийгөө биеэ засдаг гэж боддог. Гэтэл ямар биеэ засна вэ? Та нар биеэ засахдаа шим тэжээлтэй эм бэлдмэл өдөржин уух нь энэ махан биеэ л тордож байгаа хэрэг. Хаана цоорхой гарна, тэнд нөхөөс тавиулна. Хаана өвдөнө, эмчлэхийн тулд тэндээ мэс засал хийлгэнэ. Зарим хүн уушиг өвдвөл гахайн уушиг идээд төлжүүлнэ гэж боддог. Толгойн өвчин тусвал гахайн тархи, үхрийн тархи иднэ. Ингэвэл тархи төлжинө гэж боддог. Зарим нь зүрхээ өвдвөл төлжүүлэхийн тулд гахайн зүрх идэж ч мэднэ, тийм үү? (*Нэг хүн, Тийм гэж хариулав.*) Багш нь таагаад хэлтэл бараг онов бололтой. (*Бүгд инээлдэв.*) Энэ бүхэн нь бүгд миний өөрийн санаа бөгөөд гэрчлэх баримт хайгаагүй. Гэхдээ надад ингэж бодох шалтгаан бас бий. Учир нь намайг бага байхад ээж маань ихэвчлэн элэг, уушиг, зүрх, бөөр зэрэг олон зүйлийг хольж, гоймонтой хамт чанаж болгоод идүүлдэг байсан. Ингэж идвэл бүх биеийг тэжээнэ гэж тэр хэлдэг. Ээж маань энэ бүхнийг шарж, хуурч эхэлвэл би тэр даруй зугтаж, хоёр километр газар холдож одно. Учир нь би түүнийг нь харж ч зүрхлэхгүй байхад тэр нь яаж нөхөн төлжүүлэх вэ? Иймээс би их туранхай болсон байх. Ийм зүйлс харвал аймшигтай санагддаг байв. Энэ нь “нөхөн төлжүүлэх” биш, харин “айдас төрүүлэх”-ээр байлаа. Энэ нь хэтэрхий “айдас төрүүлэх”-ээр байсан болохоор харж ч зүрхлэхгүй. Та нарын зарим нь зүрх идвэл зүрх төлжинө, уушиг идвэл уушиг төлжинө гэж боддог. Нөхөн төлжүүлэе гэвэл хамгийн сайныг нь хэрэглэ. Энэ чинь амьтны зүрх болохоос хүний зүрх биш. Та нар хүн болохоор хүний зүрх идвэл илүү сайн нөхөн төлжүүлнэ биз дээ. (*Бүгд инээлдэв.*) Төлжүүлж нөхье гэвэл нөхсөн шиг нөх. Та нар хүн хөнөөгөөд зүрхийг нь идэж чадах уу? Үнэндээ хүн хөнөөх хэрэггүй, булшинд зөндөө байгаа. (*Бүгд инээлдэв.*) Сонсоход л дотор муухайрч байна, тийм үү? Гахай идэж болсон байтал хүн идэж яагаад болохгүй байх вэ? Гахай, хүн хоёрын үхэх байдал ижилхэн, адилхан л мах. Бид үнэхээр

бие махбодоо төлжүүлбэ гэвэл хүний мах идэх хэрэгтэй. Амьтны махаар яаж төлжүүлэх вэ? Улам бүр амьтан шиг болж ч мэднэ. Хүн ер нь дуртай зүйлтэйгээ адилхан болдог гэж та нар сонссон уу? Галуу нугас, эсвэл нохой тэжээдэг хүмүүс тэдэнтэйгээ төстэй болдог. Та нар харж байсан уу? *(Нэг хүн, Харсан гэж хариулав.)* Амьтны мах идвэл тэдэнтэй улам илүү төстэй болдог нь тун төвөгтэй аж. Хэрвээ нөхөн төлжүүлмээр байвал хүний мах идвэл зохино. Тэгвэл Формосад булш бунхны газар олддоггүй байдал шийдэгдэх байх. *(Бүгд инээлдэв.)* Хүний мах идэж зүрхлэхгүй бол яаж гахайн мах идэж зүрхлэнэ вэ? Адилхан л мах шүү дээ. Хүн ядаж бидэнтэй ойролцоо, химийн бүтэц нь ижилхэн, эр, эмээрээ л ялгаатай. Гэхдээ үүнийг шийдэж болно. Эрэгтэй нь эрэгтэй хүний махыг, эмэгтэй нь эмэгтэй хүний махыг идэхэд яг болно. *(Бүгд инээлдэв.)*

Багш нь та нарт зөвлөхөд хожим гахайн мах бүү ид, жинхэнээр нөхөн төлжүүлбэ гэвэл булшны газар очиж, ижил төрөлтнийхөө махыг идээрэй. Багш нь тоглосон юм. Хэрэв та нар мах идэх үнэхээр дуртай, огиудас тань хүрдэггүй бол идээрэй. Гахайг идэж чадвал хүнийг идэж бас чадна. Хамаг амьтны махыг идэх нь хамаатан саднаа идэж байгаагаас өөрцгүй, юуных нь ялгаа байх вэ? Гахай, үхрийн мах угаас амтгүй тул та нар маш их амтлагч нэмэх хэрэгтэй болдог, тийм биз дээ? *(Тийм гэж хариуцгаах.)* Үнэхээр амттай байдаг бол тийм зүйлийг огт нэмж хэрэглэхгүй байх байсан, шорлогийн махыг шарах шаардлагагүй шууд л түүхийгээр нь идчихмээр юм. Гэтэл амтгүй, бөөлжис цутгам, маш бохир учраас эхлээд угааж, дараа нь олон зүйлийн амтлагч нэмж, хэсэг дэвтээгээд үнэр танарыг нь арилсан хойно иддэг. Ойлгож байна уу? Зөвхөн халуун чинжүү, таван халуун амтлагч, хар перцийн амт л үлдэж, гахайн махны амт нь алга болсон үед нь иддэг. Иймээс “Мах тун амттай.” гэж Багшдаа хэлэх хэрэггүй. Өөрийгөө л хуурч байна. Хэрвээ загас тийм сайхан амттай юм бол яагаад далайгаас бариад л шинэхнээр нь иддэггүй вэ? Гэртээ аваачиж, угааж цэвэрлээд гаднаас нь дотогш нь зүсээд толгой сүүлийг нь тасдахад шоколад шиг хэсэг болж хувирдаг *(Бүгд инээлдэв.)*, та нар загасыг огт олж харахгүй. Маш их давс, таван халуун амтлагч, ногоон сонгино, эсвэл өөр бусад амтлагч нэмж болгоод иддэг. Энэ нь загас идэж байгаа биш, тэдгээр амтлагчийг идэж байгаа хэрэг. Тиймээс Багшдаа, “Загасны мах их амттай.” гэж битгий хэлээрэй. Ямар ч амттай юм байхгүй. Хэрэв амьд загас бариад түүхийгээр нь ид гэвэл та нар идэж огт зүрхлэхгүй, тийм биз? Тахиа, нугас, шувуу ч адилхан,

тэд бүгд маш бохир. Тийм болохоор та нар маш цэвэрхэн болтол нь угааж цэвэрлээд хэдэн цагаар жигнэж, эсвэл чанаж, эсхүл шараад анхны хэлбэрийг нь үгүй болгодог, тэр нь жигнэмэг шиг маш гоё харагддаг. Зарим хүн бас улаан, ногоон гээд маш гоё өнгө нэмдэг болохоор тэдгээрийг зарж болно, тийм биз? Хоолны газар нугас, гахайг улайтал шарахад хүмүүс дуртай. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл эд бүгд огт амтгүй болохыг харуулж байна, ойлгож байна уу? Харин цагаан будааны хувьд гэвэл бид угааж чанаад шууд иднэ. Ингэхэд давс нэмэлгүйгээр амттай байдаг. Зарим хүн шууд л иддэг. Хүнсний ногооны хувьд ч мөн адил. Та нар түүхийгээр нь, бүр давс ч нэмэлгүй идэж болно. Гэвч орчин үед хүнсний ногоог ургуулахдаа дэндүү их пестицид хэрэглэдэг, эсвэл ялгадсаар бордох болсон нь тийм ч цэвэр биш тул чанаж болгох хэрэгтэй. Тиймээс хятад хүмүүс хүнсний ногоог заавал болгож иддэг дадалтай. Үнэндээ бол хүнсний ногоог түүхийгээр нь идэж болох бөгөөд түүхийгээр нь иддэг маш олон хүнсний ногоо бий. Учир нь тэдгээр хүнсний ногоо угаасаа цэвэрхэн, амттай, сайхан үнэртэй, амин дэмээр баялаг. Жимсийг ч хиймэл амтлагч нэмэлгүйгээр шууд идэж болно. *(Багш тэр дороо нэг лийр аваад идэв.)* Үнэхээр амттай. Хэрвээ би нэг бяцхан шувууг барьж аваад ингээд идсэн бол та нарт юу бодогдох вэ? Эсвэл нисэж яваа шувууг харваж унагаад шууд идвэл та нарын дотор муухайрна, тийм биз? *(Тийм гэцгээв.)* Яагаад гэвэл энэ бүхэн бидний хоол биш гэдгийг далд ухамсар мэднэ. Гэвч одоо бид өдийг хүртэл мэхлэгдсэн учраас өөрчлөгдөхгүй байна. Хүн угаасаа ургамал хоолтон гэдгээ мартсан байна. Гэхдээ яг жинхэнээсээ мартсан гэвэл үгүй. Эс бөгөөс амьд амьтныг идэхийг хараад яагаад бөөлжмөөр болдог вэ? Багшийнхаа санааг ойлгож байна уу? Яагаад шувуу идэх нь лийр идэхээс өөр санагддаг вэ? Энэ нь амьтан идэх нь буруу, жимс идэх нь зөв гэдгийг бидний далд ухамсар мэддэг гэсэн үг. Би салатны навчийг түүхийгээр нь идвэл та нарт муухай санагдах уу? *(Үгүй гэж хариулцаав.)* Багшдаа нэг лууван өг дөө гэв. *(Багш лууванг аваад шууд түүхийгээр нь идэв.)* Хэлснээ дор нь хэрэгжүүлнэ ээ. Тэгвэл та нарт өөр санагдана. Хэрвээ би одоо нэг тахиаг амьдаар нь идвэл та нарт сайхан санагдах уу? *(Үгүй гэж хариулцаав.)* Мэдээж муухай, их аймаар, тийм үү? Гэтэл хүмүүс тахиаг угааж цэвэрлээд өдийг нь зулгааж, мөчилж, дүүфүү шиг хэсэг болгон хэрчээд бага зэрэг давс нэмж, халуун ногоотой усанд дөвтээдэг, *(Бүгд инээлдэв.)* тэгээд хоёр, гурван цаг чанаж, өөрийгөө хуураад иддэг. Лууван бол түүхий ногоо ч гэлээ тун амттай. Тэр бол бидний жинхэнэ идэж болох хоол хүнс, идэх ёстой зүйл учраас энэ нь маш танил санагдаж, айж гайхах юмгүй

байдаг. Гэтэл амьтдыг идэхэд тун муухай санагддаг. Муухай гэж мэддэг ч яагаад иддэгээ ойлгодоггүй. Учир нь эцэг, эх маань иддэг, нийгэм, улс даяараа насан туршдаа иддэг, тиймээс бид ч бас иддэг. Хэрвээ та мах идэхгүй бол хүмүүс эвэртэй туулай үзсэн мэт гайхна. Тиймээс олны төлөө идэхээс өөр замгүй. Та нар бүгд “бусдын эрхээр” байгсад болж, өөрийн эрхээр байж чадахгүй байна, ойлгож байна уу?

Юу идэхээ өөрөө тунгаан шийдэхгүй, идэхэд яагаад дотор муухайрдгаа ойлгохгүй, үргэлжлүүлэн идсээр, угаасаа ийм л байх ёстой гэж бодох болж. *(Багш луувангаа нэг хазав.)* Харин ингээд идэж зүрхлэхгүй байгаа нь дарамт шахалтаас болсон хэрэг. Та бүхэн өөрсдийгөө бяцхан чандага болгожээ! *(Бүгд инээлдэв.)* Гэр бүл, найз нөхөд, улс орон, нийгэм, дэлхий ертөнцийн дарамтанд байдаг учраас эрх тааваараа байж чаддаггүй. Эрчүүд та нар өөрсдийгөө Жинхэнэ Их эр хэмээн бүү бод, их юм ер алга! Бяцхан эр нөхөр л болж! *(Инээлдэв.)* Учир нь эхнэр тань ногоон хоол идүүлэх дургүй бол та нар идэж зүрхлэхгүй. Аав, ээж тань мах ид гэвэл та нар иднэ. Нийгмийн дунд найз нөхөдтэйгөө бизнес хийвэл тэд бүгд архи ууж, мах иддэг болохоор мах идэхгүй байж болохгүй.

Учир нь бизнес амь наснаас тань илүү чухал, чөлөөт бодол санаа, хүчтэй бие даасан байдлаас тань илүү чухал болжээ. Ингэж л та бүхэн өөрийгөө гээдэг. Сүнсээ нийгэмд, бизнест худалддаг. Өөрийн биедээ эзэн нь байж чадалгүй, бизнес тань таны эзэн болдог. Өөрөө эзэн нь биш, худалдаа наймаа, бизнесийн найзууд таны эзэн болов. Учир нь та тэдний хэлснийг хийж, тэд таныг хүйтэн цэвдэг мөнгөөр худалдан авч, та харин бүхнийг ОК гэв. Архи уух ОК, мах идэх ОК, хор уух ч ОК болсон байна.

Архи, мах бол хор. Буруу зүйл гэдгийг мэдэрдэг учраас махыг угааж, жижиглэн хэрчиж, жигнэмэг шиг болгоод маш их амтлагч нэмж, хуурч хайраад өнгө, амттай болгон өөрийгөө мэхлээд идэж орхино. Ингэж байгаа нь энэ бүх хүнсийг бид угаасаа идэж болохгүйг харуулж байна. Гэтэл лууванг юу ч нэмэхгүйгээр шууд идэж болно. Цагаан будаа, улаан лооль, жимс жимсгэнэ, ямар ч навчит ногоог бүгдийг нь шууд иднэ.

Ау Лакт нэгэн “Урт уул” гэдэг нэртэй сүрлэг өндөр уул байдаг. Их урт, өмнөдөөс умард хүртэл үргэлжилдэг, бартаа ихтэй, зарим хүн энэ уулын гүнд нуугдан бясалгадаг. Хэдхэн ээлжийн хувцастай. Ууланд газар хагалан хүнсний ногоо тарина. Будаа байхгүй, зөвхөн хүнсний ногоо л идэж амь зууна.

Энэ бол үнэн бодит явдал. Миний анхны Багш ингэж ярьсан юм. Багшийн садан тэр ууланд нуугдан бясалгаж байгаа гэсэн, ганц, хоёрхон хувцастай, давсгүй, будаагүй, бас элдэв амтлагч байхгүй. Ногоогоо чанаад л иднэ. Өдөр бүр ийм байдалтай. Насаараа ингэж амьдардаг. Иддэг юм нь хүнсний ногоо болохоор элдэв юм нэмж хачирлах хэрэггүй, ойлгож байна уу?

Ау Лакт өмнө нь хатуу бясалгал дадуулдаг бясалгагчид олон байсан. Тэд зориуд хатуу бясалгал хийсэн юм биш, өөрийгөө залхаан цээрлүүлж байсан ч юм биш. Нөхцөл байдлаас шалтгаалж, аяндаа тийм болсон аж. Тэд их тааваараа, байгаагаа хэрэглээд л санаа зовох зүйлгүй амьдарна. Тэд хатуу бясалгал хийх гэж өөрсдийгөө хүчлээгүй. Хэрвээ хүчээр хатуу бясалгасан бол юу ч олж хүртэхгүй, зөвхөн “зовлонт бурхан”, эсвэл “дэндүү зовлонт бурхан” л болно. *(Бүгд инээлдэв.)* Хамаг төрөлтний зовлон хангалттай их, гэтэл нэгэн бурхан болоход ингэж их зовж зүдэрдэг бол хэн бурхан болохыг хүсэх вэ? Би л лав зовлонт бурхан болохыг хүсэхгүй, аз жаргалтай бурхан болохыг л хүснэ. Нөхцөл байдалд тулгагдаагүй байж зориуд хатуу бясалгал хийх нь дүр эсгэсэн явдал.

Өнгөн талын зүйлсэд түшиж бясалгавал “өнгөн талын Будда” болно, “дотоодын Будда” болж чадахгүй, Бурхан чанараа олж чадахгүй. Жишээлбэл, танай гэр бүл маш их баян, та бие дааж мөнгө олж амьдрах бүрэн боломжтой, гэрийнхэн тань таны бясалгалд саад учруулахгүй байхад та зориуд маш бага идэж, зориуд турж эцээд харсан хүн: “Үнэхээр агуу мундаг бясалгагч байна.” *(Бүгд инээлдэв.)* гэж бишрээсэй гэж хүсдэг бол эцэст нь юу болж хувирах вэ? “Туранхай Будда”, “Өлсгөлөн Будда”, “Царай муутай Будда” л болно. Ингэж болохгүй!

Тэр хүмүүс хатуу бясалгал хийж байгаа нь нөхцөл байдлаас нь шалтгаалсан байх. Гэхдээ тэд их эрх тааваараа, амьдрал нь хүнд бэрх ч зовиолтой санагддаггүй. Яг л өвгөн хувраг Гуан Чин ууланд бясалгаж байхдаа огт зовуурьгүй байсан шиг, тэрээр зориуд хатуу бясалгал хийгээгүй юм, ойлгож байна уу? Бидний бясалгал тийм хэмжээнд хүрвэл зовлонгийн далайг хэдийнээ гэтэлсэн гэсэн үг.

Тиймээс зовлон ямар ч зовлон шиг санагдахгүй болно. Хэрвээ зориуд өөрийгөө шийтгэвэл сайтар бясалгаж чадахгүй буруу замаар орох нь тодорхой. Жишээ нь, бидэнд ийм сайхан амьдрах газар байсаар байхад би шавь нараа дагуулаад усны сувагт очиж амьдарвал та нарт ямар санагдах вэ? “Энэ хувраг бүр

солиорчээ. Тухтай сайхан газар байсаар байтал заавал усны сувагт очиж амьдрах юм!” гэж бодно, тийм биз? Ингэж явбал бурхан болж чадахгүй, болсон ч “Зовлонтой Будда” болно. “Зовлонтой Будда”-г дагаж бясалгахыг хэн ч хүсэхгүй. Будда баяр жаргалтай байх ёстой.

Юу байна, түүнийгээ хэрэглэх нь эрх чөлөөт хүн. Ямар нэг юм олохын төлөө нөхцөл байдлаа зориуд өөрчилж болохгүй, ингэх нь хээл хахууль болж хувирдаг, ойлгов уу? Энэ нь мөн нэг зүйлийн хар шидийн хүч юм. Учир нь тэр хүн өөрийн “хүсэл”-ээр жам ёсны хүчийг, Эзэн Бурханы хүчийг өөрийгөө сонсохыг албадаж: “Хэрэв намайг бурхан болгож өгөхгүй бол би өлбөрч үхнэ.” хэмээн хүчилж байна. Яг л чихэр өгөхгүй бол гэрийн даалгавраа хийхгүй, эсвэл унтахгүй гэж дэггүйтэх хүүхэд мэт. Бурханд хахууль өгөөд Будда болж чадахгүй. Зарим хүн цагдааг хахуульдахын тулд мөнгө өгдөг. Мөн зарим бясаллагч “би гэх үзэл”-ийн хүчийг ашиглан хурдхан нэгэн бурхан болохын тулд бурхан бодьсадваг хүчилдэг. Энэ нь боломжгүй хэрэг.

Арьяабалын бясалгалын аргыг дадуулах нь бидний хувьд тун энгийн, жам ёсны хэрэг байдаг, тийм биз? Гэр бүлийн хүмүүс тань таныг улам бүр хоол идэх дургүй байгааг мэдрэх болно. Хэрвээ та нар бясалгалаа сайтар дадуулвал хатуу бясалгал хийх ямар ч шаардлагагүй. Жамаараа л юунд ч хүлэгдэхгүй болно, ойлгов уу? Хоол идэх үедээ юу ч мэдрэхгүй, заримдаа амттай санагддаг ч идэх нь улам багасна, унтах нь ч багасаж, эр, эмийн явдал ч бодогдохоо боино. Их бясалгавал хорвоогийн аливаа явдал дэмий санагдаж, юу байгаагаа өмсөж, юу байгаагаа иднэ. Урьдынх шигээ голж шилэхгүй. Энэ дэлхийгээс маргааш ч явахад бэлэн байна, тийм биз дээ?

Бид яагаад энэ дэлхийд тэгтлээ их дурладаг вэ? Энэ дэлхийд биднийг юу ч аз жаргалтай байлгахгүй гэдгийг бид мэддэг шиг санагддаг. Бид ихэвчлэн хань ижилтэй болбол, эсвэл их мөнгөтэй болбол аз жаргалтай болно гэж боддог. Тэгээд тал бүрээр оролддог нь баяр жаргалтай болохын төлөө юм. Шунал тачаал, уур хилэн, мунхаг харанхуй байгаа нь бүгд аз жаргалын төлөө байдаг. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Энэ нь жинхэнэ шунал, хилэн, мунхаг биш. Энэ нь “Нисваанис бол бодь мөн.” гэгчийн утга учир юм.

Яагаад бид эмэгтэйчүүдэд дурладаг вэ? Учир нь эмэгтэй хүнтэй ярилцвал баяр баясгалантай болно гэж боддог. Яагаад бид эрэгтэй хүнд дурладаг вэ? Тэдэнтэй ярилцвал тун таатай,

“Түүнтэй гэрлэвэл амьдрал лавтай өөрчлөгдөж, бүр илүү баяр жаргалтай болно.” гэж боддог. Гэрлээд хоёр, гурван жилийн дараа амьдрал санаснаар нь болохгүй гэдгийг ер боддоггүй. Энэ бүхэн бүгд зүгээр л бусдыг мэхэлсэн өнгөн талын зүйлс юм, ойлгов уу? Гэрлэхээсээ, эсвэл сүй тавихаасаа өмнө найз залуу тань: “Чи минь хилэн хар үстэй, үнэхээр гоо үзэсгэлэнтэй.” гэж магтдаг байснаа гэрлээд гурав, дөрвөн жил өнгөрсний дараа харин “Өнөөдрийн хоол амтгүй байсан. Энэ шөлөнд яагаад үс чинь орчихов? Үнэхээр бохир байна!” гэх зэргээр өөлж суудаг. (Бүгд инээлдэв.) Гэрлэхээсээ өмнө тэр: “Чи минь үнэхээр сайхан, нуман хар хөмсөгтэй, эрвээхэй алаг нүдтэй.” гэхчлэн үргэлж таныг магтана. Гэрлэснээс хэдэн жилийн дараа: “Царайгаа өдөр бүр янзлаад яах юм бэ? Яаж ч янзалсан бахь байдгаараа. (Бүгд инээлдэв.) Царай зүсээ янзлахыг чинь хүлээгээд гарч чадалгүй хоёр цаг гаран боллоо. Чи ер нь гэрээс гарч хувраг болбол таарна.” (Бүгд инээлдэв.) гэнэ. Тэр үед та Багшдаа ирж: “Би гэрээс гармаар байна.” гэж гомдоллон уйлах бүрэн магадлалтай. Тийм хүнийг би ч бас тоохгүй. (Бүгд инээлдэв.) Гадагш гарах үедээ нүүрээ будахад хоёр цаг зарцуулдаг хүн гэрээс гарагч болоход тохиромжгүй. Багшийгаа дагаж гэрээс гарах хүн юу ч хийсэн хурдтай байх хэрэгтэй. Багш нь их адгуу, гарахаар бол тавхан минутанд амжуулна. Амжихгүй хүнийг бясалгалын төвд үлдээдэг, одоо энэ бүр дадал болчихсон. Багш нь гадагш тун хурдан гардаг. Гэвч би нэр алдартай болохоос эмээдэг. Дэндүү их алдар нэртэй болох нь тун ядаргаатай. Бие махбод үүнийг тэсвэрлэхгүй, өдөр бүр лууван, лийр иддэг хүн яаж тийм олон шавь хүлээн авч чадах вэ? Хожим хүч чадалтай болохын тулд мах идэж, архи уух ёстой болж магадгүй. (Бүгд инээлдэв.)

Учир нь та нар бүгд л мах идвэл хүч чадалтай болно, лууван идвэл хүч чадалтай болохгүй гэж ярьдаг, тийм үү? (Бүгд, Үгүй гэж хариулав.) Багш нь та нараар тоглосон юм. За юу! Одоо чөлөөтэй байх тухай ярилцъя. Та нарыг чөлөөтэй байлгах ёстой байтал Багш нь яагаад ногоон хоол ид гэж шаарддаг вэ? Та нар тааваараа байх ёстой байтал яагаад бас мах идэж болохгүй гэх болов? Бид эрх тааваараа байж болно, гэхдээ бусад төрөлтөнд хор хөнөөл учруулах ёсгүй, тэднийг ч бас эрх тааваар нь байлгах хэрэгтэй. Багшийнхаа санааг ойлгов уу? Жишээ нь, тамхичин хүн тамхинд дурлах нь түүний эрх, гэхдээ тамхины утаагаа бусдад хүчээр үнэрлүүлж болохгүй, ойлгов уу? Тиймээс тамхичид бол хувиа хичээсэн хүмүүс.

Мах иддэг хүн ч адил, тэд тун эрх дураараа бөгөөд мах

идэхийг хүсвэл иднэ. Мах идэх нь өөр нэг бусад төрөлтний амь насанд хор хөнөөл учруулдаг гэж боддоггүй. Гэтэл амьтад алагдах үедээ маш их шаналж зовдог. Өөрийн гэсэн үг хэлтэй ч ярьж чадахгүй. Аврах, туслах хүнгүй болохоор зарим амьтан нулимс дуслуулан уйлдаг. Амьтдын махыг идэх нь маш их хувиа хичээсэн явдал. Бид эрх дураараа байх нь буруугүй, гэхдээ бусад төрөлтнийг ч бас эрх тааваар нь байлгах учиртай. Тэд амьдрах хүсэлтэй бол амьдруулах хэрэгтэй, хүчээр толгойг нь тасдаж, махыг нь идэж яаж болох вэ, ойлгож байна уу? Тэд гомдож, эсэргүүцэж, орилж чарлана. Гэтэл бид тэднийг ойлгодоггүй, бас сонсдоггүй. Оронд нь тэднийг, та нар хүний хэлээр ярьсангүй, “тахианы хэл”, “үхрийн хэл”-ээр ярихаар чинь бид яаж ойлгож чадах вэ? Тэгэхээр алж нядлахад асуудалгүй. Формоса хэлээр ярихгүй яасан юм бэ арга алга хэмээн буруушаана. Амьтад хятад хэлээр ярилаа ч тэд сонсохыг хүсэхгүй. Учир нь хүмүүс амьтдыг хороогоод бүр дадчихсан байдаг.

Ийм маягийн чөлөөт байдал нь жинхэнэ чөлөөт байдалтай адилгүй. Чөлөөт байдал гэдэг нь хувиа бодох явдал биш. Чөлөөт байдал гэдэг нь бид өөрсдөө эрх тааваараа байж, юунд ч хүлэгдэхгүй, эсвэл хашигдахгүй, мөн юунд ч хоргодохгүй байх явдал юм. Гэхдээ бусад амьтан төрөлтнийг ч бас эрх тааваар нь байлгаж, амь насыг нь хүчээр хөнөөж болохгүй. Бид тэднийг хүчээр ходоодондоо оруулдаг. Бид үзэсгэлэнтэй сайхан ходоод гэдэстэй байж магадгүй ч амьтад тэнд очих дургүй. Тиймээс тэднийг тэнд хүчээр очуулж болохгүй. Тэд гадаад орчинд амьдрах дуртай, илүү жам ёсны амьдралаар амьдарч, уудам огторгуйгаар дүүлэн нисэж, саруул талаар дураар давхих дуртай. Яг л бид гэрийнхэнтэйгээ хамт зугаацахаар гардаг шиг тэд бас хань ижилтэйгээ, хайрт хүүхдүүдтэйгээ хамтдаа тоглож наадах дуртай. Тиймээс “эрх чөлөө”-тэй гээд мах идэх, ногоон хоол идэх хоёр ялгаагүй гэж ярьж болохгүй, эдгээр нь огт адилгүй.

За! Өнөөдөр нилээд удаан бараг хоёр цаг гаран ярилаа. Асуулт байна уу? Эсэргүүцэж байгаа хүн байна уу? Багшийнх нь ярьсан зүйлс зөв, тийм үү? (*Бүгд, Тийм гэж хариулав.*) Энд “тийм” гэж хариулсан бол хариад яг тэгж хийгээрэй. Өдөр бүр илүү их бясалган сууж, илүү их Аялгуу ажиж, зурагт бага үзэж, өөрийн Уг дүрээ илүүхэн үзээрэй!



МОГОЙН ХОРХОЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайвань, Тайбэй хот. Цаглашгүй гэрэлт бясалгалын төв
1987 оны 6 дугаар сарын 7. (Эх нь хятад хэлээр)*

Өмнөх долоо хоногт үст хорхойн тухай ярьсан, энэ долоо хоногт могойн хорхойн тухай ярих болно. Та нар могой мэднэ, тийм үү? Манай энд нэг могой бий, байнга орж ирдэг. Хэрвээ хаалганы ан цавыг бөглөөгүй бол тэр өдөр бүр орж ирнэ. Биднийг гэрлээ унтрааж, бясалгахаар суухаар л ороод ирнэ, үргэлж нэг иймэрхүү байсан. Харин одоо түүнийг оруулахаа больсон.

Нэгэн өдөр миний Өвөг Багш шавийнхаа хамт ууланд гарч салхилж яваад нэг үхэх дөхсөн могойтой таарчээ, хараахан амь тавиагүй ч биеэс нь үй олон хорхой мөлхөн гарч ирж, махыг нь идэж, нааш цааш гүйлдэж байв гэнэ. Та нар ийм зүйл харж байсан уу? Хараагүй бол төсөөлж болно. Тэр могой мэдээж их зовж, үхэж ч чадахгүй, сэхэж ч чадахгүй байсан бөгөөд биеэс нь бас үй олон хорхой гарч ирж байлаа.

Бурханы шашны сударт бас арслангийн хорхой арслангийн махыг идсэн тухай тэмдэглэсэн байдаг. Үүний утга нь бурхны шашинтнууд, эсвэл Бурханы шашны лам хуврагууд өөрсдөө шашнаа доройтуулна гэсэн санаа. Шагжамуни Будда ирээдүйг тольдоод Дээдийн Ном балрах цөвүүн цагт арслангийн биеэс олон төрлийн арслангийн хорхой гарч ирээд түүнийг хялбархан устгана гэж айлджээ. Учир нь арсланг ямар ч амьтан барьж идэж чадахгүй, зөвхөн дотор нь үржээд гарч ирсэн өт хорхой л түүнийг идэж чадна. Үүнийг дараа, эсвэл өөр нэг өдөр ярья. Одоо түрүүхэн ярьсан могойн хорхойн тухай ярилцъя.

Тэр олон могойн хорхой хаанаас гарч ирэв? Мэдээж могойн биед үржээд гарч ирсэн, тэгээд могойн мах, эсвэл нүдийг нь иддэг болохоор энэ нь нүд халтирам бөгөөд тун их зовж байгаа харагджээ. Энэ байдлыг харсан шавь нь ихэд санаа зовж багшаасаа: “Энэ байдлыг өөрчлөх арга байна уу?” гэж асуухад миний Өвөг Багш түүнд: “Өөрчилж болохгүй, энэ бол тэдний үйл үр. Энэ могой өмнө нь нэг удаа их муу багш, хуурамч төгс гэгээрсэн их багш байжээ. Тэрээр төгс гэгээрсэн их багшийн дүр эсгэн хуурмаглаж, олон хүнийг буруу аргаар бясалгуулж, тэднийг туулан гэтлэх боломжгүй болгосон байна. Өнөөх хуурамч төгс гэгээрсэн их багш нас барсныхаа дараа могой болон төржээ. Харин энэ хорхойнуудын хувьд бол түүний шавь нар нь бөгөөд одоо өшөөгөө авч байгаа. Учир нь тэдний хэн хэн нь туулан гэтэлж чадаагүй. Гэвч шавь нар нь тэднийг туулан гэтэлж чадахгүйд хүргэсэн хуурамч багшийг занан хорсдог тул толгой тархи, мах цусыг нь идэхээр ирсэн байна.” гэжээ. Иймээс бусдад буруу зөрүү зүйл заах юм бол хожмын үр дагавар нь маш аймшигтай байх болно.

Авшиг хүртэх үед Багш нь та нарт байнга “бусдад зааж болохгүй, өөрөө Их Багш болсныхоо дараа л зааж болно, эсвэл Багшийнхаа зөвшөөрлөөр л сургаж болно гэж дахин дахин сануулдгийг та нар бүгд мэднэ. Багш нь бас та нарт: “Би бол Төгс Гэгээрсэн Их Багш биш” гэж дандаа хэлдэг. “Гэгээрсэн” гэдэг нь юу вэ? “Гэгээрсэн” гэхээр юм бас байхгүй! “Багш” гэдэг нь “алдсан” гэсэн үг, учир нь үсээ “алдсан” (үсээ хуссан гэсэн утгатай) учраас “багш” болжээ. (Бүгд инээлдэв.)

Манай Ау Лакт үсээ хусуулсан хүн бүхнийг “багш” гэж хүндэтгэн дуудна, “Өвөг Багш” гэж өндөр настай хувраг хүнийг хэлнэ. Тэнд “багш” гэж нэрлэх нь манай эндхийн “хувраг”, эсвэл “гэлэнмаа” гэдэгтэй ижил. Ау Лакт мөн “гэлэн”, “гэлэнмаа” гэж хэлдэг ч тун ховор, “багш” л гэнэ. “Эх багш” гэдэг нь “гэлэнмаа”-г хэлж байгаа хэрэг, “Эцэг Багш” гэвэл харин “гэлэн”-г хэлнэ, эсвэл товчлоод “багш” гэнэ.

Би Багшийнхаа заавраар л шавь авах болсон. Үнэндээ би дургүй байсан, одоо ч дургүй. Энэ ажлыг хийх дуртай, эсвэл энэ бизнесийг хийж чадах хүн байвал дор нь шилжүүлэх болно, би гэж байнга хэлдэг.

Үнэндээ, Их Багш болох нь тийм ч сайн биш, хүмүүс ирж мөргөхөд Багш их дуртай гэж бодох хэрэггүй, үгүй дээ, жаахан ч дуртай биш. Гэтэл зарим хүн Их Багш болох их дуртай. Үсээ ч

хусаагүй, сурсан эрдэм гэхээр юмгүй байж бусдын Их Багш болох тун дуртай.

Миний шавь гэгдэгч хүмүүсийн дунд ч нилээд хэд бий. Тэд угаасаа ад шүглээд нилээн ноцтой болсон хүмүүс. Багш нь тийм хүмүүсийг сургах хүсэлгүй, гэсэн ч сургахгүй байж болохгүй. Бодьсадвагийн сахилтай, бодьсадвагийн зам мөрөөр замнаж буй хүн ялгаварлах сэтгэлтэй байж болохгүй. Тиймээс Багш нь сургахад огт тэнцэмгүй олон хүнийг шавь болгон сургадгийг та нар үргэлж хардаг. Заримдаа та нар Багшдаа гомдоллож: “Та яагаад ад шүгэлсэн ийм хүнийг сургана вэ? Тэр хүн ер сайн суралцаагүй хэвээрээ байна!” гэдэг. Тухайн үед тэр шавь адад айхтар баригдаад үхэх дөхсөн. Тэгээд Багшаасаа тусламж гуйж ирсэн юм. Адад баригдсан байдал нь жаахан дээрдмэгц буцаж очоод бусдыг сургах гээд явсан. Бусдыг сургах тусмаа тэр улам дордсон доо.

Шавь нарын зарим нь ирээд Багшид нь: “Тэртээ харьсныхаа дараа зарим нэг авшигтан тэр нэг хүнийг дагаж, нэгэн тарни унших болжээ, унших тусам түүний дэс улам доошилж, тун доогуур дэс рүү унасан байна. Тэр уг нь их дээгүүр дэстэй хүн байсан, дээгүүр түвшинд очиж, Багшийгаа болон бодьсадва нарыг хардаг, мөн маш дээд түвшнээр зугаалдаг байсан. Даанч тэр нэгэн тарнийг унших болсноос хойш дэс нь улам доошилж, асурын ертөнц, тамын ертөнц хүртэл унасан гэж би сонссон.” гэв.

Тэр ямар тарни уншсаныг та нар мэдэх үү? Тэр нь Баатараа явагч нэрт их хөлгөн тарни, бас өөр тарниуд байсан. Тэд “Баатараа явагч нэрт их хөлгөн тарни”, “Их гэтэлгэгч тарни”, “Хойдын номын тарни” зэрэг... олон тарнийг заавал унших хэрэгтэй гэдэг. Тарни уг нь зүгээр. Харин түүнийг уламжилсан хүн нь бурууджээ, түүнд ад шүглэсэн учир шавь бологчдоо бас халдаасан байна. Тиймээс унших тусам улам доройтож, дэс нь улам доошилж, улмаар хожим нь хамтдаа тамд унах болно.

Хамаг төрөлтнийг гэтэлгэх нь үнэхээр амаргүй ажил гэдгийг та нарт хэлье. Тэд хэлэхдээ Газрын зүрхэн бодьсадвагийн бясалгалын аргаар бясалгадаг гэсэн, Газрын зүрхэн бодьсадва тамын оронд байдаг болохоор тийм бясалгалын аргыг дадуулбал мэдээж та бүхэн бас тамд очно. (*Бүгд инээлдэв.*) Асуудал нь гэвэл, бид Газрын зүрхэн бодьсадва мөн үү? Газрын зүрхэн бодьсадва бидэнд Дээдийн Ном уламжилсан билүү? Үнэхээр түүний хүч байгаа юу? Тамд хийх ажил бидэнд бий юу?, энэ мэт юм. Хэрвээ бид бясалгаад архадын хутаг, бодьсадвагийн хутаг гэхчлэн ямар

нэгэн хутагийн үрийг олбол тийм хүч бидэнд бүрдэн улмаар там, диваажинд, эсвэл өөр тодорхой нэг ертөнцөд очиж, тодорхой нэг төрөлтнийг аврах тангараг тавьж болно. Мэдээж, бид ингэж чадна. Одоо та нар бясалгаад ямар нэгэн үр дүнд хараахан хүрээгүй байна, гэвч бусдаар хүндлүүлэх дуртай болохоороо энд тэндгүй элдэв зүйл дураараа ярьж, олон хүнийг сургаж явдаг. Иймээс тарни унших тусам дэс нь унаж, үй олон ад чөтгөрт түйвээгдээд буянаа бардаг. Тэгээд буян нь хүрэлцэхгүй болмогц явах тутам өвчинд ээрэгдэнэ.

Нэг өдөр түүний шавь гэгддэг хэдэн хүн Багштай нь уулзахаар ирсэн. Тэднийг хараад би их цочирдсон, учир нь өмнө нь тэд Багштай нь уулзахаар байнга ирдэг байхдаа нүүр царай нь их гэгээтэй, ямар ч асуудалгүй байв. Гэтэл ирж уулзалгүй нилээд удаж, бас өөр хүмүүсийг даган суралцаад их өөрчлөгдсөн байв. Тиймээс би тэднийг хараад үнэхээр их цочирдсон юм.

Одоо тэдний байдал сайжирсан, өөрсдөө ч их айсан бөгөөд алдаа хийснээ ойлгосон, дахиж тэдгээр тарнийг уншиж зүрхлэхгүй болсон, учир нь тэд өөрийн биеэр мэдэрсэн хэрэг. Тэгээд Багшид нь: “Хожим бид хэзээ ч уншихгүй. Багш бол хамгийн дээд нь болохыг одоо мэдлээ. Бид Багшийн бясалгалын аргыг жинхэнэ ёсоор ойлгосон, Арьяабалын бясалгалын арга бол хамгийн дээд бясалгалын арга мөн.” гэсэн. Одоо тэд маш их баяртай байгаа, дахин тийм хүмүүсээс суралцаж зүрхлэхээ больсон.

Тиймээс та бүхэн Мөр ёсыг бүтээхээс өмнө бусдыг сургах хэрэггүй, энэ нь бусдыг хорлохоос цаашгүй. Энэ үнэн шүү. Хэрвээ та бүхэнд бясалгалын үлэмж их ач буян байхгүй, дэс тань их сайн дээшлээгүй бол бусдыг бүү сурга, өөрийгөө ч хорлож, өрөөлд ч хор хөнөөл учруулна. Хэрвээ “би” гэх үзлээр бусдыг сургавал бүр ч дордоно. Хожим тэр хүмүүсийнхээ үйл түйтгэрийг үүрэхээс гадна тэр дүрс үгүй төрөлтнүүдийн үйл түйтгэрийг ч бас давхар үүрнэ.

Гэхдээ тэдний өмнөөс үйл түйтгэрийг нь үүрсэн ч гэсэн тэднийг аварч чадна гэсэн хэрэг биш. Учир нь тэдний үйл түйтгэр дэндүү хүнд болохоор өчүүхэн жаахныг нь үүрээд юу ч болохгүй, тус нэмэргүй бөгөөд өөрийгөө л хорлоно. Зөвхөн их далай л ямар ч буртаг бохирыг угааж чадна. Хэрэв бид зөвхөн ганц, хоёрхон аяга устай бол юухан ч угаах вэ дээ, усаа л бохирдуулахаас өөр ямар ч нэмэргүй. Тэр жаахан бохир усаар юуг ч угааж цэвэрлэж чадахгүй. Тэр байтугай далайн ус ч гэсэн бохир зүйл угааж эхлэх үед бохирддог. Гэвч энэ нь хэсэг хугацаанд л үргэлжилнэ, тэгээд

төд удалгүй урьдынх шигээ цэвэрхэн болно.

Тиймээс Их Багш нарт ч гэсэн хамаг төрөлтний үйл түйтгэрийг үүрэх үед асуудал гардаг, гарахгүй биш. Гэхдээ их удахгүй. Бусдын үйл түйтгэрийг үүрэх нь бусдад ач тустай бөгөөд энэ нь Их Багшид тийм ч том асуудал болохгүй, хэдийгээр жаахан нөлөөлөх ч хүнд хэцүү биш. Харин буян хишиг нь хангалтгүй хүний хувьд өөртөө хүрэлцэх юмгүй байж бусдад тусалбал мэдээж хоёулаа өр төлөөсөнд унана.

Миний Өвөг Багш, миний Их Багш, Дээдэс Багш нар бусдад маш их тусалдаг байсан учраас заримдаа их өвдөг байсныг би мэднэ. Жишээ нь, ямар ч шалтгаангүй ханиана, ямар ч шалтгаангүй хоолой нь, гэдэс нь эвгүйрхэнэ гэх зэрэг. Энэ нь хамаг төрөлтний үйл түйтгэрийг арилгахын төлөө юм. Арилгах явцад мэдээж махан биед нөлөөлнө, ядарч сульдана, эсвэл өвдөж зовно.

Миний Өвөг Багш заримдаа маш хүнд өвдөж, орноосоо босож ч чадахгүй болдог байсан гэж сонссон. Гэвч ном тайлах цаг болоход юу ч болоогүй мэт шууд босоод явдаг. Номоо тайлж дуусаад гэртээ ирэхдээ дахин хэвтэрт ордог байжээ. Тэрээр ингэх хэрэгтэй байсан учраас хэсэг хугацаанд өөрийгөө чөлөөлж, өвчнөөсөө түр зуур салдаг. Номоо тайлж дуусвал харьж, өнөөх зовлонг эдэлнэ.

Энэ нь яг би ном тайлахдаа шар орхимжоо өмсөх хэрэгтэй болдог, дараа нь гэртээ хариад түүнийгээ солиход таатай байдаг шиг юм. Ингэвэл илүү тайвширна, өдөржин орхимжтой явбал тэсэхгүй. Би угаасаа өмсөх дургүй, гэхдээ хааяа өмсөхөд сонирхолтой байдаг, том асуудал биш. Та бүхэн алс хол газраас ирсэн учраас Багш нь хүндэлж, ингэж хувцасладаг. Энэ нь ёс төртэй бөгөөд мөн миний хүндэлсэн сэтгэлийг илэрхийлнэ. Сайхан хувцаслах нь та бүхнийг хүндэлсэн хэрэг, тэрнээс биш биед амрыг бодвол унтлагын хувцас өмссөн ч болно. Хүмүүс ирэх болгонд Багш нь урт орхимж өмсөн тэдэнтэй уулздаг нь миний хүндэлсэн сэтгэлийн илэрхийлэл юм.

Заримдаа тэр өвчин нь хуурамч өвчин байдаг, учир нь Түүний өөрийнх нь өвчин биш, харин өөр хүний шидсэн өвчин цавуугаар наачихсан мэт салахгүй байдаг. Зарим үед Багш нь хэн нэгнийг хараад шууд тавгүйрхдэг, гэтэл зарим хүн Багшийг нь харсан дороо таатай сайхан болдог, учир нь бид хоорондоо харилцан солилцсоноос болсон байна. *(Бүгд инээлдэв.)* Яг л наймаа хийж

байгаа юм шиг, тэр хүн үйл түйтгэрээрээ Багшийнхаа буян хишгийг худалдан авдаг, Багш нь түүний үйл түйтгэрийг авч, Багшийнх нь буян хишгийг тэр хүн авчээ. Багш бол тусгайлан буян хишиг зардаг хүн юм. Танд үйл түйтгэр байвал ирж, эндээс буян хишиг худалдан авч болно. (*Их Багш инээв.*) Тиймээс та нар тэр даруй таатай сайхныг мэдэрдэг, харин Багш нь тэр даруй тавгүй болдог. Гэхдээ хамаагүй, заавал нэг хог цуглуулдаг хүн байх хэрэгтэй.

Манай нийгэмд тусгайлан хог цуглуулах ажилтай хүмүүс байдаг. Орчлон ертөнцөд ч мөн адил, бясалгалын талд ч мөн адил заавал нэг хог цэвэрлэх ажлыг хариуцдаг хүн байх хэрэгтэй. Тэр ч байтугай хоол хийснийхээ дараа бид аяга таваг, хоолны саваа угаах, эсвэл хогоо шүүрдэх ёстой байдаг. Гэхдээ үйл түйтгэрийг цэвэрлэхэд хэсэг хугацаа шаардагдана, тэр дороо цэвэрлэгдэх боломжгүй. Эс бөгөөс шударга бус болно, үйл үр бол үйл үр, ямар ч байсан түүнээс зайлахын аргагүй.

Зарим хүн Багшид нь: “Багшийг харах үед миний өвчин тэр дороо эдгэрсэн, ийм ч өвчин эдгэрсэн, тийм ч өвчин бас эдгэрсэн.” гэхэд нь, Багш нь: “Тийм ээ! Би аль хэдийн мэдэж байгаа. Яриад хэрэггүй, цааш яривал би танд атаархаж магадгүй.” гэдэг. (*Их Багш инээв.*) Заримдаа хэн нэг нь Багшид нь: “Би бясалгаж суухдаа төвлөрч чадахгүй байна.” гэхэд Багш нь: “За! Та одоо дахиад бясалгаж суу даа.” гэвэл тэр хүн төд удалгүй төвлөрдөг. Тэр хүн төвлөрөх үеэр Багшийнх нь сэтгэл харин үймчихнэ. (*Бүгд инээлдэв.*) Тиймээс өнөөх хүн Багшид нь: “Би сая маш сайхан бясалгав.” гэхэд нь Багш нь: “За за! ярих хэрэггүй, үргэлжлүүлэн яривал би танд атаархаж мэднэ. Таныг тухтай сайхан суух үеэр миний сэтгэл “төвлөрөөгүй”, харин ч нэг халууцлаа!” гэсэн. Үнэндээ энэ ч бас зүгээр. Угаасаа тун энгийн явдал.

Бид бохир аяга тавгаа угаах, эсвэл шал арчвал ус их бохир болно, тийм үү? Бид шалаа угаах үедээ ус улам улам бохирдоод байгааг мэддэг. Ус уг нь их цэвэрхэн байсан ч шалны алчуураа дотор нь хийж, байшингийн хамаг бохирыг тэнд бөөгнүүлсэн тул мэдээж маш бохир болно. Гэвч хувинтай бохир усыг урсгал ус руу асгавал өнөөх бохир ус хэсэг хугацааны дараа харагдахгүй болно, тийм биз? Ус асгах үед тэр газар бага зэрэг бохирдох ч удалгүй өмнөх шигээ цэвэрхэн болно. Учир нь их ус бохир зүйлсийг шингээсэн тул удалгүй цэвэршжээ.

Зарим газар бас ийм байдаг. Тэд хогоо далайд асгасан ч далайн ус бохирддоггүй. Дөнгөж асгах үед жаахан бохирддог ч

удалгүй цэвэрхэн болно. Тийм биз? Үүнтэй нэгэн адил нэгэн Их Багш болсон хүн үлэмж их устай байх хэрэгтэй. Бохирдвол өөрөө өөрийгөө цэвэрлэж, төд удалгүй цэв цэвэрхэн болно. Багшийнхаа санааг ойлгов уу? (Бүгд, *Ойлголоо гэж хариулав.*)

Тиймээс та бүхэн Их Багш болох сайхан, ашиг тус ихтэй гэж бүү бодоорой, үнэндээ ямар ч ашиг тусгүй. Гэхдээ ашиггүй байсан ч бид хийх ёстой. Хэрвээ ямар нэг зүйл маш сайн, бид түүнийг хийх их дуртай учраас хийдэг бол яримаар юм юу байх вэ? Жишээ нь, тэр хүн бидэнд тун сайн байдаг болохоор бидэнд тэр их таалагддаг гэвэл, үүнд яримаар юм байна уу? Есүс Христ нэгэнтээ: “Хэрвээ та зөвхөн өөрийн ах, эгч, дүү эсвэл хамаатан саднаа хайрлаж хүндлээд харин дайснаа занан хорсдог бол тантай юу ярих вэ дээ?” гэж хэлжээ. Ийм бол сүнслэг бясалгал дадуулдаггүй хүнээс ялгаагүй биш үү?

Бясалгагч бидний хувьд их нүгэлтэй хүнийг ч аврах хэрэгтэй. Формосад олон жил амьтан алсан, хэдэн арван жил загас барьсан, эсвэл хэдэн арван жил загас, мах зарсан хүн олон байна. Тэд бүгд авшиг хүртэхээр Багшийг нь эрж энд ирдэг. Зарим хүн надад: “Багш аа, тийм хүмүүст авшиг бүү хүртээ, тэд үнэхээр авшиг хүртмээр хүмүүс биш, тэдэнд авшиг хүртээсний дараа тухай бүр Та ядрахын туйлд хүрч амиа алдах дөхдөг.” гэдэг. Хэдийгээр тэдний үйл түйтгэр маш хүнд байдаг ч Багш нь авшиг хүртээдэг хэвээрээ. Зөвхөн тэд харамсан гэмшиж, ажил мэргэжлээ өөрчилдөг л бол болох нь тэр. Учир нь Багшид нь ялгаварлах сэтгэл байж болохгүй.

Формоса харьцангуй жижигхэн учир ажил олоход амаргүй. Амьдралын эрхээр оршин тогтнохын төлөө олон хүн дургүй ажлаа хийхээс өөр аргагүй болдог. Мэдээж хожим нь тэд ихэд харамсан гэмшиж, эсвэл алдаагаа засахаар бясалгал хийнэ. Гэсэн ч үйл түйтгэр нь байсаар байна. Үлэмж их ач буянтай л биш бол: “Би гэмшиж байна, ийм зүйл дахин хэзээ ч хийхгүй.” гэж хэлэхэд л үйл түйтгэр нь цайрчих боломжгүй. Ийм байдлаар үйл түйтгэрийг арилгаж болно гэж боддог, үнэндээ тийм амархан биш, бохир буртагийг заавал усаар угааж байж л сая цэвэршинэ. Тийм учраас Их Багш болоход хамаг төрөлтний үйл түйтгэрийг арилгаж чадах чадвартай байх ёстой. Эс бөгөөс тэдэнд Авид Бурханы тарни уншихыг заахад л болно. Дэндүү хэтрүүлж, бусдад ямар нэгэн юм заах гэх хэрэггүй.

Миний дөнгөж сая ярьсан хүн бас Багшийг нь дуурайн бусдаар өөрийн нүд рүү харуулдаг гэнэ. (Бүгд *инээлдэв.*) Хэн

болохыг нь та нар аль хэдийн мэдэж байгаа болохоор дахин яриад яахав. Багш нь Германд очих үеэр түүний нөхцөл байдал нь бүр ч дордож, бараг амиа алдах шахсан. Тэрээр өдөр бүр Багшийнхаа дууны хуурцгийг биедээ авч, алхаж явахдаа ч, унтаж байхдаа ч сонсож, тэр хуурцгаас чанга зууран салж зүрхлэхгүй байжээ. Тэр амиа алдах гэж байсан, учир нь тэр үед түүн дээр дэндүү олон ад чөтгөр ирсэн байна. Тэр өмнө нь маш олон тийм төрөлтнийг гэтэлгэсэн байжээ.

Авшиг хүртэснийх нь дараа би түүнд дахиж гэтэлгэх зан үйл бүү хийгээрэй гэж захисан. Гэвч тэр үг сонсохгүй байсаар эцэст нь ад чөтгөрт баригдсан. Сүүлд нь тэр өөрөө ч айж, гэтэлгэж зүрхлэхээ больсон юм. Хаана ч явсан бай Багшийнхаа дууны хуурцгаас салахгүй, Багшийнхаа зургийг хаа сайгүй өрж тавиад Герман луу утсаар ярьж, Багштайгаа заавал очиж уулзана гэв. Учир нь тэр амиа алдаж ч магадгүй байсан юм. Хичнээн их мөнгө зарсан ч хамаагүй, ямар ч асуудал гарсан хамаагүй, төвөг саад юу ч тохиолдсон үл тоон заавал Багштай уулзана гэсэн. Тэр үнэхээр тэсэхийн аргагүй болжээ. Гэсэн ч би түүнд: “Германд ирээд хэрэггүй ээ, миний байгаа энэ сүмд ганц л эмэгтэй хүн байна. Хэрвээ та ирж суувал тохиромжгүй. Би хэд хоногоос Формоса руу буцна” гэв. Учир нь тэр эрэгтэй хүн болохоор би түүнийг ирээд хэрэггүй гэсэн юм.

Ингээд эцэст нь тэр амьд үлдсэн, Багштайгаа утсаар ярьсны дараа тэр даруй сайжирсан гэнэ. Багшийг нь Формосад очсоны дараа тэрээр Багшийнх нь дэргэд хэсэг хугацаанд суралцан тэнхэрч, дахин сэргэсэн. Гэтэл тэр Багшдаа жаахан соригдмогц даруй салж одсон. Бидний бясалгал бүгд л энэ “би гэх үзэл”-ийн саад тогтороос болж дэвшиж чаддаггүй.

Тэр одоо ч хэвээрээ, элдэв дэмий зүйл бусдад заасаар л байгаа. Заах тусмаа улам дордож, хав харанхуй тамын орныг л харах болсон, өчүүхэн ч сайн сайхан зүйлгүй. Тэр одоо бас наашаа ирж магадгүй сурагтай байна, гэвч Би түүнийг хүлээж авахгүй. Учир нь би үнэндээ маш их ядарсан. Ийм төвөгтэй хүнийг “өөрийнх нь Их Багш”-аар харж хандуулсан нь дээр.

Газрын зүрхэн бодьсатва бол тамын орны төрөлтнүүдийг харж харгалзаж байдаг. Энэ бол Түүний ажил. Тэрээр тэнд амьдарч, тусгайлан тамын төрөлтнүүдийг сургадаг. Одоо бид хүний ертөнцөд амьдарч, арай тамд очоогүй болохоор түүнийг бясалгах хэрэг юун? Тамын орны ажлыг хийх хүн бий. Бид эндээс тэнд хүртэл доош унаж, бусдыг сургах шаардлагагүй, учир нь

бидний буян хүрэлцэхгүй болохоор үүнийг хийж болохгүй.

Баатараа явагч нэрт их хөлгөн тарнийн хувьд ч мөн адил. Гэрээс гараагүй хүн энэ тарнийг уншихгүй байсан нь дээр. Уншвал маш олон бэрхшээл тулгарна. Тэр ч байтугай гэрээс гарсан хувраг хүн уншихад ч асуудал үүсдэг. Гэрээс гарагчдын бие, хэл, сэтгэл гэрээс гараагүй хүнийхийг бодвол илүү цэвэр ариун байдаг. Тэд энэ дэлхийг аль хэдийнээ бүрэн огоорсон учраас тэдэнд ядаж л энэ талын ач буян байдаг. Үүнээс гадна тэднийг лус тэргүүтэй найман аймгийн номын сахиуснууд хамгаалж байдаг. Яагаад гэвэл тэд Мөр ёсыг (гэгээрлийг) олохын төлөө жинхэнэ чин үнэнчээр зорьсон хүмүүс учраас уншсан ч асуудал харьцангуй багатай байна. Тэд бурхны өмнөөс уншдаг бөгөөд “Би гэх үзэл”-ээр бусдыг гэтэлгээгүй. Хэрвээ түүнд “Би хамаг төрөлтнийг гэтэлгэв” гэсэн бодол байх аваас төвөг саад мөн адил их байх болно. Гэтэл гэрээс гараагүй хүн олигтой сайн бясалгаагүй мөртлөө бусдыг сургаж, бусдыг гэтэлгэнэ гэх нь сонсоход үнэхээр сэтгэл өвдмөөр. Энэ бүхэн бүгд “би гэх үзэл”-ийн уршиг юм.

Формосад ийм хүн маш олон, тиймээс бүгд мэдрэл нь муудчихжээ. Тэр хүмүүс Багшийнх нь энд ирэх үедээ тархи толгой нь хэдийнээ бүр эргүүтээд аврахад маш хүнд болсон байв. Тэд бас бусад хүнд нөлөөлж, орчны уур амьсгалыг бүхэлд нь тун таагүй муухай болгодог. Тэр ч бүү хэл Формоса даяараа тэрхүү ад чөтгөр болон сөрөг муу талын нөлөөнд автана. Тиймээс энэ дэлхийд ирж хүмүүсийг сургана гэдэг үнэхээр амаргүй ажил, саад бэрхшээл их.

Багш нь хаана ч очиж ном айлдсан бай тэр даруй асуудал үүсдэг. Асуудалгүй шинэ газар бараг байгаагүй. Тайбэйд очсон ч асуудалтай, Пэнхү, Тайнан гээд хаана очсон ч адилхан асуудал үүсдэг. Олон хүн ирж ном сонсвол шууд асуудал үүснэ. Хүн цөөн үед гайгүй.

Энэ нь ад чөтгөр тэсэж тэвчихгүй болдогтой холбоотой. Тэдний орд харш ганхаж, эвдрэн сүйрч, амьдрах газаргүй болсон тул ихэд бачимдан сандарч, буян хишиг муутай, эсвэл зүрх сэтгэл нь хангалттай цэвэр ариун бус хүмүүсийг ашиглан Багшийнх нь ажлыг үймүүлж, Багшийнх нь номын ёсыг төөрөгдүүлж, сургаал номыг бусниулдаг. Гэхдээ тийм ч амархан байхгүй. Формосад бясалгадаг хүн олон, хангалттай ариун сэтгэлтэй, цэвэр ариун хүн маш олон байгаа цагт тэд эвдэн сүйтгэж чадахгүй юм.

Учир нь нэг хүн бясалгахад хэдэн зуу, хэдэн мянган хүнд ач

тустай байдаг. Одоо Формоса хорин сая хүнтэй. Нэг хүн мянган хүнд тустай гэж тооцвол хорин мянган хүн авшиг авах хэрэгтэй байна. Тиймээс та бүхэн сайтар хичээн ажиллаж, гэртээ хариад сонинд зар сурталчилгаа тавих хэрэгтэй. *(Бүгд инээлдэв.)* Одоо бидэнд арван есөн мянга гаруй хүн хэрэгтэй байна шүү. *(Бүгд инээлдэв.)* Хорин мянгуулаа болчихвол Багш нь дахин шавь авахаа болино. *(Бүгд инээлдэв.)*

Миний Багш: “Хэрвээ нэг хүн зургаан сар тутамд хоёр хүнийг дагуулж ирээд авшиг авхуулвал арав, эсвэл хорин жилийн дараа дэлхий даяараа авшиг хүртсэн байх болно.” гэж хэлсэн юм. Учир нь авшигтны тоо байнга өсөн нэмэгдэх болно!

Хэрвээ нэг хүн хоёр хүн авч ирвэл тэр хоёр хүн нь тус бүртээ хоёр хүн авч ирэх бөгөөд хоёрын зэргээр үргэлжлэн өснө. Ингэж авшиг хүртэхээр ирсэн хүн бүр хоёр хүн дагуулж ирвэл мэдээж эцэст нь бүгд авшиг хүртэнэ. Зургаан сар тутам хоёр хүн, гурван сар тутам нэг хүн байхад болно. Та нар хариад гурван сард хэдэн хүнтэй ирж болохыг туршиж үзээрэй. Энэ ажлыг бүгдээрээ “алгуур алгуурхан” мөртлөө “хурдан түргэн” хийцгээе. *(Бүгд инээлдэв.)*, учир нь одоо цөвүүн цаг учир цаг хугацаа нэн шахамдуу байна.

Энэ арал тун жижиг, газрын зураг дээр харвал үнэхээр маш жижигхэн. Би заримдаа яагаад ийм жижигхэн газар ийм хөөр хөгжөөн ихтэй, явдал учир арвинтай байдаг юм бол гэж гайхдаг. Энэ нь маш жижиг ч гэсэн амьдрал өрнөж, зарим хүн ном айлдаж, зарим нь амьтан барьж аван идэж, зарим нь асар том сүм барьж, ер олон зүйл хийх ажээ.

Дэлхийн газрын зургаас харахад Формоса бараг харагдахгүй. Хэдийгээр харагдахааргүй жижигхэн ч “би гэх үзэл” нь харин асар том, тэр ч байтугай энэ арлаасаа ч том. “Би гэх үзэл”-гүй хүнийг энд би тун цөөн харсан. Энэ асар том “би гэх үзэл”-ээс болж сургахад тун бэрх байна. Түүнээс гадна хэт туйлширсан сургаал номлол ихтэй. Жишээ нь, юуг ч бясалгах шаардлагагүй, бүх зүйл хоосон, бүхнийг огоороход л хангалттай гэгцгээнэ. Юуг огоорох ёстой гэж? Хэрэв хэдийнээ хов хоосон болчихсон юм бол огоорох юм байх уу? Бясалгаад хов хоосон болсон бол юунд маани тарни уншина вэ? Бусдад ямар нэгэн юм зааж сургана гэж юунд явна вэ? Ийм олон сүм хийд барихын хэрэг байна уу? Бүх зүйл хов хоосон болчихсон бус уу!

Том сүм хийд барьдаг хүмүүс “хов хоосон” гэж бүр их

ярьдаг. “Бүхнийг огоорох хэрэгтэй.” гэдэг хүн л илүү олон том сүм хийд барьдаг. (*Бүгд инээлдэв.*) Бүхнийг огоорох хэрэгтэй гэдэг хүн улам олон шавьтай болохыг хүсдэг бөгөөд сүмдээ олон хүн ирүүлэх дуртай. Өөрийг нь шүтэн дагасан шавь өөр Их Багш дээр очсоныг сонсвол тэр дороо тэвчихгүй болж, хөлөө дэвслэн хүүхэд мэт аашилж, “Би хүсэхгүй байна! Чи ингэж болохгүй. Чи намайг дагаад олон арван жил болсон байж яагаад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном тайлахыг очиж сонссоор байна вэ? Яагаад Түүнээс авшиг хүртэнэ вэ?” гэх мэтээр өдрийн турш бөөн уйлаан майлаан болно. Түүний ярьдаг “хов хоосон” нь нэг иймэрхүү.

Би тэр номын багштай уулзвал биеэ сайн бодоорой л гэж хэлдэг. Тэр их туранхай, бие муутай. Тэр харин надад: “Тэрээс гарсан хүн мөнх бус зүйл болох махан бие зэргийг үл тооно. Өвдвөл тэр л биз, эрүүл саруул болбол бас тэр л биз, “сэтгэл хаана ч үл оршино” гэж хэлэв. Гэтэл шавь нь авшиг хүртэхээр энд ирвэл болохгүй болж, бөөн хэл ам дагуулж, асуудал гарна. Тэр үед өнөөх “хов хоосон” нь “дүв дүүрэн” болчихно, “үл хүлэгдэнэ” гэдэг нь “хүлэгдэнэ” болж хувирна. (*Бүгд инээлдэв.*) Өдөржин орилж хашгирч, хэрүүл тэмцэл хийгээд шавь нараа ч залхааж, өөрөө ч тэсэхээ болино.

Тиймээс энэ бүхнийг ярихаас цаашгүй, зүрх сэтгэлээрээ хийж чаддаггүй. “Аливаа бүхэн хов хоосон, сэтгэл хаана ч үл оршино.” гэж бусдын хэлэхийг сонсоод дуурайж ярьж сурдаг. Энэ нь зүгээр л “Очир огтлогч судар”-ыг давтаж, амаараа л ярьж байгаа хэрэг. Өөрөө огт бясалгасан юмгүй. Түүнийг ам нээмэгц ямархуу дэстэй хүн болохыг нь хүмүүс дорхноо мэдчихнэ. Хэрвээ “юунд ч эс оршдог” гэж хэлэх юм бол гэрээс гарсан хүмүүсийг эрх дураар нь байлгавал зохино. Шавь нар нь өөр газар очиж ном сурахад яагаад тэр өдөржин уйлна вэ? Яагаад шавь нартаа болон бусад хүмүүст ийм олон бэрхшээл, асуудал учруулдаг вэ? Тэгэхээр энэ бүхэн нь бүгд амаараа л ярих төдий байж, үнэн хэрэгтээ өөрөө хэрэгжүүлж чаддаггүй хэрэг.

Тиймээс хамгийн сайн нь бусдыг сургахгүй байх явдал юм. Их Багшийн дэсэд хүрээгүй хүн л шавьд их шунадаг, Их Багш болсны дараа тэр байдал үгүй болно. Сургах шаардлагатай бол сургана, шаардлагагүй бол эс сургана.

Би угаас хүн сургах дургүй. Гэвч энэ нь хийх ёстой зүйл учраас “дуртай”, эсвэл “дургүй” гэх юмгүй. Гэвч Багш нь адад баригдсан тэр хэдэн шавийг нилээд олон удаа сургасан ч тэд үг сонсохгүй хэвээр байдаг тул би их ядарсан. Сургаж болохгүй

бол одоо яахав дээ, энэрэх сэтгэлд ч бас хязгаар бий. Зарим үед хичээлээ өөрөө сурах нь зүйтэй.

Бурхан, бодьсадва нар бусдын үйлийн үрд хөндлөнгөөс оролцдоггүй. Бусдыг гэтэлгэх ном уншиж, эсвэл Баатарая явагч нэрт их хөлгөн тарнийг уншиж байгаа нь бусдын үйлийн үрд хөндлөнгөөс оролцож байгаа явдал юм. Учир нь ад чөтгөр танаас ирж гуйгаагүй, миний өмнөөс бусдыг гэтэлгээрэй гээгүй. Та өөрөө л төвөг саадыг бий болгож, бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцжээ.

Жишээ нь, та лам хувраг бол хүмүүс таныг ном уншуулахаар урьж залбал очиж уншина. Хэрвээ та үүнийг ёс уламжлалын дагуу хийж, ном унших нь ламын ажил гэж боддог бол энэ нь зүгээр байна. Харин тодорхой бус зорилгоор хийвэл өөртөө төвөг удна, тэр ч байтугай тамд унана. Хэрвээ мөнгөний төлөө ном уншвал маш хүнд үйл түйтгэр хураах болно. Хэрвээ бидний хийж үйлдэж буй бүхэн бусдыг зовлонгоос аварч, ач тус хүргэхийн төлөө, хамаг төрөлтнийг тайтгаруулахын төлөө бол буян хишигтэй байна. Харин буян хураахыг санаархаж хийвэл ямар ч буян хураахгүй, хураасан ч тун хязгаартай.

Бид юу хийсэн ч “би үгүй” төлвөөр хийхийг хичээх хэрэгтэй. Гэхдээ энэ их хэцүү. Учир нь бид өөрийгөө хэдийнээ “би үгүй” гэж боддог ч үнэндээ бол “бодох” төдийхөн байж, бодит байдал дээр тийм биш байдаг. Хэзээ нэг өдөр та нар тун ая зөнгөөрөө болж, юу ч хийгээгүй байтал уулзсан хүний өвчин тэр дороо эдгэрнэ, эсвэл билиг нь даруй нээгдэнэ, гэтэл та юу ч хийгээгүй байдаг. Тэр үед сая жинхэнэ “би үгүй” болно.

Одоо бол та нар зүгээр л “Би, би үгүй болсон гэж бодож байна.” гэдэг төлөвт байсаар байгаа тул үүнийг би биш Багш хийсэн, “би” бардамнаж болохгүй. Гэхдээ Багш надаас үүнийг хийхийг хүссэн, энэ нь “би” бол сайн хүн, “би” тун дажгүй хүн хэвээр байна гэсэн үг!” гэхчлэн бодно.

Маш нарийн түвшний “Би гэх үзэл” бас жаахан байсаар байна. Учир нь “би бодож байна” гэдэг нь хэвээрээ байна, тийм үү?

Бодох нь өөрийн биеэр үзэж туулахтай адилгүй, итгэх нь ахуй ойлголт харахаас өөр. Та нар дөнгөж эхэлж бясалгаж эхэлж байгаа болохоор Багш нь та нарыг алгуурхан сургана. Эхлээд энэ “би”-г огоорно. Юу ч хийсэн бай үүнийг “би” хийсэн гэж боддоггүй болгоно. Оюун ухааныг алгуурхан дадуулна. Гэхдээ энэ нь

жинхэнэ “би үгүй” болсон төлөв биш. Учир нь “би хийгээгүй.” гэдгийг та нар мөн л дадуулах хэрэгтэй, бас “үүнийг би хийсэн биш.” гэж бодох хэрэгтэй. Мөн “би үүнийг хийхгүй.” гэх бодол нь хэвээрээ байна.

Жинхэнэ “би үгүй” төлөв бол бодьсadgeгийн түвшин. Тэр юу ч хийдэггүй, гэсэн ч хүмүүс аяндаа л ач тус хүртэнэ. Багштай ирж уулзаад өвчнөө эдгээв гэж ярихыг та нар олонтаа сонсдог. Энэ нь Багш нь ямар нэг шид үзүүлж байгаа хэрэг биш. Хэрвээ та нар шид үзүүлж байна гэж хэлэх юм бол Багшийгаа гүтгэж байгаа хэрэг. Би юу ч хийгээгүй.

Энэ нь яг л ус шиг, хэрэв та ууя гэвэл шууд л ууна. Харин ус өөрөө зориуд ус бий болгон танд уулгаж байгаа биш. Бас энэ нь ус учраас өөрийгөө зориудаар танд уулгах ч гээгүй. Галын хувьд ч мөн адил. Та даараад галд ойртвол тун таатай болно. Харин гал танд зориудаар таатай мэдрэмж төрүүлээгүй. Тэр бол гал, ойртвол дулаацна. Тэр зориудаар дулаацуулаагүй. Түүнд зориудаар гэсэн санаа байхгүй. Нар би ийм сайхан гэрэлтэж байна гэж боддоггүй. Тэр таныг зориудаар халууцуулахгүй, зориудаар юу ч хийдэггүй. Зүгээр өөрийнхөө ажлаа л хийдэг. Яг л ийм байдаг. Бид ч гэсэн энэ дэсэд хүрч чадвал жинхэнээр “би үгүй” болно.

“Би үгүй”-н олон дэс байдаг. Эхэндээ бяцхан “би үгүй” байдаг. Бясалгах тусам улам сайжирч, улам дээшилж, улам өргөжин тэлнэ. Хожим ямар ч төрөлтөн ач тус хүртэх боломжтой. Тэр үед таны дэс Гурван ертөнцийг давсан байх бөгөөд зөвхөн Тавдугаар ертөнцөд хүрч байж л бусдыг сургаж болно. Эс бөгөөс өөртөө ч, өрөөлд ч төвөг болохоос цаашгүй юм.

Хэрэв бид тодорхой нэг газарт очин хүмүүсийг адисална, тодорхой нэг газарт очин бусдын өвчнийг эдгээнэ гэж боддог, мөн бид бусдын өвчнийг эдгээх дуртай хэвээр байвал энэ “би” оршсоор байгаа хэрэг. Хэдийгээр та нар Багш нь Дээдийн Ном уламжилж байхыг хардаг ч үнэн хэрэгтээ би ямар ч ном уламжлаагүй. “Уламжлах ном гэж байхгүй.” гэж Багш нь байнга ярьдаг ч Их Багш байхгүй бол Дээдийн Ном байхгүй. Ийм л байдаг.

Энэ Дээдийн Ном жамаараа л гарч ирдэг. Хэрвээ та бүхэн ач тусыг мэдэрч байвал тэр ч бас аяндаа л болсон байна. Багш нь зориудаар юу ч хийгээгүй. Хэрвээ та Багш дээрээ ирээд: “Би одоо хүнд нөхцөл байдалд байна!” гэж хэлбэл би таныг яасан ч “улам их зовоосой” гэж ерөөхгүй. Ингэх боломжгүй.

Мэдээж би та нарт аз жаргалыг л ерөөнө. Ерөөлийн тийм

сэтгэл надад бас бий. Яагаад гэвэл та нар их өрөвдөлтэй харагддаг. Та бүхэн аз жаргалтай байвал би ч бас маш их баяртай байх болно. Хэдийгээр тийм сэтгэлтэй байдаг ч та нарын амьдралыг илүү сайхан болгохын тулд би зориуд ямар нэг шид хэрэглэхгүй. Тийм зүйл байхгүй. Энэ бол зүгээр л энэрэн нигүүлсэх сэтгэл болохоос ид шид биш. Бусдын зовж буйг харах үедээ би тэдэнтэй яг ижилхэн зовдог. Энэ “ижилхэн зовох” мэдрэмжээс болж би түүний зовлонг амсаж, түүнд бага ч гэсэн буян хишиг өгөх болно. Энэ нь “жамаараа нигүүлсэх сэтгэл”-ээс (Ийм нигүүлсэх сэтгэл нь хүн төрөлхтний хайр сэтгэлээс ялгаатай) үүссэн болохоор бусдад ач тустай байж чаддаг.

Гэхдээ зөвхөн хүч чадалтай байж гэмээнэ л ач тустай байж чадна. Хүч чадалгүй бол бүр нигүүлсэнгүй сэтгэлтэй байсан ч ямар ч нэмэргүй. Хэрвээ та мөнгөгүй бол хэн нэгэн тан дээр ирээд, “Би өлсөж үхэх нь ээ!” гэвэл танд хоол байхгүй болохоор хэдийгээр түүнийг өрөвдөвч юу ч өгч чадахгүй. Харин мөнгөтэй бол өгч чадна. Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүн юуг ч онцгойлон бодох шаардлагагүй, хэрэгцээтэй хүн нь аяндаа л ач тус хүртэнэ. Хүртэхгүй гэсэн ч хүртэнэ.

Энэ нь мөнгөнөөс өөр. Та мөнгөө авдарт цоожилж болно, цүнхэндээ, эсвэл банкинд хадгалбал хэн ч түүнд хүрч чадахгүй. Харин бясалгалын буян бол үүнтэй адилгүй. Та ирвэл шууд хүртэх бөгөөд танд сайнаар нөлөөлнө. Та юу ч ярих хэрэггүй, мөн таныг авахгүй гэсэн ч өгнө. Та авах нь мэдээж. Тэр танд тустай, тиймээс авахгүй байж яаж болох вэ? Гэхдээ та “авах уу, эсвэл болих уу” гэж бодох ч шаардлагагүй, ач тус өөрөө аяндаа ирнэ. Харин их хүнд үйл түйтгэртэй хүн өөрөө буян хишгийг оруулахгүй хаачихдаг. Тийм хүн ямар ч ач тус хүртэхгүй нь аргагүй. Тийм биш бол хүн бүхэн юу хүссэнээ хүртэж чадна.

Хэрэв та нар одоо хариад “Очир огтлогч судар”-ыг уншвал илүү сайн ойлгоно. Хамаг төрөлтнийг гэтэлгэнэ, гэхдээ гэтэлгэгдсэн төрөлтөн үгүй. Өглөг өгөх боловч өглөг өгөхгүй, энэ бол жинхэнэ өглөг мөн. Өвчнийг эдгээх боловч “өвчнийг эдгээхгүй” энэ нь жинхэнэ өвчин эдгээх юм. Өвчин эдгээх нь зөвхөн энэ махан биеийн өвчнийг эмчлэх биш юм, “мунхагийн өвчин”-ийг эмчлэх нь хамгийн сайн эмчилгээ мөн.

Тиймээс бид Шагжамуни Буддаг их манлай оточ хэмээн магтан сайшаадаг. Учир нь Тэрээр өвчин бүхнээс аварна, гэхдээ ямар ч шид хэрэглэхгүй. Тэр өөрөө ид шид. Тэр ид шид болон хувирсан бөгөөд хүн бүхэн хүссэн бүхнээ авч чаддаг. Энэ нь цаглашгүй их ач

буян болон буян хишигтэй гэсэн санаа юм. Түүнд бүхий л ач буян болон буян хишиг бий, хэмжишгүй, хязгааргүй, хэрэглээд баршгүй их. Ингэж тэнгэр хийгээд хүмүүн төрөлтний Их Багш болно.

Судар номд бас сайн багш, мэргэн гэгээнтнүүд, сайн хамтран бясалгагчдыг сонгож хамт бай, мал бойлогч яргачин, амьтны амь хөнөөгч хүнтэй бүү нөхөрлө гэжээ. Тийм биш үү? Гэхдээ бурхан бодьсатва харин ийм хүмүүстэй нөхөрлөнө. Тиймээс та бүхэн: “Яагаад та ийм хүмүүст авшиг хүртээнэ вэ?” гэж Багшаасаа бүү асуу.

Даяаны бүлгийн “Арван үхрийн зураг”-ийн хамгийн сүүлийн зурагт: “Мал бойлогч, эсвэл хулгай хийгч хүн бол миний найз.” гэсэн өгүүлэмж бий. Учир нь тэр үед түүнд алагчлах сэтгэл үгүй, сайн муу гэх ялгалгүй болж, түүний ач буян барагдашгүй их болсон тул түүнээс гуйхаар ирсэн хэнд ч өгч чадна. Танд таван зуун юань хэрэгтэй бол таван зууг өгнө, таван мянга хэрэгтэй бол таван мянгыг өгнө, тавин мянга хэрэгтэй бол тавин мянгыг өгнө. Танд хэр их хэрэгтэй байна, тэр хэрээр өгнө, учир нь тэр энэ бүгдээ хэрэглэж барахгүй, мөн тэр таны хэр их хэрэглэхийг үл тооно.

Есүс Христ ч мөн адил. Тэр нэгэн удаа нэг биеэ үнэлэгч хүүхнийг шавиа болгон хүлээн авчээ. Үүнд бусад шавь нь маш их дургүйцэж, сүсэгтнүүд нь ч маш их уурлаж, Есүс Христийг буруутган: “Та яаж ийм хүнийг өөрийн шавь болгон хүлээн авч, ийм хүнийг бидний хамтран бясалгагч болохыг нь зөвшөөрч байна вэ?” гэж хэлжээ. Тэд өөрсдийгөө сүрхий сайн хүмүүс, тиймээс Есүс Христ биднийг шавиа болгосон гэж их л омог бардам байж, өөрсдийгөө агуу гэж боддог байсан ажээ. Гэтэл одоо энэ биеэ үнэлэгч хүртэл Есүс Христийн шавь болж чадаж байна. Энэ үнэхээр аймшигтай. Хожим нь тэд гадагш гарч: “Би шилдэг нь, миний Их Багш ч шилдэг. Манай бүлэг хамгийн ариун гэгээнтнүүдээр дүүрэн.” гэж бардамнах аргагүй болж гэнэ. Учир нь одоо бүхэл бүтэн бүлэгт нь нэг биеэ үнэлэгч эмэгтэй багтсан тул бүгд Есүс Христэд гомдоллов. *(Шагжамуни Будда ч мөн биеэ үнэлэгч бүсгүй Модэнжааг шавиа болгосон.)*

Есүс Христ: “Хэрвээ таны үйл түйтгэр таван зуун килограмм жинтэй бол би өршөөнө. Бусад хүнийх таван мянган кг жинтэй бол би бас л өршөөнө. Энэ бүхэн танд хамаатай гэж үү?” гэж хэлжээ. Жишээлбэл, би танд таван зуун юань өгөөд түүнд таван мянган юань өгөхөд бүгд сэтгэл хангалуун байвал бүх юм зүгээр. Жишээ нь, хэрэв та надад таван зуун юанийн өртэй

бол би танаас хожим төлөхийг шаардахгүй, таныг уучлахад бэлэн байна. Хэрэв тэр надад таван мянган юанийн өртэй бол би бас л түүнийг уучлахад бэлэн байх бөгөөд түүнийг буцааж төлөхийг шаардахгүй. Энэ нь танд ямар хамаатай билээ? Энэ мөнгө бүгд минийх, би таны хүссэн хэмжээгээр өгөх болно.

Дахин нэг жишээ авъя, та бол тэрбумтан. Энэ хүн танд хоёр зуун юанийн өртэй, тэр хүн танд хоёр мянган юанийн өртэй, өөр нэг хүн танд хоёр сая юанийн өртэй. Нэг өдөр та тэдний өрийг бүгдийг нь цайруулахаар шийджээ. Тэд өрөө төлөх чадваргүйг та мэдсэн байна. Тэгээд: “За за! Бүгдийг мартацгаа! Та нарын бүх өрийн бичгийг урж хаялаа!” гэжээ. Та одоо ч их мөнгөтэй хэвээрээ байна. Хоёр зуун юанийн өртэй хүн, хоёр сая юанийн өртэй нөгөө хүндээ атаархах хэрэггүй. Учир нь энэ бүх мөнгө тэдний мөнгө биш, баян хүний мөнгө.

Үүний нэгэн адил, Шагжамуни Будда ч энэ дэлхийд заларч байхдаа маш хүнд үйлийн үртэй хүмүүсийг гэтэлгэж байсан. Хэдийнээ ерэн есөн хүн алаад хамгийн сүүлд Бурхан Буддаг хөнөөж, зуу болгохыг санаархсан хүн ч байсан. Багш нь түүнийг үдээс өмнө нэг зуун хүний амийг хөнөөвөл Будда болж чадна гэж сургажээ. Хүн алаад Будда болно гэж сургадаг багш бас байдаг байх нь. Тэр хүн багшийнхаа хэлэхийг сонсоод үд болох дөхсөн ч зуу дахь хүнээ олоогүй тул ихэд санаа нь зовжээ. Тэгээд Бурхан Буддаг хараад даруй хөнөөхийг завдсан ч Бурхан Багш энэ тохиоллыг ашиглан түүнийг аварсан юм.

Бид үнэндээ хүний амь хөнөөсөн хүнд ойртохоос ч эмээнэ, учир нь гэмт хэрэгт холбогдож мэднэ, эсвэл түүний үйлийн үрээс үүрэлцэж магадгүй. Гэвч Бурхан бодьсадва айхгүй, хэрэв айж байвал Бурхан бодьсадва биш. Багш нь хараахан Бурхан, эсвэл бодьсадва биш. Та бүхэн Багшийгаа Бурхан бодьсадва гэж итгэх хэрэггүй. Гэхдээ Би бас Бурхан бодьсадвагаас суралцаж байна. Би үхсэн ч хамаагүй, гэмт хэрэгт холбогдохоос ч айхгүй.

Учир нь хамаг төрөлтөн надаас өөрцгүй, тэдний зовлон бэрхшээл миний зовлон бэрхшээл гэсэн үг, юунаас нь айх вэ? Гэхдээ үүнийг “би үгүй” дэсэд хүрч байж хийх ёстой. Хэрвээ та бусдыг ялгаварлах сэтгэлтэй хэвээр байгаа бол хийгээд хэрэггүй, учир нь үйлийн үрд баригдана.

Багшийнх нь саяхан ярьсан хүн бол ямар ч дэсэд хүрээгүй, өөрөө адад баригдсан, бас бусдыг өөрийнхөө нүд рүү харахыг зөвлөж байх аж. Та нар түүнийг таньдаг бол нүд нь ямархууг мэдэж байгаа. (Бүгд инээлдэв.) Түүнийг дагасан зарим хүн над

дээр ирээд: “Багшаа би түүний нүдийг хараад маш их айсан. Харин Таны нүдийг харахад маш сайхан байна” гэсэн.

Багш нь ийм зүйлийг тун цөөхөн ярьдаг. Голдуу гүн ухааны онолын талын зүйлс л ярих төдий. Учир нь та нарын олонх нь шинэ хүмүүс. Хэрвээ бүгд авшигтан байвал мэдээж би сүнслэг бясалгалын талын зүйл ярина. Гэвч үргэлж шинэ хүнтэй байдаг болохоор голдуу онолын зүйлс л ярьдаг. Жишээлбэл, “Тэнсэлгүй үнэхээр төгс туулсан Бодь мөрийн хутаг”, “Даяан гэж юу вэ?”, “Яагаад бид Арьяабалын аргаар бясалгах хэрэгтэй вэ?” гэх мэт. Багш шавь хоорондоо бясалгалын талаар ярилцах завшаан бараг олдохгүй. Та нар голдуу ах дүү, найз нөхдөө дагуулж ирдэг. Тиймээс надад ярих боломж гарахгүй байна. Заримдаа, би бас авшиг хүртсэн бясалгагч нартаа зориулж тусгайлан цаг гаргадаг. Гэвч тэд бас мартаад үргэлж нэг, хоёр шинэ хүн дагуулан ном сонсохоор ирдэг. Шинэ хүмүүсийн дэргэд би бясалгалын энэ бүх “нууц”-ыг ярьж болохгүй, тиймээс энэ тухай ярих нь тийм ч чөлөөтэй биш. Зуны хайлангийн энэ амар тайван гурван сарыг ашиглаад бясалгалын талаар ахиухан ярьж “би гэх үзэл”-ийг тань жаахан дарахгүй бол та нар олигтой бясалгахгүй байна. Бусдыг сургана гэдэг үнэхээр хэцүү ажил шүү.

Нэгэн удаа миний Өвөг Багш нэг хүнд авшиг хүртээсэн юм. Тэр хүн Өвөг Багшаас авшиг гуйж ирсэн. Тэр өмнө нь банк дээрэмдсэн гэсэн үү, хүн алсан гэсэн үү, ямар ч байсан нилээд хүнд гэмт хэрэг үйлдсэн хүн байжээ. Нэг шавь нь түүнийг Өвөг Багшид танилцуулахаар дагуулж ирсэн байв. Тэр дагуулж ирсэн шавь нь бол их сайн хүн.

Тэр үед Өвөг Багш маань шавьдаа: “Та энэ хүнийг бус, өөр жирийн зуун хүнийг танилцуулж болох байв.” гэж хэлсэн. Гэвч өнөөх шавь учрыг сайн ойлголгүй, түүнд авшиг хүртээж хайрла хэмээн гуйсаар байв. Өнөөх хүн ч бас Багшийн хөлөөс зуураад тавихгүй “Авшиг хүртэхгүй бол би эндээс явахгүй.” гэж хэлжээ. Эцэст нь Багш түүнд авшиг хүртээсэн. Авшиг өгсний дараа Багш минь голд живээд үхэх дөхсөн бөгөөд арай гэж амьд гарсан юм. Учир нь тэр хүний асар хүнд үйлийн үрээс болжээ. Миний Өвөг Багш амь насаа алдаагүй ч нилээд хэдэн цаг үхэх (голын усанд) хэрэгтэй болсон юм. Тиймээс Их Багшид асуудал байхгүй биш. Асуудал их байдаг, шавь олонтой бол асуудал бүр ч их. Гэвч энэ нь тэдний ажил учраас олон юм боддоггүй. Ямар ч асуудал учирсан арилгана. Харин балчир хүүхдийн хувьд явж сураагүй байж гүйх гэж оролдоод хэрэггүй. Тэгж их яарах хэрэг юу байна?

Багшийг нь дагаж энэхүү бясалгалын аргаар бясалгаж чадахгүй байгаа өөр бусад хүнийг хараад бид энэрэн хайрлах сэтгэлдээ хөтлөгдөн ногоон хоол идэхийг зөвлөхөд тэд идэхгүй, Багшийнх нь ном сургаалыг уншиж судлаарай гэвэл уншаад ойлгохгүй, эсвэл унших сонирхолгүй байдаг. Тэд бясалгах дуртай ч залхуу, ийм хүмүүсийг яах билээ? Ийм хүмүүст Авид Бурханы тарни уншихыг зааж, угийн шүтэж буй шашнаа үргэлжлүүлэн чин сэтгэлээсээ шүтээрэй гэхэд л болно. Хэдийгээр бид заах дуртай байлаа ч зөвхөн хүмүүс дуртай, сонирхолтой байвал л танилцуулж, сургаж болно. Бусдыг хүчээр итгүүлж, албадаж болохгүй, хүчлэх нь үр дүнд хүргэхгүй.

Даяаны бүлгийн үе үеийн Их Багш нар шавь нартаа бие даан шаргуу хичээж, боломжийг өөрөө хайж, аль болох их бясалган дадуулж, Мөр ёсыг бүтээх хэрэгтэй хэмээн сургадаг байсан. Тэдний хувьд, “Би өмнөөс тань бясалгана.” гэж хэлэх боломжгүй юм. Та хэрвээ тэднээс асуулт асуувал шууд л “Мэдэхгүй” гэж хариулна. Заримдаа бүр хариулах ч гүй, хариултыг өөрөөр тань олуулахаар үлдээнэ.

Учир нь та өөрийн чадлаар хичээж, өөрөө чармайж бүтээвэл үр дүнд хүрнэ. Хэн ч таны өмнөөс үүнийг хийж чадахгүй. Тийм учраас бясалгал хийхийг бусдад хүчилж болохгүй. Ингэж хүчлэх нь сайн биш. Хүн өөрөө гэгээрэх чин хүсэл тэмүүлэлтэй, шийдвэр төгс, үхэж төрөхийн учрыг олох үнэн сэтгэлтэй байх ёстой. Хоол идэхдээ ч энэ тухай бодож, унтахдаа ч энэ бодлоос үл салж, хаа ч явсан бай, эсвэл цаг үргэлж Мөр ёсыг хайх хүсэл зорилттой байх хэрэгтэй, зөвхөн тэр цагт л ойлгож чадна. Бусдыг хүчээр бясалгуулж болохгүй.

Энд заримдаа шавь нар залхуу байдаг нь миний санааг зовоодог, гэсэн ч би та нарыг бясалгал хийхийг хүчилж болохгүй. Хэдийгээр би зэмлэж, бас хүчилж болох ч ингээд нэмэргүй. Хүн өөрөө л бие даан бясалгах ёстой, тийм нэгэн “Яавал би үхэж төрөхийн сансрын хүрднээс мултарч чадах вэ? Яагаад би өөрийн Бурхан чанарыг бүрэн төгс ойлгож чадахгүй байна вэ? Яагаад надад ийм их нисваанис байсаар байна вэ? Яагаад би мунхаг харанхуй хэвээрээ байна вэ?” гэсэн энэ бүхний учрыг нь олох хүсэл тэмүүлэлтэй байх ёстой. Зөвхөн өөрөө л хүсэж тэмүүлбэл хариултыг олж чадна.

Өдөр бүр Багшаараа албадуулж бясалгаад хэрэггүй. Та бүхэн энд амьдрахаар ирээд залхуурч, бясалгахгүй байвал Багш нь хөөгөөд явуулна. Гэхдээ та нарыг өдөр бүр бясалгахыг хүчлэх

боломжгүй, мөн хэзээ бясалгах ёстой, хэзээ унтах ёстой, хэзээ идэх ёстой, хэзээ туулан гэтлэх талаар бодох ёстой, хэзээ амрах ёстой гэх мэт ёстойг нь тогтоон өгч, дүрэм журмаар далайлган бясалгуулж болохгүй. Ийм байж болохгүй.

Үнэхээр бясалгахыг хүссэн хүн хоногийн хорин дөрвөн цаг бясалгаж байдаг. Тэр ч байтугай ариун цэврийн өрөөнд байхдаа ч бясалгана. Сэтгэл зүрхээ “Мөр ёс” дотор байлгаж чадваас тэр бясалгал мөн. Хэрэв танд үхэх, төрөхийн талаарх асуултууд байгаа бол бясалгал мөн.

Харин зөвхөн тэнд сууснаар л бясалгаж байгаа биш, тэнд суугаа үеэр сэтгэл нилээд тогтуун болж, бие махбод арай тав тухтай, ингэснээр бодол санаа цэгцэрч бурхан бодьсадвагийн хүчтэй нилээд хялбар холбогдож чадна. Гэрлийг тод харж, улам улмаар ариусна. Ингэж хэсэг хугацаанд дадуулсны дараа, цаг хугацаа өнгөрөхөд явж байхдаа ч бясалгаж, унтаж байхдаа ч бясалгах болно. Гэхдээ энэ нь тэнд сууснаар л Будда болно гэсэн үг биш, ингэвэл “буруу Будда” болно, “зөв Будда” болохгүй. Энэ нь “буруу” болохоос “бясалгаж суух” нь буруу биш юм. Тиймээс Будда болох нь маш амархан, гэвч бас тийм амархан биш. Энэ нь бидний бясалгалын хандлагаас хамаарна.

Будда болохоос өмнө бусдын хэрэгт хөндлөнгөөс бүү оролц, тэднийг гэтэлгэх гэж яаран сандран явах хэрэггүй. Хэрэв хүн өөрийгөө ч гэтэлгэж чадахгүй бол яаж бусдыг гэтэлгэх вэ? Бусдыг гэтэлгээ гэвэл тэдэнд Багшийнхаа номыг уншихыг зөвлөж, Багшийнхаа сургаал болон Арьяабалын бясалгалын аргатай танилцуулах хэрэгтэй. Тэрнээс биш, бусдыг сургадаг багш болох гэх хэрэггүй. Хэрэв та сайн сурч амжаагүй бол яаж багш болж чадах вэ? Та англиар ярьж чадахгүй байхдаа бусдад англи хэл заана гэвэл инээдтэй хэрэг биш үү? Олон хүн Их Багш гэгдэх дуртай байдаг. Миний бодлоор энэ хачирхалтай хэрэг, Их Багш болох нь тийм зүдгүүртэй байхад Их Багш болох хүн яагаад байдаг вэ? Багш нь нөхцөл байдалд тулгагдан бусдад заахаас өөр аргагүй болсон. Хэд хэдэн удаа гадаад руу зугтсан ч эцэст нь мултарч чадаагүй.

Хэрвээ та нар үнэнхүү хайрлан энэрэх сэтгэлтэй бол бусдад Авид Бурханы тарни зааж өгч болно. Тэрнээс их багш болж, бусдыг элдэв тарни уншихыг албадах шаардлагагүй. Өдөр бүр айлаас айлд очиж, Баатараа явагч нэрт их хөлгөн тарнийг яагаад уншихгүй байна вэ? Яагаад Их нигүүлсэгч тарни, эсвэл Их гэтэлгэгч тарнийг уншихгүй байна? Яагаад та хичээнгүйлж

чармайхгүй байна вэ гэж асууж явах хэрэггүй. Өдөр бүр ямар нэг айлын хаалга тогшин ямар тарни уншвал ямар ач тустайг ярих нь бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцож байгаа л хэрэг. Тэд танаас гуйгаагүй, чөтгөр ч ирж танаас аврал эрээгүй.

Шагжамуни Будда Уламбана (Ullambana) судрыг Молом тойн Түүн дээр ирж, гуйсан учраас айлджээ. Молом тойн бол Түүний шавь, тиймээс түүнд туслах ёстой. Шагжамуни Будда Баатараа явагч нэрт их хөлгөн тарнийг ч мөн нэгэн шавьдаа зориулан айлдсан билээ. Анандад аюул тохиолдож, багшаасаа тусламж гуйсан байна. Гэхдээ энэхүү Баатараа явагч нэрт их хөлгөн тарнийг дотоодын Их Багш (хувилгаан бурхан) айлдсан гэдгийг та бүхэн мэдвэл зохино.

Манай энд ч мөн адил, зарим шавийн аав, ээж, эхнэр, нөхөр нас барахад тэд Багшаасаа тусламж гуйн утасддаг. Дараа нь үнэхээр дотоодын Их Багш илрэн гарч, тэднийг дагуулан дээд түвшин лүү авч одохыг хардаг байна. Энэ нь жам ёсны зүйл. Тэрнээс биш Багш нь танай хаалгыг тогшиж: “Нөхөр тань нас барчихаад байхад яагаад надад хэлсэнгүй вэ? Тэр авшиг хүртээгүй байжээ. Яагаад түүнийг авчирч авшиг авхуулсангүй вэ? Түүнийг нас барсныг надад хэлсэнгүй, би яаж түүнийг аврах вэ?” гэхчлэн ярихгүй. Бүх зүйл жамаараа л болдог. Таны хүссэн бүхэнд Их Багшийн хүч аль болохоор тусална. Их Багшийн хүч гэдэг нь энэ махан бие биш. Энэ хүн биш, харин өөр нэгэн дэс, бурхан бодьсавгагийн дэс юм. Энэ махан бие үнэндээ тийм ч сүрхий биш!

Хэрвээ жирийн хүн байсан бол би нэг их хамаарахгүй. Өдөр бүр бусдыг гэтэлгэж, чөтгөрийг гэтэлгэж, өөртөө төвөг удахгүй. Энэ дэлхийд чөтгөрийн сүнс дүүрэн тул хэзээ гэтэлгэж дуусах вэ? Хэрэв тэд өөрсдөө ад чөтгөр больё гэвэл өөрсдийнх нь дур, надад хамаагүй. Тийм хүмүүс амьд байхдаа юу ч хэлсэн сонсдоггүй. Ёс суртахуунтай зөв үйл хий гэвэл хийхгүй. Бурхны алдрыг магтах анхан шатны арга, бурханд залбирч мөргөх, эсвэл аль нэг шашныг шүтээрэй гэвэл шүтэхгүй. Тэгээд ч зогсохгүй, маш их нүгэл үйлддэг. Муу үйл үйлдсэн тул мэдээж муу үрийг эдэлнэ.

Харин шавь, шавийн ойр дотны хүн бол байдал арай онцгой. Учир нь тэр хүн Багшаасаа тусламж хүсдэг, тэр үед бурхан бодьсавгагийн сэтгэл хөдлөх тул мэдээж түүнд тусална. Миний шавь нарын дунд иймэрхүү байдал тун элбэг, энэ нь маш энгийн явдал.

Багш нь зарлан сурталчлаагүй, “Би чөтгөрийг гэтэлгэдэг.” гэж газар сайгүй яриагүй. Та нар л над руу утасдаж, тусламж хүсдэг. Заримдаа би үүнийг сонсохыг хүсдэггүй, учир нь зарим хүн юу ч тохиолдсон бай үргэлж Багшаасаа тусламж гуйж ирдэг. Гэвч тэд Багшийнх нь шавь учраас мэдээж би харж хандах ёстой.

Багш нь ингэж бодох төдийд л тэд буян хариулалтай болдог. Багш нь ямар нэг шидэт тарни бичээд тэдэнд илгээдэг юм биш. Ямар ч шалтгаангүйгээр ямар нэг юм унш гэж бусдыг яаж хүчлэх билээ? Хэн ч гуйгаагүй бол юунд тэгэх вэ? Хэрэв хэн нэгэн хүн жинхэнээсээ туулан гэтлэхийг хүсвэл аварч болно. Харин хүсээгүй хүнийг хүчилвэл тэр таныг зодож магадгүй. Тэгээд: “Хэн таныг энд ирж надад төвөг уд гэв? Би чөтгөр болох дуртай. Ад чөтгөрийн амьдрал их сонирхолтой” гэж ч мэднэ. *(Их Багш инээв.)*

Би дахиад нэг түүх ярья. Тэгвэл та нар илүү сайн ойлгох байх. Грект нэгэн маш сайн бясалгадаг хүн байжээ. Тэр хүн ад чөтгөр зайлуулж чаддаг, бас ямар нэг сүнсийг дагуулж, зуны амралт сувиллын газар гэх зэрэг тодорхой газарт очиж чаддаг байв. Ер нь, хэрвээ хүн амьддаа буян багатай байсан бол нас нөгчсөнийхөө дараа түр зуур тэр газарт очиж магад. Тэнд хэсэг зуур амьдраад дараа нь буцан ирж, хүн, эсвэл амьтан болж төрнө.

Өнөөх грек бясалгалтан нас нөгчсөн хүний сүнсийг дагуулаад тиймэрхүү газар оронд очдог байв. Нэгэн өдөр саяхан нас барсан нэг найзыгаа харж гэнэ. Тэр найз нь амьд байхдаа мөрийтэй тоглох их дуртай байсан учраас нас нөгчсөн ч мөн адил тийм найзуудыг хайж олоод тоглож байжээ. Хав харанхуй, бохир заваан газар чөтгөр найзуудтайгаа мөрийтэй тоглож байна гэнэ. Мөрийтэй тоглоомчин хүнд ямар газар байх нь огт хамаагүй, тоглож л байвал болно. Тэд угаасаа нууцаар тоглодог учир орчин тойрон нь тун бохир.

Мөрийтэй тоглоомчид өдөр, шөнөгүй тоглодог. Тамхи татаад л тоглоод байна. Тиймээс газар нь маш заваан, цэвэрлэх хүнгүй, хоол унд ч үгүй, хачиртай талх л идмэр аядана. Хачиртай талх яаж үүссэнийг та нар мэдэх үү? Яг ийм газраас үүссэн гэнэ. Дээр үед мөрийтэй тоглох тун дуртай нэгэн хаан байжээ. Тиймээс тэр хоол идэхээс ч залхуурна. Түүний туслах нь хачиртай талх хийж идүүлэх ийм нэг арга сэдэж олжээ. Тэгвэл тэр суудлаасаа босохгүйгээр идэнгээ тоглох боломжтой байна! *(Бүгд инээлдэв.)*

Өнөөх грек бясалгагч найзыгаа ийм бохир, харанхуй газар

тоглож суухыг хараад ихэд өрөвдөв. Өмнө нь найзууд байсан тул: “Яажшуухан амьдарч байна даа.” гэж асуусанд найз нь: “Тун сайн байгаа” гэжээ. Өнөөх бясалгагч: “Чи хар даа! Энэ газар их харанхуй, бохир заваан, сонирхол татах юу ч алга.” гэв. Тэгээд ид шидээрээ яруу сайхан аялгуу үүсгэж, гоё сайхан үзэмж бий болгон найзынхаа өмнө зуны амралтын газрыг татан авчирч, өнөөх харанхуй газрыг хийсгэн алга болгожээ. Тэгээд найзыгаа дагуулан олон газраар зугаацан явав гэнэ. Тэр хоёр тэрхүү амралт сувиллын газарт наадан зугаалж, уянгалаг сайхан хөгжмийн аялгуу сонсон цэцэг харан баясаж, амтат жимс идэн жаргажээ. Тэнд маш үзэсгэлэнтэй сайхан түвшнүүд, урсгал ус, олон гоёмсог орд харш байв. Тэрээр найздаа ёс суртахуунтай зүйлс ярьж өгчээ. Хэдэн цагийн дараа өнөөх тоглоомчин найз нь: “Чиний энэ яриа хэзээ дуусах вэ, би сонсмооргүй байна.” гэв. Бясалгагч гайхаж түүнээс: “Чи сонсмооргүй байна гэж үү? Энэ сайхан үзэмжийг харах дургүй байна уу?” гэж асуухад найз нь: “Өө! Энэ бүхэн надад үнэхээр уйтгартай байна. Явж мөрийтэй тоглоомоо тоглоомор байна!” (*Бүгд инээлдэв.*) гэжээ. Багшийнхаа санааг ойлгов уу? Тиймээс ад чөтгөрийг хүчлээд ямар ч нэмэргүй.

Бид бясалгадаг л бол бас ид шидтэй болно. Хэрэв бид иймэрхүү шидийг, жишээ нь, тарни унших, эсвэл өөр аргуудыг сурвал яриангүй чөтгөрийг зайлуулж чадна. Гэвч хожим бидний дэс дэвших үед энэ үйл түйтгэрээ заавал төлөх хэрэгтэй болно. Учир нь тэдэнд тэдний харилцаа холбоо гэж бий. Тиймээс үнэндээ амаргүй!

Зарим үед Их Багш шавьдаа туслахын тулд адын саад тогторыг багасгах аргыг зааж өгдөг. Гэвч тэр Их Багш үйл түйтгэрийг нь төлөх ёстой, учир нь бусдын үйлийн үрд хөндлөнгөөс оролцож болохгүй. Гэсэн хэдий ч шавь нь чин сэтгэлээсээ тусламж гуйсан учраас тэр Их Багш шавийнхаа үйл түйтгэрийг үүрнэ гэвэл бас болно. Гэвч Багш тэр болгон ингэхгүй. Уг нь тэр бүх адын саад тогторыг арилгах нь Их Багшийн хувьд асуудал биш ч шавь нар нь өөрсдөө Багштайгаа хамтарч, үйлийн үрээ арилгахыг зөвшөөрөх ёстой. Эс бөгөөс хожим энэ дэлхийд эргэж ирэх ёстой болно. Энэ төрөлдөө тэднээс ирэх харш саадыг амсаагүй бол дараа дахин ирж амсах болдог. Та одоо хэдэн арван жил зовж шаналж байж л дараа нь сая энэ ертөнцөөс өр тооцоогүй явж чадна.

Нэгэн их бясалгагч хүн өөрийн хүчээ ашиглан бусдыг үймүүлж болохгүй. Тэр нь ямар ч төрөлтөн байсан ялгаагүй, түүнд хор хөнөөл учруулж болохгүй. Чөтгөр ч бас нэгэн төрөлтөн,

тиймээс түүнийг бас хорлож болохгүй. Шагжамуни Будда ид шидээр чөтгөрийг зайлуулсан, эсвэл бусдын өвчнийг эдгээсэн тухай сонсож байсан уу? Сударт тэгж бичсэн байна уу? Багш нь энэ тухай бичсэн зүйл ер олж уншаагүй. Тэрээр ямар нэг өвчин эмчлээгүй.

Дөнгөж саяхан хүү нь нас барсан нэгэн хүн Шагжамуни Будда дээр ирээд ихэд уйлж, хүүгийн минь амийг аварч хайрла гэж гуйхад Бурхан Багш хөндлөнгөөс оролцолгүй, харин түүнийг яваад гэр бүлд нь ойрын таван төрлийнх нь нэг ч хүн нас бараагүй айл байна уу асуугаад ир. Хэрвээ олж чадвал тэр айлаас нэгэн эдлэл авчраарай. Тэгвэл би таны хүүг шидээр аварья гэжээ. Мэдээжээр тийм айл олдоогүй, ингэж түүнийг дөхөм аргаар ухааруулж сэхээрүүлсэн байна.

Тэр эмэгтэйн хүүг аврах чадал Шагжамуни Буддад мэдээж байсан. Гэсэн ч Тэр авраагүй. Ид шидээр бусдыг аварсан, өвчин эдгээсэн хүн өөрийгөө дөвийлгөж буй хэрэг бөгөөд энэ нь буруу явдал. Тийм хүн магад их доогуур дэстэй байна, эсвэл түүний “би гэх үзэл” нь байсаар байдаг. Их бясалгагч хүн шидийн хүч ашиглан бусдын өвчнийг эмнэхгүй.

Авшиг хүртэхэд тань Багш нь та нарт тарааж өгсөн гарын авлагд: “Хэрвээ та өмнө нь ид шидээр бусдын өвчнийг эдгээж байсан бол одоо түүнийгээ зогсоох хэрэгтэй. Эс бөгөөс таны дэс дэвшиж чадахгүй.” гэж тодорхой бичсэн. Учир нь иймэрхүү шид нь Гурван ертөнцийн дотор байдаг бөгөөд үүнийг ашиглавал туулан гэтэлж чадахгүй болно.

Жишээ нь, бид онгоцоор Америкт очиж болно. Гэтэл машин, эсвэл унадаг дугуйнаасаа салахгүй бол хэзээ бид онгоцоор нисэж амжих вэ? Унадаг дугуй нь газраар л явах зориулалттай, машиныг зөвхөн газраар л жолоодох боломжтой. Хэрэв бид тэднээс салахгүй зууралдвал онгоцонд сууж чадахгүй нь мэдээж. Нисэх онгоцны буудалд очсоны дараа онгоцонд суухаасаа өмнө тэднийгээ орхих хэрэгтэй. Та нэгэн зэрэг онгоцоор нисэж, машин жолоодож чадахгүй. Тийм биз?

Ид шидийн хүчийг ашиглаж байгаа л бол хамгийн төгс дээд биш гэсэн үг. Төгс дээд дэс огт биш. Молом тойныг хар даа, тэр тийм их шидийн хүчтэй байсан ч ямар ч ач тусгүй байв. Эхийгээ ч аварч чадаагүй юм чинь хамаг төрөлтнийг аврахыг бүр ярилтгүй. Молом тойн шидийн хүчтэй атлаа яагаад эхийгээ ч аварч чадаагүй вэ? Учир нь тэр архадын дэстэй, ид шид л бясалгаж байсан төдий,

билиг ухаан нь нээгдээгүй байжээ.

Тиймээс ид шидийг бясалгах нь ямар ч тусгүй. Багш нь: “Шид хэрэглэж болохгүй. Хэрвээ шидийн хүчтэй бол бүү ашигла.” гэж байнга хэлдэг. Би өөрөө шидийн хүч ашигладаггүй. “Манай Багш өвчин эмнэж чадна. Энд ирвэл таны өвчин дороо эдгэнэ.” гэх зэргээр гадуур гараад дураараа ярих хэрэггүй. Энэ бол та нарын зүүд. Би юуг ч зориудаар хийгээгүй. Магадгүй бага зэрэг хайрлаж өрөвдсөн л байх. Хэн нэгнийг харах үедээ өрөвдөж, жаахан хайрын сэтгэл төрж, зүрх сэтгэлдээ бодмогц тэр хүн тэр дороо адислалыг мэдрэн даруй буян хишигтэй болжээ. Тэрнээс Багш нь зориуд бодсон юмгүй, аяндаа л болдог.

Жишээ нь, та хөөрхөн хүүхэд харвал түүнийг өхөөрдөн хайрлаж, тэвэрмээр санагдах нь мэдээж. Энэ бол жам ёсны хэрэг. Та үүнийг зориудаар бодож байгаа юм уу, зориудаар түүнийг тэврэхийг хүсээгүй, тийм биш гэж үү? Бурхан бодьсадва нарын хувьд ч мөн адил, хамаг төрөлтнийг зөнгөөрөө л хайрладаг. Хүмүүс номхон хүлцэнгүй, эсвэл их зовлон бэрхшээлтэй байвал энэ бүхнийг тэдэнтэй нэгэн адил мэдрэх тул тэднийг ихэд хайрлана. Тэр хайр хамаг төрөлтөнд ач тусаа хүртээнэ. Учир нь Түүнд бодсон бүхэн нь бий болдог тийм нэгэн шид бий. Түүний соронзон талбай туйлын эвсэг найрамдуу, бусдад асар их тустай, тиймээс түүнд нь багтсан хэн ч байсан ач тус хүртдэг.

Гэхдээ хэр их, эсвэл бага ач тус хүртэх нь тэр хүн өөрийн үйлийн үрдээ хэр их халхлагдсанаас хамаардаг. Хэрэв ач тус их хүртэж байвал та нарт цонх, хаалга байгааг илэрхийлж байгаа бөгөөд ингэснээр та нар жаахныг харж чаддаг, хэрэв ач тус бага хүртэж байвал та нар дэндүү олон хана босгосныг илэрхийлж байгаа болохоор нэвт харж чаддаггүй.

За одоо, Их Багш болох хүсэлтэй хүн байна уу? Тийм хүн алга даа! Багшийгаа хардаггүй гэж бодоод гэртээ хариад нууцаар их багш гэгдэх хүртлээ хүлээх хэрэггүй шүү. Үнэндээ Багш нь бүгдийг хардаг.

Асуулт: Шагжамуни Будда ид шид хэрэглэж байсан бололтой, учир нь эрхэмсэг Анандыг нэгэн гоо бүсгүйд сэтгэл татагдахад Будда шид хэрэглэн аварсан шүү дээ. Үүнийг Их Багш тайлж өгнө үү?

Их Багш: Тэр шид хэрэглээгүй. Тэр бол зөнгөөрөө л болсон хэрэг. Яагаад вэ? Учир нь Анандад сахил алдуулж мэдэх бэрхшээл тулгарч, Бурхан Багшаас тусламж хүсэн: “Бурхан Багш минь ээ,

энд ирээд намайг үтэр түргэн аварч тусална уу, надад саад тотгор тохиолдов.” хэмээн гуйсан байна.

Шавь нарын хувьд энэ нь мэдээжийн хэрэг, бэрхшээлтэй тулгарах үедээ тэд шууд л багшийгаа бодно. Яг Багшийгаа санагалзах үед багш нь зөнгөөрөө л Гэрэл цацруулан ирж, түүнийг аварна. Шагжамуни Будда Анандыг аварсанаа ч мэдээгүй байж мэднэ. Тэр үүнийг зөнгөөрөө л хийсэн, тэр үед Бурхан Багшийн үснирээс нэгэн Гэрлийн цацраг цацарч, мянган дэлбээт лянхуа цэцгийн Гэрэл болон хувирав. Энэхүү мянган дэлбээт лянхуа цэцгийн дээр нэгэн хувилгаан бурхан залран суух ажээ. Бурхан Багш тэр хувилгаан биеэрээ Баатараа явагч нэрт их хөлгөн тарнийг айлдсан байна. Энэ тарнийг Шагжамуни Будда махан биеэрээ айлдсан биш, харин дотоодын Их Багш, хувилгаан Их Багш айлдсан юм.

“Арван зүгтээ гэрэл цацруулсан зуун эрдэнийн оройт, мянган дэлбээт эрдэнийн лянхуа цэцгийн дээр хувилгаан биет Түүнчлэн ирэгч залран суугаад... Гэрэл цацруулсан Түүнчлэн ирэгч хувилгаан тарнийг айлдав. Наму Са Та Та ... суухаа.”

Эндээс үзэхэд үүнийг чухам Бурхан Багшийн хувилгаан бие айлдсан болох нь тодорхой байна. Мэдээж Буддагийн хувилгаан бие бүхнийг хийж чадна. Түүний ид шид үлэмж их, мөн Түүнчлэн ирсэн учраас хүссэн бүхнээ хийж чадна. Энэ бол бүгд л дотоодын хэрэг бөгөөд энэ дэлхийтэй, эсвэл адын эзэнтэй ямар ч холбоогүй, тиймээс адын эзэн үүнийг саатуулж чадахгүй.

Гэвч хэрвээ ид шидийг гадна талд илрүүлэн үзүүлбэл адын эзэн ирж, гомдоллоно. Учир нь энэ дэлхийн хүмүүсийг татахын тулд шидийн хүчээ ашиглаж болохгүй. Та дотооддоо юу ч хийсэн болно, зөвхөн багш, шавь хоёр л мэднэ.

Тэр үед Ананд нүдээ анин Бурхан Багшаас аврал эржээ. Бурхан Багшийн хувилгаан бие Анандыг авруулахаар Манзушри Бурханыг (чанагуух ертөнцийн бодьсатва) явуулж буйг тэрээр харсан байна. Энэ бол түүний дотоодын ахуй ойлголт юм. Тэрээр харьж ирээд хүмүүст энэ тухайгаа ярьсан бөгөөд дараа нь тэмдэглэн авчээ. Мянган дэлбээт лянхуа цэцэг бол нэгдүгээр ертөнц гэдгийг та нар мэднэ. Аврал эрэн даатгах үедээ тэрээр нэгдүгээр ертөнцийн дэстэй байж, Багштайгаа уулзсан байна. Тэрхүү Буддагийн хувилгаан бие энэ хувилгаан тарнийг айлдсанаас энгийн махан биеэр айлдаагүй.

Асуулт: Молом тойн нэгэнт архадын хутагт хүрсэн болохоор үнэндээ түүний эх нь ач тусыг нь хүртэх ёстой байтал яагаад

бирдийн төрөл авсан бэ?

Их Багш: Учир нь архад хүн бусдыг аварч чадахгүй. Түүний эхийнх нь үйл түйтгэр асар хүнд тул Молом тойн эхийгээ аварч чадаагүй. Судар номд бодьсдва хүнд хичнээн их ид шид, хүч чадал, буян хишиг, ач буян байдгийг, эсвэл энэрэл нигүүлслийн ямархуу сэтгэлтэйг маш тодорхой бичсэн байдаг. Харин архадад энэ бүхэн тун бага, тэдний хүч чадал хязгаартай бөгөөд тэдэнд гүн гүнзгий билиг ухаан, цаглашгүй их хайр энэрлийн сэтгэл аль аль нь хомс. (Цэцгийн эрихийн судар “Хуа янь”-ийг уншвал мэднэ.)

Асуулт: Бид хараахан архадын хутагт хүрээгүй байна. Гэтэл яагаад биднийг авшиг хүртмэгц таван үе маань бүгд төрөл дээшилж чадах вэ?

Их Багш: Энэ тун энгийн явдал. Учир нь та бүхэн бодьсдвагийн зам мөрийг бясалгаж байгаа, харин архадын зам мөрийг бясалгаагүй. Багш нь та нарт архадын зам мөрийг биш, бодьсдвагийн зам мөрийг заан сургадаг. Тиймээс та бүхэн амь хөнөөж болохгүй, эр, эмийн явдлыг ч багасгавал зохино. Энэ бол бодьсдвагийн сахилууд юм. Сахилуудыг би энгийн бөгөөд товч тодорхой байдлаар эмхэтгэж, та нарт зааж өгсөн. Та нар сонсмогцоо л эдгээр нь бодьсдвагийн сахил гэдгийг мэдэх болно. Мах идэхгүй нь бодьсдвагийн сахил. Зөвхөн бодьсдвагийн сахилд л: “Хамаг төрөлтний махыг идэж болохгүй.” гэж дурдсан байдаг. Ихэнх архад ганцаараа, эсвэл хосоороо ууланд бясалгадаг. Хамаг төрөлтнийг гэтэлгээ гэх бодол тэдэнд байхгүй. Хамаг төрөлтөн тун ихээр зовж шаналж байгаа ч сэтгэл хөдөлдөггүй.

Бодьсдва нар бол өөр. Тэдний сэтгэл хөдөлж, бусдыг аврах тангараг тавьдаг. Тиймээс Арьяабал бодьсдва, Самандбадраа бодьсдва, Манзушри бодьсдва бүгдээрээ маш алдартай. Тэд билиг ухаантай, ид шидтэй, энэрэн нигүүлсэх сэтгэлтэй. Тэд төрөл тутамдаа тийм үйл үрийг тарьсан болохоор бодьсдвагийн хутагт хүрч чадсан юм.

Харин архадууд тийм үйл үрийг тариагүй болохоор мэдээж ийм үр дүнд хүрч чадахгүй юм. Тиймээс архадад бодьсдвагийн ид шид байхгүй, бодьсдвагийн нигүүлсэнгүй сэтгэл байхгүй, бодьсдвагийн хүч чадал байхгүй, Цэцгийн эрихийн судар (Hua yan)-т өгүүлэхдээ Hуа уан номын хурал хурах үед үй олон бодьсдва ирж, Бурхан Багшид шид үзүүлж, мөн гоёмсог сайхан түвшнүүдийг хувирган харуулжээ. Гэтэл уг номын хуралд оролцож байсан архадууд огт анзаараагүй байна. Тэд юу ч

сонсож чаддаггүй, яг сохор дүлий хүмүүс шиг байдаг, учир нь тэд бодьсадвагийн хутагт хүрч чадаагүй, зөвхөн архадын дэстэй юм.

Бурхан бодьсадва нар бурхан бодьсадвагийн эд зүйлсийг эдэлж, баясан Бурханы оронд жаргадаг. Харин архадын хувьд эдгээр түвшин үл таних ертөнц. Яг зааглагдсан хоёр ертөнц мэт. Архад хүн Бурхан бодьсадвагийн ертөнцийг ойлгохгүй. Мэдээж тэд бас үхэж төрөхөөс мултарч чаддаг нь гарцаагүй. Гэхдээ тэдний хүч чадал хязгаартай, бусдыг аварч чадахгүй, тэд зөвхөн жаахан ид шидийн хүчтэй төдий, яг Молом тойн шиг. Хэдийгээр Молом тойн асар их ид шидтэй боловч эхийгээ аварч чадаагүй.

Та бүхнийг авшиг хүртмэгц таван үе тань төрөл дээшилж чадна. Тийм биз? Та бүхэн бодьсадва болох, таван үеэ аврах, бодьсадвагийн замаар замнах сэтгэлтэй л байхад болно. Учир нь та нар өмнөх төрлүүддээ ийм үйл үрийг тарьж, бурхан бодьсадвагийн өмнө маш их ач буян үйлдэж, билиг ухааны үйл үр тарьж, энэрэл нигүүлслийн сэтгэлийн үйл үрийг их бүтээж байсан учраас энэ нэг төрөлдөө бодьсадвагийн зам мөртэй учирч чадсан байна. Бусад хүний хувьд хэдийгээр бид тэдэнд ярьдаг ч тэд сонсохгүй, сонирхохгүй, эсвэл ойлгохгүй байдаг нь тэд тийм үйл үрийг тариагүй учраас тэр.

Судар номд бичсэнээр, Молом тойн эхийгээ аврах чадваргүйдээ ихэд халаглажээ, тиймээс уйлсаар буцаж явав. Энэ тал дээр надад бас эргэлзээ бий. Би түүнийг үнэхээр уйлсаар буцаж явсан биш, харин тэр уйлах үедээ Бурхан Багшийн хувилгаан болон бодьсадвагийн хувилгаан илрэн гарч ирэхийг харсан гэж бодож байна. Тэдний заавар зөвлөгөөг хүлээн авсны дараа эхийгээ аврахаар буцаж очсон байх. Хэдийгээр энэ нь Бурхан бодьсадвагаас бидэнд дотоодод заасан зүйл боловч бид тэдний зааж өгсөн аргын дагуу гадна талд бас хийж чадна.

Жишээ нь, зарим хүн өөрөө өвдсөн үедээ, эсвэл хэн нэг нь өвдвөл зөвхөн Арьяабал бодьсадваг харахыг хүсэж, чин сэтгэлээсээ залбиран даатгадаг. Тэгэхэд Арьяабал бодьсадва дотоодод нь илэрч түүнд: “Та гэртээ хариад ийм ийм ургамлын навч, үндсийг хамтад нь хэдэн цаг буцалган хандлаад ээждээ өгч уулгаарай. Үүнийг уусны дараа асуудалгүй болно.” гэж зааж өгчээ. Гэхдээ Арьяабал Бурханы илрэн гарах нь жирийн нэг хүн ирээд ярих шиг байдаг биш, бид чин сэтгэлтэй байж, бодол санаагаа төвлөрүүлэх үед л сая Арьяабал бодьсадва илэрнэ. Энэ бол өөр нэгэн дэс юм.



АД ЧӨТГӨРИЙН АЖЛЫГ ТОДОРХОЙ ТАНИХҮЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайбэй хот. Цаглашгүй гэрэлт бясалгалын төв
1987 оны 8 дугаар сарын 9.(Эх нь хятад хэлээр)*

Өнөөдөр нэг авшигтан надаас: “Багш аа, Та намайг загналгүй их удлаа, яагаад вэ?” гэж асуухад би: “Танд асуудал гарвал л загнана, яг л хувцас хиртвэл угаадаг шиг. Хэрэв хувцсаа хэдийн угааж, индүүдэж, эвхээд шүүгээнд хийсэн бол мэдээж дахиж угаах шаардлагагүй, учир нь аль хэдийн угаачихсан. Харин дахин өмсөх гэж гаргасан, эсвэл хэн нэг хүн байрнаас нь хөдөлгөсөн, эсвэл хэн нэгэн санамсаргүйгээр газарт унагасан юмуу дахин угаах шаардлагатай бол угаах ёстой. Харин цэвэрхэн байвал угаах шаардлагагүй.” гэж хариулсан.

Гэхдээ энэ нь нэг удаа угаачихвал үргэлж цэвэрхэн байна гэсэн үг биш. Жишээ нь, авшиг хүртсэн нэгэн хүний дэс, тэр ч байтугай тавдугаар ертөнцөд хүрсэн ч гэсэн заримдаа ад чөтгөрийн дайралтанд өртөж болно. Дэс дээшлэх тусам илүү олон удаа дайралтанд өртдөг. Учир нь ад чөтгөр арга бүхнийг сүвэгчилж, авшигтан хүмүүсийг элдэв аргаар бурхны хүчнээс салгахыг оролддог. Тиймээс Дээдийн Ном уламжилж буй хүнд маш их төвөг бэрхшээл тарьж, ном уламжлахыг нь саатуулах, эсвэл даган суралцаж буй хүмүүст нь олон эргэлзээ тээнэгэлзлэл, саад тотгор, маргаан тэмцэл бий болгож, тэднийгсайн талыг бус, зөвхөн саар муу талыг л харах болгодог.

Жишээ нь, энд ирээд Багштай уулзах хүсэлгүй, зөвхөн гадна талын хог новш харах дуртай. Тиймээс ад шүглэсэн хүн заавал

хачин жигтэй байх албагүй, эсвэл өдөржин элдвээр хашгирч, амандаа бувтнаж, эсвэл элдэв эмх замбараагүй үйлдэл хийгээд байхгүй. Сүнслэг бясалгалд олон дэс бий. Мөн мэдээж ад шүглэх ч бас олон дэстэй, нэгдүгээр зэргийн ад шүглэх, хоёрдугаар зэргийн ад шүглэх гэж байна. Ад чөтгөр гэхээр л толгой дээрээ хоёр эвэртэй, эсвэл урт соёотой байх албагүй. Үгүй, үгүй. Ад чөтгөрийн арга заль маш уран нарийн. Тиймээс бид “Мөр ёс нэг тохой ахихад ад чөтгөр нэг алд ахина.” гэж ярьдаг.

Ад чөтгөрийн ажил нь юу вэ? Хүмүүсийг хэрэлдэж маргалдах, зодолдож тэмцэлдэх, амиа хорлох, эсвэл бусдаас өөсэв эрэх, хов жив ярихад уриалдаг. Тэр бүх сайн талыг далдалж, хүмүүст зөвхөн саар талыг дөвийлгөн харуулдаг. Багш нь сайн сургаал заах үед хүмүүст үл сонсгон тэдэнд зөвхөн авшигтнуудын ярих элдэв хэрэггүй зүйлсийг сонсгоно.

Жишээ нь, хэн нэг зан авир муутай хүний тухай ярих, эсвэл ямар гэрээс гарагч муу, ямар гэртээ бясалгагч муу, Багшид хэн сайн ханддаг, хэний бясалгал олиггүй, ямар хос сайн, тэдний гэр бүл ямар асуудалтай гэх зэрэг хэрэгцээгүй аар саар зүйлийг яриулна. Ад чөтгөр ийм л зүйлсийг ярьж, хүмүүст мэдүүлж, анхаарлыг нь тэр хар бараан зүйлд хандуулж, мөн муу тал дээр хүмүүсийн анхаарлыг нь төвлөрүүлдэг. Хэрэв бид сэтгэлээ сөрөг муу зүйлсэд хандуулбал бидний дэс тэнд гагцхна, тийм биз? Тиймээс энэ бүхнийг ад чөтгөрийн ажил гэдгийг мэдэх хэрэгтэй.

Ад чөтгөрт үүнээс илүү өндөр дэсийн ажил бас бий. Жишээ нь, хүмүүсийг олон төрлийн маргаан мэтгэлцээн, эсвэл эрдэм мэдлэгт суралцахад урамшуулдаг. Үнэнийг хэлэхэд “коан” ном хаялцаан бол тэдгээрийн нэг нь. Учир нь энэ нь оюун санааны талбарт харьяалагддаг болохоор сайндаа л нэг, эсвэл хоёрдугаар ертөнцөд хүрнэ.

Маргаж, мэтгэлцэх дуртай, эсвэл жаахан уран цэцэн үгтэй хүмүүс бол оюун ухааны түвшнийх бөгөөд хоёрдугаар ертөнцийг ч давж чадаагүй байх тул Гурван ертөнцийн чанадад гарах талаар бүр ярилтгүй. Шагжамуни Будда, эсвэл бусад ямар ч сургаалын эзнийг нирваандаа буцсаны дараа ад чөтгөр тэр бүлэг, эсвэл ашрамд шургалж, тэдгээр шашны сургаалын эзний ном буюу сургаал номлолыг аажмаар өөрчилдөг. Жишээ нь, Шагжамуни Будда бидэнд коан-ном хаялцахыг заагаагүй, тэд л ном хаялцахад хэрхэн оролцохыг сургасан.

Багш нь энэ бүхнийг зөвхөн та нарт л хэлж байна. Учир нь

та нар бол миний шавь. Хэрвээ гадны хүмүүст ийм зүйлс яривал зодуулна. Учир нь одоо ч коан-ном хаялцахыг сурч буй хүн маш олон байна. Зарим их багш нар ч мөн суралцаж байна. Тиймээс дураараа гадуур битгий яриарай. Багш нь хүмүүсийг сургадаг гурван төрлийн зүйл байдаг. Нэг дэх төрөл нь, гадна талын сургаал, хоёр дахь нь, дотоодын сургаал, нөгөөх нь гүн нууцлаг дотоодын сургаал. Тийм төрлийн дотоодын гүн нууцлаг зүйлсийг зөвхөн дотоодын Их Багштайгаа уулзах үеэр л сурч чадна.

Гэхдээ тийм төрлийн гүн дотоод мэдлэгийг бусдад мэдүүлж болохгүй. Яримагц дорхноо адын саад ихтэй болно. Учир нь энэ бол ад чөтгөрийн ажил. Бясалгагч нарт маш их саад бэрхшээл учруулах нь ад чөтгөрийн хийдэг ажил юм. Бясалгал дээшлэх тусам тэд үзэн яддаг. Үнэндээ бол ад чөтгөр тийм ч сүрхий биш. Зөвхөн биднийг сорих багаж зэмсэг юм. Бидний бясалгалд сорилт шалгалт байж л сая дэсээр ямар байгаагаа мэдэж чадна. Тиймээс ад чөтгөрийг их үзэн ядаад хэрэггүй. Харин сэрэмж болгоомжтой байж, тэдний оршин буйг таних хэрэгтэй. Тэдний сорилтонд орох үедээ энэ бол бурхны ажил биш, харин ад чөтгөрийн ажил, энэ бол баруун тал биш, харин зүүн тал гэдгийг мэдэх хэрэгтэй. Хэзээ бид хов жив ярих, эсвэл Багш болон авшигтнуудын дутагдлыг шүүмжилж байвал ад чөтгөр ажиллаж буйг мэдээд: “Үүнийг тэвчье, энэ бол ад чөтгөрийн ажил тул надад маш муу нөлөөтэй. Тиймээс даруй зогсооё.” хэмээн өөртөө нэн даруй сануулах хэрэгтэй.

Бясалгах үедээ цаг үргэлж өөрийгөө хянан дүгнэж, ад чөтгөрт боломж олгохгүй байх хэрэгтэй. “Өөрийгөө хянан шүүх” гэдэг нь өөрийгөө цаг үргэлж зэмлэн буруушааж: “Би яагаад ийм муухай юм бэ? Яагаад би ад чөтгөр шиг явдал мөртэй байдаг вэ? Би үүнээс салж амиа хорлох нь хамгийн сайн.” гэхчлэн өдөржингөө гомдоллох явдал биш юм. Өөрийгөө ийм байдлаар хянаж болохгүй.

Бид угаасаа маш ариун, гэвч бид энэ дэлхий дээр амьдарч байгаа, энд ад чөтгөрийн хүч нэн их тул бидний амьдралд нөлөөлдөг. Иймээс сэрэмж болгоомжтой байх хэрэгтэй. Үнэндээ бол бидний алдаа дутагдал бүгд ад чөтгөрийн нөлөөнд автсанаас болдог юм. “Угаас хов хоосон тул тоос хаана нь тогтох вэ?” гэдэг нь ийм утгатай. Бид угаасаа маш цэвэр ариун, гэвч дэлхий биднийг бохирдуулсан. Харин бясалгал дээшлэн дэвшвэл яг л бохирдолгүйгээр шавар дундаас урган гарч буй лянхуа цэцэг шиг байж чадна.

Лянхуа цэцэг бурхны дэсийг төлөөлдөг гэж бид ярьдаг. Яагаад вэ? Учир нь шавар намаг дунд ургадаг хэрнээ өчүүхэн ч бохирдохгүй, маш анхилам үнэртэй, цэвэрхэн байдаг. Ялаа, зөгий, эрвээхэй ойртдоггүй тул лянхуа цэцэг хамгийн цэвэрхэн цэцэг юм. Бусад цэцэг эрвээхэй, зөгий, ялаанд идүүлж, балаа соруулж устдаг ч зөвхөн лянхуа л тэгдэггүй нь сонин. Хэдийгээр лянхуа цэцэг намагт ургадаг ч хамгийн цэвэрхэн, хамгийн анхилам, бас хамгийн ариухан нь юм.

Бид бясалгах тусмаа улам бүр лянхуа цэцэг шиг болох хэрэгтэй. Гэхдээ бид дээд дэсэд хүрэхээсээ өмнө мэдээж мөн л шавар намаг дунд байдаг болохоор гадна тал нь түүнд нөлөөлөгдөж байдаг.

Жишээ нь, лянхуа цэцгийн үндсийг шавраас гаргаж авахад тийм ч цэвэр биш, гадна тал нь маш бохир байдаг тул олон удаа угаасны дараа л сая цэвэрхэн болж, идэж болно. Бидний бясалгал дээд дэсэд хүрэхээс өмнө бид лянхуа цэцгийн үндэстэй ижилхэн байдаг, дээд дэсэд хүрсний дараа шавар шавхайд нөлөөлөгдөхөө болино.

Бясалгал дээшлэх тусам дайралт ихсэж, ад чөтгөрийн саад тотгорын хорлолд олонтаа өртөнө. Хамгийн муу байдал бол биднийг Багшаас, Арьяабалын бясалгалын аргын системээс холдуулах явдал юм. Учир нь Арьяабалын бясалгалын арга бол хамгийн дээд бясалгалын арга бөгөөд бусад бясалгалын арга бол хүмүүсийг туулан гэтэлгэж чадахгүй. Хэдийгээр та бүхэн дөнгөж бясалгаж эхэлж байгаа ч даруй зарим үр дүнг харах болно, энэ нь та нарт өөртөө итгэх итгэл төрүүлж, үргэлжлэн бясалгах урам зориг өгдөг. Хэдийгээр бясалгаж эхлээд жаахан үр дүн олсон ч дорхноо ад чөтгөрт татагдаж мэднэ. Бат тууштай итгэлгүй бол бясалгана гэдэг үнэхээр амаргүй.

Мянга гаруй жилийн өмнө Бодьдарма: “Одоо цөвүүн цаг учраас муу хүн олон, сайн хүн ховор. Бясалгахад тун амаргүй. Хэрвээ би дэлхийд үлдвэл хамаг төрөлтөнд гай гамшиг, үйл түйтгэр үүсгэхээс цаашгүй. Тиймээс би явах хэрэгтэй.” гэж хэдийнээ айлджээ гэж өмнө нь ном тайлах үеэр Багш нь дурссан. Тэрээр мянга гаруй жилийн тэртээ ингэж айлдсан байна. Тэгвэл одоо ямар үе вэ? “Цөвүүн цаг” биш, “ад чөтгөрийн номын цаг үе” гэвэл зохино.

Гэвч авшиг хүртсэн хүмүүс бид санаа зовох хэрэггүй. Авшиг хүртээд бид “Алтан эрин”-д дэвшин ордог. Цөвүүн цаг,

ад чөтгөрийн номын цаг үе, алтан эрин аль нь ч бай энэ бүхэн бидний дотоод мөн чанараас шалтгаална. Тиймээс “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.” гэлцдэг. Алтан эрин лүү дэвших үү, цөвүүн цагтаа байх уу гэдэг нь бидний өөрсдийн сонголт юм.

Алтан эрин гэж юу вэ? Энэ нь амьд сэрүүн байгаа Бурхан болон Түүний шавь нар хамтдаа Дээдийн Ном дэлгэрүүлж, хамтдаа бясалгаж, энэ дэлхийн уур амьсгалыг цэвэрлэн ариусгаж байгаа гэсэн үг юм. Ийм хүмүүс Алтан эринд амьдарч байдаг. Тиймээс Шагжамуни Будда амьд сэрүүн залран байх тэр үеийг Тэрээр жинхэнэ ном дэлгэрэх цаг, эсвэл Алтан эрин гэж нэрлэсэн байна. Гэхдээ тэр үед муу хүмүүс байсан уу? Байсан. Олон хүн Түүнийг хороохыг санаархсан, мөн олон хүн Түүнийг гүтгэн буруушааж байсан. Тэр ч байтугай үеэл Девадетта нь хүртэл хэд хэдэн удаа Бурхан Багшийг хөнөөхийг оролдож, хаа ч явсан эсэргүүцэж, өөр урсгалын бүлэг үүсгэн завшаан олдох бүрийд Түүнийг хорлодог байсан.

Тиймээс цөвүүн цаг болон Алтан эринийг бид өөрсдөө бий болгодог гэдгийг мэдвэл зохино. Мэдээж Алтан эрин хийгээд Яао болон Шун-гийн цаг үе гэж байсан. Тэр үед сахил санваар гэж байсангүй, улсын хууль цааз ч байсангүй, өршөөл энэрэл, шударга ёс, ёс журам, ёслол хүндлэл, билиг ухаан, итгэл үнэмшил гэж байсангүй, ер нь юу ч байгаагүй. Тэр үеийн дэлхий ертөнц яагаад тийм энх амгалан байсан бэ? Яагаад гэвэл тэд бүгд “Мөр ёс”-той, тэд бүгд гэнэн цайлган, цэвэр ариун, төрөхөөсөө л “Мөр ёс”-той байсан. Хаан эзэн “Мөр ёс”-той, ард иргэд нь “Мөр ёс”-той, эцэг эх нь “Мөр ёс”-той, эхнэр нөхрүүд бүгд “Мөр ёс”-той байжээ. Тэнд “Мөр ёс” байсан, тиймээс хэдийгээр тэд эзэн хаан, эцэг эх, эхнэр нөхөртэй байсан ч маш цэвэр ариун байжээ.

Гэтэл одоо яагаад Багш нь эр, эмийн харилцаа ч бага байх хэрэгтэй гэдэг вэ? Учир нь хүмүүсийн оюун бодол муу болсон. Уг нь эр, эмийн явдал тийм ч муу зүйл байгаагүй, гэвч бидний бодол санаа дэндүү муу болсон байна. Хэрвээ “Мөр ёс” үгүй бол бид юу ч хийсэн бай бүгд муу болно. Тэр ч байтугай өглөг үйлдсэн ч муу, хүн аварсан ч муу, учир нь “би” авардаг тул хүмүүсийг аврах нь зорилготой болдог, “би” түүнийг аварсны дараа нэрд гарна, хүмүүс надад дуртай болно, “би”-г их нигүүлсэнгүй хүн хэмээн бодно. Ийм л юм. Иймээс энэ “би гэх үзэл” бүхнийг хорт эм болгон хувиргадаг. Өмнө нь эр, эмийн харилцаа нь тун жам ёсны, зөвхөн оршин амьдрахын төлөө, ямар ч элдэв муу санаагүй үйлдэл байсан бол одоогийн эр, эмийн харилцаа нь нэг төрлийн

бие биенээ ашигласан, хэт их махан биеийн үйлдэл болон хувирсан. Бодол санаа нь буруу болсон болохоор бүх зүйл муу болж хувирчээ.

Яао, Шун-гийн цаг үед ч эхнэр нөхөр, үр хүүхэд гэж байсан, гэхдээ хорвоо дэлхий үнэхээр сайхан энх амгалан байсан. Яагаад вэ? Учир нь бодол санаа нь цэвэр ариун, муу санаагүй байсан юм. Гэвч өнөөдөр бид хэдийгээр яг ижил зүйлийг үйлдэвч үр дүн нь өөр байна. Бид ч бас үр хүүхэд, хань ижилтэй, гэхдээ өмнөх үеэс их өөрчлөгдөж, Яао, Шун-гийн цаг үеийн нөхцөл байдал үгүй болсон байна.

Тиймээс “өршөөл энэрэл, шударга ёс, ёс журам, билиг ухаан, итгэл үнэмшил”-ийг санаачлах, урамшуулах хүн байх хэрэгтэй, учир нь хүн төрөлхтөн бүгдийг мартчихжээ. “Мөр ёс” нэгэнт үгүй болчихжээ. Одоо эмх замбараагүй болж, харилцан биесээ хорлож, хөнөөх болсон. Тиймээс хэн нэгэн гарч ирээд үүнийг олон түмэнд тайлбарлаж, тэдэнд: “Ийм байж болохгүй, та эцэг, эхдээ ингэж хандаж яаж болох вэ? Тэд таныг тээж төрүүлэн зовж зүдрэн байж өсгөж өндийлгөсөн.” гэх мэтээр хэлэх хэрэгтэй болсон байна.

Уг нь бол ямар ч тайлбарлах шаардлагагүйгээр жамаараа л эцэг, эхдээ ачлалтай байх учиртай. Тиймээс өршөөл энэрэл, шударга ёс, ёс журам, билиг ухаан, итгэл үнэмшлийн хэрэг байхгүй, эсвэл үр хүүхдийн ачлал энэрлийн цогц хэм хэмжээг тогтоох шаардлагагүй байсан. Даанч хүн төрөлхтөн улам бүр дордож байна. Найз нөхдөдөө сайнгүй, итгэл даахгүй болсон тул түүнд: “Та найзыгаа ингэж болохгүй, тэр танд итгэсэн тул тантай хамт ажиллаж байна. Та түүнийг хууран мэхэлж болохгүй, найздаа хэлсэн үгэндээ хүрэх хэрэгтэй. Зөвхөн ийм байдлаар л цаашид амар тайван ажиллана.” гэхчлэн хэлэх хэрэгтэй болжээ.

Хэрвээ аливаа хэргийг тодорхой тайлбарлах ёстой бол энэ нь тун хэцүү. Ярихын оронд жамаараа хийх нь л хамгийн сайн. “Мөр ёс”-ыг алдсанаас хойш л үг хэл хэрэгтэй болсон. Тийм учраас Күнз, Мооз нар энэ дэлхийд гарч иржээ. Энэ бүгд нь хамаг төрөлтөн Мөр ёсоо алдсанаас болжээ. Учир нь Алтан эрин нэгэнт устан баларсан байна.

Одоо улам дордсон, бид энэ зовлонтой цаг үед амьдарч байна, газар дээр маш их хорт хий байна, хэрэв хот сууринд амьдардаг бол гараад жаахан алхвал биед хүхрийн хий шиг зүйл наалдах болов. Машинаас ялгарах хар утаа бидний бие цогцос, оюун ухаан, бодол санаанд нөлөөлөх болсон. Тиймээс орчин үеийн

хүмүүс аймхай хулчгар, уур уцаартай, гутранги бодолтой байдаг. Өнөө үед хүмүүсийг гэтэлгэх, тэднийг сургах, эсвэл тайлбарлан ойлгуулахад тун амаргүй болсон. Өнөөдөр тайлбарласан зүйлийг маргааш нь мартана. Тэр ч байтугай маргаашийг ч хүлээх хэрэггүй, таныг ярьж дуусмагц тэд тэр дорхноо мартчихна. Хэрвээ Шагжамуни Будда хамаг төрөлтнийг гэтэлгэхээр одоо үед энд ирсэн бол: “Хамаг төрөлтнийг гэтэлгэхээ больё.” гэж толгой сэгсрэх байсан.

Би хэдийгээр Шагжамуни Будда биш боловч бас л нилээд хэдэн удаа толгой сэгсэрсэн билээ. Гэвч та нар Багшийгаа дахин татан гаргаж ирсэн болохоор орхиж явж төвдсөнгүй. Би хоёр, гурван шавийн маш их чин сэтгэлтэй, үнэн сэтгэлээсээ гэгээрлийг болон туулан гэтлэхийг хүсэж байгааг олж харсан. Тэгээд тэр цөөн хэдэн чин сэтгэлтэй шавийнхаа төлөө үлдсэн юм. Бусад хүнд ч бага зэрэг нөлөөлнө гэж найдаж байна, гэхдээ энэ үнэхээр амаргүй, тийм биз?

Одоо Багш нь та нараас: “Багшийнхаа сургаалаас хэр ихийг санаж байна вэ?” гэж асууя. Багш нь ном тайлж байх үед зарим нь унтана, зарим нь сонссон ч ойлгохгүй, хэрэв тэднээс дахин асуувал юу ч ойлгохгүй байгааг нь шууд мэдэх болно. Эсвэл тэднийг юм асуух үед энэ хоёр цагийг дэмий үрж, ямар ч ач тусгүй, зүгээр л агаарт ярьж, тэд юу ч сонсоогүйг Багш нь шууд мэддэг. Тиймээс хүмүүсийг сургана гэдэг үнэхээр амаргүй.

Гэхдээ ямар ч байсан энд ирсэн л бол та бүхэн их, бага ямар нэгэн хэмжээгээр ач тус хүртээд буцдаг. Харин ирж чадаагүй хүмүүсийн хувьд илүү асуудалтай.

Бясалгаад дээгүүр дэсэд хүрээгүй үедээ ирж ном сонсох нь маш чухал. Учир нь та бүхэн эндээс хүч аваад харих үедээ гэр бүл, нийгэм, улс орондоо түгээнэ. Дэлхийгээ гудамжны гэрэлгүй хөдөө газар мэт хав харанхуй газар болж хувирахыг нь бүү зөвшөөр. Хэрвээ гудамж замын дагуу олон жижиг гэрэлтэй бол хөдөө тосгонд ийм харанхуй байхгүй. Өмнө нь замын гэрэлгүй үед шөнөдөө хөдөө тосгон бүхэлдээ харанхуй болдог байсан. Хэрвээ сар байхгүй бол хөдөө газар явган явах боломжгүй бөгөөд юу ч харагдахгүй.

Та нарт ийм нөхцөл байдал тохиолдож байсан уу? Багшид нь тохиолдож байсан. Би дайны үед төрсөн, тэр үед бид ууланд амьдарч, амтаг төмс тариад иддэг байв. Аав амтаг төмс тарьж, ээж даавуу зарна. Гэхдээ аав байнга гэртээ байхгүй. Хааяа нэг

хичээл заахаар, мөн бусад ажлаа амжуулахаар явдаг байв. Аав эмч, бас багш хийдэг байсан юм. Тэр үед эмчийн орлого амьдралд хүрэлцэхгүй тул бас багшийн ажил хийдэг байсан.

Дайны хөлөөс дүрвэн амьдарч байсан болохоор аав их холоос явна. Манайх бусад айлаас нилээд зайдуу амьдардаг байв. Манай гэрийн жижигхэн чийдэнг эс тооцвол ууланд огт гэрэлгүй байсан. Гадаа их харанхуй, заримдаа бид өөрсдийгөө ч харж чаддаггүй. Та нар ер нь ийм амьдрал үзэж байсан уу? Залуу хүмүүс бол мэдэхгүй, харин ахмад үеийнхэн мэдэх байх. Бид тэр үед ганц гудамжны гэрэлтэй болсон нь хэдийгээр жижигхэн гэрэл байсан ч оргүйгээс дээр байв. Одоо бидний амьдарч байгаа ууланд гудамжны гэрэл байхгүй бол их харанхуй байх байсан.

Бясалгал хийнэ гэдэг үнэхээр амар хялбар зүйл биш. Хэрвээ бид Их Багшийн хүчинд л найдахгүй бол өөр түших зүйл байхгүй. Ийм шашны тогтолцоонд найдаад нэмэргүй, коан-ном хаялцаанд түшээд бас нэмэргүй. Энэ үнэхээр тэнэг мулгуу ном хаялцаан. Шашны ийм тогтолцоо яагаад одоо ч байсаар байна вэ? Учир нь энэ бол ад чөтгөрийн ажил, тэр биднийг завгүй байлгадаг. Өдөржин бурханд мөргөөд завгүй, ном хаялцаад завгүй, эсвэл судар унших нь энэ дэлхийг орхих хүртэл маань бидэнд сэтгэл ханамж мэдрүүлэх болно, учир нь бид: “Би бясалгал хийж байсан! Энэ маань хангалттай.” гэж өөртөө хэлж чадах юм. Хэрэв та одоогийн ямар ч шашны тогтолцоог харвал тэд бүгд л зөвхөн нас барсныхаа дараа л та бурхантай уулзана гэдэг, тийм үү? Зөвхөн нас барсныхаа дараа л Баруун зүгийн Төгс баясгалант оронд очно, туулан гэтэлж чадна гэж хэлдэг, тийм биз? Бид яг одоо туулан гэтэлж болно гэж хэн ч хэлж зүрхэлдэггүй.

Үнэндээ бол бид одоо туулан гэтэлж болно, яг одоо бурхны Гэрлийг харж болно, ядаж л бурхны Аялгууг сонсоно, хэрвээ дээгүүр дэстэй бол бид бас бурхны орныг харна, дотоодын Бурханаа харна, тэр биднийг дагуулан дээгүүр түвшинд хүрч, дээд дэсийн Бурханы ёсонд сургана. Та нар тийм дээд дэсийн ертөнцийг харахгүй, зөвхөн бурхны Аялгууг сонссон байсан ч хамаагүй, танд Их Багш байгаа бөгөөд та багшдаа итгэдэг л бол гарцаагүй туулан гэтэлнэ. Яагаад вэ? Учир нь бид сайтар бясалгах тусмаа энэ дэлхий бидний хувьд юу ч биш гэдгийг улам илүү мэдэрдэг. Бид одоо хэдийнээ туулан гэтэлсэн тул энэ дэлхийд тэгтлээ хоргодохгүй, бас дэндүү их хүлэгдэхгүй. Хэдийгээр бид эхнэр нөхөр, үр хүүхэдтэй хэвээр байгаа ч энэ бүгд бол зөвхөн үүрэг хариуцлага л юм гэдгийг мэднэ. Тэд бүгд мөнх бус бөгөөд

зөвхөн үйл үрээр холбогдсон байдаг тул бид тэдэнтэй урьдынх шигээ хэт зууралдахгүй, хэдийгээр гэрээс гараагүй ч гэсэн гэрээс гарсан хүн шиг л сэтгэл хөнгөн байдаг.

Хэрвээ нэг өдөр бидний жинхэнэ эзэн нэн өндөр дээд дэсэд хүрвэл бид хэн нь юу байхыг үл хайхарч, Будда болох эсэхийг ч үл тоон бүгд сайн, юу болсон ч хамаагүй болох бөгөөд тэр бол бид “амьд байхдаа туулан гэтэлчихсэн” явдал болно. Харин нас нөгчсөнийхөө дараа л туулан гэтэлдэг бус. Иймэрхүү яриа бол бусдыг мэхэлж буй хэрэг бөгөөд биднийг зөвхөн ямар ч цаг завгүй байлгадаг, нас нөгчсөнийхөө дараа ч туулан гэтлэх эсэхээ мэдэхээ больтол маш завгүй байлгадаг. Насан туршдаа бясалгаад ямар ч бурхны Гэрэл, эсвэл бурхны Цэцэг хараагүй, насаараа ном хаялцаанд оролцоод ямар ч үр дүнгүй, тэр ч байтугай хэрэв жаахан үр дүнтэй болсон ч гэсэн тэр нь зүгээр л оюун ухаанаар хийсвэрлэн бодсон зүйл байж, жинхэнэ төгс туулан гэтлэлт биш байдаг.

Хэрвээ та бүхэн Даяаны бүлгийн бясалгалтнаас суралцвал тэд ямар бардам гэдгийг мэдэх болно. Тэд зүгээр л маш их ярьдаг. Судар номоос цээжилсэн хэдэн өгүүлбэр, жишээ нь, “Бурхны Гэрэлд сүүдэр үгүй.”, “Цэцэг дэлгэрвэл Бурхан харагдана.”, “Даяанд үг хэл хэрэглэдэггүй.” гэх зэргийн олон зүйл ярих боловч үүнийгээ огт ойлгоогүй байдаг. Та бүхэнд ийм зүйл тохиолдож байсан уу? Тохиолдоогүй бол одоо яваад мэдэж болно. Тэдэнтэй мэтгэлцвэл маш их уйтгартай байх болно, тэгээд та: “Ээ, бурхан минь, ярих ч юм алга, би явлаа.” гэж хэлнэ. Учир нь иймэрхүү мэтгэлцээн үнэхээр утгагүй зүйл.

Тийм учраас та бүхэн сэрэмж болгоомжтой байх хэрэгтэй. Хаа сайгүй ад чөтгөрийн саад тотгор дүүрэн байна. Багшийгаа орхихыг хүссэн хүн байвал би тэдэнтэй ер зууралдахгүй. Танд эргэлзэх сэтгэл үүссэн л бол Багш нь таныг даруй явуулна. Хэдийгээр Багшаасаа холдсон хүмүүс хожим нь үнэхээр их зовж зүдэрдэг ч Багш нь: “Надаас явсны дараа танд ямар асуудал тохиолдоно.” гэдгийг нь тэдэнд хэлэхгүй. Багш нь юу ч хэлэхгүй, учир нь энэ бол таны өөрийн сонголт.

Тэр ч байтугай асуухгүйгээр Багшийгаа орхисон хүмүүс бүр ч их зүдэрдэг. Багшаасаа холдмогц ад чөтгөр тэр даруй ирдэг, учир нь түүнд одоо завшаан олджээ. Та Багшийгаа орхисон тул мэдээж тан дээр ад чөтгөр даруй ирнэ. Тиймээс янз бүрийн асуудал, элдэв төрлийн саад бэрхшээл, гай зовлон, үйл үр, үйл түйтгэр гээд юм бүхэн тан дээр бууна. Хичнээн их хугацаа өнгөрсний дараа та сая

нэг ухаан орж, Багштайгаа уулзахаар буцаж ирвэл Багш нь бас таныг хүлээгээд л авдаг.

Гэхдээ хүн болгоныг хүлээж авахгүй, тэдний хандлагыг нь харна, үнэн сэтгэлээсээ гэмшиж ухаарсан, үнэхээр даруу төлөв байна уу, эсвэл дахин төвөг бэрхшээл тарихаар ирэв үү гэдгийг харна. Төвөг удах хүмүүсийн хувьд Их Багш нарын ихэнх нь ер нь юу ч хэлэхгүй, эсвэл урьдчилж анхааруулдаггүй, зүгээр л чимээгүйхэн орхидог. Энэ нь илүү хурдан, учир нь хэрвээ түүний дэс үнэхээр доогуур бол өөрөөр нь алгуурхан суралцуулна. Тэнд түүнийг хүлээх, эсвэл түүнд доош татагдах нь сайн биш. Тиймээс Их Багш нь юу ч хэлэхгүй, зүгээр л чимээгүйхэн холддог.

Хэрэв тухайн хүний дэс үнэхээр доогуур бөгөөд багшийгаа өөрийн дэс рүү татаж, Багшаараа өрөвдүүлж, өөрийн дэсийг ойлгуулахыг санаархвал энэ нь боломжгүй хэрэг бөгөөд тэгж болохгүй. Учир нь хүн төрөлтний сэтгэл хөдлөл нь хүнийг маш их ядраадаг. Бүгд л түүнийг тайтгаруулах хэрэгтэй, түүнийг та тун сайн, ямар ч асуудалгүй гэхчлэн магтах хэрэгтэй болдог.

Гэтэл нэгэн Их Багш хүн төрөлтний тийм өчүүхэн сэтгэл хөдлөлийн төлөө ёс журамтай үйлдэл хийдэггүй. Шавиа баярлуулахын төлөө ингэж болохгүй. Харин түүнийг дээш татахаас биш, түүнтэй дэсээр ижилсэн түүнийг баярлуулах биш юм. Хэрвээ тэр явах дургүй бол тэнд нь үлдээнэ. Жишээ нь, хэрэв хэн нэг нь шаварт байвал Багш нь түүнийг татан гаргах хэрэгтэй, гэхдээ тэр өөрөө гарах дургүй бол тэнд нь тоглуулна. Харин та нар Багшийгаа түүнтэй хамт шавар дунд тоглуулахыг санаархаж болохгүй. Багш нь тийм тэнэг биш.

Жинхэнэ Их Багш маш олон хүнд авшиг хүртэхэд нь тусалж чадна. Гэхдээ зөвхөн хамгийн их буянтай хүн л Багшид итгэж, үргэлжлүүлэн бясалгаж чаддаг. Хэрвээ бид ёс суртахуунтай, эсвэл их буян хишигтэй бол ад чөтгөр биднийг яагаад ч ганхуулахгүй. Гэхдээ тэр оролдож үзэх болно. Гэвч тэр дайрах үедээ яг л толгойгоороо хана мөргөх шиг болж, эцэст нь ядраад зайлж одно. Жишээ нь, ад Багшийг нь татаж чадахгүй, тэр зөвхөн шавь нарыг татдаг. Суралцах гэж ирээд удаагүй байгаа, Багшийнхаа сургаал ёсыг гүйцэд сайн ойлгоогүй, хөөрхий тэр бяцхан амтат төмснүүд л уруу татагдах боломжтой.

Багшийг нь ад чөтгөр хааш нь ч татаж чадахгүй. Та нар харж байгаа, Багш нь Формосад ирснээс хойш өдийг хүртэл олон удаа дайралтанд өртсөн, шавь нарын дайралт, гадны хүмүүсийн

дайралт, бас танихгүй хүмүүс ч дайрсан. Гэвч надад ямар ч асуудал үүсээгүй. Харин шавь нар өчүүхэн жаахан дайралтыг ч тэсэж чадахгүй байдаг.

Тэр дайралт гэгч нь юу вэ? Жишээ нь, Багшийг нь гүтгэн муулсан хэн нэгний яриаг сонсмогц итгэл нь ганхаж эхэлдэг, нэг, хоёр хоногийн дараа хүндрэлтэй тулгарахдаа Багшдаа даатгана, байдал бага зэрэг дээрдэхийг мэдэрч, дахин Багшдаа итгэж эхэлнэ. Хэд хоног өнгөрөхөд хэрэв нэгэн авшигтан сайн биш, зарим нэг дутагдалтай, эсвэл сайн бясалгахгүй байгааг олж харвал харихдаа энэ бүх хог новшийг сэтгэлдээ тээж, гурав, дөрөв хоноод ч мартаж чадахгүй байх бөгөөд бодох тусам дургүй нь хүрч, тэгээд Багшаасаа, бясалгалын төвөөсөө улам бүр холддог. Ердөө л зарим авшигтнаас болоод Багшийгаа орхиж, бясалгалын аргаасаа хөндийрдөг. Ингэж л адад хорлогддог юм.

Ад чөтгөрийн арга маш нарийн, түүнд биднийг доош татах олон арга бий. Тиймээс бидний сэтгэл бат тууштай байх ёстой. Ад чөтгөр зүгээр нэг энгийн хүн байх албагүй. Заримдаа маш алдартай номын багшийн дүрээр өөр шашны ном сургаалыг, эсвэл өөрийн сургаал номлолыг ашиглан та нарт тайлбарлан та бүхнийг Багшаас нь, Арьяабалын бясалгалын аргаас холдуулна.

Тэр: “Энэ хүн саяхан гарч ирснийг та мэдэхгүй гэж үү? Манай Бурханы шашин аль хэдийнээ хоёр мянга таван зуун жил болов, Католик шашин мөн мянга таван зуу гаруй жил болж байна, тиймээс бид уламжлалт ёсоо даган бясалгах хэрэгтэй. Энэ Арьяабалын арга үргэлж байсан ч түүгээр бясалгаж байсан хүн хэзээ ч байгаагүй, гэтэл та яагаад ийм амархан итгэв? Бид бурхныг дурсан аялгуулан уншаад мянга, эсвэл хоёр мянга гаруй жил болж байна, мөн сая сая, хэдэн арван сая хүн маани, тарни уншиж байгааг хар. Гэтэл та яагаад нэг өчүүхэн жаахан бүлэг хүмүүстэй хамт Арьяабалын аргаар бясалгаж байна вэ? Энэ тун найдваргүй шүү, олон хүнтэй газар л хүчтэй. Ихэнх хүн үүнийг бясалгаж байгаа бол энэ нь сайн арга. Цөөн хүн бясалгаж байвал муу бясалгалын арга гэсэн үг.” гэхчлэн ярина. Түүний яриаг сонсвол их л учир зүйтэй мэт боловч үнэндээ энэ нь ад чөтгөрийн учир зүй болно.

Иймэрхүү ад чөтгөрийн учир зүйг бид яагаад сонсоод байна вэ? Багшийнхаа ярьсан үнэн номыг сонсохгүй мөртлөө яагаад ад чөтгөрийн тайлбарлах тэдгээр номын багшийг сонсох дуртай байна вэ? Учир нь таны дэс тун доогуур хэвээр байгаа бөгөөд тэдэнтэй ойролцоо дэстэй учраас тэднийг сонсож, ярьж буй зүйлийг нь

ойлгоод байгаа хэрэг. Тийм хүмүүсийн дэс хүн төрөлхтний ухамсрын түвшинд л байдаг, харин богд гэгээнтний ухамсрын түвшинд хүрээгүй байдаг. Хэрвээ хүн төрөлхтний ухамсрын түвшинд байсаар байвал хүний өчүүхэн явцуу сэтгэл хөдлөлийн хүрээнд хүлэгдсэн хэвээр байж, “миний” болон “түүний” гэсэн ялгаа байсаар байна. Харин гэгээнтэнд харьяалагддаг ухамсарт иймэрхүү явцуу сэтгэлгээ байдаггүй. Гэгээнтний үзэл бодол эгэл биднийхтэй адилгүй.

Жишээ нь, та нар одоо энд, дотор сууж байхдаа мэдээж гадаа юу болж байгааг бараг харахгүй. Зөвхөн Багшийгаа, авшигтнуудыг, энэ ашрамыг л харна. Харин дээвэр дээр гарвал нөхцөл байдал адилгүй болж, харах хүрээ өөрчлөгдөнө.

Өөр нэг жишээ бол, та нарын гадна байх үеийн бодол санаа энд орж ирсний дараах бодол санаа ч бас адилгүй байдаг. Заримдаа гэртээ бясалгаж чаддаггүй байсан бол энд ирээд бясалгаж чадна. Гэртээ байхдаа бясалгах дургүй байсан бол энд харин аяндаа бясалгах хүсэл төрнө. Яагаад вэ? Учир нь түвшин нь өөр юм.

Тиймээс үнэн, хуурмаг хоёрыг ялгах хэрэгтэй, хэн нэгэнд тухайлан итгэх шаардлагагүй. Бие даан хичээнгүйлэн бясалгаж чадвал хэсэг хугацааны дараа аяндаа дүгнэж цэгнэх чадвартай болно. Та нар үргэлжлүүлэн бясалгаж л байвал тэр ч байтугай Багшдаа итгэхгүй байсан ч болно. Хэдийгээр та ном хаялцахыг дадуулах нь сайн, эсвэл Авид Бурханы тарнийг унших нь сайн гэж хэлж байсан ч үнэндээ чухам юу нь сайн болохыг огт мэдэхгүй. Бусад хүн тийм гэж хэлэхэд, та мөн тийм гэж хэлэх үед танд зөвхөн “үүнд итгэх”, эсвэл “үүнд үл итгэх” гэсэн хоёр боломжит нөхцөл байдал л байдаг, учир нь та хараахан шүүн дүгнэх чадваргүй байна.

Одоо Багш нь Арьяабалын бясалгалын аргыг зааж байгаа тул та нар ядаж зарим нэг ач тус, үр дүнг шууд авах боломжтой. Жишээ нь, Гэрэл харж, түвшинг үзэж, билиг ухаанаа хөгжүүлж чадна. Тэр ч байтугай ийм үнэмшилтэй үр дүн нь та нарт итгэхэд, эсвэл нотлоход хангалттай биш байлаа ч Арьяабалын бясалгалын арга нь бусад бясалгалын аргаас муу гэж хэлэх, шүүн дүгнэх арга байхгүй.

Хэрвээ таны шүүлт маш муу, та юуг ч шүүн дүгнэх чадваргүй юм бол яагаад ийш тийш явж, ийм олон бясалгалын аргыг сурч дадуулж байдаг вэ? Зөвхөн нэг л аргаар бясалгах аргыг дадуул, учир нь Арьяабалын аргаар бясалгавал тэр даруй үр дүнтэй болж

чадна. Харин бусад аргаар бясалгахад тийм байхгүй. Эндээс үзвэл бид Арьяабалын бясалгалын аргыг дадуулах нь хамгийн зөв, ядаж л халаасандаа багахан ч гэсэн олзтой байна гэж баттай хэлж чадна. Хэрвээ та тодорхой өөр нэг бясалгалын аргыг сайн гэвэл өөрөө бясалгаад үзэх хэрэгтэй. Учир нь тэр аргаар бясалгаад ямар ч үр дүнд хүрэхгүй, харин Арьяабалын аргаар бясалгахад даруйхан үр дүн гарах болно. Бид наад зах нь энэ жаахан итгэлдээ түшиглэн үргэлжлүүлэн бясалгаж чадах юм.

Хэрэв танд шүүн тунгаах чадвар хараахан байхгүй бол энэ аргыг сайн, тэр аргыг муу гэж, эсвэл энэ номын багшийг сайн, тэр номын багшийг муу гэж дураараа ярьж шүүмжилж яаж болох вэ? Тодорхой шүүн дүгнэх чадвартай болъё гэвэл дээд түвшинд хүрэх ёстой. Зөвхөн тэр үед л аль бясалгалын арга нь сайн, аль нь сайн биш болохыг бүрэн мэднэ. Эрхбиш хамгийн өндөр дээвэр дээр гарч байж л бүхнийг ойлгож чадна.

Тиймээс ад чөтгөрт ашиглагдаж болохгүй, сэрэмж болгоомжтой байх хэрэгтэй. Бясалгагч нар хоногийн хорин дөрвөн цагийн турш сэрэмж төгс, болгоомжтой байх ёстой. Ад ирвэл даруйхан таних хэрэгтэй. Уйтгар гунигтай, бухимдалтай, өөрийгөө голдог, үнэлдэггүй, амиа хорлох бодолтой, хов жив ярих, бусдыг муугаар бодох дуртай байх, мөн Багшийнхаа гадаад үйлдлийг шүүмжлэх, эгэл хүний ухаан бодлоор Багшийгаа, бусад авшигтнуудыг дүгнэх зэрэг нь бүгд ад чөтгөрийн ажил мөн тул даруй түүнийг таних хэрэгтэй.

Бурхан бодьсадва нар иймэрхүү зүйлийг үл ойшоодог, ийм явдал учрыг үл хамаардаг учраас хов жив ярьдаггүй бөгөөд хэн нэгний сайн, мууг тоодоггүй. Тэр хэрэв хэн нэг хүнийг сайн биш гэж үзвэл тэр даруй түүнд: “Та ингэх нь буруу, үүнийгээ засах хэрэгтэй.” гэж хэлнэ. Энэ нь нигүүлсэнгүй сэтгэлээс үүдсэн, мөн үүрэг хариуцлага байгаа тул зааж сургах гэсэн байна. Гэхдээ тийм Их Багш зөвхөн өөрийн хариуцсан хүмүүсээ л сургахаас хүн бүхнийг сургахгүй.

Аль нэг шашин, хэн нэг хүнийг бид санаандгүй шүүмжилбэл хэм хэмжээг мэдэх хэрэгтэй.

Юуг ад чөтгөрийн сургаал гэх вэ? Юуг Бурханы сургаал гэх вэ? Бурханы сургаал бол хүмүүст туулан гэтэлж чадна гэсэн итгэл төрүүлж, тэднийг баяр жаргалтай байлгаж, өдөр бүр “Би дээд түвшинд хүрч чадна, бясалгалын тийм үрийн хутгийг олж чадна.” гэсэн итгэлтэй болгодог. Харин адын сургаал өдөр бүр

юу хийхийг танд зааж өгдөг ч ямар ч үр дүнгүй, зүгээр л ярихаас цаашгүй. Энэ бол адын сургаал юм.

Тэд өөрсдийгөө ямар ч шашин гэж нэрлэсэн бай бид адын сургаал болон бурхны сургаал байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Адын сургаал гэж юу вэ? Жишээ нь, ёс суртахуун, эсвэл нийгмийн үүрэг хариуцлагаар биднийг хүлээсэлж: “Та эхлээд ... ингэх хэрэгтэй..., тиймээс бясалгаж болохгүй.” гэж сургана.

Мэдээж бид үүрэг хариуцлагаа орхигдуулж болохгүй, гэхдээ тэр бүх үүрэг хариуцлагаар биднийг энэ дэлхийд хүлээсэлхийг зөвшөөрч болохгүй. Бид гэр бүлийнхээ өмнө ч, улс орныхоо өмнө ч хүлээсэн үүргээ сайтар биелүүлэх ёстой, гэвч бид хэзээ нэг өдөр тэднийг орхин одох нь гарцаагүй гэдгээ бас мэдэж байх хэрэгтэй. Тиймээс бид өөр зүйлд найдах ёстой. Зөвхөн гэр бүл, улс орон, эсвэл өршөөл энэрэл, шударга ёс, ёс журам, билиг ухаан, итгэл үнэмшилд найдаж болохгүй. Энэ бүгд хоёрдогч зүйл болохоос гол зүйл биш. Зөвхөн Багштайгаа хамт илүү их цагийг өнгөрөөж байж л ад чөтгөр хаана байгааг ойлгож чадна, халаасандаа хичнээн олон ад байгааг ойлгож, тэднийг хурдхан аваад шуудуунд хаяна.

Хэрэв үүрд аюулгүй байя гэвэл Багштайгаа хамт байх хэрэгтэй. “Багштайгаа хамт байх.” гэдэг ямар утгатай вэ? Энэ нь цаг үргэлж Багшийгаа дурсан санах гэсэн үг юм, та юу ч хийсэн бай Их Багшийн хүч хийж буй, юу ч бодсон бай Их Багш бодож байна гэнэ. Зөвхөн ингэснээр л та ад чөтгөрт ээрэгдэхгүй болно. Багштайгаа хамт бясалгаж байвал ад ойртож чадахгүй. Харин Багшаасаа салмагц ад чөтгөр тэр дороо хүрч ирнэ.

“Багшаасаа салах” гэж юуг хэлэх вэ? Энэ нь Багшийгаа дурсан санахгүй байх, аливааг өөрийн би гэх үзлээр үйлдэх, эгэл хүний ухаан бодлоор дураараа шүүн дүгнэх, элдэв бодол өвөрлөх, дур зоргоор ярих, Багшдаа итгэдэггүй, Багшийгаа бодохгүй байхыг хэлнэ. Ийм байвал тэр даруй ад чөтгөрт ашиглуулна. Хэрвээ та өдөр бүр Багштайгаа хамт байвал ямар ч асуудал гарахгүй нь гарцаагүй. Таны дэс ямар ч байсан бай Багш нь таныг хамгаалж, дээш дагуулж гарна. Үйл түйтгэр тань ямар байсан ч Багш нь таныг дээш дагуулж гарч чадна. Хэрвээ та өдөр бүр Багштайгаа хамт байвал, бид хамтдаа байвал Багш нь энэ баталгааг өгч чадна.

Харин Багштайгаа хамт байх хүсэлгүй бол Багш нь таныг албадахгүй. Өдөр бүр өөрийн сэтгэл зүрхэнд адыг амьдрахыг уриад байвал тархи толгой тань мэдээж адаар дүүрнэ. “Ад чөтгөр” гэж юу вэ? Бусдын зөвхөн хар бараан, саар муу талыг л хардаг

бол ад юм. Харин бусдын гэрэл гэгээтэй талыг хардаг бол бурхан мөн. Тиймээс аюулгүй байя гэвэл өдөр бүр Багштайгаа хамт байх хэрэгтэй.

Та нар дотоодын Багшийгаа харж чадах эсэх нь тийм ч чухал биш, гэхдээ Багш нь тантай хэзээд хамт байдаг гэдгийг мэдэж байх ёстой. Тэр та нартай хамт байдаг ч та бүхэн үл анзаарч, үл тоож, Түүний саналыг сонсохгүй, Түүнийг зөвлөгчөө болгодоггүй, оронд нь адыг зөвлөгчөө болгодог. Багшийнхаа сургаалыг дагахгүй, харин адын сургаалыг дагадаг. Ингэвэл бурхан бодьсадвад ч ямар ч арга байхгүй. Учир нь бурхан бодьсадва нар бусдыг ерөөс хүчилдэггүй тул та юу хийнэ, таны дур.

Би та нарт хэлэхэд, Багш нь аливаа ажлыг та нарын өмнөөс хэдийн зохицуулчихсан байдаг. Туулан гэтлэх, Баруун зүгийн Төгс баясгалант орны үрийн хутаг, богд гэгээнтнүүдийн мөрийн хутаг зэргийг бүгдийг нь зохицуулчихсан. Яг л дээл хувцасны тань хэмжээг авч, оёж бэлдээд зөвхөн өмсөх цагийг тань хүлээх мэт. Даанч та нар тэр дээлийг өмсөх хүсэлгүй, өдөржин гадаа тоглоод гэртээ харихгүй бол яаж өмсөж чадах вэ? Авшиг хүртэхэд тань Багш нь дээл хувцсыг тань хэдийнээ эсгэж, оёод бүхнийг бэлдчихдэг, хүрэх мөрийн хутаг ч аль хэдийн та нарыг хүлээж байдаг.

Гэтэл та нарын дэс дэндүү доогуур, бас адын үгийг сонсоод тун завгүй байгаа учраас энэ бүх аль хэдийнээ бэлдсэн зүйлсийг танихгүй явна. Жишээ нь, тэнд хоол бэлэн болсон бөгөөд та нарыг ирээд идэхийг тань хүлээж байна. Хэрэв Багш нь хэлэхгүй бол та нар тэнд хоол байгааг мартчихдаг, яагаад вэ? Учир нь та бүхэн Багшийнхаа ном тайлахыг сонсоод завгүй байна. Мөн цаг нь арай болоогүй тул гэдэс нь өлсөөгүй. Тиймээс идэх хүсэлгүй байгаа хэрэг. Тэр ч байтугай зарим хүний цаг нь болсон ч идэх хүсэлгүй тул өөр зүйл хийгээд завгүй, эсвэл бусадтай ярилцаж байвал мэдээж хоолоо идэж чадахгүй.

Багш нь бүх зүйлийг бэлдчихсэн. Туулан гэтлэх мөрийн хутаггүй байх нэг ч хүн байхгүй. Авшиг хүртсэн л бол бүх зүйл тэнд байж, таныг ирж авахыг хүлээж байдаг. Авшиг хүртсэн хүн тэр даруйдаа туулан гэтэлдэг. Нэрийг тань өгөөд бүртгүүлчихсэн бөгөөд ирж суух хутагтын суурь тань та нарыг хүлээж байдаг, гэвч хэрэв та нар салж одвол тэр нь байхгүй болно. Жишээ нь, Багш нь суух суудлыг тань бэлдсэн ч та нар ирэхгүй бол хэн ч тэр суудалд суухгүй. Эсвэл хоол бэлэн болсон ч хүн ирэхгүй бол мэдээж хэн ч идэхгүй. Хэдийгээр авшиг хүртээх үедээ Багш нь та

нарт: “Та бүхэн лавтай туулан гэтэлж чадна.” гэж хэлсэн ч та нарт сонголт хийх эрх чөлөө бас байдаг учраас ирээд тэрхүү мөрийн хутгийг эдлэн баясаж болно, эсвэл орхиж ч болно.

Гэвч Багш нь эрхбиш та бүхэнд: “Адын саадыг бүү март, адын хүчийг үл тоомсорлож болохгүй, тэд өдөр бүр биднийг сорьж шалгадаг. Учир нь тэд биднийг буцаж очоод өөрийн мөрийн хутгийг эдлэхэд дургүй.” гэж анхааруулах ёстой. Үнэндээ тэд дургүй биш, харин тун шударга, буцаж очоод Багшийнх нь та нарт зориулан бэлдсэн дээл хувцсыг өмсөж эдлэхүйц хүн үнэхээр мөн үү гэдгийг тань л тэд шалгаж байдаг юм.

Жишээ нь, нэгэн хүн Багшаас нь: “Багш аа, би Таныг даган гэрээс гаръя, намайг шавиа болгон хүлээн авах уу?” гэвэл Багш нь: “Хүлээн авна” гэнэ. Тэр өдрөөс эхлэн тэр даруйдаа Багш нь түүнд гэрээс гарагчийн хувцас бэлдэнэ. Эхлээд биеийнх нь хэмжээг авсны дараа худалдан авахаар явна, худалдаж аваад нэгэн газар хадгална. Учир нь цаг нь арай болоогүй, эсвэл өмсөхөд арай тэнцэхгүй байгаа тул түүнийг өмсөх цаг нь болтол би тэнд хадгална.

Энэ нь авшиг хүртсэний дараа ч мөн адил байна, Багш нь та бүхний хутагтын байр суурийг бэлдсэн бөгөөд та бүхэн өнө үүрд туулан гэтэлчихсэн. Гэвч хаяж одно гэвэл бас чөлөөтэй, энэ нь танаас хамаарна. Төрөл төрөлдөө хүссэн газраа явж болно. Гэхдээ маш их удаан хүлээсний эцэст л сая Багштайгаа дахин уулзаж чадна. Багштайгаа уулзахгүй байх боломжгүй, гэхдээ та нар нилээд зовж шаналж, уйтгарлан бухимдаж, гашуудан гуниж, төөрч тэнэх болно. Энэ тоост хорвоод хэд хэдэн удаа дахин төрж, бүр тамд ч унах болно. Хэрвээ та тэнд очих дуртай бол Багш нь ч бас таныг явуулна.

Тиймээс болгоомжтой байх хэрэгтэй. Хэрэв та нар энэ нэгэн төрөлдөө туулан гэтлэе гэвэл Их Багшийн хүч болон Арьяабалын бясалгалын аргад итгэх хэрэгтэй. Энэхүү Аялгуу нь Их Багшийн хүч, өөрөөр хэлбэл та нарын Багш мөн. Багш гэдэг нь энэхүү махан биеийг зааж байгаа биш. Бие махбод бол зөвхөн нэгэн багаж юм, учир нь энэ хүч эрхбиш нэгэн бие махбодоор дамжиж байж л сая түгэн тархаж чадна. Яг л цахилгаантай адил, цахилгаан нь цахилгааны утас, гэрлийн шил байхгүй бол гэрэл цацрааж чадахгүй. Үүний нэгэн адил, зөвхөн энэхүү цахилгаан хүчинд итгэж байж л сая Гэрэлтэй болж, сая туулан гэтэлж чадна.

Иймээс өнгөн талыг харах хэрэггүй, “Би энэ хүнд дургүй,

энэ хүн яагаад ийм дүртэй вэ?, Тийм байхгүй яасан юм бол?” гэж бүү бод. Танд энэ нэг нь таалагддаг байхад харин түүнд тэр нэг нь таалагддаг бол яах вэ? Тиймээс гадна төрхийг бүү тоо. Тэр хүн дотооддоо цахилгаантай л байвал болох нь тэр. Нэгэн гэрлийн шилний хэлбэр дүрс хүн бүхэнд таалагдаж, тэднийг сэтгэл хангалуун болгох боломж байхгүй, гэхдээ энэ нь бидэнд гэрэл гэгээ өгч, ном унших боломж олгож байвал болох нь тэр, энэ нь л хамгийн чухал юм.

Олон нийтийн газарт хувь хүн онцгойрч болохгүй, хэрвээ та бүхэн өөрийн гэсэн хувийн өнгө төрхтэй байхыг хүсэж байвал, жишээ нь, тодорхой нэгэн дүр төрхөд дуртай бол түүнийгээ өөрөө хөгжүүлж болно, хожим та тийм дүр төрхтэй болно. Тэр ч байтугай хэрэв та Багшийнхаа төрх байдалд дургүй бол өөрийгөө хөгжүүлж, өөрийн дуртай царай төрх, өөрийн дуртай зан араншиндаа хувирч болно. Багшийнхаа гадаад төрхийг шүүмжлэх шаардлагагүй. Тэр юу хийсэн ч бай та бүхэн ойлгохын аргагүй. Бусдыг загнаж зэмлэвэл түүнийг догшин ширүүн гэнэ, бусдыг сөгдүүлвэл түүнийг хатуу чанга гэнэ. Энэ нь тийм биш юм. Үнэндээ тэр юу ч хийсэн зуун хувь бүгд зөв байдаг. Та бүхэн эгэл хүмүүс учраас ойлгохгүй байгаа хэрэг. Багш нь хэзээ ч бурууддаггүй бөгөөд буруудаж болдоггүй.

Та нар хүмүүсийг зөвхөн гаднах дүр төрхөөр нь хардаг. Тэнд суух хөршийн эзэгтэйг харах үедээ тун номхон даруу хүн юм гэж бодно. Харин түүнийг хэр номхон дарууг та мэдэхгүй. Гэртээ бол тэр бүсгүй эр нөхрийнхөө толгой дээр гарсан, гэрийнхэндээ байнга төвөг уддаг даварсан нэгэн. Гаднаа номхон зантай, даруухан бүсгүй мэт харагдавч бодит амьдрал дээр огт өөр.

Тиймээс бусдыг гадаад үзэмжийг нь харж дүгнэх дэмий. Хэрэв Багш нь хэн нэгнийг загнаж байвал лавтай учир шалтгаантай байх ёстой. Та нар зөвхөн итгэж байж л гэгээнтний дэсэд хүрч чадна, эс бөгөөс эгэл хүний оюун ухааны түвшинд тэмцэлдээд тэндээ гацаж орхино шүү, “Багшийн ингэж ярих нь сайн уу, муу юу? Багш яагаад ингэж ярьдаг вэ?” гэх мэтээр үргэлж боддог. Эдгээр нь бүгд л уураг тархины маргах мэтгэлцэх хүрээнд байж, оюун санааны түвшинд харьяалагддаг, харин богд гэгээнтний дэс биш.

Оюун ухааны дэс нь богд гэгээнтний дэстэй адилгүй. Сайн муу, ухаантай тэнэг зэрэг нь оюун ухааны дэсэд харьяалагддаг. Эдгээр нь бүгд өнгөн талын зүйл бөгөөд бүгд л “асуулт ба хариулт”-ын дотор байна. Бидэнд мөн л асуулт, хариулт байж,

мөн л нэгэн хариултыг “олох” гэж байгаа л бол бидний дэс оюун ухааны түвшинд л байсаар байна гэдгийг мэдэж болно.

Тиймээс Бодьдарма өөрийн таван шавийн дэсийг шалгах үед Хүйкэ (Хятадын Даяаны бүлгийн хоёрдугаар үеийн Өвөг Багш)–гийн ээлж болоход багшдаа мөргөөд хажуу тийш зогсон юу ч дуугарсангүй гэнэ. Гэтэл зөвхөн тэр л ганцаараа мөрийн хутагт хүрч, залгамжлагчийн дэсийг олсон байв. Бусад дөрвөн шавийн хувьд багш нь асуулт асуумагц: “Миний бодлоор бол...” гээд л шууд хариулж байлаа. Мэдээж Бодьдарма бас тэдний дэсийг тодорхойлж, “Та миний арьсанд хүрчээ, та миний ясанд хүрчээ, та миний маханд хүрчээ, та миний цусанд хүрчээ гээд харин Хүйкэ миний чөмгөнд хүрсэн байна” гэсэн билээ.

Хүйкэ тэр үед маргах юу ч ярих шаардлагагүй байв, учир нь тэр хэдийнээ оюун бодлын тэмцлээс хэтийдэж, маргаан мэтгэлцээн, шүүн дүгнэлт, сайн муугийн дэсийг давж гарсан байлаа. Тэр үед л сая жинхэнэ төгс төгөлдөр болдог.

Мөн л асуулт, эсвэл эргэлзээ байх нь мэдээж, бас зүгээр. Учир нь бидний дэс ямар байна, тиймээрээ л байх ёстой. Бид дүр эсгэж, өөрийгөө мэхэлж: “Одоо надад ямар ч асуулт байхгүй. Би Багшийгаа хармагц яримаар юмгүй болдог. Би хэдийнээ “хов хоосон”-ы дэс, “ялгал үгүй”-н дэсийг олж авсан, юу ч ярих шаардлагагүй болов.” гэж хэлж болохгүй. Ингэж бодож ч болохгүй. Багшийгаа мэхэлж болохгүй бөгөөд хамтран бясалгагчдыг ч мэхэлж болохгүй. Бясалгагч хүн “их худал үг” ярьж болохгүй. “Их худал үг” гэдэг нь хүрээгүй дэсдээ хүрсэн гэж ярихыг хэлнэ. Энэ бол буруу. Багшийнх нь санаа бол хэрэв та нарт мөн л асуулт, эсвэл эргэлзээ байсаар байгаа бол дэс тань хүний оюун ухааны түвшинд байсаар байна гэсэн үг гэдгийг л ойлгуулах гэсэн юм.

Гэхдээ зөвхөн таны дэс дэндүү доогуур, Багшийгаа ойлгож чадахгүй байна гээд Багшаасаа, эсвэл бясалгалын аргаасаа холдож болохгүй.

Та нар өөрийгөө таних хэрэгтэй, “Өөрийгөө ч таниад өрөөлийг ч мэдвэл зуунтаа байлдавч зуунтаа ялна.” гэгч болно.

Энэ нь Багш нь та бүхнийг “Хов хоосон”-ы дэсэд даруй хүрэхийг шаардана гэсэн үг биш бөгөөд хэрэв та нарт эргэлзээ байвал Багш нь уурлана, эсвэл та нарыг үл хүндэтгэнэ гэсэн үг биш юм. Энэ бүхнийг ярьж буйн учир нь, та нарыг өөрийнхөө дэсийг мэдэж, илүү сонор сэрэмжтэй байж, аажуу тайван, хянуур

болгоомжтой бясалгаж, хүрсэн дэсдээ хууртаж болохгүй, бидний төвлөрөл сул байгааг ад чөтгөр далимдуулан биднийг уруу татахыг нь зөвшөөрч бүр ч болохгүй гэдгийг ойлгуулахын төлөө юм. Энэ нь бидний цаг завьг дэндүү их үрдэг бөгөөд бид эрхбиш үхэж төрөхийн сансрын хүрдэнд дахин эргэлдэх хэрэгтэй болдог юм. Ингэх нь даанч харамсалтай биш үү?

Багшийгаа дагаж бясалгах нь үнэхээр амар, мөн туулан гэтлэхэд ч маш хялбар, өдөр бүр Арьяабалын аргаар хамгийн багадаа хоёр цаг хагас бясалгаж, Багшийнхаа сэтгэгдэшгүй их ач буянд итгэж, Багш бол хамгийн дээд дэс мөн гэдэгт итгэхэд л хангалттай, өөр зүйлсийг бүү тоо. Урьд нь та нар юу ч хийсэн бай тэр бүхнийгээ даван туулж чадна. Өмнө нь хичнээн хүнд үйл түйтгэртэй байсан ч хамаагүй бүгдийг угаан арилгаж болно. Тэр ч байтугай энэ тоост хорвоод байхдаа зөвхөн хоёрдугаар ертөнцөд хүртэл бясалгасан байсан ч Багш нь таныг тавдугаар ертөнц хүртэл татна. Энэ дэлхийгээс явахад тань Багш нь ирж, таныг тосож авна. Багш хаана хүрнэ, та тэнд хүрнэ.

Харин та нэгдүгээр ертөнцөд байсаар байвал дээшээ явж чадахгүй. Учир нь нэгдүгээр ертөнцөд шунал хүсэл, уур хилэн, мунхаг харанхуй чанар дэндүү их хэвээр байдаг тул та дээшээ гарахаасаа өмнө хэсэг хугацаанд заавал тэндээ суралцах ёстой. Гэхдээ хоёрдугаар ертөнцөд оччихсон бол Багш нь таныг тавдугаар ертөнц рүү лавтайяа татаж чадна, асуудалгүй. Их Багшийн хүч хэмжээлшгүй бөгөөд сэтгэгдэшгүй их. Тэр ч байтугай “таван үе”-ээр тань дээш татаж чадах байтал ганц таныг яагаад татаж чадахгүй байх билээ? Хэрвээ дээш татаж чадахгүй бол Их Багш байж тэнцэхгүй. Та нар Багшдаа маш их итгэдэг, өдөр бүр чадах чинээгээрээ бясалгаж, маш их хичээн бясалган дадуулдаг байхад Багш нь та бүхнийг дээш татахгүй байж яаж чадах вэ? Бүхэл бүтэн гараг дэлхийгээр нь татаж чаддаг байтал өөрийн шавийг татахгүй байж болох уу? Тиймээс Багшдаа итгэсэн хүн хэзээ ч үхэж төрөхийн сансрын хүрдэнд эргэлдэхгүй гэдгийг мэдвэл зохино. Их Багшид ийм сэтгэгдэшгүй их хүч байдагт хатуу баттай итгэх хэрэгтэй.

Дөнгөж эхлэн бясалгаж буй хүний хувьд гадна талд сэтгэл татах зүйлс их, бидний анхаарал санамсарыг булааж, уруу татдаг. Яг л бяцхан хүүхэд мэт, ээж нь дотор хоол хийж байхад гадаа гудамжны худалдаачин чихэр аваарай, мөхөөлдөс аваарай гэж чангаар хашгирвал мэдээж хүүхдийн сэтгэл уруу татагдаж, гадагш гүйж гарна. Учир нь хүүхдэд будаанаас илүү чихэр, жимс,

хөнгөн зууш амттай санагддаг. Гэвч чихэр хүнийг хордуулж, шүдийг хорхойтуулна, хэт их идвэл биед муугаар нөлөөлнө.

Хүүхэд чихэрт дуртай байдаг нь гаднах цаас нь гоёмсог, идэхэд амттай байдгаас юм, гэвч үнэндээ энэ нь хоруу чанар ихтэй, их идвэл биен дэх амин дэмийг эвдэнэ. Гэвч хүүхэд амтанд нь маш их дуртай, учир нь тэд юу сайн, юу муу болохыг мэдэхгүй, дотор нь хор байсан ч мэдэхгүй. Тиймээс заримдаа хүүхдийн эмийг үйлдвэрлэхдээ их гашуун эмийг гадуур нь чихрээр бүрдэг. Хүүхэд бас дуртайяа уудгийн учир нь тэдгээр эм гаднаасаа эрээн мяраан гоёмсог өнгөтэй харагдах төдийгүй, амт нь гоё тул дотроо гашуун эмтэйг нь мэддэггүй.

Сүнслэг бясалгал дөнгөж дадуулж эхэлж буй хүн хүүхэд шиг байж болохгүй. “Мөхөөлдөс, чихэр, жигнэмэг аваарай.” гэж хэн нэгний хашгирахыг сонсонгуутаа хүүхдийн сэтгэл шууд л татагддаг. Хэдийгээр “Бие” нь Багштайгаа бясалгаж байвч “сэтгэл зүрх”-ээ бүрэн зуун хувь Багшдаа өргөхгүй, нэгээхэн хэсгийг гадна үлдээж, өөр багш нар дээр очно, бусад хийдэд мөргөнө, эсвэл аль нэг сахиусыг зөнтэй, шидтэй гэж сонсвол очиж туршиж үзнэ, тэгээд хэдий их адислуулбал төдий сайн гэж бодно. Ийм шуналын сэтгэл маш муу, өөртөө нүгэл хурааж, дэсээ гацааж, дахин дээшлэх хүртэл удаан хугацаа шаардагдах болно.

Ингэж энд тэнд замбараагүй явбал хог новш цуглуулна. Хог новшоо эрдэнэс болгохыг оролдоно. Өөрийн эрдэнэсийг сайтар зүлгээгүй атал хог новш сонирхохоор өдөр бүр явж, бөөн хог цуглуулаад түүнийгээ өөрийн эрдэнэсийн дээр овоолж, эрдэнэсээ дарчихдаг. Энэ нь үйл түйтгэртэй адилхан, хэрэв та өдөр бүр гадагш гарч, олон янзын үйл түйтгэр цуглуулаад байвал бясалгалын дэвшил тань удаан байх нь мэдээж.

Та бүхэн хэнтэй ч уулзахыг хүссэн хамаагүй, зүгээр багш нь хөндлөнгөөс оролцохгүй. Гэхдээ энэ бол ад чөтгөрийн хүч, ямар ч ач тусгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Багш нь хэдийнээ ихийг үзсэн тул мэднэ. Үнэндээ надад үүнийг харах шаардлага байхгүй. Багшид нь мэдэхгүй зүйл байхгүй гэдгийг Багш нь бас мэднэ. Би гэртээ юу ч хийж байсан Багш мэдэхгүй гэж бодвол эндүүрэл. Багш нь зүгээр л энэ тухай ярихыг хүсдэггүй. Үүнийг ярих ямар утга байна вэ? Ямар хэрэгтэй байхав дээ. Та бүхэн Багшдаа итгэхгүй бол үйл түйтгэрийг нь өөрсдөөр тань шийдвэрлүүлнэ. Та бүхэн юу ч хийсэн бай: “Багш заавал мэдчихнэ.” гэж бодох хэрэгтэй. Тиймээс хийхээсээ өмнө эхлээд ингэж хийх нь зөв болов уу? Багш зөвшөөрөх болов уу? Энэ нь миний бясалгалд ач

тустай юу гэж бодвол зохино.

Багш нь өнөөдөр та бүхэнд Багшид нь мэдэхгүй зүйл байхгүй гэдгийг шуудхан хэлье. Хэрвээ Багш нь мэддэггүй бол эгэл хүн гэсэн үг, тэгэхээр та нар Ням гараг бүр энд ирж ном сонсож, бясалгах шаардлагагүй. Ийм хол явж ирэх нь цаг заваа дэмий үрсэн хэрэг болох биш үү? Та нар уул, усыг тахиж, ясанд (relic ринсэл шарил) мөргөсөн нь дээр, ингэж дасгал хийх нь илүү зугаатай. Та нар бүлэгт элсэж, найз нөхөдтэй болж болно, нийгмийн уур амьсгал бүрдэнэ. Гэтэл яагаад ийм хол газар ирсэн юм бэ?

Хэрвээ Багш бүхнийг мэддэг гэж мэдэхгүй, Багш хаа сайгүй оршин байдаг гэдэгт итгэхгүй бол та нарыг энд ирэх хэрэгтэй гэж би бодохгүй байна, ирсний ач тус гарахгүй. Багш нь та нартай өдөр бүр хамт байдаг, Багшид нь байхгүй газаргүй, мөн мэдэхгүй зүйл гэж байдаггүй гэдгийг та нар ойлгох хэрэгтэй.

Заримдаа Багш нь та нарыг загнахад яагаад загнасныг та нар мэддэггүй. Хэдийгээр Багш нь үүнийг тайлбарладаггүй ч та нарын үйл түйтгэр дэндүү их байгаа учраас заавал угаах хэрэгтэй гэдгийг би хардаг юм. Багш нь та нарыг өрөвддөг. Хэрэв та нар дэндүү их хог новш авч ирвэл хожим цэвэрлэж барахгүй, тиймээс энэ завшааныг ашиглан аажмаар нэг хэсгийг нь угааж өгдөг. Багшид нь яагаад таныг загнаснаа хэлэх шаардлага байхгүй, тайлбарлах шаардлагагүй бөгөөд тайлбарлах ч ёсгүй. Та нарын хувьд бол Багшид мэдэхгүй зүйл гэж байхгүй гэдгийг мэдэх нь л хангалттай.

Тиймээс заримдаа Багшдаа загнуулбал эхлээд өөрөөсөө: “Би ойрд ямар алдаа гаргасан билээ? Бусдад мэдэгдэхийг хүсдэггүй нууц зүйл юу билээ.” гэж асуух хэрэгтэй. Загнуулах үедээ шууд л: “Тэр авшигтан л Багшид хэлсэн байх. Тэрнээс биш Багш яаж мэдэх вэ?” гэж бодох хэрэггүй. Би яагаад мэдэхгүй байх юм бэ? Надад хэн ч ирж хэлэхгүй, тиймээс бусдыг буруутгах хэрэггүй. Ингэж бодох нь буруу. Энэ бол өөрийгөө уучлах шалтаг хайж байгаа л хэрэг.

Уг нь та нар үнэн сэтгэлээсээ өөрийгөө шинжвэл шууд л мэднэ. Их Багш та бүхэнтэй нэгдмэл нэг учраас та бүхэн юу ч хийсэн бай Их Багш бүгдийг ойлгож, мэдэж байдаг. Үүнийг хэн ч мэдээлэх шаардлагагүй. Түүний дэс махан биед байхгүй бөгөөд Тэр энд байдаггүй. Багш нь бол энэ бие махбод биш. Магадгүй та бүхэн Багш яагаад энэ бие махбод биш вэ гэдгийг хараахан

ойлгохгүй байгаа байх.

Авшиг хүртсэний тань дараа Багш нь та нартай нэгдмэл нэг болдог. Нэг л өдөр та Багш нь та бүхэнтэй хамт алхаж, хамт хооллож, хамт ажиллаж, хамт өглөг үйлдэж, хамт доромжлолыг тэвчиж, хамт хичээнгүйлэн дэвшиж, тантай хамт бясалган сууж, гамшиг тохиолдвол таныг аварч, саад бэрхшээл учрахаас өмнө танд сануулж, таны өмнөөс зохицуулан шийдэж, учрах саад бэрхшээл, гай гамшгийг багасгаж байдаг гэдгийг мэднэ.

Энэ бүхнийг та нэгэн өдөр заавал ойлгоно, тэр үед л сая зууны зуун хувиар итгэх болно. Одоо бол таны итгэл зууны наян хувь, тэр ч байтугай зууны нэг хувь төдий л байгаа. Бүр зөвхөн зууны нэг хувийн итгэл байсан ч болно. Тэр жаахан итгэл, ядаж л зууны нэг хувийн тэр итгэл дээрээ түшиглэн та бясалгаж болно. Бусад номын багш бол танд жаахан ч итгэл төрүүлж чадахгүй. Тэр багш таныг адисалж чадна гэдэгт та итгэхгүй. Тэд зөвхөн судар л ярьж чаддаг гэж та боддог. Тэдний бясалгал нилээд давгүй байж мэднэ. Гэвч та тэднийг тантай хамт байна, таныг туулан гэтэлгэж чадна гэдэгт итгэхгүй. Зөвхөн Багшийгаа дагавал ийм итгэлтэй болно. Хэрвээ танд тийм итгэл байхгүй бол Багшаасаа суралцах ямар ч хэрэггүй.



“БОДЬ МӨР”-НИЙГ ОЛСОН ЖИНХЭНЭ ИХ БАГШИЙН СОРОНЗОН ТАЛБАЙН ТАТАХ ХҮЧ ХЯЗГААРГҮЙ ИХ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Пэнхү. 1987 оны 4 дүгээр сарын 22.
(Эх нь хятад хэлээр)*

Авшиг хүртсэний дараа Багшийгаа харахад нилээд хялбар байдаг. Гэртээ бясалган сууж байхдаа Багштайгаа уулздаг хүн Пэнхүд олон. Иймээс хэрэв та бүхэн үнэхээр Багшийгаа санаж үгүйлж байвал авшиг хүртэж, бясалгал хийх хэрэгтэй. Энэ нь зөвхөн та нарт тустай төдийгүй, Багшид нь ч бас хэрэгтэй, учир нь хожим Багш нь та нартай уулзахын тулд энэ махан биеэ ашиглах шаардлагагүй болно. Та нар гэртээ бясалган сууж байхдаа зурагт үздэгтэй тань л адил байна, Багш нь та нарын үл үзэгдэх зурагт дотор илрэх болно.

Ихэнх хүн өөрийгөө энэ бие махбод гэж боддог, тиймээс бие нь өвдвөл өөрийгөө өвдөж байна гэж бодно. Энэ бие хайртай хүмүүсээсээ хагацвал би хагацав гэж бодно. Үнэндээ бол бид энэ бие махбод биш. Хэрвээ энэ үнэн учрыг мэдэхгүй бол аливаа гуниг зовлон багасахгүй, хэрэв бид үүнийг мэдвэл зовлон гуниг маш их багасна.

Махан бие нь хувцастай адилхан, гадна талд байх бие махбод гэдэг хувцаснаас гадна дотоодод өөр нэгэн хэрэглээгүй хувцас бий. Яагаад бид бясалгагч хүн маш эрх чөлөөтэй гэж ярьдаг вэ? Учир нь тэд хамгийн гадна талын биеийг эвдэж, дараа нь түүний доторх өөр нэгэн биеийг эвддэг. Түүний дотоод талд илүү нарийн

өөр нэгэн бие байдаг бөгөөд түүнийг ч бас эвдэх ёстой. Хамгийн багадаа энэ гурван төрлийн биеийг эвдэж чадсан хүнийг эрх чөлөөт болсон хүн гэж хэлж болно.

Энэ гурван бие нь Гурван ертөнцтэй харилцан холбоотой байдаг, тиймээс бид тэднийг “Гурван ертөнц” гэж нэрлэдэг, эсвэл бас “Гурван төрлийн бие” гэж нэрлэж болно. Энэ хоёр нэршил нь бараг ижил. Бид эдгээр хувцаснаасаа салж чадвал эрх чөлөөт хүн болж чадна. Хэрэв бясалгаад илүү дээшилбэл “Түүнчлэн ирсэн”-ий түвшинд хүрэх болно.

“Түүнчлэн ирсэн” гэдэг нь тийм ч гүн нууцлаг зүйл биш бөгөөд хүрэхэд ч хэцүү биш. Бид бүгд бясалгал хийх нь тун хэцүү, дэндүү нууцлаг, бидний хувьд “Бодь мөр”-ийг олох бэрх гэж боддог. Үнэн хэрэгтээ энэ нь тийм биш. Бясалгал хийх нь шинжлэх ухаантай ижил, алхам алхмаар урагшилж, алгуурхан суралцсанаар хожим нь сургуулиа лавтай төгсөж чадна. Тийм биш бол Шагжамуни Будда яаж “Бурханы хутаг”-т хүрч чадах вэ? Эртнээс нааш өнөөг хүртэл олон хүн эрх чөлөөгөө олж, өндөр дээд дэсэд хүрсэн боловч тэдний нэр алдар түгээгүй учраас бид мэддэггүй.

Тэдгээр их багш нарын дотроос хэдхэн хүний нөхцөл байдал нилээд онцгой учраас нэр алдар нь түгж, хожмын хүмүүс зөвхөн тэд л “Түүнчлэн ирэгсэд” мөн хэмээн бодох болжээ. Үнэндээ Хималай ууланд одоо ч гэсэн маш олон их бясалгагч байдаг. Хэрэв бид тэднээс нилээд олонтой нь танилцвал тэднийг Шагжамуни Буддагаас ч өндөр дэстэй юм гэж бодох нь лавтай.

Бодит байдал дээр мэдээж тийм биш, гэхдээ яагаад бидэнд тийм бодол төрөв? Учир нь хэдийгээр бид Шагжамуни Будда энэ дэлхийд заларч байхдаа асар их хүчтэй, ид шидтэй байсан гэдгийг мэдэх ч, Түүнд бас илрүүлээгүй өөр олон янзын хүч байсан бөгөөд тэмдэглэгдэж үлдээгүй өөр олон олон үйл явдал болж байжээ. Тиймээс бид Шагжамуни Буддагийн жинхэнэ чадвар хийгээд хүч чадлыг мэдэхгүй.

Учир нь бидний мэдээгүй зүйлс их байсаар байдаг. Жишээ нь, Шагжамуни Буддагийн амьдралын талаар бид тийм ч их зүйлийг ойлгож чадахгүй, ихдээ л бусдын бичсэн судар номоос бага зэрэг ойлгодог. Гэхдээ тэдгээр судар ном Шагжамуни Буддаг амьд сэрүүн байх үед бичигдээгүй, харин Түүнийг нирвандаа буцаад гурван зуун жил болсны дараа л бичигдсэн байна. Тиймээс маш олон тэмдэглэл оновчтой биш бөгөөд гээж орхигдуулсан

зүйлс их, учир нь Түүний гарамгай сайн шавь нар нь хэдийнээ энэ дэлхийг орхин одсон тул олон зүйлийг тэмдэглэн үлдээх боломжгүй байжээ.

Яг л Багш нь илүү гүн гүнзгий ёс учрыг зөвхөн шавь нартаа л заахаас биш, бусад гадны хүнд заадаггүй шиг юм. Авшиг хүртэх хүсэлгүй хүнд мэдээж гүнзгий ёс учрыг сонсгож болохгүй. Учир нь тэнгэрийн нууцыг задруулж болохгүй. Хэдийгээр би нилээд олныг задруулсан ч зөвхөн шавь нартаа л задруулсан. Орчлон ертөнцийн хууль ийм байдаг, олон нийтийн газар гүн нууцлаг зүйлсийг ярьж болохгүй. Учир нь та бүхэн миний ярьсан ёс учрыг ойлгохгүй.

Жишээ нь, нэгэн хүн өмнө нь Тайбэйд очиж байсан, мөн хэд хэдэн удаа хоноглож байжээ. Харин та хэзээ ч Тайбэйд очиж байгаагүй бол тэр хүн танд: “Тайбэй хотын Жуншаны Хойд Замын буланд нэгэн сайхан кофены газар бий, та мэдэх үү.” гэж асуувал та ойлгохгүй. Харин өмнө нь тэнд очиж байсан хүнд хэлбэл тэр хүн дорхноо ойлгоно. Бид найздаа гүн нууцлаг зүйлийн талаар ярих үед гадны хүн ойлгохгүй.

Эхнэр, нөхрийн хувьд ч бас ижил, тэдэнд хувийн нууц мэдээж бий. Тиймээс нөхөр нь ярмагц эхнэр нь шууд ойлгоно, эсвэл эхнэр нь сануулмагц нөхөр нь шууд толгой дохино, гэвч тэдний юу яриад байгааг дэргэдэх хүн ойлгохгүй.

Сүнслэг бясалгалын хувьд ч мөн адил, дотоодын ахуй ойлголтоо гадны хүнд хэлж болохгүй. Гэвч заримдаа Багш нь баярласан үедээ бага зэрэг задруулдаг тал бий. Түрүүн бид Пэнхүд байхад Багш нь бас жаахан цухуйлгасан, хэт их ярих нь тийм ч сайн зүйл биш, учир нь ахуй ойлголт бол үг хэлтэй адилгүй.

Жишээ нь, Багш нь жигнэмэг их амттай гэж яривал, тэр нь жинхэнэ жигнэмэг биш, миний санааг ойлгов уу? Хэрвээ би ингэж дэндүү их яривал та нар хэдийгээр жинхэнэ жигнэмэгийг нь идээгүй ч Багш нь олон дахин ярихыг сонссон тул уураг тархи тань та нарыг мэхэлж: “Жигнэмэг ямар байдгийг би аль хэдийн мэднэ.” гэнэ. Ийм санаа бодолтой болсны дараа жинхэнэ жигнэмэгийг амталж үзэх хүсэлгүй болдог, тийм биз?

Багш нь өнгөн талын ёс учрыг ярих дуртайдаа биш, харин нийтийн дунд гүн нарийн ёсыг ярьж болохгүй. Хэрвээ хэн нэг хүн гүн нарийн ёсыг суралцах хүсэлтэй бол ирээд Багшийгаа даган суралцах хэрэгтэй. Гагцхүү тэр үед нь л би түүнд тайлбарлаж өгч чадах юм. Жишээ нь, хэрвээ та хэзээ ч Анагаахын сургуульд сурч

байгаагүй, эсвэл шүдний эмчийн мэдлэг эзэмшээгүй бол нэгэн шүдний эмч танд анагаах ухааны илүү гүн мэдлэгийн талаар яривал та ойлгохгүй байх болно, тийм биз? Шүдний эмчийн эхнэр ч ойлгохгүй байхад бид яаж ойлгох вэ?

Багшийг дагаж гүн нарийн ёсонд суралцах ч мөн адил. Бид өөрсдөө ахуй ойлголттой болох хэрэгтэй. Бусдын ахуй ойлголтыг сонсох нь ач холбогдолгүй. Өөрөө ахуй ойлголттой болбол огт өөр. Тэр үед бид Авид Бурханы судрыг уншихдаа уг сударт бичигдсэн олон янзын түвшний тухай ойлголттой байх бөгөөд үзэсгэлэнт цэцэг, найман эрдэнийн рашаан, бяцхан шувуудын киргээн зэргийг бүгдийг нь ойлгож чадна.

“Оточ Манал Бурханы судар”-т дорно зүгийн Оточ Манал Бурханы ач буяныг дурдаад Түүний орны газар нь болор эрдэнэ, тэнгэр нь шижир алт гэхчлэн бичсэн байдаг нь бүгд дотоодын ахуй ойлголт бөгөөд Шагжамуни Буддагийн шавь нар бясалган суух үедээ үзсэн зүйлс юм, тэгээд тэд бичиж үлдээжээ. Миний шавь нар ч бас ийм төрлийн ном судар бичиж чадах бөгөөд тэр ч байтугай тэдний ахуй ойлголт үүнээс ч илүү байж мэднэ. Миний шавь нарын дунд цөөнгүй хүний ахуй ойлголт нь Авид Бурханы сударт тэмдэглэсэн, Оточ Манал Бурханы сударт бичсэн ахуй ойлголтоос ч илүү сайн байдаг. Гэхдээ би энэ бүхнийг ярьсан ч энэ нь бас сонирхолтой биш.

Тэр өдөр нэг хүн надаас: “Хэдийгээр Авид Бурханы сударт Баруун зүгийн Төгс баясгалант орон найман эрдэнийн рашаантай, газар нь шижир алтаар бүрхэгдсэн гэж тэмдэглэсэн байдаг ч үүнийг би уйтгартай гэж боддог, бид яагаад тэнд төрөх ёстой юм бэ?” гэж асуусан. Түүний хэлж байгаа нь зөв. Надад заримдаа Авид Бурханы судрыг унших үед тун уйтгартай санагдан Авид Бурханы оронд очих сонирхолгүй болдог. Яагаад вэ? Учир нь энэ түвшин нь хэдийгээр жинхэнэ ахуй ойлголт мөн боловч бусад яримагц хүч нь алга болдог. Тиймээс бид сударт бичсэн зүйлсийг унших үедээ энэ газар юугаараа тийм сайхан бэ? Би яагаад нас нөгчсөнийхөө дараа тэнд төрнө гэж андгайлах ёстой юм бэ? Баруун зүгийн Төгс баясгалант оронд төрөхийн төлөө яагаад ингэж их шаргуу бясалгах хэрэгтэй вэ гэж боддог.

Үнэн шүү, би ч бас өмнө нь ингэж боддог байсан. Арьяабалын аргаар бясалгахаас өмнө надад Авид Бурханы тарнийг уншихыг заасан, тиймээс би түүнийг уншдаг байлаа. Учир нь надад үүнээс өөр сонголт байгаагүй. Гэсэн ч сэтгэлдээ: “Би тийм сайхан газар төрөөд юу хийнэ гэж? Би эрдэнэст дурлахгүй, найман эрдэнийн

рашаанд шунахгүй, тансаг сайхан орд харшид амьдрах хүсэлгүй, ийм юм чинь Төгс баясгалант оронд төрөөд юу хийхэв дээ?” гэж боддог байв. Яг тэр хүн шиг би үргэлж өөрөөсөө яагаад гэж асууж байсан.

Учир нь дотоодын ахуй ойлголтыг ярьж болохгүй, яривал тэр гайхамшигт гоо сайхан, суу алдар, сүр жавхлан нь алга болно. Жишээ нь, Ши Шы-г хятадын хамгийн үзэсгэлэнтэй, гоо сайхан бүсгүй гэж сонссон. Гэсэн ч бид түүнийг ямархан гоо үзэсгэлэнтэй нэгэн болохыг төсөөлж чадах уу? Ши Шы гайхамшигтай гоо үзэсгэлэнтэй, улс орон даяараа түүнийг дур булаам гэж үздэг байсан гэж сонссон ч энэ дүрслэл нь Ши Шы өөрөө биш юм. Хэрэв бид зөвхөн энэ дүрслэлийг унших юм бол мэдээж уйтгартай юм гэж бодох байсан, тийм биз?

Дотоодын ахуй ойлголтын хувьд ч мөн адил. Хэдийгээр та нар сонсохыг хүссэн ч би энэ талаар ярихдаа дурамжхан байдаг. Учир нь ярих аргагүй байдаг. Тэр ч байтугай би яримаар байсан ч энэ нь бүрэн бүтэн болохгүй, учир нь энэ дэлхийн үг хэл хязгаарлагдмал, тиймээс би яаж ч ярьсан бай энэ нь бодит байдалтай нийцэхгүй. Нөхцөл байдал нь өөр байна. Үг хэлээр илэрхийлэхээр л болчихдогсон бол бид яагаад гэрлэх хэрэгтэй болдог вэ? Зүгээр л нэг ном худалдаж аваад уншчихад л хангалттай.

Тэр номд: “Энэ бүсгүй ямар үзэсгэлэнтэй вэ, түүний гоо үзэсгэлэн ямар нүд баясгам сайхан бэ!” гэхчлэн тун тодорхой бичсэн байдаг. Энэ нь л хэдийнээ хангалттай биш үү, гэрлэхийн тулд яагаад заавал жинхэнэ бодит хүн олох хэрэгтэй вэ? Учир нь бичсэн зүйл бодит байдлаас өөр байдаг. Тиймээс гүн нарийн дотоод ахуй ойлголтыг ярина гэдэг бүр ч амаргүй. Эртний хүмүүс: “Даяанд үг хэрэггүй.” гэдэг нь ийм утгатай юм.

Одоо Багшийнх нь шавь нар ч мөн адил. Би тэдэнд ахуй ойлголтоо ярихыг зөвшөөрдөггүй, тиймээс та нар зөвхөн Шагжамуни Будда л тийм ахуй ойлголттой байсан бөгөөд Тэр л диваажин, тамын оронд хүрч чадна гэж боддог. Үнэндээ бол миний шавь нар ч тэгж чадна, ямар ч ялгаагүй. Бясалгал хийдэг л бол ахуй ойлголттой болно. Мэдээж шавь болгон бүгд тийм их ахуй ойлголттой байдаг биш. Гэхдээ ахуй ойлголттой хүмүүс бий. Учир нь тэдний дэс нь өөр, бас бясалгалын хүч нь ч өөр байдаг. Энэ нь тэдний өөрсдөө хэр их хичээл зүтгэл гаргасантай холбоотой. Миний шавь нарын ахуй ойлголт маш их, та бүхэн мэдэхгүй л болохоос. Тэр ч байтугай хэрэв тэд ном болгон хэвлүүлье гэвэл чадна. Гэхдээ би тэдэнд ярихыг зөвшөөрдөггүй,

учир нь энэ тухай ярих нь тусгүй гэдгийг би мэднэ. Хэрэв бусад хүн тэр үзэсгэлэнтэй түвшнийг ойлгож чадахгүй бол буруушааж, гүтгэнэ, элэг доог хийнэ. Хэрэв хүмүүс элэг доог хийвэл та энэ ахуй ойлголт нь онцгой зүйл биш гэж бодох болно. Гэхдээ тэд ийм ахуй ойлголттой болсноор бие, сэтгэл нь хувирч, далд ухамсар нь өөрчлөгдөж, туйлын их аз жаргалтай болж, билиг ухаан нь нээгдэнэ, энэ бүх өөрчлөлт хувиралт нийлээд тийм ахуй ойлголтыг бий болгодог гэдгийг мэддэггүй. Тиймээс ямар нэг түвшнийг хараад л болчих биш, харин хамгийн гол нь гэвэл, тэд тийм ахуй ойлголттой болсны дараа уг хүн нь бүхэлдээ өөрчлөгдөн өмнөхөөсөө тэс өөр хүн болон хувирдаг нь юм. Жишээ нь, магадгүй та бүхэн надаас: “Багш яагаад ном тайлахдаа ийм урсам сайхан ярина вэ? Багш яагаад Дээдийн Ном уламжилж чадна вэ? Яагаад зарим хүн Багшийг харахаараа нулимс унагахгүй байхын аргагүй байдаг юм бэ? Авшиг хүртээгүй байхдаа ч яагаад Багшийг ингэтлээ их санан дурсана вэ?” гэж асууж магад. Учир нь Багш нь ахуй ойлголттой болж, өөрийгөө өөрчилсөн юм. Харахад өмнөхтэйгөө адилхан тэр хүн хэвээрээ байх боловч дотоод далд ухамсар нь өөрчлөгдөж, билиг ухаан нь ч бас хувирсан бөгөөд өөр хүн болсон, өмнөхөөсөө огт өөр болчихсон хэрэг.

Хүн бүхэнд өөрийнх нь соронзон талбайн хүч байдаг. Хэрвээ хоёр соронзон талбай нь зохицолдвол харилцан таталцана. Ихэнх хүн эцэг, эхээсээ холдож чаддаг хэдий ч эхнэр, эсвэл нөхрөөсөө салж холдох гэдэг тун амаргүй байдаг. Учир нь тэдний соронзон талбай тун эв найрамдуу, тун зохицолдсон байдаг болохоор харилцан хайрлан дурлана.

Сүнслэг бясалгалын хувьд ч мөн адил, бясалгал дээшилсний дараа бидний соронзон талбай улам хүчтэй болдог, иймээс зөвхөн нэг хүнийг татах бус нэг зуу, нэг мянга, нэг түмэн хүнийг татах нь ч асуудалгүй болдог. Биднийг харсан ямар ч хүн бидэнд маш их дуртай байдаг, яагаад вэ? Учир нь бясалгал хийх болсноос хойш бидний соронзон талбай өөрчлөгдөж, улам хүчтэй болдог учраас хүмүүс биднийг хармагцаа зөнгөөрөө татагддаг, энэ нь бид хүмүүсийг зориудаар татах гэсэн биш, тэд өөрсдөө л ирдэг.

Шагжамуни Буддаг ном айлдаж байхад харсан хүн болгон Түүнийг хараад ханахгүй, нүд салгалгүй ширтдэг байсан гэж сонссон. Учир нь хүмүүс Түүнд үнэхээр маш их хайртай, удтал уулзаагүй болохоор хичнээн харсан ч сэтгэл нь ханадаггүй байжээ. Миний Багш Энэтхэгт байхад бас яг ийм байсан, тэр бүр бие засах газарт ч орох завгүй болдог.

Бясалгалд зөвхөн бусад хүний гүн нарийн ахуй ойлголт, эсвэл дотоодын ахуй ойлголтуудыг сонсоод л хангалттай болчих биш, та өөрөө ч бас ахуй ойлголттой байх ёстой. Ахуй ойлголт байхгүй бол өөрийгөө өөрчилж чадахгүй. Бусдын ахуй ойлголтыг сонсоод нэмэргүй. Энэ нь яг л шүдний эмч болохоор хэзээ ч суралцаагүй хүн зөвхөн шүдний эмч найзынхаа хэрхэн хүмүүсийн шүд эмчилдэг талаарх яриаг сонсоод л шүдний эмч болох боломжгүйтэй адил юм. Хэрэв олон дахин сонсвол бүр уйдна, сонссоор байгаад залхаж; “Би ер нь шүдний эмч болохоо больё. Сонсоод байхад ямар ч учир утгагүй юм байна.” гэж бодно. Гэтэл тэр өөрөө суралцвал энэ нь маш сонирхолтой болохыг ойлгоно.

Хэрвээ Багш нь өөрийн дотоодын ахуй ойлголт, эсвэл шавь нарынхаа ахуй ойлголтыг бүгдийг та нарт ярьдаг бол энэ нь хэрхэн яаж бясалгах талаар ярьж байгаа биш, харин дотоодын гүн нууцлаг түвшний тухай ярьж байгаа л хэрэг юм. Тиймэрхүү түвшнийг зөвхөн өөрийн биеэр л мэдэрч чадна, тиймээс “гүн нууцлаг” гэж нэрлэдэг. Та нар энэ бүхнийг сонссоны дараа тийм сүрхий санагдахгүй байж мэднэ. Авид Бурханы судрыг тайлах нь маш сэтгэл татам сонсогддог боловч цөөн хэдэн хүний сэтгэлийг л татдаг. Миний хувьд энэ нь ямар ч хэрэгцээгүй. Хэрвээ би Авид Бурханы судрыг унших нь инээдтэй хэрэг гэж хэлбэл намайг буруу номтон гэж шүүмжлэх нь ойлгомжтой. Би үнэнийг л хэлж байна. Учир нь дуу, дүрсний түвшинд гацах нь хамгийн дээд түвшин биш хэвээр байдаг. “Очир огтлогч судар”-т бас: “Дуугаар, дүрсээр Түүнчлэн ирсэнтэй уулзаж чадахгүй.” гэжээ. (Дуу аялгуугаар надад даатгаж, дүрсээр надтай уулзах нь хүмүүний үйлдэх гажуу ёс жам, Түүнчлэн ирсэнтэй уулзаж үл чадна.) Тиймээс бид Авид Бурханы орныг даван туулж байж л сая өөрийнхөө Түүнчлэн ирсэний түвшнийг, эсвэл Түүнчлэн ирсэний төлөв байдлыг хайж олж чадна. Хэрэв Багш нь ахуй ойлголтоо яривал энэ нь мөн л дуу, дүрсний дэсэд байна, эгэл хүний үг хэлээр ярьдаг л бол “хоёрдмол” байна гэсэн үг.

Уг нь би эдгээр зүйлийн талаар ярихыг хүсээгүй, гэвч ямартаа ч ярьж орхилоо. (*Бүгд инээлдэв.*) Учир нь үүнийг ярьж болохгүй, яривал дургүй хүн олон байдаг. Ихэнх хүн Авид Бурхантай их ерөөл барилдлагатай байдаг. Үнэн ёс ийм байдаг, тэр ч байтугай хэрэв үүнийг ярьж болдог байлаа ч ойлгох хүн тун цөөн. Би үүнийг ойлгодог ч нэгэнт ярьсан л бол үнэнийг хэлэх ёстой. Эс бөгөөс ярих хэрэггүй. Үнэн ёсыг ярих амаргүй, Багштайгаа илүү ойр байдаг хүмүүс л гүн нууцлаг ёс учрыг илүү сонсож чадна.

Тийм ч учраас Багшийг нь дагаж гэрээс гарах хүсэлтэй хүмүүс маш олон, учир нь ийм замаар л Багштайгаа хамт байж чадна. Багш нь хаашаа ч явсан тэд хамт явна, тэд хаана ч байсан бай Багш нь ямар ч ном тайлсан бүгдийг сонсож чаддаг. Багш нь ном тайлахдаа урьдаар бэлтгэх шаардлагагүй, бэлтгэхгүй яривал илүү сайн ярьж чадна, эсвэл дөнгөж бясалгаж дуусаад яривал илүү сайн ярьдаг. Шагжамуни Будда ч бас адилхан. Тэрээр ном тайлах бүртээ дөнгөж бясалгаж дуусаад л айлддаг байжээ.

Тиймээс сударт: “Миний сонссоноор: Шагжамуни Будда ийм ийм газарт самадигаас гарсныхаа дараа Анандад хандан..., эсвэл Манзушри бодьсадвад хандан... айлдахыг би сонсов.” гэхчлэн бичсэнийг бид байнга уншдаг. Учир нь Тэрээр самадигаас гараад их шавь нартаа нууцлаг зүйлсийн талаар ярьдаг байжээ. Тиймээс олон хүнд ярьж болохгүй, бас тийм боломж ч байхгүй. Гэхдээ бясалгал дадуулах нь гарцаагүй ач тустай байх болно гэдгийг би батална. Хэрвээ ач тусгүй байсан бол Багш нь яаж ийм болж хувирч чадах вэ?

Та нар яагаад Багшийнхаа ном тайлахыг сонсох дуртай байдаг вэ? Яагаад Багшдаа итгэдэг вэ? Учир нь та бүхэн тийм хүчийг мэдэрч чаддаг ойлгож байна уу? Тэр ч байтугай ярихгүй байсан ч та нар мэдэрнэ. Нэгэн Их Багш, эсвэл их бясалгагч хүмүүнээс асар их хүч цацарч байдаг. Тэр юу ч яриагүй хэдий ч аяндаа Түүнд татагдаж буйгаа хүмүүс мэдэрдэг, тэр ч байтугай яагаад байгаагаа ч мэддэггүй. Тэрээр хүч чадлаа санааныхаа аяар ашиглаж болно, юу хэрэглэе гэвэл түүнийгээ хэрэглэдэг.

Тэрээр хүчээ үг хэлээр дамжуулан бусдыг гэтэлгэдэг, эсвэл нүдээрээ хүчээ дамжуулан хүмүүсийг гэгээрүүлж, дэсийг нь дээшлүүлнэ. Тэр ч байтугай адислах аргаар л хамаг төрөлтнийг бас гэтэлгэж чаддаг. Юуг яаж ашиглах нь Түүний хүслээр байдаг. Гэсэн хэдий ч олон хүн Түүгээр адислуулж, нүдийг нь харж, эсвэл ном тайлахыг нь сонссон ч гэтэлгэгдсэн гэдгээ мэддэггүй. Тиймээс “Очир огтлогч судар”-т: “Хамаг төрөлтнийг гэтэлгэнэ, гэвч гэтэлгэгдсэн төрөлтөн байхгүй.” гэдэг нь ийм санаа билээ. Шагжамуни Буддагийн санаа нь: “Хамаг төрөлтөн Түүгээр хэрхэн гэтэлгэгдсэнээ мэддэггүй.” гэжээ.

Учир нь нэгэн их бясалгагч бусдыг албаар, эсвэл сэтгэл хөөрлийн аргаар өдөөн татаж, өөртөө итгүүлдэггүй. Харин Түүний нүд рүү нь хармагц л хүмүүс гэгээрч чаддаг. Иймээс “Багшийг харснаас хойш миний бясалгал дэвшсэн. Тэр ч бүү хэл бясалгаж суугаагүй, нүдээ аниагүй байх үедээ ч гэсэн маш сайн

ахуй ойлголттой байдаг, бусад хэдэн арван жил бясалгаж суусан хүнээс илүү сайн, илүү их ахуй ойлголттой байдаг.” гэх хүмүүс маш олон байдаг. Энэ бүхэн аяндаа болдог, учир нь нэгэн их бясалгагчийн энергийн соронзон талбай нь асар их бөгөөд хүчтэй. Тэрээр хүмүүсийг гэтэлгэхийн тулд заавал энд байх хэрэггүй, өөр газраас ч мөн адил гэтэлгэнэ, миний санааг ойлгов уу?

Түүнээс асар их хүч түгэж байдаг, энэ нь нүдэнд үл үзэгдэх бөгөөд гэрэл болон хувирвал л сая харж чадна. Гэхдээ тэр гэрэл нь хэмжээ хязгаартай. Харин нүдэнд үл үзэгдэх Түүний хүч чадал нь үнэхээр хэмжээ хязгааргүй байдаг. Тиймээс бид Авид Бурханыг Цаглашгүй Гэрэл хэмээн сайшаан магтдаг юм, учир нь Түүний Гэрэл хэмжээ хязгааргүй. Шагжамуни Буддагийн очсон газар болгон нь тэр даруйдаа хувирч өөрчлөгддөг байжээ. Нэгэн их бясалгагч хүн ч мөн адил, Түүний очсон тэр газар нь өөрчлөгдөж, дэс нь өмнөхөөсөө илүү дээшилдэг байна.

Хэрвээ нэгэн хүн хэдийнээ энд хүрсэн бол (*Их Багш гараараа нилээд өндөр газарт хүрч үзүүлэв.*) Их Багш түүнийг жаахан татахад л илүү өндөр газарт хүрнэ. Хэрвээ тэр хүн угийн маш доогуур газарт байвал Их Багш нар түүнийг дээш татсан ч тэр жаахан ахих төдий л байх бөгөөд дахин нилээд хэдэн удаа татуулж байж л байшингийн дээвэрт хүрнэ. Тиймээс Их Багш нар заримдаа юу ч ярих шаардлагагүй байдаг, гэвч зарим хүн Түүнийг харахын зуурт гэгээрдэг нь ийм учиртай.

Тиймээс бясалгах нь маш их ашиг тустай, бусдын ахуй ойлголтыг сонсох шаардлагагүй, өөрөө бясалгах нь хамгийн тустай. Хэрвээ та нар сонсмоор байгаа бол надад бас яримаар зүйл байхгүй, учир нь би ийм зүйлийн талаар ярьж чадахгүй. Тэр хүчийг ер нь ямар үг хэлээр ярьж илтгэж чадах билээ? Хэрвээ мэдрч чадвал энэ нь бид нилээд мэдрэмтгий, урьд төрөлдөө хэдийнээ бясалгал дадуулж, нилээд өндөр дэстэй болсныг харуулна. Хэрвээ юу ч мэдрэхгүй байвал бид чулуу хэвээрээ, маш доогуур дэстэй байна гэсэн үг. Үнэндээ хэрэв та нар сэргж мэдрэхгүй бол Багш нь ярьсан ч нэмэргүй. “Энэ Багш юу яриад байна вэ? Хүнийг татах хүч яаж байж болох вэ? Би яагаад мэдрэхгүй байна вэ?” гэж боддог. Харин хэдийнээ сэргж мэдрсэн хүний хувьд бол ярихгүй байсан ч тэр ойлгож байдаг.

Багшийг хармагцаа уйлдаг хүн зөвхөн энд ч биш, Тайбэйд ч олон бий. Энэ удаа Багшийгаа дагаж, ном тайлахыг сонсохоор Пэнхүд ирсэн гэрээс гараагүй шавь нарын дунд бас нэг хүн байна. Тэр (*Их Багш нэг авишигтныг заав.*) бас танай уйлах багт орж

болно. Тэднийг яах ч аргагүй. Багш нь заавал хатуу аргаар тэдний Багштайгаа дэндүү зууралдаж байгааг нь эвдэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол энэ махан биенээс зуураад энэ биеийг Багшийгаа хэмээн бодох тул Багшийг хармагц аз жаргалтай санагддаг байна. Гэвч би хэн нэгэн дэндүү ихээр зууралдаж байгааг харвал нилээд хатуу бясалгалын аргыг хэрэглэж, энэ махан биетэй зууралдахгүй болгоно. Хэрэв энэхүү махан биед дэндүү их хүлэгдвэл өөрийнхөө Их Багшийг эрж олохгүй болчихно.

Зарим хүн хэдийгээр Багшдаа их хайртай хэвээр байдаг ч Багшдаа хэдэн удаа загнуулсны дараа тэдний байдал нилээд сайжирч, Багштайгаа тэгж ихээр зууралдахаа болино. За! Та одоо бас Багштайгаа зууралдах уу? *(Их Багш нэгэн авшигтнаас асуухад, Тэгэхээ больсон гэж хариулав.)* Хэдэн сарын өмнө тэр хүн Багшийг харсан даруйдаа авшиг авахаар шийджээ. Тэр бол нэгэн гэрийн эзэгтэй бөгөөд нөхөртэй, хүүхэдтэй, хүүхэд нь насаар бага. Гэтэл авшиг хүртсэнийхээ дараа Багшийг даган гэрээс гарахыг л бодож, нөхөр, хүүхдүүдээ үл тоомсорлон тэд юу ч хэлсэн тоохгүй, тэднийг сонсохгүй болжээ. Шагжамуни Будда энэ дэлхийд заларч байх үед олон хүн гэр бүлээ орхин Түүнийг даган гэрээс гарч байсан гэж бид сонсож байсан нь ийм учиртай. Энэ нь Шагжамуни Будда тэр хүмүүсийг зориуд өөртөө татсан хэрэг биш юм. Түүний бясалгал нэн өндөр дээд, Түүний хүч асар их учраас хүмүүс хармагцаа л гэрээс гарч, Түүнийг дагахыг хүсдэг байжээ.

Жуанзын нэг номд ийм нэгэн түүх байдаг. Нэг өдөр шавь нь Күнзээс: “Багш аа, нэгэн газарт царай төрх нь сайн биш мөртөө зэрэмдэг, өрөөсөн хөл нь доголдог, жижигхэн намхан биетэй нэг хүн байна. Би түүнийг ямар нэгэн онцгой ёс учрыг заан сургаж байхыг хараагүй. Явж, суух, эсвэл хэвтэх аль нь ч байсан хамаагүй эв хавгүй, огтхон ч сүр жавхаагүй, гэвч түүнийг харсан бүхэн бүгд түүнтэй хамт байхыг хүсэх юм. Эрчүүд түүнийг харвал ах дүү бололцоод гэртээ харихаа болино. Бүсгүйчүүд түүнтэй уулзмагц гэртээ хариад: “Бусдын авааль эхнэр болсноос түүний татвар эм болсон нь дээр” хэмээн эцэг, эхээсээ гуйдаг байна. Тэр бараг тан шиг олон шавьтай юм. Тэр улсын иргэдийн тэн хагас нь түүний шавь болжээ. Яагаад вэ?” гэж асуухад Күнз: “За! Яриад яахав. Тэр хүн нэгэнт “Бодь мөр”-ийг олжээ.” гэсэн байна.

Тиймээс зөвхөн сайхан төрх, сүр жавхлан, гоо үзэсгэлэнгээр бусдын сэтгэлийг татахгүй. Зарим хүн Багшийг нь харахаар байнга ирдэг, учир нь эхнэр нь Багшид нь их хайртай, Багштайгаа

уулзахгүй бол уйлна, өдөр бүр Багшийнхаа зургийг харж, нулимс дуслуулдаг гэнэ. Тэгээд нөхөр нь эхнэртээ: “За яахав! Нэгэнт Багш тань тийм чухал юм бол чи яваад Багштайгаа хамт амьдрахгүй юу даа!” гэжээ. Тэд хэд хэдэн удаа муудалцсан ч эхнэрээ өөрчлөх ямар ч аргагүй байв. Нөхөр нь ихэд уурлаж, Багш нь ямархуу олноос онцгой, түмнээс төгөлдөр хүн юм бол харъя гэж боджээ. Тэр уг нь Багшид нь төвөг удахаар ирсэн боловч эцэст нь өөрөө бас Багшаас нь суралцахаар болсон юм.

Багш нь түүнийг өөрчлөх гэж зориудаар юу ч хийгээгүй. Энэ бол сүнслэг бясалгалын хүч нөлөөлсний үр дүн юм. Хэрвээ та нар ахуй ойлголтын талаар сонсох хүсэлтэй бол авшиг хүртээрэй гэж Багш нь хэлье. Авшиг хүртсэний дараа та нар өөрсдөө тийм ахуй ойлголттой болох боломжтой тул Багш нь үүнийг тайлбарлах шаардлагагүй болно. Үнэндээ яагаад ийм байдгийг би бас хэлж мэдэхгүй. Энэ бол бид өөрөө өөрийгөө өөрчилсний үр дүн. Яг л энэ шүдний эмч шиг, тэр өнгөрсөнд ч, одоо ч үргэлж л ийм тарган байсан, гэтэл яагаад одоо ийм олон хүн түүн дээр ирдэг болов? Учир нь түүнийг шүдний эмч бөгөөд бусдын өвчнийг эмнэдэг гэдгийг хүмүүс мэддэг болсон тул түүн дээр ирдэг болжээ. Анагаах ухаанд суралцахаас нь өмнө хэн ч түүн дээр эмчлүүлэх гэж ирдэггүй байсан. Гэвч тэр одоо өмнөхөөсөө өөр болсон, зургаа, долоон жил суралцаад эмч болжээ. Хэрэв та түүнээс “Та яагаад одоо ийм мундаг болчихов оо. Яаж өмнөхөөсөө огт өөр болсон бэ?” гэж асуувал тэр өнгөрсөн зургаан жилийн бүх туршлага, эсвэл сурсан эрдмээ бүгдийг танд нэг дор хэлж чадахгүй. Тэр ч байтугай хэрэв тэр танд заахыг хүслээ ч та түүнээс удаан хугацаанд суралцах хэрэгтэй, ойлгохын тулд зөвхөн түүний ярьсан зүйлд л найдах нь хангалтгүй. Бясалгалын хувьд ч мөн адил, ахуй ойлголттой больё, эсвэл дотоодын түвшнээ мэдье гэвэл өөрөө л бясалгах хэрэгтэй.

Авшиг хүртсэн хүний соронзон талбай хэдийн өөр болсон байдаг. Авшиг хүртсэн даруйд соронзон талбай нь шууд өөрчлөгддөг. Хэдийгээр дөнгөж эхлэн бясалгах үедээ бид ямар ч хүчгүй байдаг ч Их Багшийн хүч их тул бидэнд бага зэрэг хүртээнэ.

Яг л нэг баян хүн шиг, хэрвээ бид ядуу бол тэр эхлээд жаахан мөнгө өгвөл бид дараа нь өөрсдөө мөнгө олохын тулд чармайн ажиллана. Хэрэв нэн ядуу хүн өөр нэг ядуу хүнийг эргэж очвол тус болж чадахгүй, учир нь хоёулаа мөнгөгүй. Харин баян хүн таарвал даруй түүнд жаахан мөнгө өгнө, энэ нь баян хүний хувьд

бага байх хэдий ч түүний хувьд бол их мөнгө байна.

Тиймээс авшиг хүртсэн хүн тэр дорхноо ахуй ойлголтой болдог нь Багшийнхаа ахуй ойлголтоос, Багшийнхаа соронзон талбайн хүчнээс хулгайлснаас болж байгаа юм.

Нэгэн Их Багшийн хүч хүмүүсийн зүрх сэтгэлд төдийгүй амьтанд ч бас нөлөөлдөг, бүр мод, чулуунд ч гэсэн нөлөөлнө. Өвөг Багш маань амьд сэрүүн байхдаа нэг өдөр миний Багшийг эргэж үзэхээр очсон юм. Багшид нэг өрөө бий, тэндээ өөрөө бясалгаж суудаг байсан. Тэр жижиг өрөө нь манай ашрамынхтай бараг адил, угаас тийм ч онцгой зүйл байгаагүй. Гэтэл Өвөг Багш маань тэнд очсоны дараа хөгжмийн аялгуутай, эгшиг дуутай болжээ. Зөвхөн миний Багш төдийгүй тэр өрөөнд орсон хүн бүхэн сонсдог. Учир нь Өвөг Багш маань тэр модон өрөөг адислаж, модыг шидийн хүчтэй болгон амилуулжээ.

Хүмүүс бидний хувьд ч мөн адил, Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олохын зорилго нь Түүнд асар их хүч чадал байгаа учраас тэр, ойлгов уу?

Тэрээр бидний соронзон талбайд нөлөөлж, бидний соронзон талбайг, биднийг нилээд хүчтэй болгон дэсийг маань дээшлүүлж чаддаг, тиймээс бид бага зэрэг бурхан бодьсатвагийн ахуй ойлголттой болж чадна.

Эс бөгөөс, эгэл жирийн хүмүүс бид тийм ахуй ойлголттой болох боломжгүй бөгөөд дээд дэсийн төлөв байдал, эсвэл нөхцөл байдлыг биеэрээ мэдэрч чадах боломж байхгүй. Тиймээс бид нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж хайх хэрэгтэй. Тэр асар их хүч чадалтай, бид ахиухан бясалгасны дараа бас Түүнтэй адил болж чадах бөгөөд яг л баян хүн ядуу хүмүүст мөнгө өгч байгаа шиг хүч чадлаасаа бусдад өгч чадна.

Багш нь хүмүүсийг зориуд гэтэлгэдэггүй, эсвэл тэднийг татахын тулд зориуд ид шид хэрэглэдэг, эсвэл ямар нэг онцгой зүйл хийдэг юм биш. Энэ нөхцөл байдал нь бүрэн жам ёсны байдаг, хэрвээ би үүнийг зориуд санаатай хийвэл тэр “Мөр ёс” биш. Хэрвээ би ус авах ёстой хэвээр, эсвэл танд уулгахаар ус хайж байвал би өөрөө хараахан ус биш гэсэн үг. Хэрвээ би ус бол та ирэнгүүтээ л шууд мэднэ, ойлгов уу? Усны тухай ярих ч шаардлагагүй, түүнд хүрэхэд л бие норж, түүнд орвол сэрүүн сайхныг мэдэрнэ. Бас түүнийг шууд ууж болно. Зарим хүн элсэн цөлд ус олдохгүй ангаж яваад ус тааралдвал аяга сав эрэх завгүй шууд л амаараа уудаг.

Бидний бясалгал ч ижил, “Мөр ёс” болон хувирах, энэхүү их хүч болон хувирах нь бидний эцсийн зорилго юм. Тийм учраас “Очир огтлогч судар”-т: “Хэдийгээр үй олон төрөлтнийг гэтэлгэсэн ч гэтэлгэгдсэн төрөлтөн гэж байхгүй.” гэжээ. Буддагийн хувьд бол Тэрээр ямар ч төрөлтнийг гэтэлгээгүй, хамаг төрөлтний хувьд бол тэд хэрхэн гэтэлгэгдсэнээ мэдэхгүй, гэвч Түүнтэй уулзвал ихэд татагдаж, тун таатай сайхныг мэдэрнэ, Түүнийг харж чадахгүй бол хэцүү санагдаж, ихэд санан дурсана. Бидний мэдэж байгаа зүйл ердөө л энэ.

Хүн төрөлтний хайрлах сэтгэл нь бидэнд зөвхөн ийм мэдрэмж л төрүүлж чадна, эс бөгөөс Будда биднийг чухам яаж гэтэлгэдгийг бид огт мэдэхгүй байх байв.

Буддагийн хувьд, жишээ нь, Шагжамуни Будда ямар нэгэн төрөлтнийг гэтэлгэв гэж мэдрэхгүй, Тэрээр магадгүй ном айлдана, хүмүүсийг мэлмийгээрээ болгооно, гэхдээ Түүний хувьд Тэр юу ч хийгээгүй бөгөөд яг л ус шиг аяндаа л танд ус уулгая гэж ер бодолгүйгээр уух ус өгдөг.

Нар ч гэсэн адил, өдөр бүр газар дэлхийг гийгүүлж, олон ертөнц, түмэн бодисыг тэтгэж байдаг. Гэсэн хэдий ч тэр: “Би маш сайн, би хамаг төрөлтөнд дулаан илчийг асар ихээр түгээж байдаг. Надгүй бол юу ч ургахгүй.” гэж хэзээ ч боддоггүй, тэр ингэж бодохгүй, жамаараа л гэрэлтэн гийсээр байдаг. Тиймээс би тиймэрхүү зүйлийн талаар ярихгүй. Хэрвээ ахуй ойлголт ярья гэвэл хүчээр ярина, ярьсан ч тийм гүн нууцлаг түвшнийх биш. Гүн нууцлаг түвшин нь хэл ярианаас бүрмөсөн хэтийдсэн байдаг.

Шагжамуни Буддагийн шавь нар ахуй ойлголтоо бичээд үлдээсэн байна. Бидний ахуй ойлголт, эсвэл түвшин “Баатарая явагч нэрт их хөлгөн судар” болон “Богдсын ном Цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-ынхтай бараг ойролцоо, “Цэцгийн эрихийн судар”-ынхтай ч ойролцоо. Хэрвээ та бүхэн ахуй ойлголтоо мэдье гэвэл “Цэцгэн эрихийн судар”, “Баатарая явагч нэрт их хөлгөн судар”, “Авид Бурханы судар”, “Дорно зүгийн Оточ Манал Бурханы судар” болон “Хутагт Ланка-д заларсан судар” зэргийг уншаарай. Хэрвээ билиг ухаанаа мэдье гэвэл Даяаны бүлгийн судруудыг уншаарай, бидний билиг ухаан тэднийхтэй бараг ижил. Тиймээс Багш нь иймэрхүү ахуй ойлголтуудыг ярих шаардлагагүй. Хэрэв ахуй ойлголт байсаар байвал энэ нь гүн нууцлаг түвшин биш гэсэн үг. Өөрөө ахуй ойлголт болон хувирах нь л хамгийн төгс дээд түвшин болно, та нар утгыг нь ойлгов уу?

Түвшин бол би, би бол түвшин болно. Тэр үед яримаар зүйл байхгүй болох бөгөөд гэтэлгэх төрөлтөн ч байхгүй болно. Гэвч сонсохыг хүссэн хүн байдаг учраас Багш нь хүчээр л та нарт ном тайлдаг. Хүчээр ярьдаг болохоор ярьсан ч тийм гүнзгий ярьж чаддаггүй. Гүн нууцлаг зүйлсийн талаар ярьсан ч тэр нь жинхэнэ биш. Үг хэлээр илэрхийлэгдэж байгаа бүхэн нь хараахан гүн нууцлаг түвшнийх биш.

Гүн нууцлаг түвшнийг Багш нь та нарт ярихын аргагүй, илэрхийлэх үг хэллэг байхгүй, бүр ярилаа ч гэсэн та нар ойлгохгүй. Би та нарт зөвхөн бясалгал дадуулж, хурдхан авшиг хүртэж, илүү их бясалган сууж, Багшийнхаа зааврыг ягштал баримтал гэж зөвлөж л чадна. Бясалгаад үлэмж дээд түвшинд хүрсний дараа та юу ч ярих, эсвэл Багштайгаа уулзах шаардлагагүй болно, учир нь хэдийн өөрөө ахуй ойлголттой болж, өөрөө ойлгосон байдаг.

Тиймээс би хаана ч очсон хүмүүсийг авшиг хүртэж, бясалган сууж, веган хоолтон болж, сүнслэг бясалгал хурдхан дадуулаарай гэж уриалдаг. Миний хэлж ярьж болох зүйл гэвэл энэ л байна, бусдыг нь ярьж болохгүй нь үнэхээр харамсалтай! Гэвч надад өөр арга алга. Жишээ нь, мэлхий бол хоёр нутагтан амьтан, тэд яст мэлхийтэй адил усанд ч, хуурай газар дээр ч амьдарч чаддаг. Харин шанаган хорхой зөвхөн усанд сэлж чаддаг бөгөөд газар дээр амьдарч чадахгүй, өсөж томроод мэлхий болбол хуурай газар дээр гарч чадна.

Газар дээр гарч үзээд эргэж ирсэн мэлхий бусад шанагалзайдаа хандан: “Та нар мэдсэн үү, би дөнгөж сая хуурай газраас ирлээ. Тэнд үнэхээр хөгжилтэй, хүн олон, машин их, хөл хөдөлгөөн дүүрэн, хүүхдүүд эргэн тойронд гүйлдэж, салют буудуулж, жигнэмэг идэж, сүү уун чихэр иднэ. Энэ нь манай энд байгаа зүйлстэй огт адилгүй.” гэж хэлнэ.

Харин шанагалзайнууд сонсоод ер ойлгохгүй: “Эх газар гэж юу вэ? Би газар дээр гарч үзээгүй, тэнд яагаад хүмүүс байдаг вэ? Яагаад машин байдаг вэ? Бас хөл хөдөлгөөн ихтэй гэнэ үү?” гэгцгээнэ. Өнөөх мэлхий: “За за, сүүл тань тасрахаар та нарыг дагуулан явж сонирхуулъя. Би одоо яриад нэмэргүй юм байна.” гэнэ.

Яст мэлхий ч адилхан, хэрвээ нэгэн яст мэлхий буцаж ирээд жижиг жараахайнуудад: “Хуурай газрын байгалийн үзэмж үнэхээр сайхан, тэнд нартай, салхитай, та нар мэдэх үү?” гэвэл тэд сонсоод ойлгохгүй. Учир нь тэдний ертөнцөд, үгийн санд нь

“хуурай газар”, эсвэл “хүн” гэсэн үг байхгүй, мэдээж байгалийн үзэмж, машин тэрэг, нисэх онгоц гэсэн үг ч байхгүй. Тэдний хэлэнд ийм үгс байхгүй, ойлгов уу?

Үүнтэй адилаар, манай дэлхийн үг хэлээр дээд түвшнийг дүрслэх ямар ч боломжгүй. Учир нь хүн төрөлхтний үгийн санд тийм үгс байхгүй учир бидний оюун ухаан төсөөлж үл чадна, яг л тэр шанагалзайнууд, эсвэл жижиг жараахайнууд шиг. Багш нь арай илүү гүн нарийн зүйл ярьж гэсэн ч тийм ихийг ярих аргагүй. Тэр ч байтугай хэрэв би ярих дуртай байсан ч ярьж чадахгүй. Гэхдээ би ярих дургүй, учир нь аль хэдийн мэддэг болсон хүн өөрөө ахуй ойлголттой тул ярих шаардлага байхгүй. Харин ахуй ойлголтгүй хүмүүсийн хувьд тэд юу ч ойлгохгүй, хэрэв жаахан ойлголоо ч гэсэн тэр нь бүрэн гүйцэд биш.

Тэрхүү дотоодын ахуй ойлголтынхоо талаар ярихдаа хэтрүүлэн ярих хандлагатай байдаг болохоор би үүнд дургүй. Манай бясалгалын системд өөрийн дэсийг бусдад мэдэгддэггүй, зөвхөн өөрөө л мэднэ, хэтрүүлэн ярьж болохгүй.

Хэрэв зарим хүн бусдад жаахан зүйл ярьсан бол энэ нь ахуй ойлголтод тооцогдохгүй бөгөөд дотоодын дэс ч биш, үүнийг зөвхөн ялимгүй өчүүхэн зүйл гэж үзэж болно. Жишээ нь, зарим шашны ном сэтгүүлд: “Ийм тийм хүн бусдын өвчнийг эмнэж чадна, ийм тийм хүн бусдын өнгөрсөн, одоо, ирээдүйг харж чадна, ийм тийм хүн диваажин, тамаар аялж ирээд тэр тухайгаа ярьж чадна.” гэх зэрэг зүйлийг заримдаа мэдээлдэг. Энэ бүхэн бүгд балчир хүүхдийн тоглоом төдий зүйл бөгөөд ямар нэгэн гүн нууцлаг ахуй ойлголт биш.

Иймэрхүү ялимгүй зүйлсийн талаар Багш нь ер бичээгүй болохоор та нар Багш ямар ч гүн нууцлаг ёс учрыг яриагүй гэж боддог. Үнэндээ эдгээр зүйл нь тийм ч сүрхий юм биш, тэр ч байтугай Багшийнх нь шавь нарт ч онцгой санагдахгүй, зүгээр л бясалгаж эхлэх үеийн дэс төдий зүйл юм.

Үнэндээ бидний бясалгал нилээд дээшилсний дараа ийм нөхцөл байдлыг өчүүхэн ч хүсэхээ больдог. Ид шидийн хүчийг ашиглах, эсвэл өнгөрсөн, ирээдүйг мэдэх зэрэг нь тун доогуур дэс. Сүнслэг бясалгалаар тун дээгүүр хүнд ийм зүйлийг харах шаардлага угаас байхгүй. Тэрээр Түүнчлэн ирж, буцаж, юм бүхнийг мэднэ, бусдын царай төрхийг харж, гарын алгыг унших шаардлагагүйгээр түүний байдлыг мэдэж чаддаг. Тэрээр Америкт байвч энд ирэлгүйгээр бусдын өвчнийг эмнэж чадна. Хамгийн

хүнд өвчин юу вэ? Энэ бол харанхуй мунхагийн өвчин, төрөл төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэх өвчин, эсвэл сэтгэцийн өвчин юм. Мунхагийн харанхуй өвчнөө эдгээж чадвал бусад өвчин аяндаа эдгэнэ.

Багш нь өвчин эмнэх талаар ярих дургүй, хэрэв яривал өвчтэй бүх хүн над руу ирэх болно. Багш нь энэ талаар бусдад мэдэгдэх дургүй учраас ийм зүйл бичдэггүй. Гэхдээ өдөр бүр Багштайгаа хамт байдаг л бол ийм ахуй ойлголт маш олныг хүртэх болно, өөрсдөө мэдчих болохоор энэ тухай бичих, ярих шаардлагагүй. Би хаа сайгүй очиж, ийм зүйлийг ярьж сонсгох боломж байхгүй, үнэндээ бол би ярих дургүй. Хэрэв та нар мэдэх хүсэлтэй бол Багштайгаа илүүхэн хамт байгаарай.

Жишээ нь, ад чөтгөрийг зайлуулах, өвчин эмнэх зэрэг нь надад сонирхолтой биш. Та нар Багшийгаа даган суралцвал юмс жамаараа л засарч сайжирдаг. Багшийнх нь энд ирсэн зорилго нь ад чөтгөр хөөж, өвчин эмнэх явдал биш болохоор юу ч бичихгүй байдаг, ойлгов уу?

Олон хүн сонин хэвлэлээр өөрийгөө сурталчлах дуртай бөгөөд өвчин анагааж чадна, эсвэл ид шидийн хүч чадалтай гэх мэтээр бичдэг тул алдартай байдаг. Харин Багшийнх нь хувьд эдгээр нь зүгээр л хүүхдийн тоглодог тоглоом юм. Хэрэв та нар зарим гүн нууцлаг ёс учрыг сонсьё гэвэл Багш нь бас жаахан ярьж өгч магадгүй. Харин Багш өвчин эдгээж чадах болов уу, бусад хүний өнгөрсөн болон ирээдүйг харж чаддаг болов уу, эсвэл надад ид шидийн хүч чадал байгаа болов уу гэдгийг мэдэхийг хүсвэл би энэ талаар ярихгүй нь мэдээж.

Ойлгох хүсэлтэй хүн Багшийгаа даган суралцвал мэднэ, Багш нь зориудаар хэтрүүлэн ярих шаардлагагүй. Ииймэрхүү зүйлд би дургүй. Хэрвээ та нар гадуур гарч Багшийгаа өвчин эмнэдэг гэж хэтрүүлэн магтвал хүмүүс үхэж, төрөхийн зовлонгоос мултрахын төлөө бус, зөвхөн өвчнөө эмчлүүлэх гэж л ирэх болно.

Хэдийгээр Багшийнх нь ажил өвчин эмнэх биш боловч өвчнөөс аварна гэж хэлж бас болох юм. Учир нь би хүмүүсийг Гурван ертөнцийн дотор уяж хүлдэг хамгийн хүнд өвчнөөс нь авардаг. Хамаг төрөлтний харанхуй мунхагийн өвчнийг засаж, тэднийг үүрд эрх чөлөөтэй болгодог. Үүрдийн эрх чөлөө гэдэг нь яг л хувцсаа тайлахтай адил юм, хувцсаа нэг нэгээр нь тайлж байж л эцэст нь төгс туулан гэтэлнэ. Энэ бол Багшийнх нь эмчилдэг өвчин юм. Хэрэв харанхуй мунхагийн өвчнийг үндсээр

нь эмчилбэл мэдээж бусад өвчин эдгэрнэ.

Багшаараа ямар нэг гүн нууцлаг зүйлийн талаар яриулна гэвэл юу ярих ёстойгоо үнэхээр мэдэхгүй, Очир огтлогч судрын дагуу ярих ёстой юу, Зүрхэн сударт бичсэний дагуу ярих ёстой юу? Ер нь Зүрхэн судар дахь түвшнийг миний шавь нар авшиг хүртэхдээ бас мэдэрдэг. Тиймээс нүд, чих, хамар, хэл, бие болон сэтгэл байхгүй түвшин ч мөн гүн нууцлаг дэс биш.

Илүү гүн гүнзгий ёс учрыг мэдэхийг хүсвэл дотоодын хувилгаан Багш тань ярьж өгнө. Учир нь Багш нь энэ нэг бие махбод төдий биш, хүрсэн түвшин бүхэнд тань Багш нь байж байна. Тэр үед танд Багш нь илүү гүн гүнзгий зүйлсийг заах болно. Учир нь тэр түвшинд хүрвэл та нарын дэс хэдийн нилээд өндөрсөж, Багшийнхаа сургах ёс учрыг хүлээж авахуйц болдог.

Саяхан ярьсан шанагалзай мэлхий болсныхоо дараа сая хуурай газар дээр гарч чадна. Гарсных нь дараа том мэлхий түүнд: “Энэ нь хүн, тэр нь настай хүн, тэр нь лам хүн, энэ бол гэлэнмаа, тэр хоёр бол гэр бүлийн хос, чи мэдэж авав уу?” гэж танилцуулна.

Шанагалзай мэлхий болохоосоо өмнө том мэлхий юу ч гэж хэлсэн ойлгохгүй, том мэлхий настан гэж яривал тэрээр “Настан” ямар харагддагийг мэдэхгүй, тэр хүүхдийг төсөөлж чадахгүй. Шанагалзай бол шанагалзай л юм, тэр хүн гэж ямархуу байдгийг төсөөлөх аргагүй, учир нь тэдний ертөнцөд хүн, хүүхэд, нөхөр гэргий, машин, зайрмаг, кофе гэж байхгүй болохоор яаж түүнд ойлгуулах билээ? Шанагалзай мэлхий болсны дараа л том мэлхий түүнд: “Энэ кофе, тэр хортой эм, энэ хортой өвс” гэх мэтээр хэлж өгч болно. Учир нь тэр үед шанагалзай бодитоор нь харах тул тийм зүйлс тохиолдоход том мэлхий тайлбарлаж өгч чадна, өмнө нь бол тайлбарлахын аргагүй байв. Энэ нь зөвхөн мэлхийд ч биш, хүн бидний хувьд ч бас адил. Энэ дэлхий дээр олон улс гүрэн байдаг. Жишээ нь, Африк тив нилээд хоцрогдмол, тэнд онгоц, цахилгаан гэрэл, зурагт, радио байхгүй. Тэдэнд радионы тухай яривал мэдээж ойлгохгүй, тэгээд: “Энд байгаа хүн ярихад алс хол өөр газарт байгаа хүмүүст сонсогдох уу?” хэмээн бодно. Тэд үүнд итгэхгүй.

Тэдэнд бас утас байхгүй. Хэрвээ та: “Би нутагтаа байна, та нартай уулзахаар очих шаардлага байхгүй. Эндээсээ хэдэн тоо дараад л та нартай холбогдон ярилцаж болно.” гэж хэлбэл тэд бас л итгэхгүй. Учир нь тэд хоорондоо холбоо барих гэвэл хэнгэрэг цохидог.

Шинэ мэдээ гарвал ойр хавьд амьдардаг хүмүүст сонсогдохоор хэнгэрэг цохино. Хэрэв та энэ мэдээг цааш дамжуулъя гэвэл энэ тосгоныхон хэнгэрэг цохиж дуустал нь хүлээж, тэр тосгонд үргэлжлүүлэн хэнгэрэг цохиж, дараагийн тосгонд мэдээ дамжуулж болно. Хүмүүс ингэж л мэдээ дамжуулдаг байжээ. Телефон утсыг саяхан зохион бүтээсэн. Зуун жилийн өмнө хэн нэг хүн телефон утасны тухай бидэнд яривал итгэх хүн бидний дунд байхгүй байх байсан.

Урьд нэгэн цагт Ау Лакт маш цэцэн мэргэн хаан байжээ. Хятадын Тан улсын үеийн шүлэгтэй адилавар сайхан шүлэг бичдэг. Тэрээр урлаг соёлд их дуртай бөгөөд өршөөл журамтай, тун сайн хаан байжээ. Гэвч тэр гадаад улсад ер очиж байгаагүй тул харийн гүрнээс юу сурах ёстой тухай мэдэхгүй учраас нэгэн мэргэн түшмэлийг Франц улсад суралцуулахаар илгээжээ. Энэ нь ердөө л зуун жилийн өмнө болсон явдал. Тэр үед Ау Лакт хаант засаглалтай байсан бол одоо коммунист нам эрх барих болжээ. Би Ау Лакаас яваад хэдэн арван жил болсон тул одоогийн нөхцөл байдлыг сайн мэдэхгүй. Тэр үед хаан эзэн их түшмэлээ Францад суралцуулахаар илгээжээ. Тэр түшмэл суралцаж дуусаад улсдаа ирж, улс орноо хөгжүүлэн илүү баян чинээлэг, эрх чөлөөтэй болгож, ард түмнээ илүү тав тухтай амьдруулахын тулд билиг ухаанаа зориулахад бэлэн байв.

Хаан эзэндээ хандан: “Бид керосин дэнлүү хэрэглэх хэрэггүй. Францад гэрэл чийдэнг дээрээс өлгөдөг бөгөөд тос ашигладаггүй. Тэднийг өдөр бүр цэвэрлэх шаардлагагүй, гэхдээ маш цэвэрхэн байдаг. Хэзээ гэрэл хэрэг болно, зүгээр л товч дармагц гэрэл асна.” гэж илтгэв. Хаан үүнд итгэсэнгүй. Тэр түшмэл дахин: “Францад машин тэрэг нь мориор чирүүлэх шаардлагагүй өөрөө давхидаг.” гэсэнд хаан бүр итгэсэнгүй, түүнийг улам их сэжиглэжээ. Өнөөх түшмэл үргэлжлүүлэн: “Франц хүмүүс худгаас ус татах гэж зовохгүй. Тэд зөвхөн нэг төхөөрөмж угсарч суулгаад хананаасаа усаа авдаг.” гэв. Үүнийг сонсоод хаан цаашид хүлцэхийн аргагүй болж: “Чи ярьж дууссан уу? Чи эзэн хааныг мэхэлсэн ялд унав.” гэжээ. Эрт дээр үед хаан эзнийг мэхлэх нь хамгийн хүнд ял байсан бөгөөд гурван үеэр нь хөнөөдөг байв. Энэ хааны мунхаг байдлаас болж нэгэн мэргэн билигт хүмүүн ингэж гэр хотлоороо хөнөөгджээ. Хаан эзэн харь гүрэнд айлчилж үзээгүй тул гадаад улсын нөхцөл байдлыг мэдэхгүйгээс түшмэлийнхээ ярьсан зүйлд итгээгүй байна. Харин тэр түшмэл эрдэм мэдлэг сурч ирээд сайн санаагаар улсаа илүүхэн хөгжүүлэхийг хүссэн ч хорлогдсон нь тун харамсалтай.

Нэгэн амьд сэрүүн байгаа жинхэнэ Их Багш ч мөн адилхан. Бурхан бодьсатва энэ дэлхийд хувилгаан биеэр заларсан нь хамаг төрөлтнийг харанхуй мунхагаас гэгээрүүлж, бүр ч илүү сайхан түвшин энэ орчлон ертөнцөд байдгийг мэдүүлж, жинхэнэ аз жаргалыг ойлгуулж, тэдэнд өөрийгөө улам илүү танин мэдэж, хөгжүүлж амжаагүй асар их хүч өөрт нь байдгийг ойлгуулахын төлөө билээ.

Гэвч олон хүн үүнд итгэдэггүй, тиймээс Есүс Христийг загалмайд цовдолж, Күнзийг хорлож, Шагжамуни Буддаг ч мөн хорлохын тулд чулуу шидэж, гүтгэж байв. Тиймээс хамаг төрөлтнийг гэтэлгэх нь үнэхээр амаргүй ажил. Саяхан ярьсан мэлхийн үлгэртэй адил хамаг төрөлтнийг сургах тун хэцүү.

Авшиг хүртээх нь яг л том мэлхий жижиг мэлхийг дагуулан замд гарахтай адил. Том мэлхий замдаа: “Энэ бол мод бут, энэ бол өвс ногоо, энэ бол хүн, тэр бол настай хүн.” гэх мэтээр түүнд танилцуулна. Тэд хоорондоо яг л Их Багш шавь хоёр шиг.

Үнэндээ, том, жижиг мэлхийн хооронд нэг их ялгаа байхгүй. Гэсэн хэдий ч том мэлхий хэд хэдэн удаа хуурай газар дээр гарч, нааш цааш явсан тул арвин туршлагатай болж, хуурай газрын бүх газар нутаг, юмсыг мэддэг тул жижиг мэлхийд ном уламжилж чадах бөгөөд жижиг мэлхий түүнийг даган суралцвал хуурай газрын байдлыг улам их ойлгох болж, өсөж томроод буцаж очин өөр бусад жижиг мэлхийнүүдээ сургаж, тэдэнд замчилж чадах юм.

Үүн шиг, авшиг хүртсэн шавь ч мөн дөнгөж сүүлнээсээ салсан бяцхан мэлхий шиг замд гарч эхэлдэг. Иймээс Багшаасаа илүү гүн нууцлаг зүйлсийг суралцъя гэвэл дотоодын Их Багшаасаа суралцах хэрэгтэй. Учир нь маш гүн нууцлаг зүйлсийг хүн төрөлтний үг хэлээр илэрхийлэх аргагүй бөгөөд гадна талд ийм зүйлсийг зааж чадахгүй. Жишээ нь, далайд байх зүйлс хуурай газрынхаас ялгаатай, далайн гүнд хүмүүс байдаггүй.

Тиймээс гүн нууцлаг ёс учрыг ярихад тун хэцүү. Багш нь хэдийн маш олон ном тайлсан бөгөөд заримдаа бас илүү гүн нарийн зүйлсийн талаар ярьдаг. Гэхдээ “гүн” гэгдэх тэр зүйлс нь бас гүн нууцлаг онол төдий байж, та бүхэн бодитойгоор өөрөө ойлгохын аргагүй. Гэсэн хэдий ч энэ нь зөвхөн үг хэлээр илэрхийлэгдэж чадахаар бол Би энэ тухай ярихыг чадлаараа хичээнэ, гэвч ихэнх тохиолдолд үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг.

Хэрвээ үг хэлээр ярихад л хангалттай байдагсан бол Багш нь та нарт уншуулахаар ном, эсвэл гарын авлага өгөхөд л болчихно. Гэтэл та нар яагаад Багштайгаа ирж уулзах дуртай байдаг вэ? Учир нь Багш нь энэ нэгэн ном, эсвэл гарын авлага биш. Их Багшийг байх үед орчин тойрны уур амьсгал бүхэлдээ өөр болдог, ойлгов уу? Жишээ нь, таны эхнэр уг хүн нь зурагнаасаа мэдээж өөр, эс бөгөөс та түүний зурагтай гэрлэхэд л хангалттай, жинхэнэ бодит хүнийг нь эрж хайх хэрэг байх уу?

Та нарт Багшийнх нь зураг зөндөө бий. Та нар заримдаа Багшийгаа зурагнаасаа гарч ирэхийг хардаг, гэхдээ л Багштайгаа уулзах дуртай хэвээрээ. Учир нь зураг харахад хангалтгүй, зураг нь бодит хүнээс өөр. Мэдээж хэрэв Багшийгаа ойр байхгүй үед бол зургийг нь харж болно, юу ч үгүй байснаас дээр.

Тиймээс Шагжамуни Буддагийн шавь нар багшийнхаа хөрөг зургийг зураад багшийгаа дурсан санах бүрдээ, багштайгаа уулзаж чадахгүй үедээ гарган ирж хардаг байжээ. Тэд Шагжамуни Буддагийн зургийг харах, эсвэл өдөр бүр Түүний зурагт мөргөх нь мэдээж тустай, учир нь тэд бол Шагжамуни Буддагийн шавь юм. Магадгүй тэд багш нь зурагнаасаа гарч ирээд олон янзын гайхамшиг үзүүлэхийг харсан байх, тиймээс яриангүй Багшдаа мөргөнө.

Тэдний ийнхүү багшийнхаа зурагт мөргөж байгааг болон багшийнхаа зургийг хараад их баяр жаргалтай байгааг нь Шагжамуни Буддагаас суралцаагүй, эсвэл Түүнтэй уулзаагүй хүмүүс хараад даган дуурайж, сүслэн мөргөх болжээ. Үүнээс болж энэ нь аажимдаа одоо бидэнд байгаа өдөр бүр модон бурханд мөргөдөг заншил болж хувирсан байна.

Магадгүй Багшийг нь нирваандаа буцсаны дараа шавь нар маань Багшийгаа санан дурсахдаа хөрөг зурагт нь байнга мөргөөд байвал бусад хүмүүс ч үүнийг хараад даган дуурайна, ингэсний эцэст нэгэн шүтэн мөргөх шашин болж магадгүй. *(Бүгд инээлдэв.)* Үнэндээ бол тухайн Их Багш энэ дэлхийгээс явсан бол хөрөг зураг нь ямар ч нэмэргүй. Хүч нь хамгийн ихдээ гурван зуун жил л хадгалагддаг. Хэрвээ Их Багш энэ дэлхийг орхисон бол гурван зуун жилийн дараа Түүний соронзон талбай эвдэрнэ, учир нь Түүний соронзон талбай өөртэй нь хамт явдаг. Гэхдээ соронзон талбайн хүч нь багахан хадгалагдан үлдэж магад. Түүнийг тодорхой нэг газар очих үед жаахан хүч үлддэг тул тухайн газар бусад газраас өөр болж, онцгой адислах хүчтэй байдаг.

Зарим хүн Шагжамуни Буддаг харж чаддаггүй болохоороо мөргөл хийхээр явдаг, тэгээд жаахан зөн совин мэдэрдэг, яагаад вэ? Учир нь нэгэн Их Багш хэдийгээр энэ дэлхийг орхин одсон ч өмнө нь Түүгээр нэгэнтээ адислагдаж байсан газрууд мөн л өөр байдаг. Тэр газрууд бол онцгой. Тэрээр тухайн тэр газрын хэлбэлзлэлийн давтамжийг бага зэрэг дээшлүүлж, ариусгасан байдаг тул тэнд очиход тун таатай сайхан мэдрэмж төрнө. Хэрвээ бидний дэс нилээд өндөр бол адислалыг мэдрэнэ. Гэхдээ энэ бүхэн тийм сүрхий зүйл биш.

Нэгэн Их Багш энэ дэлхийг орхин одвол Түүний соронзон орон оршин байхаа больдог. Тиймээс бид нэгэнт өнгөрсөн хүний зургийг харах нь амьд хүний зургийг харахаас өөр байдаг. Одоо эрдэмтэд багаж төхөөрөмж ашиглан хэн нэгний зургаар тухайн хүн нас барсан, эсвэл амьд байгаа эсэхийг магадлан тодорхойлж чаддаг болжээ. Тиймээс амьд сэрүүн байгаа Их Багшийн гэрэл зурагт мөргөх нь мэдээж тустай. Тэр ч байтугай зарим хүн авшиг хүртээгүй ч чин сэтгэлтэй бол адислалыг мэдэрдэг. Учир нь тэр Их Багш амьд сэрүүн байгаа тул тэр зургийг адисалж чадна. Түүний соронзон орон газар бүхэнд оршдог. Учир нь Тэр бол Түүнчлэн ирсэн бөгөөд хэрвээ та Түүнийг дурсан санавал хөрөг зураггүй байсан ч адислалыг мэдэрнэ. Гэвч бидний уураг тархи олон зүйлийг мартдаг тул хөрөг зураг нь байвал тухайн хүнийг амархан дурсан санадаг бөгөөд хэдий чинээ их дурсан санана, зөн совин төдий чинээ хүчтэй мэдэрнэ.

Гэвч зөвхөн зурагт нь найдах нь таныг туулан гэтэлгэж чадахгүй. Асар их чин сэтгэлтэй, маш их буян хишигтэй, эсвэл Багшийнхаа итгэлийг олсон бол Багш тань таныг аварна. Эс бөгөөс та заавал өөрөө бясалгах хэрэгтэй хэвээрээ байна. Хэрвээ нэгэн Их Багш өөрөө таныг аврахыг хүсвэл зөвхөн ганц таныг аврах төдий байдаг. Гэтэл нэгэн хүн авшиг хүртвэл таван үе нь аврагдаж, төрөл дэвшиж чадна. Ялгаатай тал нь энэ. Тиймээс авшиг хүртсэн хүн бол хамгийн их ачлал энэрэлтэй хүн, хамгийн их билиг ухаантай хүн, хамгийн сайн найз нөхөр мөн. Учир нь авшиг хүртсэн хүний найз нөхөд нь ч нөлөөлөгдөж, ач тус хүртдэг. Тэр хэн байх нь хамаагүй, таны энэрэн хайрладаг, асран нигүүлсдэг хүн л бол Багш нь эрхбиш түүнийг харж хандана.

Одоо би та бүхэнд ахуй ойлголтын талаар бага зэрэг ярьж өгье. Тайбэйд миний нэг шавь бий. Тэр хүн Багшийг нь дагаж суралцаад хэдхэн сар болж байгаа. Нэгэн өдөр бясалгаж байхад нь дотоодын Их Багш нь түүнийг дагуулан явж, таван үеийнх нь

өвөг дээдэстэй уулзуулахад тэд бүгдээрээ төрөл дэвшсэн байжээ. Дотоодын Их Багш нь түүнд хандан: “Одоо та мэдэв үү? Багш нь таныг ерөөс мэхлээгүйг мэдэв үү?” гэжээ. Үнэхээр түүний таван үеийн өвөг дээдэс нь бүгд төрөл дэвшсэн болохыг нүдээрээ харж биеэрээ мэдэрчээ. Хожим нь тэр нэгэн чандрын сав харсан нь холын хамаатан нагац эгчийнх нь чандар байжээ, тэрээр Багшдаа, “Энд нэг нь орхигджээ, тэр бол миний холын хамаатан юм.” гэхэд Багш нь: “За! Асуудалгүй.” гэв. Багш нь түүнийг огтхон ч мэхлээгүйг тэр мэдээд сэтгэл нь ихэд догдолж, нулимсаа барьж дийлсэнгүй гэнэ.

Тэр бол эрэгтэй хүн, захирал, үйлдвэрийн эзэн. Долоо хоногийн даяан болгонд үйлдвэрээ хаагаад ирж оролцдог бөгөөд тэр үед ажилчид нь ч их баярладаг гэнэ. Эзэн нь бясалгахаар явахад ажилчид эрх тааваараа байж, цалинтай амардаг тул ажилчид нь Багшид нь их хайртай, тэд үйлдвэртээ Багшийнх нь зургийг байрлуулжээ. Тэд бүгд тамхи татахаа больсон байна. Хэдийгээр тэд Багштай нь биечлэн уулзаж байгаагүй, зөвхөн гэрэл зургийг минь харсан төдий боловч бүгд тамхинаас гарчээ. Тэднийг ятгасан хүн байхгүй, ахуй ойлголцтой болсон учраас тэд энэ хүчинд итгэсэн хэрэг.

Ийм явдлыг зөвхөн өөрийн биеэр л туулах хэрэгтэй, би юу ч тухайлан хэлэх шаардлагагүй, ийм зүйл яривал хэтрүүлж ярихтай адил болно. Тиймээс Багш нь ярих дургүй. Гэвч та бүхний сонсох хүсэл үнэхээр их учраас би бага зэрэг ярьдаг. Энэ нь та нарт хангалтгүй ч би үүнийг хэлж чадсан нь хэдийнээ тун сайн хэрэг. Уг нь бол жаахан ч задруулж болохгүй. Гэвч энд дандаа танил хүмүүс, ихэнх нь Багшийнхаа ном тайлахыг олон удаа сонссон. Тэгээд ч талаас илүү нь шавь нар байна, ганц, хоёрхон нь хараахан шавь болоогүй байгаа ч хожим Багшийгаа даган суралцах нь тодорхой тул Багш нь бага зэрэг л цухуйлгалаа, гэхдээ бусдыг нь ярьж болохгүй.

Түвшнийг ярихын аргагүй, учир нь бидний хэлэнд тэр төлөв байдлыг дүрслэх үг ч байхгүй, тэр утга санааг илэрхийлэх ч боломжгүй. Саяхан зүйрлэж ярьсан африк хүмүүстэй ижил, тэд хэзээ ч радио, зурагт харж байгаагүй учир тэдэнд юу ч хэлэх боломжгүй. Энэ нөхцөл байдал нь яг дээр дурдсан тэнэг хаан шиг, хананаас ус гарахыг хараагүй, ийм зүйл байдаг гэдэгт итгээгүй тул их түшмэлээ хөнөөжээ. Тэр түшмэл тун сүрхий авьяас төгөлдөр хүн байжээ. Түүний зохиол маш сайн байсан бөгөөд франц хэлээр ярьдаг анхны ау лак хүн байв. Тэрээр Парис хотноо францчуудад

онолын сэдвээр лекц уншдаг байсан маш сайн эрдэмтэн хүн. Ердөө л мэдэхгүйгээсээ болж нэгэн сайн хүнийг улсын эзэн хаан нь хөнөөжээ. Хаан хэзээ ч таазнаас дүүжилдэг цахилгаан гэрэл үзээгүй, мориор чирүүлэхгүйгээр давхидаг машин ч үзээгүй, байшингийн хананаас ус гоожихыг бүр ч хараагүй байв.

Эдгээр нь одоо бол хүн бүхний мэддэг нийтлэг зүйлс. Одоо Формосад бидний хэрэглэдэг усыг бүгд хананаасаа авдаг, тийм биз? Гэвч хаан өөрөө мэдэхгүй учраас түшмэлээ хөнөөжээ.

Есүс Христ тухайн үед чулуунуудад ном айлдаж байсан учраас чулуунууд Түүнийг цовдолсон юм, миний санааг ойлгов уу? Шагжамуни Буддаг ном айлдаж байх үед Түүнийг олон хүн буруушаан гүтгэж, буруу номтон гэгцгээж байв. Тэр ч байтугай Түүнд бадар өгөх ганц ч хүн олдохгүй болтлоо гүтгэгдэж байжээ. Тэрээр бүтэн гурван сарын турш морины тэжээл идсэн байна. Учир нь тэр нутгийн хүмүүс Түүнийг гүтгэж, буруу номтон, маш муу хүн хэмээн шүүмжилж байсан тул хэн ч Түүнийг дэмжиж, бадар хоол өгөөгүй ажээ, тиймээс морины тэжээл идэх л хэрэгтэй болжээ.

Их Багш байх ийм л байдаг, та нарт таалагдаж байна уу? Та нар Будда болмоор байна уу? Болмоор байгаа хүн гараа хурдан өргөөрэй, Будда болох гэж байгаа бол морины тэжээлээр хооллох хэрэгтэй болно, цовдлогдож ч мэднэ, эсвэл чулуугаар шидүүлж, гүтгүүлж муулуулна, та нар дуртай юу?

Их Багш болох ямар ч ашиггүй. Будда болох нь маш сайн, эрхэм дээд, сүр жавхлантай, хүн бүхэн мөргөж, тэнгэрээс цэцгийн хур бууна гэж бид боддог. Гэхдээ Будда болсны дараа тэд цэцэг өргөхгүй, чулуу л шиднэ. Тиймээс Будда болох нь тийм ч зугаатай биш. Би ч бас Будда болохоо больё. Уг нь энд нилээд хэдэн хүн авшиг хүртсэн ч Багшийг нь гүтгэн буруушаах хүн байгаа учраас одоо олон хүн ирж зүрхлэхгүй байна, гэхдээ энэ бол өчүүхэн хэрэг гэж үзэж болно. Багш нь хараахан Будда болж амжаагүй байхад л нөхцөл байдал ийм төвөгтэй болж, хаана ч очсон гүтгүүлж, буруу номтон гэж хэлүүлнэ.

Үнэндээ Багш нь тун баяртай байна, учир нь зөв номынхон нь тийм хүмүүсээр дүүрээд шахцалдаж байгаа болохоор би очихоо больё, “буруу номтон” байх нь арай сэлүүхэн юм байна. *(Бүгд инээлдэв.)* Маргалдах хүнгүй, гүтгэх хүнгүй, тиймээс би “буруу номтон” байх тун дуртай. *(Бүгд инээлдэв.)* Хожим бид буруу номтны урсгал болж магадгүй. Ийм нэртэй болоод удаж байгаа

болохоор дасал болжээ. Тиймээс би хаана ч очсон өөрийгөө: “Би бол буруу номын багш. Та нар надаас суралцах уу?” гэж үргэлж таницуулж байя.

Аль ч цаг үед ижилхэн, амьд сэрүүн байгаа Төгс Гэгээрсэн Их Багшийг гүтгэж муулж, чулуу шидэх хүмүүс байдаг. Заримдаа тэдний үг чулуунаас ч хатуу, чулуунаас ч дор, учир нь чулуу нэг л газрыг онодог бол хүмүүсийн гүтгэх хэл ам хүнийг бүхэлд нь, оюун санаа, зүрх сэтгэлийг бүхэлд нь ононо.

Тиймээс бид хэлэх үгээ хянаж, бие, хэл, сэтгэлээ алинаар нь ч байсан хэлэх үгээ хянаж, болгоомжтой байх хэрэгтэй. Бясалгагч хүн хамаг төрөлтөнд ач тустай байх ёстой учраас эерүү зөөлөн хандлагатай байвал зохино. Бясалгал дадуулсны дараа бусадтай муудалцах нь багасна. Маргалдах нь бидэнд тавгүй мэдрэмж төрүүлж, бид эрхэм хүмүүний шинж байдалтай байж чадаагүйгээ мэдрдэг.

Учир нь авшиг хүртсэний дараа бид жинхэнэ эрхэм хүмүүн, жинхэнэ хүн болж, хүчтэй чадалтай, сүнстэй сүлдтэй, билиг ухаантай, аядуу зөөлөн энергитэй, гэрэл гэгээтэй болно. Зөвхөн ийм байж л бид жинхэнэ хүнд тооцогдоно. Хүн төрөхөөсөө л хар бараан байдаггүй, тиймээс бясалгах хэрэгтэй. Бясалгах нь их сонирхолтой, харин Будда болох тийм ч сонирхолтой биш.

Та нар бүгд л нэгэн Будда болох нь тун сайн гэж боддог, гэхдээ энэ дэлхийд тийм ч сайн биш. Учир нь энэ дэлхийн хүмүүсийн хувьд бол Тэр яг л харийн хүнтэй адил, тиймээс амьдрахад нь маш таагүй байдаг. Дайрдаг хүн олон, шавь нарын бараг л тал нь зугтана, зарим шавь нар нь эсрэгээр гүжирдэн дайрч мэднэ, тэр ч байтугай гадны хүнээс бүр ч илүү дайрч довтолж мэднэ. Тиймээс заримдаа авшиг хүртээгүй хүн Багшид нь бараг илүү сайн ханддаг байхад авшигтай шавь нар Багшдаа тийм ч сайн ханддаггүй. Энэ нь тэдний урьд насны үйл үртэй холбоотой юм.

Учир нь тэд урьд насандаа ийм зүйл хийж байсан, хэдийгээр өмнө нь тэд тамд маш удаан байсан ч дараа нь хүний төрөл авах завшаан олдоход нөгөө л зүйлээ хийсэн хэвээрээ байдаг, тэд сайтар суралцаж чадаагүй учир дахин төрөл авна. Энэ удаа дахин төрөл аваад өнөөх зүйлээ давтвал тун хэцүү. Зөвхөн өөртөө төвөг удах төдийгүй Багшдаа ч саад болно, учир нь энэ удаа сайн сургаж чадахгүй бол дараа Багш нь дахин ирж сургах хэрэгтэй болж, яг л тэдэн шиг үхэж, төрөхийн хүрдэнд эргэлдэх болно. Гэхдээ энэ нь тэдэн шиг биш байна, Багшийн дотоод хүч ижилхэн байдаг, гадна

талдаа өөр нэг хувцас өмссөн байдаг.

Одоо яагаад ийм олон шашны урсгал, бүлэг болж хувирсныг та нар мэдэх үү? Учир нь Их Багш гарч ирэх болгондоо яг адилхан Үнэн ёсыг сургадаг. Гэвч тийм Үнэн ёсыг хэн ч зааж сургалгүй тун их удсан, эсвэл тухайн хүн өмнө нь ийм төрлийн сайн сургаалтай таараагүй тул: “Энэ Их Багш яагаад ийм сонин жигтэй сургаал заана вэ?” гэж боддог. Үнэндээ бол тэр Их Багш хачирхалтай сургаал заадаг биш, харин бид тийм сургаалтай хараахан учраагүй учраас түүнийг нь ойлгохгүй байдаг юм. Бурханы шашны судар ном арвин их, хэрвээ та зөвхөн Авид Бурханы судар уншсан бол “Агама судар”-ыг ойлгохгүй, Агама судрыг уншсаны дараа Баатарая явагч нэрт их хөлгөн судрыг ойлгохгүй хэвээрээ л байх болно. Тиймээс ийм олон шашны урсгал бий болсон байна.

Зөвхөн Даяаны бүлэг гэхэд л аль хэдийнээ маш олон урсгалтай болсон байдаг. Жишээ нь, Цаодун бүлэг, Линжи бүлэг гэх мэт. Даяаны бүлгээс гадна Хуа Янь (*Цэцгийн эрихийн*) бүлэг, Тиантай бүлэг гэж бий. Японд дэлгэрэхдээ тэд Рилиан бүлэг болж хувирсан, эсвэл Бушидо самуурайн сүсэг мөргөлийн үзэл санаатай холилдсон өөр бусад урсгал бий болсон байна.

Тэр ч байтугай Бурханыг дурсах нь ч олон урсгалд хуваагдсан бөгөөд зарим нь зөвхөн Авид Бурханы нэрийг уншихад л хангалттай гэж боддог бол зарим нь “Цаглашгүй их насан хутаг судар”-т өгүүлсэнтэй адил байх ёстой гэж үздэг. Тиймээс хэдийгээр Бурханыг дурсах боловч асар их маргаантай. Лянхуа бүлэг ч бас олон салаа урсгалтай. Зарим хүн “Богдсын ном Цагаан лянхуа нэрт их хөлгөн судар”-т мөргөнө, зарим нь “Цагаан лянхуа судар”-ыг номлоно, хоорондоо маргаж мэтгэлцээд бүгд л зөвхөн өөрийн санаа бодлыг зөвтгөж, бусдынхыг буруутгадгаас улам л ээдрээтэй болж, олон урсгалтай болжээ.

Аль нэгэн сургаал номлолыг үндэслэгч гарч ирэх бүрт Түүний зааж буй сургаал номлолыг өөр бусад нь хүлээн зөвшөөрөхгүй байх нь олонтаа байдаг. Учир нь жинхэнэ Үнэн ёсны дамжлага тасраад удсан тул хожуу үеийн хүмүүс бусдын яриаг л сонсохоос цаашгүй, өөрийн гэсэн ахуй ойлголтгүй байдаг, тиймээс тэд түүнийг өөр зүйл зааж байна хэмээн бодож, буруутган гүтгэнэ.

Жишээ нь, Линжи урсгалын сургаалын эзэн гарч ирэх үед Цаодунгийн урсгалын хүмүүс өөрсдийн сургаал ёсонд дассан тул Түүнийг буруу номтон гэж шүүмжилнэ. Тэгэхээр Тэр: “За яахав! Та нар сурах хүсэлгүй бол би Линжи урсгал болох хэрэгтэй байна.

Ингэж байж үнэн, худлыг ялгахад хялбар болно.” гэж хэлэхээс өөр аргагүйд хүрнэ. Тэр үед Их Багш нь амьд сэрүүн заларч байсан тул Түүний заасан сургаал номлолыг хүмүүс биеэрээ мэдэрч ахуй ойлголттой болдог нь тэр амаар ярихаас цаашгүй хүмүүстэй адилгүй байсан учраас өөр нэгэн урсгал болон хувирчээ.

Багшийнх нь байдал ч мөн адилхан, тиймээс хожим Чин Хайн бүлэг болж хувирч магадгүй. *(Бүгд инээлдэв.)* Учир нь Багшийнх нь сургаалыг хүлээн зөвшөөрөх хүн ховор бөгөөд Нианфо бүлэгтэн ч бас дургүй байдаг.

Одоогийн Цаодунгийн урсгал нь мөн л хүмүүсийг ямар ч сэтгэлийн оролцоогүй, зөвхөн хов хоосон төлвөөс бясалган суухыг заадаг бол Линжи урсгал бидэнд амьсгалаа нэг, хоёр, гурав, дөрөв, тав... хэмээн тоолох, эсвэл “Би хэн бэ?” гэдэг ном хаялцаанд оролцох гэх мэтийг л сургах төдий байдаг. Энэ бүхэн мэдээж биднийхээс өөр. Учир нь хэдийгээр Багшийнх нь зааж буй сургаал эртний Линжи урсгалын зааж байсантай яг ижилхэн боловч одоогийн Линжи урсгалынхаас өөр, тиймээс тэд Багшийг нь өөр сургаал номлож байна гэж боддог. Тэр ч байтугай хэрэв Багш нь Линжи урсгалын сургаалын эзэн хувилгаан дүрээрээ залран ирсэн байлаа гэхэд ч тэдэнд мэдэх боломж байхгүй, ойлгож байна уу?

Хэрвээ Багш нь одоо: “Багшийнх нь өмнөх төрөл бол Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн.” гэж хэлбэл та нар итгэх үү? Мэдээж итгэхгүй. Учир нь одоо Хүй Нөн Өвөг Багшийн шавь нар нь хүртэл Багшийг нь гүтгэн муулж байна, тэгэхээр та бүхэн яаж Багшийгаа Хүй Нөн Өвөг Багшийн хувилгаан гэж итгэх вэ? Есүс Христ энэ дэлхийд хүмүүсийг аврахаар ирэх үедээ: “Би бол өнгөрсөн үеийн... тийм тийм хүн.” гэж хэлж байжээ. Түүний санаа нь миний өмнөх төрөл бол тийм тийм Их Багш, эсвэл номын багш байсан, одоо Тэр дахин хувилгаан дүрээрээ эргэн иржээ гэсэн хэрэг. Үнэндээ Тэр бол тэдний сүсэглэн биширдэг эртний Их Багш нь юм. Түүний санаа тун тодорхой, өөрөөр хэлбэл эргэн төрөл авсан гэсэн үг. Гэвч одоо католик шашинтан хүнтэй эргэн төрөх тухай ярих юм бол тэр яагаад ч ойлгохгүй. Тэр хүн: “Та бол буруу номтон байна. Католик шашинтнууд бид сансрын хүрдний талаар ярьдаггүй бөгөөд үйл үрийн талаар ч ярьдаггүй.” гэнэ.

Үнэндээ Библи сударт үйл үрийн тухай маш тодорхой айлдсан байдаг. Библи сударт: “Та ямар үйл тарина, тийм үрийг хураана.” гэжээ. Есүс Христ өөрөө ч энэ тухайгаа миний өмнөх төрөл бол тийм тийм хүн байсан гэсэн байдаг. Би түүний нэрийг

хятадаар орчуулж чадахгүй байна. Та нар хариад Библи судраас хараарай. Есүс Христ би бол ийм ийм хүн дахин төрсөн нь юм гэж маш тодорхой хэлсэн байдаг. Хожмын хүмүүс уншаад ойлгоогүй тул өнөөгийн ийм байдалтай болж хувирсан байна.

Жишээ нь, зарим хүн бясалгаж суугаа үедээ Багшийг нь Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн болохыг харсан байна. Гэвч би ингэж хэлбэл хэн надад итгэх вэ? Би бас: “Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн эргэн ирлээ!” гэж зарлаж чадахгүй. (Бүгд инээлдэв.) Өөрсдөө ахуй ойлголттой учраас зөвхөн шавь нар л итгэнэ.

Нэгэн Их Багш зөвхөн энэ төрөлдөө л Их Багш байдаггүй. Төрөл төрөлдөө Их Багш байдаг. Тэрээр төрөл тутамдаа энэ тоост хорвоод ирж, нирваандаа буцалгүй хүмүүсийг аврахаар их тангараг тавьсан байдаг юм.

Зарим хүн Будда болмогц эргэн ирж хүмүүсийг аврахыг хүсэхгүй, амар амгалан ертөнцөд хүрч, аз жаргалыг эдлэх дуртай байдаг. Зарим хүн Будда болмогц хамаг төрөлтний зовж зүдэрч буйг хараад ихэд шаналж, улмаар тэднийг дээш дагуулахаар эргэн ирдэг тул төрөл төрөлдөө Их Багш болдог. Та бүхэн: “Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн яагаад наймхан сар бясалгаад сургуулиа төгсөж чадсан байтал Шэншиү Их Багшийнхаа дэргэд гуч гаруй жил өдөр бүр хамт байсан ч тэр нь тийм ч ач тус болоогүй, дэс нь Хүй Нөнгээс доогуур байсан юм бол?” гэж эргэлзэх хэрэггүй. Учир нь Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн төрөл төрөлдөө нэгэнт бясалгаж байсан бөгөөд Тэр бол Бодьдарма мөн, Тэр бол Шагжамуни Будда мөн.



ҮЙЛ ТҮЙТГЭР БА ТОГТСОН ҮЙЛИЙН ҮРИЙН ЯЛГАА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайбэй хот
1986 оны 8 дугаар сарын 4. (Эх нь хятад хэлээр)*

Өнөөдөр нэг шавь маань надаас: “Багш аа, авшиг хүртсэний дараа таван үеийн хамаатан садны маань төрөл нь дээшилж, төрөл төрөлдөө хийсэн үйл түйтгэр нь арилж болно гэж та хэлсэн. Гэтэл тогтсон үйлийн үр өөрчлөгддөггүй гэж Бурхан Багш айлдсан бус уу?” гэж асуув.

Тогтсон үйлийн үр болоод үйл түйтгэр нь хоёр өөр зүйл. Буддагийн хэлсэн нь буруугүй, тогтсон үйлийн үрийг өөрчилж болохгүй. Ер нь “үйл түйтгэр” гэдэг нь Алая ухамсар (Ālaya-vi-jñāna–Ухамсрын сан хөмрөг, агуулах)-т хадгалагдаж буй ухамсар юм. Энэ ой санамж төрлөөс төрөлд бидэнтэй хамт байдаг. Авшиг хүртсэний дараа Алая ухамсарт хадгалагдсан бүх дуртгал буюу ухамсрыг арилгах боломжтой. Өөрөөр хэлбэл төрөл төрлийн үйл түйтгэр устаж үгүй болно. Үүрд устдаг. Гэсэн хэдий ч бидэнд энэ төрлийн тогтсон үйлийн үр байсаар байдаг. Хэрвээ тогтсон үйлийн үрийг устгавал бид энэ хорвоо дэлхийг шууд орхих болно. Учир нь энэ төрөлдөө төлөх ёстой үйлийн үргүй болсон тул энэ дэлхийд үргэлжлүүлэн амьдрах шалтгаангүй болно. Зөвхөн энэ төрлийнхөө тогтсон үйлийн үрээр л бид амьд байж, бясалгал дадуулж, хамаг төрөлтнийг гэтэлгэж чадна. Энэ бол тогтсон үйлийн үр юм.

Хэрвээ бид зарим үйл түйтгэрээ арилгаж чадахгүй, бидэнд арилгах боломжгүй зарим үйл түйтгэр байгаа юм бол бид яаж Будда болох вэ? Үйл түйтгэрийг арилгахын аргагүй бол туулан

гэтэлж чадахгүй. Үйл түйтгэр арилбал туулан гэтэлнэ. Төрөл төрлийн үйл түйтгэрийг өөрчилж болох нь лавтай. Тиймгүй бол Шагжамуни Будда яаж Бурханы хутагт хүрч чадах вэ? Шагжамуни Буддагийн шавь нар Түүнийг даган гэрээс гарсны дараа дорхноо архадын хутагт хүрч чадсан байна, энэ нь тэд үйл түйтгэрээ арилгаснаас болжээ. Бурхан Багшийн адислалын хүчээр л тэд сая богино хугацаанд хутагтын сууринд хүрч чадсан байна. Зарим хүн “Очир огтлогч судар”-ыг уншсан ч жинхэнэ утгаар нь ойлгож чадахгүй, харин ч буруу ташаа ойлгож, сударт баригдаж, хэт автан хүлэгддэг. Ингэж судар унших нь ямар учиртай юм бэ? “Үйл түйтгэр”-ийг өөрчлөх боломжтой бөгөөд үүнийг “үйл үрийн хувирал” гэдэг. Тиймгүй бол Шагжамуни Будда яаж хүмүүсийг гэрээс гарч, нэгэн эрхэм дээд хүн болж хувирахыг уриалах билээ? Хэрэв тэд үйлийн үрээ өөрчилж чадахгүй байсан бол Шагжамуни Будда өөр өөр гарал үүсэлтэй тийм олон шавь нартай байхгүй байв. Шагжамуни Буддаг заларч байх үед нийгэм нь брахман, язгууртан, худалдаачин, боол ядуус гэсэн дөрвөн анги давхаргад хуваагдаж байв. Тэр үед боол хүн язгууртнуудтай хамт хооллож, гэрлэж, эсвэл харилцаж болохгүй байжээ. Гэвч Шагжамуни Будда үүнийг үл тоон боол хүн гэрээс гарч шаргуу бясалгавал дээдэс язгууртан болж чадна гэж үзэж байв.

Шагжамуни Будда үйл түйтгэрийг өөрчилж болно, Түүнийг дагаж гэрээс гарвал үйл түйтгэр нь гарцаагүй өөрчлөгдөнө гэдгийг мэдэж байсан. Тухайн үед олон хүн Түүний бодлыг асар их эсэргүүцэж, Түүнийг буруу номтон, зөрүүд, нийгмийн тогтолцоог эвдэн бусниулагч хэмээн зүхэн загнаж байв. Учир нь ихэнх энэтхэг хүн Дөрвөн ведийг баримталдаг тул ядуу хүн бол ядуу, баян хүн бол баян, тиймээс үйлийн үр болоод тогтсон үйлийн үрийг өөрчилж болохгүй, өөрчилнө гэдэг бол туйлын буруу үзэл гэж итгэдэг байв.

Тогтсон үйлийн үр гэж юу вэ? Жишээ нь, нэгэн хүн ядуу гуйлгачин бол энэ нь түүний тогтсон үйлийн үр юм. Тэр ийм явах заяа тавилантай, эсвэл өөр нэгэн хувь тавилантай учирна. Энэ бол ерөнхий орчлон ертөнцийн зарчим. Бясалгагч хүн тогтсон үйлийн үрээ өөрчилж чадна. Хэдийгээр бүхэлд нь өөрчилж чадахгүй ч бага зэрэг өөрчилж чадна. Жишээ нь, нэгэн хүн бусдад алуулах заяатай байсан бол магадгүй үйлийн үр нь хувирч өөрчлөгдсөний дараа гүтгэгдэх, гэмтэж бэртэх, эсвэл гараа таслуулах, хуруугаа таслуулах болж өөрчлөгдөх магадлалтай байдаг.

Тансан лам хэсэг хугацаанд бие нь өвджээ. Чин сэтгэлээсээ

гэмшин наманчилсанд нэгэн гэгээнтэн зүүдэнд нь ирээд: “Зүгээр дээ! Үйл түйтгэр тань ингэж л цэвэрлэгдэнэ.” гэж хэлжээ. Нэгэн Их Багшийг даган бясалгавал Их Багшийн буян хишгээр бидний тогтсон үйлийн үр өөрчлөгддөг. Тиймээс Буддаг даган суралцаад маш хурдан архад, бодьсатвагийн хутагт хүрдэг шавь (шравака) болдог байна.

Миний Өвөг Багшийн нэгэн шавь нь хожим багш болсон бөгөөд мөн нэгэн гэгээрсэн Их Багш юм. Нэгэн өдөр Тэр мориноос унаад үе нь мултарч, ихэд өвдөхөд дээрдэх янзгүйг нь мэдсэн нэгэн номын эгч Өвөг Багшид хэл хүргэжээ. Өвөг Багш: “За би шалгаадахъя.” гээд өдрийн турш бясалгасны дараа самадигаасаа гараад номын эгчид: “Түүний тогтсон үйлийн үр нь өөрчлөгдөж, таван жил нь таван сар болж хувирсан байна.” гэж хэлжээ.

Манай шавь нарын дунд ч ийм жишээ бий, хагалгаа хийлгэх шаардлагагүй юм байна гэж Багш нь хэлсэн тул мэс засал хийлгэх зовлонгоос ангижирсан гэнэ. Тогтсон үйлийн үр өөрчлөгдөхгүй гэдэг нь эгэл хүмүүсийн тухайд юм. Үнэндээ тогтсон үйлийн үрийг өөрчилж болдог. Зүүдлэх нь тогтсон үйлийн үрээ төлж буй бас нэгэн арга хэлбэр мөн, жишээ нь, зүүдэндээ алагдах, цусаа урсгах гэх зэрэг байдаг. Гэхдээ зөвхөн Их Багшийн тусламжтайгаар л тогтсон үйлийн үр өөрчлөгдөж чадна.

Шавь нарын заримынх нь бясалгал саад тогтор ихтэй, зарим үед тэсвэрлэхийн аргагүй байдаг, учир нь тэдэнд тогтсон үйлийн үрээс нь гадна шинэ үйлийн үр байдаг болохоор бясалгал хийх явцад жирийн хүнийг бодвол тэсэж тэвчихэд илүү хэцүү болдог. Тэд өдөр бүр эрхбиш заавал бясалгаж суун хоёр цаг хагас Гэрэл, Аялгууны бясалгал хийх ёстой, ингэвэл шинээр үүссэн үйл түйтгэрээ цэвэрлэж чадна. Гэтэл зарим хүнд өдөр бүр хоёр цаг хагас бясалгах нь хэцүү санагдан шалтаг тоочдог: Нэгд,бие муу, хоёрт, цаг зав байхгүй, гуравт, сэтгэл татах ертөнцийн зүйлс дэндүү их гэх мэт. Хэрвээ бясалгалаа Багшийнхаа тогтоож өгсөн цагийн дагуу хийхгүй бол шинэ үйлийн үр үргэлжлэн нэмэгдсээр байдаг.

Энгийн хүний тарьсан үйл үрийнх нь үр дагавар тэр даруйдаа бус, харин дараа дараагийн төрөлд нь илэрнэ. Харин Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүн энэ нэг төрөлдөө туулан гэтлэхийг хүсэж буй бол тогтсон үйлийн үр, шинэ үйлийн үр хоёр нь зэрэг илэрч байдаг. Энгийн хүн хийсэн үйлийнхээ үрийг эдлэхийн тулд заавал дахин төрөл авч, үйл үрээ эдлэх ёстой тул үйлийн үр нь тийм хурдан илрэхгүй. Арьяабалын аргаар

бясалгадаг хүн дахин сансрын хүрдэнд эргэлдэх шаардлагагүй болохоор үйл түйтгэрээ заавал энэ төрөлдөө төлж барагдуулах ёстой бөгөөд шинээр зохиосон “шинэ үйл түйтгэр”-ээ ч мөн энэ төрөлдөө төлөх ёстой.

Жишээ нь, маш их шидийн хүчтэй Молом тойн шидээ хэрэглэн маш олон түвшнийг тольдон хардаг төдийгүй буруу номтныг ч номхруулдаг байжээ. Шагжамуни Будда нэгэнтээ түүнд шидийн хүч хэрэглэж огт болохгүй гэж сануулсан ч тэр сонсоогүй байна. Эцэст нь буруу номтны чулуунд дарагдан амиа алджээ. Энэ бол түүний тарьсан шинэ үйл түйтгэр, тэгэхээр шидийн их хүчтэй байгаад ч нэг их нэмэр тус байхгүй. Үйл түйтгэр тарьсан л бол заавал буцааж төлөх хэрэгтэй болно.

Өвдөх нь заримдаа буян хишиг болдог тул та нар өвчин эмчлэхийн тулд сүнслэг бясалгалын хүчийг ашиглах ёсгүй. Энэ нь жам ёсны хуулийг зөрчиж байгаа хэрэг. Бие махбодтой байх үед л ид шидийн хүч байдаг, бие махбод байхгүй болбол ид шид ч алга болно, тиймээс энэ хүч нь төгс бус юм.

Хамгийн дээд шидийн хүч бол шидийн хүчтэй гэдгээ үл мэдэх, бусдыг гэтэлгэсэн ч гэтэлгэгдсэн хүнгүй байх явдал юм. Миний шавь нар бүгд шидийн хүчтэй. Учир нь Багш нь тэднийг хараад л ерөөл барилдлага үүсгэсэн тул энэ дэлхийгээс явахдаа тэд тамд унахгүй.

Хамгийн дээд шидийн хүч бол Би-үгүй түвшин бөгөөд хэлбэргүй, дүрсгүй. “Би-тэй байх” нь буруу номтон бөгөөд орчлон ертөнцтэй нэгдмэл болоогүй байдаг. Орчлон ертөнцтэй зохицож чадах нь үнэн ёс бөгөөд жам ёсны зүйл юм. Жишээ нь, нар газар дэлхийг гийгүүлж, дөрвөн улирал ээлжлэн солигдсоор байдаг шиг.

Шавь нарын зарим нь Багшийгаа өөр өөр дүр төрхөөр хардаг, үнэндээ бол Багш нь энэ л нэг янзаараа, гэвч хүмүүсийн хардаг нь өөр өөр, бодол санаа нь ч өөр өөр, дэс түвшин нь ч ялгаатай болохоор тусгаж буй дүрс нь мэдээж өөр өөр байдаг. Бүх зүйл сэтгэлээс үүдэлтэй.

Тогтсон үйлийн үр ба шинэ үйл түйтгэрийн аль нь ч өөрчлөгдөж болно. Гэхдээ эгэл жирийн хүнийх өөрчлөгдөхгүй. Зөвхөн бясалгагч хүнийх л өөрчлөгдөнө. Бясаллагчид ч хоорондоо ялгаатай, бясалгалын арга нь өөр өөр, дэс нь ч адилгүй. Ер нь Их Багш нарыг олон дэсэд хуваадаг. Энгийн нэг их багш хүч багатай тул бидний тогтсон үйлийн үрийг өөрчилж чадахгүй. Гэхдээ

бид түүнээс сайн сургаал номлол сонсож, ёс суртахуунтай үйл үйлдсэнээр дараа төрөлдөө их хүч чадалтай, сайн их багштай уулзаж тун магадгүй. Тэр хүн нь хэрвээ бодьсадвагийн хувилгаан мөн бол бүхий л үйлийн үрийг өөрчилж чаддаг.

Зургадугаар үеийн Өвөг Багш Хүй Нөн бол Шэншиүгээс огт өөр, билиг ухаан нь адилгүй, хүч чадал нь ч өөр. Эх газрын Хятад орон номын багш олонтой, гэрээс гарагчид ч бас маш их, Шэншиү улсын их багш болж чадсан нь үнэхээр амаргүй хэрэг. Гэхдээ түүний дэс Хүй Нөнгийнх шиг өндөр биш. Шэншиү бол жирийн нэг номын багшийн төлөөлөл. Зөвхөн Хүй Нөн л цорын ганц ихэд билиг нээгдсэн хүн юм. Тэрээр: “Бодь сэтгэлийн мод угаас байхгүй тул тольдох тавцан яаж байх вэ? Бүх зүйл нэгэнт хоосон тул тоос хаана тогтох вэ?” гэжээ. Хүний бие бол бодь мод шиг, хүний сэтгэл бол болор толь шиг, тиймээс байнга арчиж цэвэрлэж байгаарай гэж Шэншиү хэлсэн аж. Болор толь хаана буй гэсэн нь төгс гэгээрсэн хүний хувьд үйлийн үр гэж байхгүй. Ийм үгийг бусад номын багш нар хэлж зүрхлэхгүй, Хүй Нөнгийн хэлсэн үг бусад багш нарынхаас заавал өөр байдаг. Учир нь тэдний дэс асар их зөрөөтэй.

Эрин цаг бүрт тийм олон их багш төрөх боломжгүй. Энэтхэг асар том газар нутагтай ч хоёр мянга гаруй жилийн өмнө зөвхөн Шагжамуни Будда, Вималакирти Их Багш хоёр л төржээ. Эх газрын Хятадад зөвхөн Хүй Нөн Их Багш л хамгийн алдартай нь байсан хэдий ч олон хүн Түүнийг буруу номтон хэмээн гүтгэж, шүүмжлэн буруутгаж байжээ.

Хүмүүсийн зарим нь судар ном уншихад хэт автдаг. Судар бол харилцан адилгүй дэс түвшний хүмүүст зориулагдсан байдаг. Нэгэн өдөр Шагжамуни Буддагаас нэг хүн асуулт асуухад Тэрээр: “Ижилхэн” гэж хариулжээ. Удалгүй дахин өөр нэг хүн ирээд яг тийм асуулт асуухад: “Өөр өөр” гэж хариулжээ. Шавь нар нь ихэд гайхаж, яагаад ижил асуултанд өөр өөрөөр хариулна вэ? гэсэнд Шагжамуни Будда: “Энэ та нарт ямар хамаатай вэ?” гэжээ. Эндээс бид дэс нь адилгүй бол сонсох хариулт нь ч бас өөр өөр байдгийг мэдэж болно.

Зарим хүн учир явдлын үнэн мөнийг ойлгохгүй, Их Багшийн хэлсэн үгэнд итгэхгүй байдаг. Тэд мөн Түүнийг шүүн дүгнэж, гүтгэн буруушааж, буруу номтон гэнэ. Үнэндээ энэ нь Түүнийг ойлгоогүйгээс болсон хэрэг. Хэн нэгнийг шүүн дүгнэе гэвэл заавал тодорхой хугацаа өнгөрч байж л сая шүүн дүгнэж, магадлан тогтоож чадна. Шагжамуни Будда дөчин есөн жил ном

айлдсан бөгөөд Тэрээр хэлэхдээ: “Миний ярьсан нь яг л миний атгаж байгаа Линшан уулын модны навч шиг өчүүхэн төдий.”
Азучуу эгнэ Гэгээвэрийн Түүхүүд 3-д Тэгж Гэгээрсэн Их Багш Чин Хай гэжээ. Ганц хоёрхон хоногт, ганц хоёрхон жилд нэгэн Их Багшийг ойлгох боломж байх уу?

Нэгэн Их Багшийг жинхэнээр ойлгоё гэвэл заавал түүнтэй нэг ижил дэсэд хүрэх хэрэгтэй. Тэгж байж л ойлгоно. Өнөөдрийн айлдвараа энд хүрээд өндөрлөө. Асуулт байна уу?

Асуулт: Судар уншихад ихэнхдээ заавал буян хариулал үйлддэг. Бид бясалгаж суусны дараа бас буян хариулал (бясалгалын ач буянаа хамаг төрөлтөнд түгээн тараах үйл) үйлдэж болох уу?

Их Багш: Болно. Энэ бол бидний сайхан сэтгэл бөгөөд бас ивээл авралын хүчтэй.

Асуулт: Багш аа! Та сайн байна уу? Би Бурханы шашинд шинээр орсон хүн. Уг нь католик шашинтан байсан. Саяхан эхнэр маань Бурханы шашинд орсон. Би бурхны шашинтан болоод удаагүй, би ямар судар уншвал дээр вэ?

Их Багш: Ямар ч судар унших шаардлагагүй, зүгээр л сайтар шаргуу бясалгахад л болно. Гэхдээ та уншмаар байвал уншиж болно л доо. Багш өөрөө хамгийн сайн судар юм. Тиймээс зүгээр л ирээд Багштайгаа уулзаж байхад л хангалттай.

Асуулт: Би айлын байр түрээсэлж суудаг. Байрны эзний эхнэр нас барсан бөгөөд чандарыг нь зочны өрөөнд байрлуулсан юм. Манай эхнэрийн бие ойрд жаахан тавгүйрхээд байгаа нь тэр чандарын хайрцагтай холбоотой юу?

Их Багш: Тийм, гэхдээ та бясалгал хийвэл зүгээр болно. Танай эхнэр ногоон хоол идэж байгаа юу, цагаан хоолтон уу? Бясалгал хийдэг үү? Уг нь бурхан хаа сайгүй байдаг, гэхдээ ад чөтгөр ч бас бий. Хэрэв бясалгал сайн хийвэл тэр ч бүү хэл оршуулгын газар, эсвэл буг чөтгөртэй газар байсан ч та айхгүй. Хэрэв бясалгал хийхгүй бол бурхны сүмд байхдаа ч та айх болно, тэнд ч ад чөтгөр байдаг.

Тиймээс бясалгал хийх үнэхээр чухал. Хэрэв та бүх зүйлийг өөрчлөхийг хүсвэл заавал бясалгах хэрэгтэй. Үхэж төрөхийн хүрднээс ангижиръя гэвэл бүр ч илүү бясалгах хэрэгтэй.



ҮЙЛ ТҮЙТГЭР УГААС ХООСОН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайбэй хот, Цаглашигүй гэрэлт бясалгалын төв
1987 оны 10 дугаар сарын 25. (Эх нь хятад хэлээр)*

Их олон хүн нэгэн Будда болох гэж маш их яарч байгаа нь надад тун инээдтэй, бас өхөөрдөм санагддаг. Ямар төрлийн Будда болохыг хүсээ вэ? Та бүхэн аль хэдийнээ Будда болчихсон байна. Уг нь ямар ч зовлонгүй байв. Бүгд өөрөө өөртөө удсан төвөг бэрхшээл, зовлон бухимдал байдаг. Үнэн шүү, зовлонтой зүйл ер байхгүй, энэ дэлхийн аливаа юмс ердөө л тоглоом төдий!

Багшид нь угаасаа зовох зовлон байхгүй, харин та нараас болж зовлонтой болов, учир нь та нар дэндүү их зовлонтой. Багшийгаа харах болгондоо уйлж, элдэв зовлон тоочдог. Та нарыг маш их зовохыг чинь хардаг ч туслах аргагүй. Мэдээж Багш нь ч бас шаналж, “Тэр яагаад ингэж зовно вэ, яагаад ийм тэнэг юм бэ?” гэж бодно. Гэхдээ би түүнд юу ч ярихын аргагүй, учир нь тэр яг л сохор хүн шиг, нар энд тод гэрэлтэж байхад тэр харин, “Байхгүй л байна шүү дээ! Нар хаана байна вэ?” гэдэг. Багшийнхаа хэлсэн санааг ойлгож байна уу? Энэ нь үнэхээр өрөвдмөөр!

Зовлонгийн гашуун далайгаас гэтлэе гэвэл тун амархан, ердөө л жаахан чихэр нэмээд энэ гашуун далайг бал бурмын далай болгон хувиргавал болчихно. (Бүгд инээлдэв.) Уг нь бол Формоса гашуун далай байх учиргүй, учир нь энд идээд барахгүй маш их элсэн чихэр байдаг. Ямар ч хоолонд заавал элсэн чихэр нэмдэг тул идвэл дотор эвгүйрхдэг. Тэр ч байтугай давстай зүйлд ч элсэн чихэр нэмнэ. Би жинхэнэ шорвог амттай идээг Формосагаас хайгаад олоогүй. Давслаг жигнэмэгт ч элсэн чихэр нэмээд чихэрлэг амттай болгочихдог, тийм биз? Зууш нь ч

чихэрлэг амттай, харин бид энд өөрсдөө хоолоо хийдэг болохоор асуудалгүй.

Бясалгагч хүн хүсэл шунал багатай, саруул уужуу дотортой байж, ямар ч нөхцөл байдалд сэтгэл хангалуун байж, маргааш ангижирсан ч баяртай явж, тамд унасан ч үл тооно, ийм байж чадвал л сая Бурханы хутагт хүрч чадна. Хэрэв тамаас айвал Будда болж чадахгүй, хамаг төрөлтөн болохоос айвал Будда болж чадахгүй бөгөөд хамаг төрөлтнийг гэтэлгэхийг хүссэн ч Будда болж чадахгүй. Учир нь дэндүү завгүй, үүнээс ч айж, түүний ч тухай бодсоор явтал Будда гэж хэн болохыг ойлгох цаг зав гарахгүй. Бид өдөр бүхэн тамд байгаад завгүй, там, там... гэж бодсоор байгаа бол мэдээж нирвааныг харж чадахгүй, ойлгов уу? Бидний анхаарал хаана байна, сэтгэл тэнд байж, бусад зүйлийг анзаарахаа больдог, тийм биз?

Би тун энгийн нэгэн зүйрлэл яривал та нар амархан ойлгоно. Жишээ нь, та зурагт үзэж байгаа ч толгойд тань элдэв ажил, бизнестэй холбоотой шийдэж чадахгүй олон санаа зовоосон зүйл бодогдоод байвал зурагт үзэж суугаа хэдий ч юу ч үзэхгүй, тийм биз? Зурагтаар олон зүйл гарч байдаг ч бид тэр бүхнийг харахгүй байдаг. Заримдаа бид сонингоо маш анхааралтай уншиж байх үедээ хүүхдүүдийн чимээ шуугианыг сонсдоггүй. Сонингоо тавих үедээ л хүүхдүүд маш их шуугилдаж байхыг мэддэг. Тэд хэдийн шуугилдаж байсан ч бид сониндоо дэндүү их төвлөрч уншсанаасаа болоод юу ч сонсоогүй байна. Зурагтаар олон нэвтрүүлэг гарч байсан ч ажил, бизнесийнхээ асуудалд анхаарлаа хандуулсан учраас юу ч үзээгүй байдаг. Миний санааг ойлгож байна уу?

Үүнтэй ижил нөхцөл байдал гэвэл та бүхэн тамаас айж, өдөржин тамын тухай боддог бол хэдийгээр хүн нь энд амьдарч байвч сэтгэл нь аль хэдийнээ тамд орчихсон байдаг. Үүний нэгэн адил та нар хамаг төрөлтнийг “гэтэлгэх” гэвэл сэтгэл тань арван зүг, гурван цагийн хамаг төрөлтний тэнд хүрч, жинхэнэ эзэн (“билгийн мэлмий”)-ийхээ энд тогтохоо больдог. Үнэндээ бид сэтгэлээ өөрийн жинхэнэ эзэн дээрээ төвлөрүүлж л байвал ямар ч төрөлтнийг гэтэлгэж чадна. Тэднийг гэтэлгэх гэж яарах шаардлагагүй, ойлгож байна уу? Аливаа бүхэн жамаараа гэтлэгдэнэ. Хүн нь энд суугаад арван зүгийн хамаг төрөлтнийг Гэрэл цацруулан гэтэлгэнэ. Гэхдээ тэднийг гэтэлгэсэн гэж нэг ч төрөлтөн мэдэхгүй, тэр ч байтугай та дэлхий даяарыг гэтэлгэсэн ч тэд мэдэхгүй. Энэ нь сая хамаг төрөлтнийг гэтэлгэж байгаа

явдал болно.

Энэ нь та нар энд яаран ирээд: “Би хамаг төрөлтнийг гэтэлгэхийг хүсэж байна. Тэд маш их зовж байна.” гэж гунигтайгаар уйлагнах явдал биш юм. Тэр ч бүү хэл та үхтлээ уйлсан ч тэдэнд тус нэмэр болж чадахгүй. Та өдөр бүр тэдэнтэй зууралдаад тэднийг гэтэлгэх гэж яаравч тэд танаар гэтэлгүүлэхгүй. Хамаг төрөлтнийг гэтэлгэх гэгч тийм ч амар ажил биш. Та гэтэлгэх тухай бодох тусам тэд танаас улам зайлан холдоно. Бүгд л бид өөртөө яршиг төвөг эрж байгаа хэрэг, биднээр гэтэлгүүлэх дуртай төрөлтөн байхгүй. Бурхан бодьсатва хамаг төрөлтнийг гэтэлгэхдээ юу ч боддоггүй, “хамаг төрөлтнийг гэтэлгэе” гэсэн бодол төрдөггүй, тэд хийдэг ажлаа хийдэг л төдий, хамаг төрөлтөн аяндаа гэтлэгддэг.

Төрөл төрөлдөө хамаг төрөлтнийг гэтэлгэдэг хүн байдаг. Гэвч хамаг төрөлтөн Түүгээр гэтлэгдсэнээ мэддэггүй. Энэ бол Бурхан бодьсатвагийн хүч, эсвэл их Мөр ёсны хүч болно. Хамаг төрөлтнийг гэтэлгэхийн төлөө бид ямар нэгэн зүйл хийх хэрэггүй, хамаг төрөлтөн Түүнийг таньдаг л бол жамаараа гэтлэгддэг, ойлгов уу?

Тэр хүн бол туулан гэтэлсэн эрх чөлөөт болж, хэдийнээ Бурханы хутагт хүрсэн, төрөл төрөлд оршин байдаг хүн бөгөөд Тэр л хамаг төрөлтнийг гэтэлгэж байгаа хэрэг, харин бид хэн нэгнийг гэтэлгэж байгаа юм биш. Ихэнхдээ хүмүүс өөрийн “би гэх үзэл”-ээр бусдыг гэтэлгэдэг. Хамаг төрөлтөн зовж байна, тэднийг гэтэлгэх хэрэгтэй хэмээн оюун ухаанаараа боддог. Үнэндээ бол зовлонтой төрөлтөн гэж байдаггүй, зөвхөн бид өөрсдөө л зовж шаналж байдаг.

Бид билиг нээгдэхээсээ өмнө хамаг төрөлтнийг зовж байна гэж хардаг. Газрын зүрхэн бодьсатва гэгээрэхээсээ өмнө хамаг төрөлтнийг харахад тун их зовлонтой байжээ, иймээс сая тамыг харсан байна, ойлгож байна уу?

Гэгээрснийхээ дараа Тэр там гэж байхгүйг мэдсэн байна. Тэр ч байтугай хэрэв там байсан ч хамаагүй, тамд тавин мянга, эсвэл таван мянган жил байх нь бурхан бодьсатва нарын хувьд яг л нэгэн агшин төдий шиг байдаг бөгөөд там угаас оршдоггүй, ойлгов уу? Жишээ нь, бид энэ дэлхийд нэг зуун жил хүртэл амьдарч чадна, диваажинд зарим хүн таван зуун жил, таван мянган жил хүртэл амьдарч чадна гэх мэт байдаг. Энэ хугацаа ч бурхан бодьсатвагийн хувьд асар богино, ердөө л хуруу инчдэх төдий хугацаа юм. Тиймээс Бурхан Багш маш хурдан гэдгийг

илэрхийлэхдээ үргэлж үүгээр зүйрлүүлдэг.

Бид өөрсдөө нисванисийг зохиодог болохоор өдөр бүр зовж шаналдаг. Суралцах ёстой хичээлээ бид шийтгэл болгон хувиргадаг, тиймээс маш их зовлонтой байдаг юм. Багш нь та бүхэнд зовлонгийн далайгаас гарах маш хялбар арга зааж өгнө. Энэ бол зовлонтой нөхцөл байдлыг суралцах хичээл болгон хувиргах явдал, яг л сургуульд суралцаж буй мэт.

Сургуульд хүүхдүүд олон төрлийн хичээл үздэг. Зарим хичээл нь уншихад сонсголонтой шүлэг найраг байдаг нь тун таатай байдаг. Жишээ нь, Су Дунпо, Ли Байгийн яруу найраг, эсвэл мөн Жан Жигийн хамгийн алдартай яруу найраг болох:

“Сар шингэж, хэрээ гуаглан
огторгуй дүүрэн хяруу,
Загасчдын дэн, голын хөвөөний агч мод
гансралт нойрыг эсэргүүлмүй.
Ханшань уулын хийдийн дуган
Гү сү хотын гадна,
Хүрэл жүнгийн шөнийн дуун
аяны онгоцноо сонсогдмуй.”

Энэ үнэхээр уран тансаг, таатай сайхан байнам биш үү? Хэн нэгэн тийм сайхан үзэмжийг яаж ийм яруу сайхан дүрсэлж чадна вэ гэж бид гайхаж магад.

Цао цао ч мөн шүлэг бичиж чаддаг байсан. Түүний шүлгүүд бас их тансаг сайхан, сэтгэл хөдөлгөм байдаг. Түүний шүлгүүдийг унших үедээ би ихэд биширсэн. Хүн хөнөөхдөө нүдээ ч цавчдаггүй хүн яаж ийм сайхан шүлэг бичдэг байна аа гэж бодсон. Яагаад ийм төрлийн хүн тийм болсныг нь дараа Багш нь ярьж өгье. Учир нь жинхэнэ яруу найрагчид, эсвэл жинхэнэ хөгжимчдийг хагас гэгээнтэн гэж нэрлэж болох бөгөөд тэдний санаа сэтгэл нь цайлган, оюун бодол нь эрхэм дээд, тэд өдөр бүр өөрийн яруу найраг, хөгжмийн аялгуундаа автан цэнгэж байдаг.

Сургуульд яруу найраг, уран зохиол, дуу хөгжим, математик, биеийн тамир зэрэг олон хичээл заадаг. Би ахлах сургуульд сурч байхдаа хөгжмийн хичээл үзэж байсан, үүнээс гадна уран зураг, уран бичлэг, гар урлал, уран гимнастик, биеийн тамир зэрэг хичээл ордог байв. Бид олон хичээлд суралцах ёстой байсан. Зарим хичээлд бид илүү дуртай, заримд нь дургүй. Хэрэв

бидний дуртай хичээл орвол ихэд сонирхож, таатай санагдаж, аз жаргалтай болдог. Дургүй хичээл орвол урамгүй болж дургүйцэн: “Ийм уйтгартай зүйл үзэж яах юм бэ? Үүнийг сураад юу хийх вэ?” гэж бодно.

Багш нь ч багадаа бас иймэрхүү байдалтай байсан. Та нар энэ ном дахь Багшийнхаа товч намтрыг харвал сар бүр тэргүүн байрын батламж авдаг байсан тухай дурдсан байгаа, үнэндээ бол миний сурсан зүйл тун бага.

Ахлах сургуульд сурч байхдаа дургүй хичээл орвол хичээлийн завсарлага хүртэл чимээгүй хүлээж, дараа нь гадагш сэмхэн гарч, мотоциклоо унаад далайн эрэгт очин давалгааны чимээ сонсдог, эсвэл кофе шонд суун кофе ууж, жигнэмэг идэж, хөгжим сонсдог байлаа. Сэтгэлд нийцтэй хичээлүүдийг илүүд үздэг байсан тул сонирхсон хичээлээ сонгон суралцдаг байв. Далайн чимээ сонсож, өгүүлэл бичих дуртай байсан. Далайн чимээ сонсох үедээ онгод хөглөгдөх даруйд шүлэг тэрлэнэ. Дараа нь түүнийгээ эмхэтгэж, ном хэвлүүлсэн. Би багадаа өөрийн шүлгийн түүврээ хэвлүүлсэн болохоор ахлах сургуульдаа аль хэдийн их алдартай болсон байв. Учир нь тэд миний шүлэгт их дуртай.

Би тийм ч их сураагүй, хамгийн залхуу нь байсан. Надаас та нар үлгэр дуурайл бүү аваарай. Би үнэнийг л ярьж байна. Та бүхэн Багшийгаа дуурайн суралцаж болохгүй. Учир нь Формосад нөхцөл байдал огт адилгүй, хувь хүний чадамж ч өөр өөр, зарим хүн маш ихийг сурч байж төгсдөг бол зарим хүн нэг ихийг сураагүй ч төгсөж чаддаг.

Энэ нь: “Нохой эвшээхэд ялаа аманд нь оров.” гэдэг үгтэй адил, нохой зориуд ялааг залгиагүй, харин нохойг эвшээх үед ялаа аманд нь орж таарсан байна. Багшийнх нь нөхцөл байдал үүн шиг, би сураагүй ч луу биет номын сахиуснууд миний өмнөөс суралцаж, миний өмнөөс шалгалт өгсөн байх. Та нар энэ муу үлгэр жишээг дагаж болохгүй. Сургуульд байхад манай ангийнхан бүгд Багшийг нь эрхлүүлдэг байлаа. Тэд Багшийг нь маш их шүтэж, надаар их бахархаж, хөхиүлэн магтдаг байсан тул би их л эрх хүүхэд байсан юм, ойлгов уу?

Багш нь багаасаа л магтаал сайшаалд дэндүү умбасан, бараг л үхтлээ эрхэлсэн, юу дуртайгаа хийдэг хүүхэд байв. Багш нар ч бас намайг их эрхлүүлнэ, яагаад гэдгийг би мэдэхгүй. Би тийм ч сайн сурч байгаагүй. Дургүй хичээл орох бүрт зугтаж яваад кофе уудаг байв. Гэсэн ч тэд бүгд надад сайн, бүр маш их хайртай

байсан. Тэр багш нар яагаад надад тийм их хайртай байсныг би одоо ч ойлгодоггүй. Тэр ч байтугай би хичээлд нь дургүй байхад ч надад сайн ханддаг байсан.

Хэрэв би хааяа үлдэж, тэдний заадаг хичээлийг нь сонсвол тэдэнд нэр хүндтэй санагдах бөгөөд дуртай байдаг байсан. Харин бусад сурагч бол тэгж болохгүй, хүн бүр хичээлээ таслаад кофе уухаар явж болдог юм биш. Учир нь манай ахлах сургууль маш хатуу дүрэм журамтай, нэр дуудаж бүртгэнэ, хэрвээ нэр дуудахад байхгүй бол асуудалд орно, ойлгож байна уу?

Гэвч тэд Багшийг нь хичээлээ таслахыг хараагүй мэт байх бөгөөд бүртгэх үед нэр дуудахад байхгүй бол бас хамаарахгүй, хэн нэгэн нь миний өмнөөс заавал хариулж, “өвчтэй тул харьсан, эсвэл угаалгын өрөө лүү явсан, эсвэл юу ч юм... түүнд тохиолдсон.” гэх мэтчилэн аргална. Ангийн хүүхдүүд Багшийг нь үргэлж хамгаална, хэдийгээр ганц хоёр их атаархдаг хүүхэд байсан ч ихэнх нь надад тун сайн хандана. Учир нь тэд надтай хамт байхдаа эрх тааваараа, баяр баясгалантай, чөлөөтэй байж, тийм ч төлөв томоотой биш болдог. Мөн сургуулиас ч тэгж их хатуурхахгүй. Тэд бүгд миний чөлөөтэй, тааваараа байхыг хараад өөрсдөө тийм байж чадахгүй тул их л бахархана.

Энэ дэлхий ч ялгаагүй, хэрвээ бид хүчтэй бол өөрсдийн хичээлээ сонгож чадна. Арьяабалын аргаар бясалган дадуулдаг хүн улам хүчирхэг болж, улам бүр өөртөө итгэж, өөрийн хичээлээ улам илүү сонгох чадалтай болно. Энэ дэлхийн сургуульд хүлэгдэхээ больж, улам хөнгөн сэлүүн, эрх чөлөөтэй болдог. Энэ нь Бид хувийн зан чанараа өөрчилсөн биш, харин бидний хандлага, үзэл бодол өөрчлөгдөж, аливаа зүйлийг өөрөөр хардаг болсон байна. Жишээ нь, өмнө нь бидэнд амин чухал байсан зүйлс, хэрэг явдлууд одоо огт чухал биш болсон, ойлгож байна уу? Учир нь бид ямар нэг зүйлтэй дэндүү их зууралдахаа больсон болохоор хүмүүс биднийг хараад: “Энэ хүн Их Багшийг даган суралцсанаас хойш зан чанар нь маш их өөрчлөгджээ.” гэдэг. Энэ нь Багш нь шидийн хүчээр түүний зан араншинг өөрчсөн хэрэг биш, харин Арьяабалын бясалгалын аргыг дадуулснаар үзэл санаа нь өөрчлөгдсөн байна. Яг л хүүхэд шиг, хүүхэд том болох тусмаа бодол санаа нь өөр болдог, тийм биз? Бидний санаа бодол одоо хорин настай үеийнхээсээ ондоо, таван настай үеийнхээсээ бүр ч ондоо болсон, тийм биз? (*Бүгд, Тийм гэж хариулав.*) Учир нь бид өсөж том болжээ.

Бясалгагч хүн, ялангуяа Арьяабалын бясалгалын аргыг

дадуулдаг хүн ч мөн адил. Хэрэв тэд үнэхээр Багшийнхаа зааврын дагуу бясалгавал өөрчлөгдөх нь гарцаагүй. Өөрчлөгдөхгүй байх боломжгүй. Учир нь энэхүү Арьяабалын хүч сэтгэгдэшгүй их, яг л ус шиг, хэрэв бидний хувцас хиртэй бол савандаж, урсгал усаар угаавал лавтай цэвэрхэн болно, ойлгож байна уу? Арьяабал бол тийм төрлийн Аялгууны урсгал бөгөөд мэдээж энэ нь бидэнд үйл түйтгэрээ угаан арилгахад тусална. Зөвхөн тэр үед л бид үйл түйтгэр угаасаа хоосон гэдгийг жинхэнээр ойлгоно.

Яагаад “хоосон” гэж хэлдэг вэ? Тэр үед бид өөрийгөө уучилж, энэ нь юу ч биш, энэ бол үйл түйтгэр биш, жамаараа болсон зүйл байсан бөгөөд би ямар ч гэмт хэрэг хийгээгүй гэдгээ ухаардаг, ойлгов уу? Тэр үед бид яагаад гэмгүй болохоо жинхэнэ ёсоор ухаарч ойлгоно. Учир нь энэ нь угаасаа гэм биш.

Жишээ нь, бид багадаа эцэг, эхээсээ: “Би хаанаас ирсэн бэ?” гэж байнга асуудаг байсан. Би ч гэсэн ээжээсээ ингэж асуухад тэр, би чамайг бодь модны дороос олсон гэсэн. Манай тосгонд сүмийн яг дэргэд нэгэн маш үзэсгэлэнтэй гоёмсог, сүүдэртээ сэрүүхэн аварга том бодь мод ургасан байдаг байв. Би ээжээсээ: “Би хаанаас ирсэн бэ?” гэж асуух болгонд тэндээс олж аваад өсгөсөн гэж хариулна. Зарим хүн хүүхдэдээ: “Чи миний аман дотроос гарч ирсэн.” гэх юмуу, эсвэл өөр тайлбар хэлдэг. Харин та нар хүүхдэдээ юу гэж хэлдгийг би мэдэхгүй. Хүүхэд өсөж томроод тухайлбал, өсвөр насанд хүрэхдээ сонин хэвлэл, зурагтаас жаахан ойлголттой болж, хүүхэд яаж төрдгийг мэдэх болдог. Гэсэн ч эцэг, эх нь тэднийг хүүхэдтэй болохыг нь зөвшөөрөхгүй хэвээр байдаг, ойлгож байна уу? (*Хэн ч хариулсангүй.*) Та нар яагаад ийм чухал царайтай болчихов? Энэ сүртэй зүйл биш шүү дээ! Өчүүхэн явдал! Энэ тухай ярих бүрт хүмүүс их л сандардаг. Загатнасан газраа маажих нь ноцтой явдал гэж та нар бодож байна уу? (*Бүгдээрээ, Үгүй гэж хариулав.*) Иймэрхүү зүйл нь яг л загатнасан газраа маажих шиг жам ёсны хэрэг, тэгж их сандарч тэвдэх шаардлагагүй. Та нарыг харахад бараг сонсож зүрхлэхгүй байх шиг байна. Үнэндээ үүнээс ч дор зүйлс байдаг, гэхдээ би тэдний талаар хараахан яриагүй байна.

Хүүхэд өсөж, өсвөр насанд хүрвэл эцэг, эх нь түүнд: “Охидтой ойрхон байж болохгүй, найз охинтой болох хэрэггүй, эрэгтэй, эмэгтэй хүмүүс заавал тусдаа байх ёстой.” гэж хэлдэг. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ахлах сургуулиудийн дунд цагдаа нар байна. Багш нар, эцэг, эх гээд олон ёс зүйн ойлголт, нийгмийн зүгээс хориглосон зүйлс, таван сахил, арван сахил гэх мэтийг

бүгдийг нь тэдний дунд тавьдаг. Гэхдээ тэд том болж, жишээ нь хорь, хорин тав, эсвэл гучин нас хүрвэл эцэг, эх нь гэрлэхийг шаардаж эхэлдэг. Тэр үед тэд гэрлэхээс өөр аргагүй болно. Тэр үед тэр хүсэхгүй байх болно, учир нь тэр илүү дэвшилтэт зүйлийг сурах ёстой. Тэр хүүхэдтэй болох насанд хүрсэн бөгөөд хэрвээ хүүхэдтэй болохгүй бол эцэг, эх нь сэтгэл зовно. Энэ бүхэн хоорондоо зөрчилтэй биш гэж үү? Үгүй. Тэр үед танд буруутай мэдрэмж төрсөн хэвээрээ байх уу? Үгүй. Учир нь та том болж, өөр санаа бодолтой болжээ, хүүхэдтэй болох нь буруу зүйл биш, жам ёсны хэрэг гэдгийг та мэднэ. Та гэрлэж, эхнэртэйгээ харилцаатай байж үр хүүхэдтэй болж, эцэг эхээ баярлуулах хэрэгтэй. Бидний багадаа нүгэл гэж боддог байсан зүйлс одоо зөвдөж, маш чухал, зайлшгүй зүйл болсон байна, ойлгож байна уу? (*Бүгд, Тийм гэж хариулав.*) Та нар ойлгоогүй л юм шиг харагдаж байна даа. Хэрэв та нар ойлгохгүй байвал Багш нь өөр зүйрлэл хэлж болно.

Бясалгалын хувьд ч мөн адил, хэдийгээр үйл түйтгэр угаас хоосон хэдий ч заавал үе шаттайгаар алгуураар бясалгаж байж “Үйл түйтгэр угаас хоосон.” болохыг жинхэнэ ёсоор ойлгоно. Бага байхад энийг ч, тэрийг ч хийж болохгүй байсан, арай томорсон хойно ч мөн л хийж болохгүй хэвээрээ байдаг. Тэр ч байтугай мэддэг байсан ч түүнийг хийж болохгүй хэвээр байсан. Харин том болоход тэдгээр нь заавал хийх ёстой зүйл болон хувирч, хийхгүй байж болохгүй болно. Тэр цагт энэ нь нэг төрлийн үүрэг хариуцлага, даалгавар болдог. Өмнө нь хагуу хориглодог байсан бол одоо гэрлэх хэрэгтэй хэмээн хүүхдүүдээ ятгах болжээ, тийм биз?

Үүнтэй ижил, бясалгал дээшлэх үед, тэр ч байтугай дэлхийгээрээ таныг гэмт хэрэг үйлдсэн, эсвэл асар хүнд үйл түйтгэртэй гэж хэлсэн ч хамаагүй та ер үл тоох бөгөөд харин ч инээдэмтэй санагдаж: “Үйл үйтгэр гэж юу вэ? Би үйл түйтгэр гэж мэдэхгүй, хэрвээ та үйл түйтгэртэй бол түүнийгээ тэврээд унтаж болно. Харин надад үйл түйтгэр байхгүй.” гэж хэлэх юм. Ойлгож байна уу? Гэвч үйл түйтгэрээс зуураад байгаа түйтгэртэй тэр хүн танд ер итгэхгүй. Тэр харин: “Танд ч бас үйл түйтгэр бий.” гэж танд хэлнэ. Учир нь тэр үйл түйтгэртэй гэдгээ мэдэрч, хаа сайгүй үйл түйтгэр хардаг, тэр дундаа таныг багтаагаад бүгд үйл түйтгэртэй байдаг. Тэр таныг хэдийнээ зовлонгийн далайгаас гэтэлж, үйлийн үрээс мултарсан бөгөөд юу ч хийсэн бай өчүүхэн ч нөлөөлөгдөхгүй болсныг үл мэднэ. Яг л хүүхэд өсөж томроод гэрлэсэн хойноо эр, эмийн явдал үйлдсэн ч гэм буруутай санагдахгүй болдог шиг, ойлгов уу? Тэр ингэж хийж

болох бөгөөд энэ нь хууль ёсны гэдгийг тэр мэднэ. Гэхдээ тэрээр энэ бүхнийг арван долоо, наймтай ахлах сургуулийн сурагчид хэлэхгүй, хэлэхийг ч хүсэхгүй. Учир нь хэлсэн ч тэр хүүхэд итгэхгүй. Насанд хүрч гэрлэсэн хүн шиг эрх чөлөө тэр хүүхдэд байхгүй, учир нь хараахан нас биенд хүрээгүй тул тэр хүүхэд ойлгохгүй. Сурган хүмүүжүүлэх ханыг давж амжаагүй, хатуу чанд ёс суртахууны үзэл баримтлалаас хэтийдээгүй байдаг.

Жишээлбэл, хэрвээ бага сургуулиа төгсөөгүй бол бид хүссэн ч дунд сургууль, ахлах сургуульд орж чадахгүй. Сэмхэн ороод суухад, тэр байтугай хэн ч мэдэхгүй байсан ч бидэнд нэг л тавгүй байна, учир нь удалгүй ахлах сургуулийн олон шалгалтыг өгөх хэрэгтэй болно. Бага сургуулиа ч төгсөөгүй бидэнд ахлах сургуулийн шалгалтыг өгөх боломж огт байхгүй. Тиймээс нууцаар орж суралцсан ч бид юу ч хийж чадахгүй, учир нь сургуулийн ёс журамд нийцэхгүй байгаагаа мэдэж байдаг, ойлгож байна уу? Зовлонгийн далайгаас гэтлэхэд ч мөн адил, хэрвээ “үйл түйтгэр угаасаа хоосон” гэдгийг мэдэрч ойлгоогүй бол Арьяабалын аргаар бясалгах хэрэгтэй. “Үйл түйтгэр угаасаа хоосон.” болохыг мэдэрсэн бөгөөд “үйл түйтгэр угаасаа хоосон”-ы дэсэд хэдийнээ хүрсэн бол Арьяабалын аргаар бясалгах шаардлагагүй. Багш нь та нарт баяр хүргэнэ. Гэхдээ энэ нь хүмүүст их л эргэлзээтэй санагдах байх, ойлгож байна уу?

Бид хэдийгээр Арьяабалын аргаар бясалгавал “үйл түйтгэр угаасаа хоосон” болохыг жинхэнээр мэдрэх боловч хэзээ ч бид хүн алахгүй, ингэхийн оронд бүхий л төрөлтөн, орчлон ертөнцийн түмэн бодисыг илүү хүндэлнэ. Учир нь аливаа юм бүхэн өөрийн гэсэн үнэ цэнтэй, хүн бүхэн Бурхан чанартай, төрөлтөн бүхэн үнэхээр үнэт эрдэнэ мэт, үзэсгэлэн гоо төгс төгөлдөр. Чийгийн улаан хорхой ч төгс төгөлдөр, намгийн мэлхий ч төгс төгөлдөр, хүмүүс бүр ч илүү төгс төгөлдөр. Тэр цагт гэтэлгэгдэх ёстой төрөлтөн байхгүй болно, ойлгов уу?

Биднийг Багш гэтэлгэв гэж та нар боддог. Гэвч үгүй юм, та бүхэн өөрөө өөрийгөө гэтэлгэсэн, Багш нь ерөөсөө юу ч хийгээгүй. Гэхдээ би та бүхэнд үнэнийг хэлэх ёстой. Би та нарт маш их баярлаж байна. Хэрэв та нар үйл явдлыг сэргээх гэж ирээгүй бол Багш нь энд уйдаж үхэх байв. *(Бүгдээрээ инээлдэв.)* Учир нь надад одоо хийх ажил байхгүй болохоор энд би өөр юу хийх билээ? Өдрийг яаж барах вэ? Өмнө нь Багш нь нэгэн Будда болъё, бясалгая гэж хүсдэг хэвээрээ, үүнийг ч, түүнийг ч хийх ёстой хэвээрээ, хамаг төрөлтнийг гэтэлгэе гээд их л завгүй,

өдөржин яарч, бас ямар нэгэн зүйл хайна, эсвэл ирээдүйн хэрэг явдлыг анхаарах гэхчлэн хийгээд дуусахгүй их ажилтай байсан. Одоо бол Багш нь үнэхээр уйдаж байна, заримдаа юу хийхээ ч ойлгохоо больдог. Та нар байгаа болохоор Багш нь завгүй байна. Гэвч та нар заримдаа Багшийгаа дэндүү завгүй болгодог тул Багш нь бас гомдоллодог. Үнэндээ ямар ч ажилгүй атал өдөржин завгүй, завгүй, завгүй, учир нь та бүхний сэтгэл амар амгалан биш болохоор Багшдаа ажил гаргаж, төвөг уддаг. Тэр ч байтугай энд хүрэлцэн ирсэн ч Багш нь та нарт юу ч сургаж чаддаггүй. Учир нь та нар дэндүү завгүй, арван зүг, гурван цагийн бурхдыг бодоод судар ном бодоод тархи толгойгоо: “Би гэгээрмээр байна. Би заавал гэгээрнэ, би гэгээрнэ.” гэсэн бодлоор дүүргэдэг. Тэр ч байтугай Багш нь таны өмнөөс билгийг тань нээгдүүлэх гэсэн ч танд нээгдэх зай байхгүй, учир нь дэндүү олон зүйлийг савлаж, дэндүү зайгүй чихэлдсэн байна.

Дээр үед нэг хүн нэгэн их багшаас суралцахаар очжээ. Тэр гэгээрэхээр ихэд яарч байсан тул их багшийг шавдуулж, нууц түлхүүрээ өгөхийг шаардсан байна. Өнөөх их багш түүнд: “Та жаахан хүлээвэл яаж байна? Одоо цаг нь арай л болоогүй байна.” гэжээ. Тэр хүлээхээс өөр аргагүй болов. Гэвч өдөр бүр яарч адгасан хэвээр, энийг ч, тэрийг ч асууж лавлана. Хэсэг хүлээсний эцэст тэсэлгүй Багш дээрээ очиж, дахин лавлахад Багш нь түүнд: “Дахиад жаахан хүлээ, цаг нь арай болоогүй байна, та одоо арай л болохгүй.” гэхэд тэр итгэхгүй заавал авна гэв. Нэг өдөр Багшийнх нь бие өвдөхөд өнөөх гэгээрэхээр яарсан хүн Багшдаа хутга тулган: “Та өнөөдөр надад Дээдийн Ном уламжлах хэрэгтэй. Хэрвээ уламжлахгүй бол би таныг хөнөөнө. Өнөөдөр та өвдөөд хөдөлж чадахгүй болов, надад хурдан ном уламжил.” гэжээ. Багш нь шүүрс алдан: “Би одоо өгсөн ч чамд тавих газар байхгүй байна.” гэхэд тэр хүн сая нэг сэхээрч, билиг нь нээгджээ.

Гэгээрэлд олон дэс бий. Түүний тухайн өдрийн гэгээрэл нь биднийхтэй адилгүй. “Гэгээрсэн” гэдэг нь тэр хүн эцэст нь өөрөө хэтэрхий дүүрсэн байгаагаа ойлгож, мэдсэн гэсэн үг. Түүний тархи толгой нь өөрийн гэсэн өрөөсгөл бодол, хувийн үзэл санаа, санал дүгнэлтээр дүүрсэн байгааг ойлгожээ. Учир нь заавал ингэх ёстой гэж тэр бодно. Харин гэгээрэл бол тийм байх ёсгүй. Хэрэв Багш нь түүнд энэ нь тийм байх ёстой гэж сургавал тэр зөвшөөрөхгүй. Тэгвэл яах ёстой вэ? Хандах зүг нь өөр, хэрэв түүнд наашаа гэхэд эргэхгүй бол яаж тэндхийн зүйлсийг харж чадах вэ? Энд ирэх үедээ та нар сэтгэлээ тайвшруулж чадвал Багшийнхаа адислалын хүч, сэтгэлийн амар амгалан, билиг нээгдсэний хүчийг даруй сэрж

мэдрэх болно. Харин дэндүү цаг завгүй, дэндүү сэтгэл хөдөлсөн байвал Багш нь адисалсан ч та хүртэж чадахгүй.

Жишээ нь, Багш нь та бүхэнд адистай зүйлс тараан өгөх үеэр анхаарлаа төвлөрүүлээд хоёр алгаа дэлгэж байж л сая Багшийнхаа алимийг хүртэж чаддаг биш үү? Харин та нар ийшээ, тийшээ хөдлөөд байвал, “Би алим авмаар байна, би алим авмаар байна.” гэж тасралтгүй үглэсэн ч олж хүртэж чадахгүй, хажуугийн хүн тань авчихаж мэднэ. Учир нь тэр нам жим сууж, тосож авахаар хүлээж байжээ, ойлгож байна уу?

Та нар бүгд л Багшдаа маш их итгэдэг гэж ярьдаг. Хүн бүр ингэж боддог бөгөөд та нарын төсөөлөн бодох чадвар тун баялаг. Үнэндээ та нар итгэдэггүй, зууны нэг хувь итгэдэг нь нэгэнт тун сайн болчихжээ, үнэн хэрэгтээ тийм ч их итгэдэггүй. Учир Багш нь та нарыг зүүн тийш яв гэвэл баруун тийш явдаг, Багш нь та нарыг урагшаа яваарай гэвэл та нар хойшоо явдаг. Өөрийн санаа бодлоо л даган үйлдэхээс биш, Багшийнхаа зөвлөгөөг үл дагана. Тийм учраас та бүхэн зовлонгийн далайгаас салж чадахгүй байна. Энэ нь та нар дэндүү хөөр хөгжөөнтэй, хэтэрхий сэтгэл хөдлөлтэй, хэтэрхий зав муутай, би гэх үзэл хэт ихтэй байдгаас болж байгаа юм, ойлгож байна уу? “Би ийм байдалтай баймаар байна.”, “Би” ийм байдалтай байж л сая гэгээрч чадна гэдгийг “би” мэднэ, “Би” энд ирж, заавал гэгээрнэ.”, “Би” энд Төгс Гэгээрсэн Их Багшийг хайхаар ирсэн”, “Би” энд ... ирсэн.”

Гэвч Багшийнх нь үзэл бодол та нарынхаас өөр бөгөөд Багшийнх нь зааж сургах арга ч та нарын тархи толгой дахь бодол (би гэх үзлийн бодол)-уудаас өөр байдаг, тиймээс та бүхэн Багш яагаад намайг сонсохгүй байна вэ хэмээн маш их шаналж зовдог. Ойлгож байна уу? Ийм бодол л та нарыг зовоодог. Учир нь та нар: “Би энд зөвхөн гэгээрэх л гэж ирсэн. Тэр яагаад намайг ойлгохгүй байна вэ?” гэж боддог.

Багш нь яагаад та нарыг ойлгохгүй байх билээ? Хэрвээ та нар Багшийгаа ойлгохгүй байна гэж бодож байвал энд байх хэрэггүй, буцаад явж болно. Хэрвээ Багш нь үнэхээр тийм тэнэг юм бол та нар энд ирж намайг харах шаардлагагүй. Тэр ч байтугай энд амьдарч, надад шавилах хэрэг юун? Ойлгож байна уу? Энэ нь та нар Багшдаа бүрмөсөн итгэж байгаагүй гэдгийг илэрхийлж байна.

Тиймээс л өдөр бүр энийг ч авна, тэрийг ч авна гэдэг. Учир нь миний сэтгэлийг Багш ойлгохгүй байх вий, Багш надад юу хэрэгтэйг мэдэхгүй байх вий гэж айж байдаг .

Бясалгагч нар ийм байхад эгэл жирийн хүмүүсийг яриад ч яах билээ? Мэдээж тэд бүгд зовлонгийн далайд живээд гэтлэх ямар ч аргагүй байдаг. Учир нь бүхэл өдөржингөө тархи толгойныхоо тасралтгүй үглэхийг л сонсдог. Бидний тархи толгой бол яг л эгэл хүн шиг, тэр бичлэг хийн хурааж авснаа л гаргадаг. Түүнд хайр энэрэл, билиг ухаан, мөн дүгнэж цэгнэх чадвар ч байхгүй, ойлгов уу?

Тэр биднээр зүгээр л элдэв хэрэгтэй, хэрэггүй зүйл хийлгэж, цагааныг харлуулж, харыг цагаан болгодог. Хэрвээ бид бүхэл өдөржин түүнийг сонсвол улам л шаналж зовно. Тиймээс Төгс Гэгээрсэн Их Багшийг хайх хэрэгтэй.

“Төгс Гэгээрсэн Их Багшийг хайх” гэдэг Түүнтэй очиж уулзах биш, эсвэл цасан дээр гурван өдрийн турш сөгдөх явдал ч биш юм. “Төгс Гэгээрсэн Их Багшийг хайх” гэдэг нь өөрийнхөө жинхэнэ Их Багшийг хайна гэсэн үг. Бидний дотоодод жинхэнэ эзэн маань байх бөгөөд Тэр бидний уураг тархинаас хавьгүй илүү сайн. Хэрвээ бид дотоодын жинхэнэ Их Багшаа эрж олоогүй байгаа бол гадна талын жинхэнэ Их Багшийн зааврыг сонсох хэрэгтэй. Учир нь тэрхүү гадна талын жинхэнэ Их Багш нь өөрийнхөө жинхэнэ Их Багшийг хэдийнээ олсон нэгэн тул юу хийхийг мэднэ. Хэрвээ бид өөрийнхөө дотоодын жинхэнэ Их Багшийг олж чадаагүй мөртлөө гадна талын жинхэнэ Их Багшийн сургаалыг сонсдоггүй бол бүр ч хэцүү. Бурхан болох тухай ярих ч хэрэггүй. Тэр ч байтугай хэрэв Бурхан болсон ч мунхаг Бурхан, чимээ шуугиантай Бурхан, сэтгэлийн хөөрөлтэй Бурхан, ямар ч хэрэгцээгүй Бурхан л болно, утгыг нь ойлгож байна уу?

Үнэндээ бол одоо ч бид бүгдээрээ Бурхан юм. Багшийнх нь сая хэлсэн хөөр хөгжөөнтэй Бурхан, сэтгэлийн хөөрөлтэй Бурхан, уур уцаартай Бурхан, би гэх үзэлтэй Бурхан, мунхаг Бурхан, ямар ч хэрэгцээгүй Бурхан гээд Бурхан биш хүн гэж ер байхгүй. Гэвч Бурханы дэс харилцан адилгүй байдаг. Зарим Бурхан нь иймэрхүү, зарим нь тиймэрхүү, зарим нь их зовлонтой байдаг тул бид тэднийг “цухалдуу Бурхан”, эсвэл “зовлон шаналантай Бурхан”, “яаруу сандруу Бурхан” (*Бүгд инээлдэв.*) гэнэ. Тийм Бурхан тун төвөгтэй, өөртөө ямар ч тус нэмэргүй байгаад зогсохгүй бусад Бурхадыг ч бас залхаана.

Зарим хүн өөрийгөө хэдийнээ нэгэн Бурхан болсон хэмээн боддог. Гэсэн ч тэр өдөр бүр уйлна, учир нь өөрийгөө хянах чадваргүй хэвээрээ байдаг. Бурхан хэмээгдэгч тэрээр хамаг төрөлтнөөс ч илүү зовлонтой. Учир нь юу ч болсон бай хамаг

төрөлтөн одоо ч мунхаг харанхуй байсаар байгаа, тэд тамын орныг үзэж хараагүй болохоор тамд ямар их зовлонтой байдаг гэдгийг мэдэхгүй, тиймээс тамын төрөлтний өмнөөс зовно гэхгүй. Тэд асурын орныг үзээгүй тул асурын төрөлтөн ямаршуухан ширүүн байдгийг мэдэхгүй, тэнд очоогүй учраас асурууд тэдэн рүү дайрах боломжгүй, тиймээс мэдэхгүй бөгөөд тийм газар байдагт ч итгэдэггүй тул тэдэнд зовох юм байхгүй.

Гэвч зарим хүн өөрийгөө хэдийнээ Бурхан болсон гэж боддог, тэд там, диваажинг харж чадна, эсвэл асурын оронд юмуу, бусад нилээд дээгүүр түвшинд очоод өөрийгөө хэдийнээ нирваанд хүрсэн гэж боддог байна. Хамгийн дээд түвшинд хүрэхээсээ өмнө мэдээж тэрээр доод түвшний ертөнцүүдээр дайрч өнгөрнө. Асурын орноор дайрвал тэдний дайралтанд өртөж зовно, тамын орноор дайрвал бас зовно. Хараахан Ханьцашгүй үнэхээр төгс туулсан Бодь мөрийн хутагт хүрээгүй байгаа ийм хүн ч Бурхан мөн, түүнийг Бурхан биш гэж хэлж болохгүй. (Учир нь төрөлтөн бүхэн Бурхан мөн.) Зарим хүн тийм хүнийг Арьяабал бодьсадва хэмээн магтан сайшааж мэднэ.

Тийм хүн маш нигүүлсэнгүй сэтгэлтэй. Хамаг төрөлтний зовлонг хараад өөрөө ч зовж шанална. Өөрийгөө хянаж үл чадах тул бүхэл өдөржингөө хамаг төрөлтнийг гэтэлгэх тухай л бодож, зогсолтгүй яарч, завгүй байдаг. Ийм хүн бас бодьсадва юм, тэр маш нигүүлсэнгүй. Гэвч “энэрэл нигүүлслэлийн сэтгэл үгүй” түвшинг даваагүй байсаар байгаа аж.

Жинхэнэ их нигүүлсэнгүй бол хамаг төрөлтнийг эрх тааваар нь байлгаж, хэн гэтлэхийг хүснэ, түүнийг гэтэлгэнэ, гэтэлгэгдэх хүсэлгүй бол зүгээр орхино. Учир нь Түүний хувьд тэд бол хичээлээ сурч буй сурагчид. Тэд сурах ёстой хичээлээ сурна, зарим хичээл нь сонирхолтой, зарим нь сонирхолгүй. Гэвч тэд заавал суралцах ёстой, тэгж байж л төгсөнө. Тиймээс тэдний төлөө зовох хэрэггүй. Мэдээж зовж буйг нь харж өрөвддөг ч сэтгэл нь тайван. Энэ нь хайрлах энэрэх сэтгэлгүй бөгөөд шударга бус гэсэн үг биш, тэднийг өрөвдөж, ойлгоно, гэхдээ Түүний өөрийнх нь сэтгэл саруул уужим байдаг. Энэ үеэс л Тэр сая хамаг төрөлтнийг гэтэлгэж чадах болно, сая жинхэнээр Мөр ёсыг бүтээх болно, жинхэнээр ихэд туулан гэтлэх болно, ойлгож байна уу?

Бясалгалд маш олон дэс бий, Газрын зүрхэн бодьсадвагийн дэс, Манзушри Бурханы дэс, Арьяабал Бурханы дэс, Очирваань Бурханы дэс, Авид Бурханы дэс, Түүнчлэн ирсний дэс, Тэнсэлгүй үнэхээр төгс туулсны дэс, Төгс оройн дээдийн дэс гэхчлэн байна.

Та бүхэн өдөр бүр Арьяабал бодьсадвагаас аврал эрж, Арьяабал бодьсадва болохыг хүсдэг, энэ нь бас буруугүй. Гэхдээ Будда болсныхоо дараа бас Арьяабал бодьсадватай зууралдахаа болих хэрэгтэй, Түүнийг эрх чөлөөтэй байлга, өдөр бүр Түүнтэй зууралдаад л байж болохгүй.

Арьяабал бодьсадвагийн дэс ч гэсэн мөн нэг төрлийн түр зуурын дэс төдий, ойлгож байна уу? Гэвч зарим хүн тэр дэсэд үлдэх дуртай. Үлдэж болно! Тавтай морил! Тийм хүн яг Газрын зүрхэн бодьсадватай адилхан. Газрын зүрхэн бодьсадва бясалгаад тэр нэгэн дэсэд хүрч, тамын төрөлтнүүдийн зовж буйг хараад сэтгэл нь хөдөлж, биеэ барьж чадалгүй, төрөл төрөлдөө тамд сууж, тамын төрөлтнийг гэтэлгэнэ гэсэн андгай тангараг тавьсан байна. Тэрээр: “Там хоосрохоос нааш би Будда болохгүй.” гэж тангарагласан. Энэ бол билиг ухаангүй тангараг. Уучлаарай! Би Газрын зүрхэн бодьсадваг буруутгаж байгаа юм биш, би Түүнийг ихэд биширдэг. Гэвч би та нарт хэлэх ёстой: “Тэнд зогсонгиширч хэрэггүй, учир нь там хэзээ ч хоосрохгүй. Хамаг төрөлтөн өөрөө өөрийгөө гэтэлгэдэг, та тамд үлдсэн ч нэмэргүй.”

Газрын зүрхэн бодьсадва төрөл төрөлдөө тамд байгаа. Та нар там хоосрохыг харсан уу? Тэр хичнээн төрөлтөнд зааж сургав? Тэр хичнээн төрөлтнийг аварч чадав? Чадаагүй, үйл түйтгэр бол үйл түйтгэр. Хамаг төрөлтөн сэрээгүй цагт тэднийг гэтэлгэх арга байхгүй. Тэд зүүдэндээ байгаа үед бүх зүйл нь үнэн байдаг. Та замын хажууд зогсчихоод зүүдэлж буй хүнд: “Сэрээрэй! Энэ бүхэн хуурмаг зүйл.” гэж хэлэх аргагүй. Учир нь та түүнээс хол байгаа, та энэ гэрт, тэр нөгөө гэрт унтаж байна. Тэр өөрийн зүүдэндээ, та ч бас өөрийнхөө зүүдэнд байна, та түүнээс хэтэрхий хол зайтай байгаа болохоор түүнийг сэрээж чадахгүй. Учир нь зүүд яг бодит мэт байдаг, тийм биз?

Үнэндээ, там угаас хоосон. Там бас тийм аймаар сүртэй ч юм биш. Яг нэг автомат машин шиг, нэг товчлууур дарахад л зогсоно. Тиймээс та нар заримдаа тамын хамгаалагч чөтгөр шийтгэлийн машиныг зогсоодог гэж сонсож байсан. Гэхдээ та бүхэн завсаргүй тамын тухай бас сонссон байх, тэнд төрөлтнүүдийг тасралтгүй шийтгэж байдаг. Яагаад тийм аймаар байна вэ? Учир нь энэ машин яг автомат машин шиг, та товчлуурыг дарвал тэр аяндаа ажиллаж, тасралтгүй эргэлдэнэ, энэ нь яг дуу хураагуур шиг. Зарим дуу хураагч тасралтгүй тоглож байдаг ч бид унтраах товчийг нь дарвал тэр зогсоно, учир нь энэ бол нэг төрлийн автомат машин.

Жишээ нь, бид унтах үедээ дуу хураагуурыг асаахад тэр

үргэлжлүүлэн тоглосоор байдаг, бид өглөө сэрээд унтраах товчийг дарахад тэр унтарна, ойлгож байна уу? Тиймээс Газрын зүрхэн бодьсадва энэ тангарагийг тавихдаа өөрийгөө тамд үлдээж, өөртөө төвөг уджээ. Тэр эхлээд тамд очих хэрэггүй байсан юм, там жам ёсоороо өөрөө шийдвэрлэнэ, ойлгов уу?

Зарим хүн Багш энд хамаг төрөлтнийг гэтэлгэх тангараг тавиад ирсэн гэлцдэг. Үнэндээ бол тангараг тавьсан юмгүй, ямар тангараг тавьснаа ч би мэдэхгүй. Би та нарт зөвхөн Арьяабал бодьсадва бол угаас хэлбэр дүрсгүй, нэг төрлийн түгээмэл хайрын хүч, энэрэнгүй нигүүлсэнгүй чанар юм гэж л хэлж чадна.

Орчлон ертөнцөд маш олон чанар бий. Энэрэнгүй нигүүлсэнгүйн хүч үй түмээр хувирдаг, тэрээр багахан хэмжээний хүч илгээн нэг хүн болгон хувиргадаг. Тэр хүн нь Арьяабал бодьсадвагийн хүчтэй байх бөгөөд тэр хүчийг аль хэдийнээ бэлдээд дотоодод нь суулгасан байдаг, тиймээс түүнийг бууж ирэхэд цоожлогдсон эрдэнэсээ нээхэд нь түүнд туслах нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш гарч ирнэ. Тэр үеэс эхлэн тэрээр эрдэнэсээ ашиглана. Түүнийг бид Арьяабал бодьсадвагийн хувилгаан гэдэг. Ийм л байдаг, тийм ч ер бусын нууцлаг зүйл биш.

Бид Авид Бурхан (Цаглашгүй Гэрэл)-д даатган залбирахад тэр цаглашгүй гэрэлт бурхан Гэрэл цацруулан ирж тун магадгүй. Гэвч Гэрэл цацруулан бууж ирэх үедээ заавал олон түвшин, олон орчны уур амьсгалыг туулах хэрэгтэй болно. Нэг дэх уур амьсгалын орчноор өнгөрөхдөө Гэрэл хэвээрээ байна, хоёр дахь уур амьсгалын орчноор өнгөрөхдөө мөн Гэрэл хэвээрээ байна, гэхдээ жаахан зузаарна. Харин гурав дахь дэсээр өнгөрөхдөө Гэрэл хэвээрээ байх ч бүр ч илүү бүдүүн баараг болно. Дөрөв дэх, тав дахиар дайран өнгөрч, доошлох тусам бүр илүү бүдүүн баараг болж зузаарна. Эцэст нь ийм болж хувирна (*Их Багш өөрийн биеэ заав.*), уг нь бол ийм биш байсан. Олон дэсийн хувиралтыг дамжин тийм түвшний нөлөөлөлд өртсөний дараа ийм болж хувирчээ, Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Энэ бие харахад махан биетэй адил боловч тэр бол махан бие биш, тэр энгийн эгэл зүйл биш, харин нэг зүйлийн Гэрэл юм. Нилээд зузаан, бүдүүлэг гэрэл нь ийм болж хувирдаг. Та нар ч мөн ялгаагүй, эгэл жирийн хүмүүс биш. Угаас гэрэл гэгээтэй орноос бууж ирсэн ч энд ирээд бясалгаагүй тул хүч чадалгүй болоод энд үлджээ. Одоо их л уйтгарлаж, сүнсний эх нутагтаа буцахыг хүсэн бурхан бодьсадвад даатгаж, бууж ирэн биднийг дээш татахыг гуйжээ. Тиймээс бурхан бодьсадва бууж ирээд биднийг дээш

татдаг юм, ойлгож байна уу?

Гэвч дээш татахад тийм ч амаргүй. Учир нь бид эндхийн амьдралдаа дасаж, элдэв үзэл бодолдоо автсан тул юу ч хийсэн гэм буруутай болно гэж боддог. Эгэл хүн байхад олон хүн бидэнд: “Хэрэв ингэвэл буруудна. Тэгвэл үйл түйтгэр үүсгэнэ.” гэхчлэн хэлдэг байсан. Төрөл тутамдаа ингэж хэлүүлсээр ирсэн тул бид хэдийнээ дассан. Тиймээс бурхан бодьсадва одоо бидэнд “Та нарт үйл түйтгэр байхгүй.” гэвэл бид тийм ч хурдан итгэхгүй, гэм буруутай гэж бусдаар хэлүүлсэн мэдрэмж тийм ч хурдан мартагдахгүй.

Эгэл хүний хувьд бага байхаас нь аав, ээж нь яаж сургасан байна, том болоод тийм байдалтай болдог, тийм биз? Хүний амьдралд ар тал, гэр орон тун чухал, учир нь бид нийгэм, мөн эгэл хүний оюун ухаандаа хөтлөгдөж, өөрийгөө нүгэл хилэнцтэй, гэм буруутай, янз бүрийн нэр хочтой эгэл жирийн хүн гэж боддог. Тиймээс бурхан бодьсадва: “Та бүхэн гэм буруугүй.” гэж хэлсэн ч тийм амархан итгэхгүй, гэм нүглээ огоорч, нүгэл хилэнцээсээ салж чаддаггүй, учир нь хэдэн мянга, хэдэн тэрбум жил дэр мэт дэргэдээ байлгасан болохоор одоо тавьж явуулъя гээд ч чадахгүй байдаг.

Хэдэн жил угж хөхсөн хүүхдэд дөрөв, таван нас хүрэх үед нь аав, ээж нь угжны оронд өөр сайн зүйл авч өгсөн ч угжаа орхих дургүй байдаг. Түүнд: “Энэ одоо чамд хэрэггүй. Жаахан байхдаа чи их уйлдаг байсан болохоор угж хөхүүлж унтуулдаг байлаа. Одоо саадгүй унтах болсон, бас уйлахаа больж, чихэр жигнэмэг, алим жимс идэж чадах болсон тул угжны хэрэггүй болов, тэрийг март.” гэж хэлдэг. Гэвч тэр хэрэгтэй гэж бодоод салах дургүй байдаг. Ойлгож байна уу? Үнэндээ бол энэ нь дадал болсон төдий зүйл, тэрний хэрэг огт байхгүй, таван нас хүрсэн хүүхдэд угжны хэрэг байх уу?

Бага байхад нь сүүнээс өөр өгчихмөөр зүйл олдохгүй, тэр ч байтугай амттан ч өгөх аргагүй байдаг тул аав, ээж нь угжиж тайтгаруулдаг байжээ. Мөн хүүхэд угжгүй бол заримдаа өөртөө итгэлгүй байж, унтаж чадахгүй, уйлсаар байдаг тул ээж нь тайтгаруулахын тулд угж хөхүүлэх шаардлагатай болдог. Хорин дөрвөн цаг сүү уулгавал гэдэс ходоод нь дийлэхгүй дэлбэрэх тул сүүгүй хиймэл угжаар л аргална.

Том болж алим жимс, чихэр жигнэмэг, ногоо, дүүфүү бүгдийг иддэг болсон тул уйлбал алим, чихэр өгөөд тайвшруулна.

Унтахад нь аав, ээж нь үлгэр ярьж өгвөл сонсох дуртай, баярладаг тул угж хөхөх хэрэггүй болжээ. Нойрсох үедээ угж хэрэглэх шаардлагагүй. Одоо угж хөхвөл шүд нь цухуйж байгаа болохоор муугаар нөлөөлж, орсойно. Өмнө нь угж түүнд хэрэгтэй байсан ч одоо бол ашиггүй болсон байна. Тиймээс одоо угжнаасаа заавал салах хэрэгтэй. Гэтэл тэр одоо болтол салж чадахгүй байдаг.

Бид энэ тоост хорвоод бууж ирэхэд ч мөн адил. Уг нь зарим хичээлд суралцах ёстой байсан бол одоо хэдийнээ сайн сурсан, дахин сурах шаардлагагүй болсон. Тиймээс Багш нь: “Энэ шаардлагагүй. Үйл түйтгэр бол шаардлагагүй зүйл тул огоорвол зохино!” гэж хэлсэн ч та нар таягдан хаяж чадахгүй байдаг, ойлгож байна уу? Тэгээд нилээд удсаны хойно сая зууралдахаа болино. Үнэндээ энэ нь тийм ч амархан байхгүй, заавал ямар нэг зүйлээр орлуулснаар тэр зүйлийг мартах болно. Яг л нялх хүүхдэд угж өгөхгүй гэвэл оронд нь заавал чихэр, шоколад өгөх, эсвэл алим, улаан лууван өгөх юмуу, кино үзүүлж, бөмбөгөөр тоглуулах хэрэгтэй байдаг шиг. Тэгж байж л угжийг нь мартуулна.

Үүн шиг, бидний оюун санаанд Арьябалын бясалгалын арга нь нэг төрлийн орлуулах зүйл болдог. Учир нь бидний оюун ухаанд энэ дэлхий үзэсгэлэн төгөлдөр, сонирхолтой, маш сайхан тул өдөржингөө энэнээс ч, тэрнээс ч зуурч, энийг ч, тэрийг ч, гоо үзэсгэлэн гэх мэтийг шүүрэн авах гэж гардаг. Царайлаг эрчүүд, эд мөнгө, алдар нэр, байр суурь, эрдмийн зэрэг, ажлын байраас зууралдана. Ойлгож байна уу? Энэ дэлхий тун сонирхолтой, олон янзаар улиран хувьсах нь хүмүүсийг төөрөгдүүлдэг, олон зүйлд сэтгэл нь татагдаад энэ ч сайхан, тэр ч гоё гэсээр өөрөө чухам хэн болохоо мартжээ. Тиймээс түүнд нэгэн бат тогтвортой зүйл өгч, намжуун тогтуун болгох хэрэгтэй. Угаасаа бидний уураг тархинд энэ ертөнц маш сонирхолтой газар байдаг болохоор түүнтэй зууралдах дуртай байж, өдөржингөө түүнээс салж чадахгүй болдог. Гэхдээ хэсэг хугацаанд зууралдсаны дараа энэ дэлхийн хичнээн сайхан зүйл, хамгийн учир утгатай юм ч удалгүй ямар ч утгагүй болно. Одоо зууралдаж байгаа зүйл нь удалгүй муухай болж хувирна, тийм ч сайхан биш шиг санагддаг. Өөр нэг зүйлтэй зууралдсаны дараа тэр нь бас мөнхийн биш санагдана, юм бүхэн бүгд л мөнх бус шиг болдог.

Гэтэл мөнх бус болох тусам бид төдий ихээр зууралдах дуртай, учир нь сэтгэл ханадаггүй, ойлгов уу? Үүнтэй зууралдсан ч сэтгэл дундуур, түүнтэй зууралдсан ч сэтгэл дундуур, өдөржингөө сайн зүйлсийг хайдаг хэдий ч сэтгэл дундуур хэвээр, юутай ч

зууралдсан бүгд л сэтгэлийг хангаж чаддаггүй. Энэ ертөнцийн хамгийн үзэсгэлэнтэй зүйлс, эсвэл хамгийн сонирхолтой зүйлс байлаа ч гэсэн хэсэг хугацаа өнгөрсний дараа ямар ч сонирхолгүй болдог. Жишээ нь, бид нэгэн бүсгүйд хайртай байсан, учир нь тэр ер бусын үзэсгэлэн гоо, сэтгэл татам байв, гэвч удалгүй тэр тийм ч сэтгэл булаам санагдахаа больдог, тийм биз дээ? (*Эрчүүд, Тийм гэж хариулав.*)

Бүсгүйчүүдийн хувьд ч мөн адил, нэг залууд дурлаад танилцсан залуу нь эхэндээ тун романтик, царайлаг, эрхэмсэг хүн шиг байсан ч танилцаад хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр таны төсөөлж байсан шиг тийм ч сайн биш шиг санагддаг. Түүний алдаа дутагдал нь явах тусам ил болж, хожим маш их урам хугарах болно. Тэгээд уйлж хашгирч төвөг удах, байшин дээрээс үсэрч үхэхдээ тулж, амиа хорлох шахна. Энэ бүхнийг бид өөрсдөө л ургуулан бодсон, ойлгож байна уу? Тэр залуу угийн л тийм хүн, өөрчлөгдсөн юмгүй. Бид зөвхөн өмнө нь алдаа дутагдлыг нь олж хараагүй байсан, харин одоо олж хардаг болжээ, тиймээс маш их сэтгэлээр унаж байгаа хэрэг.

Энэхүү уураг тархи ямар нэг зүйлтэй зууралдахдаа төгс төгөлдөр зүйлийг эрж цөхрөөд ядарч цуцах болно. Тэр үед Их Багш түүнд: “Хөөе, хэзээ ч хувирдаггүй үргэлжийн мөнх, төгс төгөлдөр нэгэн зүйл байдаг. Тэр танаас хэзээ ч холдохгүй, өдөр бүхэн түүнтэй хамт байж болно. Тэр хэзээ ч урмыг тань хугалахгүй. Түүнтэй танилцахыг хүсэж байна уу?” гэхэд тэр: “Тийм ээ! Би оролдоод үзмээр байна!” гэнэ. Зөвхөн энэ үед л Их Багш түүнд Арьяабалын бясалгалын аргыг зааж чадна.

Энэ Аялгууны урсгал хэзээ ч зогсохгүй, Тэр хэзээ ч таныг мэхлэхгүй, Тэр өдөр бүхэн байх бөгөөд Түүнийг эрж хайж л байвал Тэр хэзээд байж байдаг. Энэ бол бидний Уг дүр буюу тэрхүү Гэрэл юм. Авшиг хүртсэний дараа бид үүрд Гэрэлтэй болдог, Түүнийг хайвал Тэр байж л байдаг, Тэр бол материаллаг зүйл биш, Тэр бол өнө мөнхийн зүйл бөгөөд үүрд мөнх оршдог.

Энэхүү Аялгууны урсгал нь бидний уураг тархийг тайвшруулж чаддаг. Уураг тархи: “Эцэст нь би ямар нэг мөнхийн тогтмол, хувиршгүй байнгын зүйлийг оллоо. Би хэзээ ч ийм нэг өнө мөнхийн зүйл олж байгаагүй.” хэмээнэ. Тэр одоо намжуун тогтуун болж, сэтгэл нь ханаж, цаашид түүнд ядаргаатай санагдахаа болино. Тиймээс Арьяабалын аргаар бясалгадаг хүн улам бүр тайван тогтуун болдог нь ийм учиртай. Учир нь уураг тархи тогтвортой, баяр жаргалтай, сэтгэл хангалуун байдаг,

сэтгэл хангалуун, тогтвортой байвал тэр тайвширч чадна. Тэр үед л уураг тархи үнэн, худлыг ялгаж чадна, ойлгож байна уу?

Бидний уураг тархи материаллаг зүйл боловч ч хэрэг тус ихтэй, тэр тайвширвал сүнс маань түүнийг сайтар ашиглаж чадна. Тэр үед л сая тэр уураг тархи жинхэнээр өөрөө бодож сэтгэн “үйл түйтгэр угаасаа хоосон” гэдгийг ойлгоно. Амьдрал бол зүгээр л жүжиг, энэ дэлхий жүжгийн тайз бөгөөд угаас ямар ч асуудал байхгүйг ухаардаг. Тэр үед л сая “үйл түйтгэр угаасаа хоосон” хэмээн хэлж чадна, энэ нь сая жинхэнэ утгаараа туулан гэтлэлт мөн.

Арьяабалын аргаар бясалгадаг хүн авшиг хүртсэн даруйдаа туулан гэтэлдэг. Гэвч та бүхэн өөрийн туулан гэтэлсэн хэр хэмжээгээ хараахан мэдэхгүй байна. Учир нь та маш их догдолж, тайвширч амжаагүй байх тул өөрийн туулан гэтэлсэн байр суурийг таньж чаддаггүй, Багшийнхаа санааг ойлгов уу?

Жишээ нь, нуурын усанд олон загас байв. Хэрэв салхи их хүчтэй байвал ус давалгаалж, долгио ихээр үүсээд ус тогтуун болохгүй байна, эсвэл ус нь их бохир байвал бид загасыг нь харж чадахгүй, тийм биз? Нуурын мандлын ус тогтуун болох үед л бид сая загасыг харж чадна. Энэ нь загас дөнгөж сая гарч ирсэн хэрэг биш, угаасаа л нууранд байсан ч нуурын ус давалгаалж байснаас болоод бид харж чадахгүй байжээ, ойлгов уу?

Бидний эзэн ч мөн ийм. Тэрээр угаас цэвэр ариун, цайлган цагаан, бид юу ч хийсэн байлаа түүнд нөлөөлөхгүй, бид юу ч хийсэн бай бүгдийг махан бие маань л үйлдэж байдаг. Энэ чухал зүйлийг та нар ойлгож байна уу? Учир нь бүгдийг махан бие үйлдсэн, бид үйлдээгүй, тиймээс бид үйл түйтгэргүй, ойлгож байна уу?

Хоолыг ч гэсэн энэ махан бие идэж байгаа, харин бидний эзэн иддэггүй, тиймээс бид энэ дэлхийд ямар ч өргүй. Хулгайг энэ гар л хийсэн, бидний эзэн хулгайлаагүй, тиймээс бид ял гэмгүй. Гэхдээ та нар хариад хулгай хийж болохгүй шүү! (*Бүгд инээлдэв.*) Багш нь та нарыг буцаж очоод банк дээрэмд гээгүй, үүнийг зөв ойлгох хэрэгтэй. Гадуур гараад: “Манай Багш хулгай хийвэл асуудалгүй.” гэсэн гэж болохгүй. Ингэвэл цагдаа ирээд Багшийг нь баривчилж, шоронд хүргэнэ, ойлгож байна уу?

Багшийнхаа сургаалыг буруугаар ойлгож болохгүй. Миний та бүхэнд ярьж буй зүйл бол дээд дэсийн зүйлс. Гэхдээ та бүхэн энэхүү дээд дэсийн зүйлсийг хараахан олж аваагүй байгаа тул

ингэж болохгүй. Хожим та нар дээд дэсийн зүйлсийг хүртэх үедээ бүр ч үйлдэхгүй, хулгай хийх нь битгий хэл хийх ч боломжгүй.

Эрх чөлөөнд хүрвэл үйл түйтгэр угаас хоосон болохыг ойлгож мэднэ. Үнэхээр үйл түйтгэр гэж байхгүй. Тиймээс Багш нь хэнийг ч гэтэлгэдэггүй, та бүхэн өөрөө өөрийгөө гэтэлгэж чадна. Залбиран даатгах үедээ та нарын хүч илрэн гардаг, Багш нь зөвхөн танд үүнийг нээж, энэ хүчийг улам бүр хөгжүүлэхийг зааж өгдөг. Багшийнх сургаал номлол нь та нарт энэ хүчээ илүү их ашиглахыг, хөгцрүүлэн муудуулж болохгүйг сануулахын төлөө юм. Хэрэв долоо хоног бүр Багш нь ном тайлж сануулахгүй бол та нар мартаж, бясалгалын аргаасаа буцаж мэднэ, ойлгов уу?

Авшиг хүртсэнээс тань хойш хэрэв хэн ч та нарыг үргэлжлүүлэн урамшуулж, тайвшруулж байхгүй бол та нар бясалгах хүсэлгүй болж, сэтгэлээ доройтуулж магад. Тиймээс Багш нь ном тайлах нь бас ач тустай. Хэсэг хугацаагаар бясалгасны дараа та нар өөрөө өөртөө ном тайлдаг болно, тэр цагт Багш нь тайлбарлах шаардлагагүй болно. Та нар бусдад ном тайлдаг болбол энд ирж Багшийнхаа ном тайлахыг сонсох шаардлагагүй. Гэвч тийм дэсэд хүрэхээсээ өмнө бясалгалаа илүү их дадуулж, Багшийнхаа ном тайлахыг илүү их сонсох хэрэгтэй. Хэрэв та нарт ингэх нь хэрэггүй санагдвал бас асуудалгүй. Юуг ч заавал хийх ёстой гэж Багш нь албадахгүй, бүх зүйл сэтгэлээрээ, чөлөөтэй. За, одоо асуулт байна уу?

Асуулт: Би их ном уншсан, тэдгээрийн нэг нь “Турван ертөнцийн доторх байдал тойм” гэдэг ном. Үүнд: Шавь нь өндөг идсэнээс болж Их Багш Иланд байхдаа түүний өмнөөс үйл түйтгэрийг нь үүрч, улмаар бие нь ихэд өвдсөн гэсэн хэсгийг уншаад миний зүрх хэсэг зуур тэсэхүйеэ бэрх дарамт мэдэрч, амьсгал авахад хэцүү болсон. Энэ байдал таван минут орчим үргэлжилсэн, яагаад тэгсэн бэ гэдгийг би мэдэхгүй байна.

Их Багш: Учир нь та тэр үед Багшийнхаа мэдэрснийг мэдэрчээ. Багшийнх нь ярьсан бүхэн үнэн, тиймээс нилээд мэдрэмтгий хүн мэдэрч чаддаг, ойлгов уу? (*Тэр агшин бараг л таван минут үргэлжилсэн.*) Уучлаарай! Тэр зовлонт таван минут таны хувьд хэдийн дэндүү хүнд байсан байх. (*Тэр үед би хурдхан босоод гүн амьсгаа авсан.*) Одоо та илүү дээрдсэн үү? (Хамаагүй дээрдсэн.) Та Багшийнхаа эдэлсэн зовлонгоос өчүүхэн төдийг амсахад л тэсэхийн аргагүй байжээ. (*Би хараахан авшиг аваагүй байгаа болохоор ойлгохгүй байна.*) Би ойлгож байна! Та энэрэнгүй сэтгэлтэй, чин сэтгэлээсээ харилцдаг учраас уг

мэдрэмжийг амсчээ. Ийм байдлаар та Багшийнхаа зовлонг тодорхой хэмжээгээр ойлгож чадна. Эс бөгөөс миний зовсныг сонссон хүмүүсийн ихэнх нь Багш тоглоом хийж байна гэж боддог. Хамаг төрөлтний өмнөөс үйл түйтгэрийг нь үүрэхэд зовлон эдлэх нь бодитой зүйл, гэвч Багш нь зөвхөн хүлцэн тэвчиж л чадна.

“Үйл түйтгэр угаасаа хоосон” учраас Багшид нь мэдээж үйл түйтгэр байхгүй, гэхдээ та нарын хувьд мөн л байсаар байдаг. Хэрвээ Багш нь та бүхний үйл түйтгэрийн гэм бурууг арилгавал тэрхүү гэм бурууг өөрийн биедээ авах хэрэгтэй болно.

Багш нь угаасаа үйл түйтгэргүй, гэвч та бүхэн үйл түйтгэртэй учраас энэ гэм буруутай мэдрэмжийг арилгахын тулд тэрхүү мэдрэмжийг хаа нэг тийшээ явуулах хэрэгтэй болно, жишээ нь, Багш руугаа явуулах хэрэгтэй. Тиймээс Багш нь үйл түйтгэрийн өвчин тусдаг. Ямар ч хятадын, эсвэл барууны эмч миний өвчнийг оношилж чаддаггүй. Тэдний шинжилгээний хариу нь бүгд зүгээр гардаг, гэвч би үнэхээр өвдсөн байдаг. Би та нарт худлаа яриагүй, өдөр бүр бие минь тавгүй байдаг нь хамаг төрөлтний үйл түйтгэр юм. Вималакирти сударт: “Хамаг төрөлтөн өвчтэй байна, тийм учраас би өвчтэй байгаа юм.” гэж бичсэн нь ийм утгатай.

Багшийнх нь номд ч мөн соронзон талбайн солилцооны талаар бичсэн, хэрвээ танд гэм буруутай мэдрэмж байвал Багшдаа ирээд яривал зүгээр болдог. Гэвч энэ гэм буруутай мэдрэмж угаасаа байсан, учир нь бид нэгэнт түүнийг бий болгосон учраас энэ нь байх ёстой. Юм бүхэн ийм байдаг, нэгэнт бүтээгдсэн л бол оршин байх ёстой. Та бүхэн Мял богдын түүхийг уншсан уу? *(Уншаагүй гэж хариулцаав.)*

За! Тэгвэл би одоо ярьж өгье.

Мял богдыг нилээд нас ахисан үед нь нэгэн номын багш ихэд жөтөөрхөж, Түүнд хор уулгахаар нэг хүнийг явуулжээ. Хор өгч явуулах үедээ тэрээр уг хэргийг бүтээсний дараа түүнд маш үнэтэй эрдэнэс өгнө хэмээн амласан байна. Түүний ар гэрийн аж амьдрал ядуу тарчиг тул хэргийг бүтээхээр зөвшөөрчээ. Гэвч Мял богдыг хараад хийж зүрхэлсэнгүй. Мял богд тун их хайрын сэтгэлтэй хүн байсан тул тэрээр Түүнийг алж Түүнд хор өгч чадахгүй нь гэж үнэнээ хэлсэн байна. Мял богд түүнд: “Та буцаж очоод түүнээс эхлээд үнэт эрдэнэсээ аваад ир, дараа нь надад хортой эмээ өгөөрэй. Би одоо увал тэр таныг мэхэлж, үнэт эрдэнэсээ өгөхгүй байж мэднэ.” гэж хэлжээ.

Тэр хүн эргэж очоод Түүний хэлснээр хийж, үнэт эрдэнээ

аваад ирэхэд Мял богд ч хорыг ууж гэнэ. Уусны дараа олон хоног хамаг бие нь шархирч өвджээ. Эмчлэх ямар ч арга байсангүй. Түүнд хор барьсан өнөөх номын багш одоо өрөвдсөн царай гарган Түүнийг тайтгаруулж: “Багш аа, миний сэтгэл тун их зовж байна. Та яагаад ингэж айхтар өвдчихөв өө? Та надтай зовлонгоосоо хуваалцаж болох уу? Би дуртайяа таны өмнөөс өвдөнө. Учир нь та бол нэгэн агуу бодьсадва. Та хэрэв эсэн мэнд байвал хамаг төрөлтнөөс олныг гэтэлгэнэ. Би ямар ч хэрэгцээгүй хүн, тиймээс таны өмнөөс өвчнийг тань авъя!” хэмээн матрын нулимс унагажээ. Матрын нулимсны түүхийг та нар мэдэх үү?

Урьд нэгэн бяцхан цагаан туулай матар харахаар иржээ. Матарт ойртож зүрхлэхгүй байсан тул матар хуурамч нулимс унаган: “Миний шүд маш их өвдөж байна, надад тусалж шүдийг минь авч өгөх хүн байхгүй.” гэв. Туулай эхлээд ойртож зүрхлэхгүй байсан ч уйлах үедээ тэрээр хичнээн их өвдөж зовж байгааг нь хараад сэтгэл нь ихэд хөдөлж, түүнд туслахаар ойртож очоод матарт идүүлсэн байна. Багшийнх нь ярьсан “матрын нулимс” гэдэг нь ийм утгатай.

Өнөөх номын багш ярих зуураа хоёр дусал матрын нулимс унагав. Мял богд: “Зүгээр дээ, энэ бол үйл түйтгэрийн өвчин, би тэвчиж чадна.” гэв. Тэр номын багш: “Та бол далай их шидийн хүчтэй билээ. Өвчнөө надад шилжүүлчих. Та бусдыг адисалж чаддаг болохоор өвчнийг ч мөн бусдад шилжүүлж чадах нь дамжиггүй. Та заавал ийм зовлон эдлэх хэрэг юун.” гэв. Тэр заавал өвчнийг нь авна гэх тул Мял богд түүнд: “Та энэ өвчнийг яагаад ч тэсвэрлэж чадахгүй. Миний энэ өвчин бол хүмүүсийн үйл түйтгэр, тиймээс та ганцаараа үүрч болохгүй, үүрч тэсвэрлэж чадахгүй.” гэв.

Нэгэн Их Багшийн үүрч чаддаг үйл түйтгэр жирийн хүнийхтэй адилгүй. Авшиг хүртээх үедээ Багш нь та нарын таван үеийнхний төрлийг дээшлүүлдэг. Энэ үед би жаахан өвдөх төдий болно. Харин та нар өөрөө бусдад авшиг хүртээвэл тэр хүний үйл түйтгэр, мөн түүний таван үеийн өвөг дээдсийнх нь үйл түйтгэр бүгд тан дээр буух үед та хүлцэн тэсвэрлэж чадахгүй болно. Та нар зөвхөн ганц хүнд авшиг хүртээхэд ийм болох юм. Харин Багш нь хэдэн мянга, хэдэн зуун хүнд авшиг хүртээдэг, ойлгож байна уу? Учир нь хүч нь адилгүй. Яг л хүүхэд таван килограмм зүйл өргөвөл энэ нь түүний хувьд хэдийн дэндүү хүнд байна, харин насанд хүрсэн их хүчтэй хүнд бол тавин килограмм ч асуудалгүй байдаг шиг юм. Учир нь хүч нь адилгүй тул тэсвэрлэх хэмжээ нь

өөр өөр байдаг.

Тэр үед Мял богд өөрийн өвчнийг түүнд шилжүүлэхгүй байв. Тэр номын багш угаасаа Мял богдод итгэдэггүй, Түүнийг хорлох санаа агуулж байсан тул одоо хамгийн сүүлийн удаа Мял богд дээр ирээд нэр алдрыг нь гутаах бүхий л аргыг сүвэгчилж байв. Шавь нарт нь тэдний багш Мял богд ямар ч хэрэггүй хүн, Тэр бол хуурамч Их Багш, өвчнийг бусдад шилжүүлж ч чадахгүй гэж мэдүүлэхийг оролдож байжээ. Мял богд: “Өвчнийг би танд шилжүүлж чадахгүй байгаа юм биш. Таныг тэсэхгүй байх гэж айх тул төвдөхгүй байна.” гэв. Хэдийгээр өөрийг нь хордуулсан хүн нь тэр гэдгийг Мял богд мэдэж байсан ч түүнд хэлсэнгүй, зөвхөн тун эелдэг зөөлнөөр ингэж хариулжээ.

Тэр номын багш: “Та өвчнөө надад өгчих.” гэж тасралтгүй шавдуулсанд Мял богд түүнд: “За, Би өвчнөө эхлээд тэр хаалганд шилжүүлье, тэгвэл та хэр айхтар хүчтэй болохыг нь ойлгоно. Би тун жаахныг л шилжүүлье.” гэв. Мял богд өвчнөөсөө хаалганд шилжүүлэх үед хаалга тэр даруй тоос болон хувирчээ. Гэвч өнөөх номын багш бас л үл итгэж: “Ингэсэн ч би итгэхгүй. Та магадгүй шидийн хүчээ ашиглан хаалгыг эвдсэн байх, тэрнээс энэ нь өвчний хүч биш гэж би бодож байна. Та надад өвчнөө шилжүүлчих, тэгэх үү?” гэж шалахад Мял богд аргагүйн эрхэнд: “За. Би танд тун багыг л шилжүүлье!” гээд багаханыг шилжүүлэхэд өнөөх хүн тэр дороо тэсэшгүй болж, газарт унаад орилж гарч гэнэ ээ.

Тэр үед л тэр сая үнэмшиж, Мял богдын үүрч буй өвчний зовлонг ойлгож, ихэд харамсан гэмшиж, өөрийн хийсэн нүглээ хүлээн зөвшөөрч, Мял богдоос өршөөл эржээ. Мял богд түүнд: “Хамаагүй дээ. Энэ бол бас хүмүүсийн үйл түйтгэр юм. Би өөрөө дуртай уусан. Ганц таны өөрийн хүч намайг хөнөөж чадахгүй, ойлгов уу? Надад хор уулгасан хүн нь та биш, энэ бол хүмүүсийн үйл түйтгэр. Та үүнийг хийх ёстой байсан, энэ бол таны ажил. Би таныг өршөөнө, ямар ч асуудалгүй !” гэжээ.

Та энэрэн нигүүлсэнгүй сэтгэлтэй, мөн тэр номыг сайтар анхаарлаа төвлөрүүлэн уншсан учраас Багштайгаа агшин зуур холбогдсон болохоор Багшийнхаа далдын жинхэнэ хүчийг мэдэрч, Багшийнхаа хоромхон зуурын зовлонг ойлгож мэдэрчээ. Гэвч таван минут таны хувьд дэндүү урт хугацаа. Та дэндүү их зовжээ, намайг өршөөгөөрэй! Тэсэхийн аргагүй байсан, тийм үү? *(Тэр үед энэ нь тэвчихийн аргагүй байсан. Гэхдээ би тэр өдөр дахиад уншсан ч тийм мэдрэмж дахин төрөөгүй.)* Багшийнх нь ном жирийн номтой адилгүй. Ийм ахуй ойлголттой болж байж

л сая та нар Багшийнх нь ярьсан бүхэн үнэн бодит болохыг жинхэнээр ойлгож чадна.

Ер нь та нарт ийм ахуй ойлголт байдаггүй болохоор тийм сайн ойлгож мэдэрдэггүй. Үнэндээ бол Багшийн ном бүгд адислах хүчтэй. Хэрвээ та нар хүндлэх сэтгэлгүйгээсээ болоод адислалын хүч байхгүй гэж бодон дорд үзвэл хэзээ нэгэн өдөр үүнийг өөрөө мэдрэх үедээ харамсан гэмших болно, ойлгож байна уу? Тэр үед та үл итгэсэн, эсвэл дэндүү их хүндэтгэлтэй хандсан учраас адислалын хүчний тийм “тавгүй” байдлыг биеэрээ мэдэрсэн үү гэдгийг би сайн мэдэхгүй байна.

Заримдаа шавь нар Багшийгаа тун ихээр өрөвдөн хөөрхийлбөл Багшийнхаа зовлонг байдлыг бас бага зэрэг мэдэрдэг. Хэрвээ Багш нь түүгээр амсуулахыг зөвшөөрвөл бага зэрэг амсуулна, учир нь тэр хүн их чин сэтгэлтэй, тийм зовлонг биеэрээ мэдрэхийг хүсдэг. Хэрэв тэр баяртай байвал Багшийн зовлон, эсвэл Багшийн адислалын хүч, эсвэл Багшийн баяр жаргалыг бие, сэтгэлээрээ мэдрч чадна. Гэхдээ маш их чин сэтгэлтэй, маш өгөөмөр хайрын сэтгэлтэй байж л сая тийм нэгэн холбоосыг хүлээн авдаг. Урьд нь би Багшийгаа хэзээ ч гэсэн өвдөж, эсвэл зовж шаналсан бай бүгдийг мэддэг байсан.

Би олон зүйлийг ярьж зүрхэлдэггүй, учир нь яривал та нар айна. Гэвч бид зовлонгоос айх хэрэггүй, Газрын зүрхэн бодьсатва тамаас айгаагүй байхад бид жаахан зовлон амсахаас айх хэрэг юун? Багш нь зовлон зүдгүүрээс ч, энэхүү махан бие өвдөхөөс ч айдаггүй, эсвэл махан бие ямар нэгэн нөхцөл байдлыг хүлцэн тэвчиж чадахгүйгээс айдаггүй. Гэхдээ Багш нь байхгүй бол та нар хүлцэн тэвчиж чадахгүйгээс айдаг. Тиймээс Багш нь махан биеэ тун их хайрлан гамнахыг хичээдэг. Надад одоо хооллох ямар ч хүсэл байхгүй, гэвч хүчээр иддэг. Гашуун эмийг дургүй ч заавал уух хэрэгтэй. Учир нь би та нар үнэхээр чин сэтгэлтэй байгааг мэднэ. Багштайгаа уулзахгүй долоо хоноход тэсэхгүй байгаа хүмүүс намайг бүр явчихвал яах бол?

Одоо та нар өсөж том болоогүй, хангалттай хүч чадалтай биш байна. Багштайгаа уулзахгүй хэд хоновол маш их санадаг, эхнэр, нөхрөөсөө ч илүүтэй санана. Тэр мэдрэмжийг илэрхийлэх аргагүй, эрэгтэй, эмэгтэй бүгд ялгаагүй ийм байдаг. Би та бүхний энэ сэтгэлийг ойлгоно, тиймээс Багш нь та нарт хатуу хандаж, нүүр тал өгдөггүй. Учир нь та нар Багшдаа хэдийнээ ийм их хайртай байхад би та нарыг илүү их хайрлавал бүр муу болох биш үү? Та нар дэлхий ертөнцийг огоорч, ажлаа төдийгүй эхнэр,

нөхрөө ч шуудуу руу шидэж орхиод энд Багштайгаа хамт байхаар ирнэ.

Би та нарыг Багштайгаа дэндүү ихээр зууралдуулж, гадна талын хайрын сэтгэлийг тань дэндүү хүнд болгож зүрхлэхгүй, Багшийнхаа санааг ойлгов уу? Тиймээс Багш нь та нартай ойр дотно байх нь ховор, хайрын сэтгэлээ илэрхийлэх нь ч ховор байдаг, тийм биз? Та нар ирэх бүртээ Багшийнхаа хүн загнаж байхыг хардаг, ирэх тусмаа илүү их загнуулна, Багшийн ажлыг сайн хийх тусмаа Багшдаа илүү их загнуулна, хэр их өргөл баривал Багш нь төдий чангаар загнана, чин сэтгэлтэй байх тусмаа хөөгдөнө, ийм байдаг, тийм биз? Учир нь та нарын хүлэгдэх сэтгэл хэт хүндэрч, өөрийнхөө сэтгэлийн эрхшээлээс гарч чадахгүй болох вий гэж Багш нь айдаг.

Энэ (*Их Багш өөрийн биеэ заав.*) бол нэгэн махан бие төдий, хэзээ нэгэн өдөр эндээс явна, тиймээс түүнтэй хэт зууралдах хэрэггүй. Багшийгаа хүндлэн дээдэлж, хайрлах хэдий ч хэмжээ хязгаартай байх хэрэгтэй, өөрийн хайрын сэтгэлээ хянаж, хүндлэлийн хязгаарыг давалгүй, тэр үл үзэгдэх хил хязгаараас хэтрэхгүй байх хэрэгтэй. Багшид нь та бүхний нэг алхаад нэг мөргөх хүндлэл хэрэггүй, мөн энд ирээд Багшдаа мөргөх ч хэрэггүй. Гэхдээ хэрэв та нар хайрын сэтгэлээ жаахан тайван байлгаж чадвал бясалгахад тань дөхөм, Багшид нь ч амар, та бүхэнд ч амар байна, ойлгож байна уу? Хэрэв та нар дэндүү ихээр зууралдаад байвал хоёулаа живж үхэх болно.

Хэрвээ нэг хүн усанд живж байгаа хүнийг аваръя гэвэл эхлээд түүнийг цохиж, ухаан алдуулах хэрэгтэй, эс бөгөөс тэр айж, хэтэрхий сандарснаасаа болоод хаанаас ч хамаагүй зуурвал сэлэхэд хэцүүдэж, аварч чадалгүй, улмаар хоёулаа живж үхэж мэднэ. Ийм нөхцөл байдлыг та нар мэдэх үү?

Үүнтэй ижил, та бүхэн Багшаасаа хэт их зууралдах хэрэггүй, хэрвээ би сэлж чадахгүй болбол бидний хэн нь ч тэртээ чанадын эрэгт хүрч чадахгүй. Та нар сэтгэлдээ юу хүсэж, юуны төлөө залбирч байдгийг Багш нь мэднэ, Багш нь үүнийг алгуурхнаар бүгдийг шийдвэрлэнэ, цаг нь ирэхэд бүх зүйл ойлгогдоно, ойлгож байна уу? Бүгдийг нэг амьсгаагаар хийнэ гэж байхгүй, мод нэг хоногийн дотор бүдүүн мод болох боломжгүй, бяцхан хүүхэд ч гэсэн нэг хоногийн дотор өсөж том болох боломжгүй, тиймээс тэгж их яарах хэрэггүй.

Зарим үед Багш нь та бүхний Мөр ёсыг хайх сэтгэлд уярч,

та нарт дэндүү сайн ханддаг. Магадгүй тэр өдөр Багшид нь тун таатай сайхан байсан, эсвэл онцгой их баярласан учраас үүнийг мартсан, эсвэл та нар тун ихээр зовж шаналж байхыг хараад Багш нь өөрийн эрхгүй л дэндүү ихийг өгчихдөг. Гэвч дэндүү ихийг өгвөл та нар дорхноо эрх танхай болж, сахилгагүйтнэ. Тиймээс Багш нь та нарыг эрхлүүлэх нь ховор, зөвхөн загнахаас биш, магтан сайшаадаггүй.

Ямар нэгэн сайн үйл хийгээд энд ирэхэд тань Багш нь: “Хөөх Гайхалтай! Их бясалгагч, их бодьсатва ирлээ. Би таныг энд ирж, хамаг төрөлтнийг гэтэлгэхийг тань хоёр зуун жил хүлээж байна.” гэж хэлнэ гэж бүү бодоорой. (*Багш формоса аялгаар хэлэхэд хүмүүс инээв.*) Ийм зүйл байхгүй. Хэрвээ Багш нь ингэж хэлбэл та бүхний санаа бодлыг ярьсан хэрэг болно, Багш бидний бодол сэтгэлийг ойлгож, юу бодож байгааг мэдэж байна гэдгийг тань та нарт мэдүүлж байгаа хэрэг болно. Энэ нь Багшийнх нь хувьд тийм ч чухал бус. Та нар ямар төрөлтнийг гэтэлгэх вэ? Танаар гэтэлгэгдэх төрөлтөн хаана байна вэ? Хэрвээ та хамаг төрөлтнийг гэтэлгэж чадах юм бол Шагжамуни Будда тэднийг аль хэдийн бүгдийг гэтэлгээд дуусгачих байсан. Таныг энд яаран ирж, их баатар болохыг хүлээх хэрэг байх уу?

Газрын зүрхэн бодьсатвад алсын бодол байгаагүй, учир нь тэр үед хараахан гэгээрээгүй байсан болохоор ийм нэг эмх замбараагүй тангараг тавьсан байна. Та нарт гэж хэлэхэд Тэр одоо үүндээ ихэд харамсан гэмшиж байж магадгүй, (*Бүгд инээв.*) учир нь өөрийн тэрхүү хүчтэй хүсэл зоригоос мултрах аргагүй болсон байна, ойлгож байна уу? Бидний бодол санаа маш хүчтэй, юу хүснэ, түүнийгээ авдаг тул хэрэв бид өөрийнхөө жинхэнэ хүч чадлаа бүгдийг тэрхүү хүсэлдээ хандуулбал уг хүсэлдээ өөрийгөө хүлж орхино.

Тиймээс дураараа элдэв андгай тангараг бүү тавь. Харин туулан гэтэлж, өөрсдийнхөө нисваанисаас ангижрах андгай тавих нь хамгийн зөв. Нисваанисгүй төрөлтөн энэ ертөнцөд байхгүй, аливаа бүхэн бүгд л бидний өөрсдийн нисваанис, ойлгож байна уу? Бидэнд холын хараа, алсын бодол байхгүй болохоор л сая тамын орон, диваажин гэж байдаг.

Үнэндээ энэ дэлхий гайхалтай сайхан, үзэсгэлэнтэй. Дэлхий ийм үзэсгэлэнтэй гэдгийг магадгүй та нар харж чаддаггүй ч үнэхээр тийм байдаг. Заримдаа та нар бясалган сууж байхдаа маш сайхан түвшнийг гэнэт олж үздэг. Хэдийгээр та энэ өрөөнд байсаар байгаа, эсвэл бүр бие засах өрөөнд байсан ч диваажингийн

ахуй ойлголт үзэх нь бий. Энэ нь бие засах өрөө диваажин болсон хэрэг биш, харин бидний билиг ухаан нээгдсэн хэрэг. Тиймээс бие засах өрөө Тушита Тэнгэрийн орон болжээ. Та нар судар уншсан ч үүнийг ойлгодоггүй, жишээ нь, Вималакирти сударт тэмдэглэгдсэнээр, Вималакирти Их Багшийг харахаар олон хүн ирэхэд Тэрээр өөрийн өрөөг маш үзэсгэлэнтэй түвшин болгон хувиргаад тэр жижигхэн өрөөнд нь үй түмэн бодьсатва сууж, диваажин болон маш олон бурхны орон Түүний өрөөнд илрэн гарсан байдаг. Энэ нь ямар утгатай вэ? “Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгдсэн.” гэсэн үг юм.

Газар бүхэн бурхны орон, хамаг төрөлтөн хэдийн төгс төгөлдөр, танаар гэтэлгэгдэхээ хүлээсэн төрөлтөн байхгүй. Та бүхэн гэгээрснийхээ дараа хамаг төрөлтөн гэж үгүй, хүн гэж үгүй, диваажин, эсвэл тамын орон гэж үгүй гэдгийг мэднэ. Энэ дэлхий үнэхээр үзэсгэлэнтэй сайхан шүү. Шагжамуни Будда заримдаа энэ тоост хорвоог түр зуур маш үзэсгэлэнтэй сайхан ертөнц болгон хувиргадаг байжээ, учир нь Тэрээр шавь нараа бүгдийг гэгээрүүлсэн байдаг. Тэр үед энэ тоост хорвоо гэнэт маш амар амгалан, үзэсгэлэнтэй сайхан болж, газар шороо нь алт болж, өвсөн овоохойнууд нь тансаг орд харш болон хувирдаг, тийм биш үү?

Бид ч гэгээрвэл энэ дэлхий мөн тийм болон хувирч, өчүүхэн ч бохир буртаггүй, дургүйцэж, уурлах зүйлгүй нэн сайхан Бурхны орон болж хувирна. Шагжамуни Бурханы суудаг орон бол бурхны орон юм. Их Багш нар, бурхан бодьсатва нар амьдардаг л бол тэр газар нь бурхны орон болно. Хэрвээ энэ нь бурхны орон биш бол бурхан яаж амьдрах билээ? Ойлгож байна уу?

Заримдаа та нар Багшийнхаа хувилгаан биеийг энэхүү махан биетэй адилгүй байгааг хардаг, учир нь тэр үед та нар чанагуух ертөнц нь болно, тиймээс Багшийнхаа жинхэнэ биеийг олж харж чадна. Тэр бол жинхэнэ Их Багш, харин энэ (*Их Багш өөрийн биеэ заав.*) бол хуурмаг юм, ойлгож байна уу?

Учир нь зарим хүн өөрөө жинхэнэ зүйлсийг харж чадахгүй тул хуурмаг юмсыг л харахаас өөр аргагүй болдог, яг л зарим хүн Арьяабалын бясалгалын аргыг дадуулж чадахгүй, эсвэл Багшийнхаа дээд дэсийн сургаал ёсыг сонсож чадахгүй, харин Арьяабал бодьсатвагийн баримал хөргийг шүтэх дуртай байдагтай адил, иймээс би түүнд Арьяабал бодьсатвагийн хөргийг худалдан авч өгдөг. Учир нь ингэвэл түүнд тун их тус болж, өөрийн биеэ тайтгаруулж чадна, өдөр бүр хуурмаг Арьяабал бодьсатвад ёслон

мөргөж, тун тухтай байдаг. Хэрэв үнэхээр ийм юм бол юу нь болохгүй байх вэ? Ойлгож байна уу? Би түүнд жинхэнэ Арьяабал бодьсадваг өгөхийн аргагүй, тэр хуурмагт нь дуртай болохоор түүнийг нь өгнө. Нялх хүүхэд алим, жигнэмэг, чихэр, эсвэл амтат идээ идэж чадахгүй бол бид түүнийг тайтгаруулахын тулд угж хөхүүлж тайтгаруулдаг, учир нь түүнд угж хэрэгтэй! Бид угж угаасаа ач тусгүй гэдгийг мэдэхгүй биш, мэднэ, гэвч түүнд өгдөг, учир нь түүнд шаардлагатай, ойлгож байна уу? Үүний нэгэн адил, бид гэгээрснийхээ дараа биднээр гэтэлгэгдэх төрөлтөн байдаггүй гэдгийг мэднэ, хэрвээ үнэхээр гэтэлгээ гэвэл бас угаас байхгүй гэдгийг мэддэг, гэтэл хамаг төрөлтөн ойлгоогүй байсаар байдаг тул тэдэнд заах хэрэгтэй, ойлгож байна уу? Та нарыг харахад бүгд Будда, гэтэл та нар бүгд өөрийгөө бүгд ад гэж боддог. (*Бүгд инээлдэв.*) Иймээс би юу ч ярих аргагүй. Би та нарт сэтгэлээ тогтуун байлга, дэлхий дахин угаас амгалан, бачуурч давчидмаар юм огт үгүй гэж хэлдэг ч та нар мөн л бачимдан сандарч, амар тайван байж чаддаггүй. Надад үнэхээр ямар ч арга алга, Багш нь тэвчээртэй хүлээх хэрэгтэй. Хэсэг хугацааны дараа та нар өөрсдөө ухаарчихвал зүгээр болно.

Иймээс Их Багш бологсод заавал хэмжээлшгүй тэвчээртэй байх хэрэгтэй. Та нар “Очирогтлогч судар”-т “гутаал доромжлолыг хүлцэн тэсвэрлэх хэрэгтэй” гэсэн байдгийг харсан. Үнэндээ “гутаал доромжлолыг хүлцэн тэсвэрлэх” гэдгийг Шагжамуни Будда л хэлэх эрхтэй, бусад хүн биднийг харааж загнавал дуугүй байх нь гутаал доромжлолыг хүлцэн тэсвэрлэж байгаа хэрэг гэж та нар боддог, тийм үү? Тийм биш, энэ нь доромжлолыг хүлцэн тэсвэрлэж байгаа хэрэг биш. “Доромжлолыг хүлцэн тэсвэрлэх” гэгч нь нэгэн Их Багш бологч хамаг төрөлтөн харанхуй мунхаг, өөрсдийгөө Будда гэдгээ мэддэггүй, өдөржингөө үнэн, худлыг ойлгохгүй, сэтгэл хөөрч явахыг хардаг хэдий ч тэдэнд ойлгуулах ямар ч арга байхгүй болохоор дэргэд нь тэвчээртэй зогсож, хүлээх л хэрэг болдог, энэ бол сая жинхэнэ доромжлолыг хүлцэн тэсвэрлэх, жинхэнэ хүлцэнгүй сэтгэл болно.

Есүс Христ “Хэрэв хэн нэгэн бидний баруун хацрыг алгавал түүнд зүүн хацраа ч бас алгадуулж бай!” гэж хэлсэн байдаг. Энэ бол жирийн хүмүүний хүлцэнгүй сэтгэл, тийм ч сүрхий юм биш, тэр нь зөвхөн АБВ-гийн дэс, хүүхдийн дэс төдий. Нэгэн Их Багш бологч л жинхэнэ хүлцэнгүй сэтгэлтэй байж чаддаг, та нар Их Багш болсон хойноо мэдэх болно, одоо хурдан бясалгаж, Их Багш болбол сая миний дарамт хөнгөрнө.

Та нарыг Их Багш болохоос өмнө би заавал та нарын төлөө энэ бие махбодоо харж халамжлах хэрэгтэй, иймээс заримдаа та нар бас Багшийгаа амраах хэрэгтэй. Энэ нь би амрах, эсвэл унтах дуртайдаа биш юм, харин амарсны хойно, маргааш нь та нарт дахин үйлчилж чадна, ойлгож байна уу? Хэрвээ өдөр бүр цаг завгүй яаралтай ажиллавал энэ бие махбод тун удахгүй нурж унах болно, яг л машин тэрэг шиг дэндүү их ашиглаж, зогсолтгүй ажиллуулбал машин нь халангуутаа дэлбэрч, түргэн эвдэрч сүйднэ; хэрвээ алгуурхан, болгоомжтой ашиглавал удаан ашиглаж чадна. Багш нь та нарын төлөө л энэ бие махбодоо арчилдаг, учир нь Багш нь олон янзын уур амьсгалд зохицсон байх хэрэгтэй, ойлгож байна уу? Багш нь тун мэдрэмтгий, та нартай адилгүй, та нар өдөр бүр яарч, элдэв юм бодож, замбараагүй зүйлс хийсэн ч хамаагүй байдаг, гэтэл Багш нь тийм биш, заримдаа яарах хэрэгтэй, заримдаа нам тайван байх хэрэгтэй, тэгэхгүй бол хэлбэр дүрсгүй ажлыг хийхийн арга үгүй. Үзэгдэж харагддаггүй ажил нь хэлбэр дүрстэй ажлаас нэн чухал, ойлгож байна уу? Багш бол энэ махан бие цогцос биш бөгөөд зөвхөн энд л ном тайлж байгаа төдий биш, Багшийн үзэгдэж харагддаггүй ажил төрөл тун олон, иймээс л та нар гэртээ байхдаа Багш нь хувилгаан дүрээрээ ирэхийг харж чаддаг, машины осолд орох үед зөвхөн Багш нь ирж авардаг, та нар аль ч түвшинд хүрсэн бай Багш нь замчлагч болдгийг хардаг, тэр бол Багшийнх нь ажил юм.

Багш нь зөвхөн ном тайлдаг төдий биш, ном тайлах нь хараахан Бодь мөрийн хутгийг олоогүй байгаа хүмүүсийг тайтгаруулж, бясалгахад нь зоригжуулахын төлөө юм, ойлгож байна уу? Нэгэн жижигхэн бүлгийн хүмүүсийн төлөө хоёр, гурван цагийг үрэх нь тийм ч их ач тустай биш байж мэднэ, учир нь тэд Багшийнхаа ном тайлахыг сонсоод гэртээ харимагц мартчихдаг, дараа ирэхдээ ярьсан зүйлийг дахин асууна. Үнэндээ та нарын хувьд энд ирээд Багшийнхаа нүд рүү харах нь л хангалттай, Багштайгаа дэндүү их битгий зууралдаад бай, тэгэхгүй бол хоёулаа живж үхэх болно. Та нар Багшдаа энэрэнгүй хандахгүй бол ядаж бусад хүмүүст энэрэнгүй хандах хэрэгтэй, учир нь хэрвээ Багш байхгүй болбол юм бүхэн бүгд алга болно. Махан бие цогцос чухал биш, гэвч бас тун чухал. Энэ махан бие цогцос байхгүй бол хувилгаан бие байж чадахгүй; гадна талын Их Багш үгүй бол дотоодын Их Багш байхгүй; авшиг уламжлах хүн байхгүй бол хүч дамжуулах хүнгүй болно, Их Багшийн адислал бүр ч байж чадахгүй, юу ч байж чадахгүй. Иймээс бурхан бодьсатва махан бие цогцостой байх хэрэгтэй. Та нар энэ махан бие цогцсыг хамгаалж байгаа

нь өөрсдийнхөө төлөө юм, иймээс Багшийгаа хайрлахад хэмжээ хязгаараас хэтэрч болохгүй! Багшийнхаа амрах цагийг хүндэтгэх хэрэгтэй, ингэвэл Багш нь сая хүч тамираа сэргээж, та нарт болон бүгдэд илүү их үйлчилж чадна.

Багшид нь тайван орчин шаардлагатай, тэгж байж л нэн олон үзэгдэж харагддаггүй ажлыг хийж чадна, хэрвээ бие махбодын байдал дэндүү муу байвал ажиллаж чадахгүй, ойлгож байна уу? Бие махбод өвдөж муудвал яршиг болно, тэгвэл та нар зөвхөн энэ бие цогцсыг алдах төдий биш, бусад олон төрөлтөн ч авшиг хүртэх аргагүй болж, хамаг төрөлтөн бүгд Багшаа алдах болно, зөвхөн ганц та нар ч биш. Тэр ч байтугай бүхий л Формосад ганц ч хүн авшиг хүртээгүй байсан ч Багш нь энд байдаг л бол Формоса өөр байна, дэлхий ертөнц ч адилгүй байна. Харин заавал авшиг хүртвэл сая бусдад тусалж чаддаг биш бөгөөд заавал Багшийгаа харвал л сая Багшийнхаа хүчийг хүртэж чаддаг биш, ойлгож байна уу? Тэр өдөр та Багшийнхаа номыг уншаад ахуй ойлголттой болсон, одоо Багшийнхаа ярьсныг дорхноо ойлгох болов. Тухайн тэр үед та зүгээр л гэртээ суугаад ном уншиж, Багштайгаа уулзахаар ирээгүй байсан, тэгсэн хэрнээ тэгж цочиж самгардсан, тийм биш үү? Таны хүлээж авсан нь таагүй ахуй ойлголт байсан ч ийм замаар л та нар Багшийнх нь ярьсан бүхэн үнэн болохыг мэдэрч чадна.

Өөр хүмүүс бүгд л тун тааламжтай ахуй ойлголттой болдог, жишээлбэл, билиг нээгдэх, Гэрэл харах, дотоодын Аялгуу сонсох, эсвэл Багшийнхаа хувилгаан биеийг харах гэх зэрэг. Гэтэл та харин хамгаас тааламжгүй ахуй ойлголттой болсон шиг л байна, уучлаарай! Та тийм зовуурьтай ахуй ойлголтдоо дуртай байсан байж ч магад. Зарим хүн гашуун эм, эсвэл кофе уух дуртай байдаг. Бид кофе уухад тун гашуун санагддаг байхад дуртай хүмүүст нь харин тун таатай сайхан санагддаг, тийм биш үү? Бид архи уух дургүй, гэтэл зарим хүн дуртай, тэр ч байтугай тэд архинд донтдог. Та тийм зовуурьтай ахуй ойлголтонд дуртай юу? (*Тэр хүн, Дургүй гэж хариулав.*) Сайн байна! Дараагаар ийм байдал дахин тохиолдохгүй, зөвхөн тааламжтай ахуй ойлголттой байх болно, та нар бүгд ойлгосон уу?



ХЭЛБЭЛЗЭЛИЙН ХҮЧ ҮЙЛ ТҮЙТГЭРИЙГ АРИУСГАЖ ЧАДДАГ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Тайвань, Тайбэй, Цаглашгүй гэрэлт бясалгалын төв
1987 оны 11 дүгээр сарын 29.(Эх нь хятад хэлээр)*

Ажилтайн улмаас долоо хоногийн даяанд оролцохоор чөлөө авч чадаагүй хүмүүс их байна. Тэд долоо хоногийн даяаны гурван хоногт нь хамрагдаж болох боломжтой эсэхийг Багшаас нь асуусан. Тэр үед Багш нь нилээд хатуу байжээ, гурав хоногийн даяан бол гурав хоногийн даяан, долоо хоногийн даяан бол долоо хоногийн даяан. Гэтэл долоо хоногийн даяан дууссаны дараа, Тайбэйд буцаж ирээд би живж үхэх шахсан, (Бүгд инээлдэв.) яагаад гэвэл тэд бүгдээрээ уйлсан, бүр эрэгтэйчүүд хүртэл уйлсан, учрыг нь асуухад тэд долоо хоног Багшийгаа харж чадаагүй болохоор тун их зовсон гэв.

Би одоо Иланд очиж зүрхлэхгүй болов, тэнд бас нэг уйланхай шавь бий, түүнийг Гүэ авхай гэдэг, уйлах дуртай болохоор нь би түүнийг “уйланхай авхай” гэж дууддаг юм, тэр Багшийг нь дагаж гэрээс гарах тун дуртай. Энэ махан бие цогцос бол зөвхөн төлөөлөгч төдий, та мөнхөд ашиглаж, эсвэл мөнхөд харах боломжгүй гэж Багш нь хэлсэн. Их Багш нар энэ дэлхийд гурван жил, таван жил, хорин жил, тавин жил, эсвэл зуун жил амьдардаг, махан бие мөнх байж чадахгүй, зөвхөн хувилгаан бие л хаа сайгүй оршиж, хаа ч байж болдог.

Яагаад хүн болгон Багшийгаа харахаараа уйлдаг вэ? Ганц намайг ч биш, олон хүн миний Багш юмуу, Өвөг Багшийг харахаараа бас уйлдаг байсан. Учир нь нэгэн амьд сэрүүн байгаа

жинхэнэ Их Багш маш ховор, Түүнтэй хэдэн зуун сая галавт зөвхөн ганцхан удаа уулзаж чаддаг. Энэ нь Төгс Гэгээрсэн Их Багш сая сая галавт ганцхан удаа илэрдэг гэсэн үг биш, харин бид хэдэн зуун сая галавт Түүнтэй ганц удаа л уулздагт хэргийн учир оршино. Учир нь бид өөрсдийн хичээлээ сайн сурах ёстой, чийгийн улаан хорхойн бясалгалын арга, мэлхийн бясалгалын арга, морь, заан, үхэр гэх зэрэг олон амьтны бясалгалын аргыг сурна. Бид наян дөрвөн мянган төрлийн төрөлтөн байх үедээ наян дөрвөн мянган зүйлийн бясалгалын аргад суралцдаг.

Та нар мэлхий бясалгал дадуулдаггүй гэж битгий бодоорой, тэд бясалгадаг. Яст мэлхийг бясалгадаггүй гэж бүү бодоорой, зарим яст мэлхий бясалгал хийгээд шулам болдгийг та нар сонссон байх. Үнэг ч бас бясалгал дадуулдаг, тэд өөрсдийнхөө бясалгалын аргаар бясалгаад хүн болж хувирдаг. Энэ бол үнэн учир явдал, харин “Сахиулсан өргөмжилсөн үлгэр” дэх түүх биш. Үүнээс гадна бясалгалын арга олон байдаг, бид одоо “хүний бясалгалын арга”-аар бясалгаж, хүний Мөр ёсыг бясалгаж байна. Хүний бясалгалын арга нь амьтны бясалгалын аргаас ч олон байдаг, бид олон бясалгалын аргыг сонгож болно, гэтэл амьтад чадахгүй.

Жишээлбэл, чийгийн улаан хорхой зөвхөн чийгийн улаан хорхойн бясалгалын аргаа л дадуулж, цаг нь болсны дараа сая бусад бясалгалын аргыг дадуулж болно. Гэтэл хүн бол сонгож болно, учир нь бид “далд ухамсар”-тай, чөлөөт эрхтэй. Бид бирд, адгуусны бясалгалын аргыг сонгож болох бөгөөд диваажин, асурын бясалгалын аргыг ч сонгон бясалгаж болно, бас бие махбодоо чийрэгжүүлэх бясалгалын аргыг сонгон бясалгаж болно, өөрөөр хэлбэл энэ нь урт насалж, үхэшгүй мөнх байх гэсэн үг юм.

Хэдий тийм ч бидний махан бие хязгаарлагдмал бөгөөд үхэшгүй мөнх амьдрахыг бясалгахад тийм ч хялбар биш, тийм бишсэн бол Шагжамуни Будда ч бас үүнийг бясалгачих байсан. Тэр бас үхэлгүй мөнхрөхийг бясалгаж байсан гэж би сонссон. Судар номд тэмдэглэснээр, Шагжамуни Будда энэ тоост хорвоод тун урт хугацаагаар саатаж болох байсан хэдий ч үлдсэнгүй, яагаад гэдгийг та нар мэдэх үү? Тэрээр нэгэнтээ тоост хорвоод үүрд үлдэж болох юм гэж Анандад сэм дохиолжээ. Гэтэл Ананд үнэхээр тэнэг байжээ, тэр үед адын хүчин билиг ухааныг нь хаачихсан байсан тул тэрээр Шагжамуни Буддаг үлдэхийг гуйгаагүй аж. Ойлгож байна уу? Хэрэв нэг ч шавь нь Түүнээс үлдэхийг гуйгаагүй бол Тэр үлдэж чадахгүй юм. Гэхдээ энэ бол

бүгд урьдаас тогтсон зүйл, учир нь хамаг төрөлтний үйлийн үр маш хүнд болохоор ийм болжээ. Энэ нь Анандад ямар нэгэн асуудал байсан хэрэг биш, харин хамаг төрөлтний үйлийн үрээс үүдсэн байна.

Тэр ч байтугай хэрэв нэгэн Их Багш шавь нартаа маш их хайртай, тэдэнтэй ойр байх дуртай, үүрд хамт байхыг хүсдэг байсан ч заавал шавь нарынхаа бясалгалд найдна, хамаг төрөлтний нийтийн үйлийн үр, улс орны нийтийн үйлийн үрд найдна, ингэж л сая шийдэж чадна. Миний бодлоор формосачууд маш их буянтай, Формоса бол хамгийн их буянтай улс.

Энэтхэг ч гэсэн маш их буянтай улс, тэд угаас их буянтай. Энэтхэгийн уламжлалт ёс заншил, дадал зуршил, хүмүүнлэг сэтгэл, газар зүйн байрлал нь угаасаа өлзийтэй. Энэтхэгчүүд өнөөг хүртэл цагаан цайлган, маш сайхан сэтгэлтэй хэвээр байна, тэд эрт үеийнхтэйгээ адилхан мөн л цагаан хоол иддэг. Ислам болон католик шашинтнуудыг эс тооцвол цөөхөн хүн мах иддэг, гэхдээ зарим сикх шашинтан манай бурхны шашинтнууд шиг мах иддэг. Бурхны шашинтнууд уг нь цагаан хоолтон байх ёстой, “Эсэрваа тэнгэрийн судар”, “Газрын зүрхэн бодьсадвагийн судар” зэрэг аль ч судар номд цөмд нь бурхны шашинтнууд цагаан хоолтон байх ёстой гэж онцолсон байдаг. Гэсэн хэдий ч зарим хүн, тэр дундаа хувраг хүн ч мах идсээр байна. Энэ нь тухайн орны зан заншил, уламжлал болон газар зүйн байрлалтай холбоотой.

Жишээлбэл, Төвөдөд ногоо тарьж болдоггүй, тарьсан ч ногоо нь олигтой ургахгүй учраас тэд ургамал хоолтон болж чадахгүй. Эсвэл Япон бол мах иддэг улс орон, хэрвээ та тэнд бадарчилбал хэн танд ургамал хоол өгөх вэ? Тайланд, Мьянмарт ч мөн ийм, хүмүүс юу өгвөл түүнийг нь иддэг. Гэвч Шагжамуни Будда нилээд азтай, тэр Энэтхэгт төрж өссөн, Энэтхэг угаасаа цагаан хоолт улс орон, одоо ч гэсэн цагаан хоолтон хэвээрээ байна. Тэд бүгд шар хувцастай хуврагууд мах идэж болохгүй гэдгийг мэддэг.

Шагжамуни Будда шавь нартайгаа бадарлаж байх тэр үед тэдний ихэнх нь цагаан хоолтон байсан. Тэгээд ч Шагжамуни Будда тун нэр алдартай байсан, өдөр бүр хоол идүүлэхээр урьдаг хүмүүстэй, шинэ газар орон луу явах үедээ л бадарлах хэрэгтэйгээс биш, бусад үед тун цөөн бадарладаг, үгүй бол бас хааны ордонд очиж, бадарлаж болно, тэгвэл хаан эзэн өөрийн биеэр зочилж харгалзана. Та нар ямар ямар хаан Шагжамуни Будда болон шавь нарыг нь урьж, өргөл өргөж, өөрийн биеэр хүндэтгэн зочилсон гэдгийг сонссон уу?

Гэхдээ тэр үед бас зарим нь мах иддэг байсан. Бид үүнийг яаж мэдэж болох вэ? “Нирваан судар”-т Шагжамуни Буддагийн шавь нь: “Бадарчлах үед зарим хүн мах өгвөл яах вэ?” гэж асуусанд Шагжамуни Будда: “Гэртээ харьсны хойно, идэхээсээ өмнө махтай хэсгийг нь угааж цэвэрлэсний дараа сая идэж болно.” гэжээ. Тэр маш тодорхой хэлжээ, тийм үү? Хэрвээ хэн нэгэн хүн Шагжамуни Будда мах иддэг гэж яривал тэрээр судар номыг ойлгодоггүй, гүнзгий судалдаггүй, судар ном их уншдаггүйгээс болсон хэрэг. Тийм учраас ийм буруу ойлголттой байдаг. Үгүй бол “Эсэрваа тэнгэрийн судар”, “Баатараа явагч нэрт их хөлгөн судар”, “Хутагт Ланка-д заларсан судар”, “Газрын зүрхэн бодьсадвагийн судар” -т бүгдэд нь тодорхой тэмдэглэсэн байдаг.

“Газрын зүрхэн бодьсадвагийн судар”-т хүн нас барвал цагаан хоолоор сүнсийг нь тахиx хэрэгтэй, хэрвээ түүнд тахил өргөхийн тулд амь хороовол, эсвэл түүний төлөө амь хороож, бурхан, эсвэл сахиус хувилгаадыг тахивал уг нь үйл түйтгэргүй байснаа дорхноо бий болж, нас нөгчигсдийн сүнс тэр дороо амь хороосон үйл түйтгэрт доош татагддаг. Уг нь тамд унахгүй байх байсан, гэтэл нас барсны учирт нь амь хороож зочдод идүүлбэл тамд унах болно. Түүнчлэн тэр сүнс уг нь тун их буянтай байж, тэнгэрт дэвших байсан бол бид амь хороож түүний сүнсийг тахиснаар тийм түргэн тэнгэрт дэвшиж чадахгүй, эсвэл тэнгэрт дэвших боломжгүй болох бөгөөд заавал дахин хүн, эсвэл адгуусны төрөл авах хэрэгтэй болно.

Судар номд тэмдэглэснийг үндэслэвэл бид Шагжамуни Будда ургамал хоолтон байхыг сургаагүй гэж хэлэх аргагүй. Олон хүн Багшийг нь бусдыг ургамал хоол идэхийг сургаж байгаа учраас буруу номтон, бярмань шашинтан гэж ярьдаг, иймээс би дашрамд нь тайлбарлаж байна, ингэвэл хожим та нар бусдад тайлбарлан ярьж чадна, хэрэв та нар өөрсдөө сураагүй бол яаж тайлбарлах вэ? Багш нь та нарт тайлбарлаж өгвөл та нар бусдад ярьж чадна, тэгэхгүй бол хүмүүс тантай жаахан маргалдахад л та ярих үггүй болно. Та нар судар ном сонсохдоо анхааралтай сонсох хэрэгтэй, хожим ач тустай, хүмүүс биднээс, юунд үүнийг бясалгаж байна вэ, эсвэл юунд ургамал хоол иднэ вэ гэж асуувал юу гэж хариулахаа мэдэх хэрэгтэй.

Энэ нь бид маргах дуртай гэсэн үг биш, гэхдээ бид ойлгож байх хэрэгтэй, мөн бусдад шахагдаж болохгүй. Бид хэн нэгэнтэй маргах шаардлагагүй, гэтэл хүн бидэнтэй маргалдвал яаж хариулахаа мэдэх хэрэгтэй. Гэхдээ дэндүү ихээр мэтгэж маргах

хэрэггүй, үр дүн байхгүй бол маргалдахаа зогсоох хэрэгтэй. Цаад хүн сонсохгүй ч хамаагүй, бид хоёр гараа наманчлан түүнд амар амгалан, аз жаргалыг ерөөж, Авид Бурхан гэж залбирах хэрэгтэй. Маргах хэрэггүй, уурлаж болохгүй, тэгвэл сүр жавхаагаа алдана, тэгэх ч шаардлагагүй, ойлгож байна уу?

Багш нь саяхан нас нөгчих явдлыг ярьсан, тийм нөхцөл байдал ямар ч аргагүй байдаг биш үү? Бид үйл түйтгэргүй ч бусад хүн биднийг үйл түйтгэртэй болгодог нь тун аймшигтай явдал биш гэж үү? Иймээс та нар сайн үйл үйлдвэл хангалттай, нас барсны хойно лавтай тэнгэрт дэвшинэ гэж битгий бодоорой, хэлж мэдэх аргагүй. Гэр бүл тань маш баян чинээлэг бол тэд маш олон гахай, үхэр алж, сүнсийг тань тахиж, өдий төдий зочин урьж, нас нөгчсөнийг тань тэмдэглэх болно. *(Бүгд инээлдэв.)* Та нар мэднэ, энэ нь үнэндээ гунигтай, бухимдалтай байх ёстой ч тэд гунигтай байдаггүй. Миний харахад тэднийг зочдоо дайлж байх үед маш олон хүн цуглан яриа хөөрөө их, энэ мах нь амттай, тэр дарс нь гайхалтай, мах, дарс хоёр зохицон дажгүй хослоод үнэхээр гайхалтай амттай байна гэцгээнэ, тэгээд их идэх тусмаа илүү их ууж, улам чанга дуугаар хөөрөлдөн наргидаг.

Уг нь тэд энд нас барсан хүний сүнсний төлөө хамтдаа маани тарни уншин бурхан бодьсadgeаас адислал гуйх юмуу, Эзэн Бурханаас аврал гуйх, эсвэл хамтаар бясалгаж суух гэх зэргээр сүнснийг нь төрөл дэвшүүлэхийн төлөө ирсэн, гэтэл оронд нь харин хоол идэхэд нь л тусалж, нас барсан хүний ар гэрийнхэнд бөөн ажил удна, ар гэрийнхэн нь ихэд яарна, ядарна, зовнино, бас олон зочныг дайлах хэрэгтэй. Үүнийг үнэхээр ойлгомжгүй хэрэг гэж би бодож байна! Бид өнөөдөр нас барах үед хэн ч тусалж чадахгүй байдаг талаар ярилцсан, гэхдээ битгий нас барах дөхөхөөрөө л сая бясалгаж эхлээрэй. Өглөг үйлдэж, сахил сахивал хангалттай болчихно гэж битгий бодоорой. Хэдийгээр өглөг үйлдвэл буян хишигтэй болдог ч бусад хүн бидэнд үйл түйтгэр зохионо, тэр үйл түйтгэрийг бид бас төлж дуусгах ёстой, буян хишиг болон үйл түйтгэр адилгүй. Бидэнд буян хишиг ч, үйл түйтгэр ч байдаг.

Хүн нас барсныхаа дараа үнэхээр тун хөөрхийлөлтэй, ямар ч эрхгүй, ад чөтгөр хүрч ирээд аваад явна, тэд бидэнд юу ч тайлбарлахыг зөвшөөрөхгүй, Эрлэг Номун хааны зарлигаар биднийг аваад явдаг, нэг үг ч яриулахгүй, тэр үед бид юу ч ярьж чадахгүй, учир нь..., иймээс..., гэхдээ..., гэтэл... гэх зэргийн олон шалтгийг тань ойшоохгүй, ад чөтгөр энэрэн нигүүлсэх сэтгэлгүй, тэдний ажил маш тодорхой байдаг бөгөөд тэд хэнийг

ч хамгаалахгүй. Тэр ч байтугай хаан эзэн, лам хувраг, албан тушаалтан гэх зэрэг хэн байсан ч ял гэмтэй л бол тэд ирээд баривчлан аваачна. Бизнесийн нэрийн хуудас ямар ч хэрэггүй, ямар нэг эзэн хаан, ямар ямар том ноён, эсвэл ямар нэг тодорхой албан тушаалтан эсэх нь тэдэнд хамаагүй, та хичнээн их мөнгөтэй байсан тэднийг хахуульдаж чадахгүй, энэ бол төвөгтэй асуудал шүү.

Энэ дэлхийд бид хээл хахуульд дасчихсан, тэр ч байтугай нас барсныхаа хойно ч буян хишгээрээ Эрлэгийн хаанд хээл хахууль өгч болно гэж боддог. Зарим хүн хээл хахууль өгөхийн тулд хуурамч мөнгө шатаадаг нь инээдэмтэй биш үү? Бид хэтэрхий оройтоглоо хүлээх ёсгүй. Харин одооноос “ачаа тээш”-ээ бэлтгэж эхлэх хэрэгтэй, цаг нь болмогц түүнийгээ аваад л явчихна.

Ачаа тээш гэж юу билээ гэвэл бидний бясалгалын ач буян юм, өглөг үйлдэж, сахил сахих нь тус тусын буян хишигтэй, гэвч Арьяабалын аргаар бясалгавал цаглашгүй ач буянтай, чанагуух ертөнцийн ач буянтай болно, ямарваа ач буян нь Арьяабалын аргаар бясалгахаас нэн сайн биш, яагаад гэвэл, жишээлбэл, хэрэв та нэгэн гуйлгачинд хоёр зуун төгрөгийн өглөг өгсөн байвал дараа төрөлдөө хоёр зуун сая төгрөг авахаар буцаж ирээд гуйлгачин болох ёстой болно, гуйлгачны бясалгалын аргыг дадуулах дуртай хүн байна уу? Сонсоход Ау Лакт нэг маш баян гуйлгачин байсан гэж сонссон, түүнийг нас барсны дараа цүнхнээс нь очир алмас, шижир алт зэрэг олон үнэт зүйл олдсон байна. Тэрээр жирийн хүмүүсээс илүү баян байжээ, хүмүүс түүнийг тийм баян байх юм гэж үнэхээр бодож байгаагүй аж. Магадгүй тэр дараа төрөлдөө буцаж ирээд гуйлгачны бясалгалын аргыг дадуулахыг хүссэн байх. *(Бүгд инээлдэв.)*

Тийм ч учраас Багш нь авшиг хүртээх үедээ та нарт өгдөг гарын авлагад таван сахилын талаар бичсэн байдаг. Хэрэв та нар өглөг өгвөл Багшдаа зориулж байна гэж бодох хэрэгтэй. Энэ нь тэр мөнгө угтаа Багшийн мөнгө гэдгийг илэрхийлж байгаа гэсэн үг юм, ингэвэл буян хишигтэй холбогдохгүй болно. Өглөг үйлдэх нь яг л шууданч захидал хүргэхтэй адил юм, захидал нь шууданчийнх биш, захидлыг хүргэх нь л түүний үүрэг. Өглөг үйлдэхдээ буян хишигтэй болохыг бодох нь тун эгдүүтэй явдал, учир нь буцаж ирээд буянаа эдлэх ёстой. Хэрвээ хэн хүн буцаж ирэхийг хүсвэл ийм байдлаар өглөг өгч болно, хэрэв буцаж ирэхийг хүсэхгүй байгаа бол өглөг үйлдвэл даруйхан мартах хэрэгтэй, мөн өглөг үйлдэх нь үйлдээгүйтэй адил байгаа эсэхийг

шалгаарай. Хэрвээ та нар Багшдаа итгэхгүй бол түүнийг Бурхан бодьсадвагийн мөнгө гэж үзэн: “Би” түүнд өглөг өгч байна, “Би” машид баярласан, “Би” тийм сайн, тийм энэрэнгүй гэж битгий бодоорой, ингэвэл яршигтай болж, хэд хэдэн удаа буцаж ирээд энэ буянаа хэд дахин эдлэх ёстой болно, гэвч буцаж ирэх үедээ Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олоход хэцүү байх бөгөөд шинэ үйл түйтгэр зохиож, дахин төрөл төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэж эхэлдэг.

Хэрэв энэ төрөлдөө шинэ үйл түйтгэр зохиовол дараа төрөлдөө хүн болж чадахгүй, харин амьтан болж ч тун магад, амьтан бас буян эдлэх боломжтой, тийм биз? Жишээлбэл, ерөнхийлөгчийн зуслангийн харшид нохой байх нь эгэл жирийн хүмүүсээс илүү их жаргал эдэлдэг. Баруунд ийм эрхэмсэг угсаат нохой маш үнэ цэнэтэй байдаг, тэд өөрийн гэсэн иргэний үнэмлэхтэй, түүн дээр нь тамга тэмдэгтэй зураг нь бий, мөн тэд тусгай эмчтэй байдаг. Гэтэл энэ дэлхий дээр ядуу, тийм сайн асрал халамж хүртэж чаддаггүй хүн олон, зарим хүн биеэ худалдавч авах хүнгүй байгаа тул тэд ямар ч үнэ цэнгүй байдаг, тийм биз дээ?

Зарим хүний үйл түйтгэр маш хүнд гэж бид сонссон, зарим хүнийг түүний хэлбэлзлэл маш ширүүн, эсвэл ахуй орчин, агаар амьсгал нь сайн биш гэж ярьдаг. Орчны агаар амьсгал хаанаас гарч ирдэг вэ гэвэл хэлбэлзлэлийн хүчнээс ялгардаг, энэ нь зурагтын хэлбэлзлэлийн хүчтэй адилхан. Заримдаа бидэнд тухайн хүний орчны агаар амьсгал нь сайнгүй, хэлбэлзлэл нь тааламжтай биш юм шиг санагддаг нь хүмүүст таагүй мэдрэмж төрүүлдэг. Гэхдээ зарим хүний хэлбэлзлэл нь амгалан тайван, эерүү агаар амьсгал бий болгодог нь хүмүүст таатай сайхан мэдрэмж төрүүлдэг. Иймээс чөтгөр нь чөтгөрийн хэлбэлзлийн хүчтэй, бодьсадва бол бодьсадвагийн хэлбэлзлийн хүчтэй, хүн бол хүний хэлбэлзлийн хүчтэй, сайхан сэтгэлтэй хүн сайн хэлбэлзлийн хүчтэй, хэрцгий хүн бол хэрцгий хэлбэлзлийн хүчтэй байдаг. Арьяабал ч мөн нэг зүйлийн хэлбэлзлийн хүч мөн, Арьяабалын бясалгалын арга бол дотоодын Аялгуугаа ажих явдал бөгөөд нэг зүйлийн хэлбэлзлийн хүч юм. Хамгийн эерүү найрсаг, хамгийн дээд, хамгийн хүчтэй хэлбэлзлийн хүчийг ашиглан бүдүүн баараг хүнд хэлбэлзлийн хүчийг сарниулдаг, ингэснээр үйл түйтгэрийг угаан цэвэрлэж чадна.

Бид өглөг үйлдэх, сахил сахих... гэх зэргээр юу хийсэн байлаа ч хангалттай аюулгүй биш. Хэдийгээр бид сахил сахидаг ч хэрэв бусад хүн сахихгүй, бидний төрөл садан сахихгүй бол

тэд алдаа гаргаж, үйл түйтгэр зохион бидэнд нөлөөлж, биднийг бохирдуулж, бидэнд үйл түйтгэр авчрах болно. Ойлгож байна уу? Яг л жолооч шиг, тэрээр хичнээн сайн жолоодож, хичээн болгоомжилдог ч бай автомашины осол хэзээ ч гарахгүй гэсэн баталгаа байхгүй. Энэ нь бид анхаарал болгоомжгүй, эсвэл сайн жолоодохгүй байгаагаас болсон биш, харин бусад хүн муу жолоодож, бидэнд нөлөөлснөөс болдог. Иймээс зөвхөн өөрийн хүчиндээ л найдаж болохгүй, зарим хүн машин жолоодоходоо бас бурхан бодьсатвагаас тусламж гуйдаг, Багшийнх нь зарим шавь ч Багшаасаа тусламж гуйдаг, учир нь бид зөвхөн хичээж болгоомжлох болон машин жолоодох сайн ур чадвартаа найдаад болчихгүй.

Үүнтэй адилаар өглөг үйлдэх, сахил сахих, доромжлолыг хүлцэх, хичээнгүйлэн чармайх зэрэг ямар ч бясалгалын аргыг дадуулах нь бүгд сайн, бүгдийг бясалгаж болно, гэхдээ хэрэв үйл түйтгэрээс хэтийдэж, өнө үүрд туулан гэтлээ гэвэл цорын ганц арга зам нь Арьяабалын бясалгалын арга юм. Хэлбэлзлийн хүчээр л хэлбэлзлийн хүчийг сарниулж чадна, ойлгож байна уу? Материаллаг зүйлсээр хэлбэр дүрсгүй, материаллаг бус зүйлсийг арилгаж чадахгүй. Иймээс бид хэлбэр дүрсгүй Аялгуу, хэлбэр дүрсгүй хэлбэлзлээр л тиймэрхүү хэлбэр дүрсгүй хэлбэлзл (үйл түйтгэр)-ийг арилгаж чадна. Тиймээс бид хэлбэр дүрсгүй хэлбэлзл(үйл түйтгэр)-ийг арилгахын тулд хэлбэр дүрсгүй Аялгуу, хэлбэр дүрсгүй хэлбэлзлийг ашиглах ёстой.

Бид юу сурсан ч үндэслэлтэй, логикт нийцсэн, мөн уг зүйлийг сурахаас өмнөх бидний эрдэм мэдлэгт нийцсэн байвал сая сурах хэрэгтэй. “Ариун орон” сайн гэж хүн яривал “Ариун орон”-ыг бясалгана, амьсгалыг бясалгавал сайн гэхийг сонсоод амьсгалын аргыг дадуулна, коан-ном хаялцаан сайн гэхийг сонсоод ном хаялцахыг дадуулна, ингэж мухар сохроор шүтэж болохгүй. Юуг бясалгасан ч бүгд жаахан ач тустай, гэхдээ энэ нь зөвхөн сэтгэл зүйд л бага зэрэг нөлөөлдөг.

Бид бурханд мөргөхдөө хэдэн дусал матрын нулимс унагаадаг. *(Бүгд инээлдэв.)* Матар сэтгэл нь хөдөлбөл л уйлдаг гэдгийг та нар мэдэх үү? Зарим хүн бас матрын нулимс унагадаг, гэхдээ тэр нь хуурмаг байдаг. Бид бурханд мөргөх үедээ нулимс унагаж байвал бидэнд илүү таатай сайхан санагддаг, олон хүнтэй хамт маани, тарни уншвал илүү аятайхан байдаг, алдаа буруугаа наманчлахдаа нулимс унагавал сэтгэл тайвширч, санаа амарч, тайтгардаг, тийм биш үү? Жишээлбэл, сахил хүртэж, шүтэн дагах

үед номын багш: “Өнөөдрөөс эхлэн та миний шавь болсон.” гэж ярихыг сонсвол тун таатай санагддаг, тийм үү?

Дэлхийн үг хэлээр хэлбэр дүрсгүй, нарийн үйл түйтгэрийг яаж угаан цэвэрлэж чадах вэ? Энэ нь хялбар биш, учир нь үйл түйтгэр бол төрөл төрөлдөө бичиж тэмдэглэж авсан нөлөөлөл юм. Жишээлбэл, видео хальсан дээр видео бичлэг хийх боломжтой байдаг. Энэ нь хамтдаа дүрс үүсгэхийн тулд нэг төрлийн хэлбэлзлийн хүчинд тулгуурладаг, тийм биз? Видео хальс нь жижигхэн дугтуйнд багтдаг хэдий ч тэр нь дотроо маш олон түүх, бодит нөхцөл байдлын зураглалыг агуулж байдаг. Хэрвээ бид өдөр бүр түүнд хандан: “Таны энэ бичлэг тийм ч сайн харагдахгүй байна. Та үүнийгээ арчиж болох уу? Надад өөр нэг бичлэг таалагдаж байна.” гэж хэлсэн ч, видео хальсанд хичнээн их ярьсан ч тэр өөрөө бичлэгийг арчин цэвэрлэж чадахгүй. Тэгвэл яаж арчиж баллах вэ? Нэгэн товчлуурыг дарж арчих, эсвэл өөр нэгэн хэлбэлзлийн хүчийг ашиглан дахин өөр дүрсийг бичиж авбал хуучин байсан дүрс нь арилдаг, түүнээс биш өөр арга байхгүй, та видео хальсыг хүчээр задлаад усаар угааж болохгүй. Ус нь зөвхөн гадна талд байгаа хувцас, эсвэл бохир юмсыг угаан цэвэрлэж чадна, гэвч видео хальсыг угааж чадахгүй.

Үүнтэй адилаар үйл түйтгэрийг ном хаялцаанаар яаж угаан цэвэрлэж болох вэ? Үйл түйтгэр бол хэлбэр дүрсгүй, төрөл төрөлдөө шингээсэн зүйл бөгөөд нэг зүйлийн маш бүдүүн баараг, үл үзэгдэх хэлбэлзлэлд хамаардаг. Бид хэрхэн дэлхийн үг хэлийг ашиглан үл үзэгдэх хэлбэлзлийг угаан арилгаж чадах вэ? Багшийнхаа санааг ойлгож байна уу? Зөвхөн хэлбэр дүрсгүй хэлбэлзлийг ашиглаж байж л хэлбэр дүрсгүй хэлбэлзлийг арилгаж чадна.

Арьяабалын бясалгалын аргыг хүн зохион бүтээсэн биш, харин нэг зүйлийн хэлбэр дүрсгүй хэлбэлзлийн хүч юм, үүнийг бүгд мэднэ. Иймээс энэ дотоодын Аялгууг ашиглан хэлбэр дүрсгүй, бүдүүн баараг, хүнд хэлбэлзлийг угааж чадна. Энэ нь учир зүйд нийцэх үү, үгүй юу? Яг л дуу хураагч шиг, бид нэг дуу бичиж авснаа дараа нь сонсох дургүй болбол өөр дуунууд бичсэнээр тэр дуу алга болдог.

Энэ дэлхийд бясалгалын арга тун олон. Зарим хүн Багшаас нь: “Яагаад үүнийг бясалгаж болохгүй, түүнийг ч бясалгаж болохгүй вэ” гэж асуудаг, болохгүй биш, харин хүч нь адилгүй юм. Хэрвээ үйл түйтгэрээ арилгая гэвэл зөвхөн Арьяабалын бясалгалын аргаар л бясалгавал сая арилгаж чадна гэж Багш нь

саяхан ярьсан, үүнийг та нар ч гэсэн ойлгоно. Хэрвээ хэн нэгэн хүн асуувал бид үүнийг жинхэнээр ойлгож байж л сая хариулж чадна, хэрэв ойлгохгүй бол ярьж чадахгүй.

Ер нь гэмшин наманчлах, мөргөх, уул, усыг тахин шүтэх, ном хаялцахад оролцох, амьсгалаа ажиглах гэх мэт нь бүгд материаллаг, гадна талын зүйлс бөгөөд хэлбэр дүрсгүй, нарийн үйл түйтгэрийг угааж чадахгүй. Гадна талын зүйлс дотоодын юмсыг яаж ариусган угааж чадах вэ? Жишээлбэл, миний ходоод сайн биш, дотооддоо гэм урхагтай бол би ходоодоо эмнэн засъя гэвэл дотроос нь засаж, эм ууж, гэм архагийг нь арилгах хэрэгтэй, эсвэл мэс засал хийлгэж, эмчээр гэдэс дотроо сайхан эмчлүүлэх хэрэгтэй, харин гэдсээ гаднаас нь усаар угааж болохгүй, тэгвэл яасан ч сайн болж чадахгүй. Урьд нь Цао цао тархины өвчтэй байжээ, тэгээд Хуа Төү-гээс: “Миний өвчнийг засаж чадах арга байна уу?” гэж асуужээ, тэрээр бараг тархины хорт хавдартай байсан бололтой. “Тархинд тань хагалгаа хийж, дотроос нь эмчлэх хэрэгтэй” гэж Хуа Тоү хэлсэнд Цао Цао итгэсэнгүй, гадна нь эм түрхсээр сайн болчихно гэж бодсон байна. Гадна талд нь түрхэх болон дотор талд нь түрхэх хоёр ондоо, тийм биз?

Жишээлбэл, гашуун өргөст хэмхийн гаднах хальсыг нь ямар ч усаар угаасан, эсвэл гаднах хальсыг нь элсэн чихэр, зөгийн балыг хэдэн хоног түрхлээ ч доторх нь чихэрлэг амттай болох уу? Болохгүй, учир нь доторх нь гашуун, доторх бүх эд эс нь гашуун тул гаднах хальсыг нь усаар угаахад гашуун амт нь арилах боломжгүй, эсвэл хальсанд нь зөгийн бал түрхвэл чихэрлэг амттай болчихгүй. Гашуун өргөст хэмхийг чихэрлэг амттай болгохгүй. Гашуун өргөст хэмхийг чихэрлэг амттай болгохын тулд чихэртэй усанд хэдэн хоногоор дэвтээж, чихэрлэг ус дотор нь нэвчсэний дараа нилээд удтал чихэрт хуурвал бүх зүйл нь чихэрлэг амттай болдог, тэр ч байтугай исгэлэн нимбэг ч чихэрлэг амттай болно, гаа ч бас чихэрлэг болдог. Ингэвэл илүү амтлаг болно.

Үүнтэй адилаар, хэрэв бид үйл түйтгэрээ угаан цэвэрлээ гэвэл дотоод хэлбэлзлээрээ дотоод дахь харанхуй газраа цэвэрлэх хэрэгтэй. Бидний үйл түйтгэр арьсны гадна талд байхгүй, бие махбодод ч байхгүй, иймээс усаар угаагаад нэмэргүй. Энэтхэгт жил бүр, ялангуяа зуны улиралд маш олон хүн Ганга мөрөнд очин биеэ угаадаг, тэд ингэснээр үйл түйтгэрээ угааж чадна гэж боддог байна. Католик шашинтнууд ч бас усан баталгаа хийж, усан баптизмын адис хүртээдэг, тэгдэг биз дээ? Гэвч энэ нь ямар ч ач тусгүй.

Хэрвээ нэгэн их хүчтэй Их Багш бол заавал бие дээр чинь ус цацдаг биш, Тэр танд гараараа хүрсэн л бол үйл түйтгэр тань арилж, таныг хармагц бас үйл түйтгэрийг тань цэвэрлэж чаддаг, заавал ус хэрэглэх шаардлагагүй. Гэтэл зарим улс оронд ус хэрэглэж заншсан болохоор энэ уламжлалаа үргэлжлүүлсээр байдаг. Библи сударт Иохан: “Мэдээж би усаар баптизм хүртээдэг, гэвч надаас бүр ч их хүчтэй хүн ус ашиглах шаардлагагүй, харин Ариун Сүнсээр баптизм хүртээнэ, галаар баптизм хүртээнэ.” гэж хэлснийг тэмдэглэжээ. Гал гэдэг нь Гэрэлийг хэлж буй, харин галаар хүмүүсийг шатаах биш юм, гэтэл хожмын хүмүүс үүнийг ойлгодоггүй. Заримдаа бид гал дээгүүр харайж буй хүнийг хараад ингэх нь үйл түйтгэрийг цэвэрлэж чадна гэж боддог. Зарим сүм бас гаднаа савтай ус тавьдаг бөгөөд орж ирсэн мөргөлчин хүмүүс өөрсдийгөө ёс төдий угаадаг. Бидний үйл түйтгэрийг угаан цэвэрлэж чаддаг зүйл нь ус биш гэдгийг тэд мэддэггүй. Рашаан ус гэгч бол нэг зүйлийн үзэгдэж харагддаггүй ус мөн, зөвхөн ийм хэлбэр дүрсгүй усаар л бидний хэлбэр дүрсгүй үйл түйтгэрийг угааж чадна.

Та нар үйл түйтгэрийг ямар байдгийг харж байсан уу? (*Хүмүүс, Хараагүй гэж хариулав.*) Гэтэл хүмүүс бүгд үйл түйтгэрийн тухай мэддэг, наад зах нь ядаж л шашинд итгэдэг хүмүүс мэднэ, аль ч шашин биднийг үйл түйтгэртэй гэж хэлдэг, Католик шашин, Бурханы шашин, Исламын шашин аль нь ч бай бүгд л адилхан зүйлийг хэлдэг.

Үйл түйтгэр гэгч чухам юу вэ гэвэл хүн бүрийн дотоод даь гэм буруугийн сэтгэлгээ, нэг зүйлийн үзэгдэж харагддаггүй хүч юм. Үйл түйтгэр биднийг өдөр бүр дарж байгаа юм шиг санагддаг, заримдаа энэ нь маш хүчтэй, заримдаа арай хөнгөн байдаг. Хүн бүхэн үүнийг мэдэрч чадна, энэ нь өдөр бүр тохиолддог, үгүй гэж үү? Үйл түйтгэр үл үзэгдэх боловч бид сэрж мэдэрч чаддаг юм чинь Бурханы хүчийг, Их Багшийн хүчийг яажшуухан мэдэрдэг бол? Бид үүнийг бүр ч илүү сэрж мэдрэх ёстой. Та нарын хэн нэгэн үүнийг сэрж мэдэрсэн үү? (*Мэдэрсэн гэж нэг хүн хариулав.*)

Үйл түйтгэр нэгэнт байдаг болохоор цэвэрлэх арга заавал байх ёстой. Өвчин байвал эм байдаг, иймээс хэрэв үйл түйтгэр байвал ариусган цэвэрлэх арга ч байдаг. Гэхдээ буян хишгээр үйл түйтгэрийг угааж чадахгүй, гагцхүү ач буянаар л угааж чадна. Буян хишиг бол хүн, тэнгэрийн буянд л хамаарна, өөрөөр хэлбэл дараа төрөлдөө дахин буцаж ирээд ертөнцийн жаргалыг эдэлж чадна, үлэмж их мөнгө, алдар нэр, аз завшаан, эд хөрөнгө

бүхэнтэй байж, олон хүнд хүндлэгдэнэ гэх зэрэг. Энэ бол буян хишиг. Ач буян (хятадаар “гүн дэ” (“merit”) гэх бөгөөд “гүн” гэдэг нь чармайхыг хэлдэг, “дэ” гэдэг нь буян гэсэн үг)-ыг зөвхөн сүнслэг бясалгал дадуулснаар л олж авч чаддаг. Зөвхөн шаргуу бясалгалаар л жинхэнэ (“ач буян”) -ыг олж чадна.

(Ач буян) гэдэг бол жам ёсны “Мөр ёс”, эсвэл “Уг дүр” гэсэн утгатай. Энэхүү “ач буян”-ыг энгийн үгээр ярьж илтгэж чадахгүй, “Нэрийг нэрлэж болох болбоос мөнхийн нэр бус”, “Мөр ёсыг ярьж болох аваас мөнхийн Мөр ёс бус” гэдгийн утгатай адилхан. Иймээс бид “ёс суртахуун” (хятадаар “Дао дэ” (“morality”) гэх бөгөөд “Дао” гэдэг нь Мөр ёсыг хэлдэг, “дэ” гэдэг нь буян гэсэн үг) гэж ярих үедээ энэ хоёр үгийг нийлүүлж хэлдэг бөгөөд эдгээр нь нэг л зүйлийг заадаг, учир нь бид анх хаанаас ирсэн тэр “Уг дүр”-ээ чухалчлахыг хүсдэг юм. Энэ бол жинхэнэ “ач буян” бөгөөд үүнийг хичээл зүтгэлээр л олох ёстой. Харин эд зүйлээр, эсвэл алт мөнгөөр худалдан авах боломжгүй. Өглөг өгөх нь тун сайн, Гурван Эрдэнэд өргөл тахил өргөх нь ч бас сайн, аль аль нь буян хишигтэй, гэвч үүнд ач буян байхгүй. Ач буяныг шаргуу хичээл зүтгэлээр л олж авах ёстой бөгөөд ач буян болон буян хишиг хоёр нь өөр.

Иймээс бид гэрээс гарагчдыг хамаг төрөлтний буян хишгийн тариа гэдэг, харин ач буяны тариа гэж хэлдэггүй. Ач буяны тариа нь бидэнд байна, бид өөрсдөө газар хагалж, өөрсдөө тарьж байж л сая өөрсдийн ач буянаа олж чадна, буян хишгийн тариа бол бусдынх, бид түүнийг зээлж болно, гэхдээ тэгж болох ч тэр нь хязгаартай. Хэрвээ бид өөрсдийн тариагаа өөрөө таривал бусдад ямар ч өргүй байх болно.

Гурван Эрдэнийг тахиx нь буян хишигтэй, гэтэл Шагжамуни Бурхан Гурван Эрдэнийг тахивал нэгэн бурхан болж чадна гэж хэлээгүй бөгөөд өглөг үйлдэж, сахил сахивал бурхан болж чадна гэж ч яриагүй, хэрвээ сахил сахиснаар л нэгэн бурхан болчихдог бол Шагжамуни Буддагийн шавь нар бясалгаж суух шаардлагагүй, даяан агуулах шаардлагагүй байсан. Түүний гэрээс гараагүй шавь нар нь хэрэв сахилаа тийм ч тодорхой сахиж чаддаггүй бол хэрхэн туулан гэтэлж чадах вэ? Шагжамуни Будда гэрээс гараагүй байх үед хоёр зуун тавин сахил гэж байгаагүй, тиймээс Тэр яаж бурхан болж чадах вэ? Сахил бол хожим нь л бий болсон, та нар хэрвээ сахил хүртвэл зарим сахилыг тодорхой нэгэн нөхцөл байдлын төлөө л тогтоосон гэдгийг мэдэх болно.

Үнэндээ гэрээс гарагчдын сахилуудыг бүлэгт зориулан бий

болгожээ. Бид нэгэн бүлэгт амьдрахад бүлгийн дүрэмтэй байх хэрэгтэй, жишээлбэл, армид цэргийн дүрэм байдаг, тэд сахил гэж ярьдаггүй. Дүрмийн тухайд гэвэл энэ нь үнэндээ сахилтай яг адилхан. Гэрээс гарагч болон гэрээс гараагүй хүмүүс бүгд л таван сахил гэх мэт дүрэмтэй байдаг. Хэрвээ таван сахил байгаагүй бол манай нийгэм эмх замбараагүй болно, хүмүүс харилцан хядалцаж, ямар ч дүрэм журам байхгүй, хүссэн хүнээ хөнөөж, хүссэнээрээ бусдын эхнэрийг булаана, хүслээрээ бусдын эр нөхөртэй караоке-д очно. Энэ нь нэн эмх замбараагүй явдал биш гэж үү? Ийм ертөнц амар тайван байж чадахгүй, хүмүүс харилцан нэгнээ үзэн ядаж, харилцан атаархаж, харилцан дайтаж, харилцан хядалцах болно. Хэрэв таван сахилгүй бол та нар дураар хулгайлна, дээрэмдэнэ, ажил хийхгүй, баян тансаг айл гэрийг хармагц шууд очоод булаан дээрэмдэх болно.

Урьдын Яао, Шүнгийн цаг үед сахил санваар гэж байгаагүй бөгөөд зам дээр гээгдсэн зүйлсийг ч авдаг хүн байгаагүй, тийм биз? Тэр үед таван сахил, эсвэл арван сахил, эсвэл ямар ч сахил гэж байгаагүй, ерөөсөө байх ч шаардлагагүй байсан. Хожим нь хүмүүс улам улмаар муу санаа үүсгэж, юм хулгайлах болов, гаднаас олсноо авахаар барахгүй, бусдын гэрт орж хулгайлж, дээрэмдэх болсон, тиймээс сая хууль цааз тогтоож эхэлсэн бөгөөд тэр хууль цааз нь хожим сахил санваар болж хувирсан байна.

Формосад нэг эрэгтэй нэг л эхнэр авдаг хуультай, нэг эрэгтэй хоёр эхнэр авах буюу хоёр эрэгтэй нэг эхнэртэй байж болохгүй. Багш нь: “Зүгээр ээ, энэ бол өчүүхэн явдал, бүгд Гурван ертөнцийн доторх хэрэг, бидний Арьяабалын бясалгалтан бол Гурван ертөнцөөс хэтийдсэн болохоор хамаарах хэрэггүй, та нар олон эхнэр авч болно.” гэж ярьж болохгүй. Багш нь ингэж яривал хоёрхон хоног ном дэлгэрүүлээд дараа нь засгийн газарт хөөгдөж, өөр газар жишээлбэл, Төвөд, эсвэл хань ижлийн харилцаа нилээд чөлөөтэй улсад хүргэгдэж тун ч магад.

Төвөдөд нэг эмэгтэй ямар ч асуудалгүйгээр олон нөхөртэй байж болно, тэдний хувьд энэ нь тун энгийн явдал. Төвөд яагаад тийм заншилтай байдгийг би мэдэхгүй, магадгүй эрэгтэйчүүд дэндүү олон, эмэгтэйчүүд дэндүү цөөн байдаг, эсвэл энэ нь мөнгөө хэмнэхийн төлөө ч байж мэднэ, учир нь гэрлэх ёслол хийхэд маш их мөнгө шаардагддаг. Энэ нь мөн хамт амьдрахад хүн бүрт нилээд дөхөм байдгаас ч болсон байж магад, хэрвээ эрэгтэй хүн бүр зөвхөн ганцхан эхнэртэй гэрлэвэл тун олон байшин шаардлагатай болно, тэнд мод маш ховор, учир нь Хималай уул бүтэн жилийн

турш мөс цасанд хучигддаг бөгөөд тэндхийн уул маш өндөр, уур амьсгал нь тун хүйтэн болохоор мод ургахад амаргүй.

Төвөдөд нэг гэр бүлд олон ах, дүү хамт амьдарч, бүгдээрээ ганцхан эмэгтэйтэй гэрлэдэг, гэвч харилцан тэмцэл болдоггүй, тэд дасчихсан, энэ бол тэдний заншил. Зарим нь дургүй бол бас өөрөө өөр эхнэр эрж болно, тэгэхэд бусад ах дүүс нь эсэргүүцдэггүй. Гэтэл зарим гэр бүлийнхэн хүчээр бүх ах дүүсийг ганцхан эмэгтэйтэй гэрлүүлдэг, ингэвэл хамтдаа тариалангаа арчлан тордож болно, хүн бүр нэг эхнэр авбал хожим эхнэр нь нөхрөө аваад явчихвал тариалан эрхлэх хүнгүй болохоос тэд санаа зовдог. Төвөдөд хөдөлмөрийн хүч нилээд үнэтэй, газар тариалан эрхлэхэд дутагддаг тул иймэрхүү уламжлал бий болсон ч байж магад.

Багш нь хэрвээ тэнд ном дэлгэрүүлэх гэж очвол ийм явдлыг хамаарч болохгүй, эс бөгөөс ном дэлгэрүүлж чадахгүй. Би тэдэнд: “Та нар ингэж болохгүй.” гэж болохгүй, учир нь тэд төрөл төрөлдөө ийм байсан, би тэдний уламжлалыг өөрчлөх хэрэг юун? Багш нь ном дэлгэрүүлэх нь хүмүүсийн сүнсийг аврахын төлөө болохоос биш, харин тэдний уламжлалыг нь өөрчлөх явдал биш, ойлгож байна уу? Тэд баяртай л байвал болох нь тэр. Хэрвээ тэд хардаж атаархаж, маргалдаж хэрэлдэж эхэлбэл асуудал байгаа хэрэг, тэгвэл л сая тэдэнд: “Та нар битгий ингэ, хурдан салж холд, бүү маргалд.” гэж хэлж болно. Хэрвээ эв найртай амьдарч, хоорондоо ямар ч асуудал байхгүй бол бид асуудал эрэх хэрэг юу билээ?

Иймээс сайн, муу, эсвэл сахил санваар нь бүгд л тухайн улс орны зан заншилтай холбоотой байдаг. Бид өөрсдийн бясалгал дадалдаа илүү алсын хараатай байж, сайн, муугийн дэсийг давчихвал сая амар тайван байж чадна. Бусдын муу үйлийг хараад өдөржин бусдыг шүүмжлэх хэрэггүй. Тэр эмэгтэй урьд төрөлдөө Төвөдөд төрсөн байж магадгүй, түүний тэр олон эр нөхөр нь энэ төрөлд нь ирсэн байна, тэгээд тэд энэ төрөлдөө урьд төрлийнхөө нөлөөг хүртэж, өнгөрсөн үеийнх нь дадал зуршил нь мөн л хэвээр байсаар, энэ дадал зуршил нь тэр эмэгтэйд ийм зүйл хийхэд хүргэсэн тул үүнийг “үйл түйтгэр” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь өнгөрсөн төрөлдөө шингээсэн сэтгэгдэл, дадал нь одоо илрэн гарч байгаа хэрэг юм.

Сахил санваар нь бидний бясалгал дадалд туслан бидэнд нийгэмтэй амар амгалан хамтран оршин байх боломж олгодог. Жишээлбэл, Формосад нэг эрэгтэй нэг л эхнэр авч болох

хуультай, тэгвэл бид бясалгахдаа: “Хууль цааз надад хамаагүй, би бол чанагуух ертөнцийнх болохоор хорин эхнэр авч болно.” гэж ярьж болохгүй. Ганцхан эхнэртэй ч яриг төвөг тийм их байхад, хорин эхнэр аваад яаж амьдарч чадах вэ? Тийм биш үү? Дахиад хэлбэл өөр хүн бас танд яриг удна, тэд: “Та яагаад ингэдэг юм? Бидэнтэй ер адилгүй.” гэхчлэн ярина. Үүнээс гадна эхнэрийн тань төрөл садан нь ч танд төвөг удна, эхнэртэйгээ хамт байх нь ч бас танд яригтай.

Хэрвээ бид олон түмэнтэй адилгүй бол өөртөө яриг төвөг удна, иймээс нөхцөл байдал ямар байсан ч бид ингэж болохгүй. Нийгэмтэй зохицохгүй бол тун олон яриг тохиолдон өдөржин бусдын дайралттай учирч, хачин амьтан шиг харагддаг. Жишээлбэл, Төвөдөд зарим гэрийн ах, дүү тавуулаа нэгл хүүхэнтэй гэрлэдэг, тэр хүүхэн нь дүрслэхийн аргагүй царай муутай байдаг. Төвөдөд тогооны ёроолын хар хөөг хонины өөх тостой холиод царайндаа түрхэн хар хүүхэн болдог, тэд гялтганасан харыг л гоё гэж үздэг аж. Та нар элдэв өнгөөр гоёдог байхад тэд хар, тослог өнгөөр гоёдог (*Бүгд инээлдэв.*) Төвөд бүсгүйчүүд бүгд хар өнгөөр гоёдоггүй боловч ихэнх тариачин бүсгүй хар тос түрхдэг.

Хэрвээ нэг нөхөр нь өөр оронд хүрч, сайхан хүүхнийг харвал эхнэрийнхээ царай муутайг мэдэж, хамт амьдрах хүсэлгүй болох бөгөөд нүүрэндээ хар тос түрхээгүй өөр нэгэн залуухан, гоё эхнэр эрнэ. Гэвч ингэвэл гэр бүлийнхнийхээ эсэргүүцэлтэй тулгарч, төрөл садан, найз нөхөд нь төвөг учруулдаг, тэгээд дахин тэндээ амьдрахын аргагүй болж, өөр газар шилжин нүүж, өөрөө өөрийнхөөрөө амьдрах хэрэгтэй болно. Уг нь тэр нэг хэсэг тариалангийн талбай, нэг байшин, нэг хэсэг эд хөрөнгө өвлөн залгамжлах байсан, гэтэл уламжлалт ёсыг зөрчсөн хэрэг хийсэн болохоор аав, ээж нь гадуурхан сохор зоос ч өгдөггүй, тиймээс тэр хүн эхнэрээ дагуулан өөрөө амьдралаа залгуулдаг. Бид зан заншил, нийгмийн уламжлалыг дагахгүй бол тэр нь бидэнд маш их төвөг учруулна гэдэг нь ийм утгатай.

Иймээс Багш нь бас шавь нараа явуулж, сахил хүртүүлдэг. Сахил хүртэх нь тун сайн, тэндхийн ёс тун хатуу, тэндэхтэй харьцуулсан хойноо тэд Багшийнх нь энд илүү сайн, тийм ч хатуу бишийг ойлгодог. Тэгэхгүй бол тэд тун эмзэг, жаахан загнамагц зугатчихна. Сахил хүртэх нь ач тустай, гэтэл зарим хүн сахил хүртэх дургүй, “Сахил хүртээд яах вэ? Бясалгал хийвэл болчихно, яах гэж заавал гэлэн болох юм?” гэж ярина.

Жишээлбэл, бид өдөр бүр эндээ бясалгадаг, муу хэрэг

үйлдэхгүй, ажлаа дуусгамагц бясалгаж сууна, ихээхэн бясалгадаг бол сахил хүртэхгүй байж ч болно, учир нь сахил зөрчихгүй тул ямар сахил гэж хүртэх вэ? Сахил зөрчвөл сая сахил хүртэх хэрэгтэй, гэрээс гарагчид ямар ч муу хэрэг үйлдэхгүй, сахил зөрчих боломж ерөөс байхгүй бөгөөд гадуур гарч бусадтай хэл ам болдоггүй юм чинь ямар юмных нь хэлний нүгэл байх вэ? Ууланд амьдарч байхад эгдүүцмээр, эсвэл санаанд таалагдахгүй явдлыг олж харахгүй тул сэтгэлийн нүгэл яаж үйлдэх вэ? Өдөр бүр бясалгаж суун Аялгуу аждаг болохоор үйл түйтгэртэй ч бүгдийг нь ариусгадаг, ийм юм чинь сахил хүртэх, эсвэл хүртэхгүй нь адилхан, ойлгож байна уу?

Гэрээс гарах гэдэг нь юуг хэлдэг вэ гэвэл гэр бүлээсээ сална, хайр сэтгэлийн хүлээс, хүлэгдэж баригддаг нөхцөл байдлаас сална, тээр дараасгүй, эрх чөлөөтэй болно, мөн олон цагаар нэгэн амьд сэрүүн жинхэнэ Их Багштай хамт бясалгаж, Түүнийг даган Түүний үлгэр жишээ, билиг ухаан, сургаалаас нь суралцахыг хэлнэ. Учир нь Түүнтэй ойр байснаар их зүйлийг сурч, сайн хэлбэлзлэлийн нөлөөг нь нилээд түргэн хүртэж чадна. Иймээс тун олон хүн гэрээс гарч Шагжамуни Бурханыг дагаж явжээ. Зөвхөн гэрээс гарах нь хангалттай биш, харин амьд сэрүүн байгаа Төгс Гэгээрсэн Их Багшийг дагавал сая зөвдөнө, ойлгож байна уу?

Шагжамуни Будда амьд сэрүүн байхад бас өөр бусад гэрээс гарагч байсан хэдий ч тэд юу ч олоогүй, зарим гэрээс гарагч шууд л тамд унасан, тийм биз? “Бурханы нүдний өмнө тамд унагсдыг бурхан ч авардаггүй.” гэж судар номд бичсэн байдаг. Иймээс заавал бурхнаас суралцаж, бурханд итгэвэл сая төрөл дэвшиж чадна, харин гэрээс гарвал л төрөл дэвших биш. Багш нь саяхан машин жолоодох тухай ярьсан, бид маш сайн жолоодож, замын хөдөлгөөний дүрмийг баримталсан ч бусад хүн биднийг мөргөж мэднэ, учир нь тэдэнд архи уусан, машинаа сайн жолооддоггүй, бачимдан сандарсан, хурдтай давхисан, эсвэл өвдсөн, анхаарал болгоомжгүй байсан гэх зэрэг олон шалтгаан байж болно.

Үүнтэй адилаар энэ тоост хорвоод бид сахилаа тодорхой сахихын аргагүй, амьсгалмагц амь хороож, алхахдаа ч амь хороодог, усанд орохдоо саван хэрэглэх, эсвэл бие засах өрөөнд ариутгалын бодис тавихдаа бас амь хороодог, тийм биз дээ? Иймээс сахил зөрчихөөс зайлсхийх арга байхгүй. Хорин дөрвөн цагаар хөдлөхгүй суусан ч жинхэнээр сахил сахих боломжгүй, учир нь жижиг шавжнууд бидний биед наалдаж, эсвэл мөргөж үхдэг. Амьсгалахад ч маш олон хумхын амьтан үхдэг, тэр

байтугай амьсгалахгүй ч гэсэн гараараа дарвал, жишээлбэл, зүүт нэгэн газарт хатгавал тоо томшгүй амьтан алагддаг.

Тийм жаахан газарт тоо томшгүй амь оршиж байгаа юм чинь алхах, ус уух, юм ярих, амьсгалах, эргэн тойрондоо хөдөлж явах, хувцас өмсөх, хувцас угаах, усанд орох, сахлаа хусах, үс гээгээ угаах гэх мэт нь бүгд л амь хороох сахилыг зөрчиж байдаг хэрэг. Хамгийн эхний сахил “амь хороохгүй байх” сахилыг тодорхой сахиж чадахгүй байгаа юм чинь бусад сахилыг бүр ч ярих юм биш, тийм биш үү? Бясалгал хийхэд сахил зөрчих нөхцөл байдлаас бид зайлсхийх арга байхгүй, иймээс чанагуух ертөнцийн хүчинд найдах хэрэгтэй, эс бөгөөс сахил хүртэх нь сахил хүртээгүйтэй адил болно.

Жишээлбэл, тархины хорт хавдар, эсвэл нарийн гэдэсний хорт хавдартай хүнийг мэс засал хийж, дотроос нь засах хэрэгтэй, гэтэл өвдөж байгаа үед нь хэн нэг хүн түүнд аспирын уулгах, эсвэл морфин, үгүй бол өвчин намдаах тариа хийвэл дорхноо өвдөхөө болих боловч хорт хавдар нь хэвээрээ л байна, ойлгож байна уу? Тэр үед яагаад дорхноо өвдөхөө больдог вэ гэвэл мэдээ алдуулсан болохоор өвдөлтөө мэдрэхээ больжээ, гэтэл хорт хавдар нь хэвээрээ байгаа, энэ бол өвчний үндсийг таслах арга биш, зөвхөн өвдөлтийг түр зуур намдаах төдий зүйл.

Багш нь яагаад та нарыг Арьяабалын бясалгалын аргыг дадуулах хэрэгтэй гэж дахин дахин онцолдог вэ гэвэл зөвхөн хэлбэлзэл л бидний бүдүүн баараг хэлбэлзлийг сарниулж, биднийг үйл түйтгэрээ угаахад тусална. Арьяабалын бясалгалын аргыг уг нь хамгийн сүүлд заадаг, эхлээд Бурхадын нэрийг дурсан унших, эсвэл Таван Ариун Нэрийг унших, ямар нэгэн тарни уншиж, бодол санаагаа төвлөрүүлж, сүнсээ гаргаж дасгалжихад суралцах ёстой. Энэ бясалгалын аргыг сайн дадуулсны дараа л та нар Арьяабалын бясалгалын аргыг дадуулж болно.

Гэтэл манай систем бол нэг удаад бүхнийг зааж дуусгадаг, яагаад вэ гэвэл, хэрвээ энэ дотоодын Аялгууг уламжлахгүй, зөвхөн Бурхадын нэрийг унших, “Тэрэл” ажихад л дадуулвал сүнс гарах үед хамгаалах хэн ч байхгүй, Их Багшийн хамгаалах хүч ч байхгүй байх болно, ойлгож байна уу? Ойлгосон уу? Тиймээс Арьяабалын бясалгалын аргыг сургах хэрэгтэй байдаг.

“Баатараа явагч нэрт их хөлгөн судар”, “Олонх Бурхант Богдсын ном Цагаан лянхуа судар”-ыг хоёуланг нь хамгийн сүүлд тайлжээ. Энэ хоёр сударт “Арьяабалын бясалгалын арга”-ыг

ярьсан, тийм биз? Учир нь Шагжамуни Будда шавь нараа эхлээд сайн бясалгахад дадуулсны дараа сая Арьяабалын бясалгалын аргыг заажээ. Хэдийгээр Ананд Бурхан Багшийг удаан жилээр асран халамжилсан боловч тэр даруй Арьяабалын бясалгалын аргыг сурч чадаагүй байсан. Нэг өдөр тэрээр гадуур гараад Модэнжиа бүсгүйн шившлэгт увдислуулан сахилаа зөрчих шахав, тэгэхэд Шагжамуни Будда түүнийг авруулахаар Манзушри Бурханыг илгээсэн байна, тэгээд Анандыг буцаж ирснийх нь дараа түүнийг хамгаалах гэж Арьяабалын бясалгалын аргыг уламжилжээ. Ойлгож байна уу? Арьяабалын бясалгалын арга байхгүй бол Гурван ертөнцийг давах тухай ярих шаардлагагүй, энэ бол тоглоом хийж байгаа явдал.

Хэрэв бид Гурван ертөнцийг даван туулья гэвэл энэхүү Аялгуугүйгээр дээш гарч чадахгүй, эрхбиш энэ хүчинд түшиглэж байж л биднийг дээш татан гаргаж чадна. Жишээлбэл, та Формосагийн бүх газраар хүрч очиж байсан бол дугуйгаар ч Формосаг тойрон аялж болно, хаа ч хүрч очсон, хэдэн жилээр зугаалсан ч тун чөлөөтэй байж, хаа хүрье гэвэл хүрч чадна, гэвч хаа хүрсэн ч бүгд Формосагийн газар нутаг. Одоо та Америкт мөн л дугуйгаар хүрнэ гэвэл тэр чинь тоглоом хийж байгаа явдал болно. Хэрэв Америкт очихыг хүсэж байвал эхлээд онгоцонд суух хэрэгтэй, хуурай замаар хүрэх гэвэл өөр бусад тээврийн хэрэгслийг ашиглана, унадаг дугуйгаар тэнгэрт нисэх боломжгүй, эс тэгвэл хүн нь дугуйтайгаа хамт газарт унана.

Иймээс юуг ч бясалгахыг хүссэн, ямар нэг зүйл бэлтгэх хэрэгтэй, хэрэв Гурван ертөнцийг даван туулж, Гурван ертөнцийн чанадад нисэн хүрье гэвэл “Арьяабал”-ын онгоцыг ашиглах хэрэгтэй, “Арьяабал”-ын онгоц байхгүй бол хэн ч дээш гарч чадахгүй, яг л онгоцгүй бол хэн ч тэнгэрт нисэж чадахгүйтэй адил, ойлгож байна уу? Иймээс Арьяабалын бясалгалын арга бол хамгийн дээд нь бөгөөд үнэндээ хамгийн сүүлд заах ёстой байсан. Гэсэн хэдий ч Дээдийн Ном балрах цаг үед цаг хугацаа маш давчуу, амжихгүй болчих вий гэж айхдаа Багш нь та нарыг хамгаалалттай байлгахын тулд бүгдийг зааж өгдөг. Тэгэхгүй бол та нар эхлээд Бурханыг дурсахыг дадуулах ёстой бөгөөд сэтгэл огт самуурахгүй болсон хойноо л сая Арьяабалын бясалгалын аргыг дадуулж болдог юм, ойлгож байна уу?

Багшийгаа та нар харж чадахгүй байна гэж битгий бодоорой, та нарын сонсдог Аялгуу бол Багш нь мөн, хэлбэлзлэлийн хүч бол Багш нь мөн. Багш нь бол Гэрэл, хэлбэлзлийн хүч мөн, энэ бие

махбод биш. Багш нь бол өөр нэг зүйлийн хэлбэлзлийн хүч бөгөөд түүнийг бие махбодоор ороовол сая хүмүүст харагдаж чадна. Та нар өдөр бүр Багшийгаа хардаг, Гэрэл харахдаа Багшийгаа хардаг, Аялгуу сонсохдоо Багштайгаа хамт байдаг, ойлгож байна уу? Заримдаа та нар Аялгуу ажаагүй байсан ч гэсэн Аялгуу хэвээрээ байж байдаг, учир нь Багш нь тэнд байгаа бөгөөд хамгаалах хүч тэнд байна. Иймээс Арьяабалын аргаар бясалгахгүй байж болохгүй, Арьяабалын бясалгалын аргыг дадуулахгүй бол доош унаж, хэн ч та нарыг аварч чадахгүй. Яг л өвчтэй хүн шиг, хэрэв эм уухгүй бол мэдээж өвчин нь улам хүндэрч, хэзээ нэгэн өдөр нас нөгчих нь гарцаагүй, хэрэв хоол идэхгүй бол улам бүр өлсөж, нэг л өдөр өлбөрч үхэж мэднэ. Багш нь өдөр бүр Арьяабалын бясалгалын аргыг тайлж, та нарыг Арьяабалын бясалгалын аргыг дадуул гэдэг, та нар ч гэсэн ирж сонсдог, ингэх нь уйтгартай санагдахгүй юу?

Энэ нь өдөр бүр хоол идэхтэй л адил, өнөөдөр идвэл маргааш бас иднэ, тийм биз дээ? Иймээс хэр их завтай бол тэр хэрээр бясалгана, бясалгал дадуулах цаг зав байхгүй гэж шалтаг тоочиж болохгүй, хорин минут бясалгасан ч огт бясалгаагүй байснаас дээр, тийм биш гэж үү? Хэрэв үнэхээр завгүй байгаа бол хорин минут бясалгах хэрэгтэй. Хоолоо түргэн идэж, бага ярьж, утсаар бага ярих хэрэгтэй, үнэхээр бясалган суух газар олдохгүй бол бие засах өрөөнд ч бясалгаж болно, тэнд саад хийх хүн үгүй.

Асуулт: Авшигтан бус хүн бэлэг өгвөл бэлгийг нь авч болох уу?

Их Багш: Татгалзаж чадахаар бол татгалз, хэрэв татгалзаж чадахааргүй бол өөр зүйл худалдан авч өгөөрэй. Бусдын бэлгийг яасан ч авч болохгүй. Та нарын ач буян хангалттай байгаад авч зүрхэлбэл танд баяр хүргэе! Гэхдээ би авдаггүй, энэ нь та нарын нэмэгдэл үйл түйтгэрийн олз, иймээс авахгүй бол хамгийн сайн. Хэрвээ авшигтан өгвөл авч болно, учир нь гаднах ихэнх хүний үйл түйтгэр тун хүнд, Багшаар нь угаалгуулж цэвэрлүүлээгүй болохоор авч болохгүй. Хэрэв та авбал бясалгал дадалд тань саадтай болно. Та нар асуусан болохоор л Багш нь онцлон тайлбарлалаа, гаднах хүмүүст ярьж болохгүй, яривал биднийг гүтгэж байна гэж бодох болно, ойлгож байна уу?

Асуулт: Шагжамуни Буддагаас суралцдаг байсан гэрээс гарагчид яагаад юуг ч авч болдог байсан бэ?

Их Багш: Юуг ч авдаг байсан юм биш, тэд өдөрт нэг удаа л

бадарлаж, жаахан хоол олж иддэг. Өмссөн хувцас нь ч бас урагдаж навтарсан бөгөөд сольж өмсөх гуравхан хувцастай, бүгдийг нь хүмүүсийн орхисон хувцаснаас түүж авдаг байсан. Жишээлбэл, нас барагсдын хувцсыг булшных нь хажууд орхидог, түүнийг нь түүж авчраад хэсгүүдийг нь дахин нийлүүлэн оёод өмсдөг, иймээс гэрээс гарагчдын орхимж тийм олон хэсэгтэй байдаг байжээ.

Гэтэл өнөөгийн гэрээс гарагчид шинэ бөс даавууг ашиглахдаа ч хэсэглэн хайчилсны дараа дахин зүйж оёдог нь төвөгтэй бөгөөд цаг их үрдэг, мөн үзэмжгүй харагддаг. Урьдны гэрээс гарагчид бусдын орхисон бөс даавууг түүгээд зүйж, нөхдөг байсан, тийм учраас будганд оруулдаг, учир нь олон өнгийн бөсийг зүйж оёсон болохоор өнгө зүс муутай харагдана, иймээс оёж дууссаны хойно шар өнгөөр, эсвэл өөр нэгэн жигд өнгөөр будах хэрэгтэй. Гэтэл өнөөдөр өөр болжээ, тэд шинэ бөс даавуу худалдан авч хайчлан жижигхэн хэсэг болгосны дараа дахин нийлүүлэн оёод өмсдөг.

Багшийнх нь одоо өмсөж байгаа энэ хувцас тун гоё харагддаг. Гэтэл үнэндээ нэг ярд (1ярд = 0,914 м) нь арван долоон юанийн л үнэтэй. Ийм хамгийн хямд бөсийг бас эсгэж, эвлүүлж оёод нэг хувцас болгож болно. Гэтэл зарим хүн маш үнэтэй хувцас өмсдөг, тэд маш үнэтэй бөс даавуу худалдан аваад харьсны хойно жижиг жижиг хэсэг болгон хайчилдаг нь маш үрэлгэн хэрэг, энэ бүхэн нь уламжлалаас болж байгаа юм. Одоогийн гэрээс гарагчид хувцсаа будсан эсэх нь хамаагүй, нэг хувцас нь хоёр, гурван өнгөтэй байдаг эртний Энэтхэгийн гэрээс гаргачдынхаас ялгаатай нь тэдний хувцас бүгд шив шинэ, иймээс одоогийн гэрээс гарсан хуврагуудын хувцсыг будганд оруулах шаардлагагүй. Урьдын энэтхэгчүүдийн талаас илүү хувь нь цагаан өнгийн хувцас өмсдөг байв, одоо ч ийм. Хувцас нь элэгдээд хаяж орхих үед мөн л цагаан өнгөтэй хэвээр байдаг ч өөр өнгөтэй холилдоод саарал, хар, шар гэхчлэн өнгө зүс муутай болдог, үүнийг гэрээс гарагчид оршуулгын газраас түүж авчирсны дараа улам сүр жавхлантай харагдуулахын тулд нэг ижил өнгөөр буддаг, ийм л юм, үүнд онцгой зүйл байхгүй, ойлгож байна уу?

Хэдийгээр сахилд хувцсаа будах хэрэгтэй гэж дурдсан байдаг боловч энэ сахилын ач холбогдол бага. Хэрэв хувцсаа будахгүй бол бясалгаж чадахгүй гэдэг нь утгагүй хэрэг. Шагжамуни Бурхан ийм санаагаар яриагүй, Тэрээр гол нь гэрээс гарагчдыг сүр жавхлантай хувцаслаж байгаасай гэж хүсэж байсан. Тэдний хувцас урагдаж навтарсан нь хамаагүй, сүр жавхлантай байх хэрэгтэй, гэхдээ дэндүү олон өнгийн байж болохгүй, тэгвэл

хачин жигтэй харагдана гэсэн санаа юм. Жишээлбэл, Багшийнх нь орхимж олон өнгийн бөс даавуугаар оёсон, энэ хэсэг нь улаан, тэр хэсэг нь ногоон, энд шар, тэнд хар гэхчлэн өнгөтэй байвал солирсон хүн шиг харагдахгүй юу? Тиймээс олон өнгийн хуучин бөс даавуугаар оёсон байлаа ч будаг оруулж, нэгэн жигд өнгөтэй болгох хэрэгтэй.

Иймээс сахил болгон бүгд чухал гэсэн үг биш, харин таван сахил нь хамгийн чухал, бид таван сахилыг л сахивал болчихно. Багшийнхаа бясалгалын аргыг гэрээс гараагүй хүмүүс ч, гэрээс гарагчид ч бясалгаж болно, бясалгах цагтай л бол болчихно, заавал үсээ хусах шаардлагагүй, мэдээж үсээ хусуулбал заавал Багштайгаа хамт амьдрах хэрэгтэй. Зарим хүн Багшаасаа салахыг хүсдэггүй, Багшийгаа ганцхан удаа харсны дараа салахаа больчихдог, бүр нэг алхам ч холдохыг хүсдэггүй, явах болбол тэд зогсолтгүй ихэд уйлдаг. Энд суугаа хүмүүсийн дунд уйланхай ноён, уйланхай авхай, уйланхай бүсгүй байна. (*Бүгд инээлдэв.*)

Энэ нь формосачууд хайрын сэтгэлээр нэн гүн байдгаас болсон биш, зарим хүн миний шавь нарын уйлах болон Багшийгаа тэгж ихээр хайрлахыг хараад формосачууд гадаадын хүнийг нилээд хүндэтгэдэг гэж боддог, тийм биш. Үнэндээ би бас гадаадын хүн биш, намайг харахад та нартай адил харагддаг уу? Ау лакчууд зүс царайгаар хятадуудтай тун төстэй санагдахгүй юу? Хэрвээ би үг ярихгүй бол намайг ау лак хүн гэж хэн ч мэдэхгүй, тийм үү? Иймээс тэд намайг гадаад хүн болохоор л уйлдаг биш, харин Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүмүүст нэгэн сэтгэгдэшгүй хайрын хүч байдаг. Бясалгал дээшлэх тусам хайрын хүч төдий чинээ их байна, хүмүүс хармагцаа дуртай болж, шүүмжилдэг хүн ч дуртай, гүтгэдэг хүмүүст ч мөн таалагддаг, гэвч тэд үүнийгээ илэрхийлж чаддаггүй бөгөөд яагаад дуртай байдгаа мэддэггүй.

Нэг хүний эхнэр Багшийг нь дэндүү их хайрласнаас болж нөхөр нь гадуур намайг сүрхий гүтгэсэн, тэр хүн уг нь надаас хэрэг нэхэхээр ирсэн ч Багшийг нь хармагц юу ч ярьж чадаагүй, дахин гүтгэж зүрхлэхгүй болж, Багшийнх нь хайранд хайлчихсан бололтой. Багш нь ямар нэгэн аргаар түүнийг эзэмдсэн биш, ид шидийг ч огт ашиглаагүй. Багшид нь ид шидийн хүчийг ашиглах шаардлага байхгүй. Ид шидийг ашиглах нь та бие махбоддоо хүлэгдэж байгаагаас болдог, бусдад туслахын аргагүй, нөхцөл байдлыг шийдвэрлэж чаддаггүй болохоороо л ид шидийг ашигладаг. Хэрвээ та хаа сайгүй оршиж чаддаг бол ид шид хэрэглэх

шаардлага байна уу? Ойлгож байна уу? Өвчнийг “үндэс”-нээс нь засах хэрэгтэй, харин ид шидийн хүчийг ашиглаж болохгүй.

Ид шид нь доод дэсийнх бөгөөд Гурван ертөнцөд хүлэгддэг хүмүүс л ид шид ашигладаг, Гурван ертөнцийн гаднах хүмүүс ашиглах шаардлагагүй. Түүнд бие махбод байвч жинхэнэ хүн нь энэ махан бие цогцсонд нь оршдоггүй, тиймээс хаа сайгүй оршдог. Тэрээр ямарваа орон, ямарваа юмыг бүгдийг харж чадна, яг л сансраас зураг авч байгаа хүн дэлхийг бүхэлд нь харж чаддаг шиг.

Хэдийгээр АНУ гэрэл зураг авахын тулд хиймэл дагуул хөөргөдөг боловч хиймэл дагуул тийм олон, тийм нарийн тодорхой зураг авч чаддаггүй. Гэхдээ та нар мэдэх үү?, “Түүнчлэн ирэгч”-ийн авсан гэрэл зураг хамгаас тодорхой, “Бурхан”-ы авсан гэрэл зураг бол хамгийн тод бөгөөд Тэр ямар ч газрын зургийг бүгдийг авч чаддаг. Иймээс (Хотол зохилдогч) гэдэг нь түгээмэл, нийтлэг гэсэн утгатай, хаа ч гэсэн хаалга байдаг бөгөөд бүгд л бясалгалын арга болно. Арьяабалын бясалгалын арга бол Хотол зохилдогч мөн. “Хотол зохилдогч зүйл”, “Арьяабалын зүйл”, “Арьяабалын бясалгалын арга” болон “Түгээмэл, нийтлэг бясалгалын арга” гэдэг нь бүгд адилхан утгатай. Сонсогчдын танин мэдэхүйн ойлголтын түвшин адилгүй байдаг болохоор заримдаа Багш нь бас өөрөөр ярьж, өөр өөр нэр хэрэглэдэг. Шагжамуни Бурхан болон бусад Төгс Гэгээрсэн Их Багш нарын хувьд ч мөн ийм байдаг, учир нь хамаг төрөлтний танин мэдэхүйн ойлголтын түвшин өөр өөр болохоор ярьдаг зүйлс нь ч адилгүй.

Асуулт: Бясалгагч хүн ой мод, өвс ургамлыг дураар огтолж болдог уу?

Их Багш: Мэдээж дураар огтолж болохгүй. Бидний хайр амьтад болон ургамал модыг ч гэрэлтүүлэх ёстой, тэд бүгд амьтай. Хүнсний ногоо идэх нь бид энэрэнгүй гэдгийг илэрхийлэхгүй, хэрвээ бид үнэхээр энэрэнгүй сэтгэлтэй байсан бол юу ч идэхгүй, гэхдээ та нар өлсөж үхэж болохгүй шүү! (*Инээлдэв.*) Учир нь энэхүү бие махбодыг хамгаалахын тулд жаахан хүнсний ногоо идэх хэрэгтэй байдаг. Заримдаа хүнсний ногоог ч идэж төвдөхгүй болдог, би нэг хэсэг хугацаанд тэр ч байтугай хүнсний ногоо ч идэж зүрхлэхгүй болж, идэхдээ уйлдаг байсан, одоо дасчихсан шиг байна, сэтгэл тийм ч эмзэг биш болжээ.

Та нар хоол идэхдээ юу ч бодох хэрэггүй, эхлээд арван зүг, гурван цагийн бурхад, богд гэгээнтэн, их бодьсадва, Төгс

Гэгээрсэн Их Багшид өргөснийхөө хойно л сая идээрэй. Гэрээс гарагчид жаахан аваад гаднах хамаг төрөлтөнд өргөж болно, бид “бодол”-оороо өргөдөг тул шоргоолж, чийгийн улаан хорхой зэрэг амьтан ирж иднэ, ингэх нь тэдэнд ач тустай, дараа нь бид идэж болно. Зөвхөн гэрээс гарагчид ч гэлтгүй гэрээс гараагүй хүмүүс ч адил, бурханд өргөл өргөхгүйгээр идэх нь ад чөтгөрийн хоолыг идэж байгаа хэрэг болно, бид бурхан, богд гэгээнтнүүдэд дээжээ өргөвөл богдын хоол, бурхны хоолыг идэх болно. Эзэн Бурханд өргөсөн ч бас болно, Заавал “Бурхан” гэх үгэнд баригдах албагүй, христийн шашинтнууд Эзэн Бурханд дээжилж болно.

Бид ч гэсэн мод огтолж болохгүй, хэрвээ мод тайрахаас зайлж чадахгүй бол бас аргагүй. Мэдээж бид муу санаанаас тайрсан биш, жишээлбэл, байшин барихад мод огтлох хэрэг гардаг, тэр нь аргагүй байдлаас болсон хэрэг, гэхдээ тэгэх шаардлагагүй бол барихгүй бол хамгийн сайн. *(Ад модон дээр амьдардаг уу?)* Ад хаа сайгүй байж болно, харин модыг огтолвол л явчихдаг биш, иймээс байгалийг сүйтгэж болохгүй. Одоо Формосад цаг агаар тун их өөрчлөгдсөн нь ой модыг дэндүү ихээр огтолсноос болжээ. Бидний амьдардаг газар уг нь салхигүй байсан, гэтэл бусад хүн уулын ойр хавийн модыг бүгдийг огтолсноос гаднах юмс салхинд үлээгдэн эвдэрч, модод ч хар салхинд цохигдон унасан. Урьд нь эндхийн модод маш өндөр, бүдүүн байсан тул салхигүй байжээ, учир нь модод халхавч болдог байв, харин одоо уулс бүгд нүцгэрчээ. Уулан дахь ажилчид ой модыг огтолмогц тэр дорхноо салхи шуурч эхэлсэн, бидний олон юм салхинд үлээгдэн хийсэж, модод унасан, байшин ч бас эвдэрсэн.

Зөвхөн энэрэнгүй сэтгэлийн үүднээс мод огтолдоггүй юм биш, хэрвээ дур зоргоороо огтолвол өөрсдийгөө хорлож байгаа хэрэг. Үйл үр маш түргэн илэрдгийг бид харж чадна, бид ой модыг тайрвал дараа нь хар салхи биднийг “тайрна”. Учир нь мод олон бол салхийг хаадаг, бороо их бол ой мод өндөр, бүдүүн, эгц, өтгөн саглагар ургадаг, тийм биш үү? Гэтэл мод огтолвол салхи салхилж, аль хэдийнээ бүдүүн болчихсон модыг ч хугалдаг, хэрвээ бороо орохгүй бол мод бүдүүрч чадахгүй, үүний үр нөлөө тийм хялбар биш, дараа нь мод улам давжаарах бөгөөд ургах боломжгүй болно, ийм замаар ой мод улам бүр цөөрнө. Зарим улс ой модоо хоосортол огтолсноос элсэн цөл болж хувирсан.

Би Грек улсад очоод тэндхийн уулс нь модгүй байхыг харсан. Урьд нь энд мод их байсан, харин одоо модоо огтлон усан онгоц барих, дайн байлдаан хийх, эсвэл байшин барих, үгүй бол

хоол хийхдээ түлээнд хэрэглэсний улмаас улам бүр цөөрсөн гэж тэд надад ярьж байсан. Модны өсөлт угаас маш удаан байдаг бөгөөд огтлох тусам улам цөөрнө, хожим зулзаган мод ч үгүй болно, зөвхөн зүлэг ногоо байлаа ч модгүй байх болно. Тэнд ус тун бага, бороо хур ч цөөн ордог нь маш харамсалтай.

Бурхан Багшийн ярьсан бүхэн бүгд ач тустай. Бид ой модыг дураар огтолдоггүй нь зөвхөн тэд амьтай байдгаас болсон биш, харин орчин тойрноо хамгаалахын төлөө юм. Формосачууд ой модоо дураар огтлохыг хараад би тун их зовнисон, гэвч Багшид нь ямар ч хүч байхгүй, би Формосагийн хүн биш, гадаадын хүн (*Бүгд инээлдэв.*) бөгөөд гэрээс гарагч, тиймээс бусдад хамаагүй юу ч хэлж чадахгүй, гэвч харахаар сэтгэл өвдөх юм. Та нар хэрвээ ой модыг дураар огтолж байхыг харвал тэднийг эх орноо хамгаалахыг ятгах хэрэгтэй, улс гэрээ хамгаалах хэрэгтэй, тэгэхгүй бол хожим ой модыг дэндүү ихээр огтолвол уул улам хувхайрна, тэгвэл асуудал үүснэ, Формосад галт уул их байна, хэрвээ ус дутвал дэндүү халуун болно.

Асуулт: Би хэрвээ ялаа, шумуул, жоом зэргийг устгах захирамж гаргавал үйл түйтгэртэй болох уу?

Их Багш: Ямар захирамж вэ? (Засгийн газрын захирамж). Хэрвээ та ямар нэг зүйл хийх ёстой байвал хийгээрэй!, учир нь хүний амь нас ямар ч амьтныхаас эрхэм. Мэдээжээр, ингэх нь бас үйл түйтгэртэй, гэвч энэ орчлон ертөнцийн хууль дүрэм ийм байдаг, том амьтад нь оршин тогтнохын тулд жижиг амьтдаа хөнөөдөг, гэвч энэ том амьтан үйл түйтгэрээ бас төлөх ёстой. Хэрэв та улс орноо хамгаалахын төлөө шумуул устгах захирамж гаргасан бол энэ нь засгийн газрын үүрэг болохоор үйл түйтгэр нь тийм их биш нь мэдээжийн хэрэг, гэхдээ тэр нь тун бага. Хэрэв та Арьяабалын бясалгалын аргыг илүүхэн дадуулж чадвал түүнийгээ арилгаж чадна. Хүний амь нас бусад ямар ч амь насаас илүү эрхэм, хэрвээ хүнийг хамгаалахын төлөө эрхбиш хийх хэрэгтэй бол тэгж болно. Жишээлбэл, тариачин тариа тарихдаа арвин ургац хураахын төлөө пестицид цацах хэрэгтэй болдог, хэдийгээр ингэх нь амь ихээр хороох боловч түүнд өөр арга байхгүй.

Асуулт: Хүний амийг хамгаалах хэрэгтэй гэж Багш та ярьсан, хэрвээ нас нөгчих шахаж байгаа хүн заавал амьтны гаралтай найрлагатай хятад эм тан уух хэрэгтэй бол сахил зөрчсөнд тооцогдох уу?

Их Багш: Тооцогдоно. Учир нь архи болон амьтны

гаралтай орц агуулаагүй, мөн хүний амь насыг ч аварч чадах хятадын уламжлалт эм тан маш олон байдаг, та тэднээс сонгож болно. Гэтэл тариачдын байдал үүнтэй адилгүй, тэдэнд өөр сонголт байхгүй, ойлгож байна уу? Хятадын эмийн төрөл зүйл олон, сонгож болно. Та нар архи, эсвэл амьтны гаралтай орц найрлагатай хятад эм тан уух ёсгүй, ойлгож байна уу? Та ийм зөрүүд байж болохгүй, сонгож болно шүү дээ. Гэхдээ та заавал архи болон амьтны гаралтай орц найрлагатай хятад эм тан уух гэж зүтгэвэл өөртөө үйл түйтгэр зохиож байгаа хэрэг болохоор Багш нь таны өмнө ямар ч хариуцлага үүрэхгүй. Архи уух нь

бидний билиг ухааныг самууруулж, тархи толгойг төөрөгдүүлж, бясалгалд муугаар нөлөөлөн тодорхой сэтгэх чадваргүй болгодог. Махан биеийн өчүүхэн өвчнөөс аврах гээд тархи толгойны өвчин олох нь ямар сайн зүйл байх билээ? Дараа нь тархи толгой сэргэг бус, сайн бодож тунгааж чадахгүй, өдөр бүр согтуу хүн шиг явна, учир нь архи бидний тархины мэдрэлийг гэмтээдэг. Эмийн төрөл зүйл олон, зөвхөн ганцхан төрлийг л уух албагүй. Архийг гадна талын эмчилгээнд ашиглаж болно, гэвч ууж болохгүй. Гэтэл миний харснаар ихэнх хүн архийг ууж хэрэглэдэг, зарим гэрээс гарагч ч гэсэн адилхан, тэд архи ууж болно гэж боддог ч ингэж болохгүй.

Миний Өвөг Багш өвдөөд бясалгаж суух үед “хувилгаан багш” гэгдэгч дотоодод нь илэрч: “Хэрвээ та өвдсөн бол эмчилгээний дарс, эсвэл амьтны гаралтай орц бүхий эм ууж болно, хамаагүй.” гэж хэлэхийг харжээ. Тэгээд бясалгалаасаа гарсны дараа дотроо: Өнөөдөр яагаад дотоодын Их Багш болон гадна талын Их Багш хоёрын яриа адилгүй болов гэж ихэд сэжиглэжээ, гэхдээ эм уугаагүй аж. Учир нь түүний Их Багш нь эмчилгээний дарсыг ч ууж болохгүй гэж удаа дараа онцлон хэлдэг болохоор дахин бясалгахаар сууж, дотоодын Их Багшаасаа тусламж гуйв, тэгэхэд өнөөх хүн илэрсэнгүй, тэр бясалгалаа жаахан сулруулсанд “хувилгаан багш” гэгдэгч дахин илэрч, мөн л нөгөө зүйлээ ярьж, эмтэй дарс ууж болно, амьтны гаралтай орц найрлагатай эм уусан ч хамаагүй гэж ярьжээ, тэр үед тэр Их Багшийнхаа: “Бясалгаж суухдаа дотоодын Их Багшийгаа харвал харц нь энэрэнгүй эсэхийг нь ажих хэрэгтэй.” гэж нэгэнтээ хэлснийг санажээ.

Их Багш нь нүднийх нь харцыг ажихаас гадна бас ялган таних онцгой аргыг заасан байжээ. Авшиг хүртээх үедээ би жинхэнэ бурхан болон хуурмаг бурхныг хэрхэн танихыг аль хэдийн ярьсан, хэрвээ мартсан бол бусад авшигтнаас асууж болно, энд шинэ хүн байгаа тул би задруулж болохгүй. Дээр дурдсан таних аргуудаас гадна Багшийнхаа заасан Таван Ариун Нэрийг уншиж болно, хэрвээ тэр ад чөтгөр бол тэр даруй зугтана! Иймээс Арьяабалын бясалгалын аргыг дадуулах нь хамгийн аюулгүй, Багш нь та нарт бүх зүйлийг ярьчихсан, та нарын бясалгалд адын саад огт тохиолдохгүй, ад шүглэхгүй, аюулгүй. Тэр бүү хэл, хэрвээ тэр үед бүх аргыг бүгдийг нь мартчихсан ч байсан хувилгаан Их Багш хажуугаас тань харж харгалзсан хэвээр байна, энэ нь хэд дахин аюулгүй биш гэж үү? Иймээс “Арьяабалын бясалгалын арга”-ыг дадуулснаар хэнд ч ад шүглэхгүй.

АВШИГ ХҮРТЭХҮЙ: АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажиг” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажиг багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон сүнслэг бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурьдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан.” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Шабд (Shabd)”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Гэгээрэх” гэдэг нь дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд

орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Насан туршдаа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж, Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө сүнслэг дадал бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө дадуулан бясалгаж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрж хайдаггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод сүнслэг дадал бясалгалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг тань л хүлээж авна.

ТАВАН САХИЛ

Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ.*

Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ.

Өөрийн бус зүйл авахыг цээрлэнэ.

Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ.

*Энэ сахил нь цэвэр веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

**Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи уух, тамхи, хар тамхи татах, мөрийтэй тоглоом тоглох, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг үзэх, ном, сэтгүүл унших, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх явдал багтана.

ВЕГАН ХООЛНЫ АЧ ТҮС

Насан турш веган (ургамал) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгал (Quan Yin Method)-ын авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь яриангүй. Бусад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “Ямар үйл хийнэ, тийм үр байна.” гэсэн үйлийн үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг.

Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлхтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын

шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ургамал хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!” гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодис хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: “Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ.” гэжээ. Мөн тэрээр: “Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?” гэжээ. “Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой.” гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард “Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй.” гэж зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогчдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг өвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм.” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4.5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний

чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно.

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.

ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цочирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болохсон. Хэрэв нэг акр газарт овъёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцай (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд, амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

АМЬТНЫ ЗОВЛОН

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтныг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно.” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Ургамал хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм.” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар ургамал хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хувраг ургамал хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө.” гэж (Genesis, 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай.” гэсэн үг юм. (Genesis, 9:4) Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ

пустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Isaiah: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг.” гэсэн байдаг. (Ромчуудад илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил).

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг. 211

Хятадын агуу их Зэн Багш Хань Шань-Зу мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаач, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс ургамал хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Алберт Эйнштейн, Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Алберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Альберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол ургамал хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс ургамал

хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, цэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр Төгс Гэгээрсэн Их Багш
Чин Хайн лекцийн эмхтгэл**

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Төвөд (1), Унгар (1), Фин(1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1,2) Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн
хоорондын захиа**

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн
гайхамшигт мөчүүд**

Ау Лак (1-2), Хятад (1-2)

**1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал /
тусгай хэвлэл**

Англи (1), Ау Лак (1)

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном
дэлгэрүүлсэн аялал**

Англи (1-6), Хятад (1-6)

Их Багшийн ярьсан үлгэр, түүх

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

Эзэн Бурхан ба хүмүүсийн тухай - Библийн үлгэрүүдээс

Англи, Ау Лак, Хятад

Эзэн Бурхантай шууд холбогдох - Энхтайванд хүрэх зам

Англи, Ау Лак, Хятад

Амьдралаа солонгоруулья

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Эрүү мэндээ ухаарахуй - Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна! Англи/Хятад (ном + CD)

Онч мэргэн үгс (1)

Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман, Англи/Солонгос, Англи/Япон

Онч мэргэн үгс (2)

Англи (1), Хятад (1)

Тэнгэрлэг зоог - Олон улсын ургамал хоолны гал тогоо

Англи/Хятад, Ау Лак, Япон

Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт

Англи/Хятад

Диваажингийн урлаг

Англи, Ау Лак, Хятад, Монгол

Жинхэнэ хайр

Англи, Хятад, DVD, MP4

Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)

Англи/Ау Лак/ Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог Англи/Ау Лак/Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог

Уран зургийн цувралууд Англи (1), Хятад (1)

Тэнгэрийн хувцас Англи/Хятад

Шувууд миний амьдралд

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт

Эрхэм ариун амьтад

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

Аниргүй нулимс

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

Вуузуу шүлгүүд

Англи, Ау Лак, Хятад

Мартагдсан дурсамж

Англи, Ау Лак, Хятад

Хайрга ба Алт

Англи, Ау Лак, Хятад

Эрвээхэйн мөрөөдөл

Англи, Ау Лак, Хятад

Өмнөх амьдралын зам мөр

Ау Лак, Хятад

Эрт дээр үе

Англи, Ау Лак, Хятад

Эрин зууны хайр

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Аниргүй нулимсыг хайрлахуй

Англи, Хятад, CD, DVD, MP4

Амьдрал болоод ухамсрын тухай бодрол

Доктор Жанезын бичсэн ном, Хятад хэл дээр

Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс
<http://crisis2peace.org> хаягаар олон хэл дээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Бусад айлдвар болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филиппин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэлээр хэвлэгджээ.

БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын
Нийгэмлэг**

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса, БНХАУ
(36899)

Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни 95173-
0247, АНУ

Суприм Мастер Телевиз

И-мэйл: Peace@SupremeMasterTV.com

Утас: 1-626-444-4385

Факс: 1-626-444-4386

Ном орчуулгын алба:

И-мэйл: divine@godsdirectcontact.org

(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд
оролцож болно.)

Мэдээний алба:

И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

S.M. Celestial Co., Ltd:

И-мэйл: smclothes123@gmail.com;

Vegann@hotmail.com

Утас: 886-3-4601391

Факс: 886-3-4602857

Веб сайт: <http://www.smcelestial.com> <http://www.sm-celestial.com>

Сүнслэг асуулт хариултын баг:

И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689 <http://www.smchbooks.com>

Онлайн дэлгүүр

Celestial Shop: <http://www.theCelestialShop.com> (Англи)

Eden: <http://www.EdenRules.com/> (Англи, Хятад)

Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр

<http://www.lovingfood.com.tw>

”Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ ресторан

И-мэйл: service@lovinghut.com

Утас: 886-3-4683345

Факс: 886-3-4681581

Веб хуудас: <http://www.lovinghut.com/tw/>

Гуан Инь веб хуудасны хаяг

Бурхантай шууд холбогдох - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

https://www.godsdirectcontact.org.tw/en2/index.php#related_links

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Гуан Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэлээр “Агшин зуур Гэгээрэхийн түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

Суприм Мастер Телевиз

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнаар үзэх хаяг: <http://suprememastertv.com/mn1/>

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-ийг олон хэлээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэлээр)

<http://sb.godsdirectcontact.net>

<http://www.direkter-kontakt-mit-gott.org/booklet>

<http://www.godsdirectcontact.com/sb/index.html>

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР-3

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын
Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

Хаяг: Тайбэй хот, Жүнзэн дүүргийн баруун замын 1-р хэсэг, 8-р
давхарын 16, 72 тоот

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл : smchbooks@Godsdirectcontact.org

<http://www.smchbooks.com>

Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2015

Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Энэхүү номын агуулгыг дахин хэвлүүлэх нээлттэй бөгөөд, үүний тулд
эхлээд нийтлэгч компаниас зөвшөөрөл авах ёстойг анхаарна уу.

Анхны хэвлэл: 1987 оны 09 сарын 01

Хоёр дахь хэвлэл: 1988 оны 01 сарын 15

Гурав дахь хэвлэл: 1992 оны 10 сарын 25

Дөрөв дэх хэвлэл: 1991 оны 04 сарын 01

Тав дахь хэвлэл: 1993 оны 03 сарын 25

Зургаа дахь хэвлэл: 1994 оны 08 сарын 10

Долоо дахь хэвлэл: 1998 оны 10 сар

Найм дахь хэвлэл: 2003 оны 04 сар

Ес дэх хэвлэл: 2009 оны 08 сар

Арав дахь хэвлэл: 2013 оны 09 сар

Хялбаршуулсан өрөлт: 2015 оны 10 сар

Энэхүү хувилбарыг монгол хэлнээ орчуулсан 2023 оны 10 сар

Анхны цахим хувилбар: <http://www.gegeerel.mn/> 2024 оны 1-р сар

Хоёр дахь цахим хувилбар <http://www.gegeerel.mn/> 2025 оны 8-р сар

Та бүхэн номын талаархи санал сэтгэгдлээ Mon.nomiinbag@gmail.com

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Тайбэй хот: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын
Нийгэмлэг, 1987

3 –р боть: 14.8x21 см

ISBN 978-957-98468-8-2 (Боть 3 : Хатуу хавтастай)

1. Сүнслэг дадал бясалгал 2. Оюун санааны амьдрал
192.1 86014160

Энэ дэлхийд залран буй Төгс Гэгээрсэн Их багштай учрахад хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт аяллууд гүнзгий ухааруулсан юм. Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн номыг ухааруулж чадна. Энэхүү номын ёсоор бясалгаад бид хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүссэн, жинхэнэ үнэн номыг хайсан, үхэж, төрөх, бясалгал, гэгээрэл, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт эрж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.